

Зурган индекс	Зураг дээрээс хайлт хийнэ	
Аюулгүй байдал ба дохиолол	Энэ хэсгийг бүрэн уншина Гол сэдэв: Хүүхдийн суудал, хулгайгаас сэргийлэх систем	1
Автомашины мэдээлэл ба индикаторууд	Жолоодлоготой холбоотой мэдээлэл (Гол сэдэв: Хянах самбар, мэдээллийн дэлгэц)	2
Жолоодлогын өмнө	Хаалга, цонх нээх хаах, жолоодлогын өмнөх тохиргоо хийх (Гол сэдэв: Түлхүүр, хаалга, суудал, автомат цонх)	3
Жолоодлого	Автомашины жолоодлогын үеийн зөвлөгөө (Гол сэдэв: Хөдөлгүүр асаах, шатахуун цэнэглэх)	4
Салоны функц, тоноглолууд	Салоны функц, тоноглолуудын ашиглалт (Гол сэдэв: Эйр кондишн, хайрцгууд)	5
Засвар үйлчилгээ ба арчилгаа	Автомашинд хийх шаардлагатай засвар үйлчилгээ ба арчилгаа (Гол сэдэв: Гадна болон дотор тал, гэрлийн ламп)	6
Асуудал үүссэн үед	Хэвийн ажиллагаа алдагдсан, онцгой байдал үүссэн үед авах арга хэмжээ (Гол сэдэв: Аккумуляторын цэнэг суух, дугуй хагарах)	7
Автомашины техник үзүүлэлт	Автомашины техник үзүүлэлт, тохиргоо (Гол сэдэв: Шатахуун, тос, дугуйн хийн даралт)	8
Индекс	Шинж тэмдгээр хайна	
	Үсгийн дарааллаар хайна	

Танд хэрэгтэй мэдээлэл	6
Гарын авлагын тэмдэг	10
Хэрхэн хайх вэ	11
Зурган индекс	12

1

Аюулгүй байдал ба дохиолол

1-1. Ашиглалтын аюулгүй байдал	
Жолоодлогын өмнө	32
Жолоодлогын аюулгүй байдал	33
Аюулгүйн бүс	34
SRS аюулгүйн дэр	38
Хаягдал утааны анхааруулга	44
1-2. Хүүхдийн аюулгүй байдал	
Хүүхэд зорчих үед	46
Хүүхдийн суудал	46
1-3. Онцгой нөхцөлийн үед туслах систем	
ERA-GLONASS/EVAK	75
1-4. Хулгайгаас сэргийлэх систем	
Хөдөлгүүрийн иммобилайзер систем	79
Давхар түгжих систем	80
Дохиоллын систем	81

2

Автомашины мэдээлэл ба индикаторууд

2-1. Хянах самбар	
Анхааруулах ба индикаторууд	88
Хянах самбарын хэмжих хэрэгслүүд	94
Мэдээллийн дэлгэц	99
HUD дэлгэц	100
Дэлгэцээр гарах контент	104

3

Жолоодлогын өмнө

3-1. Түлхүүрийн мэдээлэл	
Түлхүүр	114
3-2. Хаалга нээх, хаах ба түгжих	
Хажуугийн хаалга	119
Хураагддаг гишгүүр	124
Тээшний хаалга	127
Тээшний хаалганы нээгддэг цонх	142
Smart entry & start систем	145
3-3. Суудлын тохиргоо	
Урд суудал	150
Арын суудлууд	152
Толгойн түшлэг	160
3-4. Жолооны хүрд, толины тохиргоо	
Жолооны хүрд	163
Голын толь	165
Дижитал голын толь	166
Хажуугийн толь	176
3-5. Цонх, дээврийн нээлхий нээх хаах	
Автомат цонх	179
Дээврийн нээлхий	182
3-6. Хувийн тохиргоо	
Жолоодлогын байрлал санах систем	185
Миний тохиргоо	190

4

Жолоодлого

4-1. Жолоодлогын өмнө	
Автомашин жолоодох	189
Ачаа тээш, багааж	195
Чиргүүл чирэх (чирэх дэгээтэй)	197
4-2. Жолоодох үеийн зааварчилгаа	
Асаах товч	204
Автомат хурдны хайрцаг	208

Эргэх дохионы хөшүүрэг	213
Зогсоолын тоормос.....	214
Тоормос баригч.....	217
4-3. Гэрэл, шил арчигчийн ажиллагаа	
Их гэрэл асаах товч.....	219
AHS холын гэрэл	222
AHB холын гэрэл	226
Манангийн гэрлийн товч	228
Шил арчигч ба угаагч	229
Хойд шил арчигч ба угаагч	232
4-4. Шатахуун цэнэглэх	
Шатахууны савны таг онгойлгох	234
4-5. Жолоодлогод туслах систем ашиглах	
Lexus Safety System +.....	236
PCS систем	242
LTA систем	256
LCA систем.....	261
LDA систем.....	264
PDA систем	269
FCTA систем	274
RSA систем	277
Динамик радарын хурд барих систем	281
Хурд баригч.....	292
EDSS систем	295
Хурд хязгаарлагч	297
BSM систем.....	300
Араас автомашин ойртож буйг анхааруулах функц	305
Автомат арын ослын дохионы гэрэл.....	308
Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт)	310

Аюулгүй буухад туслах систем	312
Lexus parking assist-мэдрэгч	316
RCTA функц	322
RCD функц	327
PKSB тоормос	330
PKSB тоормос (урд, хойд талын хөдөлгөөнгүй объект)	334
PKSB тоормос (ар талын явж буй автомашин)	337
PKSB тоормос (ар талын явган зорчигч)	338
Multi-terrain монитор.....	340
Жолоодлогын горим сонгох товч	407
Дөрвөн дугуй хөтлөх систем	409
Арын дифференциал цоожлогч	412
Crawl Control	413
Multi-terrain Select систем	416
Уруу замд туслах удирдлагын систем.....	419
Жолоодлогод туслах системүүд	421
4-6. Жолоодлогын зөвлөмж	
Бартаат замын жолоодлого	427
Өвлийн жолоодлого	429

5

Салоны функц,
тоноглолууд

5-1. Lexus агааржуулалтын автомат горим	
Lexus агааржуулалтын автомат горим.....	434
5-2. Агааржуулалтын систем болон цан арилгагч	
Урд автомат агааржуулалтын систем.....	435
Арын автомат агааржуулалтын систем.....	443

	Жолооны хүрд халаагч/суудал халаагч/суудлын агааржуулагч	446
5-3.	Салоны гэрэл ашиглах Салоны гэрлийн жагсаалт....	448
5-4.	Хайрцаг тавиур зэргийг ашиглах Хайрцаг тавиурын жагсаалт	452
	Тээшний хэсэг	456
5-5.	Салоны бусад хэрэгсэл ашиглах Цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхий	459
	Салоны бусад хэрэгслүүд	461

6

Засвар үйлчилгээ ба арчилгаа

6-1.	Засвар үйлчилгээ ба арчилгаа Автомашины гадна талыг цэвэрлэх, хамгаалах	476
	Автомашины дотор талыг цэвэрлэх, хамгаалах	479
6-2.	Засвар үйлчилгээ Засвар үйлчилгээнд тавигдах шаардлага.....	482
	Хуваарьт засвар үйлчилгээ..	484

6-3.	Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээ Өөрөө хийх засвар үйлчилгээний анхааруулга	491
	Капот	493
	Хөдөлгүүрийн хэсэг.....	494
	Дугуй	503
	Дугуйны хийн даралт	513
	Обуд	514
	Салоны агаар шүүгч	516
	Электрон түлхүүрийн зай	517
	Гал хамгаалагч шалгах, солих	520
	Гэрлийн ламп	522

7

Асуудал үүссэн үед

7-1.	Чухал мэдээлэл Ослын дохионы гэрэл.....	524
	Онцгой нөхцөл байдалд автомашин зогсоох шаардлагатай үед	524
	Түвшин нэмэгдэж буй усанд автомашин суусан үед	525
7-2.	Онцгой нөхцөлд авах арга хэмжээ Чирүүлэх, ачиж тээвэрлэх үед	527
	Автомашинд асуудал гарсан гэж үзвэл	530
	Бензин насос таслах систем	531
	Анхааруулах гэрэл ассан, анхааруулах дохио дуугарсан үед	532
	Дэлгэц дээр анхааруулга гарсан үед	541
	Дугуй хагарсан үед	548
	Хөдөлгүүр сахахгүй үед.....	557
	Түлхүүрээ гэсэн үед	559

Электрон түлхүүр хэвийн ажиллахгүй үед.....	559
Аккумуляторын цэнэг суусан үед	561
Хөдөлгүүр халсан үед	566
Автомашин суусан үед	568

8 Техник үзүүлэлт

8-1. Техник үзүүлэлт Засвар үйлчилгээний мэдээлэл (шатахуун, тос г.м.).....	572
Шатахууны мэдээлэл	582
8-2. Тохиргоог өөрчлөх Өөрчлөх боломжтой тохиргоо	583
8-3. Дахин тохируулах тохиргоо Дахин тохируулах зүйлс.....	600

Индекс

Энэ үед яах вэ... (Асуудал шийдвэрлэх)	602
Индекс	605

1

2

3

4

5

6

7

8

Танд хэрэгтэй мэдээлэл



АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үеийн ерөнхий анхааруулга

Согтууруулах ундаа, эмийн нөлөөлөл дор жолоо барих: Архи, согтууруулах ундаа, жолоо барих чадварт нөлөөлөх эмийн нөлөөнд орсон үед автомашин жолоодохыг хориглоно. Архи, согтууруулах ундаа, зарим төрлийн эм нь хариу үйлдлийг удаашруулах, нөхцөл байдлыг зөвөөр дүгнэх болон орон зай баримжаалах чадварыг бууруулдаг тул амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

Замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцох: Замын хөдөлгөөнд бусад тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн гаргаж болзошгүй алдааг урьдчилан тооцоолж осол аваараас сэргийлэн цаг ямагт анхаарал болгоомжтой оролцоно.

Жолоочийн анхаарал сарних: Автомашин жолоодох үед жолоодлогод бүх анхаарлаа хандуулна. Системийн тохиргоо хийх, гар утсаар ярих, унших зэргээр анхаарлаа сарниулах нь өөрийн болон зорчигч мөн бусдын амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах осолд хүргэх аюултай.

■ Хүүхдийн аюулгүй байдлын ерөнхий анхааруулга

Автомашинд насанд хүрээгүй хүүхдийг харгалзах хүнгүйгээр үлдээх мөн автомашины түлхүүр үлдээн ашиглуулахыг хориглоно.

Хүүхэд автомашиныг асаах, араг сул араанд шилжүүлэх зэрэг аюултай. Мөн тамхины асаагуур, цонх дээврийн нээлхий (тоноглогдсон загварт) болон бусад тоноглолоор тоглон өөрийгөө гэмтээх аюултай. Улмаар хэт халсан буюу хөрсөн бүхээг нь хүүхдийн амь насанд аюултай.

Хэрэглэгчийн ерөнхий гарын авлага

Тус гарын авлага нь бүх загварт зориулагдсан ба нийтлэг тоноглол, функцийг тайлбарлах тул таны автомашинд байхгүй мэдээлэл орсон байж болно.

Номыг хэвлэлтэд өгсөн тухайн үеийн техник үзүүлэлтийг гарын авлагад тэмдэглэсэн болно. Бүтээгдэхүүний сайжруулалтыг цаг ямагт хийдэг Lexus-н бодлогын дагуу бид урьдчилан мэдэгдэлгүйгээр гарын авлагад өөрчлөлт хийх эрхтэй.

Техник үзүүлэлтээс хамаарч бодит тоноглол зэрэг нь зургаас өөр харагдаж болно.

Евроазийн Эдийн Засгийн Холбоо: Автомашин болон системийн аюулгүй ажиллагааны тухай автомашинд тэмдэглэгдсэн Англи хэл дээрх мэдээллүүд нь зөвхөн засвар үйлчилгээний ажилтнуудад зориулсан болно.

Lexus нэмэлт тоноглол, сэлбэг хэрэгсэл ба автомашинд өөрчлөлт хийх

Lexus автомашины оригинал бус олон төрлийн нэмэлт тоноглол, сэлбэг хэрэгсэл зах зээл дээр худалдаалагддаг. Эдгээр нь таны Lexus автомашины аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, эвдрэл үүсгэж болзошгүй тул оригинал биш тоноглол, сэлбэг хэрэгсэлтэй холбоотой аливаа хариуцлагыг Тоёота Мотор Корпорац хүлээх, баталгаа гаргах, ашиглалтын гүйцэтгэлийг батлах боломжгүй ба угсарч суурилуулах, солих ажлыг мөн хийж гүйцэтгэхгүй болно.

Мөн тус автомашинд Lexus-н оригинал бус бүтээгдэхүүн ашиглан өөрчлөлт хийж болохгүй. Оригинал бус бүтээгдэхүүн ашиглан өөрчлөлт хийх нь автомашины ажиллагаа, аюулгүй байдал, эдэлгээнд сөргөөр нөлөөлөх мөн хууль дүрмийн зөрчил үүсгэж болно. Өөрчлөлтийн улмаас үүссэн гэмтэл, хүчин чадлын бууралт зэрэг нь үйлдвэрлэгчийн баталгаанд хамаарахгүй болох ч магадлалтай.

Мөн өөрчлөлт хийх нь Lexus Safety System + зэрэг аюулгүй байдлын тоноглолуудад нөлөөлөх ба ослын үед хэвийн ажиллахгүй байх эсвэл ажиллах ёсгүй нөхцөлд ажиллах зэрэг эрсдэл үүсгэж болно.

Кибер халдлагын эрсдэл

Электрон төхөөрөмж, радио суурилуулах нь эдгээр эд ангиар дамжуулан кибер халдлагад өртөх эрсдэлийг нэмэгдүүлэх, осолд хүргэх, хувийн мэдээлэл алдагдахад хүргэнэ.

Lexus нь Lexus-н оригинал бус бүтээгдэхүүн суулгаснаас үүссэн асуудалд баталгаа өгдөггүй.

Радио станц угсрах

Автомашинд радио станц угсарч ашиглах нь дараах системийн ажиллагаанд нөлөөлж болно:

- Олон портын шатахуун цацах систем/олон портын дараалсан шатахуун цацах систем
- Lexus Safety System +
- Хурд баригч
- ABS үл түгжигдэх тоормос
- SRS аюулгүйн дэрний систем
- Аюулгүйн бүс чангалах систем

Радио станц суурилуулахтай холбоотой анхаарах зүйлс болон тусгай зааварчилгааг та өөрийн Lexus дилерээс авах шаардлагатай.

Таны хүсэлтээр Lexus дилер радио давтамж, цахилгааны хүчин чадал, антены байрлал, радио станц суурилуулахад шаардлагатай дэлгэрэнгүй мэдээллийг өгөх боломжтой.

Автомашины дата өгөгдлийг хадгалах

Тус автомашинд дараах төрлийн дата өгөгдлийг хадгалах компьютер байдаг:

■ Хадгалагдах дата

Функц тус бүрийн ажиллагааны байдлаас хамаарч дараах дата хадгалагддаг.

- Хөдөлгүүр/Цахилгаан моторын хурд (хөтлөх моторын хурд)
- Хаазны дөрөөний ажиллагаа
- Тоормосны дөрөөний ажиллагаа
- Автомашины хурд
- Жолоодлогод туслах системүүдийн ажиллагааны статус
- Камерын дүрс

Тус автомашинд камер суурилагдсан болно. Камерын байрлалыг та Lexus дилерээс тодруулна уу.

Хадгалах дата өгөгдөл нь автомашины зэрэглэл, тоноглолоос хамаарч өөр өөр байна.

Компьютерт харилцан яриа, дуу хадгалагдахгүй ба зөвхөн тодорхой нөхцөлд автомашины гадна орчны зураг хадгалагдана.

■ Дата өгөгдлийн ашиглалт

Өгөгдлийг үүссэн доголдлыг оношлох, судалгаа болон хөгжүүлэлт хийх, чанарыг сайжруулах зорилгоор Lexus ашиглаж болно.

Дараахаас бусад үед өгөгдлийг Lexus гуравдагч талд үл дамжуулна:

- Автомашин эзэмшигч, түрээсийн автомашины түрээслэгчийн зөвшөөрөл авсан үед

- Цагдаагийн байгууллага, шүүх, төрийн байгууллагаас албан хүсэлт ирсэн үед
- Lexus шүүх дээр ашиглах үед
- Тодорхой нэг автомашин, хэрэглэгчийн хувийн мэдээлэлтэй холбоогүй өгөгдлийг судалгааны журмаар ашиглах

Хадгалагдсан дүрсийг Lexus дилер дээр устгуулж болно.

Дүрс хадгалах функцийг цуцлах боломжтой. Энэ үед дата өгөгдөл хадгалагдахгүй.

Lexus Safety System + системээр дамжуулан Lexus сервер лүү судалгаа, хөгжүүлэлтийн зорилгоор дата дамжуулахыг зөвшөөрөхгүй нөхцөлд Lexus дилертээ хандана уу.

Тохиолдлын өгөгдлийн бичигч (EDR)

Автомашинд тохиолдлын өгөгдлийг бичигч (EDR) суурилагдсан болно. EDR-н үндсэн зорилго нь аюулгүйн дэр дэлгэгдэх, зам дээрх саад мөргөх зэргээр осол, осолд дөхсөн тохиолдол үүссэн үед автомашины дата өгөгдлийг хадгалах ба энэхүү өгөгдлийг ашиглан автомашины системийн хариу үйлдэл, ажиллагааг мэдэх боломжтой болдог. EDR нь автомашины динамик болон аюулгүйн системийн 30 хүртэлх секундйн богино хугацааны өгөгдлийг хадгалах ба мөргөлтийн хэмжээ, төрлөөс хамаарч зарим тохиолдолд хадгалдаггүй.

EDR дараах өгөгдлүүдийг хадгална:

- Автомашины системүүд хэрхэн ажиллаж байсан
- Жолооч хаазны дөрөө, тоормосны дөрөөг ямар хэмжээнд (эсвэл гүйцэд) гишгэсэн
- Тухайн үед ямар хурдаар явж байсан

Эдгээр өгөгдөл нь осол, гэмтэл үүссэн үеийн нөхцөл байдлыг мэдэхэд тусална.

ТЭМДЭГЛЭЛ: EDR нь зөвхөн томоохон ослын үеийн өгөгдлийг хадгалах ба хэвийн жолоодлогын үеийн өгөгдөл болон хувийн мэдээлэл зэргийг (нэр, хүйс, нас, осол гарсан байршил) хадгалдаггүй. Нөгөөтээгүүр бусад талууд жишээлбэл хууль, цагдаагийн байгууллага зэрэг нь ослын мөрдлөг хийх үед олж авсан хувийн мэдээллийг EDR өгөгдөлтэй нэгтгэж болно.

EDR-н өгөгдлийг уншихад тусгай төхөөрөмж шаардлагатай ба автомашин эсвэл EDR-т хандах нөхцөл бүрдсэн байна. Автомашины үйлдвэрлэгчээс гадна хууль, цагдаагийн байгууллага зэрэг бусад талууд тусгай төхөөрөмжтэй байх ба автомашин эсвэл EDR-т хандах боломжтой үед өгөгдөл уншиж болно.

- EDR дата өгөгдлийг гуравдагч этгээдэд дэлгэх

Дараахаас бусад тохиолдолд Lexus EDR өгөгдлийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй:

- Автомашин эзэмшигч (түрээ-

сийн автомашины түрээслэгч)-с зөвшөөрөл авсан үед

- Цагдаа, шүүх, төрийн байгууллагын албан хүсэлтийн дагуу
- Lexus шүүх дээр ашиглах үед

Мөн шаардлагатай үед Lexus дараах байдлаар ашиглаж болно:

- Автомашины аюулгүй байдлын судалгаа хийх үед
- Тодорхой нэг автомашин, хэрэглэгчтэй холбоогүй өгөгдлийг судалгааны журмаар ашиглах зорилгоор гуравдагч этгээдэд дамжуулах үед

Lexus автомашиныг устгалд оруулах

Энэхүү Lexus автомашины SRS аюулгүйн дэр, аюулгүйн бүс буцаан чангалагч нь тэсрэмтгий химийн бодис агуулах тул тэдгээрийг автомашинаас салгалгүй устгалд оруулсан тохиолдолд гал түймэр гарах зэрэг ослын шалтгаан болдог. Автомашиныг устгалд оруулахын өмнө мэргэжлийн засварын газар эсвэл өөрийн Lexus дилерт хандаж SRS аюулгүйн дэр, аюулгүйн бүс буцаан чангалагчийг салгуулна.

“QR Code”

“QR Code” үг нь DENSO WAVE INCORPORATED-н Япон болон бусад улсад бүртгэлтэй барааны тэмдэгт болно.


Гарын авлагын тэмдэг

Тус гарын авлагад ашиглагдах тэмдгийн утга


Тэмдэг

Тэмдэг	Утга
	АЮУЛТАЙ: Дагаж мөрдөөгүй тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах зүйлсийг тайлбарлана.
	АНХААР: Дагаж мөрдөөгүй тохиолдолд автомашин болон түүний эд ангид гэмтэл учруулах зүйлсийг тайлбарлана.
	Үйлдлийн эсвэл ажиллагааны дарааллыг илтгэнэ. Тоон дарааллын дагуу хийж гүйцэтгэнэ.

Зураг дахь тэмдэг



Тэмдэг	Утга
	Товч болон төхөөрөмжийг ажиллуулах үеийн үйлдэл (дарах, эргүүлэх г.м.)-г тайлбарлана.
	Аливаа үйлдлийн үр дүнг тайлбарлана (жишээ нь таг онгойно г.м.).





Тэмдэг	Утга
	Тайлбарлаж буй эд анги, түүний байрлалыг заана.
	“Болохгүй”, “Хориглоно” болон “Хориотой” утгыг илэрхийлнэ.

Хэрхэн хайх вэ


■ Нэрээр хайх

- Индекс: →X.605



■ Байрлалаар хайх

- Зурган индекс: →X.12



■ Шинж тэмдэг, дуугаар хайх

- Энэ үед яах вэ... (Асуудал шийдвэрлэх): →X.602




■ Гарчгаар хайх

- Гарчиг: →X.2

Зурган индекс

■ Дотор тал



- A** Хажуугийн хаалгаX.119
 - Түгжих/тайлах.....X.119, 122
 - Хажуугийн цонх нээх/хаахX.178
 - Механик түлхүүрээр түгжих/тайлахX.559
 - Анхааруулах мэдээлэлX.541
- B** Тээшний хаалгаX.126
 - Түгжих/тайлах.....X.127
 - Тээшний хаалга нээх/хаахX.128
 - Тээшний хаалганы нээгддэг цонхX.142
 - Анхааруулах мэдээлэлX.541
- C** Хажуугийн толь.....X.175
 - Толь тохируулах.....X.175
 - Толь эвхэх.....X.176
 - Жолоодлогын байрлал санах системX.185
 - Толины цан арилгах.....X.440

D	Шил арчигч	X.230
	Өвлийн улиралд анхаарах зүйлс	X.433
	Хөлдөлтөөс сэргийлэх (салхины шилний мөс арилгагч*)X.440	
	Автомашин угаах үеийн анхааруулга	X.478
E	Шатахууны савны таг	X.235
	Шатахуун цэнэглэх	X.235
	Шатахууны төрөл/шатахууны савны багтаамж.....	X.576
F	Дугуй.....	X.505
	Дугуйны хэмжээ/хийн даралт	X.581
	Өвлийн дугуй/дугуйны гинж.....	X.433
	Шалгах/байрлал солих/ дугуйн даралт анхааруулах систем	X.505
	Дугуй хагарсан үед.....	X.548
G	Капот	X.494
	Нээх	X.494
	Хөдөлгүүрийн тос	X.576
	Автомашин халсан үед	X.566
	Анхааруулах мэдээлэл	X.541

Гадна талын жолоодлогын гэрлийн ламп
(Солих арга: X.525)

H	Их гэрэл/урд оврын гэрэл/өдрийн хөдөлгөөний гэрэл.....	X.219
I	Урд манангийн гэрэл*/Арын манангийн гэрэл*	X.229
J	Эргэлтийн нэмэлт гэрэл.....	X.221
K	Эргэх дохионы гэрэл.....	X.212
L	Тоормосны гэрэл	
	Индикатор	X.90
	Динамик радарын хурд барих систем.....	X.284
	Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт)*	X.311

Уруу замд туслах удирдлагын систем*X.423

[M] Арын гэрэлX.219


[N] Ухрах арааны гэрэл

Арааны хөшүүргийг R байрлалд шилжүүлэхX.208

[O] Дугаарын гэрэл.....X.219

* : Тоноглогдсон загварт

■ Удирдлагын самбар (зүүн жолооны хүрдтэй)




A	Асаах товч.....	X.203
	Хөдөлгүүр асаах/горим солих	X.203
	Онцгой үед хөдөлгүүр унтраах.....	X.524
	Хөдөлгүүр асахгүй үед.....	X.557
	Анхааруулах мэдээлэл	X.541
B	Арааны хөшүүрэг.....	X.207
	Арааны хөшүүрэг шилжүүлэх.....	X.208
	Чирүүлэх үеийн анхааруулга	X.527
	Арааны хөшүүрэг шилжихгүй үед	X.209
C	Хэмжих хэрэгслүүд.....	X.94
	Хянах самбарын хэмжих хэрэгслүүд/ Хянах самбарын гэрлийн тохиргоо	X.94
	Анхааруулах гэрэл/индикаторууд	X.88
	Анхааруулах гэрэл ассан үед.....	X.532
D	Мэдээллийн дэлгэц	X.99

Дэлгэц	X.99
Анхааруулах мэдээлэл ассан үед.....	X.541
E Эргэх дохионы хөшүүрэг.....	X.212
Их гэрэл асаах товч	X.219
Их гэрэл/Урд оврын гэрэл/Арын гэрэл/ Өдрийн хөдөлгөөний гэрэл.....	X.219
Урд манангийн гэрэл ^{*1} /Арын манангийн гэрэл ^{*1}	X.229
AHS холын гэрлийн товч ^{*1}	X.223
Автомат холын гэрлийн товч.....	X.226
F Шил арчигч ба шил угаагч	X.230
Хойд шил арчигч ба шил угаагч	X.233
Ашиглалт.....	X.230, 233
Шил арчигчийн шингэн нэмэх.....	X.503
Их гэрэл угаагч ^{*1}	X.230
Анхааруулах мэдээлэл	X.503
G Ослын дохионы гэрлийн товч.....	X.524
H Шатахууны савны таг нээх товч	X.236
I Капот нээх хөшүүрэг	X.494
J Жолооны хүрд тохируулах хөшүүрэг ^{*1} / Жолооны хүрд тохируулах товч ^{*1}	X.163
Тохиргоо.....	X.163
Жолоодлогын байрлал санах систем ^{*1}	X.184
K Агааржуулалтын систем	X.436
Ашиглалт.....	X.436
Арын цонхны цан арилгагч	X.440
L Аудио систем ^{*2}	

^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.


■ Удирдлагын товчууд (зүүн жолооны хүрдтэй)



- A** “ODO TRIP” товч.....X.97
- B** Удирдлагын самбарын гэрэл тохируулах товчX.98
- C** Жолоодлогын байрлал санах системийн товч^{*1}X.185
- D** VIEW товч^{*1, 2}X.347
- E** PKSB товч^{*1}X.334
- F** Тээшний автомат хаалганы товчX.128
- G** Хураагддаг гишгүүр товч^{*1}X.126
- H** Хажуугийн толины товчX.175
- I** Хаалга түгжих товч.....X.122
- J** Автомат цонхны товчX.178
- K** Цонх түгжих товчX.180


^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Панорамик камертай загварт дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.



- A** Хянах самбарын удирдлагын товч.....X.104
- B** Жолооны хурдний араа солих хөшүүргийн товч.....X.210
- C** Гар утасны товч*
- D** LTA системийн товчX.259
- E** Хурд баригчийн товч
Динамик радарын хурд барих систем.....X.282
Хурд баригчX.293
- F** Аудио удирдлагын товч*
- G** Дуудлага хийх, яриаг дуусгах товч*


*: Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.



- A** MODE SELECT товч.....X.410, 418, 421, 423
- B** DRIVE MODE товч.....X.410
- C** MTS товч*X.421
- D** DAC/CRAWL товч*X.418, 423
- E** 2-р араагаар хөдөлгөөн эхлэх горимын товч*X.210
- F** VSC OFF товч.....X.427
- G** Төвийн дифференциал цоожлогчийн товчX.413
- H** Арын дифференциал цоожлогчийн товч*X.415
- I** Дөрвөн дугуй хөтлөх системийн товчX.412
- J** Тоормос баригчийн товч.....X.216
- K** Зогсоолын тоормос товч.....X.213
 Залгах/салгах.....X.213
 Өвлийн улиралд анхаарах зүйлсX.434
 Анхааруулах дохио/мэдээлэлX.538, 541

* : Тоноглогдсон загварт


■ Дотор тал (зүүн жолооны хүрдтэй)



A SRS аюулгүйн дэр	X.38
B Шалавч	X.32
C Урд суудал	X.150
D Арын суудлууд	X.152
2-р эгнээний суудал	X.152
3-р эгнээний суудал *	X.152
E Толгойн түшлэг	X.160
F Аюулгүйн бүс	X.34
G Голын хайрцаг *	X.454
Хөргүүртэй хайрцаг *	X.462
H Дотор талын түгжих товч	X.122
I Аяганы тавиур	X.455
J Ундааны тавиур	X.455

* : Тоноглогдсон загварт

■ Дээд тал (зүүн жолооны хүрдтэй)



A	Голын толь ^{*1}	X.165
	Дижитал голын толь ^{*1}	X.166
B	Нарны хаалт ^{*2}	X.463
C	Нарны хаалтын толь	X.463
D	Бүхээгийн гэрэл ^{*3}	X.450
	Хувийн гэрлүүд ^{*3}	X.451
E	Дээврийн нээлхийний товч ^{*1}	X.181
	Дээврийн электрон нарны хаалтын товч ^{*1}	X.460
F	Дээврийн нээлхийний товч ^{*1}	X.181
	Бүдгэрүүлэх товч ^{*1}	X.460
G	“SOS” товч ^{*1}	X.76


^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: ХҮҮХДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДЭД НОЦТОЙ ХОХИРОЛ УЧРУУЛАХ аюултай тул аюулгүйн дэрний дэлгэгдэх хүрээнд хүүхдийн суудлыг АРАГШ харуулан суурилуулахыг ХАТУУ ХОРИГЛОНО. (→X.48)



*3: Зурагт урд талыг харуулсан бөгөөд ар талд мөн тоноглогдсон болно.

■ Удирдлагын самбар (баруун жолооны хүрдтэй)




- A** Асаах товч.....X.203
 - Хөдөлгүүр асаах/горим солихX.203
 - Онцгой үед хөдөлгүүр унтраах.....X.524
 - Хөдөлгүүр асахгүй үед.....X.557
 - Анхааруулах мэдээлэлX.541
- B** Арааны хөшүүрэг.....X.207
 - Арааны хөшүүрэг шилжүүлэх.....X.208
 - Чирүүлэх үеийн анхааруулга.....X.527
 - Арааны хөшүүрэг шилжихгүй үедX.209
- C** Хэмжих хэрэгслүүд.....X.94
 - Хянах самбарын хэмжих хэрэгслүүд/
Хянах самбарын гэрлийн тохиргооX.94
 - Анхааруулах гэрэл/индикаторуудX.88
 - Анхааруулах гэрэл ассан үед.....X.532
- D** Мэдээллийн дэлгэцX.99

Дэлгэц	X.99
Анхааруулах мэдээлэл ассан үед.....	X.541
E Эргэх дохионы хөшүүрэг.....	X.212
Их гэрэл асаах товч	X.219
Их гэрэл/Урд оврын гэрэл/Арын гэрэл/ Өдрийн хөдөлгөөний гэрэл.....	X.219
Урд манангийн гэрэл/Арын манангийн гэрэл ^{*1}	X.229
AHS холын гэрлийн товч ^{*1}	X.223
Автомат холын гэрлийн товч.....	X.226
F Шил арчигч ба шил угаагч	X.230
Хойд шил арчигч ба шил угаагч	X.233
Ашиглалт.....	X.230, 233
Шил арчигчийн шингэн нэмэх.....	X.503
Их гэрэл угаагч	X.230
Анхааруулах мэдээлэл	X.503
G Ослын дохионы гэрлийн товч.....	X.524
H Шатахууны савны таг нээх товч	X.236
I Капот нээх хөшүүрэг	X.494
J Жолооны хүрд тохируулах товч.....	X.163
Тохиргоо.....	X.163
Жолоодлогын байрлал санах систем	X.185
K Агааржуулалтын систем	X.436
Ашиглалт.....	X.436
Арын цонхны цан арилгагч	X.440
L Аудио систем ^{*2}	

^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.


■ Удирдлагын товчууд (баруун жолооны хүрдтэй)



- A** VIEW товч^{*1, 2}X.347
- B** Удирдлагын самбарын гэрэл тохируулах товчX.98
- C** “ODO TRIP” товч.....X.97
- D** Жолоодлогын байрлал санах системийн товчX.185
- E** Хажуугийн толины товчX.175
- F** Хаалга түгжих товч.....X.122
- G** Автомат цонхны товчX.178
- H** Цонх түгжих товчX.180
- I** Тээшний автомат хаалганы товчX.128
- J** PKSB товчX.334
- K** Хураагддаг гишгүүр товч^{*1}X.126


^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Панорамик камертай загварт дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.



- A** Хянах самбарын удирдлагын товч.....X.104
- B** Жолооны хурдний араа солих хөшүүргийн товч.....X.210
- C** Гар утасны товч*
- D** LTA системийн товчX.259
- E** Хурд баригчийн товч
Динамик радарын хурд барих систем.....X.282
Хурд баригчX.293
- F** Аудио удирдлагын товч*
- G** Дуудлага хийх, яриаг дуусгах товч*


*: Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.



- A** “TOW HAUL” товчX.211
- B** VSC OFF товчX.427
- C** MODE SELECT товчX.410, 418, 421, 423
- D** DRIVE MODE товчX.410
- E** MTS товч *X.421
- F** DAC/CRAWL товч *X.418, 423
- G** 2-р араагаар хөдөлгөөн эхлэх горимын товч *X.210
- H** Зогсоолын тоормос товчX.213
Залгах/салгахX.213
Өвлийн улиралд анхаарах зүйлсX.434
Анхааруулах дохио/мэдээлэлX.538, 541
- I** Тоормос баригчийн товчX.216
- J** Дөрвөн дугуй хөтлөх системийн товчX.412
- K** Төвийн дифференциал цоожлогчийн товчX.413
- L** Арын дифференциал цоожлогчийн товч *X.415

* : Тоноглогдсон загварт


■ Дотор тал (баруун жолооны хүрдтэй)



A	SRS аюулгүйн дэр	X.38
B	Шалавч	X.32
C	Урд суудал	X.150
D	Арын суудлууд	X.152
	2-р эгнээний суудал	X.152
	3-р эгнээний суудал*	X.152
E	Толгойн түшлэг	X.160
F	Аюулгүйн бүс	X.34
G	Голын хайрцаг*	X.454
	Хөргүүртэй хайрцаг*	X.462
H	Дотор талын түгжих товч	X.122
I	Аяганы тавиур	X.455
J	Ундааны тавиур	X.455

* : Тоноглогдсон загварт

■ Дээд тал (баруун жолооны хүрдтэй)



A	Голын толь ^{*1}	X.165
	Дижитал голын толь ^{*1}	X.166
B	Нарны хаалт ^{*2}	X.463
C	Нарны хаалтын толь	X.463
D	Бүхээгийн гэрэл ^{*3}	X.450
	Хувийн гэрлүүд ^{*3}	X.451
E	Дээврийн нээлхийний товч ^{*1}	X.181
	Дээврийн электрон нарны хаалтын товч ^{*1}	X.460
F	Дээврийн нээлхийний товч ^{*1}	X.181
	Бүдгэрүүлэх товч ^{*1}	X.460

^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: ХҮҮХДИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДЭД НОЦТОЙ ХОХИРОЛ УЧРУУЛАХ аюултай тул аюулгүйн дэрний дэлгэгдэх хүрээнд хүүхдийн суудлыг АРАГШ харуулан суурилуулахыг ХАТУУ ХОРИГЛОНО. (→X.48)



^{*3}: Зурагт урд талыг харуулсан бөгөөд ар талд мөн тоноглогдсон болно.

1-1. Ашиглалтынаюулгүйбайдал	
Жолоодлогын өмнө	32
Жолоодлогын аюулгүй байдал	33
Аюулгүйн бүс.....	34
SRS аюулгүйн дэр	38
Хаягдал утааны анхааруулга	44
1-2. Хүүхдийн аюулгүй байдал	
Хүүхэд зорчих үед	46
Хүүхдийн суудал.....	46
1-3. Онцгой нөхцөлийн үед туслах систем	
ERA-GLONASS/EVAK.....	75
1-4. Хулгайгаас сэргийлэх систем	
Хөдөлгүүрийн иммобилайзер систем..	79
Давхар түгжих систем	80
Дохиоллын систем.....	81


Жолоодлогын өмнө

Жолоодлогын аюулгүй байдлыг хангах үүднээс хөдөлгөөн эхлэхийн өмнө дараах зүйлсийг шалгана.


Шалавч угсрах

Зөвхөн ижил төрлийн нэг оны загварт зориулагдсан шалавч ашиглана. Шалавчийг хивсэнцэр дээр зөв байрлалд угсарна.

- 1 Бэхлэх дэгээ (хавчаар)-г шалавчны нүхэнд хийнэ.



- 2 Бэхлэх дэгээ (хавчаар) тус бүрийн дээд товчийг эргүүлж шалавчийг тогтооно.



Тогтоох үед Δ тэмдгийг [A]-тай тааруулна.

Бэхлэх дэгээний хэлбэр зурагт

үзүүлснээс өөр байж болно.

⚠ АЮУЛТАЙ


Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд шалавч гулсаж жолоодлогын үед дөрөөний ажиллагаанд саад учруулах аюултай. Улмаар автомашин огцом хурд нэмэх эсвэл автомашиныг зогсооход хүндрэлтэй нөхцөл үүсэж болзошгүй ба амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.

■ Жолоочийн шалавч угсрах

- Lexus-н оригинал шалавч байсан ч өөр загварын мөн өөр оны загварын шалавч ашиглахгүй.
- Зөвхөн жолоочийн суудалд зориулсан шалавч ашиглана.
- Шалавчийг дэгээ (хавчаар) ашиглан зөв угсарна.
- Хоёроос олон тооны шалавч давхарлан ашиглаж болохгүй.
- Дээд доод талыг буруу байрлуулахгүй.

■ Жолоодлогын өмнө

- Шалавч зөв байрлалд, бүх дэгээнд (хавчаар) бэхлэгдсэн эсэхийг нягтална. Ялангуяа шалны цэвэрлэгээний дараа сайтар анхаарна.




- Хөдөлгүүр унтраастай үед арааны Р байрлалд бүх дөрөөг шаланд тултал гишгэж шалавчинд хүрэхгүй байгаа эсэхийг шалгана.

Жолоодлогын аюулгүй байдал

Жолоодлогын аюулгүй байдлыг хангахын тулд хөдөлгөөний өмнө суудал мөн толийг зөв байрлалд тохируулна.

Жолоодлогын зөв байрлал



- A** Суудлын түшлэгийг жолооны хүрд рүү тонгойхгүй, цэх суух байдлаар тохируулна. (→X.150)
- B** Жолооч дөрөөг тултал гишгэх, жолооны хүрдийг хоёр гараар барих үед тохой бага зэрэг нугарах байдлаар суудлыг тохируулна. (→X.150)
- C** Толгойн түшлэгийн төв хэсэг жолоочийн чихний орчимд байхаар тохируулж түгжинэ. (→X.160)
- D** Аюулгүйн бүсийг зөв зүүж хэрэглэнэ. (→X.35)

⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Хөдөлгөөний үед жолоочийн суудлын байрлалыг тохируулж болохгүй. Жолоодлогоо алдахад хүрч болно.
- Жолооч, зорчигчийн суудлын түшлэгт зөөлөвч хавчуулж ашиглахгүй. Зөөлөвч нь зөв байрлалтай суухад саад болох, аюулгүйн бүс, толгойн түшлэгийн ашиглалтын зөв нөлөөг бууруулах магадлалтай.
- Урд суудлын доод талд эд зүйлс тавьж болохгүй. Эд зүйлс суудлын замд тээглэж суудал түгжигдэхгүй болж болно. Энэ нь осолд хүргэж болзошгүй бөгөөд улмаар суудлын байрлал тохируулах механизмуудыг гэмтээх магадлалтай.
- Авто замаар зорчих үед хуулиар тогтоосон хурдны хязгаарыг хатуу мөрдөнө.
- Холын замд жолоо барих үедээ тогтмол амралт хийхийг зөвлөж байна. Мөн жолоо барих үед ядрах эсвэл нойр хүрвэл өөрийгөө хүчлэн үргэлжлүүлэн жолоо барилгүй нэн даруй амарна.

Аюулгүйн бүсний зөв ашиглалт

Хөдөлгөөн эхлэхийн өмнө жолооч болон бүх зорчигч аюулгүйн бүсийг зөв зүүсэн эсэхийг нягтална. (→X.35)

Бага насны хүүхэд аюулгүйн бүсийг зөв зүүх насанд хүрэх хүртэл хүүхдийн аюулгүйн бүс болон зориулалтын хүүхдийн

суудал ашиглана. (→Х.46)

Толь тохируулах

Автомашины голын толь (тоноглогдсон загварт), дижитал голын толь (тоноглогдсон загварт) болон хажуугийн толинд автомашины арын хэсэг сайн харагдах байдлаар тохируулна. (→Х.165, 166, 175)

Аюулгүйн бүс

Хөдөлгөөн эхлэхийн өмнө жолооч, зорчигч бүр аюулгүйн бүс зүүнэ.

АЮУЛТАЙ

Огцом тоормос, эргэлт, ослын үед үүсэж болох бэртэл гэмтлийн эрсдэлийг бууруулах үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

■ Аюулгүйн бүс зүүж ашиглах

- Бүх зорчигч аюулгүйн бүс зүүсэн эсэхийг нягтална.
- Аюулгүйн бүсийг зөв зүүж хэрэглэнэ.
- Бүс тус бүрийг зөвхөн нэг хүн ашиглана. Бага насны хүүхэдтэй хамт зэрэг нэгээс илүү хүн ашиглахыг хориглоно.
- Lexus нь бага насны хүүхдийг арын суудалд суулгаж аюулгүй бүс зүүх эсвэл тохирох хүүхдийн суудал ашиглахыг зөвлөдөг.
- Өөрт тохиромжтой байрлалд суухын тулд суудлын түшлэгийг хэт налуулж болохгүй. Жолооч болон зорчигч нуруу цэх, арагш шахаж суух үед аюулгүйн бүс хамгийн үр дүнтэй байна.
- Аюулгүйн бүсний мөрний хэсгийг суганы доогуур хийхгүй.
- Аюулгүйн бүсийг ташаагаараа аль болох доогуур бүсэлнэ.
- 3-р эгнээний суудалтай загвар: 3-р эгнээний суудлын аюулгүйн бүс ашиглах үед бүсийг тогтоох дэгээнээс салгана. (→Х.156, 158)


⚠ АЮУЛТАЙ

■ Жирэмсэн эх

Эмчийн зөвлөгөө авч аюулгүйн бүсийг зөв зүүнэ. (→Х.35)

Жирэмсэн эмэгтэй бусад зорчигчийн адил аюулгүйн бүсний ташааны хэсгийг ташаагаараа дайруулан аль болох доор зүүнэ. Бүсний мөрний хэсгийг цээжээрээ дайруулан хангалттай татна. Бүсийг хэвлий, гэдэс дээгүүрээ татаж зүүхээс зайлсхийнэ.

Аюулгүйн бүс зөв зүүгээгүйгээс огцом тоормос, эргэлт эсвэл ослын үед жирэмсэн эхээс гадна ургийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.



■ Бие өвдсөн хүн

Эмчийн зөвлөгөө авч аюулгүйн бүс зөв зүүж хэрэглэнэ. (→Х.35)

■ Автомашинд бага насны хүүхэд байгаа үед


→Х.71

■ Аюулгүйн бүсний гэмтэл, элэгдэл

- Бүс, түгжих хэл, гархийг хаалганд хавчуулан гэмтээж болохгүй.

- Бүс зүсэгдээгүй, сэмрээгүй, эд ангиуд нь сулраагүй эсэхийг тогтмол шалгана. Бүс элэгдэж муудах нь жолооч болон зорчигчийг ноцтой гэмтлээс хамгаалах чадваргүй болох ба бүс гэмтсэн үед шинээр солих хүртэл ашиглахыг хориглоно.
- Бүс зөв түгжигдсэн мөн хуниралдаагүй эсэхийг шалгана. Аюулгүйн бүс хэвийн ажиллахгүй үед Lexus дилертээ нэн даруй хандана.
- Автомашин ноцтой осолд орсон тохиолдолд аюулгүйн бүс болон суудлыг нүдэнд ил харагдах гэмтэлтэй эсэхээс үл хамааран цогцоор нь солино.
- Аюулгүйн бүсийг угсрах, салгах, задлах, өөрчлөх, хаяхаар оролдохыг хориглох ба шаардлагатай бүх засвар үйлчилгээг Lexus дилер дээр хийлгэнэ. Буруу засвар үйлчилгээ бүсний хэвийн ажиллагаа алдагдуулна.

Зөв зүүж ашиглах



- Аюулгүйн бүсний мөрний хэсгийг мөрний дээгүүр татна. Энэ үед аюулгүйн бүс хүзүүнд шүргэлцэхгүй байх эсвэл мөрнөөс унахгүй байхаар тохируулна.
- Ташааны хэсгийг ташаандаа аль болох доор байдлаар

татна.

- Суудлын түшлэгээ тохируулна. Нуруу цэх, арагш шахаж сууна.
- Бүсийг мушгиралдуулж болохгүй.

■ Бага насны хүүхэд бүс зүүх


Аюулгүйн бүс нь насанд хүрсэн хүний биеийн хэмжээнд тохируулан хийгдсэн байдаг.

- Бага насны хүүхэд аюулгүйн бүсийг зөв зүүх насанд хүрэх хүртэл хүүхдийн аюулгүйн бүс, зориулалтын хүүхдийн суудал ашиглана. (→Х.46)
- Бага насны хүүхэд бүсийг зөв зүүх насанд хүрсэн үед аюулгүйн бүсний зөв хэрэглээ хэсэгт заасан зааврыг мөрдөнө. (→Х.34)

■ Аюулгүйн бүсний дүрэм журам

Тухайн улс орны аюулгүйн бүсний дүрэм журмыг баримтлах үүднээс Lexus дилертээ хандаж бүсээ солиулах эсвэл суурилуулна.

Аюулгүйн бүс зүүх, тайлах




- 1 Бүс зүүх үед түгжих хэлийг гархинд хийж чаг гэж дуугарах хүртэл түлхэнэ.
- 2 Гархины товч **A** дарж бүсийг тайлна.

■ Аюулгүйн бүс цоожлогч (ELR)

Автомашин огцом тоормос хийсэн, доржилт авсан зэрэг үед цоожлогч функц аюулгүйн бүсийг цоожилдог. Бүсийг зөөлөн татах үед энэ функц идэвхжихгүй ба бүсийг бүрэн сунгах боломжтой болно.

Аюулгүйн бүсний өндөр тохируулах (урд суудал)



- 1 Суллах товчийг **A** дарангаа бүсний суурийг доош дарна.
- 2 Суллах товчийг **A** дарангаа бүсний суурийг дээш түлхэнэ.

Дуугарах хүртэл шаардагдах хэмжээгээр дээш, доош шилжүүлнэ.

⚠ АЮУЛТАЙ

■ Аюулгүйн бүсний өндөр тохируулагч


Аюулгүйн бүсний мөрний хэсэг жолооч ба зорчигчийн мөрний төв хэсгээр дайрч байгаа эсэхийг цаг ямагт нягтална. Бүс жолооч ба зорчигчийн хүзүүнээс зайтай мөн мөрнөөс доош унахааргүй байрлалд байна. Эсрэг тохиолдолд огцом тоормос, огцом эргэлт, ослын үед бүсний хамгаалах чадвар буурснаас амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэлд хүргэж болзошгүй.

Аюулгүйн бүс буцаан чангалагч

► ERA-GLONASS/EVAK-гүй загвар

Автомашин урд ба хажуу талаараа тодорхой төрлийн хүчтэй мөргөлтөнд өртөх үед урд суудлын аюулгүйн бүс огцом хураагдаж жолооч болон зорчигчийг суудалтай чанга барина.


Энэ функц автомашин урд, хажуу, ар талаараа хүч багатай мөргөлтөд өртсөн, хөмөрсөн үед ажиллахгүй.



► ERA-GLONASS/EVAK-тай загвар

Автомашин урд ба хажуу талаараа тодорхой төрлийн хүчтэй мөргөлтөнд өртөх, хөмрөх үед урд болон 2-р эгнээний захын суудлын аюулгүйн бүс огцом хураагдаж жолооч болон зорчигчийг суудалтай чанга барина.

Энэ функц автомашин урд, хажуу, ар талаараа хүч багатай мөргөлтөд өртсөн үед ажиллахгүй.



■ Ажилласан аюулгүйн бүс буцаан чангалагчийг солих

Автомашин хэд хэдэн мөргөлтөнд өртсөн тохиолдолд бүс буцаан чангалагч зөвхөн эхний мөргөлтийн үед ажиллах ба 2 ба түүнээс хойших мөргөлтийн үед идэвхжихгүй.

■ PCS системтэй уялдаатай аюулгүйн бүс буцаан чангалагч

Мөргөлтийн өмнөх тоормосны PCS систем мөргөлт үүсэх магадлал өндөр гэж тооцоолсон үед аюулгүйн бүс буцаан чангалагч ажиллахад бэлэн байдалд ордог.

⚠ АЮУЛТАЙ

■ Аюулгүйн бүс буцаан чангалагч

Аюулгүйн бүс буцаан татагч идэвхэжсэн үед SRS анхааруулах гэрэл асна. Энэ тохиолдолд аюулгүйн бүсийг дахин ашиглах боломжгүй болох ба Lexus дилер дээр солиулах шаардлагатай.


Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

SRS аюулгүйн дэр

Жолооч, зорчигчдод ноцтой гэмтэл учруулж болзошгүй цохилтод өртсөн үед SRS аюулгүйн дэр дэлгэгдэнэ. Дэр аюулгүйн бүстэй хамт ажиллаж амь нас, эрүүл мэндэд учирч болох ноцтой эрсдэлийг бууруулна.

SRS аюулгүйн дэрний систем

■ SRS аюулгүйн дэрний байрлал



- A** SRS жолоочийн аюулгүйн дэр/урд зорчигчийн аюулгүйн дэр
Жолооч, урд зорчигчийн толгой, цээжин биеийг цохилтоос хамгаална.
- B** SRS өвдөгний аюулгүйн дэр
Жолооч болон урд зорчигчийг хамгаална.
- C** SRS хажуугийн аюулгүйн дэр
Жолооч болон урд зорчигчийн биеийг хамгаална.
- D** SRS хөшигөн аюулгүйн дэр
Урд суудал, арын захын суудлын зорчигчийн толгойг хамгаална.

SRS аюулгүйн дэрний эд ангиудыг зурагт үзүүлэв. Аюулгүйн дэрний мэдрэгчийн иж бүрдэл нь системийг удирддаг. Дэр дэлгэгдэх үед

дэрний дотор химийн урвал явагдаж хоргүй хийгээр дэрийг хормын дотор дүүргэн жолооч, зорчигчийг хамгаалдаг.

■ SRS аюулгүйн дэлгэгдсэн үед

- SRS аюулгүйн дэр өндөр хэмтэй хий ашиглан огцом хурдаар дэлгэгдэх тул дэлгэгдэх үедээ бага зэргийн шалбархай, түлэгдэл, хөхрөлт зэргийг үүсгэж болзошгүй.
- Чанга дуу гарч цагаан нунтаг цацагдана.
- Аюулгүйн дэрний модулийн эд ангиуд (жолооны хүрдийн гол, аюулгүйн дэрний таг, аюулгүйн дэр дэлгэгч) болон дэрний ойр байрлах эд ангиуд халан хэдэн минутын хугацаанд өндөр хэмтэй байж болно. Аюулгүйн дэр мөн адил өндөр хэмтэй байж болно.
- Салхины шил хагарч болзошгүй.
- Бүх хаалганы түгжээ тайлагдана. (→X.120)
- Тоормос, тоормосны гэрэл автоматаар удирдагдана. (→X.426)
- Салоны гэрлүүд асна. (→X.450)
- Ослын дохионы гэрэл автоматаар асна. (→X.524)
- Шатахуун таслагдана. (→X.531)
- ERA-GLONASS/EVAK-тай загвар: Дараах нөхцөлүүд үүссэн үед тус систем ERA-GLONASS/EVAK удирдлагын төв рүү ослын дуудлага хийж автомашины байрлалыг ("SOS" товч дарах шаардлагагүй) мэдээлэх ба оператор энэ үед ослын түвшин болон тусламж шаардлагатай эсэхийг тодруулна. Жолооч болон зорчигч харилцах боломжгүй үед оператор ослын нөхцөл үүссэн гэж үзэн түргэн, онцгой албыг дуудлагад гаргана. (→X.75)
- SRS аюулгүйн дэр ажилласан
- Аюулгүйн бүс буцаан чангалагч ажилласан
- Ноцтой хойд мөргөлтөнд өртсөн
- Автомашин хөмөрсөн
- * Зарим нөхцөлд дуудлага хийгдэхгүй байж болно. (→X.76)

■ SRS аюулгүйн дэр дэлгэгдэх урд талын мөргөлтүүд


- Тогтоосон хэмжээ (20 - 30км/ц [12 - 18 миль/ц] орчим хурдаар хөдөлгөөнгүй хатуу хана урд талаараа мөргөхтэй дүйцэх)-с давсан мөргөлт үүсэх үед SRS урд аюулгүйн дэр дэлгэгдэнэ.
- SRS урд аюулгүйн дэр
- SRS өвдөгний аюулгүйн дэр
- Нөгөөтээгүүр дараах тохиолдлуудад энэхүү хурдны тогтоосон хэмжээ харьцангуй өндөр байж болно:
- Мөргөлт үүсэх үед хөдөлгөөнд орох, хэлбэрээ өөрчлөх объект буюу зогсож буй автомашин эсвэл замын тэмдэг мөргөсөн үед
- Автомашины урд хэсэг ачааны машины тэвшний доогуур орох буюу бусад машины доогуур шургах байдлаар мөргөлдсөн үед
- Мөргөлтийн нөхцөлөөс хамаарч зөвхөн дараах систем ажиллаж болно:
- Аюулгүйн бүс буцаан чангалагч
- Урд талаараа ноцтой мөргөлтөд өртсөн үед 2 талын SRS хөшигөн аюулгүйн дэр мөн дэлгэгдэж болно.

■ Хажуугийн мөргөлтөд SRS аюулгүйн дэр дэлгэгдэх нөхцөлүүд

- Тогтоосон хэмжээ (1500кг (3300 фунт) орчим жинтэй автомашин 20 - 30км/ц [12 - 18 миль/ц] хурдаар автомашины кабиныг хөндлөн чиглэлээс мөргөхтэй дүйцэх)-с давсан мөргөлт үүсэх үед дараах SRS аюулгүйн дэр дэлгэгдэнэ:
- SRS хажуугийн аюулгүйн дэр
- SRS хөшигөн аюулгүйн дэр


■ Доод талаас ирсэн цохилтод SRS аюулгүйн дэр дэлгэгдэх нөхцөлүүд

- Автомашины доод талд хүчтэй цохилт мэдрэгдэх үед дараах аюулгүйн дэрнүүд дэлгэгдэж болно:
- SRS урд аюулгүйн дэр
- SRS өвдөгний аюулгүйн дэр
- SRS хажуугийн аюулгүйн дэр
- SRS хөшигөн аюулгүйн дэр




■ SRS аюулгүйн дэр дэлгэгдэхгүй нөхцөлүүд


- Автомашин хажуу болон хойд талаараа мөргөлтөнд өртсөн, хөмөрсөн эсвэл бага хурдтай үедээ урд талын мөргөлтөнд өртсөн үед дараах дэр дэлгэгдэхгүй. Нөгөөтээгүүр автомашины хурдыг тодорхой хэмжээнээс давуулаад бууруулах мөргөлтийн үед аюулгүйн дэр дэлгэгдэж болно.
- SRS урд аюулгүйн дэр
- SRS өвдөгний аюулгүйн дэр




- SRS хөшигөн аюулгүйн дэртэй загвар: Автомашин тодорхой өнцөгтэй хажуугийн мөргөлт эсвэл зорчигчийн хэсгээс өөр хэсгээрээ хажуугийн мөргөлтөнд өртсөн үед дараах SRS аюулгүйн дэр дэлгэгдэхгүй байж болно:
- SRS хажуугийн аюулгүйн дэр
- SRS хөшигөн аюулгүйн дэр



- Автомашин хөмөрсөн, урд, хойд талын эсвэл бага хурдтай хажуугийн мөргөлтөнд өртсөн үед дараах SRS аюулгүйн дэр дэлгэгдэхгүй:
- SRS хажуугийн аюулгүйн дэр




- Автомашин хөмөрсөн, хойд талын эсвэл бага хурдтай урд, хажуу талын мөргөлтөнд дараах дэр ерөнхийдөө дэлгэгдэхгүй:
- SRS хөшигөн аюулгүйн дэр




■ Lexus дилерт хандах нөхцөл

Дараах тохиолдлуудад автомашинд оношилгоо болон засвар үйлчилгээ хийлгэх шаардлагатай. Lexus дилертээ нэн даруй хандана уу.


- Аль нэг SRS аюулгүйн дэр дэлгэгдсэн
- Автомашины урд хэсэг гэмтсэн, хэлбэрээ алдсан эсвэл дараах SRS аюулгүйн дэр дэлгэгдэхээргүй хэмжээний осолд өртсөн:
- SRS урд аюулгүйн дэр
- SRS өвдөгний аюулгүйн дэр




- Хаалганы зарим хэсэг эсвэл ойр орчим нь гэмтсэн, нүх үүссэн болон хэлбэрээ алдсан эсвэл дараах SRS аюулгүйн дэр дэлгэгдэхээргүй хэмжээний осолд автомашин өртсөн үед:
- SRS хажуугийн аюулгүйн дэр
- SRS хөшигөн аюулгүйн дэр




- Жолооны хүрдний төв хэсэг эсвэл урд зорчигчийн аюулгүйн дэрний ойр орчим эсвэл хянах самбарын доод тал зурагдсан, хагарсан эсвэл бусад гэмтэл авсан үед



- SRS хажуугийн аюулгүйн дэртэй суудлын зөөлөвчний гадаргуу зурагдсан, хагарсан эсвэл бусад гэмтэл авсан үед



- Урд болон хажуу, хойд талын тулгуур багана эсвэл SRS хөшигөн дэр бүхий дээврийн зах хэсэг хагарсан, зурагдсан, гэмтсэн үед



АЮУЛТАЙ

■ SRS аюулгүйн дэрний анхааруулга


Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Жолооч болон бүх зорчигч тус бүрийн аюулгүйн бүс зүүж хэрэглэнэ. SRS аюулгүйн дэр нь аюулгүйн бүстэй хамт ашиглагддаг нэмэлт төхөөрөмж юм.
- Жолоочийн дэр дэлгэгдэх үед дэрнээс 50 - 75 мм (2 - 3 инч.) зай нь эрсдэлтэй бүсэд тооцогдох тул дэрнээс 250 мм (10 инч.)-с зайтай суух нь аюулгүй орчныг бүрдүүлнэ. Тус зай нь жолооны хүрдний төвөөс жолоочийн цээж хүртэлх зай юм. Хэрэв та хүрднээс 250 мм (10 инч.) хүртэлх зайд суудаг бол жолоо барих байрлалаа дараах аргаар өөрчилж болно:
- Дөрөөнд чөлөөтэй хүрэх байдлаар өөрийн суудлаа боломжит хэмжээнд арагш гүйлгэнэ.


! АЮУЛТАЙ

- Суудлыг бага зэрэг арагш налуулна. Жолоочийн суудал урагш тулсан үед ч ихэнх жолооч суудлаа бага зэрэг арагш налуулах төдийд дэрнээс 250 мм (10 инч.) зай барих боломжтой. Суудлыг арагш налуулах нь замын харагдах байдалд сөргөөр нөлөөлж байвал хатуу, гулгадаггүй зөөлөвч ашиглан суудлаа өндөрлөнө. Суудлын өндрийн тохиргоотой автомашины суудлыг өндөр болгоно.
- Боломжтой үед жолооны хүрдийг доош буулгана. Аюулгүйн дэр толгой, хүзүү рүү биш цээж рүү чиглэнэ. Суудлыг дээрх байдлаар тохируулах ба энэ үед дөрөө, жолооны хүрдний ажиллагаа мөн хянах самбарын харагдах байдал сайн байна.
- Урд зорчигчийн SRS аюулгүйн дэр мөн адил хүчтэй дэлгэгдэх ба ялангуяа зорчигч дэрэнд хэт ойр байгаа үед амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай. Тус суудлыг аюулгүйн дэрнээс боломжит хэмжээнд хол, зорчигч цэх суух байдлаар тохируулна.
- Дэлгэгдсэн аюулгүйн дэр суудалд эсвэл хүүхдийн суудалд буруу суусан бага насны хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна. Тиймээс бүх хүүхдийг арын суудалд суулгах, суудлын болон хүүхдийн суудлын бүс зүүхийг Lexus хатуу сануулж байна. Арын суудалд суулгах нь илүү аюулгүй. (→X.46)

- Суудлаа өнцөгдөж суух эсвэл автомашины урд хэсэг руу хэт шахаж сууж болохгүй.



- Бага насны хүүхдийг SRS аюулгүйн дэрний урд зогсоох болон урд зорчигчийн өвөр дээр суулгаж болохгүй.
- Жолооч, урд зорчигч өвөр дээрээ эд зүйлс тавьж болохгүй.



- Хаалга, урд болон дээд хүрээ, хажуугийн болон хойд талын тулгуур багануудыг налж болохгүй.




- Суудал дээр хаалга руу харан сууж толгой, гар зэргээ автомашинаас гаргаж болохгүй.




⚠ АЮУЛТАЙ

- Хянах самбар, хянах самбарын доод тал, жолооны хүрдний төв хэсэгт эд зүйл байрлуулж, налуулж болохгүй.



- Хаалга, салхины шил, хаалганы шил, хажуу ба хойд тулгуур багана, хаалганы дээд хүрээ, бариул зэрэгт эд зүйлс өлгөж болохгүй.



- Хувцас өлгөх дэгээнд хувцасны өлгүүр болон бусад хатуу эд зүйл өлгөж болохгүй. Хөшигөн SRS аюулгүйн дэр дэлгэгдэх үед тэдгээр нь шидэгдэж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй.

- Өвдөгний SRS аюулгүйн дэрний дэлгэгдэх хэсэгт пластик наалт байвал хуулж авна.

- SRS аюулгүйн дэр дэлгэгдэх хэсгийг хаах суудлын нэмэлт хэрэгсэл нь дэр дэлгэгдэхэд саад учруулах тул ашиглахыг хориглоно. Ийм төрлийн нэмэлт хэрэгсэл нь аюулгүйн дэр зөв ажиллахад саад учруулах, системийг ажиллагаагүй болгох эсвэл гэнэт дэлгэгдэхэд хүргэж болзошгүй ба улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй.

- SRS аюулгүйн дэрний эд ангиудын ойр орчим болон урд хаалгыг цохих буюу их хэмжээний хүчний нөлөөнд оруулж болохгүй. Энэ нь SRS аюулгүйн дэрний ажиллагаанд доголдол үүсгэж болзошгүй.

- SRS аюулгүйн дэр дэлгэгдсэн даруйд халсан байж болзошгүй тул дэрний аливаа эд ангид хүрч болохгүй.

- SRS аюулгүйн дэр дэлгэгдсэний дараа амьсгалахад хүндрэлтэй байвал цонх эсвэл хаалга онгойлгож цэвэр агаар оруулах, аюулгүй нөхцөлд автомашиныг орхин гарна. Дэр дэлгэгдэх үед цацагдсан тоосонцор арьсны харшил үүсгэхээс сэргийлж даруй угаана.

- SRS аюулгүйн дэр байрлах хэсгүүд гэмтсэн эсвэл хагарсан үед Lexus-н албан ёсны дилерт хандаж солиулна.

■ SRS аюулгүйн дэрэнд өөрчлөлт хийх, устгалд оруулах

Lexus-н албан ёсны дилерт хандалгүйгээр автомашинаа устгалд оруулах эсвэл дараах өөрчлөлтүүдийг хийж болохгүй. SRS аюулгүйн дэрний ажиллагаанд доголдол үүсгэх эсвэл гэнэт ажиллах (дэлгэгдэх) ба ноцтой гэмтэл мөн үхэлд хүргэж болзошгүй.

- SRS аюулгүйн дэр суурилуулах, салгах, задлах болох засварлах

- Дараах эд анги, ойр орчмыг засварлах, өөрчлөх, салгах буюу солих
- Жолооны хүрд
- Удирдлагын самбар
- Хянах самбар
- Суудал
- Суудлын бүрээс
- Урд багана
- Хажуу багана
- Хойд багана
- Дээд араам

АЮУЛТАЙ

- Урд хаалганы хавтас
- Урд хаалганы араам
- Урд хаалганы спикер
- Урд хаалганы хавтаст өөрчлөлт (нүх гаргах зэрэг) хийх.
- Дараах эд анги, ойр орчмыг засварлах эсвэл өөрчлөх
- Урд крыло
- Урд гупер
- Зорчигчийн хэсгийн хажуу тал
- Дараах эд анги, тоноглол суурилуулах
- Төмөр гупер
- Цас түрэх хусуур
- Лебёдка
- Автомашины тулгуур эд ангийг өөрчлөх
- Радио станц болон CD тоглуулагч зэргийн электрон тоног төхөөрөмж суурилуулах

Хаягдал утааны анхааруулга

Утаа нь аюултай бодис агуулах тул амьсгалсан тохиолдолд аюултай.

АЮУЛТАЙ

Автомашины хаягдал утаанд өнгө болон үнэргүй нүүрстөрөгчийн исэл (CO) агуулагдах тул дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд хаягдал утаа автомашины бүхээгт орж хүний мэдрэлийн тогтолцоонд нөлөөлөх замаар осолд хүргэх эсвэл амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй.

■ Автомашин жолоодох үед анхаарах зүйлс

- Тээшний хаалга хаалттай байна.
- Тээшний хаалга хаалттай үед бүхээгт хаягдал утааны үнэр үнэртвэл цонхоо нээх мөн даруй өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа оношлуулна.
- Авто зогсоолд байрлуулах, удаан зогсолт хийх үед
- Гарааш зэрэг битүү эсвэл агааржуулалт муутай орчинд байх үед хөдөлгүүрийг унтраана.
- Хөдөлгүүрийг удаан хугацаагаар асаалттай байлгахыг хориглоно. Хөдөлгүүрийг зайлшгүй шаардлагаар удаан хугацаанд асаалттай байлгах тохиолдолд автомашиныг задгай талбайд байрлуулах ба яндангаас гарч буй утаа бүхээгт орохгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Цас хунгарласан эсвэл цас орж буй газар хөдөлгүүрийг асаалттай хэвээр орхихыг хориглоно. Асаалттай автомашины ойр орчимд цас хунгарласан үед хаягдал утаа хуримтлагдаж бүхээг рүү орж болзошгүй.

**АЮУЛТАЙ****■ Яндан**

Автомашины яндангийн систем, эд ангиудыг тогтмол шалгана. Янданд зэврэлтээс үүдсэн нүх болон цууралт үүссэн, залгаас хэсэг нь гэмтсэн эсвэл яндангаас хэвийн бус дуу гарч байгаа тохиолдолд өөрийн Lexus дилерт хандаж оношилгоо, засвар хийлгэнэ үү.

Хүүхэд зорчих үед

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Хүүхэд аюулгүйн бүс зөв зүүж хэрэглэх боломжтой болох хүртэл тохирсон хүүхдийн суудлыг ашиглана.

- Араа, шил арчигчид санамсаргүй хүрэхээс зайлсхийж бага насны хүүхдийг арын суудалд суулгах нь зүйтэй.
- Хөдөлгөөний үед бага насны хүүхэд санамсаргүй хаалга цонх нээхээс сэргийлж арын хаалганы хүүхэд хамгаалах түгжээ, цонх түгжих товчийг түгжинэ. (→Х.123, 180)
- Цонх, капот, хаалга, арын хаалга, суудал зэрэг хүний бие хавчих аюултай эд ангитай хүүхэд харьцах, ажиллуулахыг хориглоно.



АЮУЛТАЙ

■ Автомашинд бага насны хүүхэд байгаа үед

Бага насны хүүхдийг автомашинд хараа хяналтгүй үлдээх мөн автомашины түлхүүр өгөх, ашиглуулах зэргийг хориглоно.

Хүүхэд автомашин асаах, арааг сул араанд шилжүүлж болзошгүй. Мөн автомашины цонх, дээврийн нээлхий (тоноглогдсон загварт) бусад эд ангиар тоглон өөрийгөө гэмтээх аюултай. Түүнчлэн бүхээгт хуримтлагдсан хэт халуун буюу хүйтэн температур нь бага насны хүүхдэд үхлийн аюултай.

Хүүхдийн суудал

Хүүхдийн суудал угсрахын өмнө тус гарын авлагын анхааруулга, хүүхдийн суудлын төрлүүд болон угсрах арга зэрэгтэй сайтар танилцана.

- Аюулгүйн бүсийг зөв зүүх боломжгүй бага насны хүүхэд зорчих үед хүүхдийн аюулгүй байдлын үүднээс арын суудалд хүүхдийн суудал угсарч ашиглана. Гарын авлагад заасан дарааллын дагуу хүүхдийн суудал угсарна.
- Илүү аюулгүй байхын тулд тус автомашинд Lexus-н оригинал хүүхдийн суудал ашиглахыг зөвлөж байна. Lexus хүүхдийн суудал нь Lexus автомашинд зориулан хийгдсэн байдаг ба Lexus дилерээс худалдан авах боломжтой.

Гарчиг

Анхаарах зүйлс: Х.47

Хүүхдийн суудал ашиглах үед: Х.48

Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромж: Х.50, 54, 59, 64

Хүүхдийн суудал угсрах: Х.69

- Аюулгүйн бүсээр бэхлэгддэг: Х.70
- ISOFIX хатуу холболтоор бэхлэгддэг: Х.72
- Дээд талдаа бэхэлгээтэй: Х.73

Анхаарах зүйлс

- Хүүхдийн суудалтай холбоотой тухайн улсын хууль дүрмийг Lexus дилерээсээ авна уу.
- Бага насны хүүхэд аюулгүйн бүсийг зөв зүүх нас, биеийн хэмжээнд хүрэх хүртэл хүүхдийн суудал ашиглана.
- Бага насны хүүхдийн нас, биеийн хэмжээнд тохирсон хүүхдийн суудал ашиглана.
- Зарим хүүхдийн суудал автомашинд таардаггүй. Хүүхдийн суудал худалдан авах, ашиглахын өмнө суудлын байрлалтай хэр тохиромжтойг шалгана уу. (→X.50, 54, 59, 64)

**АЮУЛТАЙ****■ Хүүхэд зорчих үед**

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Осол болон огцом тоормосны үед бага насны хүүхдийг сайтар хамгаалахын тулд хүүхдэд биеийн хэмжээ, насанд нь тохирсон аюулгүйн бүс эсвэл хүүхдийн суудал ашиглана. Хэрхэн угсрах тухай дэлгэрэнгүй мэдээллийг хүүхдийн суудлын ашиглалтын гарын авлагаас харна уу. Тус гарын авлагад хүүхдийн суудал угсрах тухай зөвхөн ерөнхий мэдээллийг тусгасан болно.

- Хүүхдийн биеийн хэмжээнд таарсан, тохирох хүүхдийн суудлыг арын суудалд байрлуулан ашиглахыг Lexus танд онцгойлон анхааруулж байна. Ослын статистик мэдээнээс харахад арын суудалд байрлуулсан хүүхдийн суудалд хүүхэд зөв суух нь хамгийн аюулгүй байдаг байна.

- Хүүхдийг гар дээрээ авч явах нь аюулгүй байдлыг хангахгүй. Ослын үед хүүхэд салхины шил мөргөх, тухайн хүн болон автомашины завсар хавчуулагдах зэрэг аюултай.

■ Хүүхдийн суудлын зөв хэрэглээ

Хүүхдийн суудлыг бүрэн гүйцэд, зөв суурилуулаагүйгээс огцом тоормос, эргэлт, ослын үед хүүхэд болон бусад зорчигч гэмтэх улмаар үхэлд хүрэх аюултай.

- Осол аваар зэргээр автомашин хүчтэй мөргөлтөнд өртсөн үед хүүхдийн суудал нүдэнд ил харагдахгүй гэмтсэн байж болно. Энэ тохиолдолд дахин ашиглаж болохгүй.

- Хүүхдийн суудлын төрлөөс хамаарч автомашинд суурилуулахад хүндрэлтэй эсвэл суурилуулж болохгүй байж болно. Энэ тохиолдолд тухайн автомашинд тохирох эсэхийг нягтална. (→X.50, 54, 59, 64) Тус гарын авлага болон хүүхдийн суудал ашиглалтын гарын авлагад заасан хүүхдийн суудал суурилуулах зааврыг сайтар уншиж танилцсаны дараа зөв суурилуулах ба холбогдох дүрэм журмыг мөрдөнө.

- Хүүхдийн суудлыг ашиглаагүй үед ч автомашины суудал дээр зөв бэхэлж суурилуулна. Хүүхдийн суудлыг зорчигчийн хэсэгт бэхэлгээгүй орхиж болохгүй.

- Хүүхдийн суудлыг салгаж авсан тохиолдолд автомашинаас бүрэн гаргах эсвэл тээшний хэсэгт сайтар бэхэлнэ.

Хүүхдийн суудал ашиглах

■ Урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал угсрах

Бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс хүүхдийн суудлыг арын суудалд суурилуулна. Зайлшгүй шаардлагаар урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал суурилуулах тохиолдолд дараах тохиргоог хийнэ.

- Суудлын түшлэгийг чанх босоо байрлалд тохируулна.

Хүүхдийн суудал болон суудлын түшлэг хооронд зай байгаа үед түшлэгийг тохируулж зайгүй болгоно.

- Урд суудлыг хамгийн хойд байрлал хүртэл хойшлуулна. Зорчигчийн суудлын өндөр тохируулах боломжтой үед хамгийн өндөрт тохируулна.
- Хүүхдийн суудалтай суудлын толгойн түшлэг давхцаж байвал толгойн түшлэгийг салгах боломжтой үед салгана. Түшлэгийг салгах боломжгүй үед хамгийн өндөр байрлалд тохируулна.




⚠ АЮУЛТАЙ


■ Хүүхдийн суудал ашиглах үед

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Урд зорчигчийн суудалд хүүхдийн арагш харсан суудал угсрахыг хориглоно. Урд зорчигчийн аюулгүйн дэр ослын үед хүчтэй дэлгэгдэхдээ хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.



- Арагш харсан хүүхдийн суудлыг урд зорчигчийн суудалд угсрах хориотойг анхааруулсан тэмдэг урд зорчигчийн суудлын нарны хаалт дээр байдаг. Тэмдгийн агуулгыг зурагт харуулав.



⚠ АЮУЛТАЙ



⚠ АЮУЛТАЙ

- Урд зорчигчийн суудалд зайлшгүй шаардлагаар хүүхдийн суудал ашиглах үед зөвхөн урагш харсан хүүхдийн суудал угсарна. Урагш харсан хүүхдийн суудлыг урд зорчигчийн суудалд угсрах үед суудлыг арагш тулгана. Эсрэг тохиолдолд аюулгүйн дэр дэлгэгдэх үед хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.




- Хүүхдийн суудал ашиглаж байгаа эсэхээс үл хамааран хаалга, суудлын ойр орчим, урд хойд тулгуур багана болон дээд талын хүрээ зэрэг SRS хажуугийн, SRS хөшигөн аюулгүйн дэр дэлгэгдэх хэсгийг хүүхэд толгой болох биеэрээ налахыг хориглоно. SRS хажуугийн болон хөшигөн аюулгүйн дэр дэлгэгдсэн үед хүүхдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.



- Хүүхдийн суудал (суудал өндөрсөгч) ашиглах үед аюулгүйн бүсний мөрний хэсэг хүүхдийн мөрний төв дээр таарч байгааг тухай бүр шалгах, бүс хүүхдийн хүзүүнээс зайтай байх мөн мөрнөөс унжихгүй хэмжээнд байна.

▲ АЮУЛТАЙ

- Бага насны хүүхдийн нас, биеийн хэмжээнд тохирсон хүүхдийн суудлыг арын суудалд суурилуулж ашиглана.
- Хүүхдийн суудлыг зөв угсрахад жолоочийн суудалд тулж саад болж байвал зүүн талын (баруун жолооны хүрдтэй) эсвэл баруун талын (зүүн жолооны хүрдтэй) арын суудалд хүүхдийн суудал угсарна.



- Урд зорчигчийн суудлыг хүүхдийн суудалд тулах, саад болохгүй байдлаар тохируулна.

Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромж (ASEAN, Латин Америк, Карибын орнуудаас бусад)


■ Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромж

Автомашины суудал ба хүүхдийн суудлын тохиромж (→X.51) нь хүүхдийн суудал болон суурилуулах боломжтой суудлын байрлалыг тэмдгээр харуулдаг. Тухайн сонгосон хүүхдийн суудлыг дараах [Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромжийг шалгахын өмнө]

заасны дагуу шалгана.

■ Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромжийг шалгахын өмнө

- 1 Хүүхдийн суудлын стандартыг шалгана.
Хүүхдийн суудал нь UN(ECE) R44^{*1} эсвэл UN(ECE) R129^{*1},
2 стандартад хамаарна.
Хүүхдийн суудлын стандартын тохирлын тэмдгийг дараах зурагт үзүүлэв.
Хүүхдийн суудлынхаа тохирлын тэмдгийг шалгана уу.



Бүртгэлийн дугаарын жишээг дээрх зурагт үзүүлэв.

- A** UN(ECE) R44 тохирлын тэмдэг^{*3}

UN(ECE) R44 тэмдэгт заасан жингийн бүлэгт хамаарах бага насны хүүхдийн суудал.

- B** UN(ECE) R129 тохирлын тэмдэг^{*3}


UN(ECE) R129 тэмдэгт заасан жин

болон өндрийн бүлэгт хамаарах бага насны хүүхдийн суудал.

2 Хүүхдийн суудлын категорийг шалгана.

Хүүхдийн суудлын тохирлын тэмдгээс дараах аль категорид хамаарахыг шалгана. Нэмэлт мэдээлэл шаардлагатай үед хүүхдийн суудлын хэрэглэгчийн гарын авлагыг шалгах эсвэл борлуулагчаас мэдээлэл авна уу.

- “универсал”
- “хагас универсал”
- “хязгаарлагдмал”
- “Тодорхой автомашины”




*1: UN(ECE) R44 болон UN(ECE) R129 нь НҮБ-с баталсан хүүхдийн суудлын журам болно.

*2: Хүснэгтэд дурдсан хүүхдийн суудал нь EX-с бусад улс орон, бүс нутагт байхгүй байж болно.


*3: Бүтээгдэхүүнээс хамаарч тэмдгийн хэлбэр өөр байж болно.

■ Автомашины суудал ба хүүхдийн суудлын тохиромж:

► Зүүн жолооны хүрдтэй 5 суудалтай загвар



► Зүүн жолооны хүрдтэй 7 суудалтай загвар



1 *1, 2, 3	UF *4
------------	-------


② *2, 3	 
③ *2, 3	 

-  Тухайн жинд зөвшөөрөгдсөн “универсал” хүүхдийн суудалд тохиромжтой.
-  Аюулгүйн бүсээр бэхлэгддэг урагш харсан “универсал” суудалд тохиромжтой.
-  i-Size болон ISOFIX хүүхдийн суудалд тохиромжтой.
-  Дээд талдаа бэхэлгээтэй.
-  Хүүхдийн суудалд тохиромжгүй.
-  Урд зорчигчийн суудалд арагш харсан хүүхдийн суудал ашиглахыг хориглоно.

*1: Урд суудлыг хамгийн хойд

байрлал хүртэл хойшлуулна. Хэрэв тухайн зорчигчийн суудал өндрийн тохиргоотой бол хамгийн өндөр байрлалд тохируулна.

*2: Суудлын түшлэгийг чанх босоо тохируулна. Урагш харсан хүүхдийн суудал угсрах үед хүүхдийн суудал болон суудлын түшлэг хооронд зай гарч байвал түшлэгийг шахаж зайгүй болгоно.



*3: Хүүхдийн суудалтай суудлын толгойн түшлэг давхцаж байвал толгойн түшлэгийг салгах боломжтой үед салгана. Эсвэл толгойн түшлэгийг боломжит өндөр байрлалд тохируулна.

*4: Зөвхөн урагш харсан хүүхдийн суудал ашиглана.

■ Хүүхдийн суудал суурилуулах дэлгэрэнгүй мэдээлэл

Суудлын байрлал			
Суудлын байрлалын дугаар	①	②	③
Аюулгүйн бүсээр бэхлэгддэг универсал категорид тохиромжтой (Тийм/Үгүй)	Тийм Зөвхөн урагш харсан	Тийм	Тийм
i-Size суудлын байрлал (Тийм/Үгүй)	Үгүй	Тийм	Тийм

Суудлын байрлал			
Суудлын байрлалын дугаар	①	②	③
Хажуугийн бэхэлгээнд тохиромжтой суудлын байрлал (L1/L2/Үгүй)	Үгүй	Үгүй	Үгүй
Арагш харсан бэхэлгээнд тохиромжтой (R1/R2X/R2/R3/Үгүй)	Үгүй	R1, R2X, R2, R3	R1, R2X, R2, R3
Урагш харсан бэхэлгээнд тохиромжтой (F2X/F2/F3/Үгүй)	Үгүй	F2X, F2, F3	F2X, F2, F3
Суудал өндөрсөгчид тохиромжтой (B2/B3/Үгүй)	B2, B3 Зөвхөн бүсээр бэхлэгддэг	B2, B3	B2, B3

ISOFIX хүүхдийн суудал нь олон төрлийн “бэхэлгээний ангилал”-тай дээрх хүснэгтэд суудлын ямар байрлалд аль төрлийн бэхэлгээтэй хүүхдийн суудал ашиглах боломжтойг харуулав. Бэхэлгээний ангиллыг дараах хүснэгтээс харна уу.


Хүүхдийн суудал нь “бэхэлгээний ангилал”-гүй (дараах хүснэгтэд тохирох мэдээлэл байхгүй үед), тохиромжтой “автомашины жагсаалт”-н мэдээлэл ашиглах эсвэл хүүхдийн суудлын дэлгүүрээс асууна.

Бэхэлгээ	Дэлгэрэнгүй мэдээлэл
F3	Бүтэн өндөртэй, урагш харсан хүүхдийн суудал
F2	Хагас өндөртэй, урагш харсан хүүхдийн суудал
F2X	Хагас өндөртэй, урагш харсан хүүхдийн суудал
R3	Бүтэн өндөртэй, арагш харсан хүүхдийн суудал
R2	Хагас өндөртэй, арагш харсан хүүхдийн суудал
R2X	Хагас өндөртэй, арагш харсан хүүхдийн суудал
R1	Бага насны хүүхдийн арагш харсан суудал
L1	Нярай хүүхдийн зүүн тийш харсан хөндлөн суудал
L2	Нярай хүүхдийн баруун тийш харсан хөндлөн суудал
B2	Суудал өндөрсөгч
B3	Суудал өндөрсөгч

Арын суудалд зарим хүүхдийн суудал ашиглах үед хажуу

суудлын аюулгүйн бүсийг зөв зүүх боломжгүй болох зэргээр бүсний хэвийн ажиллагаа алдагддаг. Аюулгүйн бүс зорчигчийн мөр ба ташаагаар зөв бүслэгдсэн эсэхийг нягтална. Бүс буруу бүслэгдэхээр эсвэл хүүхдийн суудалтай шүргэлцэж байвал суудлыг өөр байрлалд шилжүүлнэ. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Арын суудалд хүүхдийн суудал угсрах үед урд суудлыг хүүхдийн суудлаас зайтай байдлаар тохируулна.
- Хүүхдийн суудлыг бэхлэх цэгт холбох үед хүүхдийн суудал суудлын түшлэгт тулбал түшлэгийг арагш налуулна.
- Аюулгүйн бүсний мөрний гархи хүүхдийн аюулгүйн бүсний чиглүүлэгчээс урагш үед суудлын түшлэгийг урагшлуулна.



- Суудал өндөрсөгч ашиглах үед хүүхдийн нурууны байрлал хэт цэх байвал суудлын түшлэгийг биед тохиромжтой

байдалд тохируулна. Мөн аюулгүйн бүсний мөрний гархи хүүхдийн аюулгүйн бүсний чиглүүлэгчээс урагш байвал түшлэгийг урагшлуулна

Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромж (ASEAN-н орнууд)

■ Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромж


Автомашинны суудал ба хүүхдийн суудлын тохиромж (→X.55) нь хүүхдийн суудал болон суурилуулах боломжтой суудлын байрлалыг тэмдгээр харуулдаг. Мөн ашиглахыг зөвлөсөн хүүхдийн суудлын мэдээллийг харуулсан болно. Үүнээс гадна [Ашиглахыг зөвлөсөн хүүхдийн суудал ба тохиромж] хэсгээс зөвлөж буй хүүхдийн суудлын мэдээллийг авна уу. (→X.58) Тухайн сонгосон хүүхдийн суудлыг дараах [Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромжийг шалгахын өмнө] заасны дагуу шалгана.

■ Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромжийг шалгахын өмнө

- 1 Хүүхдийн суудлын стандартыг шалгана.
Хүүхдийн суудал нь UN(ECE) (ECE) R44*¹ эсвэл UN(ECE) R129*^{1, 2} стандартад

хамаарна.

Хүүхдийн суудлын стандартын тохирлын тэмдгийг дараах зурагт үзүүлэв. Хүүхдийн суудалд бэхлэгдсэн тохирлын тэмдгийг шалгана уу.



Бүртгэлийн дугаарын жишээг дээрх зурагт үзүүлэв.

A UN(ECE) R44 тохирлын тэмдэг*³

UN(ECE) R44 тэмдэгт заасан жингийн бүлэгт хамаарах бага насны хүүхдийн суудал.

B UN(ECE) R129 тохирлын тэмдэг*³


UN(ECE) R129 тэмдэгт заасан жин болон өндрийн бүлэгт хамаарах бага насны хүүхдийн суудал.

2 Хүүхдийн суудлын категорийг шалгана.

Хүүхдийн суудлын тохирлын тэмдгээс дараах аль категорид хамаарахыг шалгана. Нэмэлт мэдээлэл шаардлагатай үед хүүхдийн суудлын хэрэглэгчийн гарын авлагыг

шалгах эсвэл борлуулагчаас мэдээлэл авна уу.

- “универсал”
- “хагас универсал”
- “хязгаарлагдмал”
- “Тодорхой автомашины”




*1: UN(ECE) R44 болон UN(ECE) R129 нь НҮБ-с баталсан хүүхдийн суудлын журам болно.

*2: Хүснэгтэд дурдсан хүүхдийн суудал нь ЕХ-с бусад улс орон, бүс нутагт байхгүй байж болно.


*3: Бүтээгдэхүүнээс хамаарч тэмдгийн хэлбэр өөр байж болно.

■ **Автомашины суудал ба хүүхдийн суудлын тохиромж**


► Зүүн жолооны хүрдтэй 5 суудалтай загвар




- Баруун жолооны хүрдтэй 5 суудалтай загвар



- Зүүн жолооны хүрдтэй 7 суудалтай загвар



- Баруун жолооны хүрдтэй 7 суудалтай загвар



① *1, 2, 3	UF*4
② *2, 3	U L
③ *2, 3	U L



Тухайн жинд зөвшөөрөгдсөн “универсал” хүүхдийн суудалд тохиромжтой.



Аюулгүйн бүсээр бэхлэгддэг урагш харсан “универсал” хүүхдийн суудалд тохиромжтой.



Тохирох хүүхдийн суудлын хүснэгтэд заасан хүүхдийн суудалд тохиромжтой.
(→X.58)



i-Size болон ISOFIX хүүхдийн суудалд тохиромжтой.



Дээд талдаа бэхэлгээтэй.



Хүүхдийн суудалд тохиромжгүй.




Урд зорчигчийн суудалд урагш харсан хүүхдийн суудал ашиглахыг хориглоно.

*1: Урд суудлыг хамгийн хойд байрлал хүртэл хойшлуулна. Хэрэв тухайн зорчигчийн суудал өндрийн тохиргоотой бол хамгийн өндөр байрлалд тохируулна.

*2: Суудлын түшлэгийг чанх босоо

тохируулна. Урагш харсан хүүхдийн суудал угсрах үед хүүхдийн суудал болон суудлын түшлэг хооронд зай гарч байвал түшлэгийг шахаж зайгүй болгоно.



*3. Хүүхдийн суудалтай суудлын толгойн түшлэг давхцаж байвал толгойн түшлэгийг салгах боломжтой үед салгана. Эсвэл толгойн түшлэгийг боломжит өндөр байрлалд тохируулна.

*4. Зөвхөн урагш харсан хүүхдийн суудал ашиглана.

■ Хүүхдийн суудал суурилуулах дэлгэрэнгүй мэдээлэл

Суудлын байрлал			
Суудлын байрлалын дугаар	①	②	③
Аюулгүйн бүсээр бэхлэгддэг универсал категорид тохиромжтой (Тийм/Үгүй)	Тийм Зөвхөн урагш харсан	Тийм	Тийм
i-Size суудлын байрлал (Тийм/Үгүй)	Үгүй	Тийм	Тийм
Хажуугийн бэхэлгээнд тохиромжтой суудлын байрлал (L1/L2/Үгүй)	Үгүй	Үгүй	Үгүй
Арагш харсан бэхэлгээнд тохиромжтой (R1/R2X/R2/R3/Үгүй)	Үгүй	R1, R2X, R2, R3	R1, R2X, R2, R3
Урагш харсан бэхэлгээнд тохиромжтой (F2X/F2/F3/Үгүй)	Үгүй	F2X, F2, F3	F2X, F2, F3
Суудал өндөрсөгчид тохиромжтой (B2/B3/Үгүй)	B2, B3 Зөвхөн бүсээр бэхлэгддэг	B2, B3	B2, B3

ISOFIX хүүхдийн суудал нь олон төрлийн “бэхэлгээний ангилал”-д хуваагддаг ба дараах хүснэгтэд заасан суудлын байрлалд хүүхдийн суудал ашиглаж болно. Таны ашиглах гэж буй хүүхдийн суудал нь “бэхэлгээний ангилал”-гүй

(эсвэл дараах хүснэгтэд тохирох мэдээлэл байхгүй үед), тохиромжтой “автомашины жагсаалт” дахь мэдээллийг ашиглах эсвэл тухайн хүүхдийн суудлын борлуулагчаас тодруулна.

Бэхэлгээ	Дэлгэрэнгүй мэдээлэл
F3	Бүтэн өндөртэй, урагш харсан хүүхдийн суудал
F2	Хагас өндөртэй, урагш харсан хүүхдийн суудал
F2X	Хагас өндөртэй, урагш харсан хүүхдийн суудал
R3	Бүтэн өндөртэй, арагш харсан хүүхдийн суудал
R2	Хагас өндөртэй, арагш харсан хүүхдийн суудал
R2X	Хагас өндөртэй, арагш харсан хүүхдийн суудал
R1	Бага насны хүүхдийн арагш харсан суудал
L1	Нярай хүүхдийн зүүн тийш харсан хөндлөн суудал
L2	Нярай хүүхдийн баруун тийш харсан хөндлөн суудал
B2	Суудал өндөрсөгч
B3	Суудал өндөрсөгч

■ Ашиглахыг зөвлөсөн хүүхдийн суудал ба тохиромж

	Тохиромжтой хүүхдийн суудал	Суудлын байрлал		
		①	②	③
i-Size хүүхдийн суудал	i-Size MIDI (Тийм/Үгүй)	Үгүй	Тийм	Тийм

Хүснэгтэд дурдсан хүүхдийн суудал ASEAN-с өөр бүс нутагт байхгүй байж болно.


Арын суудалд зарим төрлийн хүүхдийн суудал ашиглах үед хажуугийн суудлын аюулгүйн бүсийг зөв зүүх буюу аюулгүйн бүсний хэвийн ажиллагаа алдагддаг. Аюулгүйн бүс зорчигчийн мөр болон ташаагаар зөв бүслэгдсэнийг нягтална. Аюулгүйн бүс буруу бүслэгдсэн эсвэл хүүхдийн суудалтай шүргэж байвал хүүхдийн суудлыг

өөр байрлалд шилжүүлнэ. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Арын суудалд хүүхдийн суудал угсрах үед урд суудлыг бага насны хүүхэд эсвэл хүүхдийн суудлаас зайтай байдлаар тохируулна.
- Хүүхдийн суудлыг бэхлэх цэгт холбох үед суудлын түшлэгт тулж байвал түшлэгийг арагш

налуулж тохируулна.

- Аюулгүйн бүсний мөрний гархи хүүхдийн аюулгүйн бүсний чиглүүлэгчээс урагш үед суудлын түшлэгийг урагшлуулна.



- Суудал өндөрсөгч ашиглах үед хүүхдийн нурууны байрлал хэт цэх байвал суудлын түшлэгийг биед тохиромжтой байдлаар тохируулна. Аюулгүйн бүсний мөрний гархи хүүхдийн аюулгүйн бүсний чиглүүлэгчээс урагш үед суудлын түшлэгийг урагшлуулна.

Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромж (Латин Америк, Карибын орнууд)


- Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромж

Автомашины суудал ба хүүхдийн суудлын тохиромж (→Х.60) нь хүүхдийн суудал болон суурилуулах боломжтой суудлын байрлалыг тэмдгээр харуулдаг.

Мөн ашиглахыг зөвлөсөн хүүхдийн суудлын мэдээллийг харуулсан болно. Үүнээс гадна [Ашиглахыг зөвлөсөн хүүхдийн суудал ба тохиромж] хэсгээс зөвлөж буй хүүхдийн суудлын мэдээллийг авна уу. (→Х.63) Тухайн сонгосон хүүхдийн суудлыг дараах [Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромжийг шалгахын өмнө] заасны дагуу шалгана.

- Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромжийг шалгахын өмнө

- 1 Хүүхдийн суудлын стандартыг шалгана.
Хүүхдийн суудал нь UN(ECE) R44*1, эсвэл UN(ECE) R129*1, 2 стандартад хамаарна. Хүүхдийн суудлын стандартын тохирлын тэмдгийг дараах зурагт үзүүлэв.




Бүртгэлийн дугаарын жишээг дээрх зурагт үзүүлэв.

A UN(ECE) R44 тохирлын тэмдэг^{*3}
UN(ECE) R44 тэмдэгт заасан жингийн бүлэгт хамаарах бага насны хүүхдийн суудал.

B UN(ECE) R129 тохирлын тэмдэг^{*3}
UN(ECE) R129 тэмдэгт заасан жин болон өндрийн бүлэгт хамаарах бага насны хүүхдийн суудал.

2 Хүүхдийн суудлын категорийг шалгана.
Хүүхдийн суудлын тохирлын тэмдгээс дараах аль категорид хамаарахыг шалгана. Нэмэлт мэдээлэл шаардлагатай үед хүүхдийн суудлын хэрэглэгчийн гарын авлагыг шалгах эсвэл борлуулагчаас мэдээлэл авна уу.

- “универсал”
- “хагас универсал”
- “хязгаарлагдмал”
- “Тодорхой автомашины”



^{*1}: UN(ECE) R44 болон UN(ECE) R129 нь НҮБ-с баталсан хүүхдийн суудлын журам болно.


^{*2}: Хүснэгтэд дурдсан хүүхдийн суудал нь EX-с бусад улс орон, бүс

нутагт байхгүй байж болно.


^{*3}: Бүтээгдэхүүнээс хамаарч тэмдгийн хэлбэр өөр байж болно.

■ Автомашины суудал ба хүүхдийн суудлын тохиромж


► 5 суудалтай загвар



► 6 суудалтай загвар



► 7 суудалтай загвар



① *1, 2, 3	UF*4
② *2, 3	 
③ *2, 3	 



Тухайн жинд зөвшөөрөгдсөн “универсал” хүүхдийн суудалд тохиромжтой.



Аюулгүйн бүсээр бэхлэгддэг урагш харсан “универсал” хүүхдийн суудалд тохиромжтой.



Тохирох хүүхдийн суудлын хүснэгтэд заасан хүүхдийн суудалд тохиромжтой.
(→X.63)



i-Size болон ISOFIX хүүхдийн суудалд тохиромжтой.



Дээд талдаа бэхэлгээтэй.



Хүүхдийн суудалд тохиромжгүй.




Урд зорчигчийн суудалд урагш харсан хүүхдийн суудал ашиглахыг хориглоно.

*1: Урд суудлыг хамгийн хойд байрлал хүртэл хойшлуулна. Хэрэв тухайн зорчигчийн суудал өндрийн тохиргоотой бол хамгийн өндөр байрлалд тохируулна.

*2: Суудлын түшлэгийг чанх босоо

тохируулна. Урагш харсан хүүхдийн суудал угсрах үед хүүхдийн суудал болон суудлын түшлэг хооронд зай гарч байвал түшлэгийг шахаж зайгүй болгоно.



*3: Хүүхдийн суудалтай суудлын толгойн түшлэг давхцаж байвал толгойн түшлэгийг салгах боломжтой үед салгана. Эсвэл толгойн түшлэгийг боломжит өндөр байрлалд тохируулна.

*4: Зөвхөн урагш харсан хүүхдийн суудал ашиглана.

■ Хүүхдийн суудал суурилуулах дэлгэрэнгүй мэдээлэл

Суудлын байрлал			
Суудлын байрлалын дугаар	①	②	③
Аюулгүйн бүсээр бэхлэгддэг универсал категорид тохиромжтой (Тийм/Үгүй)	Тийм Зөвхөн урагш харсан	Тийм	Тийм
i-Size суудлын байрлал (Тийм/Үгүй)	Үгүй	Тийм	Тийм
Хажуугийн бэхлэгээнд тохиромжтой суудлын байрлал (L1/L2/Үгүй)	Үгүй	Үгүй	Үгүй
Арагш харсан бэхлэгээнд тохиромжтой (R1/R2X/R2/R3/Үгүй)	Үгүй	R1, R2X, R2, R3	R1, R2X, R2, R3
Урагш харсан бэхлэгээнд тохиромжтой (F2X/F2/F3/Үгүй)	Үгүй	F2X, F2, F3	F2X, F2, F3
Суудал өндөрсөгчид тохиромжтой (B2/B3/Үгүй)	B2, B3 Зөвхөн бүсээр бэхлэгддэг	B2, B3	B2, B3

ISOFIX хүүхдийн суудал нь олон төрлийн “бэхлэгээний ангилал”-д хуваагддаг ба дараах хүснэгтэд заасан суудлын байрлалд хүүхдийн суудал ашиглаж болно.

Таны ашиглах гэж буй хүүхдийн суудал нь “бэхлэгээний ангилал”-гүй (эсвэл дараах хүснэгтэд тохирох мэдээлэл байхгүй үед), тохиромжтой “автомашинны жагсаалт” дахь мэдээллийг ашиглах эсвэл тухайн хүүхдийн суудлын борлуулагчаас тодруулна.

Бэхэлгээ	Дэлгэрэнгүй мэдээлэл
F3	Бүтэн өндөртэй, урагш харсан хүүхдийн суудал
F2	Хагас өндөртэй, урагш харсан хүүхдийн суудал
F2X	Хагас өндөртэй, урагш харсан хүүхдийн суудал
R3	Бүтэн өндөртэй, арагш харсан хүүхдийн суудал
R2	Хагас өндөртэй, арагш харсан хүүхдийн суудал
R2X	Хагас өндөртэй, арагш харсан хүүхдийн суудал
R1	Бага насны хүүхдийн арагш харсан суудал

Бэхэлгээ	Дэлгэрэнгүй мэдээлэл
L1	Нярай хүүхдийн зүүн тийш харсан хөндлөн суудал
L2	Нярай хүүхдийн баруун тийш харсан хөндлөн суудал
B2	Суудал өндөрсгөгч
B3	Суудал өндөрсгөгч

■ Ашиглахыг зөвлөсөн хүүхдийн суудал ба тохиромж


	Тохиромжтой хүүхдийн суудал	Суудлын байрлал		
		①	②	③
i-Size хүүхдийн суудал	i-Size MIDI (Тийм/Үгүй)	Үгүй	Тийм	Тийм

Хүснэгтэд дурдсан хүүхдийн суудал Латин Америк, Карибын орнуудаас өөр бүс нутагт байхгүй байж болно.

Арын суудалд зарим төрлийн хүүхдийн суудал ашиглах үед хажуугийн суудлын аюулгүйн бүсийг зөв зүүх буюу аюулгүйн бүсний хэвийн ажиллагаа алдагддаг. Аюулгүйн бүс зорчигчийн мөр болон ташаагаар зөв бүслэгдсэн эсэхийг нягтална. Аюулгүйн бүс буруу бүслэгдсэн эсвэл хүүхдийн суудалтай шүргэж байвал хүүхдийн суудлыг өөр байрлалд шилжүүлнэ. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Арын суудалд хүүхдийн суудал угсрах үед урд суудлыг бага насны хүүхэд эсвэл хүүхдийн суудлаас зайтай байдлаар тохируулна.
- Хүүхдийн суудлыг бэхлэх цэгт холбох үед суудлын түшлэгт тулж байвал түшлэгийг арагш налуулж тохируулна.

- Аюулгүйн бүсний мөрний гархи хүүхдийн аюулгүйн бүсний чиглүүлэгчээс урагш үед суудлын түшлэгийг урагшлуулна.



- Суудал өндөрсгөгч ашиглах үед хүүхдийн нурууны байрлал хэт цэх байвал суудлын түшлэгийг биед тохиромжтой байдлаар тохируулна. Аюулгүйн бүсний мөрний гархи хүүхдийн аюулгүйн бүсний чиглүүлэгчээс урагш үед суудлын түшлэгийг урагшлуулна.

Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромж (Европ)

■ Хүүхдийн суудал ба автомашины суудлын тохиромж

Автомашинны суудал ба хүүхдийн суудлын тохиромж (→Х.65) нь хүүхдийн суудал болон суурилуулах боломжтой суудлын байрлалыг тэмдгээр харуулдаг.


Мөн ашиглахыг зөвлөсөн хүүхдийн суудлын мэдээллийг харуулсан болно. Үүнээс гадна [Ашиглахыг зөвлөсөн хүүхдийн суудал ба тохиромж] хэсгээс зөвлөж буй хүүхдийн суудлын мэдээллийг авна уу. (→Х.65)

Тухайн сонгосон хүүхдийн суудлыг дараах [Хүүхдийн суудал ба автомашинны суудлын тохиромжийг шалгахын өмнө] заасны дагуу шалгана.

■ Хүүхдийн суудал ба автомашинны суудлын тохиромжийг шалгахын өмнө

- 1 Хүүхдийн суудлын стандартыг шалгана.
Хүүхдийн суудал нь UN(ECE) (ECE) R44^{*1} эсвэл UN(ECE) R129^{*1, 2} стандартад хамаарна.
Хүүхдийн суудлын стандартын тохирлын тэмдгийг дараах зурагт үзүүлэв. Хүүхдийн


суудалд бэхлэгдсэн тохирлын тэмдгийг шалгана уу.



Бүртгэлийн дугаарын жишээг дээрх зурагт үзүүлэв.

- A** UN(ECE) R44 тохирлын тэмдэг^{*3}
UN(ECE) R44 тэмдэгт заасан жингийн бүлэгт хамаарах бага насны хүүхдийн суудал.
 - B** UN(ECE) R129 тохирлын тэмдэг^{*3}
UN(ECE) R129 тэмдэгт заасан жин болон өндрийн бүлэгт хамаарах бага насны хүүхдийн суудал.
- 2 Хүүхдийн суудлын категорийг шалгана.
Хүүхдийн суудлын тохирлын тэмдгээс дараах аль категорид хамаарахыг шалгана. Нэмэлт мэдээлэл шаардлагатай үед хүүхдийн суудлын хэрэглэгчийн гарын авлагыг шалгах эсвэл борлуулагчаас мэдээлэл авна уу.
- “универсал”

- “хагас универсал”
- “хязгаарлагдмал”
- “Тодорхой автомашины”




*1: UN(ECE) R44 болон UN(ECE) R129 нь НҮБ-с баталсан хүүхдийн суудлын журам болно.

*2: Хүснэгтэд дурдсан хүүхдийн суудал нь EX-с бусад улс орон, бүс нутагт байхгүй байж болно.

*3: Бүтээгдэхүүнээс хамаарч тэмдгийн хэлбэр өөр байж болно.

■ Автомашины суудал ба хүүхдийн суудлын тохиромж



Урд зорчигчийн аюулгүйн дэр идэвхтэй.



Аюулгүйн дэр гар аргаар унтраах товч ON горимд байгаа үед урд зорчигчийн суудалд арагш харсан хүүхдийн суудал угсарч болохгүй.



Тухайн жинд зөвшөөрөгдсөн “универсал” хүүхдийн суудалд тохиромжтой.



Аюулгүйн бүсээр бэхлэгддэг урагш харсан “универсал” хүүхдийн суудалд тохиромжтой.



Тохирох хүүхдийн суудлын хүснэгтэд заасан хүүхдийн суудалд тохиромжтой. (→X.68)



i-Size болон ISOFIX хүүхдийн суудалд тохиромжтой.




Дээд талдаа бэхэлгээтэй.



Хүүхдийн суудалд тохиромжгүй.

*1: Урд суудлыг хамгийн хойд байрлал хүртэл хойшлуулна. Хэрэв тухайн зорчигчийн суудал өндрийн тохиргоотой бол хамгийн өндөр байрлалд тохируулна.

*2: Суудлын түшлэгийг чанх босоо тохируулна. Урагш харсан хүүхдийн суудал угсах үед хүүхдийн суудал болон суудлын түшлэг хооронд зай гарч байвал түшлэгийг шахаж зайгүй болгоно.



*3: Хүүхдийн суудалтай суудлын толгойн түшлэг давхцаж байвал толгойн түшлэгийг салгах боломжтой үед салгана. Эсвэл толгойн түшлэгийг боломжит өндөр байрлалд тохируулна.

*4: Зөвхөн KIDFIX i-SIZE-д хамаатай.

*5: Тулгууртай хүүхдийн суудалд тохиромжгүй.


Арын суудалд зарим төрлийн хүүхдийн суудал ашиглах үед хажуугийн суудлын аюулгүйн бүсийг зөв зүүх буюу аюулгүйн бүсний хэвийн ажиллагаа алдагддаг. Аюулгүйн бүс зорчигчийн мөр болон ташаагаар зөв бүслэгдсэнийг нягтална. Аюулгүйн бүс буруу бүслэгдсэн эсвэл хүүхдийн суудалтай шүргэж байвал хүүхдийн суудлыг өөр байрлалд шилжүүлнэ. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Арын суудалд хүүхдийн суудал угсрах үед урд суудлыг бага насны хүүхэд эсвэл хүүхдийн суудлаас зайтай байдлаар тохируулна.

- Хүүхдийн суудлыг бэхлэх цэгт холбох үед суудлын түшлэгт тулж байвал түшлэгийг арагш

налуулж тохируулна.

- Аюулгүйн бүсний мөрний гархи хүүхдийн аюулгүйн бүсний чиглүүлэгчээс урагш үед суудлын түшлэгийг урагшлуулна.



- Суудал өндөрсгөгч ашиглах үед хүүхдийн нурууны байрлал хэт цэх байвал суудлын түшлэгийг биед тохиромжтой байдлаар тохируулна. Аюулгүйн бүсний мөрний гархи хүүхдийн аюулгүйн бүсний чиглүүлэгчээс урагш үед суудлын түшлэгийг урагшлуулна.

■ Хүүхдийн суудал суурилуулах дэлгэрэнгүй мэдээлэл

Суудлын байрлал			
Суудлын байрлалын дугаар	① ^{*2}	②	③
Аюулгүйн бүсээр бэхлэгддэг универсал категорид тохиромжтой (Тийм/Үгүй) ^{*1}	Тийм Зөвхөн урагш харсан	Тийм	Тийм
i-Size суудлын байрлал (Тийм/Үгүй)	Үгүй	Тийм	Тийм
Хажуугийн бэхэлгээнд тохиромжтой суудлын байрлал (L1/L2/Үгүй)	Үгүй	Үгүй	Үгүй
Арагш харсан бэхэлгээнд тохиромжтой (R1/R2X/R2/R3/Үгүй)	Үгүй	R1, R2X, R2, R3	R1, R2X, R2, R3
Урагш харсан бэхэлгээнд тохиромжтой (F2X/F2/F3/Үгүй)	Үгүй	F2X, F2, F3	F2X, F2, F3
Суудал өндөрсөгчид тохиромжтой (B2/B3/Үгүй)	B2, B3 Зөвхөн бүсээр бэхлэгддэг	B2, B3	B2, B3

*1: Бүх универсал категори (Бүлэг 0, 0+, I, II ба III).

*2: Тулгууртай хүүхдийн суудалд тохиромжгүй.

Lexus нь ② ба ③ суудлын байрлал ашиглахыг зөвлөдөг.

ISOFIX хүүхдийн суудал нь олон төрлийн “бэхэлгээний ангилал”-тай дээрх хүснэгтэд суудлын ямар байрлалд аль төрлийн бэхэлгээтэй хүүхдийн суудал ашиглах боломжтойг харуулав. Бэхэлгээний ангиллыг дараах хүснэгтээс харна уу.

Хүүхдийн суудал нь “бэхэлгээний ангилал”-гүй (дараах хүснэгтэд тохирох мэдээлэл байхгүй үед), тохиромжтой “автомашины жагсаалт”-н мэдээлэл ашиглах эсвэл хүүхдийн суудлын дэлгүүрээс асууна.

Жингийн бүлэг	Хүүхдийн жин	Хэм-жээ	Бэхэл-гээ	Хүүхдийн суудлын төрөл
0	10кг (22 lb.) хүртэл	E	R1	Бага насны хүүхдийн арагш харсан
		F	L1	Нярай хүүхдийн зүүн тийш харсан хөндлөн
		G	L2	Нярай хүүхдийн баруун тийш харсан хөндлөн

Жин- гийн бүлэг	Хүүхдийн жин	Хэм- жээ	Бэхэл- гээ	Хүүхдийн суудлын төрөл
0+	13кг (28 lb.) хүртэл	C	R3	Бүтэн өндөртэй, арагш харсан
		D	R2	Хагас өндөртэй, арагш харсан
		—	R2X	Хагас өндөртэй, арагш харсан
		E	R1	Бага насны хүүхдийн арагш харсан
I	9 - 18кг (20 - 39 lb.)	A	F3	Бүтэн өндөртэй, урагш харсан
		B	F2	Хагас өндөртэй, урагш харсан
		B1	F2X	Хагас өндөртэй, урагш харсан
		C	R3	Бүтэн өндөртэй, арагш харсан
		D	R2	Хагас өндөртэй, арагш харсан
II	15 - 25кг (34 - 55 lb.)	—	B2, B3	Суудал өндөрсөгч
III	22 - 36 кг (48 - 79 lb.)			

■ Тохиромжтой хүүхдийн суудлын мэдээлэл

Тохиромжтой хүүхдийн суудал	Хэмжээ	Харах чиглэл	Бэхэлгээ	
			Доод талын	Аюулгүйн бүс
MAXI COSI PEARL 360 & FAMILYFIX 360 BASE	40 - 105 см	Арагш харсан	Тийм	Боломжгүй
	17.5 кг (38 lb.) хүртэл			
	15 сар хүртэл 76 - 105 см	Урагш харсан		
	17.5 кг (38 lb.) хүртэл			
LEXUS KIDFIX i-SIZE*1, 2	100 - 150 см	Зөвхөн урагш харсан	Тийм	Тийм
	15 - 36 кг (34 - 79 lb.)			


*1: Аюулгүйн бүсийг SecureGuard дундуур гаргана.

*2: LEXUS нь доод талын бэхэлгээг зөвлөдөг

Хүснэгтэд дурдсан хүүхдийн суудал EX, Нэгдсэн Вант Улсаас өөр бүс нутагт байхгүй байж болно.


● SecureGuard-тай хүүхдийн суудал ашиглах үед зурагт


үзүүлсний дагуу SecureGuard **A** дундуур аюулгүйн бүсний ташааны хэсгийг гаргана.



Хүүхдийн суудал угсрах

Угсрах арга дарааллыг хүүхдийн суудлын ашиглалтын гарын авлагад заасан зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

	Угсрах арга	Хуудас
Аюулгүйн бүсээр бэхэлж угсрах		X.70

Угсрах арга	Хуудас
ISOFIX хатуу бэхлэгээ	 X.72
Дэгээ бэхлэх цэг	 X.73


Аюулгүйн бүсээр бэхлэгд- дэг хүүхдийн суудал

■ Аюулгүйн бүс ашиглан угсрах


Угсрах арга дарааллыг хүүхдийн суудлын ашиглалтын гарын авлагад заасан зааврын дагуу хийж гүйцэтгэнэ. Таны хүүхдийн суудал “универсал” категорид хамаарахгүй (эсвэл хүснэгтэд шаардлагатай мэдээлэл байхгүй) үед хүүхдийн суудлын тохиромжтой “автомашины жагсаалт” дахь мэдээллийг ашиглах эсвэл тухайн хүүхдийн суудлын борлуулагчаас тодруулна. (→X.50, 54, 59, 64)

- 1 Зайлшгүй шаардлагаар урд зорчигчийн суудалд хүүхдийн суудал угсрах үед X.48-д заасан урд суудлын тохиргоог хийнэ.
- 2 Суудлын түшлэгийг чанх босоо тохируулна. Урагш харсан хүүхдийн суудал угсрах үед хүүхдийн суудал болон суудлын түшлэг хооронд зай гарч байвал түшлэгийг шахаж зайгүй болгоно.
- 3 Хүүхдийн суудалтай суудлын толгойн түшлэг давхцаж байвал толгойн түшлэгийг салгах боломжтой үед салгана. Эсвэл толгойн түшлэгийг боломжит өндөр байрлалд тохируулна. (→X.160)

- 4 Аюулгүйн бүсийг хүүхдийн суудал дундуур гаргах ба бүсний хэлийг гархинд хийнэ. Бүс мушгираагүй эсэхийг нягтална. Хүүхдийн суудлын зааварчилгаанд заасны дагуу аюулгүйн бүсээр хүүхдийн суудлыг сайтар бэхэлнэ.



- 5 Хэрэв таны хүүхдийн суудал аюулгүйн бүс түгжигчгүй бол бүсийг хавчаараар хавчиж хөдөлгөөнгүй бэхэлнэ.



- 6 Суудлыг угсарсны дараа нааш цааш татаж хөдөлгөөнгүй болсон эсэхийг нягтална. (→Р.72)

■ Аюулгүйн бүсээр бэхлэгдсэн хүүхдийн суудал салгах

Аюулгүйн бүсний хэлийг доош дарангаа гархины товчийг дарж бүсийг гүйцэд татан авна.

Бүс тайлах үед суудлын зөөлөвчний харих хүчээр хүүхдийн суудал хүчтэй түлхэгдэж болох тул хүүхдийн суудлыг сайтар дарангаа бүс тайлна.

Аюулгүйн бүс өөрөө хураагддаг тул хураах байрлалд зөөлөн буцаана.

■ Хүүхдийн суудал угсрах үед

Хүүхдийн суудал угсрах үед бүс гүйхээс сэргийлсэн хавчаар шаардагдана. Суудлыг хүүхдийн суудлын үйлдвэрлэгчийн гарын авлагад заасны дагуу угсрах ба таны суудалд бүс гүйхээс сэргийлсэн хавчаар дагалдаж ирээгүй тохиолдолд та өөрийн Lexus дилерт хандан дараах кодоор захиалан авах боломжтой.:

Locking clip for child restraint system (Сэлбэгийн дугаар. 73119-22010)



АЮУЛТАЙ

■ Хүүхдийн суудал угсрах үед

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Бага насны хүүхдийг аюулгүйн бүсээр тоглуулахыг хориглоно. Хүүхдийн хүзүүнд бүс орооцолдвол амьсгал нь боогдох, амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай. Дээрх байдал үүсэж бүсний түгжээ тайлагдахгүй байвал бүсийг хайчаар хайчилна.
- Бүсний хэл ба гархи гүйцэд түгжигдсэн, бүс хуниралдаагүй эсэхийг нягтална.
- Хүүхдийн суудлыг урагш хойш, баруун зүүн тийш татаж хөдөлгөөнгүй бэхлэгдсэн эсэхийг шалгана.
- Хүүхдийн суудал угсарсны дараа автомашины суудлын байрлалыг өөрчилж болохгүй.


⚠ АЮУЛТАЙ

- Хүүхдийн суудал (суудал өндөрсөгч) ашиглах үед аюулгүйн бүсний мөрний хэсэг хүүхдийн мөрний төв дээр таарч байгаа эсэхийг тухай бүр шалгах ба бүс хүүхдийн хүзүүнээс зайтай байх мөн мөрнөөс унжихгүй хэмжээнд байна.
- Хүүхдийн суудал үйлдвэрлэгчийн зааварчилгааг баримталж суурилуулна.

ISOFIX хатуу холболтоор бэхлэгддэг хүүхдийн суудал

■ ISOFIX бэхэлгээ (ISOFIX хүүхдийн суудал)

Энэ төрлийн бэхэлгээ нь арын захын суудалд суурилагдсан байдаг. (Бэхэлгээний байрлалыг тэмдгээр илэрхийлэв.)



■ ISOFIX хатуу холболтоор угсрах (ISOFIX хүүхдийн суудал)

Угсрах арга дарааллыг хүүхдийн суудлын ашиглалтын гарын авлагад заасан зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

Хэрэв таны хүүхдийн суудал “универсал” категорид хамаарахгүй (эсвэл хүснэгтэд шаардлагатай мэдээлэл байхгүй) үед хүүхдийн суудлын тохиромжтой “автомашинны жагсаалт” дахь мэдээллийг ашиглах эсвэл тухайн хүүхдийн суудлын борлуулагчаас тодруулна. (→X.50, 54, 59)


1 Суудлын түшлэгийг чанх босоо байрлалд тохируулна.

Урагш харсан хүүхдийн суудал угсрах үед хэрэв хүүхдийн суудал болон суудлын түшлэг хооронд зай байгаа үед түшлэгийг тохируулж зайгүй болгоно.

2 Хүүхдийн суудалтай суудлын толгойн түшлэг давхцаж байвал толгойн түшлэгийг салгах боломжтой үед салгана. Эсвэл толгойн түшлэгийг боломжит өндөр байрлалд тохируулна. (→X.160)


3 Тагийг нээнэ.

Тагийг суудлын зөөлөвч болон түшлэгийн завсарт хийнэ.



- 4 Хатуу бэхэлгээний дэгээний байрлалыг нягтлаад хүүхдийн суудлыг угсарна.

Дэгээ нь суудлын зөөлөвч болон түшлэгийн завсар байрлана.



- 5 Суудлыг угсарсны дараа нааш цааш татаж хөдөлгөөнгүй болсон эсэхийг нягтална. (→P.72)

⚠ АЮУЛТАЙ


■ Хүүхдийн суудал угсрах үед

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Хүүхдийн суудал угсарсны дараа суудлын байрлалыг өөрчилж болохгүй.
- Бэхэлгээний дэгээ ашиглах үед дэгээ болон хүүхдийн суудал завсар гадны биет мөн хүүхдийн суудлын ардуур аюулгүйн бүс хавчуулагдаагүйг нягтална.
- Хүүхдийн суудал үйлдвэрлэгчийн зааварчилгааг баримталж суурилуулна.

■ “i-Size MIDi” хүүхдийн суудал ашиглах үед (ASEAN, Латин Америк, Карибын орнууд)

Тулгуурыг ISOFIX холбогчтой дараах байдлаар холбоно:




- 1 ISOFIX холбогчийг 3-н тоо харагдах байдлаар түгжинэ.
- 2 Тулгуурыг 4 нүх харагдах байдлаар түгжинэ.

Дээд талдаа бэхэлгээтэй хүүхдийн суудал ашиглах

■ Дээд талын бэхэлгээ

2-р эгнээний захын суудлууд нь дээд талын бэхэлгээтэй байдаг.

Дээд талын бэхэлгээтэй хүүхдийн суудал суурилуулахад тус бэхэлгээг ашиглана.



A Дээд талын бэхэлгээ

B Дээд талын бэхэлгээний бүс

■ Бэхэлгээний бүсийг дэгээнд тогтоох

Угсрах арга дарааллыг хүүхдийн суудлын ашиглалтын гарын авлагад заасан зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.


1 Толгойн түшлэгийг хамгийн дээд байрлалд тохируулна.

Хүүхдийн суудал эсвэл дээд бэхэлгээний бүстэй суудлын толгойн түшлэг давхцаж байвал толгойн түшлэгийг салгах боломжтой үед салгана. (→X.160)



2 Дэгээний тагийг нээгээд бүсийг дэгээнд тогтоох ба сайтар чангална.

Бэхэлгээний бүсийг сайтар чангалсан эсэхийг нягтална. (→P.72) Толгойн түшлэгийг дээш өргөж хүүхдийн суудал суурилуулах үед бэхэлгээний бүсийг толгойн түшлэгийн доогуур гаргана.



A Дээд талын бэхэлгээний бүс

B Дэгээ

! АЮУЛТАЙ

■ Хүүхдийн суудал угсрах үед

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Дээд талын бүс гүйцэд түгжигдсэн мөн бүс хуниралдаагүй эсэхийг нягтална.
- Бэхэлгээний бүсийг зориулалтын дэгээнээс өөр газарт бэхэлж болохгүй.
- Хүүхдийн суудал угсарсны дараа суудлын байрлалыг өөрчилж болохгүй.
- Хүүхдийн суудал үйлдвэрлэгчийн зааварчилгааг баримталж хүүхдийн суудлыг автомашинд суурилуулна.
- Толгойн түшлэгийг дээш өргөж хүүхдийн суудал суурилуулах үед бэхэлгээний бүсийг толгойн түшлэгийн доогуур гаргах ба толгойн түшлэгийг доош буцааж буулгахгүй.

! АНХААР

■ Дээд талын бэхэлгээ

Ашиглаагүй үед тагийг таглана. Таг таглаагүй үед бэхэлгээ гэмтэх магадлалтай.

ERA-GLONASS/EVAK^{*1, 2,} 3

^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Ослын дуудлагын үйлчилгээний хамрах хүрээнд ажиллана. Дэлгэрэнгүйг Lexus дилерээсээ тодруулна уу.


^{*3}: Тухайн улсаас хамаарч системийн нэр өөр байдаг

Суурилагдсан төхөөрөмжөөр (GLONASS [Global Navigation Satellite System] болон GPS [Global Positioning System] сигнал ашиглах) автомашины байрлал болон чиглэлийг тодорхойлж зам тээврийн ослын үед яаралтай дуудлага өгөх үүднээс автомашины мэдээллийг (боловсруулалт хийлгүйгээр) ослын дуудлагын үйлчилгээнд дамжуулдаг. Үүнээс гадна гар утасны (GSM) сүлжээ ашиглан ERA-GLONASS/EVAK системийн оператортай ярилцах боломж бүрдүүлдэг

ERA-GLONASS/EVAK удирдлагын төв рүү ослын автомат дуудлага болон ослын дуудлага (“SOS” товч дарах) хийх боломж бүрдүүлдэг.

Тус үйлчилгээ Эдийн Засгийн Холбооны техникийн шаардлагын дагуу суурилагддаг.

Системийн эд ангиуд



A Микрофон

B “SOS” товч^{*}

C Индикаторууд

^{*}: ERA-GLONASS/EVAK системийн оператортай холбогдох товч. Өөр системийн бусад төрлийн SOS нь энэ төхөөрөмжид хамаарахгүй ба ERA-GLONASS/EVAK системийн оператортай холбогдох зориулалтгүй.

Ослын дуудлагын үйлчилгээ

■ Автомат ослын дуудлага

Аль нэг аюулгүйн дэр дэлгэгдсэн үед систем ERA-GLONASS/EVAK удирдлагын төв^{*} рүү автоматаар дуудлага хийдэг. Хүлээн авсан операторт автомашины байршил, осол үүссэн цаг хугацаа, автомашины арлын дугаар илгээгдэх ба оператор үүссэн нөхцөл байдлыг тодруулахаар холбогдоно. Жолооч, зорчигч хариу өгөхгүй тохиолдолд оператор автоматаар ослын дуудлага гэж үзэж хамгийн

ойрын онцгой алба (112 дугаар зэрэг) руу нөхцөл байдлыг мэдээлж тусламж илгээх хүсэлт тавина.

* : Зарим тохиолдолд дуудлага хийгддэггүй. (→X.76)

■ Ослын дуудлага

Онцгой нөхцөл байдалд “SOS” товч дарж ERA-GLONASS/EVAK удирдлагын төв* рүү дуудлага хийнэ. Хүлээн авсан оператор автомашины байрлал тодорхойлж нөхцөл байдлын үнэлгээ хийх ба шаардлагатай тусламж илгээнэ.

“SOS” товч санамсар болгоомжгүй дарсан үед операторт тусламж шаардлагагүй тухай хэлнэ.

* : Зарим тохиолдолд дуудлага хийгддэггүй. (→X.76)

Индикаторууд

Асаах товч ON горимд шилжих үед улаан индикатор гэрэл 10 секунд асаад унтарна. Үргэлжлээд ногоон индикатор асаж өгөгдөл дамжуулах модулийн сервис идэвхэжсэнийг илтгэнэ. Индикаторууд дараах утга илэрхийлнэ:

- Ногоон гэрэл асаж систем идэвхэжсэнийг илтгэнэ.
- Ногоон индикатор гэрэл анивчиж асах нь ослын дуудлага эсвэл автомат ослын дуудлага хийгдэж байгааг илтгэнэ.
- Индикатор асахгүй байх нь

систем идэвхжээгүйг илтгэнэ.

- Асаах товчийг ON горимд шилжүүлснээс бусад үед улаан гэрэл анивчих нь системд доголдол эсвэл зай хураагуурын цэнэг сууж байгааг илтгэнэ. Нөөц зай хураагуурын ашиглалтын хугацаа 3 хүртэлх жил байна.
- Ослын дуудлага хийх үед улаан индикатор 30 секунд анивчих нь дуудлага амжилтгүй болсон эсвэл гар утасны сүлжээ муу байгааг илтгэнэ.

Төхөөрөмж шалгах горим

Ослын дуудлагын системийн ажиллагааг шалгах боломжтой байдаг. Төхөөрөмжийг шалгах үед Lexus дилертээ хандана уу.

■ Free/Open Source Software-н мэдээлэл

Тус бүтээгдэхүүн нь Free/Open Source Software (FOSS)-тэй болно.

FOSS-н лиценз, эх сурвалж зэрэг мэдээллийг дараах холбоосноос авах боломжтой.

<http://www.opensourceautomotive.com/dcm/lexus/19MC/>



АЮУЛТАЙ

■ Ослын дуудлага хийгдэхгүй нөхцөлүүд

- Дараах нөхцөлд ослын дуудлага хийгдэхгүй байж болно. Энэ тохиолдолд онцгой алба (112 дугаар зэрэг) руу ойрын энгийн утаснаас дуудлага хийнэ.



АЮУЛТАЙ

- Гар утасны сүлжээтэй орчинд ч сүлжээ барилт муу эсвэл шугам завгүй байгаагаас ERA-GLONASS/EVAK удирдлагын төв рүү дуудлага хийх боломжгүй байж болно. Энэ нөхцөлд систем eCall удирдлагын төв рүү ослын дуудлага хийх оролдлого хийсэн ч eCall удирдлагын төвтэй холбогдож тусламж дуудах боломжгүй.
- Гар утасны сүлжээгүй орчинд ослын дуудлага хийх боломжгүй.
- Аль нэг холбогдох төхөөрөмжүүд ("SOS" товчны самбар, индикаторууд, микрофон, спикер, DCM, антен эсвэл төхөөрөмжийн холболтын утас) доголдсон, гэмтсэн эсвэл эвдэрсэн үед ослын дуудлага хийх боломжгүй.
- Ослын дуудлага хийх үед систем ERA-GLONASS/EVAK удирдлагын төвтэй холбогдох олон оролдлого хийдэг. Нөгөөтээгүүр радио долгион муу байгаагаас систем гар утасны сүлжээнд холбогдож чадахгүй байх, улмаар систем ERA-GLONASS/EVAK удирдлагын төвтэй холбогдолгүй дуудлага дуусаж болно. Энэ үед дуудлага тасарсныг илтгэж улаан индикатор 30 секунд анивчина.
- Төхөөрөмж хүчтэй цохилтод өртсөн үед дуудлага хийх боломжгүй.
- Зай хураагуурын хүчдэл буурсан эсвэл холболт салгагдсан үед систем ERA-GLONASS/EVAK удирдлагын төвтэй холбогдох боломжгүй.

■ Ослын дуудлагын системийг шинээр сольсон үед

Ослын дуудлагын системийн бүртгэлийг хийлгэх шаардлагатай. Та Lexus дилерт хандана уу.

■ Аюулгүй байдлын төлөө

- Анхааралтай жолоодно уу. Тус функц нь зам тээврийн осол, эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай болох зэрэг онцгой нөхцөлд ослын дуудлага хийхэд туслах функц бөгөөд жолооч, зорчигчийг ямарваа нэгэн байдлаар хамгаалах боломжгүй. Та аюулгүй байдлын төлөө бүсээ зүүж анхааралтай зорчино уу.
- Онцгой байдлын үед өөрийн болон бусдын амь насыг нэгдүгээрт тавина.
- Шатаж буй зүйл болон бусад хэвийн бус үнэр үнэртсэн тохиолдолд автомашиныг орхиж аюулгүй газарт очино.
- Системийн хэвийн ажиллагааны үед аюулгүйн дэр дэлгэгдсэн тохиолдолд систем ослын дуудлага хийнэ. Систем аюулгүйн дэр дэлгэгдээгүй ч ар талаасаа мөргүүлэх эсвэл хөмрөх үед систем ослын дуудлага хийнэ.
- Аюулгүй байдлын үүднээс жолоодлого хийнгээ ослын дуудлага хийж болохгүй. Жолоодлогын үед дуудлага хийх нь санамсар болгоомжгүй осолд хүргэх аюултай бөгөөд жолоогоо алдахад хүргэж болзошгүй. Ослын дуудлага хийхээс өмнө аюулгүй газарт зогсолт хийгээд орчны аюулгүй байдлыг нягтлаад дуудлага хийнэ.
- Гал хамгаалагч солих үед зөвхөн тохирох гал хамгаалагч ашиглана. Тохирохгүй гал хамгаалагч ашигласнаар хэлхээнд оч үсрэх, утаа гарч болзошгүй ба улмаар галын аюулд хүргэнэ.
- Утаа эсвэл хэвийн бус үнэр үнэртэж байгаа үед системийг ашиглах нь галын аюул үүсгэж болзошгүй. Нэн даруй системийг ашиглахаа зогсоож Lexus дилерт хандана уу.

**АНХААР****■ Эвдрэл гэмтлээс сэргийлэх**

“SOS” товчны самбар, спикер зэрэгт шингэн зүйл цацах, цохих гэмтээхээс сэргийлнэ.

**АНХААР****■ Ослын дуудлага, засварын үед “SOS” товчны самбар, спикер, микрофонд доголдол үүссэн үед**

Ослын дуудлага хийж болохгүй байж болзошгүй тул системийн статусыг шалгах эсвэл ERA-GLON-ASS/EVAK удирдлагын төвийн оператортай холбогдоно. Дээрх аль нэг эд анги гэмтсэн нөхцөлд Lexus дилерт хандаж шалгуулна уу.

Хөдөлгүүрийн иммобилайзер систем

Автомашины компьютерт урьдчилан бүртгүүлээгүй үед автомашин асаахаас сэргийлдэг транспондер чип автомашины түлхүүрт суурилагдсан байдаг.


Автомашинаа орхих үедээ түлхүүрээ дотор нь үлдээж огт болохгүй.

Тус систем автомашиныг хулгайд өртөхөөс сэргийлэх зорилготой. Нөгөөтээгүүр систем нь автомашины хулгайн эсрэг үнэмлэхүй хамгаалалт биш юм.

Системийг идэвхжүүлэх

Автомашиныг унтраах үед индикатор гэрэл анивчиж систем ажиллаж буйг илтгэнэ.

Асаах товчийг АСС эсвэл ОН горимд шилжүүлэх үед системийн ажиллагаа цуцлагдсаныг илтгэж индикатор гэрэл унтарна.



■ Системийн засвар үйлчилгээ

Автомашинд засвар үйлчилгээ хийх шаардлагагүй хөдөлгүүрийн иммобилайзер систем суурилагдсан байдаг.

■ Системийг доголдолд хүргэж болзошгүй нөхцөлүүд

- Түлхүүр металл эд зүйлтэй нийлсэн үед
- Өөр автомашины түлхүүр (транспондер чиптэй) ойр орчимд байгаа эсвэл тийм төрлийн түлхүүртэй хамт үед



АНХААР

■ Системийн хэвийн ажиллагааг хангах


Системийн хориглоно.	салгах, Эсрэг	өөрчлөхийг тохиолдолд
системийн хэвийн ажиллагаа алдагдах аюултай.		

Давхар түгжих систем*

*: Тоноглогдсон загварт

Тус систем зөвшөөрөлгүй нэвтрэх оролдлого хийсэн үед дотор болон гадна талаас автомашины түгжээ тайлах функцийг идэвхгүй болгож автомашиныг халдлагаас хамгаална.

Энэхүү систем суурилагдсан автомашины салхины шил болон урд 2 хаалганд холбогдох тэмдэг наагдсан байна.



Давхар түгжих системийг идэвхжүүлэх, цуцлах

■ Идэвхжүүлэх

Хөдөлгүүрийг унтраан бүх зорчигчийг буулгаад бүх хаалга гүйцэд хаана.

Entry функц ашиглах: Хаалганы гадна талын бариулны мэдрэгчид 5 секундийн дотор 2 удаа хүрнэ.

Түлхүүрийн алсын удирдлага ашиглах:  товчийг 5 секундийн дотор 2 удаа дарна.

■ Цуцлах

Entry функц ашиглах: Жолоочийн хаалганы бариулаас удаан барина.

Түлхүүрийн алсын удирдлага ашиглах:  товчийг дарна.

⚠ АЮУЛТАЙ

■ Давхар түгжих системийн анхааруулга

Автомашины хаалга дотор талаас онгойхгүй тул автомашинд хүн байгаа үед идэвхжүүлж болохгүй.

Дохиоллын систем

Автомашин халдлагад өртсөн үед дохиоллын систем анхааруулах дуут дохио дуугаргах, гэрэл анивчуулах байдлаар ажиллана.

Дохиоллын систем идэвхжүүлсэн үед дараах тохиолдлуудад систем ажиллана:

- Армен, Украин, Казахстан, Беларусь, Молдав, Орос, Азербайжан, Гүрж, Киргиз, Малайз, Монгол улсаас бусад: Түгжээтэй үед хаалга, тээшний хаалга эсвэл тээшний хаалганы нээгддэг цонх (тоноглогдсон загварт)-г Entry функц, түлхүүрийн алсын удирдлага, механик түлхүүр ашиглалгүй нээсэн үед (Хаалга автоматаар буцаж түгжигдэнэ)
- Армен, Украин, Казахстан, Беларусь, Молдав, Орос, Азербайжан, Гүрж, Киргиз, Малайз, Монгол улс: Түгжээтэй үед хаалга, тээшний хаалга эсвэл тээшний хаалганы нээгддэг цонх (тоноглогдсон загварт)-г Entry функц, түлхүүрийн алсын удирдлага ашиглалгүй нээсэн үед (Хаалга автоматаар буцаж түгжигдэнэ)
- Капот нээх үед
- Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч автомашин дотор хөдөлгөөн мэдэрсэн. (Автомашинд хүн нэвтэрсэн)
- Хазайлтын мэдрэгч автомашин хазайсныг мэдэрсэн.

Дохиоллын систем идэвхижүүлэх/цуцлах/зогсоох

■ Түгжихийн өмнө шалгах зүйл

Систем санамсаргүйгээр идэвхжих болон автомашины хулгайгаас сэргийлж дараах зүйлсийг нягтална:

- Автомашинд хүн үлдээгүй.
- Дохиолол идэвхжүүлэхээс өмнө цонх, дээврийн нээлхий (тоноглогдсон загварт) хаагдсан.
- Үнэт эдлэл, хувийн эд зүйлсээ автомашинд үлдээгээгүй.


■ Идэвхжүүлэх

- Армен, Украин, Казахстан, Беларусь, Молдав, Орос, Азербайжан, Гүрж, Киргиз, Малайз, Монгол улсаас бусад

Бүх хаалга, капот зэргийг хаагаад түгжинэ.

Систем автоматаар 30 секундийн дараа идэвхэжнэ.

Хэвийн горимоор асаж байсан индикатор гэрэл анивчиж асна.




- ▶ Армен, Украин, Казахстан, Беларусь, Молдав, Орос, Азербайжан, Гүрж, Киргиз, Малайз, Монгол улс

Бүх хаалга, тээшний хаалганы нээгддэг цонх (тоноглогдсон загварт), капот хаагаад entry функц эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар түгжинэ.

Систем автоматаар 30 секундийн дараа идэвхэжнэ.

Хэвийн горимоор асаж байсан индикатор гэрэл анивчж асна.



■ Цуцлах эсвэл зогсоох

Дараах аль нэг үйлдлийг хийж гүйцэтгэнэ:

- ▶ Армен, Украин, Казахстан, Беларусь, Молдав, Орос, Азербайжан, Гүрж, Киргиз, Малайз, Монгол улсаас бусад
- Хаалганы түгжээ тайлна.
- Асаах товчийг АСС эсвэл ON-д шилжүүлэх эсвэл хөдөлгүүр асаана. (Дохиоллын систем хэдэн секундийн дараа цуцлагдах буюу зогсоно.)

- ▶ Армен, Украин, Казахстан, Беларусь, Молдав, Орос, Азербайжан, Гүрж, Киргиз, Малайз, Монгол улс

- Entry функц эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар түгжээ тайлна.
- Хөдөлгүүр асаана. (Дохиоллын систем хэдэн секундийн дараа цуцлагдах буюу зогсоно.)

■ Дохиоллын систем идэвхжүүлэх

Капот нээлттэй байсан ч бүх хаалгыг түгжин дохиоллын системийг идэвхжүүлэх боломжтой.


■ Системийн засвар үйлчилгээ

Автомашинд засвар үйлчилгээ шаардлагагүй систем суурилагдсан.


■ Дохиолол ажиллах тохиолдлууд

Дохиоллын систем дараах нөхцөлд ажиллаж болно: (Дохиоллын системийг унтраах нь системийг идэвхгүй болгоно.)


- Хаалганы түгжээг механик түлхүүрээр тайлсан.



- Автомашины дотор талаас хаалга, капот нээх эсвэл түгжих товчоор автомашины түгжээг тайлах.



- Автомашин түгжигдсэн үед аккумуляторыг цэнэглэсэн эсвэл сольсон. (→X.561)



■ Дохиоллын системийн хаалга түгжих функц

Дараах нөхцөлүүдэд байдлаас хамаарч автомашинд зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлж хаалга автоматаар түгжигдэж болно:

- Автомашины дотор үлдсэн хүн хаалганы түгжээ тайлснаас шалтгаалж дохиолол идэвхэжсэн үед
- Дохиолол идэвхэжсэний дараа автомашин дотроос хаалганы түгжээ тайлах оролдлого хийсэн үед
- Аккумулятор цэнэглэх, сольсон үед

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим функцийг өөрчлөх боломжтой. (→X.583)



АНХААР

■ Хэвийн ажиллагааг хангах

Системийг салгах, өөрчлөхийг хориглоно. Хэвийн ажиллагаа алдагдах аюултай.

**Дохиоллын өмнөх систем
(Армен, Украин, Казахстан,
Беларусь, Молдав, Орос,
Азербайжан, Гүрж, Киргиз,
Малайз, Монгол улсаас
бусад)**

Дохиоллын систем идэвхтэй үед

механик түлхүүрээр хаалганы түгжээ тайлбал дохиоллын өмнөх систем 10 секунд дуугарна.

Хаалгыг буцааж түгжсэн эсвэл тус 10 секундийн дотор дохиоллын өмнөх системийг цуцалсан нөхцөлд дохиоллын систем дуугарна.

Дохиоллын өмнөх системийг дараах аргаар зогсооно:

- Хаалга хаагаад Smart entry & start систем эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар түгжинэ.
- Асаах товчийг ACC эсвэл ON-д шилжүүлэх эсвэл хөдөлгүүрийг асаана. (Хэдэн секундийн дараа дохиоллын систем цуцлагдана.)

Гадны биет, хазайлт мэдрэгч

■ Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч, хазайлт мэдрэгчийн ажиллагаа

- Автомашинд гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч нь автомашин халдлагад өртөх эсвэл автомашин дотор хөдөлгөөн үүссэн үед мэдрэнэ.
- Хазайлт мэдрэгч нь автомашин ачигдах зэргээр хазайлт үүссэн үед мэдрэнэ.

Тус систем нь хулгайгаас сэргийлэх систем ба нөгөөтээгүүр автомашины халдлагын эсрэг үнэмлэхүй хамгаалалт биш юм.

Дохиоллын систем идэвхтэй үед

■ Гадны биет, хазайлт мэдрэгчийг идэвхжүүлэх

Дохиоллын систем идэвхжих үед гадны биет, хазайлт мэдрэгч автоматаар идэвхэжнэ. (→Х.81)

■ Системийг цуцлах

Автомашин дотор гэрийн тэжээвэр амьтан болон бусад хөдөлдөг зүйл үлдээх үед эдгээр нь дохиолол ажиллуулж болох тул дохиоллын систем идэвхжүүлэхийн өмнө мэдрэгчүүдийг цуцална.

1 Голын дэлгэцээс -г дарна.

2 -г дарна.

Системийн ажиллагаа цуцлагдаж мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

Товч дээр дахин дарж гадны биет, хазайлт мэдрэгчийг идэвхжүүлнэ.

Мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

■ Мэдрэгчийг салгах, систем автоматаар идэвхжих

● Автомашинд гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч болон хазайлт мэдрэгчийг салгасан үед дохиоллын систем идэвхтэй хэвээр байна.

● Мэдрэгчийг салгасны дараа асаах товч дарах, entry функц болон алсын удирдлагатай түлхүүрээр хаалганы түгжээ тайлах үед эдгээр системүүд дахин идэвхэжнэ.

● Дохиоллын систем салгагдах тухай бүрд автомашинд гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч болон хазайлт мэдрэгч идэвхэжнэ.

■ Автомашинд гадны биет нэвтэрснийг таних мэдрэгчтэй автомашинд анхаарах зүйлс


Мэдрэгч дараах тохиолдлуудад до-

хиоллын системийг идэвхжүүлнэ:


- Автомашины дотор хүн эсвэл гэрийн тэжээвэр амьтан үлдсэн.



- Цонх, дээврийн нээлхий (тоноглогдсон автомашинд) нээлттэй үед. Энэ тохиолдолд мэдрэгч дараах зүйлсийг мэдрэх боломжтой:
 - Салхи эсвэл автомашины бүхээг дахь навч, хорхой шавьж зэргийн хөдөлгөөн
 - Бусад автомашины автомашинд гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч зэргийн цацаж буй хэт авианы давтамж
 - Автомашины гадна талд байгаа хүний хөдөлгөөн




- Бүхээгт байгаа ялаа, дэнгийн эрвээхэй зэрэг шавьж
- Бүхээгт өлгөдөг тоглоом эсвэл хувцасны өлгүүрт өлгөөстэй хувцас зэрэг хялбар хөдөлдөг эд зүйлс байгаа үед




- Авто зогсоол, гарааж зэрэг дуу

чимээ, чичиргээ ихтэй газар
автомашин байрлуулсан үед



- Автомашинд үргэлжилсэн чичиргээ, доргилт учруулах байдлаар тогтсон цас, мөсийг арилгах үед



- Автомашин өндөр даралттай авто угаалга эсвэл автомат авто угаалгын газарт байгаа үед
- Автомашин мөндөр, аянга цахилгаан мөн бусад үргэлжилсэн чичиргээ, доргилтод өртсөн үед

■ Хазайлтын мэдрэгчтэй холбоотой анхаарах зүйлс

Мэдрэгч дараах тохиолдлуудад дохиоллын системийг идэвхжүүлнэ:

- Усан онгоц, чиргүүл, галт тэрэг зэргээр автомашин тээвэрлэж байгаа үед
- Автомашиныг авто зогсоолд байрлуулсан үед
- Автомашиныг автоматаар хөдөлгөх зарчмаар ажилладаг авто угаалгад байгаа
- Аль нэг дугуйны хийн даралт буурсан үед
- Домкратаар өргөх үед
- Газар хөдлөлт үүсэх эсвэл зам цөмрөх үед
- Дээврийн ачаанд ачаа тээш ачсан,


буулгасан үед




АНХААР

■ Автомашинд гадны биет нэвтэрснийг таних мэдрэгчийн хэвийн ажиллагааг хангах

- Мэдрэгчийн хэвийн ажиллагааг хангахын тулд мэдрэгчид хүрэх, таглахыг хориглоно.



- Мэдрэгчийн нүх рүү агаар цэвэршүүлэгч болон бусад зүйл шууд цацахыг хориглоно.



- Lexus-н оригинал биш тоноглол суурилуулах, жолооч болон урд зорчигчийн суудлын хооронд аливаа эд зүйлс тавих нь мэдрэгчийн чадварыг бууруулна.

Автомашины мэдээлэл ба индикаторууд

2

2-1. Хянах самбар

Анхааруулах гэрэл болон
индикаторууд.....88

Хянах самбарын хэмжих
хэрэгслүүд.....93

Мэдээллийн дэлгэц.....98

HUD дэлгэц.....99

Дэлгэцээр гарах контент
.....102

Анхааруулах гэрэл ба индикаторууд

Хянах самбар, хажуугийн толь болон бусад хэсгүүдэд байрлах анхааруулах гэрэл ба индикаторууд нь жолоочид автомашины олон төрлийн системийн ажиллагааг харуулдаг.

Хянах самбар дээр гарах анхааруулах гэрэл ба индикаторууд

► Төрөл 1



Бүс нутгаас хамаарч хэмжих хэрэгслийн нэгж, индикатор өөр байж болно.

► Төрөл 2



Бүс нутгаас хамаарч хэмжих хэрэгслийн нэгж, индикатор өөр байж болно.

► Төрөл 3



Бүс нутгаас хамаарч хэмжих хэрэгслийн нэгж, индикатор өөр байж болно.

Анхааруулах гэрэл

Системд доголдол үүссэн үед тухайн системийн анхааруулах гэрэл асаж анхааруулга өгнө.



Тоормосны системийн анхааруулах гэрэл^{*1}
(Улаан) (→X.532)



Тоормосны системийн анхааруулах гэрэл^{*1}
(Шар) (→X.532)



Аккумулятор цэнэглэх системийн анхааруулах гэрэл^{*2} (→X.532)



Хөдөлгүүрийн тосны даралт багассаныг анхааруулах гэрэл^{*2} (→X.533)



Хөргөлтийн шингэний хэм анхааруулах гэрэл^{*2} (→X.533)



Доголдол анхааруулах гэрэл^{*1} (→X.533)



SRS анхааруулах гэрэл^{*1} (→X.533)



ABS анхааруулах гэрэл^{*1}
(→X.534)



Жолооны хүчлүүрийн анхааруулах гэрэл^{*1}
(Улаан) (→X.534)



Жолооны хүчлүүрийн анхааруулах гэрэл^{*1}
(Шар) (→X.534)



PCS анхааруулах гэрэл^{*1}
(→X.534)



LTA индикатор (→X.534)



LDA индикатор (→X.535)



PDA индикатор
(тоноглогдсон үед)
(Шар) (→X.535)



Хурд баригчийн индикатор
(→X.535)



(Шар)



(Шар)

Динамик радарын хурд баригчийн индикатор
(→X.535)



(Шар)

Хурд хязгаарлагч индикатор (тоноглогдсон үед) (→X.535)



Жолоодлогод туслах мэдээллийн индикатор*¹
(→X.536)



Lexus parking assist-мэдрэгчийн OFF индикатор*¹ (→X.536)



Дөрөөний буруу ажиллагаа анхааруулах гэрэл*²
(→X.536)



Шарвалтын индикатор*¹
(→X.537)



(Анивчих)

4 дугуй хөтлөх системийн нам хурдны индикатор
(→X.537)



(Анивчих)

Төвийн дифференциал цоожлогчийн индикатор
(→X.537)



(Анивчих)

Хойд дифференциал цоожлогчийн индикатор (тоноглогдсон үед)(→X.537)



(Анивчих)

Зогсоолын тоормосны индикатор (→X.538)



(Анивчих)

Тоормос баригчийн ажиллагааны индикатор*¹
(→X.538)



Шатахуун багассаны анхааруулах гэрэл
(→X.538)



Дугуйн даралт анхааруулах гэрэл*¹ (→X.538)



Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүс анхааруулах гэрэл (→X.539)



Арын зорчигчийн аюулгүйн бүс анхааруулах гэрэл
(→X.539)

*¹: Асаах товчийг ON-д шилжүүлэхэд системийн ажиллагааг шалгаж асах ба хөдөлгүүр асах эсвэл хэдэн секундйн дараа унтарна. Системийн хэвийн ажиллагаа алдагдсан үед гэрэл асах болон унтрахгүй. Lexus дилерт хандана.

*²: Мэдээллийн дэлгэц дээр асна.



АЮУЛТАЙ

■ Аюулгүйн системийн анхааруулах гэрэл асахгүй үед

Хөдөлгүүр асаах үед ABS болон SRS анхааруулах гэрэл зэрэг аюулгүйн системийн индикатор гэрэл асахгүй байх нь эдгээр аюулгүйн систем ослын үед ажиллах боломжгүйг илтгэх ба улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай. Даруй Lexus дилертээ хандаж автомашинаа оношлуулна.

Индикатор

Индикаторууд нь жолоочид автомашины олон төрлийн системийн ажиллагааг харуулдаг.



Эргэх дохионы индикатор
(→X.212)



Оврын гэрлийн индикатор
(→X.219)



Холын гэрлийн индикатор
(→X.221)



ABS индикатор
(тоноглогдсон үед)(→X.222)



АНВ индикатор (→X.226)

Урд манангийн гэрэл
индикатор (тоноглогдсон
үед) (→X.229)



Арын манангийн гэрэл
индикатор (тоноглогдсон
үед) (→X.229)



PCS анхааруулах гэрэл*^{1, 2}
(→X.245)



LTA индикатор (→X.261)
(Цагаан)



LTA индикатор (→X.261)
(Ногоон)



LTA индикатор (→X.261)
(Шар)
(Анивчих)



LDA индикатор (→X.268)
(Ногоон)



LDA индикатор (→X.268)
(Шар)
(Анивчих)



LDA OFF индикатор*²
(→X.268)



PDA индикатор
(тоноглогдсон үед)
(Цагаан) (→X.274)



PDA индикатор
(тоноглогдсон үед)
(Ногоон) (→X.274)



Хурд баригчийн индикатор
(→X.295)
(Ногоон)



Хурд баригчийн индикатор
(→X.295)
(Цагаан)



Динамик радарын хурд
баригчийн индикатор
(→X.291)
(Ногоон)



Динамик радарын хурд
баригчийн индикатор
(→X.291)
(Цагаан)



Хурд хязгаарлагч
индикатор (тоноглогдсон
үед) (→X.298)
(Ногоон)



Хурд хязгаарлагч
индикатор (тоноглогдсон
үед) (→X.298)
(Цагаан)



Жолоодлогод туслах
мэдээллийн индикатор*^{1, 2}
(→X.301, 313, 323, 329)



Хажуугийн толины
индикатор*³ (→X.301, 313,
323)



Lexus parking assist-
мэдрэгчийн OFF
индикатор*^{1, 2} (→X.317)



Lexus parking assist-
мэдрэгчийн индикатор*⁶
(→X.317)



Эко жолоодлогын
индикатор*¹ (→X.104)



Шарвалтын индикатор*¹
(→X.427)
(Анивчих)



VSC OFF индикатор*^{1, 2}
(→X.427)



Уруу замд туслах
удирдлагын системийн
индикатор*¹ (→X.423)



Crawl Control индикатор*¹
(→X.417)



2-р араагаар хөдөлгөөн
эхлэх горимын индикатор
(тоноглогдсон үед)(→X.209)

	4 дугуй хөтлөх системийн нам хурдны индикатор (→X.412)
	Төвийн дифференциал цоожлогчийн индикатор (→X.413)
	Хойд дифференциал цоожлогчийн индикатор (тоноглогдсон үед)(→X.415)
	Зогсоолын тоормосны индикатор (→X.213)
	Тоормос баригчийн хүлээлгийн индикатор* ¹ (→X.216)
	Тоормос баригчийн ажиллагааны индикатор* ¹ (→X.216)
	Smart entry & start системийн индикатор* ⁴ (→X.203)
	Хэт хүйтэн агаарын хэмийн индикатор* ⁵ (→X.95)
	Тоормосны гэрлийн индикатор (→X.92)
	Эко жолоодлогын горимын индикатор (→X.410)
	SPORT горимын индикатор (тоноглогдсон үед)(→X.410)
	Comfort горимын индикатор (тоноглогдсон үед)(→X.410)
	SPORT S горимын индикатор (тоноглогдсон үед) (→X.410)
	SPORT S+ горимын индикатор (тоноглогдсон үед) (→X.410)
	Custom горимын индикатор (тоноглогдсон үед)(→X.410)
	AUTO горимын индикатор (тоноглогдсон үед)(→X.420)
	DIRT горимын индикатор (тоноглогдсон үед)(→X.420)

	SAND горимын индикатор (тоноглогдсон үед)(→X.420)
	MUD горимын индикатор (тоноглогдсон үед)(→X.420)
	DEEP SNOW горимын индикатор (тоноглогдсон үед) (→X.420)
	ROCK горимын индикатор (тоноглогдсон үед)(→X.420)
	"TOW HAUL" индикатор (тоноглогдсон үед)(→X.211)

*¹: Энэ гэрлүүд нь асаах товчийг ON горимд шилжүүлсэн үед системийн ажиллагааг шалгаж байгааг илтгэн асах ба хөдөлгүүр асах эсвэл хэдэн секундйн хугацаа өнгөрсний дараа унтарна. Гэрэл асахгүй эсвэл унтрахгүй байх нь системийн хэвийн ажиллагаа алдагдсаныг илэрхийлнэ. Та өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа оношлуулна уу.

*²: Тус гэрэл систем унтрах үед асна.

*³: Хажуугийн толь дээр асна.

*⁴: Энэ гэрэл нь мэдээллийн дэлгэц дээр анхааруулгатай хамт гарна.

*⁵: Гадна агаарын хэм 3°C (37°F) ба түүнээс доош үед индикатор 10 секунд орчим анивчаад үргэлжлэн асна.

*⁶: Голын дэлгэц, арын камергүй автомашин

■ Lexus parking assist-мэдрэгчийн OFF индикатор

Голын дэлгэцгүй автомашин: Тус индикатор нь Lexus parking assist мэдрэгч асаалттай, унтарсан эсэхээс үл хамааран арааг R-д шилжүүлэх үед асна.

■ Тоормосны гэрлийн индикатор

Тоормос гишгэх эсвэл жолоодлогод туслах системийн ажиллагаагаар тоормослох үед тус гэрэл асна.


Хянах самбарын хэмжих хэрэгслүүд

Хянах самбар

■ Байрлал

Хянах самбарын төрлийг өөрчлөх боломжтой. (→X.583)

► Төрөл 1/ Төрөл 3



Хянах самбар дээрх хэмжилтийн нэгж болон дэлгэц бүс нутгаас хамаарч өөр байж болно.

A Мэдээллийн дэлгэц

Жолоочид жолоодлоготой холбоотой олон төрлийн мэдээлэл өгнө (→X.98)

Доголдол үүссэн үед анхааруулах мэдээлэл гаргана (→X.541)

B Гадна агаарын хэм (→X.95)

C Тахометр (Зөвхөн төрөл 1)

Хөдөлгүүрийн 1 минутын эргэлтийн хурдыг харуулна

D Дижитал спидометр

Автомашин хурдыг заана

E Шилжих боломжтой дээд араа/арааны байрлал

Сонгосон араа, шилжих боломжтой дээд араа/арааны байрлал (→X.207)

F Цаг

GPS цаг нь GPS цагны мэдээллээр автоматаар тохируулагддаг. Дэлгэрэнгүйг "Мультимедиа гарын авлага"-с харна уу.

G Вольтметр

Аккумуляторын цэнэгийн хэмжээг харуулна

Н Туулах боломжтой зай

Одоогийн шатахуунаар туулах боломжтой зайг заана. (→X.95)

И Шатахууны хэмжээ

Шатахууны саванд байгаа шатахууны хэмжээг харуулна

Ж Хөдөлгүүрийн тосны даралт хэмжигч

Хөдөлгүүрийн тосны даралтыг харуулна

К Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм

Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэмийг заана

Л Одометр, гүйлт ба тосны засвар үйлчилгээ

Одометр:

Автомашины нийт гүйлтийг заана


Гүйлт:

Автомашины гүйлтийг өмнөх удаа тэглэснээс хойших гүйлтийг заана. Гүйлт А болон В-г ашиглаж 2 өөр гүйлтийг нэгэн зэрэг хэмжих боломжтой.

Тосны засвар үйлчилгээ:

Дараагийн удаа хөдөлгүүрийн тос солих хүртэлх зайг заана.

► Төрөл 2



Хянах самбар дээрх хэмжилтийн нэгж болон дэлгэц бүс нутгаас хамаарч өөр байж болно.

А Тахометр

Хөдөлгүүрийн 1 минутын эргэлтийн хурдыг харуулна

В Мэдээллийн дэлгэц

Жолоочид жолоодлоготой холбоотой олон төрлийн мэдээлэл өгнө (→X.98)

Доголдол үүссэн үед анхааруулах мэдээлэл гаргана (→Х.541)

C Гадна агаарын хэм (→Х.95)

D Дижитал спидометр

Автомашинны хурдыг заана

E Шилжих боломжтой дээд араа/арааны байрлал

Сонгосон араа, шилжих боломжтой дээд араа/арааны байрлал. (→Х.207)

F Цаг

GPS цаг нь GPS цагны мэдээллээр автоматаар тохируулагддаг.

Дэлгэрэнгүйг “Мультимедиа гарын авлага”-с харна уу.

G Аналог спидометр

Автомашинны хурдыг заана

H Туулах боломжтой зай

Одоогийн шатахуунаар туулах боломжтой зайг заана (→Х.95)

I Шатахууны хэмжээ

Шатахууны саванд байгаа шатахууны хэмжээг харуулна

J Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм

Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэмийг заана

K Одометр ба гүйлтийн дэлгэц (→Х.96)

■ Хэмжих хэрэгсэл ба дэлгэц асах нөхцөлүүд

Асаах товч ON горимд байгаа.

■ Туулах боломжтой зай

● Туулах боломжтой зайн хэмжээг шатахууны дундаж зарцуулалт дээр үндэслэн тооцож гаргадаг. Тиймээс бодит туулсан зай өөр байж болно.

● Бага хэмжээний шатахуун нэмж цэнэглэх үед дэлгэцийн заалт өөрчлөгдөхгүй байж болно. Шатахуун цэнэглэх үед түлхүүрийг off-д буцааж унтраана. Унтраалгүй шатахуун цэнэглэсэн үед дэлгэцийн заалт өөрчлөгдөхгүй байж болно.

● “Refuel” анхааруулга гарсан үед шатахууны үлдэгдэл хэмжээ бага бөгөөд туулах боломжтой зайг зөв тооцоолох боломжгүй байж болно.

■ Гадна агаарын хэмийн дэлгэц

● Дараах нөхцөлд гадна агаарын хэмийг зөв заахгүй байх эсвэл

заалт хэвийн нөхцөлөөс илүү удаанаар солигдож болно.

- Автомашин зогсож байгаа эсвэл бага хурдаар (20км/ц [12 миль/ц]-с бага хурд) явж байгаа үед
- Гадна агаарын хэм огцом өөрчлөгдсөн (гарааж, туннел зэрэгт орох эсвэл гарах г.м.)

● Дэлгэц дээр “--” эсвэл “E” тэмдэг гарвал системд доголдол үүссэн байж болзошгүй. Та өөрийн Lexus дилерт хандана уу.

● Гадна агаарын хэмийг -40°C (-40°F)-с 60°C (140°F) хэмийн хооронд заах боломжтой.

● Гадна агаарын хэм 3°C (37°F) ба

түүнээс доош үед  индикатор 10 секунд анивчаад асна.

■ LCD дэлгэц

Дэлгэц дээр хар эсвэл цагаан жижиг цэг гарч болно. Энэ нь LCD дэлгэцийн онцлог бөгөөд дэлгэцийн хэвийн

ажиллагаа алдагдаагүй болно.

■ Нээлттэй программ хангамжийн мэдээлэл

Тус бүтээгдэхүүн нь Free/Open Source Software (FOSS) буюу нээлттэй программ хангамж агуулдаг. Лиценз болон эх үүсвэрийн кодын тухай дэлгэрэнгүйг дараах холбоосноос харна уу.

<https://www.yazaki-group.com/rd-tech/oss/880>



АЮУЛТАЙ

■ Хүйтэн нөхцөл дэх мэдээллийн дэлгэц

Шингэн кристал дэлгэц (LCD) ашиглахын өмнө автомашины салоныг хангалттай хэмжээнд халаана. Хэт нам температурт дэлгэц удаан болох, хоцролт үүсэж болно.

Жишээлбэл жолооч арааны хөшүүргийг шилжүүлэх үед тухайн сонгосон арааны байрлалыг дэлгэц хоцорч харуулж болно. Үүнээс шалтгаалж жолооч арааг хүнд араанд шилжүүлэх улмаар хүчтэй хөдөлгүүрийн тоормос үүсэж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.



АНХААР

■ Хөдөлгүүр болон эд ангийг гэмтлээс сэргийлэх

● Тахометрийн зүүг хөдөлгүүрийн дээд эргэлтийг заах улаан бүсэд орох байдлаар хааз өгч болохгүй.

● Хөргөлтийн шингэний заалт улаан бүс ("H")-д орсон үед хөдөлгүүр хэт халсан байх магадлалтай. Аюулгүй газар даруй зогсоох ба бүрэн хөрсний дараа хөдөлгүүрийг шалгана. (→X.566)

■ Вольметр

Хөдөлгүүр асаалттай үед вольтметрийн заалт 19 V-с дээш эсвэл 9 V-с доош зааж байвал аккумулятор эсвэл аккумулятор цэнэглэх системд доголдол үүссэн байж болно. Та өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа оношлуулна уу.

■ Хөдөлгүүрийн тосны даралт хэмжигч

Хөдөлгүүр асаалттай үед тосны даралт унасан тохиолдолд автомашиныг аюулгүй газар зогсоож даруй тосны хэмжээг шалгана. (→X.496)

Хөдөлгүүрийн тосны хэмжээ хэвийн үед эсвэл тос нэмсэн ч тосны даралт унасан хэвээр байвал хөдөлгүүрийн тосолгооны системд доголдол үүссэн байх магадлалтай тул та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

"ODO TRIP" товч ашиглах

■ Дэлгэцийн мэдээлэл

● Одометр

Автомашины нийт гүйлтийг заана.

● Гүйлт A/Гүйлт B

Автомашины гүйлтийг өмнөх удаа тэглэснээс хойших гүйлтийг заана. Гүйлт A болон B-г ашиглаж 2 өөр гүйлтийг нэгэн зэрэг хэмжих боломжтой.


● Дараагийн тос солих хүртэлх зай

Дараагийн тос солих хүртэлх зайг заана.

■ Дэлгэц солих

"ODO TRIP" товч дарах бүрд дэлгэцээр гарах мэдээлэл өөрчлөгдөнө. Гүйлтийн дэлгэц гаргасан үед товчийг удаан дарж

гүйлтийн заалтыг тэглэх боломжтой.




■ Автоматаар гарч ирдэг дэлгэц

Тос солих зай дөхсөн үед тос солих шаардлагатайг анхааруулсан анхааруулга болон солих зайг харуулсан мэдээлэл автоматаар гарч ирнэ.

Хянах самбарын гэрлийн түвшин тохируулах

Хянах самбарын гэрлийн түвшнийг тохируулах боломжтой.



- 1 Бүдэг
- 2 Тод

■ Хянах самбарын гэрлийн түвшин (өдрийн ба шөнийн горим)

Хянах самбарын гэрлийн түвшнийг өөр өөрөөр тохируулах боломжтой.

Дараах нөхцөлүүдэд өдөр ба шөнийн горимоор тохируулах боломжтой.


- Өдрийн горим: Оврын гэрэл унтраастай эсвэл асаалттай ч орчны гэрэл тод үед
- Шөнийн горим: Оврын гэрэл унтраастай эсвэл асаалттай ба орчны гэрэл бүдэг үед

Мэдээллийн дэлгэц

Мэдээллийн дэлгэц нь шатахуун зарцуулалт болон жолоодлоготой холбоотой олон төрлийн мэдээллийг харуулдаг. Мөн мэдээллийн дэлгэц ашиглан дэлгэц болон бусад тохиргоо хийх боломжтой.

Дэлгэцийн агуулга

Мэдээллийн дэлгэц дээр дараах мэдээллийг гаргах боломжтой



- A** Дэлгэцийн мэдээллийн хэсэг (зүүн)
- B** Дэлгэцийн мэдээллийн хэсэг (баруун)
- C** Дэлгэцийн мэдээллийн хэсэг (төв хэсэг)
- D** Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц
Жолоодлогод туслах системийн мэдээлэл дэлгэцээр гарсан үед

системүүдийн ажиллагааг заахгүй.

- E** RSA замын тэмдэг таних системийн дэлгэц автомашинд) (→X.278)

■ Дэлгэцийн мэдээллийн хэсэг (төв хэсэг)

- Хоосон дэлгэц (→X.109)
- Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц (→X.104)
- Газрын зургийн дэлгэц (тоноглогдсон загварт) (→X.104)
- Дэлгэцийн мэдээллийн хэсэг (зүүн/баруун)
- Хоосон дэлгэц (→X.109)
- Шатахууны хэмнэлт (→X.103)
- Эко жолоодлогын индикатор (→X.104)
- Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц (→X.104)
- Навигацийн системтэй холбоотой мэдээллийн дэлгэц (→X.104)
- Аудио системтэй холбоотой дэлгэц (→X.105)
- Жолоодлогын мэдээллийн дэлгэц (→X.105)
- Зүтгэх хүчний удирдлагын дэлгэц (→X.105)
- Хазайлт заах дэлгэц (→X.105)
- Туслах хэмжих хэрэгслүүд (→X.107)
- Хөдөлгүүр/Хурдны хайрцгийн тосны хэм (→X.108)
- Турбо (→X.108)
- G-хүч (→X.108)

● Хоосон дэлгэц (→X.109)

■ Мэдээллийн дэлгэц ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ LCD дэлгэц

→X.95

■ Жолоодлогын горим өөрчлөх үед

Сонгосон жолоодлогын горимоос хамаарч мэдээллийн дэлгэцийн суурь өнгө өөрчлөгдөнө. (→X.410)



АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үед ашиглах тохиолдолд анхаарах зүйлс

● Жолоодлогын үед мэдээллийн дэлгэцийг удирдах үед ойр орчмын аюулгүй байдалд өндөр анхаарал хандуулна.

● Жолоодлогын үед явган зорчигч, зам дээрх эд зүйл, урд талын автомашин зэргийг харж чадахгүй байж болох тул мэдээллийн дэлгэц рүү удаан харж болохгүй.

■ Хүйтэн нөхцөл дэх мэдээллийн дэлгэц


→X.96

HUD (Head-up display)
дэлгэц*

*: Тоноглогдсон загварт

HUD дэлгэц нь жолоодлоготой холбоотой мэдээлэл болон жолоодлогод туслах системийн ажиллагааг салхины шилэн дээр харуулна.


Системийн эд ангиуд



HUD дэлгэцийн төрлийг өөрчлөх боломжтой. (→X.583)

Жолоодлогын нөхцөл болон HUD дэлгэцийн тохиргооноос хамаарч дэлгэцээр гарах контент өөрчлөгдөнө. Тухайн нөхцөлөөс хамаарч автоматаар гарч ирдэг дэлгэц гарч болно.

■ Бүтэн



Тус гарын авлагад ашигласан зураг нь HUD дэлгэцийн ажиллагааг харуулах зорилготой жишээ болно. Бодит байдлаас өөр байж болно.

A Жолоодлогод туслах системийн дэлгэцийн хэсэг (→X.104)/ Навигацийн системтэй холбоотой дэлгэцийн хэсэг/ Тахометрийн дэлгэцийн хэсэг (→X.102)


B Жолоодлогод туслах системийн дэлгэцийн хэсэг (→X.104)

C Спидометр

D Арааны байрлал/шилжих боломжтой дээд араа/араа (→X.207)

E RSA замын тэмдэг таних системийн дэлгэц (тоноглогдсон загварт) (→X.278)

■ Стандарт



Тус гарын авлагад ашигласан зураг нь HUD дэлгэцийн ажиллагааг харуулах зорилготой жишээ болно. Бодит байдлаас өөр байж болно.


A Жолоодлогод туслах системийн дэлгэцийн хэсэг (→X.104)

B Спидометр

C Арааны байрлал/шилжих боломжтой дээд араа/араа (→X.207)

D RSA замын тэмдэг таних системийн дэлгэц (тоноглогдсон загварт) (→X.278)

■ Жижиг



A Спидометр

■ HUD дэлгэцийн ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ HUD дэлгэц ашиглах

HUD дэлгэц нь нарны гэрэл, ялангуяа туйлширсан нарны шилээр харах үед бүдэг, муу харагдаж болно. HUD дэлгэцийн гэрлийг тод болгон тохируулах эсвэл нарын шилээ авна.

■ Гудамжны нэрийн дэлгэц

Зөвхөн газрын зурагт байгаа гудамжны нэр дэлгэцээр гарна.

! АЮУЛТАЙ

■ HUD дэлгэц ашиглах

● HUD дэлгэцийн байрлал болон гэрлийн хэмжээ аюулгүй жолоодлогод саад учруулахгүй эсэхийг нягтална. Буруу байрлалд байрлуулсан дүрс, тохируулсан гэрлийн хэмжээ нь жолоочийн хараанд саад учруулах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.


- Жолоодлогын үед урд талд байх явган зорчигч, зам дээрх эд зүйл зэргийг харж чадахгүй байж болох тул HUD дэлгэц рүү байнга, удаан харж болохгүй.



АНХААР

■ HUD дэлгэцийн проектор

- HUD дэлгэцийн проекторын ойр орчимд аливаа уух зүйл тавьж болохгүй. Проектор норсон нөхцөлд цахилгааны гэмтэл үүсэж болзошгүй.



- HUD дэлгэцийн проектор дээр эд зүйл тавих, наалт нааж болохгүй. Дэлгэцийн заалтыг алдагдуулна.
- HUD дэлгэцийн проекторын дотор талд хуруугаар хүрэх, хатуу зүйлээр хатгаж болохгүй. Механик гэмтлээс үүдсэн доголдолд хүргэнэ.

HUD дэлгэц ашиглах

■ HUD дэлгэцийн тохиргоо өөрчлөх

- 1 Голын дэлгэцийн -г сонгоно.
- 2 “Vehicle customise”-г сонгоно.
- 3 “Head up display”-г сонгоно.

Дараах тохиргоог хийх боломжтой.

- HUD дэлгэцийг идэвхжүү-

лэх/цуцлах

HUD дэлгэцийг идэвхжүүлэх/цуцлах үед сонгоно.

● HUD дэлгэцийн төрөл

HUD дэлгэцийн төрлийг өөрчилнө. (→X.99)

● HUD дэлгэцийн гэрлийн түвшин, байрлал

HUD дэлгэцийн гэрлийн түвшин, дэлгэцийн байрлал тохируулна.

● Дэлгэцийн өнцөг

HUD дэлгэцийн өнцгийг тохируулна.

■ HUD дэлгэцийг идэвхжүүлэх/цуцлах

HUD дэлгэцийн ажиллагааг цуцалсан нөхцөлд хөдөлгүүр асаах товчийг ON горимд асаасан ч идэвхжихгүй.

■ Дэлгэцийн гэрлийн хэмжээ

HUD дэлгэцийн гэрлийн хэмжээг тохируулах боломжтойгоос гадна орчны гэрэлд нийцүүлэн дэлгэцийн гэрлийн хэмжээ автоматаар өөрчлөгддөг.

■ HUD дэлгэцийн байрлалын автомат тохиргоо

Санах ойд дэлгэцийн байрлалыг сануулсан үед хүссэн байрлалд дэлгэцийн тохиргоо автоматаар хийгдэнэ. (→X.188)

■ Аккумулятор салгагдсан үед

HUD дэлгэц үндсэн тохиргоогоор тохируулагдана.

▲ АЮУЛТАЙ

■ HUD дэлгэцийн тохиргоо өөрчлөх үеийн анхааруулга

HUD дэлгэцийн тохиргоо хийх үед хөдөлгүүр асаалттай байх шаардлагатай тул автомашиныг агааржуулалт сайтай газар зогсооно. Битүү орчинд нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) зэрэг хорт хий агуулагддаг утаа хуримтлагдаж автомашины дотор орох, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

▲ АНХААР

■ Дэлгэцийн тохиргоо хийх үед

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж хөдөлгүүр асаалттай үед дэлгэцийн тохиргоо хийнэ.

Тахометрийн дэлгэцийн хэсэг

■ Тахометр

Хөдөлгүүрийн 1 минутын эргэлтийн хурдыг харуулна.

■ HUD дэлгэцийн ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.


■ Тахометр гарах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед тахометр HUD дэлгэц дээр гарна.

- LTA систем, LDA систем, динамик радарын хурд барих систем цуцлагдсан
- HUD бүтэн дэлгэцийн горим сонгосон (→X.99)
- Эко жолоодлогын горимоос өөр жолоодлогын горим сонгосон

Дэлгэцээр гарах контент

Эд анги/ажиллагаа



A < / > : Дэлгэц солин курсор хөдөлгөнө

^ / v : Дэлгэцээр гарах контент өөрчлөх ба дэлгэцийг дээш доош гүйлгэнэ

B Дарах: Сонгох/Тохируулах
Удаан дарах: Тэглэх/Өөрчлөх боломжтой тохиргоо болон курсор гаргана

C Өмнөх дэлгэц рүү буцах

D Дуудлага хийх/хүлээн авах болон дуудлагын түүх дэлгэц

Гарын оролцоогүй утасны системтэй холбогдсон дуудлагын мэдээлэл дэлгэц дээр гарна. Гарын оролцоогүй утасны системийн тухай дэлгэрэнгүй "Мультимедиа системийн хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Жолоодлогын мэдээлэл гарах

Жолоодлоготой холбоотой мэдээлэл дараах дэлгэцүүд дээр гарна.

- Мэдээллийн дэлгэц

- HUD дэлгэц (тоноглогдсон загварт)
- Голын дэлгэц

Дэлгэцээс хамаарч гарах контент өөр байна.

Мэдээллийн дэлгэц өөрчлөх


■ Хянах самбарын төрөл өөрчлөх

Голын дэлгэцийн -р хянах самбарын төрлийг өөрчлөх боломжтой. (→Х.583)

■ Дэлгэц өөрчлөх

Дэлгэцийн мэдээллийн гурван хэсэгт гаргах мэдээллийг сонгоно.

Хянах самбарын удирдлагын товчийн < эсвэл > -г дарж дэлгэцийг гүйлгэнэ.



- A** Анхааруулах мэдээлэл
Анхааруулах мэдээллийг гаргах үед сонгоно.
Анхааруулах мэдээлэл байхгүй


үед дэлгэц дээр мэдээлэл гарахгүй. (→Х.110)

■ Дэлгэцийн мэдээллийн хэсэг дээр гарах зүйлс

Дэлгэцийн мэдээллийн хэсэг (зүүн/төв хэсэг/баруун) дээр гарах функцийг идэвхжүүлэх буюу цуцална.

- 1 < эсвэл > -г дарж дэлгэц сонгоно.
- 2 ОК товчийг удаан дарж дэлгэцийн мэдээллийн хэсэг (төв хэсэг) дээр курсор гаргана.
- 3 < эсвэл > -г дарж курсор хөдөлгөн дэлгэцийн мэдээллийн хэсгийг сонгоно.
- 4 ^ эсвэл v -г дарж сонголтоо хийнэ.

Шатахууны хэмнэлт




- A** Одоогийн шатахуун зарцуулалт
Одоогийн шатахуунаар туулах боломжтой зайг заана.
- B** Заалтыг тэглэснээс хойших шатахууны дундаж хэмнэлт*

*: Дэлгэцээр гарч буй шатахуун зарцуулалтыг зөвхөн мэдээллийн журмаар ашиглана.

Эко жолоодлогын индикатор

■ Эко жолоодлогын индикатор



A Эко жолоодлогын индикатор

Байгаль орчинд ээлтэй байдлаар хааз өгөх (эко жолоодлого) үед эко жолоодлогын индикатор асна. Хаазны хэмжээ эко жолоодлогын бүсээс давсан эсвэл автомашин зогссон үед унтарна.

B Эко жолоодлогын индикаторын бүсийн дэлгэц

Хаазны хэмжээнд үндэслэсэн одоогийн эко жолоодлогын харьцаагаар эко жолоодлогын бүсийг санал болгоно.

C Хаазны хэмжээнд үндэслэсэн эко жолоодлогын харьцаа

Хаазны хэмжээ эко жолоодлогын бүсээс давсан үед эко жолоодлогын индикаторын бүсийн дэлгэцийн баруун тал асна.

Энэ үед эко жолоодлогын индикатор унтарна.

D Эко жолоодлогын бүс

■ Эко жолоодлогын индикатор

Эко жолоодлогын индикатор дараах нөхцөлүүдэд ажиллахгүй:

- Араа D-с өөр байрлалд байгаа
- Автомашины хурд 130 км/ц (80 mph)-с дээш

Жолоодлогод туслах системийн мэдээллийн дэлгэц

Мэдээллийн дэлгэц эсвэл HUD дэлгэцээр (тоноглогдсон загварт) дараах системүүдийн ажиллагааг харуулна.

- LTA систем (→X.257)
- LCA систем (тоноглогдсон загварт) (→X.262)
- LDA систем (→X.265)
- PDA систем (тоноглогдсон загварт) (→X.270)
- Динамик радарын хурд барих систем (→X.282)
- Хурд баригч (→X.293)

Газрын зургийн дэлгэц (тоноглогдсон загварт)

Навигацийн системийн газрын зургийн мэдээлэл гаргана.

Навигацийн системтэй холбоотой дэлгэц

Мэдээллийн дэлгэц дээр дараах мэдээллийг гаргах боломжтой.

- Маршрут заагч
- Гудамжны нэр
- Луужингийн дэлгэц

Аудио системтэй холбоотой дэлгэц

Аудио системийн ажиллагааг мэдээллийн дэлгэц дээр гаргах боломжтой.

Жолоодлогын мэдээллийн дэлгэц

Мэдээллийн дэлгэц дээр дараах зүйлсийг гаргана.

Дэлгэцийн заалтыг мэдээллийн журмаар ашиглана.

- “Average Speed”: Заалтыг тэглэснээс хойших дундаж хурдыг заана.
- “Total Time”: Заалтыг тэглэснээс хойших хугацааг заана.


Бартаат замын мэдээллийн дэлгэц

Голын дэлгэц дээр дараах мэдээллийг гаргах боломжтой.

■ Голын дэлгэц дээр бартаат замын мэдээлэл гаргана.

- 1 Үндсэн цэсээс -г сонгоно.
- 2 “Off-road information”-г сонгоно.

■ Бартаат замын мэдээллийн дэлгэц




- A** Туслах хурдны хайрцгийн горим (→X.412)
- B** Жолоодлогын горим (→X.410)
- C** Crawl control системийн дэлгэц (→X.107)
- D** Зүтгэх хүчний удирдлагын дэлгэц (→X.106)

Е Хазайлт заах дэлгэц (→Х.106)

■ **Зүтгэх хүчний удирдлагын дэлгэц**

► Голын дэлгэц



А Тоормосны дөрөөний монитор
Тоормосны дөрөө гишгэсэн хэмжээг харуулна.

В Урд дугуйн чиглэл заах дэлгэц
Жолооны хүрдийг эргүүлсэн чиглэл болон хэмжээнд нийцүүлэн урд дугуйн чиглэлийг заана.

С Холимгийн хаалтын монитор
Холимгийн хаалтын нээгдсэн хэмжээг бодит цагаар харуулна.

Д Дифференциал цоожлогчийн ажиллагааны статус


Төвийн эсвэл арын дифференциал цоожлогчийн ажиллагааг харуулна. (→Х.413, 415)

Зураг нь жишээ бөгөөд мэдээллийн дэлгэц, голын дэлгэцийн бодит заалтаас өөр байж болно.

Е Дугуйн хий эргэлт заах дэлгэц*
Дугуйн хий эргэх үед дэлгэцийн тэмдгийн өнгө өөрчлөгдөн анивчина.

* : Зөвхөн Sport горим сонгогдсон үед дэлгэцээр гарна.

► Мэдээллийн дэлгэц



А Урд дугуйн чиглэл заах дэлгэц
Жолооны хүрдийг эргүүлсэн чиглэл болон хэмжээнд нийцүүлэн урд дугуйн чиглэлийг заана.


В Дугуйн хий эргэлт заах дэлгэц*
Дугуйн хий эргэх үед дэлгэцийн тэмдгийн өнгө өөрчлөгдөн анивчина.

* : Зөвхөн Sport горим сонгогдсон үед дэлгэцээр гарна.

Зураг нь жишээ бөгөөд мэдээллийн дэлгэц, голын дэлгэцийн бодит заалтаас өөр байж болно.

■ **Хазайлт заах дэлгэц**

► Голын дэлгэц



А Урд болон хойд талын хазайлтын өнцөг

Урд болон хойд талын хазайлтын

өнцгийг заана.


В Баруун, зүүн хазайлтын өнцөг

Баруун болон зүүн талын хазайлтын өнцгийг заана.

С Заах шугам

Автомашины хазалтын өнцгийг шулуун зураасаар заана.

► Мэдээллийн дэлгэц



А Урд болон хойд талын хазайлтын өнцөг

Урд болон хойд талын хазайлтын өнцгийг заана.

В Баруун, зүүн хазайлтын өнцөг


Баруун болон зүүн талын хазайлтын өнцгийг заана.

С Заах шугам

Автомашины хазалтын өнцгийг шулуун зураасаар заана.


■ Crawl control-н дэлгэц (тоноглогдсон загварт)

Crawl Control системийн ажиллагааг харуулна. (→X.418)



Туслах хэмжих хэрэгслүүд

Мэдээллийн дэлгэц дээр дараах зүйлсийг гаргана.



А Вольтметр

Аккумуляторын цэнэгийн хэмжээг харуулна.


В Хөдөлгүүрийн тосны даралт хэмжигч

Хөдөлгүүрийн тосны даралт заана. Даралт буурах үед дохио дуугарч анхааруулга гарна. (→X.533)

Дэлгэцийн заалтыг зөвлөмж болгон ашиглана. Замын байдал, агаарын хэм болон автомашины хурднаас хамаарч дэлгэцийн заалт бодит байдлаас өөр байж болно.

Хөдөлгүүр/Хурдны хайрцгийн тосны хэм

Мэдээллийн дэлгэц дээр дараах зүйлсийг гаргана.



A Хөдөлгүүрийн тосны хэм


Хөдөлгүүрийн тосны хэм заана. Тосны хэм 140 °C (284 °F)-с давах үед дэлгэц анивचना.

B Хурдны хайрцгийн тосны хэм

Хурдны хайрцгийн тосны хэм заана.

Турбо

Мэдээллийн дэлгэц дээр турбо бүүстийн даралтыг гаргах боломжтой.



Дэлгэцийн заалтыг зөвлөмж болгон ашиглана. Замын байдал, агаарын хэм болон автомашины хурднаас хамаарч дэлгэцийн заалт бодит


байдлаас өөр байж болно.

G-хүч

Мэдээллийн дэлгэц дээр автомашинд ирж буй хөндлөн чиглэлийн G-хүчийг харуулна.

G-хүчний дэлгэцийг тойруулан жолооны хурд баруун, зүүн эргүүлсэн хэмжээ, хааз гишгэсэн хэмжээ, тоормосны шингэний даралтыг харуулна.

Дэлгэцийн заалтыг зөвлөмж болгон ашиглана. Замын байдал, агаарын хэм болон автомашины хурднаас хамаарч дэлгэцийн заалт бодит байдлаас өөр байж болно.



A Хурд авалтын G-хүч

B Одоогийн G-хүчний хэмжээ (урд/хойд, баруун/зүүн G-хүчний тооцоолсон хэмжээ)

C Бүртгэгдсэн дээд G-хүч

D Хааз гишгэсэн хэмжээ

E Тоормосны шингэний даралт

F Жолооны хурд эргүүлсэн хэмжээ

● Бүртгэгдсэн дээд G-хүч тэглэх

Хөдөлгүүр асаах бүрд дэлгэцийн заалт тэглэгдэнэ.

● Оргил үеийг барих функц

Хөндлөн чиглэлийн 0.5 G-с давсан G-хүч үүссэн үед G-хүчний дэлгэц улбар шар өнгөтэй болох ба заалтыг 2 секунд хадгална.

■ G-хүчний дэлгэц

- Налуу газар автомашин зогссон байсан ч G-хүчний дэлгэц тэгийг заахгүй байж болно.
- Автомашины ашиглалтаас хамаарч тоормос гүйцэд гишгэсэн ч тоормосны шингэний даралтын дэлгэц дээд утгыг заахгүй байж болно.
- Аккумуляторыг салгаад залгасан үед жолооны хүрд эргүүлсэн хэмжээ түр гарахгүй байж болно. Тодорхой зайд явахад дэлгэц гарна.

Хоосон (контент гарахгүй)

Мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарахгүй.

Дугуйн даралт

Голын дэлгэц дээр дугуйн даралт анхааруулах системийн заалтыг харуулна.

■ Голын дэлгэц дээр дугуйн даралт гаргах

- 1 Үндсэн цэсийн -г сонгоно.
- 2 “Tyre pressure”-г сонгоно.

■ Дугуйн даралт

→X.507


Одоогийн шатахуун зарцуулалт/түүхийн дэлгэц

Голын дэлгэц дээр шатахуун зарцуулалтын мэдээллийг гаргах боломжтой.

■ Голын дэлгэц дээр шатахуун зарцуулалт/түүх гаргах

- 1 Үндсэн цэсийн -г сонгоно.
- 2 “Trip info”-г сонгоно.
- 3 “Current” эсвэл “History”-г сонгоно.

■ Одоогийн шатахуун зарцуулалтын дэлгэц




- A** Түүхийн мэдээллийг тэглэх
- B** Өмнөх 15 минутын шатахуун зарцуулалт
- C** Одоогийн шатахуун зарцуулалт
- D** Хөдөлгүүр асааснаас хойших автомашины дундаж хурд
- E** Туулах боломжтой зай
- F** Хөдөлгүүр асааснаас хойших хугацаа

Шатахуун зарцуулалтын хэмжээг та мэдээллийн журмаар ашиглана уу.

Дэлгэцийн заалт зөвхөн жишээ ба бодит үзүүлэлтээс өөр байж болно.

■ Шатахуун зарцуулалтын түүх



- A** Сүүлийн шатахуун зарцуулалт
- B** Хамгийн сайн шатахуун зарцуулалт
- C** Өмнөх шатахуун зарцуулалт
- D** Түүхийн дата өгөгдлийг тэглэх
- E** Одоогийн шатахуун зарцуулалтын мэдээллийг шинэчлэх

Шатахуун зарцуулалтын хэмжээг мэдээллийн журмаар ашиглана уу.

Дэлгэцийн заалт нь зөвхөн жишээ ба бодит үзүүлэлтээс өөр байж болно.

■ Түүхийг шинэчлэх

Одоогийн шатахуун зарцуулалтыг хэмжих үүднээс "Update"-г сонгож дундаж шатахуун зарцуулалтын түүхийг шинэчилнэ.

■ Мэдээллийг тэглэх

"Clear data"-г сонгож шатахуун зарцуулалтын мэдээллийг тэглэнэ.

■ Туулах боломжтой зай

Шатахууны үлдэгдэл нөөцийн хэмжээгээр туулах боломжтой хамгийн хол зайг тооцож харуулна.

Туулах зайг автомашины дундаж шатахуун зарцуулалтын хэмжээг үндэслэн тооцдог тул дэлгэцээр заасан зай болон бодит туулсан зай өөр байж болно.

Автоматаар гарч ирдэг дэлгэцийн мэдээлэл

Тус дэлгэц нь мэдээллийн дэлгэц, HUD дэлгэц (тоноглогдсон загварт) дээр шаардлагатай үед гарч ирнэ.

Автоматаар гарч ирдэг дэлгэц гарсан үед одоогийн дэлгэцэд буцахгүй байж болно. Тодорхой хугацааны дараа анхны дэлгэцэд буцна.

■ Жолоодлогод туслах систем

Анхааруулга, зөвлөмж, зөвлөгөө эсвэл холбогдох системийн ажиллагааг харуулна.

- Динамик радарын хурд барих систем
- Хурд баригч
- LTA систем
- LCA систем (тоноглогдсон загварт)
- LDA систем
- PDA систем (тоноглогдсон загварт)
- PCS систем
- RSA замын тэмдэг таних системийн дэлгэц (тоноглогдсон загварт)
- Аюулгүй буухад туслах систем

■ Анхааруулах мэдээлэл

Тухайн нөхцөлөөс хамаарч зарим анхааруулах мэдээлэл гарна.

Функц солих товчийг удаан дарж анхааруулах мэдээллийг гаргах боломжтой. (→X.102)

■ Гарын оролцоогүй системийн статус

Гарын оролцоогүй систем

ажиллах үед гарна.

■ Зөвлөмж функц

Дараах нөхцөлд жолоочид зөвлөмж болгох мэдээлэл гарч ирнэ. Зөвлөмжийн дэлгэрэнгүйг жолооны хүрдний товч даран харна уу.

● Их гэрэл унтраах зөвлөмж

Асаах товчийг унтрааснаас хойш тодорхой хугацаанд их гэрэл асаалттай байх үед зөвлөмж асна.

● Тээшний автомат хаалга идэвхжүүлэх зөвлөмж

Тээшний автомат хаалганы систем цуцалсан (голын дэлгэц дээр off) ба хянах самбарын тээшний автомат хаалганы товч дарсан үед тээшний автомат хаалганы систем идэвхжүүлэх эсэх талаар зөвлөмж гарна.

● Автомат цонх хаах зөвлөмж (шил арчигчтай уялдаатай)

Цонх нээлттэй үед шил арчигчийг ажиллуулбал цонх хаах эсэх тухай асуулт дэлгэц дээр гарна.

Бүх цонхыг хаах үед “Yes”-г дарна.

● Автомат цонх хаах зөвлөмж (Өндөр хурдаар явах үед)

Автомат цонхыг нээлттэй хэвээр тодорхой хурднаас давах үед автомат цонх хаах эсэх тухай асуулт дэлгэц дээр гарна. Хаах үед “Yes”-г дарна.

■ Жолооны хүрдний товчны ажиллагааны дэлгэц

Жолооны хүрдний аудио системийн удирдлагын эсвэл дуудлага хийх, яриа дуусгах товчийг дарсан үед дэлгэцээр

гарна.

■ Навигацийн системтэй холбоотой мэдээлэл

Тухайн нөхцөлөөс хамаарч наavigацийн системтэй холбоотой маршрутын заавар гарч болно.

Асаах товчийг унтраах үед дэлгэцээр гарах зүйлс

Асаах товчийг унтраах бүрд дараах зүйлс мэдээллийн дэлгэц дээр гарна.

- Асааснаас хойших дундаж шатахуун зарцуулалт*
- Асааснаас хойших явсан зай*
- Асааснаас хойших явсан хугацаа*


*: Хөдөлгүүр унтрах бүрд тэглэгдэнэ.

3-1. Түлхүүрийн мэдээлэл	
Түлхүүр.....	114
3-2. Хаалга нээх, хаах ба түгжих	
Хажуугийн хаалга	118
Хураагддаг гишгүүр.....	123
Тээшний хаалга	125
Тээшний хаалганы нээгддэг цонх	140
Smart entry & start систем	143
3-3. Суудлын тохиргоо	
Урд суудал	148
Арын суудлууд.....	150
Толгойн түшлэг.....	158
3-4. Жолооны хүрд, толины тохиргоо	
Жолооны хүрд	161
Голын толь.....	162
Дижитал голын толь.....	163
Хажуугийн толь.....	172
3-5. Цонх, дээврийн нээлхий нээх хаах	
Автомат цонх	175
Дээврийн нээлхий	178
3-6. Хувийн тохиргоо	
Жолоодлогын байрлал санах систем.....	181
Миний тохиргоо	185

Түлхүүр

Түлхүүрийн төрлүүд

Автомашинд дараах түлхүүрүүд дагалдаж ирнэ.



A Электрон түлхүүр

- Smart entry & start системийн ажиллагаа (→X.143)
- Алсын удирдлагын ажиллагаа (→X.116)

B Механик түлхүүр

C Түлхүүрийн дугаартай пайз

D Түлхүүр карт (Электрон түлхүүр) (тоноглогдсон загварт)


Smart entry & start системийн ажиллагаа (→X.143)

■ Түлхүүр карт (тоноглогдсон загварт)


- Түлхүүр карт нь усны хамгаалалт-

гүй болно.

- Түлхүүр карт дотор байх механик түлхүүрийг зөвхөн түлхүүр карт хэвийн ажиллахгүй үед ашиглана.
- Механик түлхүүрийг сугалан гаргахад хүндрэлтэй байвал балын хошуу зэргээр түгжээ тайлах товчийг дарна. Мөн зоос зэргийг ашиглаж болно.
- Түгжээ тайлах товчийг дарангаа механик түлхүүрийг түлхүүр картанд буцааж хийнэ.



- Тагийг сайтар таглаагүйгээс зай унах эсвэл түлхүүр норсноор зайг салгасан зэрэг үед буцааж угсрахдаа зайн нэмэх талыг Lexus эмблемтэй тал руу харуулна.



■ Нисэх онгоцоор зорчих үед

Онгоцоор зорчихдоо биедээ автомашины алсын электрон түлхүүр авч явах үед түлхүүрийн аливаа товчийг дарж болохгүй. Түлхүүрийг цүнх болон бусад саванд хийх бол түлхүүрийн товч санамсаргүй дарагдахаас сэргийлнэ. Товч дарагдах үед түлхүүрээс онгоцны жолоодлогод саад учруулах радио долгион цацагддаг.

■ Түлхүүрийн цэнэг дуусах

- Хэвийн нөхцөлд зайны ашиглалтын хугацаа 1 - 2 жил байна.

(Түлхүүр картын зайны ашиглалтын хугацаа 1-1.5 жил байна.)

- Зайны цэнэг муудсан үед хөдөлгөөр унтраахад автомашины бүхээг дотор дуут дохио дуугарна.
- Түлхүүрийг удаан хугацаанд ашиглахгүй үед зайны цэнэг муудахаас сэргийлж электрон түлхүүрийг зайны цэнэг хэмнэх горимд тохируулна. (→X.144)
- Электрон түлхүүр нь байнга радио долгион хүлээн авдаг тул түлхүүр ашиглагдаагүй үед ч зай цэнэгээ алдаж байдаг. Дараах шинж тэмдгүүд электрон түлхүүрийн зай цэнэгээ алдсаныг илтгэнэ. Шаардлагатай үед зайг шинээр солино.
- Smart entry & start систем эсвэл алсын удирдлагын систем ажиллахгүй байх
- Түлхүүр таних хүрээ багасах
- Түлхүүр дэх LED индикатор гэрэл асахгүй байх
- Түлхүүрийн зайг өөрөө солих боломжтой (→X.519). Нөгөөтээгүүр электрон түлхүүрийн гэмтлээс сэргийлж Lexus дилер дээр солиулахыг зөвлөж байна.
- Зайны цэнэг буурахаас сэргийлж электрон түлхүүрийг соронзон орон үүсгэдэг цахилгаан хэрэгслээс 1м (3 фут) зайнд орхиж болохгүй:
- Зурагт
- Компьютер
- Цэнэглэгдэж буй гар утас болон утасгүй суурин утас
- Ширээний чийдэн
- Индукцийн плитка
- Электрон түлхүүрийг автомашины ойр орчимд шаардлагатай хэмжээнээс удаан байлгасан үед түлхүүрийн системийг ашиглаагүй байсан ч түлхүүрийн зай илүү хурдан дуусаж болно. Түлхүүр ашиглаагүй үед электрон түлхүүрийг автомашины ойр орчимд шаардлагатай хэмжээнээс удаан байлгахгүй байх нь зүйтэй.
- **Электрон түлхүүр, асаах товчны горимтой холбоотой мэдээлэл гарсан үед**

Бүхээгт түлхүүрээ үлдээх, асаах товчийг унтраалгүйгээр биедээ түлхүүр аван автомашинаас гарах

бусад зорчигч түлхүүр санамсаргүй авч явахаас сэргийлэн мэдээллийн дэлгэц дээр электрон түлхүүр, асаах товчны горимтой холбоотой мэдээлэл гарна. Энэ нөхцөлд дэлгэцийн зааварчилгааг баримтална.

■ Мэдээллийн дэлгэц (Smart entry & start системтэй загвар) дээр “Key Battery Low Replace Key Battery” гарсан үед

Электрон түлхүүрийн зайн цэнэг дууссан. Электрон түлхүүрийн зайг шинээр солино. (→X.519)

■ Зай солих

→X.519

■ Бүртгэлтэй түлхүүрийн дугаар шалгах

Бүртгэлтэй түлхүүрийн дугаарыг Lexus дилерт хандан шалгуулах боломжтой.

■ Мэдээллийн дэлгэц дээр “A New Key has been Registered Contact Your Dealer for Details” анхааруулга гарсан үед

Шинэ түлхүүр бүртгүүлснээс хойш 10 хоногийн хугацаанд хаалга түгжээтэй үед жолоочийн хаалгыг гадна талаас онгойлгоход дэлгэц дээр тус анхааруулга гарна.

Энэ анхааруулга гарсан ба та шинэ электрон түлхүүрээ бүртгүүлээгүй үед та өөрийн Lexus дилерт хандаж танд байгаагаас өөр электрон түлхүүрийг тухайн автомашинд бүртгүүлээгүй эсэхийг шалгуулна уу.



АНХААР

■ Түлхүүр гэмтэхээс сэргийлэх

- Түлхүүрийг унагах, хүчтэй доргиох, мушгихыг хориглоно.
- Удаан хугацаанд хэт өндөр хэмд байлгахыг хориглоно.
- Норгох, хэт авианы угаалгын машинаар угаах зэргийг хориглоно.
- Түлхүүрт металл, соронзон материалтай эд зүйлс зүүх, ойр орчимд тавихыг хориглоно.



АНХААР

- Түлхүүрийг задлахыг хориглоно.
- Түлхүүрийн гадаргуу дээр наалт, аливаа зүйл нааж болохгүй.
- Түлхүүрийг зурагт, аудио хөгжим, индукцийн плитка зэрэг соронзон орон үүсгэдэг эд зүйлсийн ойр орчимд тавихыг хориглоно.
- Нам давтамжийн сэргээгч аппарат эсвэл богино долгионы шарлагын аппарат зэрэг эмчилгээний аппаратын дэргэд тавих мөн биедээ авч яваа үед эмчилгээ хийлгэхийг хориглоно.

■ Биедээ электрон түлхүүр авч явах

Электрон түлхүүрийг асаалттай цахилгаан хэрэгслээс 10см(3.9 инч) ба түүнээс хол зайд байлгана. Электрон түлхүүрээс 10см(3.9 инч) хүртэлх зайд байгаа цахилгаан хэрэгслээс ялгарсан радио долгион түлхүүрийн хэвийн ажиллагааг алдагдуулах магадлалтай.

■ Smart entry & start системд доголдол, түлхүүртэй холбоотой асуудал үүссэн үед

→X.559

■ Электрон түлхүүрээ гэссэн үед

→X.559


■ Түлхүүр карт ашиглах үед (тоноглогдсон загварт)

- Түлхүүр картад механик түлхүүрийг буцааж хийх үедээ хүчтэй дарж болохгүй. Түлхүүр картыг гэмтээнэ.
- Түлхүүр картын зай эсвэл картын терминал норсон үед зай зэвэрч түлхүүр карт ажиллахгүй болно. Түлхүүрийг ус, шингэн зүйлд унагаасан, дээр нь асгасан үед нэн даруй зайн тагийг авч зай болон терминалыг арчина (тагийг зөөлөн атгаад татна). Зай зэвэрсэн үед өөрийн Lexus дилерт хандаж солиулна.

- Зайны тагийг авахдаа халив ашиглах болон тагийг хүчээр эвдлэж болохгүй. Хүчээр салгах нь түлхүүрийг гэмтээх, хэлбэр нь алдагдахад хүргэнэ.
- Тагийг олон дахин салгавал таг суларна.
- Зайг угсрах үед зөв харуулж хийхэд анхаарна. Буруу харуулж угсравал зайны цэнэг хурдан сууна.
- Дараах нөхцөлүүдэд түлхүүр карт гэмтэх эсвэл хамгаалалтын хуулга нь хууларч болно:
 - Түлхүүр картыг зоос, түлхүүр зэрэг хатуу эд зүйлтэй хамт авч явах үед
 - Балын хошуу зэрэг хурц эд зүйлээр хусах үед
 - Картын гадаргууг шингэлэгч эсвэл бензенээр арчсан үед

Түлхүүрийн алсын удирдлага

Электрон түлхүүр нь дараах алсын удирдлагын ажиллагаатай:



A Бүх хаалга түгжинэ (→X.118)

B Бүх цонх, дээврийн нээлхийг^{*1},
² хаана (→X.118)

C Бүх хаалга тайлна (→X.118)

D Бүх цонх, дээврийн нээлхий*¹,
² нээнэ (→X.118)

E Тээшний автомат хаалга нээж
 хаана (→X.126)

F Дохиоллын системийг
 ажиллуулна*² (→X.117)


*¹: Дээрх тохиргоонуудыг өөрийн
 дилер хандан хийлгүүлнэ.

*²: Тоноглогдсон загварт

■ Паник горим (тоноглогдсон загварт)

( товчийг 1 секундээс удаан дарахад дохиолол дуугарах ба автомашины гэрлүүд асаж автомашинд нэвтрэх, эвдрэл гэмтэл учруулах гэж буй хүнээс автомашиныг хамгаална.

Дохиоллыг зогсоох үед түлхүүрийн алсын удирдлагын аль нэг товчийг дарна.




Механик түлхүүр ашиглах

Түгжээ тайлах товчийг дарж механик түлхүүрийг сугалан гаргана.

Механик түлхүүрийг зөвхөн нэг тийш харуулан хийх боломжтой ховил электрон түлхүүрт байдаг. Түлхүүрийн нүхэнд механик түлхүүр орохгүй үед түлхүүрийг нөгөө тийш харуулан хийнэ.

Механик түлхүүрийг хэрэглэсний дараа электрон түлхүүрт буцаан

хийж хадгалах ба электрон түлхүүрээс салгаж болохгүй. Электрон түлхүүрийн зай суусан эсвэл entry функцийн хэвийн ажиллагаа алдагдсан үед механик түлхүүр хэрэг болно (→X.559)



■ Авто зогсоолын ажилтанд автомашины түлхүүр үлдээх үед

Шаардлагатай тохиолдолд урд хайрцгийг түгжинэ. (→X.454)
 Механик түлхүүрийг өөртөө үлдээх ба зөвхөн электрон түлхүүрийг зогсоолын ажилтанд өгнө.

■ Механик түлхүүрээ гэссэн үед

→X.559


Хажуугийн хаалга

Автомашиныг түлхүүрийн алсын удирдлага, түлхүүр, хаалга түгжих товч мөн дотор талын түгжих товчоор цоожлох/тайлах боломжтой.

Гадна талаас хаалга түгжих, тайлах

■ Entry функц ашиглах

Электрон түлхүүрийг биедээ авч явснаар дараах үйлдлүүдийг хийх боломжтой.




1 Жолоочийн хаалганы бариулыг атгаж эсвэл арын хаалганы мэдрэгчид хүрч бүх хаалганы түгжээг тайлна (тоноглогдсон загварт).

Хаалганы бариулын ард байрлах мэдрэгчид хүрээгүй тохиолдолд түгжээ тайлагдахгүй. Хаалга түгжигдсэнээс хойш 3 секундйн хугацаанд түгжээ тайлагдахгүй.

2 Хаалга түгжих мэдрэгч (бариулны дээд талд байрлах хонхорхой хэсэг)-т хүрч хаалгыг түгжинэ.

Хаалга бүрэн түгжигдсэн эсэхийг шалгана.

■ Алсын удирдлага



1 Бүх хаалга түгжинэ

Хаалга бүрэн түгжигдсэн эсэхийг шалгана.

Цонх, дээврийн нээлхий* хаахын тулд удаан дарна.

2 Бүх хаалга тайлна

Товчийг нэг дарахад жолоочийн хаалганы түгжээ тайлагдана. 3 секундйн дотор дахин дарахад бүх хаалга тайлагдана.

Цонх, дээврийн нээлхийг нээхийн тулд удаан дарна. (тоноглогдсон загварт).*

*: Хэрэглэгчийн хүсэлтээр Lexus дилер дээр хийгдэх тохиргоо.

■ Түгжээ тайлах функцийг тохиргоо өөрчлөх

Алсын удирдлагаар хаалга тайлах үед аль хаалганы түгжээ тайлагдах тохиргоог урьдчилан тохируулж болно. Тохиргоог автомашин дотор эсвэл автомашинаас 1 метрийн ойр зайд хийх боломжтой.

1 Хөдөлгүүрийг унтраана.

2 Тохиргоо хийх үед дохиоллын систем санамсаргүйгээр идэвхжихээс сэргийлж гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч болон хазайлтын мэдрэгчийг унтраана (→X.84)

- 3 Түлхүүр дээрх индикатор гэрэл унтарсны дараа түлхүүрийн  -г дарангаа  ,  эсвэл  товчийг 5 секунд орчим дарна.

Дээрх үйлдлүүдийг хийх бүрд тохиргоо дараах байдлаар өөрчлөгдөнө. (Тохиргоог үргэлжлүүлэн солих үед товчнуудыг суллаад 5-с дээш секундний дараа 3-р үйлдлийг давтана.)

Мэдээллийн дэлгэц/Дуу	Түгжээ тайлах функц
 (Зүүн жолооны хүрдтэй)	Жолоочийн хаалганы бариулыг атгахад зөвхөн жолоочийн хаалга тайлагдах
 (Баруун жолооны хүрдтэй) Гадна: Дуут дохио 3 удаа дуугарна	Зорчигчийн хаалганы бариулыг атгахад бүх хаалга тайлагдах
 Гадна: Дуут дохио 2 удаа дуугарна	Аль нэг хаалганы бариулыг атгахад бүх хаалга тайлагдах

Тохиргоо хийж дууссаны дараа автомашины дохиолол санамсаргүй ажиллахаас сэргийлж алсын удирдлагатай түлхүүрээр түгжээг тайлж хаалгыг нэг удаа нээгээд хаана. ( товч дарснаас хойш 30 секундний хугацаанд хаалгыг онгойлгоогүй үед хаалга автоматаар түгжигдэх ба дохиоллын систем идэвхэжнэ.)

Дохиоллын систем ажиллавал нэн даруй салгана (→Х.82).

■ Хүчтэй доргилтын үед түгжээ тайлах систем

Автомашин хүчтэй цохилтонд өртсөн үед бүх хаалганы түгжээ тайлагдана. Цохилтын хүч, ослын төрлөөс хамаарч зарим тохиолдолд систем ажиллахгүй байж болно.

■ Дохио

Хаалга: Дуут дохио (тоноглогдсон загварт) дуугарах ба ослын дохионы гэрэл анивчиж хаалга түгжигдсэн/тайлагдсаныг илтгэнэ. (Түгжигдсэн: 1 удаа; Тайлагдсан: 2 удаа).

Цонх, дээврийн нээлхий (тоноглогдсон автомашинд): Дуут дохио дуугарч түлхүүрийн алсын удирдлагаар автомат цонх, дээврийн нээлхий ажиллаж байгааг анхааруулна.


■ Аюулгүйн функц

Түлхүүрийн алсын удирдлага эсвэл entry функцээр автомашины хаалга эсвэл тээшний хаалганы нээгддэг цонхны(тоноглогдсон загварт) түгжээг тайлснаас хойш 30 секундний дотор аль нэг хаалгыг нээгээгүй үед аюулгүйн функц ажиллаж автомашиныг автоматаар түгжинэ. (Нөгөөтээгүүр электрон түлхүүрийн байрлалаас хамаарч түлхүүр бүхээгт байгаа гэж буруу танигдаж болно. Энэ үед хаалганы түгжээ тайлагдахгүй.)

■ Бариулны дээд талын хаалга түгжих мэдрэгчээр хаалга түгжигдэхгүй үед

Бариулны дээд талын мэдрэгчид хуруугаараа хүрэх үед хаалга түгжигдэхгүй байвал гарын алгаар хүрнэ.

Бээлий өмссөн байвал тайлж хүрнэ.



■ Хаалганы түгжээний дуут дохио

Дараах нөхцөлд дуут дохио 5 секунд үргэлжлэн дуугарна. Бүх хаалга болон тээшний хаалганы нээгддэг цонхыг сайтар хааж автомашиныг дахин түгжинэ.

- Бусад хаалга, тээшний хаалганы нээгддэг цонх (тоноглогдсон загварт) нээлттэй үед Smart entry & start системээр хаалга түгжих оролдлого хийсэн.
- Тээшний хаалганы нээгддэг цонх эсвэл хаалга онгорхой үед түлхүүрийн алсын удирдлагаар автомашиныг түгжих оролдлого хийсэн.

■ Дохиоллын систем идэвхжүүлэх

Хаалга түгжих үед автомашины дохиоллын систем идэвхэжнэ. (→X.81)

■ Smart entry & start систем эсвэл түлхүүрийн алсын удирдлагын функцийн ажиллагаанд нөлөөлөх нөхцөлүүд

→X.144

■ Smart entry & start систем эсвэл түлхүүрийн алсын удирдлагын функцийн хэвийн ажиллагаа алдагдсан үед

- Smart entry & start системтэй загвар: Механик түлхүүр ашиглан хаалга түгжих буюу тайлна. (→X.559)
- Түлхүүрийн зай суусан байвал шинээр солино. (→X.519)

■ Түлхүүрийн зай суусан үед

Smart entry & start систем эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар хаалга түгжих, тайлах боломжгүй. Механик түлхүүр (Smart entry & start системтэй загвар) ашиглан түгжих, тайлах үйлдэл хийнэ. (→X.559)

■ Арын суудлын анхааруулах функц

Асаах товчийг OFF горимд унтраасан ба дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед эд зүйлсээ арын суудал дээр мартсаныг анхааруулах зорилгоор дуут дохио дуугарах ба мэдээллийн дэлгэц дээр анхааруулга 6 секунд гарна.

Бүх хаалгыг түгжсэний дараа хоёр дахь анхааруулга зогсож ослын дохионы гэрэл хэдэн секунд анивчиж дуут дохио дуугаран, мэдээллийн

дэлгэц дээр гарна.

- Арын хаалгыг нээгээд хааснаас хойш 10 минутын дотор хөдөлгүүр асаасан.

- Хөдөлгүүр ассанаас хойш жолоочийн арын хаалгыг нээгээд хаасан.

Автомашиныг түгжихийн өмнө арын хаалгыг нээсэн тохиолдолд хоёр дахь анхааруулга ажиллахгүй.

Мөн арын хаалгыг онгойлгоод буцаагаад 2 секунд орчмын дотор хаасан тохиолдолд арын суудлын анхааруулах функц ажиллахгүй.

Арын суудлын анхааруулах функц нь зөвхөн хаалганы нээгдэх/хаагдах үйлдэл дээр үндэслэн суудал дээр эд зүйлсээ тавьсан, мартсан байж болохыг тооцоолдог ба тус функц эд зүйлээ мартаж үлдээсэн ч ажиллахгүй байх эсвэл шаардлагагүй тохиолдолд ажиллаж болно.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим тохиргоог (түлхүүр ашиглан хаалга тайлах г.м.) өөрчлөх боломжтой.

(Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)



АЮУЛТАЙ

■ Ослоос урьдчилан сэргийлэх

Автомашин жолоодох үед дараах анхааруулгыг дагаж мөрдөнө. Эсрэг тохиолдолд хаалга онгойн зорчигч шидэгдэх улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэлд хүрэх аюултай.

- Бүх хаалга бүрэн хаагдаж түгжигдсэн эсэхийг нягтална.

- Хөдөлгөөний үед хаалганы дотор бариулаас татахыг хориглоно. Жолооч болон урд зорчигчийн түгжээтэй хаалганы бариулыг (зөвхөн зарим загварын автомашинд) татах үед хаалга онгойж болзошгүй.

- Арын суудалд бага насны хүүхэд суулган тээвэрлэх үед арын хаалганы хүүхэд хамгаалах түгжээг түгжинэ.

■ Хаалга нээх хаах үед

Налуу газар зогссон үед хаалга нээхэд аюулгүй зай байгаа эсэх, автомашины гадна хэр хүчтэй салхитай байгаа зэрэг ойр орчмыг нягтална. Хаалга нээх хаах үед огцом шидэгдэхээс сэргийлж хаалганы бариулаас сайтар барина.


⚠ АЮУЛТАЙ

■ Түлхүүрийн алсын удирдлага ашиглан автомат цонх эсвэл дээврийн нээлхий (тоноглогдсон загварт) ажиллуулах үед

Автомат цонх, дээврийн нээлхий зэрэгт зорчигчид хавчигдаж болзошгүй тул аюулгүй эсэхийг бүрэн нягтласны дараа ажиллуулна. Бага насны хүүхдээр түлхүүрийн алсын удирдлага, механик түлхүүр зэргийг ашиглуулж болохгүй. Хүүхэд болон зорчигч цонхны шил, дээврийн нээлхий, панорамик дээврийн нээлхийд хавчигдах аюултай.

Автомашины дотор талаас хаалга түгжих, тайлах


■ Хаалга түгжих товч ашиглах



- 1 Бүх хаалга түгжинэ
- 2 Бүх хаалга тайлна

■ Дотор талын түгжих товч (түгжих)

Товчийг доош дарж хаалгыг түгжинэ.




■ Дотор талын түгжих товч (тайлах)

Урд хаалга: Товчийг татаж түгжээг тайлна.

Хаалганы түгжээ тайлах үед дотор талын түгжих товч дээш гарч ирнэ.

Арын хаалга: Бариулаас 1 удаа татан түгжээг тайлна. Дахин татаж хаалга нээнэ.

Хаалганы түгжээ тайлах үед дотор талын түгжих товч дээш гарч ирнэ.



■ Урд хаалгыг гадна талаас нь түлхүүргүйгээр түгжих

- 1 Түгжих товчийг доош дарна. (→X.121)
- 2 Хаалганы бариулыг татсан хэвээр хаалгыг хаана.

Хөдөлгүүр асаах товч ACC болон ON горимд байгаа эсвэл электрон түлхүүр автомашин дотор байгаа үед хаалга түгжигдэхгүй.

Нөгөөтээгүүр, электрон түлхүүр зөв танигдалгүй хаалга түгжигдэх тохиолдол гарч болно.

■ Хаалга дутуу хаагдсаныг мэдээллийн дэлгэц дээр анхааруулах үед


Автомашинь хурд 5км/ц (3 миль/ц) хүрсэн үед анхааруулах дуут дохио дуугарч хаалга эсвэл капот дутуу хаагдсаныг анхааруулна. Хаалга болон капотыг бүрэн хаана. Аль хаалга эсвэл капот эсэх нь мэдээллийн дэлгэц дээр гарна.

■ Түлхүүрийн алсын удирдлага эсвэл entry функцээр бүх хаалгыг түгжсэн үед

- Хаалга түгжих товчоор түгжээг тайлах боломжгүй.
- Entry функц (Entry функц, Smart entry & start системтэй загвар), түлхүүрийн алсын удирдлагаар түгжээ тайлна.

Арын хаалганы хүүхэд хамгаалах түгжээ

Хүүхэд хамгаалах түгжээг түгжсэн үед автомашиныг дотор талаас нь онгойлгох боломжгүй.



1 Түгжээ тайлах

2 Түгжих

Тус түгжээ нь хүүхэд арын хаалга онгойлгохоос сэргийлнэ. Арын хаалга тус бүрийн түгжээг доош татаж арын бүх хаалгыг түгжинэ.

Автоматаар хаалга түгжих, тайлах систем

Дараах функцүүдийг идэвхжүүлэх, цуцлах боломжтой:

Дэлгэрэнгүйг Х.583-с харна уу.

Функц	Үйлдэл
Автомашинь хурднаас хамааралтай хаалга түгжих функц	Хурд 20км/ц (12миль/ц)-ийг давах үед бүх хаалга автоматаар түгжигдэнэ.
Арааны байрлалаар хаалга түгжих функц	Арааг Р араанаас бусад арааны байрлалд шилжүүлэхэд бүх хаалга түгжигдэнэ.
Арааны байрлалаар хаалга тайлах функц	Арааг Р араанд буцаах үед бүх хаалга тайлагдана.
Жолоочийн хаалганаас хамааралтай хаалга тайлах функц	Асаах товчийг OFF горимд буцааснаас хойш 45 секундийн дотор жолоочийн хаалгыг онгойлгоход бүх хаалга тайлагдана.

Хураагддаг гишгүүр*

* Тоноглогдсон загварт

Хажуугийн хаалга нээх үед тус гишгүүр гарч ирнэ.

Хажуугийн хаалга хаах, бүхээгийн товч дарах эсвэл автомашины хурд 5 км/ц (3 миль/ц)-с давах үед гишгүүр хураагдана.

⚠ АЮУЛТАЙ

■ Хураагддаг гишгүүрийн анхааруулга

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд ноцтой гэмтэл авах аюултай.


- Хураагддаг гишгүүр ажиллах үед жолооч, зорчигч болон ойр орчимд байгаа хүн гишгүүрт гар биеэ хавчуулахаас сэргийлнэ.
- Буух болон суухын өмнө гишгүүр бүрэн дэлгэгдсэн эсвэл хураагдсан эсэхийг нягтална. Хураагддаг гишгүүр ажиллах явцад бууж суусан нөхцөлд гишгүүрийн ажиллагаа зогсоно.
- Хураагддаг гишгүүрийн товч дарахын өмнө гишгүүр бусад хүнийг гэмтээх эрсдэлгүй эсэхийг нягтална.
- Гишгүүрийг цэвэрлэх, домкрат ашиглах, автомашин доор аливаа зүйл байрлуулах эсвэл гишгүүрийн хэвийн ажиллагаа алдагдсан үед гишгүүрийн товчийг унтраана.
- Хураагддаг гишгүүрийг хүүхдээр удирдуулж болохгүй. Гишгүүр буруу ажиллуулсан нөхцөлд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

- Жолоодлогын дараа хураагддаг гишгүүр халсан байж болно. Бууж суух үед гишгүүрийн металл эд ангид биеийн ил гарсан хэсгээр хүрэхээс зайлсхийнэ.

■ Хавчилтаас хамгаалах функц

Автомашин болон гишгүүр хооронд биеийн аль нэг хэсэг бусад эд зүйл хийж болохгүй. Тухайн биеийн хэсэг, эд зүйлийн хэлбэрээс хамаарч хавчилтаас хамгаалах функц ажиллахгүй байх улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

Хажуугийн хаалгатай холбоотой ажиллагаа (автомат горим)



- 1 Хаалга нээх: Тухайн гишгүүр дэлгэгдэнэ.
- 2 Хаалга хаах: Тухайн гишгүүр хураагдана.

■ Хавчилтаас хамгаалах функц

Гишгүүр хураагдах үед аливаа зүйл

хавчуулагдвал буцаж дэлгэгдэнэ. Дэлгэгдэх үед аливаа зүйлд тулбал гишгүүр буцаж хураагдана.

Хураагддаг гишгүүр ажиллах явцад аливаа саад 3 удаа мэдрэгдсэн тохиолдолд гишгүүр тухайн саадад тулсан байрлалд зогсоно. Саадыг чөлөөлсөн ба тухайн гишгүүр талын хаалгыг нээгээд хаасан эсвэл гишгүүрийн товч дарсан үед гишгүүр дахин дэлгэгдэх, хураагдах оролдлого хийнэ.

■ Автоматаар хураагдах функц

Дараах нөхцөлүүдэд аюулгүйн үүднээс гишгүүр автоматаар хураагдана:

- Гишгүүр бүрэн хураагдаагүй
- Автомашины хурд 5 км/ц (3 миль/ц)-с давсан

Автомашины хурд 5 км/ц (3 миль/ц)-с буух хүртэл гишгүүр дэлгэгдэхгүй.

■ Мэдээллийн дэлгэц дээр “Power Steps Unable to Deploy See Owner’s Manual” анхааруулга гарсан үед

Гишгүүр бүрэн дэлгэгдээгүй.

Хаалга нээгээд хаах эсвэл бүхээгийн товч даран гишгүүрийг бүрэн дэлгэнэ. (→X.124)

■ Мэдээллийн дэлгэц дээр “Power Steps Unable to Retract See Owner’s Manual” анхааруулга гарсан үед

Гишгүүр бүрэн хураагдаагүй.

Гишгүүр болон автомашин завсар аливаа зүйл хавчуулагдаагүй эсэхийг шалгана.

■ Мэдээллийн дэлгэц дээр “Power Steps System Malfunction Visit Your Dealer” is анхааруулга гарсан үед

Системд доголдол үүссэн байж болзошгүй. Lexus дилер дээрээ оношлуулна уу.

■ Гишгүүрт цас, шавар наалдсан эсвэл гишгүүр хөлдсөн үед

Хураагддаг гишгүүрийн хэвийн ажиллагаа алдагдана. Гишгүүр дээр гишгэхийн өмнө бүрэн дэлгэгдсэн эсэхийг нягтална.


Хураагддаг гишгүүр хэвийн ажиллахгүй үед тогтсон цас, шаврыг

арилгана. Гишгүүрийг цэвэрлэсэн ч хэвийн ажиллахгүй нөхцөлд Lexus дилертээ хандана уу.

■ Буух, суух үед

Автомашин доод хэсэгт хүрч гутал, хувцас бохирдож магадгүй тул болгоомжтой бууж сууна.

Бүхээг дотроос хураагддаг гишгүүрийг дэлгэх



1 Хураагддаг гишгүүрийг автомат горимд тохируулна.

Тус горимд тохируулсан үед хажуугийн наалга нээх/хаах үйлдлээр гишгүүр ажиллана. (→X.123)

2 2 гишгүүрийг зэрэг хураана.

■ Автоматаар хураах функц

Автомашины хурд 5 км/ц (3 миль/ц)-с давах аюулгүйн үүднээс гишгүүр автоматаар хураагдана:

■ Аккумулятор цэнэглэх/дахин залгах үед

Дараах үйлдлийг хийнэ.

- 1 Асаах товчийг ON горимд шилжүүлнэ.
- 2 “AUTO” товчийг дараах 5 секунд дотор “OFF” товчийг 10 удаа дарна.

Хураагддаг гишгүүр бүрэн дэлгэгдээд хураагдана.

Тээшний хаалга

Дараах байдлаар тээшний хаалгыг түгжих, тайлах, нээх болон хаана.

⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

■ Жолоодлогын өмнө

● Тээшний хаалга бүрэн хаагдсан эсэхийг нягтална. Хаалга дутуу хаагдсан тохиолдолд хөдөлгөөний үед гэнэт онгойж ойр орчмын эд зүйлсийг цохих мөн тээш шидэгдэж осол аваар үүсгэх аюултай.

● Тээшний хэсэгт бага насны хүүхэд тоглуулж болохгүй. Тээшний хэсэгт хүүхэд санамсаргүй түгжигдвэл битүү бүгчим орчимд хэт халууцах болон бэртэл гэмтэл авах аюултай.

● Тээшний хэсэгт бага насны хүүхэд тоглуулж болохгүй. Тээшний хэсэгт хүүхэд санамсаргүй түгжигдвэл битүү бүгчим орчимд хэт халууцах болон бэртэл гэмтэл авах аюултай.

■ Хөдөлгөөний үед

● Хөдөлгөөний үед тээшний хаалгыг бүрэн хаасан байна. Онгорхой хаалга бусад эд зүйлсийг цохих эсвэл тээш шидэгдэн осол үүсгэх аюултай.

● Тээшний хэсэгт хүн суулгаж тээвэрлэхийг хориглоно. Огцом хааз, шарвалт, эргэлт зэргийн үед шидэгдэн хүндээр гэмтэх аюултай.

⚠ АЮУЛТАЙ

■ Тээшний хаалга ажиллуулах

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд тээшний хаалга гэнэт хаагдаж хүний биеийг хавчих, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

● Тээшний хаалга онгойлгохын өмнө хаалганд тогтсон цас, мөс зэргийг арилгана. Эсрэг тохиолдолд хаалга нээх үед буцаж хүчтэй хаагдаж болзошгүй.

● Тээшний хаалга нээх, хаах үед аюулгүй байдлыг нягтална.

● Ойр орчимд хүн байгаа үед тэдэнд учрах аюул байхгүй эсэхийг нягтлаад хаалга нээгдэх, хаагдах гэж байгааг анхааруулна.

● Хүчтэй салхинд тээшний хаалга савж болзошгүй тул салхитай өдөр хаалга нээх, хаах үед өндөр анхааралтай байна.

● Тээшний хаалгыг бүрэн хаагаагүй үед гэнэт онгойх магадлалтай. Налуу газарт тээшний хаалга гүйцэд нээгдээгүй үедээ буцаж гэнэт хаагдаж болзошгүй. Тээшний хэсгийг ашиглахын өмнө тээшний хаалга гүйцэд онгойсон, аюулгүй эсэхийг нягтална.

● Тээшний хаалга хаах үед гар, хуруу зэргээ хавчуулахаас болгоомжилно.




- Хаалга хаахын тулд тээшний хаалга өргөгч (→Х.137)-с татах, зүүгдэх хориотой. Хаалга өргөгчийн цилиндр эвдэрч осол аваарт хүргэх аюултай.
- Унадаг дугуйны суурь болон бусад ижил төрлийн хүнд зүйл тээшний хаалганд бэхэлсэн тохиолдолд хаалга нээсний дараа гэнэт хаагдах улмаар хүний гар, толгой, хүзүү хавчиж гэмтээх аюултай. Нэмэлт тоноглол угсрах үед Lexus-ын оригинал тоноглол ашиглана.

Тээшний хаалга гадна талаас түгжих/тайлах

■ Entry функц ашиглах

Электрон түлхүүр биедээ авч явснаар дараах үйлдлүүдийг хийх боломжтой.



1 Бүх хаалга тайлна.

Хаалга түгжигдсэнээс хойш 3 секундйн хугацаанд түгжээ тайлагдахгүй.

2 Бүх хаалга түгжинэ.

Хаалга бүрэн түгжигдсэн эсэхийг шалгана.

■ Түлхүүрийн алсын удирдлага ашиглах

→Х.118

■ Ажиллах үеийн дуут дохио

→Х.119

■ Аюулгүйн функцүүд

→Х.119

Тээшний хаалга дотор талаас түгжих/тайлах

■ Хаалга түгжих товч ашиглах

→Х.121

Тээшний хаалга нээх/хаах

■ Түлхүүрийн алсын удирдлага ашиглах

Товчийг удаан дарна.

Тээшний хаалга автоматаар нээгдэж/хаагдана.

Тээшний хаалга ажиллуулахын өмнө түгжээг тайлна.

Тээшний автомат хаалга нээгдэх/хаагдах хүртэл товчийг үргэлжлүүлэн дарна. Хаалга ажиллаж байх үед товчийг дарвал хаалганы ажиллагаа түр зогсоно. Товчийг дахин дарвал хаалга эсрэг чигт ажиллана.




■ Хянах самбар дахь тээшний автомат хаалганы товч

Товчийг удаан дарна.

Тээшний хаалга автоматаар нээгдэж/хаагдана.

Тээшний хаалга ажиллуулахын өмнө түгжээг тайлна.

Хаалга ажиллаж байх үед товчийг дарвал хаалганы ажиллагаа түр зогсоно. Товчийг дахин дарвал хаалга эсрэг чигт ажиллана.




■ Тээшний хаалга товч ашиглах

● Нээх

Тээшний хаалгыг онгойлгохдоо тээшний хаалга товчийг дарна

Тээшний хаалга цоожтой үед: Электрон түлхүүрийн тээшний хаалга товчийг удаан дарна.

Хаалга автоматаар онгойно. Хаалга нээгдэх эсвэл хаагдах хүртэл товчийг дарна.




● Хаах

Тээшний хаалганы доод хэсэгт байрлах  товчийг дарна.

Тээшний хаалга автоматаар хаагдана.

Хаалга ажиллаж байх үед  товчийг дахин дарвал хаалганы ажиллагаа зогсоно.  товчийг дахин дарвал хаалга эсрэг чигт ажиллана.



● Тээшний хаалга хаагаад хаалганаас холдсоны дараа бүх хаалга түгжих (хаагаад түгжих [хаалганаас холдох] функц)


1 Электрон түлхүүртэй үедээ тээшний хаалганаас бусад бүх хаалгыг хааж тээшний

хаалганы доод хэсэгт байрлах



товчийг дарна.

Хэвийн үеэс арай өөр дуут дохио дуугарч тээшний автомат хаалга автоматаар хаагаад түгжих функц (хаалганаас холдох) ажиллахад бэлэн болсныг илтгэнэ.



2 Дуут дохио дуугарч байх үед тээшний хаалганаас холдоно.

Мэдрэгч таныг тээшний хаалганаас холдсоныг мэдэрсэн үед дуут дохио дуугарч ослын дохионы гэрэл (тоноглогдсон загварт) анивчина. Тээшний хаалганаас холдсон чиглэл, электрон түлхүүрийг барьж буй байдал эсвэл бусад нөхцөл байдлаас хамаарч таныг холдсоныг мэдрэгч зөв танихгүй байж болно.

Тээшний автомат хаалганаас бусад бүх хаалга түгжигдэх ба тээшний автомат хаалга хаагдах үедээ мөн түгжигдэнэ. Бүх хаалга хаагдаж түгжигдсэнийг илтгэж дуут дохио дуугарч (тоноглогдсон загварт) ослын дохионы гэрэл анивчина.

Хаалганаас 30 секундийн дотор холдоогүй үед систем ажиллахад бэлэн болсон статус цуцлагдана. Функцийг дахин ажиллуулах үед үйлдлийг давтана.

Электрон түлхүүртэй үедээ хаалганд дахин ойртвол тээшний хаалганы ажиллагаа зогсож бүх хаалганы түгжээ тайлагдах ба дуут дохио дуугарч (тоноглогдсон загварт) ослын дохионы гэрэл анивчина.

Тээшний хаалганы ажиллагаа

зогссоны дараа  товчийг дарвал функц дахин ажиллахад бэлэн байдалд шилжинэ.

- Тээшний хаалгыг хааж бүх хаалга түгжих функц (хаагаад түгжих функц)*

* : Lexus дилер дээр тохируулна.


Электрон түлхүүртэй үедээ тээшний хаалганаас бусад бүх хаалгыг хаагаад тээшний хаалганы доод

хэсэгт байрлах  товчийг дарна.

Хэвийн үеэс арай өөр дуут дохио дуугарч тээшний автомат хаалга автоматаар хаагдаж эхэлнэ. Тээшний автомат хаалганаас бусад бүх хаалга түгжигдэх ба тээшний автомат хаалга хаагдах үедээ мөн түгжигдэнэ. Бүх хаалга хаагдаж түгжигдсэнийг илтгэж ажиллагааны дуут дохио дуугарна. (→Х.119)

Тээшний автомат хаалга ажиллах

үед  товчийг дахин дарахад хаалганы ажиллагаа зогсоно. Товчийг дахин дарах үед хаалга эсрэг чигт ажиллаж эхэлнэ.




■ Тээшний хаалганы бариул ашиглах

Тээшний хаалганы бариул  -г

ашиглан хаалгыг доош буулгана.

Тээшний хаалга хаахад туслах систем (→Х.132) идэвхжих ба хаалга автоматаар хаагдана.




■ **Гарын оролцоогүй тээшний автомат хаалга (Гарын оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин)**

Гарын оролцоогүй тээшний автомат хаалга гэдэг нь арын гуперны төв хэсгийн доогуур хөлөө оруулаад гаргах үед тээшний автомат хаалгыг автоматаар нээх буюу хаах функц юм. Тус функц гарын оролцоогүй тээшний автомат хаалганы функцийг идэвхжүүлсэн, биедээ электрон түлхүүртэй, асаах товч OFF горимын үед ажиллана.

1 Биедээ электрон түлхүүр аванга арын гуперны Smart entry & start системийн ажиллах хүрээ болох 30-50см

(11.8-19.7 инч) зай дотор зогсоно.



A Kick сенсор

B Гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллах хүрээ

C Smart entry & start системийн ажиллах хүрээ (→Х.143)

2 Арын гупернээс 10см (3.9 инч) зайд хөлөө оруулаад дуут дохио дуугарсны дараа хөлөө буцааж гаргана.

Дээрх үйлдлийг 1 секундийн дотор хийж гүйцэтгэнэ.


Арын гуперны доод талд хөлийн хөдөлгөөн мэдрэгдээгүй тохиолдолд тээшний хаалга автоматаар ажиллахгүй.

Гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллуулах үед арын гуперт хөлөөр хүрэхгүй.

Бүхээг эсвэл тээшний хэсэгт өөр электрон түлхүүр байгаа үед хаалга ажиллаж эхлэхдээ бага зэрэг удаан байж болно.

Дуут дохио 2 удаа дуугарсан үед

үйлдлийг давтана.



A Kick сенсор

B Гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллах хүрээ

3 Гуперны доогуур хөл ороод гарсныг kick сенсор мэдрэх үед дуут дохио дуугарах ба тээшний хаалга автоматаар нээгдэх буюу хаагдана.

Тээшний хаалга нээгдэх буюу хаагдах явцад арын гупер доогуур хөлөө оруулаад гаргавал тээшний хаалганы ажиллагаа зогсоно.

Тээшний хаалганы ажиллагаа түр зогссон үед арын гупер доогуур хөлөө дахин оруулаад гаргавал тээшний хаалга эсрэг чиглэлд ажиллана.

■ Тээшний хаалганаас холдсоны дараа kick сенсороор тээшний хаалга хаагаад түгжих (Гарын оролцоогүй хаалга хаагаад түгжих [хаалганаас холдох] функц) *1, 2


*1: Тоноглогдсон загварт

*2: Lexus дилер дээр тохируулна.

Гарын оролцоогүй тээшний автомат хаалгыг хөлөө арын гуперны баруун доод талаар

оруулж гаргаад холдох үед тээшний хаалга хаагаад түгжих боломжтой. Гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллуулах үед асаах товч OFF горимд, тээшний автомат хаалга функцийг (kick сенсор) идэвхжүүлсэн мөн электрон түлхүүрийг биедээ авсан байх шаардлагатай.

1 Биедээ электрон түлхүүр аванга арын гуперны Smart entry & start системийн ажиллах хүрээ болох 30-50см (11.8-19.7 инч) зай дотор зогсоно.



A Kick сенсор

B Гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллах хүрээ

C Smart entry & start системийн ажиллах хүрээ (→X.143)


2 Арын гуперны доогуур 10 см (3.9инч) орчмын зайд хөлөө оруулж дуут дохио дуугарсны дараа хөлөө буцаан гаргана.

Дээрх үйлдлийг 1 секундйн дотор хийж гүйцэтгэнэ.

Арын гуперны доод талд хөлийн хөдөлгөөн мэдрэгдээгүй үед тээшний хаалга автоматаар ажиллахгүй.

Бүхээг эсвэл тээшний хэсэгт өөр электрон түлхүүр байгаа үед хаалга ажиллаж эхлэх эхэн үедээ бага зэрэг удаан байж болно.

Дуут дохио 2 удаа дуугарвал үйлдлийг давтана.



A Kick сенсор

B Гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллах хүрээ

3 Гуперны доогуур хөл ороод гарсныг kick сенсор мэдрэх үед хэвийн үеэс арай өөр дуут дохио дуугарах ба тээшний хаалга автоматаар нээгдэх буюу хаагдана.

4 Дуут дохио дуугарч байх үед тээшний хаалганаас холдоно.

Мэдрэгч таныг тээшний хаалганаас холдсоныг мэдэрсэн үед дуут дохио дуугарч ослын дохионы гэрэл (тоноглогдсон загварт) анивчана. Тээшний хаалганаас холдсон чиглэл, электрон түлхүүрийг барьж байгаа байдал эсвэл бусад нөхцөл байдлаас хамаарч таныг холдсоныг мэдрэгч зөв танихгүй байж болно.

Тээшнээс бусад бүх хаалга түгжигдэх ба тээшний автомат хаалга хаагдах үедээ түгжигдэнэ. Бүх хаалга хаагдаж түгжигдсэнийг илтгэж ажиллагааны дуут дохио дуугарч (тоноглогдсон загварт) ослын дохионы гэрэл анивчана.

Тээшний хаалганаас 30 секунд

дотор холдоогүй тохиолдолд систем ажиллахад бэлэн болсон статус цуцлагдана. Функцийг дахин ажиллуулах үед үйлдлийг давтана.

Электрон түлхүүртэй хүн тээшний хаалганд ойртвол хаалганы ажиллагаа зогсож бүх хаалганы түгжээ тайлагдах ба дуут дохио дуугарч (тоноглогдсон загварт) ослын дохионы гэрэл анивчана.

Тээшний хаалганы ажиллагаа зогссоны дараа дахин ажиллуулбал гарын оролцоогүй хаагад түгжих (хаалганаас холдох) функц ажиллахад бэлэн байдалд шилжинэ.

■ Тээшний хэсгийн гэрэл

- Тээшний хэсгийн гэрлийн товч асах байрлалд тээшний хаалга нээх үед гэрэл автоматаар асна.
- Хөдөлгүүрийн асаах товч OFF үед гэрэл 20 минутын дараа унтарна.

■ Тээшний хаалга хаагч

Тээшний хаалга дутуу хаагдсан үед автоматаар гүйцэд хаана.

Асаах товчны горимоос үл хамааран тээшний хаалга хаагч ажиллана.

■ Тээшний автомат хаалга ажиллах нөхцөл

Дараах нөхцөлд автоматаар нээгдэх буюу хаагдана:


- Тээшний автомат хаалганы системийг идэвхжүүлсэн үед
- Тээшний хаалга түгжигдээгүй үед Нөгөөтээгүүр биедээ электрон түлхүүртэй үед тээшний хаалга нээх товчийг удаан дарсан тохиолдолд хаалга түгжээтэй байсан ч хэвийн ажиллана (→Х.127)
- Асаах товч ON үед дээр дурдсанаас гадна дараах нөхцөлүүдэд тээшний хаалга ажиллана:
 - Зогсоолын тоормос татсан
 - Тоормосны дөрөө гишгэсэн
 - Арааны хөшүүрэг Р-д байгаа үед

■ Тээшний автомат хаалганы ажиллагаа

- Дуут дохио дуугарч тээшний хаалга нээгдэж, хаагдаж буйг илтгэнэ.
- Тээшний автомат хаалганы системийг цуцалсан үед тээшний автомат хаалга ажиллахгүй ба хаалгыг гараар нээж хаана.
- Тээшний автомат хаалга онгойх явцад хүн болон бусад эд зүйлд тулвал ажиллагаа зогсоно.

■ Хавчихаас хамгаалах функц

Тээшний хаалганы хоёр талд функцийн мэдрэгч суурилагдсан байдаг. Хаалга хаагдах явцад аливаа саад тулгарвал тээшний хаалга автоматаар эсрэг чиглэлд ажиллах буюу зогсоно.



■ Хаалга унахаас сэргийлэх функц

Тээшний хаалга автоматаар онгойх үед хаалга аливаа зүйлд тулсан эсвэл хаалганд огцом хүчээр нөлөөлсөн үед тус функц ажиллаж хаалга огцом унахаас сэргийлж онгойх үйлдлийг зогсоно.

■ Тээшний хаалга хаахад туслах систем

Нээлттэй тээшний хаалгыг гараар бага зэрэг дарах үед тээшний хаалга автоматаар бүрэн хаагдана.

■ Тээшний хаалга хамгийн сүүлд түгжигдэх функц

Тус функц тээшний автомат хаалга нээлттэй үед бусад бүх хаалгыг түгждэг.

Дараах үйлдлийг хийх үед тээшний хаалганаас бусад бүх хаалга түгжигдэх ба тээшний автомат хаалга

мөн хаагдах үедээ түгжигдэнэ.

- 1 Тээшний хаалганаас бусад бүх хаалгыг хаана.
- 2 Тээшний автомат хаалга хаагдах явцад бусад хаалгыг Smart entry & start систем (→X.118) эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар түгжинэ. (→X.118)

Дуут дохио дуугарч бүх хаалга хаагдаж түгжигдсэнийг илтгэнэ. (→X.119)

- Тус функцийн ажиллагаа эхэлсний дараа электрон түлхүүрийг автомашин дотор орхивол түлхүүр автомашин дотор түгжигдэх аюултай.
- Функц ажиллан хаалга хаагдах явцад хавчихаас хамгаалах функц ажиллах зэргээр тээшний автомат хаалганы ажиллагаа зогссон тохиолдолд тус функцийн ажиллагаа цуцлагдах ба бүх хаалганы түгжээ тайлагдана.
- Автомашиныг орхихын өмнө бүх хаалга түгжигдсэн эсэхийг нягтална.

■ Хаагаад түгжих (хаалганаас холдох) функц ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед тус функц ажиллана:

- Хаагаад түгжих (хаалганаас холдох) функцийг идэвхжүүлсэн
- Бүхээгт электрон түлхүүр байхгүй
- Тээшний автомат хаалганаас бусад бүх хаалга хаалттай
- Хөдөлгүүрийн асаах товч OFF горимд буюу унтраастай
- Электрон түлхүүр системийн таних хүрээнд байгаа

■ Хаагаад түгжих функц (хаалганаас холдох) ажиллахгүй байж болох нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд функц хэвийн ажиллахгүй байж болно:

- Smart entry & start системийн хэвийн ажиллагаа алдагдсан
- Хаагаад түгжих функцийн хэвийн

ажиллагаа алдагдсан

- Хаагаад түгжих функц (хаалганаас холдох) ажиллахад бэлэн байдалд байгаа үед хаалганаас холдсон
- Автомашинд бүртгүүлсэн электрон түлхүүрийн тоо нэмэгдсэн

■ Хаагаад түгжих функц* ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед тус функц ажиллана:

- Бүхээгт электрон түлхүүр байхгүй
 - Тээшний автомат хаалганаас бусад бүх хаалга хаалттай
 - Асаах товч OFF горимд унтраастай
- * : Lexus дилер дээр тохируулна.

■ Хаагаад түгжих функц* ажиллахгүй байж болох нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд тус функц хэвийн ажиллахгүй байж болно:

- Тээшний автомат хаалганы доод хэсгийн  товчийг электрон түлхүүртэй гараар дарсан үед
- Тээшний автомат хаалганы доод хэсгийн  товчийг электрон түлхүүр цүнх, уутанд хийж газарт тавиад дарсан үед
- Тээшний автомат хаалганы доод хэсгийн  товчийг электрон түлхүүр ойр орчимд байхгүй үед дарсан

* : Lexus дилер дээр тохируулна.

■ Гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллах нөхцөл (Гарын оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин)

Гарын оролцоогүй тээшний автомат хаалга дараах нөхцөлүүд бүрдсэн үед нээгдэх буюу хаагдана:

- Гарын оролцоогүй тээшний автомат хаалгыг (kick сенсор) идэвхжүүлсэн.
- Асаах товч OFF горимд эсвэл ON

горимд Р араатай байгаа.

- Электрон түлхүүр ажиллах хүрээнд байгаа. (→Х.143)
- Арын гуперын гол хэсэгт хөл ороод гарсан.
Тээшний автомат хаалга нь арын гуперын гол хэсгийг доогуур гар, тохой, өвдөг зэргээ оруулаад гаргасан үед мөн ажиллах боломжтой. Арын гуперын төв хэсгийн доор мэдрэгч байгааг анхаарна уу.

■ Гарын оролцоогүй тээшний автомат хаалга зөв ажиллахгүй байж болох нөхцөлүүд (Гарын оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин)

Дараах нөхцөлүүдэд гарын оролцоогүй тээшний автомат хаалга зөв ажиллахгүй байж болно:

- Гуперын доороос хөлөө аваагүй.
- Арын гуперын хүчтэй цохисон эсвэл гуперт хүрсэн хэвээр байх.

Арын гуперт гар болон бусад зүйлсээр удаан хугацаанд хүрсэн бол гарын оролцоогүй тээшний автомат хаалгыг дахин ажиллуулахын өмнө хэсэг хүлээнэ.

- Ажиллагааг гүйцэтгэсэн хүн арын гуперт хэт ойр байсан.
- Автомашин болон электрон түлхүүрийн сигнал солилцох явцад бусад радио долгионы эх үүсвэр саад болсон үед. (→Х.144)
- Автомашин төлбөртэй зогсоол, ШТС, цахилгаан халаалттай зам, өдрийн гэрэл зэрэг гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагаанд нөлөөлөх цахилгаан долгионы шуугиан үүсгэдэг төхөөрөмжийн ойр орчимд байгаа үед.
- Телевизийн цамхаг, радио станц, цахилгаан станц, том дэлгэц, нисэх буудал бусад хүчтэй радио долгион ялгаруулдаг газрын ойр орчимд.
- Автомашин угааж байгаа, хүчтэй бороотой зэргээр арын гупер лүү их хэмжээний ус цацагдсан.
- Арын гупер дээр цас, мөс, шавар тогтсон.
- Өвс ургамал зэрэг хөдөлгөөнтэй эд зүйл арын гуперт хүрсэн байдалтайгаар удаан зогсолт хийсэн.

- Арын гуперт нэмэлт тоноглол угсарсан.

Нэмэлт тоноглол угсарсан үед гарын оролцоогүй тээшний автомат хаалганы (Kick сенсор) ажиллагааг салгана.

■ **Гарын оролцоогүй тээшний автомат хаалга (Гарын оролцоогүй тээшний автомат хаалгатай автомашин) санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх**

Электрон түлхүүр ажиллах хүрээнд байгаад үед гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллаж болзошгүй тул дараах нөхцөлд анхаарал болгоомжтой байна.

Санамсаргүй ажиллахаас сэргийлж гарын оролцоогүй тээшний автомат хаалганы (Kick сенсор) ажиллагааг салгана.

- Автомашиныг угаалгах эсвэл хүчтэй бороотой зэргээр арын гупер луу их хэмжээний ус цацагдсан.
- Арын гуперт тогтсон тоос шороог арчиж цэвэрлэх үед.
- Жижиг биетэй амьтан эсвэл бөмбөг зэрэг жижиг эд зүйл арын гуперны доогуур хөдөлсөн үед.
- Арын гуперны доороос аливаа эд зүйл хөдөлж холдсон үед.
- Арын тээшний хаалга дээр суусан хүн хөлөө савчуулан хөдлөх үед.
- Автомашины араар өнгөрч буй хүн арын гуперт хөл, биеэрээ хүрсэн үед.
- Автомашин төлбөртэй зогсоол, ШТС, цахилгаан халаалттай зам, өдрийн гэрэл зэрэг гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагаанд нөлөөлөх цахилгаан долгионы шуугиан үүсгэдэг төхөөрөмжийн ойр орчимд байгаа үед.
- Телевизийн цамхаг, радио станц, цахилгаан станц, том дэлгэц, нисэх буудал бусад хүчтэй радио долгион ялгаруулдаг газрын ойр орчимд.
- Өвс ургамал зэрэг хөдөлгөөнтэй эд зүйл арын гуперт хүрсэн байдалтайгаар удаан зогсолт хийсэн.
- Арын гуперт ачаа тээш ойр байгаа.
- Арын гуперт нэмэлт тоноглол, бүтээлэг суурилуулсан эсвэл

салгаж авсан.

- Автомашин чирүүлж буй үед.

■ **Гарын оролцоогүй хаагаад түгжих функц (хаалганаас холдох)^{*1} ажиллах нөхцөл**

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед тус функц ажиллана:

- Гарын оролцоогүй хаагаад түгжих функц (хаалганаас холдох)^{*2}-г идэвхжүүлсэн.
- Гарын оролцоогүй тээшний автомат хаалга^{*1} идэвхжүүлсэн.
- Бүхээгт электрон түлхүүр байхгүй.
- Тээшний автомат хаалганаас бусад бүх хаалга хаалттай.
- Хөдөлгүүрийн асаах товч OFF горимд унтраастай.
- Электрон түлхүүр системийн мэдрэх хүрээнд байгаа.

^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Lexus дилер дээр тохируулна.

■ **Гарын оролцоогүй хаагаад түгжих функц (хаалганаас холдох)^{*1, 2} ажиллахгүй байж болох нөхцөлүүд**

Дараах нөхцөлүүдэд функц хэвийн ажиллахгүй байж болно:

- Smart entry & start системийн хэвийн ажиллагаа алдагдсан.
- Хаагаад түгжих функцийн хэвийн ажиллагаа алдагдсан.
- Хаагаад түгжих функц (хаалганаас холдох) ажиллахад бэлэн байдалд байгаа үед хаалганаас холдсон.
- Автомашинд бүртгүүлсэн электрон түлхүүрийн тоо нэмэгдсэн.
- Гарын оролцоогүй тээшний автомат хаалга хэвийн ажиллахгүй үед^{*1}.

^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Lexus дилер дээр тохируулна.

■ **Аккумулятор дахин холбох үед**

Тээшний автомат хаалганы хэвийн ажиллагааг сэргээхийн тулд хаалгыг гараар хаана.


■ **Тээшний хаалга нээгч ажиллахгүй үед**

Тээшний хаалганы түгжээг дотор


талаас тайлах боломжтой.

1 Тагийг тайлж авна.


Хортон суухаас сэргийлж халивын үзүүрийг даавуугаар жийрэглэнэ.




2 Боолтыг суллана.



3 Тагийг эргүүлнэ.



4 Хөшүүргийг хөдөлгөнө.



5 Урвуу дарааллаар угсарна.


■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим тохиргоог (Тээшний автомат хаалга онгойх өнцөг) өөрчлөх боломжтой. (Дэлгэрэнгүйг: →Х.583)

! АЮУЛТАЙ

■ Тээшний хаалга хаагч

● Тээшний хаалга дутуу хаагдсан үед тус функц гүйцэд хаана. Функц ажиллаж эхлэх хүртэл цөөн хэдэн секундийн хугацаа шаардагдана. Тулгуур эрхтний гэмтэл бусад ноцтой гэмтэлд хүргэж болзошгүй тул гар хуруу мөн бусад зүйлс хаалганд хавчуулагдахаас сэргийлнэ.



● Тээшний автомат хаалганы ажиллагааг салгасан ч тээшний хаалга хаагч ажиллах тул анхаарал болгоомжтой байна.

■ Тээшний автомат хаалга

Хаалга ажиллуулах үед дараах анхааруулгыг дагаж мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

● Ойр орчимд хаалганы ажиллагаанд саад учруулах эсвэл таны эд зүйлийг татаж хавчуулах эд зүйл байхгүй эсэхийг нягтална.

● Ойр орчимд бусад хүн байгаа үед аюулгүй байдлыг нягтлах хаалга нээх, хаах гэж буйг анхааруулна.



АЮУЛТАЙ

- Тээшний хаалга автоматаар ажиллах үед тээшний автомат хаалганы системийг унтраавал автомат ажиллагаа зогсоно. Энэ үед тээшний хаалгыг гараар нээж хаана. Хаалга гэнэт нээгдэх, хаагдах аюултай тул налуу газар өндөр анхаарал болгоомжтой байна.
- Тээшний автомат хаалга ажиллах нөхцөлүүд бүрдээгүй үед анхааруулах дуут дохио дуугарах ба тээшний хаалганы ажиллагаа зогсоно. Энэ үед тээшний хаалга гараар ажиллуулна. Энэ үед тээшний хаалгыг гараар нээж хаана. Налуу газар дээр тээшний хаалга огцом нээгдэх буюу хаагдаж болзошгүй тул өндөр анхаарал болгоомжтой харьцана.
- Налуу газарт тээшний хаалга нээсний дараа огцом хаагдаж болно. Тээшний хаалгыг бүрэн нээж хөдөлгөөнгүй болсон эсэхийг нягтална.
- Дараах нөхцөлд тээшний автомат хаалга алдаа зааж ажиллагаа нь зогсоно. Энэ үед хаалгыг гараар нээж хаана. Хаалга гэнэт нээгдэх, хаагдах аюултай тул налуу газар анхааралтай байна.
- Хаалга саадад тулсан үед
- Автомат хаалга ажиллах явцад хөдөлгүүр асаах товч ON горимд шилжих, хөдөлгүүр асаах зэргээр аккумуляторын хүчдэл унасан

● Унадаг дугуйны суурь, ижил төрлийн хүнд зүйл хаалганд бэхэлбэл автомат хаалга ажиллахгүй байх эсвэл хаалга нээгдсэний дараа гэнэт хаагдан, улмаар хүний гар, толгой, хүзүү хавчиж гэмтээх аюултай. Хаалганд нэмэлт тоноглол суурилуулах бол Lexus-н оригинал тоноглол ашиглах нь зүйтэй.

■ Хавчихаас хамгаалах функц

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Хавчихаас хамгаалах функцийн ажиллагааг шалгахын тулд биеэ хавчуулж турших нь аюултай.
- Хаалга бүрэн хаагдахын дөнгөж өмнө хавчуулагдсан эд зүйлийг хавчихаас хамгаалах функц мэдрэхгүй байх магадлалтай. Гар хуруу болон бусад эд зүйл хавчуулахгүй байхад анхаарна.
- Функц хавчуулагдсан эд зүйлийн хэлбэрээс хамаарч ажиллахгүй байж болно. Гар хуруу болон бусад эд зүйл хавчуулахгүй байхад анхаарна.

■ Гарын оролцоогүй тээшний автомат хаалга (тоноглогдсон загварт)

Гарын оролцоогүй тээшний автомат хаалга ажиллуулах үед дараах анхааруулгыг дагаж мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Ойр орчимд хаалганы ажиллагаанд саад учруулах эсвэл танд татаж хавчуулагдах эд зүйлс байхгүй эсэхийг нягтална.
- Арын гуперны доогуур хөлөө хийх үед түлэгдэж гэмтэх аюултай тул яндан бүрэн хөрөх хүртэл хүрч болохгүй.

- Электрон түлхүүрийг тээшний хэсгийн ажиллах хүрээнд (түлхүүр таних хүрээ) дотор үлдээж болохгүй.

⚠ АЮУЛТАЙ

- **Хаагаад түгжих (хаалганаас холдох) функц болон гарын оролцоогүй хаагаад түгжих (хаалганаас холдох) функц**

*1: Тоноглогдсон загварт

*2: Lexus дилер дээр тохируулна.

Тээшний хаалганаас холдох үед тээшний хаалга автоматаар хаагдаж эхэлнэ. Ойр орчимд хаалганы ажиллагаанд саад учруулах эсвэл таны эд зүйлийг татаж хавчуулах эд зүйл байхгүй эсэхийг нягтална.


⚠ АНХААР

- **Тээшний хаалга өргөгч**

Тээшний хаалганд хаалгыг тодорхой байрлалд барих хаалга өргөгч суурилагдсан байдаг.

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд хаалга өргөгчийг эвдэх болон хэвийн ажиллагаа нь алдагдахад хүргэнэ.



- Хуулга, наалддаг цаас болон бусад эд зүйлсийг өргөгчийн голд наахгүй
- Тээшний автомат хаалганд Lexus-н оригиналаас бусад нэмэлт тоноглол угсарч болохгүй.

- Хаалга өргөгчинд огцом хүчээр нөлөөлөхгүй.

- **Тээшний хаалга хаагч эвдрэхээс сэргийлэх**

Хаалга автоматаар ажиллах явцад огцом хүчээр нөлөөлөхийг хориглоно. Тээшний хаалганд гэмтэл учруулах аюултай.

- **Тээшний автомат хаалгыг гэмтлээс сэргийлэх**

- Тээшний хаалганы хөдөлгөөнд саад болох мөс зэргийн зүйл хаалга болон араамны завсар байхгүй эсэхийг нягтална. Хаалганы ажиллагаанд хэт ачаалал үзүүлэх байдлаар ажиллуулах нь системийг эвдрэлд хүргэнэ.

- Хаалга ажиллах явцад огцом хүчээр нөлөөлөхийг хориглоно.

- Мэдрэгчүүдийг (тээшний автомат хаалганы зүүн ба баруун өнцөгт байрлах) хутга зэрэг иртэй зүйлээр гэмтээж болохгүй. Мэдрэгчүүд гэмтвэл тээшний хаалга автомат горимоор ажиллахгүй.

- **Хаагаад түгжих функц***

Хаагаад түгжих функцээр тээшний автомат хаалга хаах үед хэвийн үеэс арай өөр анхааруулах дуут дохио дуугарна.

Функцийн ажиллагаа зөв эхэлснийг дуут дохионы дуугаар нягтална.

Мөн тээшний автомат хаалга бүрэн хаагдаад түгжигдэх дохио нь бүх хаалга түгжигдсэнийг илтгэнэ. (→X.119)

Автомашиньг орхин явахын өмнө хаалга түгжигдэж сигнал дуугарсан эсэхийг нягтална.

*: Lexus дилер дээр тохируулна.



АНХААР

■ Гарын оролцоогүй тээшний автомат хаалганы анхааруулга (тоноглогдсон загварт)

Kick сенсор нь арын гуперны төв хэсгийн доод хэсэгт байрладаг. Гарны оролцоогүй тээшний автомат хаалганы хэвийн ажиллагааг хангахын тулд дараах анхааруулгыг мөрдөнө:

- Арын гуперны төв хэсгийн доод талыг тогтмол арчиж цэвэрлэнэ.

Мэдрэгчийн ойр орчим бохирдсон, цас тогтсон үед Kick сенсор ажиллахгүй байж болно. Цас, шороо тоосыг цэвэрлээд автомашиныг өөр байрлалд шилжүүлээд мэдрэгчийн ажиллагааг шалгана. Мэдрэгч ажиллахгүй байвал өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна.

- Арын гуперны төв хэсгийн доод талд ус үл тогтогч бодис болон бусад төрлийн өнгөлгөө хийж болохгүй.

- Өвс, мод зэрэг хөдөлж арын гуперт хүрч болох зүйлтэй ойроор автомашиныг зогсоон байрлуулж болохгүй.

Арын гуперт өвс, мод зэрэг зүйлс удаан хугацаанд хүрэх байдлаар автомашиныг байрлуулбал мэдрэгч ажиллахгүй байж болно. Энэ үед автомашиныг өөр байрлалд шилжүүлж мэдрэгчийн ажиллагааг шалгана. Мэдрэгч ажиллахгүй үед та өөрийн Lexus дилерт хандан оношлуулна уу.

- Kick сенсор болон ойр орчмыг хүчтэй цохилтонд өртүүлж болохгүй.

Мэдрэгч болон түүний ойр орчим хүчтэй цохилтонд өртвөл мэдрэгчийн зөв ажиллагаа алдагдаж болзошгүй. Дараах нөхцөлүүдэд kick сенсор ажиллахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

- Kick сенсор болон түүний ойр орчим хүчтэй цохилтонд өртсөн

- Арын гуперны баруун доод тал зурагдсан, гэмтсэн

- Арын гуперыг задалж болохгүй.

- Арын гупер дээр наалт нааж болохгүй.

Арын гуперыг будаж болохгүй.

- Унадаг дугуйн суурь, ижил төрлийн хүнд зүйл тээшний автомат хаалганд бэхэлбэл мэдрэгч идэвхгүй болно.

Тээшний автомат хаалганы системийг цуцлах

Төв хянах дэлгэцээр тээшний автомат хаалганы системийг идэвхжүүлэх мөн цуцлах боломжтой. (→X.583)


- 1 Голын дэлгэцээс -г сонгоно.
- 2 “Vehicle customise”-г сонгоно.
- 3 “Door control”-г сонгоно.
- 4 “Power back door”-г сонгоно.
- 5  (ON)/  (OFF)-г сонгоно.

Голын дэлгэц дээр OFF-г сонгож тээшний автомат хаалганы ажиллагааг цуцалсан үед тус

тохиргоог ON болгож буцаах хүртэл тээшний автомат хаалганы ажиллагаа идэвхжихгүй. (Асаах товчны ажиллагаагаар идэвхжихгүй)

Гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагаа цуцлах (тоноглогдсон автомашинд)

Гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагааг (хөлөөр ажиллуулах мэдрэгч) голын дэлгэц дээр идэвхжүүлнэ/цуцална. (→X.583)

- 1 Голын дэлгэцээс -г сонгоно.
- 2 “Vehicle customise”-г сонгоно.
- 3 “Door control”-г сонгоно.
- 4 “Hands free”-г сонгоно.
- 5  (ON)/  (OFF)-г сонгоно.

Голын дэлгэц дээр OFF-г сонгож гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагааг цуцалсан үед тус тохиргоог ON болгож буцаах хүртэл гарын оролцоогүй тээшний автомат хаалганы ажиллагаа идэвхжихгүй. (Хөдөлгүүр асаах товчны ажиллагаагаар идэвхжихгүй)

Тээшний хаалганы нээгдэх байрлалыг тохируулах

Тээшний автомат хаалганы нээгдэх байрлалыг тохируулж болно.


- 1 Тээшний хаалгыг тохируулах байрлалд нээнэ. (→X.126)

2 Тээшний автомат хаалганы

 товчийг 2 секунд дарна.

Тохиргоо хийгдэж дууссаны дараа анхааруулах дуут дохио 4 удаа дуугарна.


Тээшний хаалга дахин нээх үед тухайн тохируулсан байрлалд зогсоно.



■ Тээшний хаалганы нээгдэх байрлалыг тохируулах тохиргоог цуцлах

Тээшний автомат хаалганы  товчийг 7 секунд дарна.

Анхааруулах дуут дохио 4 удаа дуугарсны дараа дахин 2 удаа дуугарна. Хаалгыг дахин нээх үед тохиргоо хийгдээгүй анхны байрлалд нээгдэнэ.



■ Өөрчлөх боломжтой тохиргоо


Мэдээллийн дэлгэцээр дамжуулан нээгдэх байрлалыг тохируулах боломжтой. (→X.583)

Тээшний хаалга дахь тээшний

автомат хаалганы  товч эсвэл мэдээллийн дэлгэцийн тохиргооны аль сүүлд хийсэн тохиргоогоор тээшний хаалга нээгдэнэ.

Арын гишгүүр

Арын гуперны гишгүүр нь ачаа ачих, буулгах үед гупер хамгаалах зориулалттай.




Тээшний хаалганы нээгддэг цонх

Тээшний хаалганы нээгддэг цонхыг тээшний хаалганы нээгддэг цонх онгойлгогчоор онгойлгоно.

Тээшний хаалганы нээгддэг цонх онгойлгох

■ Тээшний хаалганы нээгддэг цонх онгойлгогч




1 Товчийг дарах үед цонх бага зэрэг нээгдэнэ.

2 Өргөнө.

Тээшний хаалга түгжээтэй үед цонхийг нээх боломжгүй. Тээшний хаалганы түгжээг тайлаад нээнэ. (→X.126)

■ Smart entry & start систем



- 1 Электрон түлхүүртэй үед товчийг дарахад цонх бага зэрэг нээгдэнэ.

- 2 Өргөнө.

Тээшний хаалга түгжээтэй байсан ч цонхийг нээх боломжтой.

■ Тээшний хаалганы нээгддэг цонх нээх үед

- Тээшний хаалганы дээш нээгддэг цонхийг удаан, болгоомжтой нээнэ.
- Тээшний хаалга хаалттай үед цонхийг нээнэ.

■ Хойд шил арчигч ажиллах үед цонх нээх

Хойд шил арчигчийн ажиллагаа зогсоно. Цонх хаагдсан үед шил арчигч дахин ажиллаж эхэлнэ.

■ Ажиллагааны дуут дохио

→X.120

■ Нээгддэг цонх хаасны дараа

Цонх бүрэн хаагдсан эсэхийг шалгана. Нээгддэг цонх дутуу хаагдсан үед хойд шил арчигч хэвийн ажиллахгүй.

▲ АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үед

- Хөдөлгөөний үед цонхыг бүрэн хаасан байна.

Онгорхой нээгддэг цонх нь хөдөлгөөний үед бусад эд зүйлсийг цохих эсвэл тээш шидэгдэж осол аваар үүсгэх аюултай.

Мөн бүхээгт автомашины хаягдал утаа орох, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй. Хөдөлгөөн эхлэхийн өмнө цонхыг бүрэн хаана.

- Хөдөлгөөн эхлэхийн өмнө цонх бүрэн хаагдсан эсэхийг нягтлана. Дутуу хаагдсан цонх хөдөлгөөний үед гэнэт онгойх, улмаар осол үүсгэх аюултай.

■ Автомашинд бага насны хүүхэд байгаа үед

Цонхыг бага насны хүүхдээр нээлгэж хаалгаж болохгүй.

Цонх гэнэт хөдлөх, бага насны хүүхдийн гар, толгой, хүзүүг хавчих аюултай.

■ Цонх ажиллуулах

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд хаалганд хавчуулагдах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэлд хүрэх аюултай.

- Цонх нээхийн өмнө цас, мөс зэрэг цонхонд тогтсон хүнд жинтэй зүйлийг авна. Эсрэг тохиолдолд онгойсон цонх гэнэт хаагдах аюултай.

- Цонх нээх, хаах үед ойр орчмын аюулгүй байдлыг бүрэн нягтлана.

- Ойр орчимд хүн байгаа тохиолдолд тэдэнд учрах аюул байхгүй эсэхийг нягтлаад цонх нээгдэх, хаагдах гэж байгааг анхааруулна.

- Хүчтэй салхинд цонх савж болзошгүй тул салхитай өдөр хаалга нээх, хаах үед өндөр анхааралтай байна.

- Цонх бүрэн нээгдээгүй үед гэнэт хаагдаж болзошгүй. Налуу газар тээшний хаалганы цонх нээх, хаах нь тэгш талбайгаас илүү анхаарал болгоомж шаардах тул цонх өөрөө хаагдах, нээгдэхээс болгоомжилно. Тээшний хэсгийг ашиглахын өмнө тээшний хаалганы цонх бүрэн нээгдсэн, аюулгүй эсэхийг нягтлана.



⚠ АЮУЛТАЙ

- Тээшний хаалганы хаалганы цонх хаах үед гар, хуруу зэргээ хавчуулахаас болгоомжилно.



- Тээшний хаалганы цонх хаахдаа гадна талаас нь зөөлөн дарж хаана.
- Тээшний хаалганы цонх хаахын тулд цонх нээх тулгуураас татах эсвэл зүүгдэх хориотой.

Эсрэг тохиолдолд цонх нээх тулгуурт гараа хавчуулах эсвэл тулгуур эвдэрч осол аваарт хүргэх аюултай.


- Тээшний хаалганы цонхонд Lexus-н оригинал сэлбэгээс бусад аливаа оригинал бус нэмэлт тоноглол суурилуулахыг хориглоно. Цонхонд ирж буй нэмэлт жингийн улмаас нээгдсэн цонх гэнэт буцаж хаагдах аюултай.

⚠ АНХААР

■ Тээшний хаалганы цонх нээх тулгуур

Тээшний хаалганы цонхонд нээгдсэн цонхыг барих зориулалт бүхий тулгуур суурилагдсан байдаг. Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд тулгуурыг эвдэх, хэвийн ажиллагаа нь алдагдахад хүргэнэ.




- Хуулга, наалддаг цаас болон бусад эд зүйлсийг тулгуурын голд наахгүй байх.
- Тулгуурын голд бээлий мөн бусад даавуун материалтай эд зүйлс хүргэхгүй байх.
- Оригинал бус нэмэлт тоноглол цонхонд суурилуулахгүй байх.
- Тулгуурыг гараар барих, хажуу тийш татахгүй байх.

Smart entry & start систем

Автомашины электрон түлхүүрийг (түлхүүр карт мөн хамаарна) халаасандаа зэргээр биедээ авсан үедээ дараах үйлдлүүдийг хийх боломжтой. Жолооч электрон түлхүүрийг байнга биедээ авна.


- Хаалга түгжих, тайлах (→X.118)
- Тээшний хаалга түгжих, тайлах (→X.126)
- Хөдөлгүүр асаах (→X.203)

■ Антенны байрлал



- A** Гадна байрлах антен (урд)
- B** Гадна байрлах антен (хойд)
- C** Тээшний хэсгийн гадна байрлах антен
- D** Бүхээг дотор байрлах антен

■ Үйлчлэх хүрээ (электрон түлхүүрийг таних хүрээ)



A Хаалга түгжих ба тайлах

Аль нэг хаалганы гадна бариул эсвэл тээшний хаалга нээх товчноос 0.7м (2.3фут) дотор электрон түлхүүр байгаа тохиолдолд систем ажиллана. (Зөвхөн тухайн түлхүүрийг таньсан хаалга ажиллана.)

B Хөдөлгүүр асаах эсвэл хөдөлгүүр асаах товчийн горим солих

Электрон түлхүүр автомашин дотор үед систем ажиллана.

■ Анхааруулах дуут дохио дуугарсан, анхааруулга дэлгэц дээр гарсан үед

Автомашины гадна талын болон салоны анхааруулах дуут дохио, анхааруулах гэрэл болон мэдээллийн дэлгэц дээрх анхааруулах мэдээлэл нь хүний буруутай үйлдлээс шалтгаалан автомашин хулгайд өртөх мөн таамаглашгүй алдаа гарахаас сэргийлдэг. Тухайн анхааруулах мэдээллийн дагуу тохирох арга хэмжээг авна.

Дараах хүснэгтэд зөвхөн анхааруулах дуут дохио дуугарсан үеийн нөхцөл байдал, авах арга хэмжээг харуулав.

- Гадна талын анхааруулах дуут дохио нэг удаа 5 секунд дуугарах

Нөхцөл байдал	Авах арга хэмжээ
Хаалга нээлттэй үед автомашиныг түгжих оролдлого хийсэн	Бүх хаалгыг бүрэн хаасны дараа дахин түгжинэ

- Салоны анхааруулах дуут дохио үргэлжлэн дуугарах

Нөхцөл байдал	Авах арга хэмжээ
Жолоочийн хаалга нээлттэй үед асаах товчийг ACC горимд шилжүүлсэн (эсвэл асаах товчны ACC горимын үед жолоочийн хаалга нээсэн)	Асаах товчийг OFF болгон унтрааж жолоочийн хаалгыг хаана

■ Аккумулятор, түлхүүрийн зайны цэнэг хэмнэх функц

Тус функц автомашин урт хугацаанд ашиглагдаагүй үед аккумулятор болон электрон түлхүүрийн зайны цэнэг хэмнэх зорилгоор идэвхждэг.


- Дараах нөхцөлд Smart entry & start системийн хаалганы түгжээ тайлах хугацаа удаан байж болно.
- Электрон түлхүүрийг автомашинаас 3.5м (11.5 фут)-ээс хол зайд 40 секундээс дээш хугацаагаар орхисон үед
- Smart entry & start систем 5-аас дээш хоног ашиглагдаагүй үед
- Smart entry & start систем 14-с дээш хоног ашиглагдаагүй үед зөвхөн жолоочийн хаалгаар түгжээ тайлж болно. Энэ тохиолдолд жолоочийн хаалганы бариулаас барих, алсын удирдлага ашиглах эсвэл механик түлхүүрээр хаалга тайлна.

■ Электрон түлхүүрийн зайны цэнэг хэмнэх функц

- Зайны цэнэг хэмнэх горим сонгогдсон үед электрон түлхүүрийг радио долгион авдаггүй болгох замаар

зайны цэнэг алдалтыг бууруулдаг.

Товчийг дарангаа товчийг 2 удаа дарна. Электрон түлхүүрийн индикатор гэрэл 4 удаа анивчина. Зайны цэнэг хэмнэх горим сонгогдсон үед Зайны цэнэг хэмнэх горим сонгогдсон үед Smart entry & start системийг ашиглах боломжгүй болдог. Горимыг цуцлахдаа электрон түлхүүрийн аль нэг товчийг дарна.



- Удаан хугацаанд ашиглахгүй электрон түлхүүрийг урьдчилан зайны цэнэг хэмнэх горимд тохируулан хадгалах боломжтой.

■ Электрон түлхүүрийн ажиллагаа зогсох

Электрон түлхүүрийг нэг байрлалд удаан хугацаанд хөдөлгөөнгүй орхисон нөхцөлд зайны цэнэг хэмнэх үүднээс түлхүүрийн электрон удирдлагын ажиллагаа зогсдог. Түлхүүрийг өргөх зэргээр хөдөлгөх үед түлхүүрийн ажиллагаа сэргэнэ.

■ Ажиллагаанд нөлөөлөх нөхцөл

Smart entry & start систем нь хүчин чадал бага радио долгион ашигладаг. Дараах тохиолдлуудад электрон түлхүүр болон автомашины хооронд долгион тасалдаж электрон түлхүүр болон асаалтын систем, хөдөлгүүрийн иммобилайзер систем мөн алсын удирдлагын ажиллагаа алдагдаж болно.

- Электрон түлхүүрийн зай суусан үед
- Телевизийн цамхаг, цахилгаан

станц, ШТС, радио станц, том оврын дэлгэц, нисэх буудал бусад хүчтэй радио долгион болон цахилгаан долгион ялгаруулдаг газрын ойр орчимд

- Электрон түлхүүр дараах металл эд зүйлстэй нийлсэн эсвэл бүрхэгдсэн үед
 - Хөнгөн цагаан ялтастай карт
 - Дотроо хөнгөн цагаан материалаар бүрэгдсэн тамхины хайрцаг
 - Металл түрийвч, цүнх
 - Зоос
 - Металлын агаартай исэлдэх үед дулаан ялгаруулах чанарыг нь ашигласан гар дулаацуулагч элс (металл элс)
 - CD, DVD зэргийн медиа дамжуулагч
- Ойр орчимд алсын удирдлагатай түлхүүр (радио долгион цацдаг) ашиглагдаж байгаа үед
- Электрон түлхүүрийг дараах радио долгион цацдаг төхөөрөмжүүдтэй хамт авч явах үед
- Зөөврийн радио, гар утас бусад холбоо харилцааны утасгүй төхөөрөмж
- Радио долгион цацдаг өөр автомашины электрон түлхүүр, алсын удирдлагатай түлхүүр
- Персонал компьютер эсвэл халаасны компьютер
- Дижитал аудио тоглуулагч
- Зөөврийн тоглоомын консол
- Арын цонхны шилэнд металлын агуулгатай шилний наалт эсвэл металл эд зүйлс наасан үед
- Электрон түлхүүрийг зай хураагуур цэнэглэгч эсвэл цахилгаан төхөөрөмжийн хажууд тавьсан үед
- Радио долгионоор ажилладаг төлбөртэй автозогсоолд байрлуулах үед

Smart entry & start системээр хаалга түгжигдэх, түгжээ тайлагдахгүй үед дараах аль нэг үйлдлээр түгжих буюу тайлна.

- Урд хаалганд электрон түлхүүрийг ойртуулж entry функцийг

ажиллуулна.

- Түлхүүрийн алсын удирдлагыг ажиллуулна.

Дээрх аргаар хаалга түгжих, тайлах боломжгүй үед механик түлхүүр ашиглана. (→Х.117)

Хөдөлгүүр smart entry & start системээр асахгүй үед авах арга хэмжээг Х.560.-с харна уу.

■ Entry функцийн анхааруулга

- Дараах нөхцөлүүдэд электрон түлхүүр үйлчлэх хүрээ (электрон түлхүүрийг таних хүрээ)-нд байсан ч систем ажиллахгүй байж болно:
 - Хаалга түгжих, тайлах үед электрон түлхүүр цонх эсвэл хаалганы бариулд хэт ойр, автомашинаас хэт өндөр эсвэл хэт нам дор байх
 - Хөдөлгүүр асаах, хөдөлгүүр асаах товчны горим солих үед электрон түлхүүр хянах самбар, тээшний хэсгийг тусгаарлах гүйдэг хучлага (тоноглогдсон загварт) болон шалан дээр, хаалганы халаас эсвэл урд хайрцагт байх
- Автомашинаас гарах үедээ электрон түлхүүрийг хянах самбарын дээд тал, хаалганы халаасны ойр орчимд үлдээж болохгүй. Радио долгион хүлээн авч буй байдлаас хамаарч антен түлхүүрийг автомашины гадна байна гэж таних улмаар түлхүүрээ кабинд үлдээн түгжих нөхцөл бүрддэг.
- Электрон түлхүүр үйлчлэх хүрээнд байгаа үед бусад хүн хаалга түгжих, түгжээ тайлах боломжтой. Гэхдээ түгжээг зөвхөн тухайн электрон түлхүүр таньсан хаалгаар тайлах боломжтой.
- Электрон түлхүүр автомашины гадна байх хэдий ч цонхонд ойр үед хөдөлгүүр асаж болно.
- Электрон түлхүүр системийн үйлчлэх хүрээнд байгаа үед бороо орох, автомашин угаах зэргээр хаалганы бариул дээр их хэмжээний ус цацагдсан тохиолдолд хаалганы түгжээ тайлагдаж болно. (Хаалга нээж хаагаагүй бол 30 орчим секундйн дараа автоматаар түгжигдэнэ.
- Электрон түлхүүр автомашины ойр

орчимд байх үед алсын удирдлагаар автомашин түгжсэн үед entru функцээр хаалганы түгжээ тайлагдахгүй байж болно. (Түгжээг алсын удирдлагаар тайлна.)

- Бээлийтэй гараар хаалганы бариул барих үед хаалганы түгжээ тайлагдах, түгжигдэхгүй байж болно.
- Хаалга түгжих мэдрэгч ашиглан түгжих үйлдэл хийсэн үед тухайн үйлдлийг таньсныг илтгэх дохио 2 удаа дуугарна.
- Электрон түлхүүрийн үйлчлэх хүрээнд байх хаалганы бариул автомашин угаах зэргээс шалтгаалан норсон үед хаалганы түгжээ тайлагдах, түгжигдэх үйлдэл олон удаа давтагдаж болно. Энэ тохиолдолд дараах арга хэмжээг авна:
- Электрон түлхүүрийг 2м (6 фут) ба түүнээс хол зайд тавина. (Түлхүүр хулгайд алдагдахаас сэргийлнэ.)
- Электрон түлхүүрийг зайны цэнэг хэмнэх горимд тохируулж Smart entry & start системийг идэвхгүй болгоно. (→X.144)
- Электрон түлхүүр бүхээгт байгаа үед автомашин угаах зэргээр хаалганы бариул норсон үед мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарах ба дуут дохио автомашины гадна талд дуугарна. Анхааруулах дохиог унтраах үед бүх хаалгыг түгжинэ.
- Хаалга түгжих мэдрэгчид мөс, цас, шавар зэрэг тогтсон үед хэвийн ажиллахгүй. Энэ тохиолдолд мэдрэгчийг цэвэрлээд үйлдлийг давтах эсвэл бариулны доод талын түгжих мэдрэгч ашиглана.
- Үйлчлэх хүрээнд огцом орох эсвэл хаалганы бариулаас огцом татах үед систем хаалганы түгжээ тайлагдахаас сэргийлж хаалга тайлагдахгүй байж болно. Энэ тохиолдолд хаалганы бариулыг анхны байрлалд буцаах ба түгжээ тайлагдсаны дараа дахин татна.
- Үйлчлэх хүрээнд өөр электрон түлхүүр байгаа үед хаалганы бариул атгаж тайлах үед систем бага зэрэг удаан ажиллаж болно.

■ Автомашиныг удаан хугацаанд ашиглахгүй үед

- Автомашин хулгайд алдахаас

сэргийлж электрон түлхүүрийг автомашинаас 2м (6 фут) хүртэлх зайд хадгалахгүй.

- Smart entry & start системийг идэвхгүй болгох боломжтой. (→X.586)
- Электрон түлхүүрийн зайны цэнэг хэмнэх функц нь зайны цэнэг зарцуулалтыг бууруулна. (→X.144)

■ Системийг зөв ажиллуулах

Системтэй ажиллах үед электрон түлхүүртэй байна. Гадна системтэй ажиллах үед электрон түлхүүрийг автомашинд хэт ойртуулахгүй.

Электрон түлхүүрийн байршил, хэрхэн барьж байгаагаас хамаарч түлхүүр зөв танигдахгүй байх мөн систем зөв ажиллахгүй байж болно. (Автомашины дохиоллын систем гэнэт ажиллах, хаалга түгжигдэхээс сэргийлэх функц ажиллахгүй байх тохиолдол гарч болно.)

■ Smart entry & start систем хэвийн ажиллахгүй үед

- Хаалга түгжих, тайлах: Механик түлхүүр ашиглана. (→X.559)
- Хөдөлгүүр асаах: →X.560

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим тохиргоо (Smart entry & start систем зэрэг) өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.586)

Хэрэглэгчийн хүсэлтээр өөрчлөх боломжтой тохиргоогоор Smart entry & start системийг идэвхгүй болгосон үед дараах ажиллагааны дэлгэрэнгүйг тухайн хуудаснаас харна уу.

- Хаалга түгжих, тайлах: Алсын удирдлага эсвэл механик түлхүүр ашиглана. (→X.118, 559)
- Хөдөлгүүр асаах, хөдөлгүүр асаах товчны горим солих: X.560
- Хөдөлгүүр унтраах: →X.205

! АЮУЛТАЙ

■ Электрон төхөөрөмжид учруулах долгионы нөлөөллийн тухай анхааруулга

- Дотуур суулгасан дефибриллятор, кардиостимулятор /зохиомлоор зүрхний хэмнэл удирдагч/-тай хүн Smart entry & start системийн хүлээн авагч антенаас зохих зай барих шаардлагатай. (→X.143)

Радио долгион нь эдгээр төхөөрөмжийн ажиллагаанд нөлөөлж болзошгүй. Шаардлагатай үед Entry функцийг идэвхгүй болгох боломжтой. Та өөрийн Lexus дилерээс радио долгионы давтамж, цацагдах мөчлөг зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг авсны үндсэн дээр өөрийн эмчээс автомашины тус системийг идэвхгүй болгох шаардлагатай эсэх талаар зөвлөгөө авах нь зүйтэй.

! АЮУЛТАЙ


- Дотуур суулгасан дефибриллятор, кардиостимулятор /зохиомлоор зүрхний хэмнэл удирдагч/-с бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн тухайн төхөөрөмжийн үйлдвэрлэгчээс радио долгионы төхөөрөмжийн ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн тухай мэдээлэл авна. Радио долгион эмчилгээний зарим электрон төхөөрөмжид ихээхэн нөлөө үзүүлдэг.

Та өөрийн Lexus дилерт хандаж Entry функцийг хэрхэн идэвхгүй болгох тухай мэдээлэл авна уу.

Урд суудал

Суудлын байрлалыг (хөндлөн, босоо чиглэлд г.м.) тохируулна. Жолоодлогын зөв байрлалд тохируулна.

Тохиргоо хийх



- 1 Байрлал тохируулах товч
- 2 Суудлын түшлэгийн өнцөг тохируулах товч
- 3 Суудлын зөөлөвчний (урд тал) өнцөг тохируулах товч
- 4 Суудлын өндөр тохируулах товч
- 5 Суудлын зөөлөвчний хатууг тохируулах товч
- 6 Суудлын зөөлөвчний урт тохируулах товч (тоноглогдсон загварт)

■ Тохируулга хийх үед

- Суудал зорчигч, эд зүйлсэд хүрэхгүй байхад анхаарна.
- Толгойн түшлэг таазанд хүрэхгүй байхад анхаарна.

■ Жолооч буух, суухад туслах систем (тоноглогдсон загварт)

Асаах товчны горим болон жолоочийн аюулгүйн бүс зүүсэн, тайлсан зэргээс хамаарч жолоочийн суудал (зарим загварт), жолооны хүрдийг хөдөлгөж жолооч буух, суухад хялбар болгодог. (→Х.182)

. (→Х.181)

⚠ АЮУЛТАЙ

■ Суудал тохируулах үед

- Суудлын байрлал тохируулах үед бусад зорчигчдод гэмтэл учруулахгүй байхад анхаарна.
- Гэмтлээс сэргийлж суудлын доод талд эсвэл суудлын хөдөлж буй хэсэгт гараа хийж болохгүй. Гар, хуруугаа суудлын механизмд хавчин гэмтэх аюултай.
- Хөлийн ойр орчимдоо хангалттай зайтай байдлаар тохируулна.

■ Суудлын тохиргоо хийх

Ослын үед аюулгүйн бүсний завсар гулсах эрсдэлийг бууруулах зорилгоор суудлыг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн налуулахгүй. Суудлыг хэт налуулбал ослын үед аюулгүйн бүсний бүсэлхийн хэсэг ташаанаас сугарч бэлхүүсийг шахах мөн бүсний мөрний хэсэг хүзүү дарж улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэл үүсэх аюулыг нэмэгдүүлнэ. Суудал санамсаргүй хөдлөх улмаар жолооч удирдлагаа алдах аюултай тул хөдөлгөөний үед суудлын тохиргоо хийж болохгүй.

Массажтай урд суудал (тоноглогдсон загварт)

Урд суудалд дараах горим болон хүчээр ажилладаг массажны төхөөрөмж суурилагдсан байдаг.

- 1 Голын дэлгэцийн үндсэн цэсээс -г сонгоод дэд цэсээс "Seat controls"-г дарна.

- 2 “Massage”-г дарна.
- 3 Жолооч, урд зорчигчийн суудлыг сонгоно.
- 4 Горим сонгоно.
- “Centripetal”

Суудлын зөөлөвчийн урдаас түшлэгийн дээд тал руу чиглэн даралт өгнө.

- “Centrifugal”

Түшлэгийн дээд талаас суудлын зөөлөвчийн урд тал руу чиглэн даралт өгнө.

- “Upper body”

Түшлэгийн доод талаас дээш чиглэн даралт өгнө.

- “Lower body”

Суудлын зөөлөвчийн урдаас арагш чиглэн даралт өгнө.

- “Lumbar”

Түшлэгийн нурууны хэсгээр доороос дээш даралт өгнө.

- 5 Массаж хийх хүчийг сонгоод

 (on)-г дарна.

Хүчийг 5 түвшнээр тохируулах боломжтой.

Зогсоох үед  (off)-г дарна.

Хүн суугаагүй үед тухайн суудлын массажны төхөөрөмжийг асааж болохгүй.

■ Ажиллах нөхцөл

- Асаах товч ON горимд байгаа.
- Урд зорчигчийн суудал: Урд зорчигчийн суудал дээр зорчигчийн биеийн жин мэдэгдсэн.

Суудал дээр биеийн жин мэдрэгдсэн үед урд зорчигчийн хаалга нээгдэх эсвэл асаах товчийг унтраах хүртэл систем тус суудал дээр зорчигч сууж байгаа гэж тооцоолдог.

■ Автоматаар унтраах функц

Ажиллагаа 15 минутын дараа автоматаар унтарна.



АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үед анхаарах зүйлс

Жолоодлогын үед жолоочийн суудлын массажны төхөөрөмжийн тохиргоо хийж болохгүй. Эсрэг тохиолдолд жолоодлогоо алдах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүрнэ.

■ Массажны төхөөрөмж ашиглах

● Жирэмсэн болон нялх биетэй эх эсвэл эрүүл мэндийн шалтгаантай хүн (зүрх өвддөг зэрэг) төхөөрөмж ашиглахын өмнө эмчээсээ зөвлөгөө авна.

● Бага насны хүүхдээр ашиглуулж болохгүй.

● Мах идсэн, архи согтууруулах ундаа хэрэглэсэн даруйдаа ашиглахаас зайлсхийх ба үргэлжлүүлэн удаан хугацаагаар ашиглаж болохгүй.

● Ашиглах үед бие тавгүйтвэл даруй зогсооно.

Арын суудлууд

Тохиргоо хийх

■ 2-р эгнээний суудал


Хөшүүргийг татаж түшлэгийн өнцгийг тохируулна.



■ 3-р эгнээний суудал (тоноглогдсон загварт)


► Гараар тохируулдаг суудал

Хөшүүргийг татаж түшлэгийн өнцгийг тохируулна.



► Автомат суудал

Товчийг дарж түшлэгийн өнцгийг тохируулна.



⚠ АЮУЛТАЙ

■ Суудлын түшлэг ажиллуулах үед

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Дагаж мөрдөөгүй тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Суудлын түшлэгт бусад зорчигч цохигдохгүй байхад анхаарна.
- Түшлэг хөдлөн ажиллаж байх үед гар хуруу болон биеийн бусад хэсгээ хавчуулахгүй байна.
- Суудал тохируулсны дараа тухайн байрлалд бүрэн цоожлогдсон эсэхийг нягтлана.

■ Түшлэгийн өнцөг тохируулах

Түшлэгийг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн налуулж болохгүй. Ослын үед аюулгүйн бүсний бүсэлхийн хэсэг ташаанаас сугарч бэлхүүсийг шахах мөн бүсний мөрний хэсэг нь хүзүү дарах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэл үүсэх аюулыг нэмэгдүүлнэ.


3-р эгнээний суудалд суух, буух (тоноглогдсон загварт)

3-р эгнээний суудалд суухын тулд 2-г эгнээний суудал эвхэх (→Х.151)-ийн 1-р үйлдлийг хийнэ үү.


2-р эгнээний суудал эвхэх

■ Суудал эвхэхийн өмнө

- 1 Толгойн түшлэгийг хамгийн доор байрлалд болгоно.



- 2 Аюулгүйн бүсийг зурагт харуулсны дагуу хураана.




- 3 Гарын түшлэгийг эвхэнэ (→Х.474)
- 4 Арын суудалд хүрэхгүй байдлаар урд суудлыг тохируулна. (→Х.148)

■ 2-р эгнээний суудал эвхэх

- 1 Суудлын түшлэг тохируулагч хөшүүргийг эвхэх буюу 2-р эгнээний суудалд байх түшлэгийн хөшүүргийг татна.

Суудлын түшлэгийг урагш буулгаад


зөөлөвчийг дээш өргөж эвхэнэ.




- 2 Суудал хөдлөхөөс сэргийлж тагийг нээн дэгээг гаргаад туслах бариулд тогтооно.

Суудлын зөөлөвчний доод талаас тагийг салган авч суудлын дэгээг таглана.

Суудлыг хөдөлгөөнгүй бэхлээд бэхэлгээний тагийг буцааж таглана.




- 3 Суудлын зөөлөвчний доод талаас тагийг салган авч суудлын дэгээг таглана.




- 2-р эгнээний суудлыг анхны байрлалд буцаах

- 1 Суудлын дэгээний тагийг авч дэгээг салган анхны байрлалд нь буцаана.




- 2 Туслах бариулаас дэгээг салгана.

Туслах бариулаас дэгээг салгахад хүндрэлтэй үед дэгээний бүсийг суллана.




- 3 Дэгээг хурааж бэхлээд тагийг таглана.




- 4 Суудлыг анхны байрлалд буцаана.

Суудлыг түгжигдэх хүртэл нь дарна.



- 5 Түшлэгийг түгжигдэх хүртэл нь өргөнө.



▲ АЮУЛТАЙ

■ 2-р эгнээний суудал эвхэх үед

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.


- Жолоодлогын үед суудал эвхэж болохгүй.
- Тэгш газар зогсож зогсоолын тоормос татаад арааг Р-д шилжүүлнэ.
- Суудал эвхэхийн өмнө эд зүйл болон өөр бусад хүн байхгүй эсэхийг нягтална.
- Суудлын эд ангийн хооронд гар хөлөө хийж болохгүй.
- Бага насны хүүхдээр суудал удирдуулж болохгүй.
- 5 эсвэл 7 суудалтай загвар: Зөөврийн төхөөрөмж залгах залгуур эсвэл арын хайрцгийн USB залгуурт (тоноглогдсон автомашинд) төхөөрөмж залгасан үед суудлыг эвхэж болохгүй. Суудал эвхэгдэх үед төхөөрөмжийг гэмтээж болно.

■ 2-р эгнээний суудал эвхсэний дараа

- Жолоодлогын үед суудлын эвхсэн түшлэг дээр хүн суулгах, эд зүйл тавьж болохгүй.
- Тээшний хэсэгт бага насны хүүхэд оруулж болохгүй.
- Суудлыг эвхсэний дараа дэгээгээр бэхэлнэ. Эсрэг тохиолдолд хөдөлгөөний үед суудал буцаж дэлгэгдэн ноцтой гэмтэлд хүргэх аюултай.
- Суудлын дэгээ халуун болох үед түлэгдэх аюултай тул дэгээний тагийг заавал таглана.

■ 2-р эгнээний суудлыг анхны байрлалд буцаах үед

- Суудлыг буцаах үед суудлын хөл шаланд бүрэн бэхлэгдсэн эсэхийг нягтална



- 2-р эгнээний суудлыг анхны байрлалд буцаах үед гар хөл зэргээ суудал болон шалны хооронд хавчуулахаас сэргийлнэ



■ 2-р эгнээний суудлыг анхны байрлалд буцаасны дараа

- Суудлыг анхны байрлалд буцаасны дараа урагш хойш хөдөлгөж бүрэн бэхлэгдсэн эсэхийг нягтална.
- Суудлын бүс хавчуулахаас сэргийлнэ


3-р эгнээний суудал эвхэх үед (тоноглогдсон загварт)

■ Суудал эвхэхийн өмнө


- 1 Захын суудлын аюулгүйн бүсний гархийг дэгээнд бэхэлнэ.

Энэ нь мөрний бүс гэмтэхээс

сэргийлнэ.



- 2 Бүсийг татаж, толгойн түшлэгийг эвхэнэ.




- 3 3-р эгнээний суудалтай давхцахгүй байдлаар 2-р эгнээний суудлын түшлэгийн өнцгийг тохируулна. (→X.150)

■ 3-р эгнээний суудал эвхэх


Суудлын түшлэг тохируулах хөшүүрэг эсвэл 3-р эгнээний суудлын бүсийг нааш татаж түшлэгийг эвхэнэ.

Түшлэг эвхэх үед суудлын зөөлөвч шал руу хураагдана.




■ 3-р эгнээний суудлыг анхны байрлалд буцаах


- 1 Суудлын бүсийг татаж суудлын түшлэгийг хойш түлхэн түгжигдэх горим оруулна.




- 2 Бариулаас татан зөөлөвчийг гаргана.



3 Толгойн түшлэгийг дээш өргөнө.



4 3-р эгнээний суудал ашиглахаас өмнө дэгээнээс аюулгүйн бүсийг гаргана.



▲ АЮУЛТАЙ

3-р эгнээний суудал эвхэх үед

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Суудал эвхэхийн өмнө ойр орчимд эд зүйл, зорчигч байхгүйг эсэхийг нягтална.
- Анхаарал болгоомжтой хийж гүйцэтгэнэ.
- Суудлын эд ангийн хооронд гар хөлөө хийж болохгүй.
- Бага насны хүүхдээр ажиллуулж болохгүй.
- Суудлын зөөлөвч эвхэгдсэн үед суудал ашиглаж болохгүй.

■ 3-р эгнээний суудлыг анхны байрлалд буцаасны дараа

- Суудлыг анхны байрлалд буцаасны дараа урагш хойш хөдөлгөж бүрэн бэхлэгдсэн эсэхийг нягтална.
- Суудлын бүс хавчуулахаас сэргийлнэ
- Аюулгүйн бүсийг дэгээнээс нь салгана.



АНХААР


■ 3-р эгнээний суудал эвхэх үед (тээшний хаалттай автомашин)

Тээшний эвхдэг хаалттай үед хаалтыг салгана. (→Х.458)

3-р эгнээний суудал хаалтыг цохиж гэмтээж болно.

3-р эгнээний суудал эвхэх үед (автомат суудал) (тоноглогдсон загварт)

■ 3-р эгнээний суудал удирдах товчнууд



A Зүүн суудал буцаах товч

B Зүүн суудал эвхэх товч

C Баруун суудал буцаах товч

D Баруун суудал эвхэх товч


Үйлдлийг суудлын товч мөн тээшний хаалганы товч ашиглан хийх

боломжтой.

■ 3-р эгнээний суудал эвхэхийн өмнө

- 1 Захын суудлын аюулгүйн бүсний гархийг дэгээнд бэхэлнэ.

Энэ нь мөрний бүс гэмтэхээс сэргийлнэ.



- 2 2-р эгнээний суудлын түшлэгийн өнцгийг 3-р эгнээний суудалтай давхцахгүй байхаар тохируулна. (→Х.150)


■ 3-р эгнээний суудал эвхэх

Эвхэх товчийг удаан дарна.

Түшлэгийг арагш налуулсан үед түшлэг эгц босоо байрлалд зогсоно. Товчийг дахин дарж эвхэнэ.

Дуут дохио 2 удаа дуугарсны дараа түшлэг доош эвхэгдэх ба толгойн түшлэг ба суудлын зөөлөвч автоматаар шаланд хураагдана.

Суудал хураагдсаны дараа дуут дохио 2 удаа дуугарах ба үйлдэл автоматаар зогсоно. Үйлдэл дууссаны дараа товчийг суллана.




3-р эгнээний суудлыг анхны байрлалд буцаах


- 1 Буцаах товчийг удаан дарж 3-р эгнээний суудлыг анхны байрлалд буцаана.

Дуут дохио 2 удаа дуугарсны дараа түшлэг болон зөөлөвч автоматаар хөдөлж эхэлнэ. Үйлдэл дуусахаас товчийг суллаж болохгүй.


Суудал анхны байрлалд буцсаны дараа дуут дохио 2 удаа дуугарах ба үйлдэл автоматаар зогсоно. Үйлдэл дууссаны дараа товчийг суллана.



2 Толгойн түшлэгийг өргөнө



3 3-р эгнээний суудал ашиглахаас өмнө дэгээнээс аюулгүйн бүсийг гаргана.



■ 3-р эгнээний автомат суудал ажиллах нөхцөл

- Асаах товчны OFF горимын үед.
- Асаах товчны ON горимд дараах аль нэг нөхцөл үүссэн үед 3-р эгнээний суудал ажиллана:
 - Арааны хөшүүрэг Р-д байгаа
 - Тоормос гишгэсэн байгаа
 - Зогсоолын тоормос залгагдсан

■ Товчны ажиллагаа

- 3-р эгнээний суудал ажиллах үед товчийг суллаж болохгүй. Товч сулласан үед суудлын ажиллагаа зогсох ба дуут дохио үргэлжлэн дуугарна. Товчийг дахин дарж дуут дохио унтраана.
- 3-р эгнээний суудал 2-р эгнээний суудал эсвэл бусад эд ангитай ойртсон үед 3-р эгнээний суудлын хөдөлгөөн хязгаарлагдана.

■ Дуут дохио үргэлжлэн дуугарах үед

Доголдол үүссэн ба хөдөлгүүр асаалттай үед дуут дохио үргэлжлэн дуугарч болно. Энэ нөхцөлд дараах үйлдлийг хийж гүйцэтгэнэ.

- 1 Тээшний хэсгийн буцаах товчийг дарна
- 2 Суудал дээр байрлах эвхэх товчийг 10 секундйн хугацаанд 5 удаа дарахад дуут дохио 3 удаа дуугарна. (Дуут дохио 3 удаа дуугарах хүртэл товчийг суллахгүй.)
- 3 Тээшний хэсэг эсвэл суудал дээр байрлах товчийг удаан дарна.

Суудал эвхэгдэж дуусахад дуут дохио зогсоно.

Ажиллагааг гүйцэтгэх үед асуудал гарч эвхэгдэхгүй байвал өөрийн Lexus дилер дээрээ оношлуулна уу.

⚠ АЮУЛТАЙ

3-р эгнээний суудал эвхэх үед

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Суудал эвхэхийн өмнө ойр орчимд эд зүйл, зорчигч байхгүйг эсэхийг нягтална.
- Суудлын эд ангийн хооронд гар хөлөө хийж болохгүй.
- Бага насны хүүхдээр ажиллуулж болохгүй.

■ Суудлыг анхны байрлалд буцаасны дараа

- Суудлын бүсийг хавчуулахаас сэргийлнэ.
- Суудлын бүсийг дэгээнээс нь салгана.
- Толгойн түшлэгийг дээш өргөнө.



АНХААР

■ **3-р эгнээний суудал эвхэх үед (тээшний хаалттай автомашин)**

Тээшний эвхдэг хаалттай үед хаалтыг салгана. (→Х.458)

3-р эгнээний суудал хаалтыг цохиж гэмтээж болно.

Толгойн түшлэг

Толгойн түшлэг бүх суудалд суурилагдсан байна.



АЮУЛТАЙ


■ **Толгойн түшлэгийн анхааруулга**

Толгойн түшлэгийн дараах анхааруулгыг дагаж мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Толгойн түшлэгийг зөвхөн тухайн суудалд ашиглана.
- Толгойн түшлэгийг цаг ямагт зөв байрлалд тохируулна.
- Тохиргоо хийсний дараа түшлэгийг доош дарж зохих байрлалд түгжигдсэн эсэхийг нягтална.
- Автомашины толгойн түшлэггүйгээр жолоодохгүй.
- 3-р эгнээний суудалтай автомашин: 3-р эгнээний суудалд суух үед толгойн түшлэг эвхэгдээгүй эсэхийг нягтална.

Өндөр намын тохиргоо

■ **Урд суудал болон 2-р эгнээний захын суудал**




1 Дээш

2 Доош

Түгжээ тайлах товч **A** -г дарангаа толгойн түшлэгийг доош дарж буулгана.

■ 2-р эгнээний голын суудал




1 Дээш

2 Доош

Түгжээ тайлах товч **A** -г дарангаа толгойн түшлэгийг доош дарж буулгана.

■ Толгойн түшлэгийн өндөр тохируулах (Урд болон 2-р эгнээний захын суудал)

Толгойн түшлэгийн төв хэсэг таны чихнээ дээд талтай боломжит хэмжээт ойр байх байдлаар өндрийг тохируулна.



■ 2-р эгнээний голын суудал

Толгойн түшлэгийг хураагдах байрлалаас 1 шат дээшлүүлэн ашиглана.

Хөндлөн тохиргоо (тоноглогдсон автомашинд)

Толгойн түшлэгийг урагш 4 байрлалд тохируулж болно.


Хамгийн урд байрлалаас толгойн түшлэгийг урагш татвал түшлэг хамгийн арын байрлалд буцна.



Толгойн түшлэг эвхэх (3-р эгнээний суудал) (тоноглогдсон автомашинд)

Бариулаас татангаа түшлэгийг эвхэнэ.

Буцаах үед дээш татна.




Толгойн түшлэг салгах

■ Урд ба 2-р эгнээний захын суудал

Түгжээ тайлах товч **A** -г даран-

гаа түшлэгийг дээш татаж авна.


Толгойн түшлэг таазанд тулж салгахад хүндрэлтэй үед суудлын өндрийг эсвэл өнцгийг тохируулна. (→Х.148, 150)



■ 2-р эгнээний голын суудал

Түгжээ тайлах товч **A** -г дарангаа түшлэгийг дээш татаж авна.

Толгойн түшлэг таазанд тулж салгахад хүндрэлтэй үед суудлын өндрийг эсвэл өнцгийг тохируулна(→Х.150)



■ 3-р эгнээний суудал (тоноглогдсон загварт)

Толгойн түшлэгийг салгах боломжгүй.


Толгойн түшлэг угсрах

■ Урд ба 2-р эгнээний захын суудал

Түшлэгийг толгойн түшлэгийн

сууринд тааруулж түгжих байрлал орох хүртэл дарна.


Түгжээ тайлах товч **A** -г дарангаа түшлэгийг доош дарна.



■ 2-р эгнээний голын суудал

Түшлэгийг толгойн түшлэгийн сууринд тааруулж түгжих байрлал орох хүртэл дарна.

Түгжээ тайлах товч **A** -г дарангаа түшлэгийг доош дарна.




Жолооны хүрд

Тохиргоо хийх


► Гар тохиргоотой

- 1 Хүрднээс барингаа хөшүүргийг доош дарна.




- 2 Жолооны хүрдийг дээш доош, урагш хойш хөдөлгөн өөрт тохиромжтой байрлалд тохируулна.

Тохиргоо хийж дууссаны дараа хөшүүргийг дээш татаж хөдөлгөөнгүй бэхэлнэ.



► Автомат тохиргоотой

Товчийг ажиллуулах үед жолооны хүрд дараах чиглэлд хөдөлнө:



- 1 Дээш
- 2 Доош
- 3 Нааш
- 4 Цааш

■ Жолооны хүрдийг дараах нөхцөлд тохируулах боломжтой

Асаах товч ACC эсвэл ON* горимд байгаа үед

*: Жолоочийн аюулгүйн бүс бүслэгдсэн үед асаах товчны горимоос хамааралгүй хүрд тохируулж болно.

■ Жолооч буух, суухад туслах систем (тоноглогдсон загварт)

Жолооны хүрд болон жолоочийн суудал нь асаах товчны горим болон жолоочийн аюулгүйн бүс бүслэгдсэн эсэхээс хамаарч хөдөлнө. (→X.181)


■ Жолооны хүрдний байрлалын автомат тохиргоо (тоноглогдсон загварт)

Жолооны хүрдний байрлалыг жолоодлогын байрлал санах системд сануулж дахин дуудаж болно. (→X.182)

■ Автоматаар хураагдах (тоноглогдсон загварт)

Асаах товчийг унтраах үед жолоочийг буух, дахин суухад хялбар байдлаар жолооны хүрд дээш өргөгдөн урагш хураагдана.

Асаах товчийг ACC эсвэл ON горимд шилжүүлэх үед жолооны хүрд анхны байрлалд буцна.



⚠ АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үед

Хүрдний тохиргоо хийж болохгүй. Эсрэг тохиолдолд жолоодлого алдагдах, осол гаргах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохиролд хүргэх аюултай.


■ Жолооны хүрдний тохиргоо хийж дууссаны дараа (гар тохиргоотой)

Жолооны хүрд бүрэн түгжигдсэн эсэхийг нягтална. Эсрэг тохиолдолд жолооны хүрд гэнэт хөдөлж осол үүсгэх улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэлд хүргэх аюултай. Мөн жолооны хүрд бүрэн түгжигдээгүй үед дуут дохио ажиллахгүй байж болно.

Дуут дохио

Дуут дохио ажиллуулах үед

🔊 тэмдэг эсвэл түүний ойролцоо дарна.



Голын толь*


*: Тоноглогдсон загварт

Голын толийг тохируулж автомашины ар талын харагдах байдлыг сайжруулах боломжтой.

Голын толины өндрийг тохируулах

Голын толины өндрийг өөрт эвтэй байдлаар тохируулах боломжтой.

Толийг дээш доош хөдөлгөн өндрийг тохируулна.



⚠ АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үед

Жолоодлогын үед толины тохиргоо хийхийг хориглоно. Эсрэг тохиолдолд жолооч автомашины жолоодлогоо алдах, осол гаргах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэлд хүрэх аюултай.

Нүд гялбахаас сэргийлэх функц


Толинд туссан арын автомашины гэрлийн хэмжээ, түвшнээс

хамаарч толинд ойх гэрлийн тусгалыг автоматаар бууруулна.

Нүд гялбахаас сэргийлэх автомат функцийн горим ON/OFF солих


Нүд гялбахаас сэргийлэх автомат функц ON горимд байгаа үед **A** индикатор гэрэл асна. Асаах товч “ON” горимд шилжүүлэх үед тус функц автоматаар ON горимд шилжинэ.

Товчийг дахин дарах үед функц OFF горимд шилжинэ. (Индикатор **A** мөн унтарна.)



■ Мэдрэгчийн хэвийн ажиллагаа алдагдахаас сэргийлэх

Толины мэдрэгчийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүйн тулд мэдрэгчид хүрэх, таглахыг хориглоно.



Дижитал голын толь*

* Тоноглогдсон загварт

Дижитал голын толь гэдэг нь автомашины арын камерын дүрсийг дижитал голын толь дээр гаргаж жолоочид ар талыг нягтлах боломж олгодог систем юм.

Хөшүүрэг ашиглан дижитал голын толийг оптик болон дижитал толины горимд солих боломжтой.

Дижитал голын толь нь толгойн түшлэг, тээш зэрэг саадаас үл хамааран ар талыг харах боломж бүрдүүлдэг.

Толинд арын суудлыг харуулдаггүй ба зорчигчдын хувийн орон зайг мөн бүрдүүлдэг.

⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.


■ Дижитал голын толь ашиглахын өмнө

- Жолоодлогын өмнө толийг тохируулна. (→X.165)
- Оптик толины горим болон дижитал толины байрлалыг автомашины хойд тал сайн харагдах байдлаар тохируулна.
- Дижитал толины горимд шилжүүлээд дэлгэцийн тохиргоог хийнэ.

! АЮУЛТАЙ

- Оптик болон дижитал толинд харагдах байдал өөр өөр байдаг тул жолоодлогын өмнө тухайн горимуудад харагдах байдлын ялгааг нягтална.

Системийн эд ангиуд



A Камерын индикатор

Камер хэвийн ажиллаж байгааг илтгэнэ.

B Тэмдгүүдийн хэсэг

Дэлгэцийн тэмдгүүдийг харуулна. (→X.165)

C Сонгох/тохируулах товч

Тухайн өөрчлөх тохиргоог сонгох үед дарна.

D Меню товч

Тэмдэг эсвэл цэсийн сонголт хийнэ.

E Хөшүүрэг

Дижитал болон оптик толины горимд солино.


F Дижитал гялбахаас хамгаалсан толины горимын индикатор

Дижитал толины горимын үед тус индикатор гялбахаас хамгаалсан толины функц ажиллаж байгааг

илтгэнэ. (→X.165)

Горим солих

Хөшүүргээр дижитал болон оптик толины горимд солино.



1 Дижитал толины горим

Автомашины ар талын дүрсийг харуулна.

Тус горимд  тэмдэг асна.

2 Оптик толины горим

Дижитал голын толины горимыг унтрааж оптик толины горимд шилжүүлнэ.

■ Дижитал толины горим ажиллах нөхцөл

Асаах товчийг ON болгоно.

Асаах товчийг ON-с OFF эсвэл ACC горимд шилжүүлэх үед хэдэн секундйн дараа дүрс унтарна.

■ Асаах товчийг ON-с OFF эсвэл ACC горимд шилжүүлэх үед дүрс хэдэн секундйн дараа унтарна.

- Камер дээр гэрэл туссан, камер бохирдсон, усны дусал, цас тогтсон, урд талын автомашины гэрэл туссан зэргээс шалтгаалж дүрс сайн харагдахгүй байх мөн дижитал толины дүрс жолоодлогод тань саад болж байгаа үед оптик толины горимд шилжүүлнэ.

- Бороотой үед арын дүрс сайн харагдахгүй байвал арын

цонхны шил арчигчийг
ажиллуулна.


- Тээшний хаалга нээлттэй үед дижитал голын толины дүрс зөв заахгүй байж болно. Жолоодлогын өмнө тээшний хаалга хаалттай эсэхийг нягтална.
- Гэрэл ойж голын толийг харахад хүндрэлтэй үед дээврийн нээлхийн нарны хаалтыг хаана (тоноглогдсон загварт).
- Шөнийн цагаар зэрэг харанхуй орчинд жолоодох үед дараах аль нэг нөхцөл үүсэж болно. Эдгээр нь доголдлыг илэрхийлэхгүй.
- Арын автомашины гэрлийн өндрөөс хамаарч автомашины арын хэсэг цайрах эсвэл гялбаж харагдаж болно.
- Тод гэрэлтэй дүрсний автомат тохируулгын улмаас дүрсний ойр орчим гялбаж харагдаж болно.

Толины дүрсийг үзэх хүндрэлтэй эсвэл дижитал толины дүрс жолоодлогод тань саад болж байгаа үед оптик толины горимд шилжүүлнэ.

- Дижитал толины горим сонгогдсон үед голын толь халж болно. Энэ нь доголдол биш болно.
- Таны биеийн байдал, наснаас хамаарч дэлгэцийн дүрс дээр анхаарал төвлөрүүлэхэд энгийн үеэс илүү хугацаа шаардагдаж болно. Энэ үед оптик толины горимд шилжүүлнэ.
- Хөдөлгөөний үед зорчигчийг толины дүрс рүү удаан харуулж болохгүй. Дотор муухайрахад хүргэнэ.

■ Системд доголдол үүссэн үед

Дижитал голын толины горим сонгогдсон ба зурагт үзүүлсэн тэмдэг гарсан үед системд доголдол үүссэн байж болно. Тэмдэг хэдэн секунд асаад унтарна. Хөшүүргээр оптик толины горимд шилжүүлээд автомашинаа Lexus дилер дээрээ оношлуулна уу.




Толь тохируулах

■ Толины өндөр тохируулах

Голын толины өндрийг өөрт эвтэй байдлаар тохируулах боломжтой

Оптик толины горимд шилжүүлээд толийг дээш доош хөдөлгөн өндрийг тохируулна.




■ Дэлгэцийн тохируулга (Дижитал толины горим үед)

Дижитал толины горимын үед дэлгэцээр гялбахаас хамгаалах функцийг идэвхжүүлэх, цуцлах зэрэг боломжтой.

1 Меню товч дарна.

Тэмдгүүд харагдана.



2 Меню товчийг үргэлжлүүлэн дарж тохиргоогоо сонгоно.

3  эсвэл  товчийг дарж тохиргоог өөрчилнө.

Товчийг 5 секунд ба түүнээс дээш хугацаагаар ашиглаагүй үед тэмдэг унтарна.

Тэм-дэг	Тохиргоо
	Дэлгэцээр харуулах дүрсний өнцгийг тохируулна.
	Дэлгэцээр харуулах дүрсийг дээш/доош тохируулна.
	Дэлгэцээр харуулах дүрсийг баруун/зүүн тохируулна.
	Дэлгэцээр харуулах дүрсний өнцгийг тохируулна.
	Дэлгэцээр харуулах дүрсийг томруулна/ жижгэрүүлнэ.

Тэм-дэг	Тохиргоо
	Автомат нүд гялбахаас сэргийлэх функцийг идэвхжүүлнэ/цуцална.* Арын автомашины их гэрэл хэр тод байгаагаас хамаарч туссан гэрлийн хэмжээ автоматаар тохируулагдана. Асаах товчийг ON горимд шилжүүлэх бүрд автомат нүд гялбахаас сэргийлэх функц автоматаар идэвхэжнэ.
	Дижитал гялбахаас хамгаалах горимыг идэвхжүүлнэ/цуцална. Функцийг идэвхжүүлсэн үед шөнийн цагаар араас тусах арын автомашины их гэрлийн тусгалыг бууруулна.

* : Тус функц нь оптик толины горимд зориулагдсан ба нөгөөтээгүүр дижитал толины горимд тус тохиргоог өөрчлөх боломжтой.

■ Автомат нүд гялбахаас сэргийлэх функцийг идэвхжүүлэх/цуцлах (Оптик толины горим)

Оптик толины горим дахь автомат нүд гялбахаас сэргийлэх функцийг идэвхжүүлэх/цуцлах боломжтой. Тохиргоог дижитал толины горим болон оптик толины горимоос хийж болно.


► Дижитал толины горим ашиглах үед

→Х.165

► Оптик толины горим ашиглах

1 Меню товч дарна.

Тохиргооны дэлгэц гарна.



2  эсвэл  товч дарж тус функцийг ON/OFF горимд шилжүүлнэ.


Товчийг 5 секунд ба түүнээс дээш хугацаагаар ашиглаагүй үед тэмдэг унтарна.

■ Дэлгэц тохируулах (Дижитал толины горим)

- Товчийг 5 секунд ба түүнээс дээш хугацаагаар ашиглаагүй үед тэмдэг унтарна.
- Дүрсний тохиргоо хийсэн үед дүрс өөрчлөгдөж харагдаж болно. Энэ нь доголдол биш болно.
- Дижитал голын толины гэрлийг хэт тод хэмжээнд тохируулах нь нүд чилэхэд хүргэнэ. Гэрлийн хэмжээг тохиромжит хэмжээнд тохируулна. Хэрэв нүд чилбэл оптик толины горимд шилжүүлнэ.
- Дижитал голын толины гэрлийн хэмжээ автомашины урд талын гэрлийн хэмжээнээс хамаарч автоматаар тохируулагдана.
- Нүд гялбахаас сэргийлэх дижитал горим нь зөвхөн харанхуй орчинд ажилладаг. Орчны гэрлийн хэмжээнээс хамаарч дүрс бүдэг болохгүй байх мөн арын автомашины гэрлийг бууруулахгүй байж болно.

■ Гэрлийн мэдрэгчийг гэмтлээс сэргийлэх

Мэдрэгчид хүрэх, таглахыг хориглоно.



▲ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

■ Жолоодлогын үед

● Жолоодлогын үед дижитал голын толины байрлал тохируулах, дэлгэцийн тохиргоо хийхийг хориглоно.

Автомашиныг зогсоосны дараа толийг тохируулна. Эсрэг тохиолдолд жолооч автомашины жолоодлогоо алдах, осол гаргах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэлд хүрэх аюултай.

● Цаг ямагт ойр орчмын тээврийн хэрэгсэлд анхаарал хандуулна.

Дижитал болон оптик толины горимд автомашины хэмжээ ба бусад объектын харагдах байдалөөр өөр өөр байж болно. Ухрах үйлдэл хийх үед ойр орчим, ялангуяа хойд талын автомашины аюулгүй байдлыг нүдээр шууд харж нягтална.

Шөнийн цаг зэрэг харанхуй үед ар талаас автомашин ойртох үед ойр орчим бүдэг харагдаж болно.

■ Гал гарахаас сэргийлэх

Дижитал голын толиноос утаа, үнэр гарч байгаа үед үргэлжлүүлэн ашиглах нь галын аюулд хүргэнэ. Систем ашиглахаа даруй зогсоож дилертээ хандана уу.

Дижитал голын толь цэвэрлэх


■ Толины гадаргууг цэвэрлэх

Толины гадаргуу бохирдсон үед дэлгэцийн дүрс харахад хүндрэлтэй болно.

Толины нүүрийг цэвэр, хуурай алчуураар арчиж цэвэрлэнэ.

■ Камер


Дижитал голын толины камер дараах зурагт үзүүлсэн байрлалд байдаг.



АНХААР

■ Камерт доголдол үүсэхээс сэргийлэх

Толины нүх зэргийг халхлахыг хориглоно. Толь халснаас гал гарах аюултай.



■ Камерт доголдол үүсэхээс сэргийлэх

● Дижитал голын толины хэвийн ажиллагаа алдагдах тул дараах анхааруулгыг дагаж мөрдөнө.

- Камерын байрлал, өнцөг өөрчлөгдөж болзошгүй тул камерыг хүчтэй цохилт, доргилтод өртөхөөс сэргийлнэ.
- Камерыг салгах, задлах, өөрчлөхийг хориглоно.
- Камерын таг дээр органик нэгдэл, вакс, цонх цэвэрлэгч бодис эсвэл шил өнгөлөгч зэргийг хүргэж болохгүй. Хүргэсэн тохиолдолд нэн даруй арчиж цэвэрлэнэ.
- Арын шилэн дээр өнгөтэй хальс (тунгалаг хальс хамаарна) наах үед камерын урд хэсэгт нааж болохгүй. Камерын дүрс дэлгэц дээр зөв гарахгүй байх магадлалтай.
- Доголдол үүсгэх аюултай тул камерыг хүчтэй цохилтод өртөхөөс сэргийлнэ. Камер хүчтэй цохилтод өртсөн тохиолдолд та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

Дараах аль нэг шинж тэмдэг мэдэгдсэн үед

Дараах аль нэг шинж тэмдэг мэдрэгдсэн үед хүснэгтэд заасан тохирох арга хэмжээг авна.

Арга хэмжээ авсан ч шинж тэмдэг арилахгүй үед та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

Шинж тэмдэг	Шалтгаан	Шийдэл
Дүрс муу харагдаж байгаа	Толины гадаргуу бохирдсон	Гадаргууг хуурай, зөөлөн алчуураар цэвэрлэнэ.
	Дижитал голын толин дээр нар эсвэл автомашины их гэрэл шууд тусч байгаа	Оптик толины горимд шилжүүлнэ. (гэрэл дээврийн нээлхийгээр [Тоноглогдсон загварт] тусч буй үед нээлхийг хаана.
	- Автомашин харанхуй орчинд байгаа - Телевизийн цамхаг, радио станц, цахилгаан станц бусад хүчтэй радио долгион, цахилгааны шум үүсгэдэг газрын ойр орчимд - Камерын орчмын хэм хэт халуун/хүйтэн - Гадна орчны хэм хэт хүйтэн - Бороо орж байгаа эсвэл хэт чийгшилттэй. - Линз дээр нар эсвэл автомашины их гэрэл шууд тусч байгаа - Флуоресцент гэрэл (өдрийн гэрэл), натрийн ламп, мөнгөн усны орцтой гэрлийн дор байгаа үед - Автомашины хаягдал утаа камерыг халхалж байгаа үед	Оптик толины горимд шилжүүлнэ. (Дүрс муу харагдах шалтгааны нөлөө буурах үед дижитал толины горимд буцаана.)

Шинж тэмдэг	Шалтгаан	Шийдэл
Дүрс муу харагдаж байгаа	Усны дусал, тоос зэрэг гадны биет камерын линз дээр тогтсон.	Lexus дилер дээрээ оношлуулна уу.
	Тээшний хэсэг дэх тээш арын шилэнд ойж камерт саад учруулсан.	- Оптик толины горимд шилжүүлнэ. - Тээшийг камерт саад болохгүй байрлалд шилжүүлэх эсвэл хар даавуугаар хучиж арын шилэнд ойх тусгалыг бууруулна.
	Арын шил цантсан.	Оптик толины горимд шилжүүлнэ. Арын шилний цан арилгагчаар цанг арилгаад (→X.440), дижитал голын толины горимд дахин шилжүүлнэ.
	Арын шилний гадна тал бохирдсон	Арын шил арчигчаар цэвэрлэнэ.
	Арын шилний дотор тал бохирдсон	Lexus дилер дээр оношлуулна уу.
Дүрсний өнцөг алдагдсан	Тээшний хаалга дутуу хаагдсан.	Тээшний хаалга гүйцэд хаана.
	Камер, камерын ойр орчим хүчтэй цохилтод өртсөн.	Оптик толины горимд шилжүүлээд даруй өөрийн Lexus дилер дээр оношлуулна.
Дэлгэц бүдэг бөгөөд  гарч байгаа	Системд доголдол үүссэн байж болзошгүй.	Оптик толины горимд шилжүүлээд даруй өөрийн Lexus дилер дээр оношлуулна.
 гараагүй		

Шинж тэмдэг	Шалтгаан	Шийдэл
 тэмдэг дэлгэц дээр гарсан	Дижитал голын толь хэт халсан. (Дэлгэц аажмаар улам бүдэг болно. Дэлгэцийн хэм өссөн хэвээр байгаа үед дижитал голын толь унтарна.)	Дэлгэцийн хэмыг буулгах үед бүхээгийн хэмыг буулгах нь тохиромжтой арга болно. ( тэмдэг дэлгэц хөрөх үед унтарна.) Дэлгэц хөрсөн ч дэлгэц дээр  тэмдэг унтрахгүй үед та өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.
Хөшүүрэг хэвийн ажиллахгүй байгаа	Хөшүүрэгт доголдол үүссэн байж болно.	Оптик толины горимд шилжүүлээд өөрийн Lexus дилер дээр оношлуулна. ("MENU" товчийг 10 орчим секунд дарж оптик толины горимд шилжүүлнэ.)

Хажуугийн толь

Арын харагдах байдлыг сайжруулах зорилгоор хажуугийн толийг тохируулна.

■ Толины цан арилгах

Цан арилгагчаар хажуугийн толины харагдах байдлыг цэвэрлэх боломжтой. Хажуугийн толины цан арилгагчийг ажиллуулахдаа хойд цонхны цан арилгагчийг асаана. (→Х.440)

■ Нүд гялбахаас сэргийлэх автомат функц (зөвхөн жолоочийн тал)

Нүд гялбахаас сэргийлэх функцтэй голын толь (тоноглогдсон загварт) эсвэл нүд гялбахаас сэргийлэх автомат функцтэй дижитал голын толийг (тоноглогдсон загварт) (оптик горим) автомат горимд шилжүүлсэн үед хажуугийн толины нүд гялбахаас сэргийлэх автомат функц идэвхэжнэ. (→Х.162, 166)

■ Хүйтний улиралд хажуугийн толь ашиглах

Хажуугийн толийг хүйтний улиралд ашиглах үед толь хөлдөх, эвхэгдэхгүй байх, тохируулагдахгүй байж болно. Толинд тогтсон цас, мөс зэргийг унагаана.



АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үед анхаарах зүйлс

Жолоодлогын үед дараах анхааруулгыг дагаж мөрдөнө.

Дагаж мөрдөөгүй тохиолдолд жолооч автомашины жолоодлогоо алдах, осол гаргах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэлд хүрэх аюултай.

- Хөдөлгөөний үед толь тохируулахыг хориглоно.

Эвхсэн тольтой замын хөдөл-гөөнд оролцохыг хориглоно.

- Хөдөлгөөн эхлэхийн өмнө хоёр талын хажуугийн толийг дэлгэж, зөв байрлалд тохируулна.

■ Толины цан арилгагч ажиллаж байгаа үед

Толины гадаргуу хэт халах улмаар түлэх аюултай тул хажуугийн толинд хүрэхийг хориглоно.



АНХААР

■ Толинд мөс тогтсон үед


Толины гадаргууг гэмтээх тул тохиргоо хийж болохгүй. Шүршдэг мөс арилгагчаар мөсийг цэвэрлэнэ.

Тохиргоо хийх

- 1 Товч дарж тохиргоо хийх толийг сонгоно.

Тохиргоо хийх үед индикатор асна.


Товчийг дахин дарах үед товч дундын горимд шилжинэ.



A Зүүн толь

B Баруун толь

2 Товчийг дарж тохиргоо хийнэ.



- A** Дээш
- B** Баруун
- C** Доош
- D** Зүүн

■ Дараах нөхцөлд толины тохиргоо хийх боломжтой

Асаах товчны ACC эсвэл ON горимд.

■ Толины байрлалын автомат тохиргоо


Жолоодлогын байрлал санах функцэд сануулснаар толины өнцгийг автоматаар дуудах боломжтой. (→X.182)

Толь эвхэх, дэлгэх

■ Товч ашиглах

Товч дарж толь эвхэнэ.

Дахин дарж толийг анхны байрлалд буцаана.




■ Автомат горимд тохируулах

“AUTO” товч дарж автомат горимд шилжүүлнэ.

A индикатор асна.

Автомат горим нь хаалга түгжих, тайлахтай хамт толь эвхэх буюу дэлгэнэ.

Товчийг дахин дарахад гар тохиргооны горимд буцна.



■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Толийг автоматаар эвхэх, дэлгэх тохиргоог өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)

! АЮУЛТАЙ

■ Толь ажиллаж байх үед

Өөрт учирч болзошгүй гэмтэл болон толины механизм эвдрэхээс сэргийлж хөдөлж буй толинд гар хуруугаа хавчуулж болохгүй.

Ухрах араатай холбоотой толины ажиллагаа

Толины тохиргооны товч “L” эсвэл “R” байрлалд ухрах араанд сэлгэх үед хажуугийн толь автоматаар доош хөдөлж ухрах үеийн харагдцыг сайжруулна.

Функцийг цуцлах үед “L” болон “R” байрлалын дунд шилжүүлнэ.

■ Автомашин ухрах үеийн толь тохируулалт

Арааны R байрлалын үед хажуугийн толины өнцгийг өөрт тохиромжит байдлаар тохируулна. Систем тус байрлалыг ухрах үеийн толины байрлал гэж санах ба дараагийн удаагаас арааг R байрлалд шилжүүлэхэд хажуугийн толь тухайн байрлалд шилжинэ.

Тухайн санасан ухрах арааны байрлал нь хажуугийн толины энгийн байрлалтай (R-с бусад араатай үед тохируулсан толины тохиргоо) уялдаатай байна. Хажуугийн толины энгийн үеийн байрлалыг өөрчлөхөд ухрах арааны байрлал мөн өөрчлөгдөнө.


Хажуугийн толины энгийн үеийн байрлалыг өөрчлөн тохируулсан үед ухрах арааны байрлалыг дахин тохируулна.

Автомат цонх

Цонх нээх ба хаах

Дараах товчоор автомат цонхыг нээх, хаах боломжтой.

Товч дарах үед цонх дараах байдлаар ажиллана:



- 1 Хаах
- 2 Гүйцэд хаах*
- 3 Нээх
- 4 Гүйцэд нээх*

*: Цонхыг дунд нь зогсоохын тулд товчийг эсрэг чиглэлд хөдөлгөнө.

■ Автомат цонх ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа үед.

■ Хөдөлгүүр унтраасны дараа автомат цонх ажиллуулах

Асаах товч ACC эсвэл OFF горимд, хөдөлгүүр унтрааснаас хойш 45 секунд дотор автомат цонхыг ажиллуулах боломжтой. Урд талын аль нэг хаалга онгорхой хэдий ч дээрх хугацаа өнгөрсөн тохиолдолд цонх ажиллахгүй.

■ Дуу хоолойгоор удирдах системээр автомат цонх ажиллуулах*

*: Тоноглогдсон загварт

Дуугаар удирдах системээр автомат

цонхыг нээх болон хааж болно. (Зөвхөн цонх түгжих товч идэвхгүй үед ажиллана.)

Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

■ Хавчихаас хамгаалах функц

Цонх хаах үед цонх ба цонхны хүрээний завсар аливаа зүйл хавчуулагдвал цонх хаагдах хөдөлгөөн зогсож бага зэрэг нээгдэнэ.

■ Хавчуулагдахаас сэргийлэх функц

Цонх нээх үед цонх ба хаалганы завсар аливаа зүйл хавчуулагдвал цонхны нээгдэх хөдөлгөөн зогсоно.

■ Автомат цонх хэвийн нээгдэх хаагдахгүй үед

Хавчихаас хамгаалах функц эсвэл хавчуулагдахаас сэргийлэх функцийг хэвийн ажиллагаа алдагдаж цонх нээгдэх хаагдахгүй үед тухайн хаалганы автомат цонхны товч ашиглан дараах үйлдлийг хийж гүйцэтгэнэ.

● Автомашиныг зогсооно. Асаах товчны ON горим сонгогдсон үед хавчихаас хамгаалах функц эсвэл хавчуулагдахаас сэргийлэх функц ажилласнаас хойш 4 секунд дотор цонх нээх хаах товчийг гүйцэд нээх, гүйцэд хаах байдлаар ажиллуулна.

● Хэрэв дээрх үйлдлийг хийсэн ч цонх хаагдахгүй хэвээр байвал дараах үйлдлийн дагуу функцийг дахин ачаалуулна.

- 1 Асаах товчийг ON болгоно.
- 2 Цонхны товчийг гүйцэд хаах байрлалд үргэлжлүүлэн барьж цонхыг хаана.
- 3 Цонхны товчийг нэг суллаад дахин хаах байрлалд 6 ба түүнээс дээш секунд хугацаанд үргэлжлүүлэн дарна.
- 4 Цонхны товчийг гүйцэд нээх байрлалд үргэлжлүүлэн барина. Цонх нээгдсэнээс хойш 1-с дээш

секундийн хугацаанд товчийг татсан хэвээр байна.

- 5 Цонхны товчийг нэг суллаад дахин нээх байрлалд 4 ба түүнээс дээш секундийн хугацаанд дарна.
- 6 Цонхны товчийг гүйцэд хаах байрлалд үргэлжлүүлэн барина. Цонх хаагдсанаас хойш 1 секундийн хугацаанд дарна.

Цонх ажиллаж байх үед товчийг сулласан бол дээрх үйлдлийг эхнээс нь дахин давтана.

Дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч цонх буцаж нээгдэх мөн гүйцэд хаагдахгүй эсвэл нээгдэхгүй байвал та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

■ Хаалга түгжих функцтэй холбоотой цонхны ажиллагаа

- Механик түлхүүрээр автомат цонхыг нээх буюу хаах боломжтой.* (→X.560)
- Түлхүүрийн алсын удирдлагаар автомат цонхыг нээх буюу хаах боломжтой. (→X.118)
- Дохиолол идэвхэжсэн ба хаалга түгжих функцтэй холбоотой цонхны ажиллагаагаар автомат цонх хаагдаж байгаа үед дохиоллын систем ажиллаж болно.

*: Lexus дилер дээр тохируулна.

■ Автомат цонх онгорхой байгааг анхааруулах дохио

Автомат цонх нээлттэй үед асаах товчийг OFF болгож унтраасны дараа жолоочийн хаалгыг онгойлгосон тохиолдолд хянах самбарын дэлгэц дээр анхааруулга гарах ба анхааруулах дохио дуугарна.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим тохиргоог (хаалга түгжих функцтэй холбоотой цонхны ажиллагаа г.м.) өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)


! АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэлд хүрэх аюултай.

■ Автомат цонх хаах

- Бүх цонхны нээх хаах үйлдэл, тэр дундаа зорчигчийн хийж буй үйлдлийн хариуцлага жолоочид ноогддог. Санамсаргүй аюултай үйлдэл, ялангуяа бага насны хүүхдийн болгоомжгүй үйлдлээс сэргийлэхийн тулд бага насны хүүхдээр цонх ажиллуулахыг хориглоно. хүүхэд мөн бусад зорчигчид биеийн аль нэг хэсгээ цонхонд хавчуулж болзошгүй. Автомашинд бага насны хүүхэд зорчих үед цонх түгжих товчоор түгжинэ. (→X.177)

- Цонхтой харьцах үед бусад зорчигчдын биеийн аль нэг хэсэг цонхонд хавчуулагдахаас сэргийлж шалгана.



- Түлхүүрийн алсын удирдлага, механик түлхүүр ашиглан автомат цонх ажиллуулахын өмнө бусад зорчигчдын биеийн аль нэг хэсэг цонхонд хавчуулагдахаас сэргийлж шалгана. Мөн бага насны хүүхдээр алсын удирдлага, түлхүүр, механик түлхүүр ашиглан автомат цонх ажиллуулахыг хориглоно. Хүүхэд мөн бусад зорчигчид биеийн аль нэг хэсгээ цонхонд хавчуулж болзошгүй.

● Автомашинаас гарах үед асаах товчийг off горимд буцаах ба биедээ түлхүүрээ авч хүүхдийн хамт автомашинаас гарна. Хүүхэд цонх буруу ажиллуулах, тоглох зэргээс үүдэн осол гарч болзошгүй.

■ Хавчихаас хамгаалах функц

● Хавчихаас хамгаалах функцийг албаар идэвхжүүлэхийн тулд биеийн аль нэг хэсгээ санаатайгаар хавчуулахыг хориглоно.

! АЮУЛТАЙ

● Цонх бүрэн хаагдахын дөнгөж өмнө аливаа эд зүйл хавчуулагдвал хавчихаас хамгаалах функц ажиллахгүй байж болно.

■ Хавчуулагдахаас сэргийлэх функц

● Функцийг албаар идэвхжүүлэхийн тулд биеийн аль нэг хэсгээ санаатайгаар хавчуулахыг хориглоно.

● Цонх бүрэн нээгдэхийн дөнгөж өмнө аливаа эд зүйл хавчуулагдвал функц ажиллахгүй байж болно. Биеийн аль нэг хэсэг болон хувцсаа цонхонд хавчуулахаас сэргийлнэ.

Санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх (Цонх түгжих товч)


Тус функц нь бага насны хүүхэд санамсаргүйгээр зорчигчийн цонх ажиллуулахаас сэргийлнэ.

Товчийг дарна.

A асаж зорчигчийн цонх түгжигдэнэ.

Жолоочийн хаалганы цонхны товчоор зорчигчийн цонхийг нээх

буюу хааж болно.



■ Цонх түгжих товч ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа үед.

■ Аккумулятор салгагдсан үед

Цонх түгжих товч ажиллахгүй. Аккумуляторыг буцаан холбосны дараа цонх түгжих товчийг дахин дарна.


Дээврийн нээлхий*

*: Тоноглогдсон загварт

Таазанд байрлах
товчнуудаар дээврийн
нээлхийг нээж хаах буюу
өргөж буулгана.

Дээврийн нээлхий ажиллуулах

■ Нээх ба хаах



1 Нээх*


Салхины чимээг бууруулах үүднээс шууд бүрэн нээгдэхгүй ба бүрэн нээгдэхийн өмнөх байрлалд хагас нээгдэнэ.

Товчийг дахин дарж бүрэн нээнэ.

2 Хаах*

*: Товчийг хөнгөн дарж нээлхийг хагас нээнэ.

■ Өргөх ба буулгах



1 Өргөх*

2 Буулгах*

*: Товчийг хөнгөн дарж нээлхийг хагас нээнэ.

■ Дээврийн нээлхий ажиллах нөхцөл

Асаах товч ON горимын үед.

■ Хөдөлгүүр унтраасны дараа дээврийн нээлхий ажиллуулах

Асаах товч ACC эсвэл OFF горимд, хөдөлгүүр унтрааснаас хойш 45 секундний дотор дээврийн нээлхийг ажиллуулах боломжтой. Нөгөөтгээгүүр урд талын аль нэг хаалга нээсэн нөхцөлд ажиллахгүй.

■ Хавчихаас хамгаалах функц

Дээврийн нээлхий хаагдаж эсвэл бууж байгаа үед нээлхий болон араамны завсар аливаа зүйл хавчуулагдвал нээлхийний хөдөлгөөн зогсох ба бага зэрэг нээгдэнэ.

■ Нарнаас хамгаалах хаалт

Нарнаас хамгаалах хаалтыг гар аргаар нээх буюу хаах боломжтой. Мөн дээврийн нээлхий нээлттэй үед хаалтыг автоматаар нээх боломжтой.

■ Хаалга түгжих функцтэй холбоотой дээврийн нээлхийн ажиллагаа

● Механик түлхүүрээр дээврийн нээлхийг нээх буюу хаах боломжтой.* (→X.560)

● Түлхүүрийн алсын удирдлагаар дээврийн нээлхийг нээх буюу хаах

боломжтой.* (→X.118)

- Дохиолол идэвхэжсэн ба хаалга түгжих функцтэй холбоотой дээврийн нээлхийн ажиллагаагаар нээлхий хаагдаж байгаа үед дохиоллын систем ажиллаж болно.

* : Lexus дилер дээр тохируулна.

■ Дээврийн нээлхий хэвийн хаагдахгүй үед

Дараах үйлдлийг хийж гүйцэтгэнэ:

- Дээврийн нээлхийг хаасан ч буцаж бага зэрэг нээгдэж байгаа үед

- 1 Автомашиныг зогсооно.
- 2 “CLOSE” товчийг үргэлжлүүлэн дарна¹
Дээврийн нээлхий хаагдах ба буцаж нээгдээд 10 орчим секунд хөдөлгөөнгүй байна². Нээлхий дахин хаагдаж нээгдээд 1 орчим секунд хөдөлгөөнгүй байна. Үүний дараа дахин доош бууж нээгдээд бүрэн хаагдана.

- 3 Дээврийн нээлхий бүрэн хаагдсан эсэхийг нягтлаад товчийг суллана.

- Дээврийн нээлхий доош буусан ч буцаж өргөгдөөд байгаа үед

- 1 Автомашиныг зогсооно.
- 2 “UP” товчийг¹ нээлхий бүрэн нээгдэх хүртэл удаан дарна.
- 3 “UP” нэг суллаад дахин удаан дарна.

Дээврийн нээлхий нээгдсэн байрлалд 10 орчим секунд хөдөлгөөнгүй байна². Нээлхий бага зэрэг тохиргоо хийгээд 1 секунд хөдөлгөөнгүй байна. Үүний дараа дахин доош бууж нээгдээд бүрэн хаагдана.

- 4 Дээврийн нээлхий бүрэн хаагдсан эсэхийг нягтлаад товчийг суллана.

*1: Товчийг үйлдэл дуусаагүй үед сулласан нөхцөлд үйлдлийг дахин эхнээс нь хийнэ.

*2: Түлхүүрийг дээр дурдсан 10 секундийн хугацаанд товчийг сулласан нөхцөлд автомат үйлдэл цуцлагдана. Энэ үед “CLOSE” эсвэл “UP” товчийг удаан дарах ба нээлхий дээш өргөгдөж 1 секунд хөдөлгөөнгүй зогсоно. Үүний дараа дахин доош бууж нээгдээд бүрэн хаагдана. Дээврийн нээлхий бүрэн

хаагдсан эсэхийг нягтлаад товчийг суллана.

Дээрх үйлдлийг зөв дарааллын дагуу хийж гүйцэтгэсэн ч дээврийн нээлхий хэвийн хаагдахгүй байвал та өөрийн Lexus дилерт хандаж автомашины оношилгоо хийлгэнэ үү.

■ Дээврийн нээлхий онгорхой байгааг анхааруулах функц

Дээврийн нээлхий нээлттэй үед хөдөлгүүр унтраасны дараа жолоочийн хаалга онгойлгосон тохиолдолд хянах самбарын мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах ба анхааруулах дохио дуугарна.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим тохиргоог (хаалга түгжих функцтэй холбоотой ажиллагаа г.м.) өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)



АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирна.

■ Дээврийн нээлхий нээх

- Хөдөлгөөний үед гар, толгой зэргээ нээлхийгээр гаргахыг хориглоно.

- Нээлхий дээр суухыг хориглоно.

■ Дээврийн нээлхий нээх ба хаах

- Дээврийн нээлхий нээх, хаах үйлдлийн хариуцлага жолоочид ноогддог.
Санамсаргүй аюултай үйлдэл, ялангуяа бага насны хүүхдийн үйлдлээс сэргийлэхийн тулд бага насны хүүхдээр нээлхий ажиллуулахыг хориглоно. Хүүхэд бусад зорчигчид биеийн хэсгээ хавчуулж болзошгүй.

- Дээврийн нээлхийг ажиллуулах үед зорчигчдын бие нээлхийд хавчуулагдахаас сэргийлж анхаарна.

- Алсын удирдлага, механик түлхүүр ашиглан дээврийн нээлхий ажиллуулахын өмнө бусад зорчигчийн бие нээлхийд хавчуулагдахаас сэргийлж шалгана. Мөн бага насны хүүхдээр алсын удирдлага, механик түлхүүрээр дээврийн нээлхий ажиллуулахыг хориглоно. Хүүхэд болон бусад зорчигчид нээлхийд хавчуулагдаж болзошгүй.



АЮУЛТАЙ

- Автомашинаас гарах үед асаах товчийг OFF горимд буцаах ба биедээ түлхүүрээ аван бага насны хүүхдийн хамт автомашинаас гарна. Хүүхэд цонх буруу ажиллуулах, тоглох зэргээс үүдэн осол гарч болзошгүй.

■ Хавчихаас хамгаалах функц

- Хавчихаас хамгаалах функцийг албаар идэвхжүүлэхийн тулд биеийн аль нэг хэсгээ санаатай хавчуулахыг хориглоно.
- Дээврийн нээлхий бүрэн хаагдахын дөнгөж өмнө аливаа эд зүйл хавчуулагдвал хавчихаас хамгаалах функц ажиллахгүй байж болно.

Жолоодлогын байрлал санах систем*

* Тоноглогдсон загварт

Тус систем жолоочийн суудал, жолооны хүрд, хажуугийн толь болон HUD дэлгэц (тоноглогдсон загварт)-н байрлалыг таны тохиргоонд автоматаар тохируулж хялбараар буух суух боломж бүрдүүлнэ.

Миний тохиргоо идэвхтэй:

Миний тохиргоонд бүртгэгдсэн жолооч, зорчигчийн тус бүр 3 суудлын байрлал бүртгэх боломжтой.

Миний тохиргоогоор жолоочид электрон түлхүүр бүртгэгдсэн үед тухайн жолоочийн суудлын байрлал дуудагдана (санах ойн дахин дуудах функц).

Миний тохиргоо идэвхгүй:

3 хүртэлх жолоодлогын байрлал сануулж болно.

Электрон түлхүүр тус бүрд өөр жолоодлогын байрлал сануулах боломжтой. (санах ойн дахин дуудах функц).


Дэлгэрэнгүйг Х.185-с харна уу.

Жолооч хялбараар суух, буух идэвхжүүлэх (Жолооч буух, суухад туслах систем)

Дараах бүх үйлдлийг хийсэн үед

жолоочийн суудал, жолооны хүрд нь автоматаар жолооч хялбараар суух, буух боломжит байрлалд тохируулагдана.

- Арааны хөшүүргийг Р байрлалд шилжүүлсэн.
- Хөдөлгүүр асаах товч OFF горимд унтарсан.
- Жолоочийн аюулгүйн бүс тайлагдсан.



Дараах аль нэг үйлдлийг хийх үед жолоочийн суудал болон жолооны хүрд анхны байрлалд буцна.

- Асаах товчийг ACC эсвэл ON горимд шилжүүлсэн.
- Жолоочийн аюулгүйн бүс бүслэгдсэн.

■ Жолооч буух, суухад туслах системийн ажиллагаа

- Автомашинаас буух үед суудал хамгийн арагш байрлалд ойр үед жолооч буух, суухад туслах систем ажиллахгүй байж болно.
- Жолооч буух, суухад туслах систем ажиллаж байх үед суудлын тохиргоо хийвэл системийн автомат ажиллагаа зогсоно. (Суудал гар тохиргоонд шилжинэ.)
- Жолооч буух, суухад туслах систем ажиллаж байх үед суудлын тохиргоо хийвэл системийн автомат

ажиллагаа зогсоно. (Суудал гар тохиргоонд шилжинэ.)

- Жолооч буух, суухад туслах систем ажиллаж байх үед эсвэл систем ажиллаж дууссаны дараа суудлын тохиргоо хийвэл жолооч буцаж суух үед систем ажиллахгүй.

■ Хавчихаас хамгаалах функц

Суудал хөдөлж байх үед хүн ба аливаа зүйл хавчуулагдвал суудлын ажиллагаа зогсоно.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Жолооч буух, суухад туслах систем ажиллах үеийн суудлын байрлал өөрчлөгдөх хэмжээг тохируулах боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →Х.583)



АЮУЛТАЙ

- **Жолооч буух, суухад туслах систем ажиллан жолоочийн суудал, жолооны хүрд хөдлөх үед**

Бие болон бусад эд зүйл хавчуулахаас сэргийлнэ. Эсрэг тохиолдолд бэртэл гэмтэл авах, эд зүйлсээ эвдэхэд хүрнэ.


Жолоочийн байрлалыг санах ойн товчинд сануулах

■ Сануулах

- 1 Арааны хөшүүрэг Р-д байгаа эсэхийг нягтална.
- 2 Асаах товчийг ON болгоно.
- 3 Жолоочийн суудал, жолооны хүрд, хажуугийн толь, HUD дэлгэцийг (тоноглогдсон загварт) хүссэн байрлалдаа тохируулна.
- 4 “SET” товчийг дарангаа эсвэл “SET” товчийг дарснаас 3 секундн дотор “1”, “2”-р


товчийг эсвэл “3” товчийг дуут дохио дуугарах хүртэл дарна.

Товчинд өмнө нь байрлал сануулагдсан байвал тухайн байрлалын оронд шинэ байрлалыг санана.



■ Байрлал дахин дуудах

- 1 Арааны хөшүүрэг Р-д байгаа эсэхийг нягтална.
- 2 Асаах товчийг ON болгоно.
- 3 Дуут дохио дуугарах хүртэл өөрт тохирсон байрлалын санах товчийг дарна.



■ Дуудагдаж буй байрлалыг зогсоох

Дараах аль нэг үйлдлийг хийнэ:

- “SET” товч дарна.
- “1”, “2” болон “3” товч дарна.
- Суудлын тохиргооны аль нэг товчийг дарна (зөвхөн байрлал дуудах үйлдлийг зогсооно).
- Жолооны хүрдний байрлал тохируулах товчийг дарна (зөвхөн

жолооны хүрдний байрлал дуудах үйлдлийг зогсооно).

■ Хавчихаас хамгаалах функц

Суудал хөдөлж байх үед хүн ба аливаа зүйл хавчуулагдвал суудлын ажиллагаа зогсоно.

■ Дуу хоолойгоор удирдах системээр жолоочийн байрлал сануулах ойг ажиллуулах

* : Тоноглогдсон загварт

Дуугаар хоолойгоор удирдах систем ашиглан дараах үйлдлийг хийх боломжтой.

- Жолоодлогын байрлал сануулах
- Жолоодлогын байрлал дуудах (зөвхөн арааны Р байрлалд дуудах боломжтой)

Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэчийн гарын авлага"-с харна уу.

■ Санах боломжтой суудлын байрлал (→Х.148)

Суудлын түшлэгийн гүнээс бусад товчоор тохируулагдсан байрлалыг систем санана.

■ Асаах товчийг унтраасны дараа жолоодлогын байрлалын санах ойг ажиллуулах

Жолоочийн хаалга нээгдсэнээс хойш 180 секунд, хаагдсанаас хойш 60 секундийн дотор сануулсан жолоодлогын байрлалыг дуудаж болно.

■ Жолоодлогын байрлал санах функцийг зөвөөр ашиглах

Суудлын байрлалын тохиргоо нь аль нэг чиглэлд тулсан эсвэл тухайн чиглэлд суудлын тохиргоо хийх үед сануулсан суудлын байрлал дахин дуудах үед бага зэрэг өөр байж болно.

■ Жолоодлогын байрлал дуудах үед

Жолоодлогын байрлал дуудах үед толгойн түшлэгийг таазанд хүргэхээс зайлсхийнэ.

■ Сануулсан суудлын байрлал дуудагдахгүй үед

Суудлын зарим байрлалд байгаа үед байрлал сануулсан нөхцөлд тухайн байрлал дахин дуудагдахгүй байж болно. Дэлгэрэнгүйг та өөрийн Lexus дилерээс тодруулна уу.



АЮУЛТАЙ

■ Тохиргоо хийх анхааруулга

Суудлын тохиргоо хийх үед суудал арын зорчигч мөн жолоочийг жолооны хүрдэнд хэт шахахаас сэргийлнэ.

Электрон түлхүүр (санах ойн дахин дуудах функц)-ээр жолоодлогын байрлал бүртгэх, дахин дуудах, цуцлах

■ Миний тохиргоо идэвхтэй үед (электрон түлхүүрээр жолоочийг таньсан үед):

Миний тохиргоогоор электрон түлхүүр дээр сануулсан жолоочийн жолоодлогын байрлал автоматаар дуудагдана.

● Бүртгэх дараалал

Жолоодлогын дараа арааг Р байрлалд буцаах үед тухайн жолоодлогын байрлал системд бүртгэгдэнэ.

● Дахин дуудах

- 1 Миний тохиргоогоор жолооч дээр бүртгүүлсэн түлхүүртэй үед smart entry & start систем эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар жолоочийн хаалгыг тайлж нээнэ.

Жолооны хүрд, HUD дэлгэцээс (тоноглогдсон загварт) бусад сануулсан жолоодлогын байрлал дуудагдана. Нөгөөтээгүүр жолооч хялбар орох боломж бүрдүүлж жолоочийн суудал сануулсан байрлалаас хойш шилжинэ.

Суудал тухайн сануулсан байрлалд

байгаа үед хөдлөхгүй.

2 Асаах товчийг ACC эсвэл ON-д шилжүүлэх.

Суудал, жолооны хүрд, HUD дэлгэц (тоноглогдсон загварт) (зөвхөн асаах товч ON үед) сануулсан байрлал руу шилжинэ.

● Тохиргоог цуцлах

Миний бүртгэл дэх жолоочийн тохиргоог цуцална:

Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

■ Миний тохиргоо идэвхгүй үед:

Түлхүүр нэг бүрийг өөр жолоодлогын байрлал дээр сануулан дахин дуудаж болно.

● Бүртгэх дараалал

Дараах үйлдлүүдээр жолоодлогын байрлалыг "1", "2" эсвэл "3"-р товчинд сануулна:

Зөвхөн тухайн бүртгүүлэх түлхүүрийг биедээ авч жолоочийн хаалгыг хаана. Бүхээгт 2-с дээш тооны түлхүүр байх үед зөв бүртгэгдэхгүй.

1 Арааны хөшүүрэг Р-д байгаа эсэхийг нягтална.


2 Асаах товчийг ON болгоно.

3 Бүртгэх жолоодлогын байрлалыг дуудна.

4 Дуудах товч дарангаа хаалга түгжих товчийг (түгжих эсвэл тайлах) дуут дохио дуугарах хүртэл удаан дарна.

Товч бүртгэгдэхгүй үед дуут дохио 3

секунд үргэлжлэн дуугарна.



● Дахин дуудах

1 Жолоодлогын байрлалд бүртгүүлсэн электрон түлхүүрийг биедээ авах ба жолоочийн хаалганы Smart entry & start систем эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар түгжээг тайлаад нээнэ.

Жолооны хүрд, HUD дэлгэцээс (тоноглогдсон загварт) бусад сануулсан жолоодлогын байрлал дуудагдана. Нөгөөтээгүүр жолооч хялбар орох боломж бүрдүүлж жолоочийн суудал сануулсан байрлалаас хойш шилжинэ.

Суудал тухайн сануулсан байрлалд байгаа үед хөдлөхгүй.

2 Асаах товчийг ACC буюу ON горимд шилжүүлэх эсвэл аюулгүйн бүс бүсэлнэ.

Суудал, жолооны хүрд, HUD дэлгэц (тоноглогдсон загварт) (зөвхөн асаах товч ON үед) сануулсан байрлал руу шилжинэ.

● Тохиргоог цуцлах

1 Электрон түлхүүрийг биедээ авсан үедээ цуцлах ба дараа нь жолоочийн хаалгыг хаана.

Бүхээгт 2-с дээш тооны түлхүүр байгаа үед цуцлах боломжгүй.

1 Асаах товчийг ON болгоно.

- 2 Арааны хөшүүрэг Р-д байгаа эсэхийг нягтална.
- 3 “SET” товчийг дарангаа хаалга түгжих товчийг (түгжих эсвэл тайлах) дуут дохио 2 удаа дуугарах хүртэл удаан дарна.

Товч цуцлагдаагүй үед дуут дохио 3 секунд үргэлжлэн дуугарна.

■ **Санах ойг дахин дуудах функцээр жолоодлогын байрлал дуудах (Миний тохиргоо унтраастай үед)**

Smart entry & start системээр жолоочийн хаалганаас бусад хаалганы түгжээ тайлагдсан үед жолооны байрлал дуудагдахгүй. Энэ тохиолдолд тухайн байрлалын товчийг дарж дуудна.

■ **Хавчихаас хамгаалах функц**

Суудал хөдөлж байх үед хүн болон аливаа юм хавчуулагдвал суудлын ажиллагаа зогсоно.

■ **Өөрчлөх боломжтой тохиргоо**

Зарим функцийн тохиргоог өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →Х.583)

Миний тохиргоо

Электрон түлхүүр зэрэг төхөөрөмжөөр жолооч өөрийгөө системд таниулж болох ба систем жолооч тус бүрийн жолоодлогын байрлал болон бусад тохиргоог хадгална. Хэрэглэгч бүр автомашин жолоодох үедээ автоматаар өөрийн тохиргоогоо дуудах боломжтой.

Жолооч танилтыг урьдчилан сануулж тохируулна.

Миний тохиргоо системд 3 хүртэлх жолоочийн тохиргоог бүртгэх боломжтой.

Таних төхөөрөмжийн бүртгэл, бүртгэл устгах, жолоочийн нэр өөрчлөх, жолоочийн бүртгэлийн тохиргоог тэглэх, гар аргаар өөр жолоочийн тохиргоонд шилжүүлэх, жолоочийн бүртгэл устгах тухай дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Жолоочийг таних төхөөрөмжийн төрлүүд

Дараах төхөөрөмжүүдээр жолоочийг таних боломжтой.

● **Электрон түлхүүр**

Smart entry & start систем тухайн жолооч дээр бүртгэгдсэн түлхүүрээр

танина. (→X.143)

● Bluetooth® төхөөрөмж

Bluetooth® төхөөрөмж мультимедиа системд холбогдох үед жолоочийг танина. Bluetooth® төхөөрөмж холбох тухай дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Жолоочийг электрон түлхүүр эсвэл хурууны хээгээр таньсан (тоноглогдсон автомашинд) үед Bluetooth® төхөөрөмжөөр таних үйлдэл хийгдэхгүй.

Дуудагдах функцүүд

Төхөөрөмж жолоочийг таних үед дараах функцийг тохиргоо дуудагдана.

● Жолоодлогын байрлал (санах функц буцаан дуудах)^{*1}

Жолоочийг таньсан ба дараах аль нэг үйлдлийг хийх үед өмнөх жолоодлого дууссан үеийн жолоодлогын байрлал автоматаар дуудагдана.

• Жолоочийг электрон түлхүүрээр таньсан: Smart entry & start систем эсвэл түлхүүрийн алсын удирдлагаар хаалга тайлж нээсэн.

● Хянах самбар^{*2}, HUD дэлгэцийн мэдээлэл^{*1, 2}

Жолоочийг таньсан үед тухайн хэрэглэгчийн өмнө нь хөдөлгүүр унтраасан үеийн дэлгэцийн тохиргоо дахин дуудагдана.

● Мультимедиа тохиргоо^{*2}

Жолоочийг таньсан үед тухайн хэрэглэгчийн өмнө нь хөдөлгүүр унтраасан үеийн автомашины

тохиргоо дахин дуудагдана.

● Аюулгүй жолоодлогод туслах функц^{*2}

Жолоочийг таньсан үед өмнө нь хөдөлгүүр унтраах үеийн автомашины тохиргоо автоматаар дуудагдана.

● Голын дэлгэц дээр хийж болох автомашины тохиргоо^{*2}

Жолоочийг таньсан үед асаах товчийг өмнө нь унтраасан үеийн автомашины тохиргоо дахин дуудагдана.

^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Зарим тохиргоо хамаарахгүй.

4-1. Жолоодлогын өмнө	LDA систем.....	264
Автомашин жолоодох ...	PDA систем	269
Ачаа тээш, багааж.....	FCTA функц.....	274
Чиргүүл чирэх (чирэх дэгээтэй)	RSA систем	277
4-2. Жолоодох үеийн зааварчилгаа	Динамик радарын хурд барих систем.....	281
Асаах товч.....	Хурд баригч.....	292
Автомат хурдны хайрцаг	EDSS систем.....	295
Эргэх дохионы хөшүүрэг	Хурд хязгаарлагч	297
Зогсоолын тоормос	BSM систем.....	300
Тоормос баригч	Араас автомашин ойртож буйг анхааруулах функц	305
4-3. Гэрэл, шил арчигчийн ажиллагаа	Автомат арын ослын дохионы гэрэл.....	308
Их гэрэл асаах товч.....	Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт).....	310
AHS холын гэрэл	Аюулгүй буухад туслах систем.....	312
АНВ холын гэрэл	Lexus parking assist-мэдрэгч.....	316
Манангийн гэрлийн товч	RCTA функц	322
Шил арчигч ба угаагч	RCD функц	327
Хойд шил арчигч ба угаагч	PKSB систем	330
4-4. Шатахуун цэнэглэх	PKSB тоормос (урд, хойд талын хөдөлгөөнгүй объект).....	334
Шатахууны савны таг онгойлгох	PKSB тоормос (ар талын явж буй автомашин)...	337
4-5. Жолоодлогод туслах систем ашиглах	PKSB тоормос (ар талын явган зорчигч)	338
Lexus Safety System + ...	Multi-terrain монитор	340
PCS систем		
LTA систем.....		
LCA систем		

Жолоодлогын горим сонгох товч.....	407
Дөрвөн дугуй хөтлөх систем	409
Арын дифференциал цоожлогч	412
Crawl Control	413
Multi-terrain Select систем	416
Уруу замд туслах удирдлагын систем	419
Жолоодлогод туслах системүүд.....	421
4-6. Жолоодлогын зөвлөмж	
Бартаат замын жолоодлого	427
Өвлийн жолоодлого	429

Автомашин жолоодох

Автомашиныг аюулгүй жолоодохын тулд дараах зааварчилгааг дагаж мөрдөнө:

Автомашин жолоодох

■ Хөдөлгүүр асаах

→Х.203

■ Жолоодлого

- 1 Тоормосны дөрөөг гишгэнгээ арааг D байрлалд шилжүүлнэ. (→Х.208)
- 2 Зогсоолын тоормос салгана. (→Х.213)

Зогсоолын тоормосны автомат горимд зогсоолын тоормос автоматаар салгагдана. (→Х.214)

- 3 Тоормосны дөрөөг аажмаар суллан хаазны дөрөөг зөөлөн гишгэх үед автомашин явж эхэлнэ.

■ Автомашин зогсоох

- 1 Арааны D байрлалд тоормосны дөрөөг гишгэнэ.
- 2 Шаардлагатай үед зогсоолын тоормос залгана. (→Х.213)

Удаан зогсох үед арааг Р эсвэл N араанд шилжүүлнэ. (→Х.208)

■ Зогсоолд байрлуулах

- 1 Арааны D байрлалд тоормос гишгэнэ.
- 2 Зогсоолын тоормос (→Х.213) залгаад арааг Р-д шилжүүлнэ (→Х.208).

Зогсоолын тоормосны индикатор ассан байгааг нягтална.

- 3 Асаах товч дарж хөдөлгүүр унтраана.

- 4 Түлхүүрийг биедээ авснаа нягтлаад хаалга түгжинэ.

Налуу газар байрлуулах үед шаардлагатай тохиолдолд дугуйнд ивүүр хийнэ.

■ Өгсүүр замд хөдөлгөөн эхлэх

- 1 Тоормосны дөрөөг гишгэнгээ арааг D байрлалд шилжүүлнэ. (→Х.208)
- 2 Зогсоолын тоормосны товчийг татаж идэвхжүүлнэ. (→Х.213)
- 3 Тоормосны дөрөөг аажмаар суллан хаазны дөрөөг зөөлөн гишгэж хааз өгнө.
- 4 Зогсоолын тоормосны товчийг дарж тоормосыг гар аргаар салгана.

■ Өгсүүр замд хөдөлгөөн эхлэх

Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага идэвхэжнэ. (→Х.421)

■ Бороотой үед

- Бороотой үед үзэгдэх орчин буурах ба цонх цантах, зам хальтиргаатай болох тул өндөр анхааралтай жолоодно.
- Бороо орж эхлэх үед зам илүү хальтиргаатай байдаг тул өндөр анхааралтай жолоодно.
- Замын гадаргуу болон дугуйн завсар усан давхарга үүсэж жолоодлого, тоормос гүйцэд ажиллахгүй байдалд хүрч болзошгүй тул бороотой үед өндөр хурдтай жолоодохоос зайлсхийнэ.

■ Жолоодлогын үеийн хөдөлгүүрийн хурд

Дараах нөхцөлүүдэд жолоодлогын үеийн хөдөлгүүрийн хурд нэмэгдэж болно. Энэ нь жолоодлогод нийцүүлэн арааг хүнд хөнгөн араанд шилжүүлэх ажиллагаанаас

шалтгаалах ба огцом хааз нэмэгдэлтийг илэрхийлэхгүй.

- Автомашин өгсүүр, уруу замаар явж байна гэж систем таньсан үед
- Хаазны дөрөөг сулласан үед
- Sport горим*, SPORT S горим* эсвэл SPORT S+ горим сонгосон үед тоормос гишгэх (→X.407)
- “REMOLQUE” горим сонгосон үед тоормос гишгэх

*: Тоноглогдсон загварт

■ Хөдөлгүүрийн хүчийг хязгаарлах (Brake Override систем)

- Хаазны дөрөө болон тоормосны дөрөөг зэрэг гишгэх үед систем хөдөлгүүрийн хүчийг хязгаарладаг.
- Систем ажиллах үед мэдээллийн дэлгэц дээр анхааруулах мэдээлэл гарна.

■ Шинэ Lexus автомашинтай хэрхэн харьцах тухай

Ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх үүднээс шинэ автомашинд дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:

- Эхний 300 км-д (200 миль): Огцом тоормослохоос зайлсхийх.
- Эхний 800 км-д (500 миль) (чирэх дэгээтэй автомашин): Чиргүүл чирэхгүй байх.
- Эхний 1000 км-д (600 миль):
 - Хэт өндөр хурдтай явахгүй бай.
 - Огцом хаазнаас зайлсхийх
 - Хүнд араатай удаан хугацаанд явахгүй байх
 - Тогтмол хурдаар удаан хугацаанд явахгүй байх

■ Хэт хүйтэн орчинд ашиглах

Хэт хүйтэнд орчинд ашиглах үед хөдөлгүүрийг асаагаад 30-с дээш секунд нормал хаазлаад хөдөлнө. Өндөр хааз өгч болохгүй.

■ Хөдөлгүүр унтраахын өмнөх нормалдах хугацаа

Турбо гэмтэхээс сэргийлж өндөр хурдаар явсан эсвэл өгсүүр замаар

явсны дараа хөдөлгүүрийг тодорхой хугацаанд сул хаазаар ажиллуулна.

Жолоодлогын нөхцөл	Хугацаа
Хэвийн хотын жолоодлого	Шаардлагагүй
Хурдтай явах (100км/ц [62 миль/ц]-н тогтмол хурд)	Шаардлагагүй
Өгсүүр зам эсвэл 100км/ц (62 миль/ц)-с дээших тогтмол хурд (уралдааны зам зэрэг.)	1 мин орчим

■ Автомашинаа гадаадад ашиглах

Холбогдох автомашин бүртгэлийн хууль дүрмийг дагаж мөрдөхөөс гадна тохирох шатахуун байгаа эсэхийг шалгана. (→X.576)

⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

■ Хөдөлгөөн эхлэх үед

Хөдөлгүүр асаалттай зогсож байгаа үед тоормосны дөрөөг заавал гишгэнэ. Ингэснээр автомашин өөрөө хөдлөхөөс сэргийлнэ.

■ Автомашин жолоодох үед

- Хэрэв та тоормос, хаазны дөрөөний байрлалыг мэддэггүй бол буруу дөрөөг гишгэхээс сэргийлж жолоодохгүй байх нь зүйтэй.
- Тоормосны дөрөөний оронд хаазны дөрөөг андуурч гишгэх нь хурд огцом нэмэгдэх, осол аваар үүсгэхэд хүргэх аюултай.
- Ухрах үйлдэл хийх үед биеэрээ эргэж арагш харах нь дөрөөний ажиллагааг хүндрэлтэй болгодог. Дөрөөтэй зөв ажиллана.



АЮУЛТАЙ

- Автомашиныг богино зайнд хөдөлгөх үед ч жолоо барих зөв биеийн байрлалтай сууна. Энэ нь танд дөрөөтэй зөв ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- Тоормосны дөрөөг зөвхөн баруун хөлөөрөө гишгэнэ. Зүүн хөлөөрөө гишгэх нь яаралтай үед самбаачлах хурдыг багасгаж улмаар осол аваар үүсгэх аюултай.
- Шатамхай бодис дээгүүр гарах, шатамхай бодисын ойр орчимд автомашинаа зогсоож болохгүй. Яндангийн систем болон яндангаас ялгарч буй утаа нь өндөр хэмтэй байх ба шатамхай материалд гал авалцах аюултай.
- Хэвийн жолоодлогын үед хөдөлгүүр унтраахыг хориглоно. Хөдөлгөөний үед хөдөлгүүр унтраах нь жолооны механизм, тоормосны удирдлагад нөлөөлөхгүй боловч аккумуляторын үлдэгдэл цэнэг эсвэл ашиглалтаас хамаарч эдгээр механизмдын цахилгаан хүчлүүр ажиллагаагүй болж болно. Ингэснээр жолоодох, тоормослох нь хэцүү болох тул даруй замаас гарч аюулгүй газар зогсооно. Автомашиныг хэвийн аргаар зогсоох боломжгүй болсон зэрэг онцгой нөхцөл үүссэн үед:→Х.524
- Эгц налуу замаар уруудах үед аюулгүй тогтмол хурд барихын тулд хөдөлгүүрийн тоормос (хүнд араанд шилжүүлэх) ашиглана. Тоормос удаан ашиглах нь хэт халж ажиллагаагүй болоход хүргэх аюултай. (→Х.207)
- Жолоодлогын үед жолооны хурд, суудал, голын толь (тоноглогдсон загварт), дижитал голын толь (тоноглогдсон загварт) болон хажуугийн толины тохиргоо хийж болохгүй. Автомашины жолоодлого алдагдахад хүрэх аюултай.

• Хөдөлгөөний үед зорчигч гар, толгой болон биеийн бусад хэсгээ гадагш гаргаж болохгүй.

■ Хальтиргаатай замаар явах үед

- Огцом тоормослох, хаазлах мөн жолооны хурд огцом эргүүлэх нь дугуй халтирах улмаар жолоодлого алдагдахад хүргэх аюултай.
- Огцом хурдлах, араа сольж хөдөлгүүрийн тоормос хийх, хөдөлгүүрийн эргэлт өөрчлөх нь автомашин халтирахад хүргэнэ.
- Тогтоол устай газраар явсны дараа тоормосны дөрөөг зөөлөн гишгэж хэвийн ажиллагааг шалгана. Норсон наклад тоормосны хэвийн ажиллагааг алдагдуулах магадлалтай. Автомашины нэг талын наклад норж тоормос муу барих нь жолоодлогод нөлөөлнө.

■ Арааны хөшүүрэг сэлгэх үед

- Автомашин урагшаа явах араатай үед арагш өнхрөх эсвэл R араатай үед урагш өнхрөхөөс сэргийлнэ. Энэ нь хөдөлгүүр хүч алдаж унтрах эсвэл тоормос, жолооны ажиллагаа муудах, улмаар осол аваар, эвдрэл гэмтэлд хүргэнэ.
- Хөдөлгөөний үед арааг P байрлалд буцаахыг хориглоно. Энэ нь хурдны хайрцгийг гэмтээх мөн автомашины жолоодлого алдагдахад хүргэх аюултай.
- Автомашин урагшаа явж байгаа үедээ арааг R байрлалд шилжүүлж болохгүй. Энэ нь хурдны хайрцаг гэмтэх мөн автомашины жолоодлого алдагдахад хүргэх аюултай.
- Автомашин ухарч байгаа үед арааг урагшаа явах араанд шилжүүлж болохгүй. Энэ нь хурдны хайрцгийг гэмтээх мөн автомашины жолоодлого алдагдахад хүргэх аюултай.



АЮУЛТАЙ

- Явж байгаа автомашины арааг N байрлалд шилжүүлснээр хөдөлгүүр салгагдана. Арааны N байрлалд хөдөлгүүрийн тоормос ажиллахгүй.

- Автомашин жолоодох үед хаазны дөрөө гишгэнгээ араа солихгүй байхад анхаарна. Арааны хөшүүргийг өөр араанд шилжүүлэх "P болон N араанд шилжүүлэх хамаарахгүй" нь автомашин огцом ухасхийн хөдлөхөд хүргэх ба осол үүсэх, амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

■ Зурагдах, хавирах дуу гарсан үед (накладны элэгдэл заагч)

Нэн даруй өөрийн Lexus дилерт хандаж тоормосны накладаа шалгуулж солиулна уу.

Даруй солиогүй наклад тоормосны планз гэмтээх магадлалтай.

Тоормосны наклад, планз зөвшөөрөгдөх хэмжээнээс элэгдсэн үед автомашин жолоодох нь аюултай.

■ Автомашин зогссон үед

- Өндөр хааз өгч болохгүй. Автомашины араа P эсвэл N-с өөр араанд байгаа үед өндөр хааз өгөх нь автомашин огцом ухасхийн хөдлөх, улмаар осол гарахад хүргэх аюултай.
- Хөдөлгүүр асаалттай үед өнхөрч осол гаргахаас сэргийлж зогсох үед тоормос гишгэх мөн зогсоолын тоормос татна.
- Налуу газар зогсож байгаа үед автомашин урагш болон арагш өнхөрч осол аваар үүсгэхээс сэргийлж зогсох хугацаандаа тоормос гишгэх ба шаардлагатай үед зогсоолын тоормос татна.

- Өндөр хааз өгөх, хөдөлгүүр ээрүүлэхээс зайлсхийнэ. Зогсож байгаа автомашины хөдөлгүүрт өндөр хааз өгөх нь яндангийн систем хэт халах улмаар халсан яндангаас ойр орчимд байгаа шатамхай материалд гал авалцах аюултай.

■ Зогсоолд байрлуулсан үед

- Нартай үед нүдний шил, тамхины асаагуур, лаазтай шүршдэг бодис, лаазтай ундаа автомашинд үлдээхийг хориглоно. Дараах эрсдэлүүд үүснэ:

- Тамхины асаагуур, лаазтай шүршдэг бодисоос хий алдагдаж улмаар гал гарч болзошгүй
- Автомашины бүхээгийн өндөр хэмд нүдний шилний хуванцар линз болон бусад хэсгийн хэлбэр алдагдах, цуурч гэмтэх аюултай
- Ундааны лааз хагарах, ундаа автомашины бүхээгт цацагдах, цахилгааны эд ангиудад богино холболт үүсгэх аюултай
- Автомашинд тамхины асаагуур үлдээж болохгүй. Урд хайрцагт хийсэн эсвэл шалан дээр тамхины асаагуур орхисон үед суудлын тохиргоо хийх, эд зүйл хийх үед санамсаргүй дарагдаж асах, улмаар гал гарч болзошгүй.
- Сорж наалддаг наалт шилэнд наах мөн агаар цэвэршүүлэгч зэргийн сав хянах самбар, урд хэсэгт тавьж болохгүй. Эдгээр нь линз шиг гэрэл цуглуулж гал гаргах аюултай.
- Хүнхэр шил зэргийг гэрэл ойлгодог хуулгаар бүрсэн нөхцөлд автомашины цонх, хаалгыг онгорхой орхиж болохгүй. Шил хүнхэр линз шиг ойлсон гэрлийг цуглуулж гал гаргах аюултай.



АЮУЛТАЙ

● Зогсоолын тоормос татаж арааг Р байрлалд буцаах ба хөдөлгүүрийг унтрааж хаалга түгжинэ. Хөдөлгүүр асаалттай үед автомашиныг харах хүнгүй үлдээж болохгүй. Р араанд зогсоолын тоормос татаагүй автомашин өнхрөх, улмаар осол үүсгэх аюултай.

● Дөрвөн дугуйн хөтөлгөөт нам хурдны горимын индикатор асах/унтрахаас өмнө арааг шилжүүлсэн нөхцөлд хүч дамжуулах горим бүрэн шилжихгүй.

Хурдны хайрцгийн горим солих функц нь урд болон хойд кардан голыг хүч дамжуулах ангиас салгадаг тул арааны байрлалаас үл хамааран автомашин өнхөрнө. (Энэ үед индикатор анивчигч анхааруулах дуут дохио дуугарна.)

Тиймээс автомашин Р араанд байгаа эсэхээс үл хамааран өнхөрч танд болон бусдад ноцтой гэмтэл учруулах тул хурдны хайрцгийн горимыг гүйцэд солино. (→Х.409)

● Хөдөлгүүр ажиллаж байгаа эсвэл унтарсан даруйд халуун янданд хүрч болохгүй. Халуун янданд хүрсэн үед түлэгдэх аюултай.

■ Автомашинд унтах үед

Автомашинд унтах үед хөдөлгүүрийг заавал унтраана. Эсрэг тохиолдолд санамсаргүйгээр араа солих, хаазны дөрөөг гишгэснээр осол гарах мөн хөдөлгүүр хэт халснаа гал гарахад хүрэх аюултай. Үүнээс гадна автомашин агааржуулалт муутай орчинд байгаа үед яндангийн утаа хуримтлагдан бүхээгт орж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

■ Тоормослох үед

● Тоормос норсон үед илүү анхаарал болгоомжтой жолоодно. Тоормос норсон үед тоормосны зай ихэсдэг ба автомашины баруун болон зүүн талын тоормос хоёр өөрөөр барих тохиолдол гардаг. Мөн зогсоолын тоормос гүйцэд барихгүй байж болно.

● Тоормосны хүчлүүр ажиллахгүй үед бусад автомашиныг хэт ойр дагах мөн тоормослох шаардлагатай уруу зам, огцом эргэлтээс зайлсхийнэ. Хүчлүүр ажиллахгүй үед тоормос ажиллах боловч ердийнхөөс илүү хүчээр дөрөөг гишгэх шаардлагатай болох бөгөөд тоормосны зай ихэсдэг тул даруй засуулна.

● Хөдөлгүүр хүч алдаж унтарсан үед тоормосны дөрөөг олон дахин гишгэж болохгүй. Тоормосны дөрөөг гишгэх бүрд тоормосны хүчлүүрт зориулагдсан нөөц багасаж байдаг.

● Тоормосны систем 2 тусдаа гидравлик системээс бүрдэх ба аль нэг систем доголдсон үед нөгөө систем үргэлжлүүлэн ажилладаг. Энэ үед тоормосны дөрөө илүү хүч шаардах ба тоормосны зай ихэсдэг тул даруй засна.

■ Автомашин суусан үед

Автомашины аль нэг дугуй газраас хөндийрсөн эсвэл элс, шавар зэрэгт суусан үед хэт их хий эргүүлэхийг хориглоно. Явах эд ангийг гэмтээх улмаар автомашин огцом ухасхийж осол гаргах аюултай.



АНХААР

■ Автомашин жолоодох үед

● Хөдөлгүүрийн хүч хязгаарладаг тул жолоодлогын үед хааз болон тоормосыг зэрэг гишгэхгүй.



АНХААР

- Налуу зам дээр автомашиныг хөдөлгөөнгүй зогсоохын тулд хаазны дөрөө ашиглах эсвэл хааз болон тоормосны дөрөөг зэрэг гишгэж болохгүй.
- **Автомашины эд ангиудыг эвдрэл гэмтлээс хамгаалах**
- Жолооны хүрдийг аль нэг тийш тултал нь эргүүлэх мөн эргүүлсэн хэвээр удаан барьж болохгүй. Жолооны механизмын хүчлүүр эвдрэх аюултай.
- Энхэл доголтой замаар явах үед дугуй, автомашины доод тал зэргийг гэмтэхээс сэргийлж боломжит бага хурдаар явна.
- Өндөр хурдтай эсвэл өгсүүр замаар явсны дараа хөдөлгүүрийг тодорхой хугацаанд сул ажиллуулна. Турбо хөрсний дараа хөдөлгүүр унтраана. Эсрэг тохиолдолд турбо эвдрэх аюултай.
- **Хөдөлгөөний үед дугуй хагарах**
Дугуй хагарсан, гэмтсэн үед дараах нөхцөлүүд үүснэ. Жолооны хүрдийг сайтар бариад тоормосны дөрөөг зөөлөн гишгэж хурдаа хасна.
- Жолоодлого хүндрэлтэй болно.
- Автомашинаас хэвийн бус дуу чимээ, чичиргээ гарна.
- Автомашин хэвийн бус хазайна.
Дугуй хагарсан тохиолдолд авах арга хэмжээ (→Х.548)
- **Зам үерлэсэн үед**
Үертэй замаар гарах нь эрсдэлтэй. Энэ нь автомашинд дараах ноцтой гэмтэл учруулах аюултай:
- Хөдөлгүүр хүч алдаж унтрах
- Цахилгаан эд ангид богино холболт үүсэх
- Ус орсноос шалтгаалсан хөдөлгүүрийн гэмтэл үүсэх

Үертэй замаар гарсан, автомашин үерт автсан зэрэг үед өөрийн Lexus дилерт хандаж дараах зүйлсийг шалгуулна:

- Тоормосны ажиллагаа
- Хөдөлгүүр, хурдны хайрцаг, туслах хурдны хайрцаг, дифференциал зэргийн тос, шингэний хэмжээ, чанарын өөрчлөлт зэрэг
- Холхивч гүүшингийн холбооснууд (шалгах боломжтой холбооснууд) болон бусад татуурга, хөндлөвч, холбоос зэргийн тосолгооны байдал
- Радиатор бөглөрөх, хөргөлтийн сэнс ажиллагаагүй болох зэргээр хөдөлгүүрийн хөргөлтийн системийн хэвийн ажиллагаа алдагдсан эсэх
- **Автомашиныг зогсоолд байрлуулах үед**

Зогсоолын тоормос татаад арааг Р араанд буцаана. Эсрэг тохиолдолд автомашин гэнэт хөдлөх эсвэл хаазны дөрөөг санамсаргүй гишгэн огцом ухасхийх аюултай.

Огцом хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах (Хөдөлгөөн эхлэх удирдлага [DSC])

Дараах хэвийн бус үйлдэл хийгдсэн үед систем хөдөлгүүрийн хүчийг хязгаарладаг.

- Арааг R^{*}-д шилжүүлсэн.
- Урагш жолоодлогын D^{*} зэрэг араанаас Р эсвэл R араанд шилжүүлсэн.

Систем ажилласан үед анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гарна. Мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарсан үед анхааруулгын зааварчилгааг мөрдөнө.

* : Тухайн нөхцөлөөс хамаарч арааны байрлал өөрчлөгдөхгүй байж болно.

■ Хөдөлгөөн эхлэх удирдлага (DSC)

● Active TRC систем идэвхгүй үед (→Х.423) огцом хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах систем мөн салгагддаг. Огцом хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах систем идэвхэжсэн үед автомашиныг шавар, цаснаас гаргахад хүндрэлтэй болж болно. Энэ тохиолдолд Active TRC (→Х.423) системийг идэвхгүй болгож шавар цаснаас автомашин гаргах боломжтой.

Мөн огцом хөдөлгөөн эхлэхийг хязгаарлах удирдлага дараах нөхцөлүүдэд ажиллахгүй:

- Дөрвөн дугуй хөтлөх системийн товч “L4” байрлалд байгаа үед
- Төвийн дифференциал цоожлогч цоожлогдсон үед
- Multi-terrain Select* систем сонгогдсон үед

* : Тоноглогдсон загварт

Ачаа тээш, багааж

Ачаа тээвэрлэх, ачих, хадгалахтай холбоотой дараах анхааруулгыг мөрдөнө.



АЮУЛТАЙ

■ Тээшний хэсэгт ачиж тээвэрлэж болохгүй зүйлс

Дараах зүйлсийг тээшний хэсэгт тээвэрлэх нь галын аюултай:

- Дотроо бензинтэй сав
- Лаазтай аерозол

■ Ачаа тээшний анхааруулга

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд автомашины дөрөөтэй харьцахад саад учруулах, жолоочийн үзэгдэх орчныг хязгаарлах, ачсан эд зүйлс жолооч, зорчигчийг цохих зэргээр гэмтэлд хүргэх аюултай.

- Тээшний хэсгийн ачааг буулгах боломжтой болсон үедээ даруй буулгана.
- Тээшний хэсэгт суудлын түшлэгийн өндрөөс давуулан ачаа бараа давхарлан ачиж болохгүй.
- Арын суудлыг эвхсэн үед урт ачааг урд суудлын чанх ард ачихгүй.
- Зорчигч суух зориулалтгүй тул тээшний хэсэгт хүн суулгахыг хатуу хориглоно. Зорчигч зөвхөн суудал дээр сууж аюулгүйн бүс зүүнэ. Эсрэг тохиолдолд огцом тоормос, эргэлт, ослын үед амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.
- Ачааг дараах газруудад тавихыг хориглоно.
 - Жолоочийн хөлийн хажууд

▲ АЮУЛТАЙ

- Урд зорчигчийн эсвэл арын суудал дээр (эд зүйлс давхарлах үед)
- Тээшний хэсгийн эвхэгддэг хаалт дээр (тоноглогдсон загварт)
- Хянах самбар дээр
- Урд талд
- Таггүй хайрцаг, тавиур дээр

● Бүхээгийн зорчигчийн хэсэгт байгаа бүх эд зүйлсийг хөдөлгөөнгүй бэхэлнэ.

■ Ачаа ачих, жин хуваарилах


- Даац хэтрүүлэн ачиж болохгүй.
- Тэгш бус хуваарилж болохгүй.

Буруу ачих нь тоормос болон жолооны механизмыг гэмтээх улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

Дээврийн ачаа (тоноглогдсон үед)*

* : Автомашины загвараас хамаарч дээврийн ачаа өөр байдаг.

■ Дээврийн ачаа



A Туузан ачаа

B Ачааны хөндлөвч

▲ АЮУЛТАЙ

■ Ачаан дээр ачаа ачих үед

Туузан ачаан дээр ачаа ачих үед 2-с их Lexus-н оригинал эсвэл дүйцэх чанарын хөндлөвч ашиглана. Дараах анхааруулгыг мөрдөнө:

- Ачааны жинг урд ба хойд тэнхлэгт жигд хуваарилж ачна.
- Урт эсвэл өргөн ачаа ачих үед автомашины нийт урт өргөнөөс хэтрүүлэн ачихгүй. (→X.572)
- Хөдөлгөөн эхлэхийн өмнө ачааны бэхэлгээг шалгана.
- Ачаан дээр ачаа ачих нь автомашины хүндийн төвийг өндөр болгодог. Жолоодлого буруу хийвэл жолоодлогоо алдах, хөмрөх улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай тул өндөр хурдаар явах, огцом хөдөлгөөн эхлэх, огцом эргэлт хийх, огцом тоормос болон хөдөлгөөн хийхээс зайлсхийнэ.
- Хол зам туулах, донсолгоотой замаар явах эсвэл өндөр хурдтай явах үед ачааны бэхэлгээг тогтмол шалгана.
- Ачаандээр 100кг(220lb.)-схүндачаа ачихыгхориглоно. 2хөндлөвчинд ачааны жинг тэгш хуваарилна.

▲ АНХААР

■ Ачаан дээр ачаа бараа ачих үед (Дээврийн нээлхий эсвэл цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхийтэй загвар)

Дээврийн нээлхий эсвэл цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхийг гэмтээх, хортон суулгахаас сэргийлнэ.

Чиргүүл чирэх (чирэх дэгээтэй)

Энэхүү автомашин нь зорчигч, хүн тээвэрлэхэд зориулагдсан бөгөөд чиргүүл чирэх нь жолоодлого, тоормос, автомашины эдэлгээ болон шатахуун зарцуулалтад сөргөөр нөлөөлдөг. Тохирох тоноглолыг зөв ашиглах болон анхаарал болгоомжтой жолоодлогын дадал зуршлаас таны аюулгүй байдал, сэтгэл ханамж хамаарна. Чиргүүлийг бизнесийн зориулалтаар ашигласнаас шалтгаалсан эвдрэл нь Lexus үйлдвэрлэгчийн баталгаанд хамаарахгүй.

Чирэх дэгээ зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг та Lexus дилерт хандаж авна уу.

■ Дугуйны мэдээлэл

- Чиргүүл чирэх үед дугуйн даралтыг үйлдвэрлэгчийн зөвлөсөн хэмжээнээс 20.0 kPa (0.2 kgf/cm² эсвэл 3 psi) нэгжээр нэмнэ. (→X.581)
- Чиргүүлийн дугуйны хийн даралтыг чиргүүлийн бүх жин болон чиргүүлийн үйлдвэрлэгчийн зөвлөмжийг үндэслэн тохируулна.

■ Чиргүүлийн гэрэл

Чиргүүлийн эргэх дохионы гэрэл болон тоормосны гэрлийг чиргүүл холбох бүрд бүрэн ажиллагаатай байгаа эсэхийг шалгана. Автомашинтай цахилгаан утсаар шууд холбох нь цахилгаан системүүд болон гэрлүүдэд гэмтэл учруулах эрсдэлтэй.

■ Урьдчилсан аюулгүйн үзлэг

- Чиргүүлийн гарын жин автомашин дээр ирдэг тул чирэх дэгээнд ирж буй жин зөвшөөрөгдөх хэмжээнд байгааг шалгана. Мөн автомашин дээр ирж буй хүндийн жин зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг шалгана. (→X.198)
- Чиргүүл дээр ачаа сайтар бэхлэгдсэн эсэхийг шалгана.
- Хэрэв хажуугийн толинд ар тал сайн харагдахгүй байвал нэмэлт арыг харах толь суурилуулан ашиглана. Нэмэлт толины суурийг уртасгаж ар талын замын хөдөлгөөн сайн харагдахаар тохируулна.
- Чиргүүлийн гарын өндөрт тохиромжтой байдлаар чирэгч дэгээний өндрийг тохируулна.

■ Засвар үйлчилгээ

- Чиргүүл чирэх нь автомашинд хэвийн ашиглалтын үеэс илүү ачаалал өгөх тул чиргүүл чирч ашиглаж буй автомашиныг богино давтамжтайгаар засвар үйлчилгээнд хамруулах шаардлагатай.
- Чирэгч дэгээ, гар, холбооснуудыг 1000 км (600 миль) тутамд чангалж шалгах шаардлагатай.



АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ Чиргүүл чирэх анхааруулга

Бүх жингийн хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс давж болохгүй. (→X.198)

■ Осол, гэмтлээс сэргийлэх

Чиргүүл чирэх үед хурд баригч, динамик радарын хурд баригч ашиглаж болохгүй.

■ Чирэх үеийн хурд

Чиргүүлтэй автомашинд тавигдах замын хөдөлгөөний дүрмийн дагуух хурдны хязгаарыг дагаж мөрдөнө.

■ Уруу замаар уруудах үед

Хурдаа хасаад хүнд араанд шилжүүлнэ. Уруудах үед хүнд араанд огцом шилжүүлж болохгүй.

■ Тоормосны дөрөөний ажиллагаа

Тоормосны дөрөөг ойр ойр урт гишгэх эсвэл үргэлжлүүлэн гишгэж болохгүй.

Эсрэг тохиолдолд тоормос халах, ажиллагаа муудах аюултай.

Жингийн хязгаарлалт

Чиргүүл чирэхийн өмнө чирэх хүчин чадал, автомашины бүх жин, нэг тэнхлэг дээрх хамгийн их ачаалал, чиргүүлийн гар дээр дарах жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг нягтална. (→X.572)

Чиргүүлийн дэгээ, дэгээ тогтоогч

Lexus автомашинд Lexus-н чиргүүлийн дэгээ, дэгээ тогтоогч ашиглах нь зүйтэй. Мөн ижил төрлийн, адил чанартай дэгээ, дэгээ тогтоогч ашиглаж болно.

Арын гэрэл, улсын дугаарыг халхлах чирэх хэрэгсэл ашиглах үед дараах зүйлсэд анхаарна:

- Хялбар салгах, байрлалыг солих боломжтой чирэх хэрэгсэл ашиглаж болохгүй.
- Ашиглаагүй үед чирэх хэрэгслийг салгана.

Чиргүүлийн гэрэл холбох (тоноглогдсон загварт)

Автомашины арын чиргүүл

холбох цахилгаан утас ашиглана.

Буруу суурилуулах нь гэрлийг гэмтээх аюултай тул чиргүүлийн гэрэл угсрах үедээ Lexus дилерээс зөвлөгөө авна уу. Мөн чиргүүлийн гэрэлтэй холбоотой дүрэм журмыг шалгана.




АНХААР

■ Чиргүүлийн гэрлийг шууд холбохыг хориглоно.

Чиргүүлийн гэрлийг шууд холбох нь автомашины цахилгаан системийг гэмтээх, доголдол үүсгэх аюултай.

Чиргүүл дээр ачаа ачих үед анхаарах зүйлс

■ Чиргүүлийн бүх жин ба чиргүүлийн гар дээр дарах жингийн зөвшөөрөгдөх хэмжээ



A Чиргүүлийн бүх жин

Чиргүүлийн жин болон ачааны жингийн нийлбэр автомашины чирэх хүчин чадлаас давж болохгүй. Автомашины хүчин чадлаас чиргүүлийн бүх жин давах нь аюултай. (→X.572) Чиргүүл чирэх үед чиргүүлийн савлалтаас сэргийлэх холболт эсвэл тогтворжуулагч ашиглана (савлалтаас сэргийлэх


төхөөрөмж).

Чиргүүлийн жин 2000 кг (4409 lb)-с их үед чиргүүлийн савлалтаас сэргийлэх холболт эсвэл тогтворжуулагч ашиглана (савлалтаас сэргийлэх төхөөрөмж).

В Чиргүүлийн гарын жингийн зөвшөөрөгдөх хэмжээ

Ачааг чиргүүлийн гар дээр 25 кг (55.1 lb)-с дээш эсвэл автомашины чирэх хүчин чадлын 4 хувьтай тэнцэх жингээр дарах байдлаар ачна. Мөн чиргүүлийн гарын жингийн зөвшөөрөгдөх хэмжээ нь заасан хэмжээнээс давахыг хориглоно. (→X.572)

■ Мэдээллийн пайз (үйлдвэрлэгчийн пайз)



А Автомашины бүх жин

Жолооч, зорчигч, тээш, чирэх дэгээ, чиргүүлийн нийт жин автомашины бүх жингээс 100 кг (220.5 lb.-)с хэтэрч болохгүй. Бүх жингээс хэтрүүлэх нь аюултай.

В Арын тэнхлэгийн даацын хязгаар

Арын тэнхлэг дээр ирж буй жин тэнхлэгт ногдох даацын хязгаараас 15%-с хэтэрч болохгүй. Даацын хязгаараас хэтрүүлэх нь аюултай.

Автомашины чирэх хүчин чадлыг далайн түвшинд буюу нам дор газар хийсэн туршилтын үр дүнд үндэслэн гаргасан болно. Өндөрлөг газарт хөдөлгүүрийн хүч буурах ба чирэх хүчин чадал багасдаг.

! АЮУЛТАЙ

■ Автомашины бүх жин эсвэл тэнхлэгийн даацын хязгаараас бодит жин хэтэрсэн үед

Хот суурин газрын зам дээр чиргүүлтэй автомашины хурдны дээд хязгаар, хурдны хязгаар тогтоогоогүй бусад зам дээр 100км/ц (62 миль/ц)-с хэтрүүлж болохгүй.

Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осол аваар гарах эрсдэлтэй.

! АНХААР


■ Арын гупер хөнгөн цагаан хүчитгэх материалтай үед

Чирэгч дэгээний төмөр эд анги тухайн хэсэгтэй шууд харьцахаас сэргийлнэ.


Төмөр ба хөнгөн цагаан нийлсэн үед зэврэлттэй төстэй урвал явагддаг ба эд ангийн бат бөх байдлыг сулруулах, гэмтээх аюултай. Төмөр чирэгч дэгээ угсрах үед зэврэлтээс сэргийлэгч ашиглана.

Таг авах

- 1 Хавчаар салгана.




- 2 Тагны доод талыг нааш татаад 2 хумсыг мултална.



- 3 Тагийг нааш татан салгана.


Буцааж угсрах үед урвуу дарааллаар хийж гүйцэтгэнэ.




■ Таг буцаан суурилуулах

Чирэх дэгээ угсарсны дараа тагны гадна хүрээг угсрах боломжтой.

- 1 **A** тагаас гадна хүрээг салгана.



- 2 **A** гадна хүрээний 4 хумсыг хийнэ.



Чиргүүл чирэх үеийн зааварчилгаа

Чиргүүл чирэх үед автомашины жолоодлого өөр болдог. Осол аваар, амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах бэртэл гэмтлээс сэргийлж дараах зүйлсийг анхаарна:

■ Чиргүүл болон гэрлийн холболтыг шалгах

Хөдөлгөөн эхлэхийн өмнө мөн тодорхой зай туулсны дараа чиргүүл болон гэрлийн холболтыг дахин шалгана.

■ Чиргүүл чирэх дадлага хийх

- Хоосон эсвэл ачаалал багатай зам дээр чиргүүлтэй эргэлт хийх, зогсох, ухрах дадлага хийнэ.
- Чиргүүлтэй ухрах үед жолооны хүрдний өөрийн биед ойр хэсгээс барих ба чиргүүлийг зүүн эргүүлэх үед жолооны хүрдийг цагийн

зүүний дагуу, баруун эргүүлэх эсрэг эргүүлнэ. Буруу жолоодлогоос сэргийлж жолоог бага багаар эргүүлэх ба аливаа эрсдэл, ослоос сэргийлж ухрах дадлага хийх үедээ бусдын тусламж авах хэрэгтэй.

■ Автомашин хоорондын зайг нэмэгдүүлэх

10км/ц (6 миль/ц) хурдтай үед автомашин болон чиргүүлийн нийт урттай тэнцүү хэмжээний эсвэл түүнээс илүү хэмжээний автомашин хоорондын зайг урд талын автомашинаас барина. Хөндлөн шарвалт үүсгэдэг тул огцом тоормос хийхээс зайлсхийнэ. Эсрэг тохиолдолд шарвалт үүсэж жолоодлого хяналтаас гарч болно. Ялангуяа нойтон зам дээр өндөр анхаарал болгоомжтой жолоодно уу.

■ Огцом хурд нэмэх, жолоо мушгих, эргэлт хийх

Огцом өнцгөөр эргэлт хийх үед чиргүүл автомашин хоёр хайчилж шүргэлцэх, мөргөлдөх эрсдэлтэй. Эргэлтийн өмнө хурдаа сайтар хасах ба огцом тоормос хийлгүй алгуур зөөлөн эргэнэ.

■ Эргэлт хийх үед

Эргэлтийн үед чиргүүлийн дугуйны мөр автомашины дугуйнаас дотуур тойргоор эргэдэг. Чиргүүлийн дугуйн явах замыг хангалттай тооцож ердийн жолоодлого хийх үеэс илүү холуур эргэлт хийнэ.

■ Тэнцвэртэй холбоотой анхаарах зүйлс

Автомашины жолоодлогод тэгш бус гадаргуутай замын донсолгоо, хөндлөнгийн хүчтэй салхи нөлөөлдөг. Мөн зөрж өнгөрч буй автобус, том оврын ачааны машины салхинд автомашин цохигдож болох тул том оврын автомашинтай зөрөх тухай бүрд ар талаа шалгах хэрэгтэй. Автомашин дээрх байдлаар нөлөөнд орж тэнцвэр алдагдсан үед даруй тоормосны дөрөөг зөөлөн гишгэж аажмаар хурдаа хасах ба тоормослох үедээ жолооны хүрдийг тэгш барина.

■ Гүйцэж түрүүлэх үед

Эгнээ байр солих үйлдэл хийж эхлэхийн өмнө автомашин болон чиргүүлийн нийт уртыг тооцохын зэрэгцээ автомашин хоорондын зай хангалттай байгаа эсэхийг нягтална.

■ Хурдны хайрцгийн мэдээлэл

Хөдөлгүүрийн тоормос хийх үед тоормосны идэвхийг тооцож D араа сонгож болохгүй.

M байрлал сонгосон үед хурдны хайрцгийн арааны 7-с хэтрэхгүй байна. (→X.211)

■ Хөдөлгүүр хэт халсан үед

Ачаатай чиргүүлийг 30°C (85°F)-с дээш халуун үед огцом өгсүүр замаар удаан чирэх нь хөдөлгүүр хэт халахад хүргэнэ. Хөргөлтийн шингэний температурын зүү хөдөлгүүр хэт халсныг заасан үед эйр кондишноо даруй унтрааж замаас гарч аюулгүй

газарт зогсоно. (→X.566)

■ Зогсоолд байрлуулах үед

Автомашин болон чиргүүлийн дугуйнд тус бүр ивүүр хийх ба зогсоолын тоормосыг гүйцэд татаад араар Р араанд хийнэ.

■ Чиргүүл чирэх үед

Хэвийн ажиллагаа алдагдах тул дараах системүүдийг унтраана.

- LTA систем (→X.256)
- LDA систем (→X.264)
- Динамик радарын хурд барих систем (→X.281)
- Хурд баригч (→X.292)
- BSM систем (→X.300)
- Lexus parking assist-мэдрэгч (→X.316)
- RCTA функц (→X.322)
- RCD функц* (→X.327)
- PKSB тоормос* (→X.330)

*: Тоноглогдсон загварт

■ Явах эд анги шинэ үед

Шинэ хүч дамжуулах ангитай автомашинд эхний 800 км (500 миль)-т чиргүүл чирэхгүй байх нь зүйтэй.

■ Чиргүүл савласан үед

Автомашин болон чиргүүлийн жолоодлого, тэнцвэрт нэг бус хүчин зүйл (хөндлөнгийн салхи, зөрж өнгөрч буй автомашин, тэгш бус гадаргуутай зам г.м.) нөлөөлөх магадлалтай.

- Чиргүүл савласан үед:
 - Жолооны хүрдийг шулуун чиглэлд хөдөлгөөнгүй атгана
 - Жолоо эргүүлж савлагааг зогсоох арга хэмжээ авч болохгүй
 - Чиргүүл савласан даруйд хурд хасах зорилгоор хаазны дөрөөг аажмаар суллана.
- Хурд нэмэхийг хориглоно. Тоормос гишгэхийг хориглоно.

Чиргүүл савласан үед жолооны хүрд, тоормосыг зөвхөн шаардагдах хэмжээнд ашигласан үед автомашин болон чиргүүлийн тэнцвэр даруй сэр-

гэнэ (чиргүүл нь савлагаанаас сэргийлэх холболттой үед холболт савлагааг зогсооход дэмжлэг үзүүлнэ).

● Савлагаа зогссоны дараа:

- Аюулгүй газар автомашиныг зогсоон бүх зорчигчийг буулгана
- Автомашин болон чиргүүлийн дугуйг шалгана
- Чиргүүлийн ачааг шалгана

Чиргүүлийн ачаа хөдлөөгүй, бэхэлгээ хэвийн эсэхийг шалгана.

- Чиргүүлийн гарын дарах жинг боломжтой тохиолдолд шалгана.
- Ачсан ачаа тээшийг шалгана.

Зорчигчид суусны дараа автомашины даац хэтрээгүй эсэхийг шалгана.

Дээрх зүйлсийг шалгах үед аливаа доголдол илрээгүй тохиолдолд чиргүүл савлах үеийн хурд нь таны автомашин болон чиргүүлийн тухайн нөхцөлд тохирох хурдны дээд хязгаар гэж үзнэ. Энэ нөхцөлд өмнөх савлах үеийн хурдад хүргэж болохгүй. Хурд ихсэх тусам чиргүүлийн тэнцвэр алдагддагийг анхаарна.

Асаах товч

Электрон түлхүүр биедээ авсан үед дараах дарааллаар хөдөлгүүр асаах, асаах товчны горим солих боломжтой.

Хөдөлгүүр асаах

- 1 Зогсоолын тоормосны товчийг татаад тоормос залгагдсан эсэхийг нягтална. (→X.213)
- 2 Арааны хөшүүрэг Р-д байгаа эсэхийг шалгана.
- 3 Тоормосны дөрөөг гүйцэд гишгэнэ.

Мэдээллийн дэлгэц дээр  тэмдэг болон анхааруулга гарна.

Тэмдэг, анхааруулга гараагүй үед хөдөлгүүр асахгүй.

- 4 Асаах товчийг богино чанга дарна.


Асаах товчийг нэг удаа чанга дараад авахад хангалттай ба удаан дарах шаардлагагүй.

Хөдөлгүүр асах хүртэл эсвэл хөдөлгүүр асахгүй бол 30 секунд стартер ажиллана.

Хөдөлгүүр асах хүртэл тоормосны дөрөөг гишгэнэ.

Асаах товчны бүх горимоос

хөдөлгүүр асаах боломжтой.



■ Асаах товчны гэрэл

Тухайн нөхцөлөөс хамаарч асаах товчны гэрэл дараах байдлаар асна.

- Жолооч эсвэл урд зорчигчийн хаалга нээгдсэн үед асаах товчны гэрэл асна.
- Электрон түлхүүртэй үед асаах товчны OFF горимд тоормосны дөрөө гишгэх үед асаах товч анивчина.
- Асаах товчны ACC эсвэл ON горимд асаах товч асна.
- Асаах товчны ACC эсвэл ON горимоос OFF-д шилжүүлсэн үед асаах товчны гэрэл тодорхой хугацаанд үргэлжлэн асаад унтарна.

■ Хөдөлгүүр асахгүй үед

- Иммобилайзер системийг идэвхгүй болгоогүй байж болно. (→X.79) Та өөрийн Lexus дилерт хандана уу.
- Систем асахтай холбоотой анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гарсан үед зааварчилгааг дагана
- Хаалгыг механик түлхүүрээр тайлсан үед хөдөлгүүрийг smart entry & start системээр асаах боломжгүй. X.560-с хөдөлгүүр асаах тухай харна уу. Нөгөөтээгүүр автомашинд электрон түлхүүртэй ороод хаалга түгжсэн (→X.121) үед хөдөлгүүр асаах боломжтой.

■ Электрон түлхүүрийн зайны цэнэг суух

Smart entry & start системээр хөдөлгүүр асаах боломжгүй. Дэлгэрэнгүйг X.561-с харна уу.

■ Электрон түлхүүрийн зайны цэнэг суух

→X.114

■ Ажиллагаанд нөлөөлөх нөхцөл

→X.144


■ Entry функцийн анхааруулга

→X.145

■ Жолооны хүрд түгжих функц (тоноглогдсон загварт)

● Асаах товчийг OFF-д шилжүүлэн хаалга нээгдэж хаагдсаны дараа жолооны хүрд түгжих функц хүрдийг түгждэг. Асаах товчтой дахин харьцах үед жолооны хүрдний түгжээ автоматаар тайлагдана.

● Жолооны хүрдний түгжээ тайлагдахгүй үед мэдээллийн дэлгэц дээр “Push ENGINE Switch while Turning The Steering Wheel in Either Direction” мэдээлэл гарна. Арааны хөшүүрэг Р-д байгаа эсэхийг шалгана. Жолооны хүрдийг хоёр тийш эргүүлэнгээ асаах товчийг богино дарна.



● Жолооны хүрд түгжих моторын хэт халалтаас сэргийлж хөдөлгүүрийг богино хугацаанд олон удаа асааж унтраах үед моторын ажиллагаа түр хугацаанд салгагдана. Энэ үед хэсэг хугацаанд хөдөлгүүрийг асаалгүй хүлээнэ. Моторын ажиллагаа 10 секундний дараа дахин сэргэнэ.

■ Мэдээллийн дэлгэц дээр “Smart Entry & Start System Malfunction See Owner’s Manual” анхааруулга гарсан үед

Системд доголдол үүссэн байж болзошгүй. Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Электрон түлхүүрийн зай

→X.519

■ Асаах товчны ажиллагаа

● Асаах товчийг богино, чанга дараагүй үед асаах товчны горим солигдохгүй байж болно.

● Асаах товчийг OFF болгосон даруй асаах оролдлого хийвэл зарим тохиолдолд хөдөлгүүр асахгүй. Асаах товчийг OFF болгосны дараа хэдэн секундний дараа дахин асаана.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Smart entry & start системийг өөрчлөх боломжтой тохиргоогоор идэвхгүй болгосон үед дэлгэрэнгүй мэдээллийг X.560-с харна уу.

! АЮУЛТАЙ

■ Хөдөлгүүр асаах үед

Жолоочийн суудалд суусан үедээ хөдөлгүүр асаана. Асаах үед ямар ч нөхцөлд хаазны дөрөө гишгэхийг хориглоно. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ Хөдөлгүүр асаах үед (жолооны хүрд түгжигчтэй загвар)

Жолоодлогын үед хөдөлгүүр унтарсан тохиолдолд автомашин аюулгүй газарт бүрэн зогсох хүртэл хаалга түгжих эсвэл нээж болохгүй. Жолооны хүрд түгжигч ажиллаж осол хүргэх улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

! АНХААР

■ Хөдөлгүүр асаах үед

Хөдөлгүүрийн асалт муудсан, үе үе унтраад байгаа тохиолдолд Lexus дилертээ хандана.

**АНХААР****■ Асаах товчны доголдлыг илэрхийлэх нөхцөлүүд**

Асаах товч дарах үед бага зэрэг хатуу санагдах зэргээр хэвийн үетэй харьцуулахад өөр санагдвал системд доголдол үүссэн байж болзошгүй. Та нэн даруй өөрийн Lexus дилерт хандана уу.

Хөдөлгүүр унтраах

- 1 Автомашиныг зогсооно.
- 2 Зогсоолын тоормос гар ажиллагааны горимд байгаа үед зогсоолын тоормос татна. (→X.213)

Зогсоолын тоормосны индикатор ассаныг нягтална.

- 3 Арааг Р-д буцаана. (→X.208)

Арааг Р-д буцаасны дараа араа суллах товчийг дарж болохгүй.

- 4 Асаах товчийг дарна.

Хөдөлгүүрийн ажиллагаа зогсож хянах самбарын заалтууд унтарна.

- 5 Тоормосны дөрөөг суллаж хянах самбар дээр “ACCESSORY” эсвэл “POWER ON” эсвэл ON гараагүй эсэхийг нягтална.

**АЮУЛТАЙ****■ Онцгой нөхцөлд хөдөлгүүр унтраах**


● Жолоодлогын үед онцгой, аваарын нөхцөл үүсэж хөдөлгүүрийг унтраах шаардлагатай үед асаах товчийг 2-с дээш секунд эсвэл 3-с олон удаа хурдан дарна. (→X.524) Зөвхөн онцгой нөхцөл үүссэн үед асаах товч дарна. Хөдөлгүүрийг унтраах нь жолоо болон тоормосны удирдлага алдагдахад хүргэхгүй боловч жолооны механизмын цахилгаан хүчлүүрийн ажиллагаа доголдоно. Ингэснээр жолоо хатуу болох тул боломжтой үедээ нэн даруй замаас гарч аюулгүй газарт зогсоно.

● Автомашины хөдөлгөөний үед асаах товчтой харьцсан тохиолдолд мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах ба анхааруулах дуут дохио дуугарна.

● Хөдөлгөөний үед унтраасан хөдөлгүүрийг дахин асаах үед арааг N байрлалд оруулсны дараа асаах товчийг дарна.

Асаах товчны горим солих

Асаах товчны горимыг тоормосны дөрөө гишгээгүй үедээ асаах товчийг даран солих боломжтой. (Товч дарах тухай бүрд горим солигдоно.)



A “ACCESSORY”

B “POWER ON”

1 OFF^{*1}

Ослын дохионы гэрэл ашиглах боломжтой.

Мэдээллийн дэлгэц асахгүй.

2 ACC^{*2}

Аудио хөгжим зэрэг зарим электрон төхөөрөмж ашиглах боломжтой. Мэдээллийн дэлгэц дээр “ACCESSORY” тэмдэг асна.

3 ON

Бүх электрон төхөөрөмж ашиглах боломжтой.

Мэдээллийн дэлгэц дээр “POWER ON” тэмдэг асна.

^{*1}: Хөдөлгүүр унтраах үед P-с бусад араатай эсвэл арааны түгжээ суллах товч дарсан нөхцөлд асаах товч OFF-д шилжихгүй ба ON горимд үлдэнэ.

^{*2}: Өөрчлөх боломжтой тохиргоогоор ACC горимыг идэвхжүүлэх/цуцлах боломжтой. (→X.591)

Өөрчлөх боломжтой цэсээр ACC горимыг идэвхгүй болгосон үед

● Асаах товч унтраастай үед мультимедиа дэлгэцийг аккумуляторын цэнэг хэмнэх функц ажиллаж эхлэх хүртэл ашиглах боломжтой.

● Аюулгүй буухад туслах систем ажиллаж байгаа үед дохио дуугарч дуут зааварчилгаа өгнө.

■ Автоматаар унтраах функц

● ACC горим эсвэл ON (хөдөлгүүр унтраастай) горимд P араатай эсвэл араа түгжих товчийг дараагүй нөхцөлд 20 минутын дараа асаах товч OFF горимд шилжинэ.

● Аккумуляторын цэнэг бага нөхцөлд ACC горим эсвэл ON (хөдөлгүүр унтраастай) горимд P араатай эсвэл араа түгжих товчийг дараагүй нөхцөлд мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарч дохио дуугарах ба асаах товч OFF горимд автоматаар шилжинэ.

Нөгөөтээгүүр энэ нь аккумуляторын цэнэг суухаас бүрэн сэргийлэх боломжгүй тул хөдөлгүүр асаагүй үед ACC, ON горимд удаан орхиж болохгүй.



АНХААР

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

● Хөдөлгүүр асаагүй үед асаах товчийг ACC, ON горимд удаан байлгаж болохгүй.

● Мэдээллийн дэлгэц дээр хэрэв “ACCESSORY” эсвэл “POWER ON” гарвал асаах товч OFF горимд шилжээгүйг илтгэнэ. Асаах товчийг OFF горимд шилжүүлээд автомашинаас гарна.

P-с бусад араанд хөдөлгүүр унтраах

P-с бусад араанд эсвэл арааны

түгжээ суллах товч даран хөдөлгүүр унтраах үед асаах товч OFF горимд шилжихгүй. Дараах дарааллаар OFF-д шилжүүлнэ:

- 1 Зогсоолын тоормос татна.
- 2 Арааг Р-д буцаана.

Арааг Р-д буцаасны дараа араа суллах товчийг дарж болохгүй.

- 3 Мэдээллийн дэлгэц дээр “POWER ON” гарч байгааг нягтлаад асаах товч дарна.
- 4 Мэдээллийн дэлгэц дээр “ACCESSORY” эсвэл “POWER ON” унтарсныг нягтална.



АНХААР

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Р-с бусад араанд эсвэл арааны түгжээ тайлах товч даран хөдөлгүүр унтрааж болохгүй. Бусад араанд эсвэл арааны түгжээ тайлах товч даран хөдөлгүүр унтраасан үед асаах товч OFF биш ACC горимд шилжинэ. Автомашиныг ACC горимд удаан орхисон үед аккумуляторын цэнэг сууна.

Автомат хурдны хайрцаг

Өөрийн зорилго, тухайн нөхцөлд нийцүүлэн арааны байрлал сонгоно.

Арааны байрлалын зориулалт ба функц

Арааны байрлал	Зориулалт ба функц
P	Зогсоолд байрлуулах/хөдөлгүүр асаах
R	Ухрах
N	Сул араа (Хүч дамжихгүй араа)
D	Хэвийн жолоодлого* ¹
M	М жолоодлогын горим* ² (→X.211)

*¹: Шатахуун зарцуулалтыг сайжруулах, дуу чимээг бууруулах үүднээс хэвийн жолоодлогын үед D арааны байрлал сонгоно.

*²: М горим сонгосон үед арааны хөшүүрэг эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргээр (тоноглогдсон загварт) хөдөлгүүрийн тоормос хийнэ.

■ Уруу замаар явах үед

Уруу зам дээр хөдөлгүүрийн тоормос хийхийн тулд автоматаар хүнд араанд шилжих тохиолдол гардаг. Доод араанд шилжсэнээр хөдөлгүүрийн хурд нэмэгдэнэ.

■ Хурдны хайрцаг хамгаалах

- Автомашин шавар, цасанд суун дугуй удаан хий эргэсэн эсвэл жолоодлогын үед хаазны дөрөөг олон удаа гишгээд болих

тохиолдолд автомат хурдны хайрцаг хэт халж гэмтэх аюултай. Автомат хурдны хайрцгийн гэмтлээс сэргийлэх үүднээс систем түр хугацаанд араг солихгүй түгждэг.

Автомат хурдны хайрцгийн хэм бууж хэвийн хэмжээнд хүрэх үед арааны түгжээ салгагдаж хэвийн ажиллагаанд шилжинэ.

- Автомат хурдны хайрцгийн шингэн халсан үед мэдээллийн дэлгэц дээр “Transmission Oil Temp. High Stop in a safe place and See owner’s manual” анхааруулга гарна. Автомашиныг даруй аюулгүй газар зогсоон араг Р-д шилжүүлээд анхааруулга унтрах хүртэл хүлээнэ. Анхааруулга унтарсны дараа үргэлжлүүлэн жолоодож болно. Унтрахгүй үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ Динамик радарын хурд баригч эсвэл хурд баригч идэвхжүүлэн жолоодох үед

D араатай (→X.407) жолоодох үед хөдөлгүүрийн тоормос идэвхжүүлэх зорилгоор Sport, SPORT S эсвэл SPORT S+ горимд шилжүүлсэн ч динамик радарын хурд баригч эсвэл хурд баригч цуцлагдахгүй тул хөдөлгүүрийн тоормос идэвхжихгүй.

*: Тоноглогдсон загварт

■ Огцом хөдөлгөөн эхлэхээс сэргийлэх (Хөдөлгөөн эхлэх удирдлага)

→X.194

■ AI-SHIFT

AI-SHIFT нь жолоочийн жолоодлого болон хөдөлгөөний нөхцөлд тааруулан тохирох араг сонгодог. AI-SHIFT нь арааны хөшүүрэг D байрлалд автоматаар ажилладаг. (Арааны хөшүүргийг M байрлалд шилжүүлэх үед функц салгагдана.)


! АЮУЛТАЙ

■ Хальтиргаатай замаар явах үед

Огцом хурд нэмэх, араа шилжүүлж болохгүй.

Хөдөлгүүрийн тоормосны хүч гэнэт өөрчлөгдөх нь автомашин шарвах, шидэгдэх, улмаар осолд хүргэх аюултай.

Арааны хөшүүрэг шилжүүлэх



Асаах товчны ON горимд

тоормосны дөрөө гишгэнгээ* араа чөлөөлөх товч дарж хөшүүргийг сэлгэнэ



Араа чөлөөлөх товч дарангаа арааны хөшүүргийг сэлгэнэ.



Арааны хөшүүргийг

хэвийн байдлаар шилжүүлнэ.

Автомашин бүрэн зогссоны дараа арааны хөшүүргийг Р болон D байрлалын хооронд шилжүүлнэ.

*: Арааг Р-с шилжүүлэх үед тоормосны дөрөөг гишгээд араа чөлөөлөх товч дарж сэлгэнэ. Араа чөлөөлөх товчийг эхлээд дарсан үед арааны хөшүүргийн түгжээ чөлөөлөгдөхгүй.

■ Араа түгжих систем

Араа түгжих систем нь хөдөлгөөн эхлэх үеийн арааны хөшүүргийн буруу ажиллагаанаас сэргийлдэг. Арааны хөшүүргийг зөвхөн асаах товчны ON горимд тоормосны дөрөөг гишгэсэн үед араа чөлөөлөх товч дарж Р байрлалаас өөр байрлалд шилжүүлэх боломжтой.


■ Арааны хөшүүрэг Р байрлалаас шилжихгүй үед

Нэн тэргүүнд тоормосны дөрөө гишгэсэн эсэхийг нягтална. Тоормосны дөрөө гишгэсэн, араа чөлөөлөх товч үед арааны хөшүүргийг шилжүүлэх боломжгүй байвал араа түгжих системд доголдол үүссэн байх магадлалтай. Та өөрийн Lexus дилерт даруй хандаж автомашинаа оношлуулна уу. Онцгой нөхцөлд дараах аргаар арааны хөшүүрэг шилжиж байгаа эсэхийг шалгах боломжтой.


Арааны түгжээ тайлах:

- 1 Зогсоолын тоормос татна.
- 2 Асаах товчийг off горимд унтраана.
- 3 Тоормосны дөрөөг гишгэнэ.
- 4 Хасах толгойтой халив эсвэл түүнтэй адил багажаар тагийг авна.
Таганд хортон суулгах, гэмтээхээс

сэргийлж халивын үзүүр даавуу жийрэглэнэ.



- 5 Арааны түгжээ тайлах товчийг дарангаа араа чөлөөлөх товчийг дарна.
2 товчийг зэрэг дарах үед араа шилжих боломжтой.



⚠ АЮУЛТАЙ

■ Арааны түгжээ тайлах үед осол аваараас сэргийлэх

Арааны түгжээ тайлах товч дарахаас өмнө зогсоолын тоормосыг татаж тоормосны дөрөө гишгэнэ. Арааны түгжээ тайлах товч дарж арааг Р-с шилжүүлэх үед санамсаргүй тоормосны дөрөөний оронд хааз гишгэвэл автомашин огцом ухасхийж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осол үүсгэх аюултай.

Жолоодлогын горим сонгох

■ Жолоодлогын горим


→Х.407

■ 2-р араагаар хөдөлгөөн эхлэх горим (тоноглогдсон загварт)

Тус горимыг цастай зэрэг хальтиргаатай замд хөдөлгөөн эхлэхэд ашиглана.

2-р араагаар хөдөлгөөн эхлэх горимын товч дарна.

2-р араагаар хөдөлгөөн эхлэх горимын товч дахин дарж цуцална.




■ 2-р араагаар хөдөлгөөн эхлэх горим автоматаар цуцлагдах

2-р араагаар хөдөлгөөн эхлэх горим нь хөдөлгүүр унтарсны дараа автоматаар цуцлагдана.

D горимд араа сонгох

D араатай үед арааг түр өөрчлөн жолоодох үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн “-” эсвэл “+” талыг дарна.

Араа солих нь шаардлагагүй хөнгөн араанд шилжихээс сэргийлж хөнгөн арааг хязгаарлаж хөдөлгүүрийн тоормос гаргадаг.



1 Хөнгөн араанд шилжүүлэх

2 Хүнд араанд шилжүүлэх

Хянах самбар дээр D1-с D10 хүртэлх арааны шатлалыг харуулна.

D байрлалд буцах үед жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн “+” товчийг доош удаан дарна.

■ Араа солих функц

- Хурд нэмэх, хөдөлгүүрийн тоормос хийх 10 шатлалт араа сонгоно.
- Доод араанууд нь дээд араануудаас илүү хүчтэй хурд нэмэх, хөдөлгүүрийн тоормос хийх хүчтэй ба хөдөлгүүрийн эргэлт мөн нэмэгдэнэ.

■ D арааны байрлалд арааны шатлалт автоматаар цуцлагдах

Дараах нөхцөлд цуцлагдана:

- Автомашин зогссон
- Хаазны дөрөөг тодорхой хугацаанаас удаан гишгэсэн үед
- Арааг D-с өөр байрлалд сэлгэсэн
- Жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийн “+” товчийг доош удаан дарсан


■ Хүнд араанд шилжихийг хязгаарлах анхааруулах дуут дохио

Аюулгүй байдал, жолоодлогын гүйцэтгэлийг хангах үүднээс зарим нөхцөлд хүнд араанд шилжих нь хязгаарлагдаж болно. Зарим тохиолдолд жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг сэлгэсэн ч хүнд араанд шилжихгүй байж болно. (Дуут

дохио 2 удаа дуугарна.)

М горимд араа сонгох

Арааны хөшүүргийг М байрлалд сэлгэж М горимыг сонгоно. Арааны хөшүүрэг эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг хөдөлгөн арааг сонгоно.



1 Хөнгөн араанд шилжүүлэх

2 Хүнд араанд шилжүүлэх

Хөшүүргийг ажиллуулах бүр араа нэг байрлалаар өөрчлөгдөнө. Тухайн сонгосон M1-с M10 араа дэлгэц дээр гарна.

Тус горим сонгогдсон үед арааны хөшүүрэг эсвэл жолооны хүрдний арааны нэмэлт хөшүүргийг ажиллуулаагүй үед араа солигдохгүй.

Нөгөөтээгүүр М байрлал сонгогдсон ч дараах нөхцөлүүдэд араа автоматаар шилжинэ:

- Автомашины хурд буурах үед (зөвхөн хүнд араанд).
- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм бага эсвэл автомат хурдны хайрцгийн шингэний хэм хэт бага, хэт өндөр үед хөдөлгүүр болон хурдны хайрцгийг хамгаалах үүднээс эсвэл бусад шалтгаантай үед.

Мөн автомашины хурд бага үед хөнгөн арааг сонгосон ч араа шилжихгүй.

■ Хүнд араанд шилжихийг хязгаарлах анхааруулах дохио

Аюулгүй байдал, жолоодлогын гүйцэтгэлийг хангах үүднээс зарим тохиолдолд хүнд араанд шилжих нь хязгаарлагдаж болно. Зарим үед хөшүүргийг сэлгэсэн ч хүнд араанд шилжихгүй байж болно. (Дуут дохио 2 удаа дуугарна.)

■ Хөшүүргийг м байрлалд сэлгэсэн ч “М” индикатор асахгүй үед

Автомат хурдны хайрцгийн системд доголдол үүссэн байж болзошгүй. Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

“TOW HAUL” товч (тоноглогдсон загварт)


Чиргүүл болон хүнд ачаа чирэх үед “REMOLQUE” горимыг сонгоно. “REMOLQUE” горимыг идэвхжүүлэх үед чиргүүл чирэхэд тохиромжтой байдлаар хөдөлгүүр, хурдны хайрцаг, жолооны хүрдний ажиллагаа өөрчлөгдөнө.

“REMOLQUE” горимыг ашиглах

үед “TOW HAUL” товчийг дарна.

“TOW HAUL” индикатор асна.

Товчийг дахин дарж тус горимыг цуцална.



■ “REMOLQUE” горим автоматаар цуцлагдах


“REMOLQUE” горим дараах нөхцөлүүдэд цуцлагдана:

- Урд дугуй хөтлөх удирдлагыг “L4” горимд шилжүүлсэн
- Жолоодлогын горим сонгосон эсвэл Multi-terrain Select системийг (тоноглогдсон загварт) идэвхжүүлсэн

Эргэх дохионы хөшүүрэг

Зааварчилгаа

Эргэх дохионы хөшүүргийг жолооч дараах үйлдлээ илэрхийлэхэд ашиглаж болно:



- 1 Баруун гар тийш эргэх
- 2 Баруун гар тийш эгнээ солих (хөшүүргийг хагас түлхээд суллана)
- Баруун эргэх дохионы гэрэл 3 удаа анивчиж асна.
- 3 Зүүн гар тийш эгнээ солих (хөшүүргийг хагас түлхээд суллана)
- Зүүн эргэх дохионы гэрэл 3 удаа анивчиж асна.
- 4 Зүүн гар тийш эргэх

■ Дохионы гэрэл ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Индикатор хэвийн үеэс илүү түргэн анивчих

Lexus дилер дээрээ оношлуулна уу.


Зогсоолын тоормос

Зогсоолын тоормосыг автоматаар эсвэл гар аргаар залгах, салгах боломжтой. Автомат горимд арааны хөшүүргийн ажиллагаанаас хамаарч зогсоолын тоормос автоматаар ажиллана. Мөн автомат горимд гар аргаар зогсоолын тоормосыг салгаж болно.

Зааварчилгаа

■ Гар аргаар ажиллуулах горим ашиглах

Зогсоолын тоормосыг гар аргаар залгах, салгах боломжтой.



A Зогсоолын тоормосны индикатор

1 Товчийг татан тоормос залгана.

Зогсоолын тоормос болон зогсоолын тоормосны товчны индикатор асна.

Жолоодлогын үед онцгой нөхцөл байдал үүсэж зогсоолын тоормос татах шаардлагатай тохиолдолд товчийг татаад барина.

2 Товчийг доош дарж зогсоолын тоормосыг салгана.

- Тоормос гишгэнгээ зогсоолын тоормосны товчийг ажиллуулна
- Зогсоолын тоормос автоматаар салгах функц ашиглан хаазны дөрөө гишгэн зогсоолын тоормос салгах боломжтой. Тус функцийг ашиглах үед хаазыг зөөлөн гишгэнэ. (→X.214)

Зогсоолын тоормосны индикатор унтарсан эсэхийг нягтална.

Зогсоолын тоормосны индикатор анивчиж асаж байгаа үед товчийг дахин дарна. (→X.538)

■ Автомат горим сонгох

Автомашин зогссон үед дуут дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах хүртэл зогсоолын тоормосны товчийг татна.

Автомат горим сонгогдсон үед зогсоолын тоормос дараах байдлаар ажиллана.

- Арааны хөшүүргийг Р-с шилжүүлэх үед зогсоолын тоормос салгагдах ба зогсоолын тоормосны индикатор унтарна.
- Арааны хөшүүргийг Р-д шилжүүлэх үед зогсоолын тоормос залгагдах ба зогсоолын тоормосны индикатор асна.

Автомашин зогссон бөгөөд тоормосны дөрөө гишгэсэн үед арааны хөшүүргийг ажиллуулна.

Арааны хөшүүргийг хэт хурдан хөдөлгөвөл автомат функц ажиллахгүй байж болно. Энэ тохиолдолд зогсоолын тоормосыг гар аргаар залгана. (→Х.216)

■ Автомат горимыг унтраах

Автомашин зогссон үед тоормосны дөрөө гишгэнгээ дуут дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарах хүртэл зогсоолын тоормосны товчийг дарна.

■ Зогсоолын тоормосны ажиллагаа

- Асаах товчны ON-с бусад горимд зогсоолын тоормосны товчоор зогсоолын тоормосыг салгах боломжгүй.
- Асаах товчны ON-с бусад горимд автомат горим (тоормос автоматаар залгах, салгах) ажиллахгүй.

■ Зогсоолын тоормос автоматаар салгах функц

Дараах нөхцөлд хаазны дөрөө зөөлөн гишгэх үед зогсоолын тоормос автоматаар салгагдана:

- Жолоочийн хаалга хаагдсан
- Жолооч аюулгүйн бүс бүсэлсэн
- Арааны хөшүүрэг урагш эсвэл ухрах арааны байрлалд байгаа
- Доголдол анхааруулах гэрэл эсвэл тоормосны системийн анхааруулах гэрэл асаагүй

Хаазны дөрөөг зөөлөн гишгэнэ.

Хаазны дөрөө гишгэх үед зогсоолын тоормос салаагүй байвал гар аргаар салгана.

Арааг Р байрлалаас шилжүүлэх үед зогсоолын тоормос автоматаар салгагдана.

■ Зогсоолын тоормос автоматаар түгжих функц

Дараах нөхцөлүүдэд зогсоолын тоормос автоматаар идэвхэжнэ:

- Жолооч тоормос гишгээгүй
- Жолоочийн хаалга хаагдаагүй
- Жолооч аюулгүйн бүс бүслээгүй
- Араа N-с бусад байрлалд байгаа
- Доголдол анхааруулах гэрэл эсвэл тоормосны системийн анхааруулах гэрэл асаагүй

■ Мэдээллийн дэлгэц дээр “Parking Brake Temporarily Unavailable” гарсан үед

Богино хугацаанд зогсоолын тоормосыг олон дахин залгаж салгавал систем хэт халахаас сэргийлж ажиллагааг хязгаарладаг. Энэ тохиолдолд зогсоолын тоормос ажиллуулахаас зайлсхийнэ. Системийн хэвийн ажиллагаа 1 минутын дараа сэргэнэ.

■ Мэдээллийн дэлгэц дээр “EPB Activation Stopped Incompletely” эсвэл “Parking Brake Unavailable” гарсан үед

Зогсоолын тоормосны товч ашиглана. Товчийг олон удаа ажиллуулсан ч анхааруулга унтрахгүй байвал системд доголдол үүссэн байж болно. Та өөрийн Lexus дилер дээр оношилгоо хийлгэнэ үү.

■ Зогсоолын тоормос ажиллах үеийн дуу

Зогсоолын тоормос ажиллах үед цахилгаан моторын дуу (хүнгэнэсэн дуу) сонсогдож болно. Энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.

■ Зогсоолын тоормосны индикатор гэрэл

- Асаах товчны горимоос хамаарч зогсоолын тоормосны индикатор гэрэл дараах байдлаар асна: ON: Зогсоолын тоормос суллах хүртэл асна.
ON-с бусад горим: 15 секунд орчим асна.

● Зогсоолын тоормос татсан үед асаах товчийг унтраахад зогсоолын тоормосны индикатор 15 секунд орчим үргэлжлүүлэн асна. Энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.

■ Зогсоолын тоормосны товч доголдсон үед

Автомат горим (тоормос автоматаар залгагдах, салгагдах) автоматаар идэвхэжнэ.

■ Зогсоолд байрлуулах

→Х.189

■ Зогсоолын тоормосны анхааруулах дохио

Зогсоолын тоормос татсан хэвээр автомашиныг хөдөлгөх үед анхааруулах дохио дуугарна. Мэдээллийн дэлгэц дээр “Parking Brake ON” анхааруулга (автомашин хурд 5км/ц [3 миль/ц] хүрэх үед) гарна.

■ Тоормосны системийн анхааруулах гэрэл ассан үед

→Х.532

■ Өвлийн улирлын ашиглалт

→Х.431



АЮУЛТАЙ

■ Зогсоолд байрлуулах үед

Автомашинд бага насны хүүхдийг харгалзах хүнгүй үлдээхийг хориглоно. Хүүхэд зогсоолын тоормосыг санамсаргүйгээр салгаснаар автомашин хөдөлж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осол үүсгэх аюултай.

■ Зогсоолын тоормосны товч

Зогсоолын тоормосны товчны ойр орчимд аливаа эд зүйл байрлуулах, суурилуулахыг хориглоно. Тоормосны товчтой санамсаргүй харьцах аюултай. Улмаар тоормос ажиллахад хүргэж болно.

■ Зогсоолын тоормос автоматаар түгжих функц

Зогсоолын тоормосны хэвийн ажиллагааны үед тус функцийг ашиглаж болохгүй. Тус функц нь жолооч зогсоолын тоормос мартсанаас үүдсэн мөргөлтийн эрсдэлийг бууруулах зорилготой. Системд хэт найдах нь осол гаргах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.



АНХААР

■ Зогсоолд байрлуулах үед

Автомашинаас буухын өмнө арааг Р байрлалд буцааж зогсоолын тоормосыг татаад автомашин хөдөлгөөнгүй болсон эсэхийг нягтална.

■ Системд доголдол үүссэн үед

Автомашиньг аюулгүй газар зогсоож анхааруулах мэдээллийг шалгана.

■ Аккумулятор суусан үед

Зогсоолын тоормосны систем идэвхжихгүй. (→Х.561)

■ Доголдлын улмаас зогсоолын тоормос салгагдахгүй үед

Зогсоолын тоормос залгагдсан хэвээр автомашиныг жолоодох нь тоормосны эд ангиудад халалт үүсгэх улмаар тоормосны ажиллагаа муудах, элэгдэл үүсэхэд хүргэнэ. Энэ тохиолдолд даруй өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.


Тоормос баригч

Арааны хөшүүргийн D, M, N эсвэл Р арааны байрлалд тоормосны дөрөөгөөр автомашиныг зогсоосон үед тоормос баригч систем тоормосыг үргэлжлүүлэн барьдаг. Систем арааны хөшүүрэг D, M араанд хаазны дөрөө гишгэх үед хөдөлгөөнийг зөөлөн эхлэх боломж олгох байдлаар тоормосыг сулладаг.

Системийг идэвхжүүлэх

Тоормос баригч идэвхжүүлэх

Тоормос баригч ажиллахад бэлэн байгааг илтгэх индикатор (ногоон) **A** асна. Систем тоормос барьж байгаа үед тоормос баригчийн индикатор (шар) **B** асна.



■ Тоормос баригч систем ажиллах нөхцөлүүд

Дараах нөхцөлд тоормос баригч систем идэвхжихгүй:

- Жолоочийн хаалгыг хаагаагүй
- Жолооч аюулгүйн бүс бүслээгүй
- Мэдээллийн дэлгэц дээр "Parking

Brake Unavailable” эсвэл “Parking Brake Malfunction Visit Your Dealer” анхааруулга гарсан

Дээрх аль нэг нөхцөлд систем идэвхгүй болох ба тоормос ажиллахад бэлэн байгааг илтгэх индикатор унтарна. Мөн систем тоормос барьж байгаа үед дээрх аль нэг нөхцөл үүсэхэд анхааруулах дуут дохио дуугарах ба мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна. Энэ тохиолдолд зогсоолын тоормос автоматаар идэвхэжнэ.

■ Тоормос баригчийн функц

- Систем тоормосыг барьж байгаа үед 3 минутын турш тоормосны дөрөө гишгээгүй бол зогсоолын тоормос автоматаар идэвхэжнэ. Энэ тохиолдолд анхааруулах дуут дохио дуугарах ба мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна.
- Систем тоормос барьж байгаа үед системийг унтраахдаа тоормосны дөрөөг сайтар гишгээд товчийг дахин дарна.
- Налуу зам дээр тоормос баригч функц автомашиныг хөдөлгөөнгүй зогсоож чадахгүй байж болно. Энэ нөхцөлд анхааруулах дуут дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах ба энэ үед жолооч тоормос ашиглах шаардлагатай. Мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах үед зааварчилгааг мөрдөнө.
- Зогсоолын тоормос автоматаар ажиллуулахгүй үед тоормос баригчийн товчийг тоормос баригч ажиллахад бэлэн байгааг илтгэх индикатор (ногоон) унтрах хүртэл дараад асаах товчийг мөн унтраана.

■ Систем тоормосыг барьж байгаа үед зогсоолын тоормос автоматаар идэвхэжсэн тохиолдолд

Дараах аль нэг үйлдлээр зогсоолын тоормосыг салгана:

- Хаазны дөрөөг гишгэнэ (аюулгүйн бүс бүслээгүй үед зогсоолын тоормос автоматаар салгагдахгүй.)

- Тоормосны дөрөөг гишгэн зогсоолын тоормосны товчийг ажиллуулна.

Зогсоолын тоормосны индикаторын гэрэл унтарсан эсэхийг нягтална. (→X.213)

■ Lexus дилер дээр оношилгоо хийлгэх шаардлагатай үед

Тоормос баригч системийн ажиллах нөхцөл хангагдсан үед тоормос баригчийн товчийг ажиллуулсан ч тоормос баригч ажиллахад бэлэн байгааг илтгэх индикатор (ногоон) асахгүй байвал системд доголдол үүссэн байж болзошгүй. Lexus дилертээ хандаж оношлуулна уу.

■ Мэдээллийн дэлгэц дээр “Brake Hold Malfunction Press Brake to Deactivate Visit Your Dealer” эсвэл “Brake Hold Malfunction Visit Your Dealer” гарсан үед

Системд доголдол үүссэн байж болзошгүй. Lexus дилер дээрээ оношлуулна уу.

■ Анхааруулах дуут дохио, анхааруулга

Анхааруулах дуут дохио болон анхааруулга нь жолоочид анхаарал хандуулах шаардлагатай зүйл эсвэл доголдол үүссэнийг анхааруулна. Мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах үед зааварчилгааг мөрдөнө.

■ Тоормос баригч системтэй хамт өөр удирдлагын систем зэрэг ажиллах үед (уруу замд туслах удирдлагын системтэй загвар)

Дараах аль нэг нөхцөлд мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

- “Brake Hold Unavailable See the Owner’s Manual”
- Уруу замд туслах удирдлагын систем идэвхтэй үед тоормос баригчийн товч дарагдсан
- Дөрвөн дугуй хөтлөх системийн L4 горимд тоормос баригчийн товч дарсан
- “Brake Hold Unavailable Press Brake to Deactivate”

- Тоормос баригч идэвхэжсэн үед DAC/CRAWL товч дарсан
- Тоормос баригч идэвхэжсэн үед дөрвөн дугуй хөтлөх системийг L4 горимд шилжүүлсэн

Тоормос баригч болон уруу замд туслах удирдлагын систем эсвэл дөрвөн дугуй хөтлөх системийн L4 горимыг зэрэг сонгох боломжгүй.

Тоормосны дөрөө гишгэсэн үедээ тоормос баригчийн товч дарж системийг цуцална.

■ Тоормос баригчийн индикатор анивчиж байгаа үед

→X.538



АНХААР

■ Зогсоолд байрлуулах үед

Тоормос баригч систем автомашиныг удаан хугацаанд зогсооход зориулагдсан систем биш юм. Систем автомашиныг барьж байгаа үед асаах товчийг off горимд унтраах нь систем автомашины тоормосыг салгах улмаар автомашин өнхрөхөд хүргэнэ. Асаах товчтой харьцах үед тоормосны дөрөөг гишгээд арааны хөшүүргийг Р байрлалд шилжүүлж зогсоолын тоормос татна.



АЮУЛТАЙ

■ Налуу зам дээр байгаа үед

Налуу зам дээр тоормос баригч систем ашиглах үед болгоомжтой хандана. Тоормос баригчийн функц нь энэ нөхцөлд автомашиныг хөдөлгөөнгүй барих боломжгүй байж болно.

Мөн систем налуу замын налууугийн хэмжээнээс хамаарч идэвхжихгүй байж болно.

■ Хальтиргаатай зам дээр зогссон үед


Дугуйны барьцалдах чадвараас давсан үед систем автомашиныг зогсоох боломжгүй. Хальтиргаатай зам дээр системийг автомашин зогсооход ашиглаж болохгүй.

Их гэрэл асаах товч


Гар аргаар их гэрлийг удирдах мөн автомат горимд тохируулах боломжтой.

Их гэрэл асаах

 товчийг ажиллуулах үед гэрэл дараах байдлаар асна:

► А төрөл

- 1  Урд, арын, арын хажуу оврын, улсын дугаарын болон хянах самбарын гэрэл асна.
- 2  Их гэрэл болон дээр дурдсан бүх гэрэл асна.
- 3 AUTO Их гэрэл, өдрийн хөдөлгөөний гэрэл (→X.219) болон дээр дурдсан бүх гэрэл автоматаар асах буюу унтарна.

► В төрөл

- 1  Урд, арын, арын хажуу оврын, улсын дугаарын болон хянах самбарын гэрэл асна.
- 2  Их гэрэл болон дээр дурдсан бүх гэрэл асна.
- 3 AUTO Их гэрэл, өдрийн хөдөлгөөний гэрэл (→X.219) болон дээр дурдсан бүх гэрэл автоматаар асах буюу унтарна.
- 4  О Өдрийн хөдөлгөөний гэрэл асна. (→X.219)

■AUTO горим ашиглах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.


■Өдрийн хөдөлгөөний гэрлийн систем

Өдрийн цагаар бусад тээврийн хэрэгслийн жолоочид таны автомашины харагдах байдлыг нэмэгдүүлэх үүднээс  О (тоноглогдсон загварт) эсвэл AUTO байрлалд хөдөлгүүр асаж зогсоолын тоормос буулгах үед өдрийн хөдөлгөөний гэрэл автоматаар асна. (урд оврын гэрлээс тод гэрэлтэй.) Тус гэрэл нь шөнийн

жолоодлогод зориулагдаагүй болно.

■ Их гэрлийн мэдрэгч

Мэдрэгч дээр эд зүйл тавих, мэдрэгчийг халхлах эд зүйл салхины шилэнд наасан тохиолдолд мэдрэгч хэвийн ажиллахгүй. Энэ тохиолдолд мэдрэгч гэрлийн түвшнийг мэдрэхэд саад учрах улмаар автомат их гэрлийн системийн хэвийн ажиллагаа алдагдахад хүрнэ.



■ Автоматаар гэрэл унтраах систем

► А төрөл

Асаах товчийг OFF горимд унтраагаад жолоочийн хаалга нээх үед гэрэл унтарна.

Гэрлийг дахин асаах үед асаах товчийг ON байрлалд буцаах эсвэл их гэрлийг O эсвэл AUTO байрлалд буцаагаад  эсвэл  байрлалд шилжүүлнэ.

► В төрөл

● Их гэрлийн  эсвэл  байрлалд байгаа үед: Асаах товчийг ACC эсвэл OFF-д шилжүүлэх үед их гэрэл болон урд манангийн гэрэл унтарна.

● Их гэрлийн AUTO байрлалд байгаа үед: Асаах товчийг ACC эсвэл OFF-д шилжүүлэх үед их гэрэл болон бүх гэрэл унтарна.

Гэрлийг дахин асаах үед асаах товчийг ON байрлалд буцаах эсвэл их гэрлийг O эсвэл AUTO байрлалд буцаагаад  эсвэл  байрлалд шилжүүлнэ.

► С төрөл

● Их гэрэл асаалттай үед: Асаах товчийг ACC эсвэл OFF горимд шилжүүлээд жолоочийн хаалга нээгээд хааснаас 30 секундийн дараа их гэрэл болон оврын гэрэл унтарна. (Бүх хаалга түгжигдсэний дараа түлхүүрийн  товч дарвал гэрлүүд шууд унтарна.)

● Зөвхөн оврын гэрэл асаалттай үед: Асаах товчийг ACC эсвэл OFF горимд шилжүүлээд жолоочийн хаалга нээх үед оврын гэрэл автоматаар унтарна.

Гэрэл дахин асаах үед асаах товчийг ON эсвэл гэрлийг AUTO горимд шилжүүлээд  эсвэл -д буцаана.

■ Гэрэл сануулах дохио

Гэрэл асаалттай үед асаах товчийг ACC эсвэл OFF горимд шилжүүлээд жолоочийн хаалга онгойлгосон тохиолдолд анхааруулах дохио дуугарна.

■ Их гэрлийн түвшин тохируулах автомат систем

Зорчигчдын тоо, ачааны байдалд тохируулан их гэрлийн тусгалыг бусад тээврийн хэрэгслийн жолоочид саад учруулахгүй түвшинд автоматаар тохируулах систем.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх функц

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж асаах товчны OFF горимд их гэрэл, арын гэрэл асаалттай үед аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх функц 20 минутын дараа бүх гэрлийг унтраана. Асаах товчийг ON горимд шилжүүлэх үед тус функц цуцлагдана.

Дараах аль нэг үйлдлийг хийх үед аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх функцийн ажиллагаа цуцлагдаад дахин идэвхэжнэ. Функц дахин идэвхэжсэнээс 20 минутын дараа бүх гэрэл унтарна:

● Их гэрэл асаах товчийг

ажиллуулсан

- Хаалга нээсэн, хаасан

■ Хаалганы түгжээ тайлах үед (Welcome гэрэл)

Их гэрлийн AUTO байрлалд байгаа ба орчны гэрэл бүдэг үед автомашины entry функц эсвэл алсын удирдлагаар тайлсан үед урд оврын гэрэл автоматаар асна.

■ Тоормосны гэрэл

Арын оврын гэрэл ассан эсэхээс хамаарч тоормосны гэрлийн асалт өөр байна.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим тохиргоог (гэрлийн мэдрэгчийн мэдрэмтгий байдал зэрэг)-г өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо →X.583)




АНХААР

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед гэрлүүдийг шаардлагатай хэмжээнээс удаан хугацаанд асааж болохгүй.

Холын гэрэлд шилжүүлэх



- 1 Их гэрэл асаалттай үед хөшүүргийг урагш түлхэж холын гэрэлд шилжүүлнэ.

Хөшүүргийг голын байрлал руу буцааж холын гэрлийг унтраана.

- 2 Хөшүүргийг нааш татаж холын гэрлийг нэг удаа асаана.


Их гэрлийг асааж унтраах байдлаар гэрлээрээ дохих боломжтой.

Их гэрэл үргэлжлэн асах (тоноглогдсон загварт)

Тус систем асаах товчийг OFF горимд шилжүүлсэн үед их гэрлийг 30 секунд үргэлжлүүлэн асаадаг.

Асаах товчийг OFF горимд унтраасны дараа их гэрлийн AUTO байрлалд хөшүүргийг нааш татаад суллана.

Хөшүүргийг дахин нааш татаад суллах үед тус системийн ажиллагаа цуцлагдана.



Эргэх дохионы нэмэлт гэрэл (тоноглогдсон загварт)

Их гэрэл (ойрын гэрэл) асаалттай ба дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед эргэх дохионы нэмэлт гэрэл асаж эргэх чиглэлийг заана. Тус гэрэл нь уулзвар эсвэл шөнийн

жолоодлогын үед автомашины харагдах байдлыг нэмэгдүүлнэ.

- Жолооны хүрдийг ажиллуулсан
- Эргэх дохионы хөшүүргийг ажиллуулсан
- Арааны хөшүүрэг R байрлалд байгаа (Баруун болон зүүн эргэх дохионы нэмэлт гэрэл зэрэг асна)

■ Эргэх дохионы нэмэлт гэрлийн удирдлага

- Эргэх дохионы нэмэлт гэрэл нь автомашины хурд 30км/ц (19 миль/ц)-с бага үед асах ба хурд 35км/ц (22 миль/ц)-г давах үед унтарна.
- 30 минут үргэлжлэн ассаны дараа гэрэл автоматаар унтарна.

AHS (Adaptive High-beam System) холын гэрэл*

*: Тоноглогдсон загварт

AHS холын гэрэл нь салхины шилний дээд хэсгийн дотор талд байрлах урд камераар замын гэрэлтүүлэг, орчны болон зөрж өнгөрч буй автомашин зэргийн гэрлийг мэдэрдэг ба шаардлагатай тохиолдолд их гэрлийн тусгалыг автоматаар хуваарилдаг.



АЮУЛТАЙ

■ AHS холын гэрэлтэй холбоотой хязгаарлалтууд

AHS холын гэрлийн системд хэт найдаж болохгүй. Замын хөдөлгөөнд хөдөлгөөний аюулгүй байдлыг цаг ямагт хангаж оролцох ба ойр орчмын нөхцөл байдлыг сайтар анхаарч шаардлагатай тохиолдолд их гэрлийг гар аргаар асаах буюу унтраана.

■ AHS холын гэрлийг санамсаргүй ажиллуулахаас сэргийлэх


- Шаардлагатай үед системийг цуцална: →X.236

Системийн функц

- Автомашины хурдад нийцүүлэн холын гэрлийн гэрлийн хүч, тусах хүрээг тохируулна.
- Эргэлт дээр эргэж буй талын зам илүү тод байхаар холын гэрлийн тусгал, эргэлтийг тохируулна.
- Урд талын автомашин байгаа

хэсэгт хэсэгчлэн их гэрэл тусахгүй бусад хэсэгт их гэрэл тусах байдлаар тохируулна.

Тус гэрэл нь урд талын автомашины жолоочийн нүд гялбахаас сэргийлэнгээ жолоочид харагдах байдлыг нэмэгдүүлнэ.




A Холын гэрэл тусч буй талбай

B Ойрын гэрэл тусч буй талбай

- Урд талд явж буй автомашин хүртэлх зайнд тохируулан ойрын гэрэл тусах зайг тааруулна.


AHS систем идэвхжүүлэх

1 AHS системийн товч дарна.



2 Их гэрэл асаах товчийг **АУТО** эсвэл **АУТО** эсвэл  байрлалд шилжүүлнэ.

Их гэрлийн хөшүүрэг ойрын гэрлийн байрлалд байгаа үед AHS систем идэвхжиж AHS индикатор асна.



■ Их гэрлийн тусгалын хуваарилалт автоматаар солигдох нөхцөлүүд

- Дараах бүх нөхцөл бүрдсэн нөхцөлд их гэрэл автоматаар асаж систем ажиллана:

- Автомашины хурд 15км/ц (9 миль/ц)-с их
- Автомашины урд тал харанхуй

* Автомашины хурд 30км/ц (19 миль/ц)-с давах үед их гэрэл тухайн эргэж буй чиглэлийн замыг энгийн үеэс илүү тодоор гэрэлтүүлнэ.

- Дараах бүх нөхцөл бүрдсэн үед холын гэрэл гэрэл AHS горимоор ажиллах ба урд талын автомашин хүртэлх зайнаас хамаарч ойрын гэрлийн тусах зай автоматаар тохируулагдана:

- Автомашины 15км/ц (9 миль/ц)-с их
- Автомашины урд тал харанхуй байгаа
- Урд талд их гэрэл эсвэл арын гэрлээ асаасан автомашин байгаа
- Урд талд замын гэрэл, автомашины гэрэл цөөн байгаа

- Дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед их гэрэл эсвэл AHS горимоор ажиллаж буй их гэрэл унтарч ойрын гэрэлд шилжинэ:

- Автомашины хурд 12км/ц (7 миль/ц)-с бага
- Автомашины урд тал харанхуй биш
- Урд талд олон автомашин байгаа
- Урд талын автомашинууд хурдтай

явж байгаа ба их гэрэл нүдийг нь гялбуулж болох үед

■ Урд камерын ажиллагаа

- Дараах нөхцөлд их гэрэл автоматаар AHS горимд шилжихгүй байх магадлалтай:
 - Урд талд өөр автомашин хажуу талаас огцом орж ирсэн үед
 - Автомашины урдуур өөр автомашин хөндлөн гарах үед
 - Замын эгнээ тусгаарлагч, зам дагуух мод мөн замын дараалсан эргэлт зэргээс шалтгаалж урд талын автомашин олон дахин урд гарч ирэх үед
 - Өргөн зам дээр эсрэг чиглэлийн автомашин холуур зөрж өнгөрөх үед
 - Урд талын автомашин хол үед
 - Урд талын автомашин гэрлээ асаагаагүй үед
 - Урд талын автомашины гэрэл бүдэг үед
 - Таны автомашин их гэрэл зэрэг хүчтэй гэрлийг урд талын автомашин ойлгож байгаа үед
 - Мэдрэгч хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд: X.240
- Урд талын автомашин их гэрлээ асаалгүй манангийн гэрлээ асаасан үед холын гэрэл AHS горимд шилжихгүй байх магадлалтай.
- Байшин байгууламжийн гэрэл, замын гэрэлтүүлэг, гэрлэн дохио, гэрэлтэй самбарын гэрэл бусад гэрэл ойлгогч материалаас шалтгаалж холын гэрэл AHS горимд шилжихгүй байх эсвэл асахгүй байх магадлалтай.
- Дараах хүчин зүйлүүд нь их гэрэл асах хурд эсвэл унтрах хугацаанд нөлөөлнө:
 - Урд талын автомашины гэрлийн хэмжээ
 - Урд талын автомашины хөдөлгөөн болон чиглэл
 - Урд талын автомашин хүртэлх зай
 - Урд талын автомашины зөвхөн нэг талын гэрэл асах
 - Урд талд 2 дугуйтай механикжсан тээврийн хэрэгсэл байгаа үед
 - Замын байдал (налуу, эргэлт, замын гадаргуу г.м.)
 - Зорчигчдын тоо болон ачааны

хэмжээ

- Холын гэрлийн тусгалын хуваарилалт нь жолоочийн тооцоолоогүй, урьдчилан таамаглаагүй үед асах буюу унтрах магадлалтай.
- Унадаг дугуй мөн түүнтэй адил зүйлс мэдрэгчид танигдахгүй байх магадлалтай.
- Дараах нөхцөлүүдэд орчны гэрлийн түвшнийг систем нарийн тогтооход хүндрэлтэй байх магадлалтай. Энэ тохиолдолд холын гэрэл рүү шилжихгүй байх эсвэл холын гэрэл явган зорчигч бусад тээврийн хэрэгсэл болон бусад хүндрэл учруулж болзошгүй. Энэ үед хол болон ойрын гэрлүүдийг хооронд нь гар аргаар шилжүүлнэ.
- Орчны гэрлийн түвшин автомашины их гэрэл, арын гэрэл, манангийн гэрэлтэй ижил түвшинд байгаа үед
- Урд талын автомашины гэрэл унтраастай, бохирдсон, өнгө нь өөрчлөгдсөн, тусгал нь алдагдсан үед
- Холын болон ойрын гэрлийг хооронд нь ойр ойрхон шилжүүлсэн үед
- Бусад тээврийн хэрэгсэл, явган зорчигчид холын гэрэл саад учруулж байгаа гэж жолооч бодож байгаа үед
- Тухайн автомашин анх нийлүүлэгдсэн улсаас замын хөдөлгөөний эсрэг урсгалтай бусад улс оронд, жишээлбэл замын хөдөлгөөний баруун гарын дүрэмтэй улсад зориулагдсан автомашиныг зүүн гарын дүрэмтэй улсад эсвэл эсрэгээр ашиглах үед
- Системийг цуцлах шаардлагатай нөхцөлүүд: →X.236
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд: →X.240

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим функцийг өөрчлөх боломжтой. (→X.583)


Холын гэрлийг гар аргаар асаах/унтраах

■ Холын гэрэлд шилжүүлэх

Хөшүүргийг урагш түлхэнэ.

AHS системийн индикатор унтарч холын гэрлийн индикатор асна.

AHS системийг дахин идэвхжүүлэх үед хөшүүргийг анхны байрлалд буцаана.




■ Ойрын гэрэлд шилжүүлэх

AHS системийн товч дарна.

AHS системийн индикатор унтарна.

AHS системийг дахин идэвхжүүлэх үед товчийг дахин дарна.




Ойрын гэрэлд түр шилжүүлэх

Холын гэрэл ашиглах нь тохиромжгүй эсвэл холын гэрэл

бусад жолооч, явган зорчигчдод хүндрэл учруулж байгаа гэж үзсэн үед ойрын гэрэлд шилжүүлэх нь зүйтэй.

Хөшүүргийг нааш татаад анхны байрлалд буцаана.

Хөшүүргийг нааш татах хугацаанд холын гэрэл асах ба хөшүүргийг анхны байрлалд буцаасны дараа тодорхой хугацаанд ойрын гэрэл асаад AHS холын гэрлийн горимд шилжинэ.



АНВ (Automatic High Beam) холын гэрэл

АНВ холын гэрэл нь салхины шилний дээд хэсгийн дотор талд байрлах урд камераар замын гэрэлтүүлэг, орчны болон зөрж өнгөрч буй автомашин зэргийн гэрлийг мэдэрч хол ба ойрын гэрлийг автоматаар сольдог.

⚠ АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал


АНВ холын гэрлийн системд хэт найдаж болохгүй. Ойр орчмоо анхааран цаг ямагт аюулгүй жолоодох ба шаардлагатай үед их гэрлийг гар аргаар асааж унтраана.

■ АНВ холын гэрлийн буруу ажиллагаанаас сэргийлэх

- Шаардлагатай үед системийг цуцална: →Х.236

Автомат холын гэрэл ашиглах


- 1 Автомат холын гэрлийн товч дарна.



- 2 Их гэрэл асаах товчийг AUTO

эсвэл  байрлалд шилжүүлнэ.

Их гэрэл ойрын гэрлийн байрлалд байгаа үед АНВ идэвхжиж индикатор асна.



■ Автомат холын гэрэл автоматаар ажиллах нөхцөл

- Дараах бүх нөхцөл бүрдсэн үед их гэрэл автоматаар асна:
 - Автомашины хурд 30км/ц (19 миль/ц)-с их
 - Автомашины урд тал харанхуй
 - Урд талд гэрэлтэй автомашин байхгүй
 - Урд талд цөөн хэдэн гудамжны болон бусад гэрэл байгаа
- Дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед ойрын гэрэлд шилжинэ:
 - Автомашины хурд 25км/ц (16 миль/ц)-с буурсан
 - Автомашины урд тал харанхуй биш
 - Урд талд гэрэлтэй автомашин байгаа
 - Урд талд олон гудамжны болон бусад гэрэл байгаа

■ Урд камерын ажиллагаа

- Дараах нөхцөлд их гэрэл автоматаар ойрын гэрэлд шилжихгүй байх магадлалтай:
 - Урд талд өөр автомашин хажуу талаас огцом орж ирсэн үед
 - Автомашины урдуур өөр автомашин хөндлөн гарах үед
 - Замын эгнээ тусгаарлагч, зам дагуух мод мөн замын дараалсан эргэлт зэргээс шалтгаалж урд талын автомашин олон дахин урд гарч ирэх үед

- Өргөн зам дээр эсрэг чиглэлийн автомашин холуур зөрж өнгөрөх үед
- Урд талын автомашин хол үед
- Урд талын автомашин гэрлээ асаагаагүй үед
- Урд талын автомашины гэрэл бүдэг үед
- Таны автомашин их гэрэл зэрэг хүчтэй гэрлийг урд талын автомашин ойлгож байгаа үед
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд: →Х.240
- Урд талын автомашин их гэрлээ асаалгүй манангийн гэрлээ асаасан үед холын гэрэл АНВ горимд шилжихгүй байх магадлалтай.
- Байшин байгууламжийн гэрэл, замын гэрэлтүүлэг, гэрлэн дохио, гэрэлтэй самбарын гэрлээс шалтгаалж холын гэрэл ойрын гэрэлд шилжих эсвэл асахгүй байх магадлалтай.
- Дараах хүчин зүйлүүд нь их гэрэл асах эсвэл унтрах хугацаанд нөлөөлнө:
 - Урд талын автомашины гэрлийн хэмжээ
 - Урд талын автомашины хөдөлгөөн болон чиглэл
 - Урд талын автомашин хүртэлх зай
 - Урд талын автомашины зөвхөн нэг талын гэрэл асах
 - Урд талд 2 дугуйтай механикжсан тээврийн хэрэгсэл байгаа үед
 - Замын байдал (налуу, эргэлт, замын гадаргуу г.м.)
 - Зорчигчдын тоо болон ачааны хэмжээ
- Их гэрэл хол ба ойрын гэрэлд урьдчилан таамаглаагүй үед солигдох магадлалтай.
- Унадаг дугуй мөн түүнтэй адил зүйлс мэдрэгчид танигдахгүй байх магадлалтай.
- Дараах нөхцөлүүдэд орчны гэрлийн түвшнийг систем нарийн тогтооход хүндрэлтэй байх магадлалтай. Энэ тохиолдолд холын гэрэл рүү шилжихгүй байх эсвэл холын гэрэл явган зорчигч бусад тээврийн хэрэгсэл болон бусад хүндрэл учруулж болзошгүй. Энэ үед хол болон ойрын гэрлүүдийг хооронд нь гар аргаар шилжүүлнэ.
- Орчны гэрлийн түвшин автомашины их гэрэл, арын гэрэл, манангийн гэрэлтэй ижил түвшинд байгаа үед
- Урд талын автомашины гэрэл унтраастай, бохирдсон, өнгө нь өөрчлөгдсөн, тусгал нь алдагдсан үед
- Холын болон ойрын гэрлийг хооронд нь ойр ойрхон шилжүүлсэн үед
- Бусад тээврийн хэрэгсэл, явган зорчигчид холын гэрэл саад учруулж байгаа гэж жолооч бодож байгаа үед
- Тухайн автомашин анх нийлүүлэгдсэн улсаас замын хөдөлгөөний эсрэг урсгалтай бусад улс оронд, жишээлбэл замын хөдөлгөөний баруун гарын дүрэмтэй улсад зориулагдсан автомашиныг зүүн гарын дүрэмтэй улсад эсвэл эсрэгээр ашиглах үед
- Системийг цуцлах шаардлагатай нөхцөлүүд: →Х.236
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд: →Х.240


Холын гэрлийг гар аргаар асаах/унтраах

■ Холын гэрэлд шилжүүлэх

Хөшүүргийг урагш түлхэнэ.

АНВ системийн индикатор унтарч холын гэрлийн индикатор асна.

АНВ системийг дахин идэвхжүүлэх үед хөшүүргийг анхны байрлалд буцаана.




■ Ойрын гэрэлд шилжүүлэх

АНВ системийн товч дарна.

АНВ системийн индикатор унтарна.

АНВ системийг дахин идэвхжүүлэх үед товчийг дахин дарна.




Ойрын гэрэлд түр шилжүүлэх

Холын гэрэл ашиглах нь тохиромжгүй эсвэл холын гэрэл бусад жолооч, явган зорчигчдод хүндрэл учруулж байгаа гэж үзсэн нөхцөлд ойрын гэрэлд шилжүүлэх нь зүйтэй.

Хөшүүргийг нааш татаад анхны байрлалд буцаана.

Хөшүүргийг нааш татах хугацаанд холын гэрэл асах ба хөшүүргийг анхны байрлалд буцаасны дараа тодорхой хугацаанд ойрын гэрэл асаад АНВ холын гэрлийн горимд шилжинэ.




Манангийн гэрлийн товч

Бороо, манан зэрэг хүнд нөхцөлд манангийн гэрэл нь үзэгдэх орчныг сайжруулдаг.

Ажиллуулах дараалал


► Урд манангийн гэрлийн товч



1 ○ Off

2 Урд манангийн гэрэл асах


► Хойд манангийн гэрэл



1 ○ Off

2 0 $\frac{1}{2}$ Манангийн гэрэл асах

► Урд болон хойд манангийн гэрлийн товч



1 ○ Off

2 0 $\frac{1}{2}$ Урд манангийн гэрэл асах

3 0 $\frac{1}{2}$ Урд, хойд манангийн гэрэл асах

Товчны цагаригийг 0 $\frac{1}{2}$ -д буцаана.

Цагаригийг дахин ажиллуулах үед хойд манангийн гэрэл унтарна.

■ Ашиглах боломжтой нөхцөл

► Урд манангийн гэрэлтэй автомашин
Оврын гэрэл асаалттай үед

► Зөвхөн хойд манангийн гэрэлтэй

Их гэрэл асаалттай үед

► Урд болон хойд манангийн гэрэлтэй
Урд манангийн гэрэл: Оврын гэрэл асаалттай үед

Хойд манангийн гэрэл: Урд манангийн гэрэл асаалттай үед

Шил арчигч ба угаагч

Хөшүүрэг ашиглан автомат болон гар горимд шилжүүлж болох ба мөн шил угаагчийг ажиллуулах боломжтой.

⚠ АНХААР


■ Салхины шил хуурай үед

Салхины шилийг гэмтээж болзошгүй тул шил арчигч ашиглаж болохгүй.

Шил арчигчийн хөшүүрэгтэй ажиллах

🪄 хөшүүргийг ажиллуулах үед шил арчигч, угаагч дараах байдлаар ажиллана:

AUTO горимд бороо мэдрэгч борооны дусал мэдэрсэн үед шил арчигч автоматаар ажиллана. Борооны хэмжээ, автомашины хурдад шил арчигчийн хурдыг тохируулна.



1 ○ Off


2 AUTO Бороо мэдрэгчийн ажиллагаа

3 ▼ Удаан

4 ▼ Хурдан


5 ▲ Нэг удаа арчих

AUTO-г сонгосон үед мэдрэгчийн мэдрэх түвшнийг тохируулна.



6 Мэдрэх түвшнийг нэмэгдүүлэх

7 Мэдрэх түвшнийг багасгах



8 Шил арчигч/угаагч давхар ажиллах

Хөшүүргийг татах үед шил арчигч автоматаар ажиллана.

Шил арчигч хэд хэдэн удаа ажиллаад тодорхой хугацааны дараа дахин нэг ажиллана.

Их гэрэл угаагчтай загвар: Их гэрэл асаалттай үед хөшүүргийг татахад их гэрэл угаагч нэг удаа ажиллана. Үргэлжлүүлэн их гэрэл

угаагч хөшүүргийг таван удаа татах тутамд нэг удаа ажиллана.

■ Шил арчигч, угаагчийн ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Дуугаар удирдах системээр* шил арчигч, угаагч ажиллуулах

*: Тоноглогдсон загварт

Дуугаар удирдах систем ашиглан дараах үйлдлийг хийх боломжтой.

- Шил арчигчийг зөвхөн нэг удаа ажиллуулах
- Шил угаагч ажиллуулах (зөвхөн автомашин зогсож байгаа үед хийх боломжтой.)

Дуугаар удирдах системийн дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.


■ Шил арчигчийн ажиллагаанд үзүүлэх автомашины хурдны нөлөө

Шил арчигчийн удаан ажиллагааны горим сонгогдсон ба автомашин хөдөлгөөнгүй үед ажиллагаа удаан горимоос тасалдсан горимд шилжинэ. (Нөгөөтээгүүр мэдрэгчийн мэдрэх түвшнийг хурдан горимоор тохируулсан үед тус горимоор ажиллахгүй.)

■ Бороо мэдрэгч

- Бороо мэдрэгч нь борооны дуслын хэмжээг мэдэрдэг.

Бороо мэдрэгч нь оптик мэдрэгч ашигладаг. Мэдрэгч нь өглөө болон оройн нар шууд тусах эсвэл хорхой шавьж салхины шилэн дээр байгаа үед зөв ажиллахгүй байж болно.



- Асаах товч ON горимд байгаа үед

шил арчигчийг AUTO болгоход AUTO горимд шилжсэнийг илтгэж шил арчигч нэг удаа ажиллана.

- Шил арчигчийн AUTO горимд мэдрэгчийн мэдрэх түвшнийг нэмэгдүүлэх тохиргоо хийхэд тохиргоо хийгдсэнийг илтгэж шил арчигч нэг удаа ажиллана.
- Бороо мэдрэгчийн температур 85°C (185°F)-с их эсвэл -30°C (22°F)-с бага үед систем автоматаар ажиллахгүй байж болно. Энэ тохиолдолд "AUTO"-с өөр горим сонгоно.

■ Шил арчигчийн шингэн цацагдахгүй үед

Шил арчигчийн шингэний нөөцийн саванд шингэн байгаа тохиолдолд угаагчийн хошуу бөглөрөөгүй эсэхийг эсэхийг шалгана.

■ Шил арчигчийн хошуу халаагч (тоноглогдсон загварт)

Асаах товчны ON горимд гадна агаарын хэм 5°C (41°F) хэмээс бага үед шил арчигчийн хошуу халаагч ажиллана.



АЮУЛТАЙ

■ Шил арчигчийн AUTO горим ашиглах анхааруулга

AUTO горим сонгогдсон үед мэдрэгчид хүрэх эсвэл салхины шил доргилтод өртөх үед шил арчигч гэнэт ажиллаж болзошгүй. Шил арчигчид гар хуруугаа болон бусад зүйл хавчуулахаас сэргийлнэ.

■ Шил арчигчийн шингэн ашиглах анхааруулга

Хүйтэн нөхцөлд салхины шил халах хүртэл шил арчигчийн шингэн ашиглаж болохгүй. Шил арчигчийн шингэн шилэнд хөлдөж наалдан жолоочийн үзэгдэх орчныг бууруулах аюултай ба улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэж болзошгүй.

■ Шил арчигчийн хошуу халаагч ажиллах үед (тоноглогдсон загварт)

Түлэх аюултай тул хошуунд хүрч болохгүй.



АНХААР

■ Шил угаагчийн хошуунаас шингэн цацагдахгүй үед

Шил арчигчийн шингэний насос хэт халах аюултай тул шил арчигчийн хөшүүргийг нааш татан удаан ажиллуулж болохгүй.

■ Угаагчийн хошуу бөглөрсөн үед

Lexus дилерт хандана уу.

Зүү болон бусад зүйлээр сэтгэж болохгүй. Хошуу гэмтэх аюултай.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед шил арчигчийг шаардлагатай хэмжээнээс удаан ажиллуулж болохгүй.

Хойд шил арчигч ба угаагч

Хөшүүргийн үзүүрийг эргүүлэн хойд шил арчигч ба угаагчийг ажиллуулна.




АНХААР

■ Арын шил хуурай үед


Арын шилийг гэмтээх тул шил арчигчийг ажиллуулж болохгүй.

Хөшүүргийг ажиллуулах

 товчийг ажиллуулах үед хойд шил арчигч дараах байдлаар ажиллана:



- 1 ○ Off
- 2 --- Тасалдсан горим
- 3 — Хэвийн ажиллагаа



4 Шил арчигч/угаагч давхар ажиллах

Хөшүүргийг түлхэх үед шил арчигч болон угаагч ажиллана.

Камер угаагчтай автомашин: Угаагч автоматаар ажиллан дараах камеруудыг цэвэрлэнэ.

- Панорамик дэлгэцийн камер* (тоноглогдсон загварт)
- Multi-terrain монитормын камер (тоноглогдсон загварт) (→X.395)

*: Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

■ Хойд шил арчигч ба угаагч ажиллах нөхцөлүүд

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед хойд шил арчигч ба угаагч ажиллана:

- Асаах товч ON горимд байгаа.
- Тээшний хаалганы нээгддэг цонх хаалттай.

■ Дуугаар удирдах системээр* хойд шил арчигч ба угаагч ажиллуулах

*: Тоноглогдсон загварт

Дуугаар удирдах систем ашиглан дараах үйлдлийг хийх боломжтой.

- Хойд шил арчигчийг зөвхөн нэг удаа ажиллуулах
- Хойд шил угаагч ажиллуулах (зөвхөн автомашин зогсож байгаа үед хийх боломжтой.)

Дуугаар удирдах системийн тухай дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

■ Шил арчигчийн шингэн цацагдахгүй үед

Шил арчигчийн шингэний нөөцийн саванд шингэн байгаа тохиолдолд угаагчийн хошуу бөглөрөөгүй эсэхийг эсэхийг шалгана.

■ Дутуу үлдсэн усны дусал урсаххаас сэргийлэх

Шил арчигч хэд хэдэн удаа ажиллаад тодорхой хугацааны дараа дахин нэг ажиллана.

■ Тээшний хаалга нээх үйлдэлтэй холбоотой хойд шил арчигчийн ажиллагааг зогсоох функц

Хойд шил арчигч ажиллаж байх үед автомашиныг зогсоон тээшний хаалгыг нээвэл автомашины ойр орчимд байгаа хүн рүү ус цацагдахаас сэргийлж хойд шил арчигчийн ажиллагаа зогсоно. Тээшний хаалга хаагдах үед шил арчигчийн ажиллагаа дахин сэргэнэ.

■ Ухрах араатай холбоотой хойд шил арчигчийн функц

Урд шил арчигч ажиллах үед арааг R-д шилжүүлбэл хойд шил арчигч нэг удаа ажиллана.



АНХААР

■ Шил арчигч шингэний нөөцийн сав хоосон үед

Шил арчигчийн шингэний насос хэт халах аюултай тул хойд шил угаагчийг удаан ажиллуулж болохгүй.

■ Угаагчийн хошуу бөглөрсөн үед

Та өөрийн Lexus дилерт хандана уу. Зүү болон бусад зүйлээр сэтгэж болохгүй. Хошуу гэмтэх аюултай.

■ Аккумулятор суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед шил арчигчийг шаардлагатай хэмжээнээс удаан ажиллуулж болохгүй.

Шатахууны савны таг онгойлгох

Шатахууны савны тагийг дараах дарааллаар онгойлгоно:

Шатахуун цэнэглэхийн өмнө

- Бүх хаалга, цонхнуудыг хааж асаах товчийг OFF горимд унтраана.
- Шатахууны төрлийг нягтална.

■ Шатахууны төрөл

→X.582

■ Хар тугалгагүй бензинд зориулсан шатахууны савны амсар

Буруу шатахуун цэнэглэхээс сэргийлж Lexus автомашины шатахууны савны амсар нь зөвхөн хар тугалгагүй бензиний тусгай хошуу орох зориулалт бүхий хийцтэй байдаг.



АЮУЛТАЙ

■ Шатахуун цэнэглэх үед

Амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюултай тул дараах анхааруулгыг мөрдөнө.

- Шатахууны савны таг нээхийн өмнө автомашины будаггүй металл гадаргууд хүрч хуримтлагдсан байж болзошгүй статик гүйдлийг цэнэггүйжүүлнэ. Шатахууны ууранд статик цэнэгээс үүссэн оч гал авалцах аюултай.

- Шатахууны савны тагнаас сайтар атган зөөлөн эргүүлэн тайлна. Таг тайлах үед шуугьсан чимээ гарч болно. Тагийг бүрэн тайлахын өмнө чимээ зогсохыг хүлээнэ. Халуун нөхцөлд өндөр даралтад орсон шатахуун савны амсраас цацагдаж улмаар гэмтэлд хүргэж болзошгүй.

- Биед хуримтлагдсан статик гүйдлээ цэнэггүйжүүлээгүй аливаа хүнийг нээлттэй шатахууны саванд ойртуулахыг хориглоно.

- Ууршсан шатахуунаар амьсгалахыг хориглоно. Амьсгалсан тохиолдолд хүний биед хортой нэгдлүүдийг шатахуун агуулдаг.

- Шатахуун цэнэглэх үед тамхи татахыг хориглоно. Шатахуунд гал авалцаж гал түймэр үүсэх аюултай.

- Автомашинд буцаж суух эсвэл бусад хүн болон статик гүйдэл хуримтлагдсан байж болзошгүй эд зүйлсэд хүрэхийг хориглоно. Эдгээр үйлдэл нь статик гүйдлийн цэнэг хуримтлагдах, улмаар оч үсэрч гал авалцах аюултай.

■ Шатахуун цэнэглэх үед

Шатахууны савнаас шатахуун хальж асгарахаас сэргийлж дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:


- Түгээгүүрийн хошууг шатахууны саванд гүйцэд шургуулна.
- Хошуу автоматаар буух үед шатахуун цэнэглэлтийг зогсооно.
- Шатахууны сав дүүрсэн үед нэмж хийхийг хориглоно.

**АНХААР****■ Шатахуун цэнэглэх**


Шатахуун цэнэглэх үед шатахуун асгахыг хориглоно. Хаягдал утааны системийн хэвийн ажиллагаа алдагдах, шатахууны системийн эд ангиудыг гэмтээх, автомашины будагтай арьс гэмтэх зэргээр сөрөг нөлөө үзүүлэх аюултай.

Шатахууны савны таг онгойлгох

- 1 Хөшүүргийг татна.




- 2 Тагийг зөөлөн эргүүлэн нээгээд тусгай сууринд байрлуулна.

**Шатахууны савны таг хаах**

Шатахуун цэнэглэж дууссаны дараа тагийг чаг хийж дуугарах

хүртэл эргүүлнэ. Тагнаас гараа авах үед таг эсрэг чиглэлд бага зэрэг буцна.

**АЮУЛТАЙ****■ Шатахууны савны таг солих**

Зөвхөн тухайн загварын автомашинд зориулагдсан Lexus-н оригинал шатахууны савны таг ашиглана. Эсрэг тохиолдолд галын аюул үүсэх мөн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бусад аюул эрсдэл үүсгэх аюултай.

Lexus Safety System +

Lexus Safety System + нь жолоодлогод туслах дараах системүүдээс бүрдэх ба аюулгүй, тав тухтай жолоодлого хийх боломжийг бүрдүүлдэг:



АЮУЛТАЙ

■ Lexus Safety System +

Тус систем жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган жолоодох нөхцөлд ажиллах бөгөөд мөргөлт үүссэн үед жолооч, зорчигч болон автомашинд учрах нөлөөг бууруулах мөн жолоодлогын хэвийн нөхцөлд жолоочид тусалдаг. Системийн ажиллагааны нарийвчлал болон үйлчлэл нь хязгаартай тул ажиллагаанд хэт найдаж болохгүй. Жолооч хөдөлгөөнд цаг ямагт аюулгүй оролцох, ойр орчимдоо анхаарал хандуулах үүрэгтэй.

■ Ашиглалтын аюулгүй байдал

- Системд хэт найдаж болохгүй. Эргэн тойрондоо анхаарал хандуулан аюулгүй жолоодох нь жолоочийн үүрэг юм. Систем бүх нөхцөлүүдэд ажиллахгүй байж болох ба мөн үзүүлэх дэмжлэг хязгаартай. Систем автомашины аюулгүй жолоодлогыг хангана гэж хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.
- Хэвийн ажиллахгүй байх улмаар осолд хүргэх аюултай тул системийн ажиллагааг туршиж үзэж болохгүй.
- Жолоодлогын явцад жолоочид анхааруулга өгөх эсвэл систем доголдсон үед анхааруулга эсвэл дуут дохио өгнө. Анхааруулга гарсан үед зааврыг дагана.

- Хөгжмийн дуу зэрэг гадаад дуу чимээнээс шалтгаалж дохио сайн сонсогдохгүй байж болно. Мөн замын нөхцөл байдлаас шалтгаалж системийн ажиллагааг мэдэхэд хүндрэлтэй байж болно

■ Системийг цуцлах шаардлагатай нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд системийн ажиллагааг цуцална.

Эсрэг тохиолдолд систем хэвийн ажиллахгүй байх улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүрэх аюултай.

- Даац хэтэрснээс шалтгаалан автомашин хазайсан эсвэл дугуй хагарсан
- Хэт өндөр хурдаар явах үед
- Өөр автомашин чирэх үед
- Ачааны машин, усан онгоц, галт тэрэг болон бусад ижил төстэй тээврийн хэрэгслээр автомашин тээвэрлэж байгаа үед
- Автомашиныг авто засварын лифтээр өргөсөн ба хөдөлгүүр асаалттай, дугуй чөлөөтэй эргэх боломжтой үед
- Автомашиныг динамометр, спидометрийн тестер зэрэг хэмжилт хийх зориулалттай эргэдэг дарамт хийцтэй төхөөрөмж дээр оношилгоо хийх, тэнхлэг тохиргоо хийх
- Авто спорт эсвэл бартаат зам дээр жолоодох үед
- Автомат автомашин угаалга ашиглах үед
- Мэдрэгч эсвэл мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохигдсоноос үүдэн мэдрэгчийн байрлал алдагдсан эсвэл хэлбэр алдагдсан
- Автомашинд мэдрэгчийг халхлах нэмэлт тоноглол, гэрэл угсарсан үед

⚠ АЮУЛТАЙ

- Нөөц дугуй ашиглаж байгаа эсвэл зөөврийн дугуйн шингэн нөхөөс ашиглаж дугуй нөхсөн үед
- Дугуй хэт элэгдсэн эсвэл дугуйн хийн даралт хэт өндөр, хэт бага
- Тохирохгүй хэмжээтэй дугуй ашигласан үед
- Осол, эвдрэл гэмтэл зэргийн улмаас автомашиныг тэнцвэртэй жолоодох боломжгүй үед

Жолоодлогод туслах систем

- AHS холын гэрэл*
→X.222
- AHB холын гэрэл*
→X.226
- PCS систем
→X.242
- LTA систем
→X.256
- LDA систем
→X.264
- LCA систем*
→X.261
- FCTA функц*
→X.274
- PDA систем*
→X.269
- RSA систем*
→X.277
- Динамик радарын хурд барих систем
→X.281

■ Хурд баригч

→X.300

■ Хурд хязгаарлагч*

→X.297

■ EDSS систем*

→X.295


*: Тоноглогдсон загварт

Мэдрэгчүүд

Олон төрлийн мэдрэгчүүд ажиллан системийн ажиллагаанд шаардлагатай мэдээллийг цуглуулж байдаг.

■ Орчны байдлыг мэдрэх мэдрэгчүүд

► Урд




A Урд радарын мэдрэгч

B Урд камер

C Урд хажуугийн радарын мэдрэгч*

*: Тоноглогдсон загварт

► Хойд



A Хойд хажуугийн радарын мэдрэгч

! АЮУЛТАЙ

■ Радарын мэдрэгчийг гэмтэл, доголдлоос сэргийлэх


Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд радарын мэдрэгчийн хэвийн ажиллагаа алдагдах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүрэх аюултай.

- Радарын мэдрэгч болон радарын мэдрэгчийн тагийг байнга цэвэр байлгана.

Радарын мэдрэгчийн урд тал, эмблемийн ар тал бохирдсон, ус цас болсон байвал цэвэрлэнэ.


Радарын мэдрэгч, мэдрэгчийн тагийг зөөлөн даавуугаар болгоомжтой арчиж цэвэрлэнэ.



A Радарын мэдрэгч

B Радарын мэдрэгчийн таг

- Урд хажуугийн радарын мэдрэгчтэй автомашин: Урд гуперт байх урд хажуугийн радарын мэдрэгчийн ойр орчмыг цаг ямагт цэвэр байлгана.



- Радарын мэдрэгч, мэдрэгчийн таг, эдгээрийн ойр орчимд нэмэлт тоноглол хийх, наалт (тунгалаг наалт мөн хамаарна) болон бусад зүйл наах, байрлуулахыг хориглоно.

- Радарын мэдрэгч, түүний ойр орчмыг хүчтэй цохилтоос хамгаална.

Радарын мэдрэгч, радиаторын тор, урд гупер хүчтэй цохилтод өртсөн тохиолдолд Lexus дилертээ хандаж оношлуулна уу.

- Радарын мэдрэгчийг задлахгүй.

- Радарын мэдрэгч, мэдрэгчийн таг, тэдгээрийн ойр орчмыг өөрчлөх, будахыг хориглоно.

- Дараах тохиолдлуудад радарын мэдрэгчийн тохиргоо хийлгэх шаардлагатай. Дэлгэрэнгүйг та өөрийн Lexus дилерээс авна уу.

- Радарын мэдрэгч, радиаторын торыг салгаад буцааж суурилуулсан эсвэл сольсон
- Урд гупер эсвэл гуперны торон нүүр сольсон

▲ АЮУЛТАЙ

■ Халаагчтай радарын мэдрэгчийн таг (тоноглогдсон загварт)

Радарын мэдрэгчийн таг дээр цас тогтох магадлалтай гэж систем тооцоолсон үед халаагч автоматаар ажиллана. Цэвэрлэх зэргээр радарын мэдрэгчийн ойр орчимд хүрэх үед түлэгдэхээс сэргийлнэ.

■ Урд камерыг гэмтэл, доголдлоос сэргийлэх


Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд урд камерын хэвийн ажиллагаа алдагдах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

● Салхины шилийг цаг ямагт цэвэр байлгана.

- Салхины шил бохирдсон, тосорхог давхарга, усны дусал, цас зэрэг тогтсон үед цэвэрлэнэ
- Салхины шилэнд шил өнгөлөгчөөр өнгөлгөө хийсэн байсан ч урд камерын урд талын салхины шилний бохирдлыг шил арчигчаар заавал цэвэрлэнэ
- Салхины шилний дотор талын урд камер суурилагдсан хэсэг бохирдсон тохиолдолд Lexus дилерт хандана

- Салхины шилний урд камерын урд талын хэсэг (зурагт саарлаар тэмдэглэсэн хэсэг) дээр наалт (тунгалаг наалт мөн хамаарна) болон бусад зүйл наах, байрлуулахыг хориглоно.



A 4 см (1.6 in.) орчим

B 4 см (1.6 in.) орчим

- Салхины шилний урд камерын урд талын хэсэг цантсан, мөс тогтсон үед салхины шилний цан арилгагчаар арилгана.

- Салхины шилний урд камерын урд талын хэсэгт тогтсон усан дуслыг шил арчигч гүйцэд арчихгүй байвал шил арчигчийг солино.

- Салхины шилэнд хуулга наахыг хориглоно.

- Салхины шил гэмтсэн, цуурсан тохиолдолд шинээр солино.

Салхины шил сольсон үед урд камерын тохиргоог өөрийн Lexus дилер дээр хийлгэнэ үү.

- Урд камерыг норгож болохгүй.

- Урд камер луу хүчтэй гэрэл тусгаж болохгүй.



АЮУЛТАЙ

- Урд камерыг бохирдуулж гэмтээж болохгүй.

Салхины шилний дотор талыг цэвэрлэх үед камерын линзэнд шил угаагч шингэн орохоос сэргийлнэ. Мөн линзэнд гараар хүрэхийг хориглоно.

Линз бохирдсон, гэмтсэн тохиолдолд Lexus дилертээ хандана уу.

- Урд камерыг хүчтэй цохилтоос хамгаална.
- Урд камерын байрлалыг солих, чиглэлийг өөрчлөх болон салгаж авахыг хориглоно.
- Урд камерыг задлахыг хориглоно.
- Урд камерын ойр орчимд байрлах автомашины эд ангиуд (голын толь г.м.) болон таазны хэсгийг өөрчлөхийг хориглоно.
- Капот, радиаторын тор, урд гупер дээр камерын мэдрэгчийг хаах нэмэлт тоноглол суурилуулахыг хориглоно. Дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн Lexus дилерт хандаж авна уу.
- Серфингийн тавцан зэрэг урт зүйл автомашины дээр байрлуулах үед урд камерыг халхлахгүй эсэхийг нягтална.
- Их гэрэл болон бусад гэрлийг өөрчлөхийг хориглоно.

■ Салхины шилэн дэх урд камерын байрлал

Салхины шил цантсан гэж систем тооцоолсон үед салхины шилний урд камер байрлах хэсгийн цанг арилгах үүднээс систем автоматаар шил халаагч ажиллуулж болно. Цэвэрлэх үед түлэгдэх аюултай тул салхины шил хангалттай хөрөх хүртэл урд камерын ойр орчимд хүрч болохгүй.

■ Ашиглах үеийн анхааруулга

Аудио дэлгэцтэй загвар: Тус функцийг ашиглах үед Lexus-н серверийн үйлчилгээний гэрээнд хамрагдах шаардлагатай. Дэлгэрэнгүйг та өөрийн Lexus дилерт хандана уу.


- LCA систем (тоноглогдсон загварт)

→X.261


■ Мэдрэгч хэвийн ажиллахгүй байх магадлалтай нөхцөлүүд

- Өөрчлөлт хийснээс шалтгаалж автомашины өндөр, хазайлт өөрчлөгдсөн үед
- Салхины шил бохирдсон, цантсан, цуурсан, гэмтсэн үед
- Орчны хэм хэт өндөр эсвэл хэт нам үед
- Шавар, ус, цас, хорхой шавьж, гадны биет зэрэг мэдрэгчийн урд талд наалдсан үед
- Аадар бороо, манан, цас, шороон шуурга зэрэг цаг агаар муу үед
- Урд талын автомашинаас ус, цас, шороо зэрэг шидэгдсэн эсвэл манан, утаан дундуур явах үед
- Шөнийн цагаар эсвэл хонгил зэргээр харанхуйд явах үед их гэрэл асаагүй үед
- Их гэрлийн линз бохирдсон ба гэрлийн тусгал муу үед
- Их гэрлийн тусгал алдагдсан үед
- Их гэрэл доголдож байгаа үед
- Бусад автомашины их гэрэл, нар эсвэл ойсон гэрэл урд камер луу шууд тусах үед
- Орчны гэрлийн түвшин огцом өөрчлөгдөх үед
- Телевизийн цамхаг, дахин дамжуулах станц, радарар тоноглогдсон автомашин, цахилгаан станц бусад хүчтэй радио болон цахилгаан долгион ялгаруулдаг газрын ойр орчимд
- Шил арчигч урд камер халхлах үед
- Дараах зэрэг радио долгион хүчтэй ойлгох байршил, эд зүйлийн ойр орчимд:
 - Хонгил
 - Төмөр гүүр

- Хайрган зам
- Ховилтой, цасаар хучигдсан зам
- Хана
- Том ачааны машин
- Траншейны таг
- Замын хашлага
- Төмөр хавтан
- Замаас дээш илүү гарсан, доош буусан хэсэг
- Жижиг хувийн зорчих хэрэгсэл зэрэг тухайн мэдрэх боломжтой тээврийн хэрэгсэл жижиг овортой үед
- Ачаагүй ачааны машин зэрэг мэдрэх боломжтой объектын урд эсвэл хойд тал нь жижиг үед
- Урд талд намхан тэвштэй ачааны машин зэрэг хойд тал нь намхан автомашин байгаа үед



- Урд талд өндөрлөсөн автомашин байгаа үед



- Мэдрэх боломжтой объект тэвшнээсээ илүү гарсан ачаа ачсан үед
- Даавуу, хучлага зэргээр хэсэгчлэн бүрхэгдсэн зэргээр мэдрэх боломжтой объект ил харагдах металл гадаргуу багатай үед
- Мэдрэх боломжтой объект нь трактор, мотоциклын шаахай зэрэг онцгой хэлбэртэй үед
- Мэдрэх боломжтой автомашин хүртэлх зай хэт ойр болсон үед
- Мэдрэх боломжтой автомашин эгц урд биш тодорхой өнцөгт байгаа үед

- Мэдрэх боломжтой автомашинд цас, шавар зэрэг наалдсан үед
- Дараах төрлийн замаар жолоодох үед:
 - Огцом эргэлттэй эсвэл олон эргэлттэй зам
 - Огцом өгсүүр, огцом уруу зэрэг налуугийн хэмжээ өөрчлөгддөг зам
 - Нэг тал руугаа хазайсан замаар явах үед
 - Дугуйн мөрөөр хонхойсон зам дээр явах үед
 - Бартаа ихтэй, засвар үйлчилгээ хийгдээгүй зам
 - Энхэл донхол, овгор ихтэй зам
- Жолооны хүрдийг олон дахин эсвэл огцом эргүүлсэн үед
- Автомашин эгнээндээ тогтмол нэг байрлалд явахгүй үед
- Тус систем болон тоормос зэрэгтэй холбоотой эд ангиуд хүйтэн эсвэл хэт халсан, норсон үед
- Дугуйны тэнхлэг тохиргоо алдагдсан үед
- Цас, мөс тогтсон, хайрган хучилттай зэрэг замын гадаргуу хальтиргаатай үед
- Автомашины чиглэл эргэлтийн хэлбэрээс өөр үед
- Эргэлт рүү орох үеийн автомашины хурд хэт өндөр үед
- Авто зогсоол, гарааш, автомашины лифт зэрэгт орох/гарах
- Авто зогсоол дотор явах үед
- Өндөр өвс, модны мөчир, хөшиг зэрэг явах үед автомашинд хүрч болох эд зүйлстэй, газраар явах үед
- Хүчтэй салхитай үед
- Эгнээ хэт өргөн эсвэл хэт нарийн
- Эгнээгээ сольсон даруйд эсвэл уулзвараар нэвтэрсэн даруйд
- Түр зуурын эгнээ эсвэл зам засварын улмаас зохицуулалт хийгдэж буй уулзвараар
- Ойр орчимд замын эгнээ тусгаарлах зурвастай төстэй замын бүтэц, хээ, сүүдэр байгаа үед
- Нэг эгнээнд хэд хэдэн цагаан шугам байгаа үед
- Эгнээ тусгаарлах зурвас тод биш эсвэл нойтон замаар явах үед
- Замын эргэлттэй хэсэг дэх

тусгаарлах зурвас

- Бетонон зам зэрэг тод өнгөтэй, гэрэл ойлгодог замаар явах үед

■ Системийн зарим эсвэл бүх функц ажиллахгүй нөхцөлүүд

- Тус систем эсвэл тус системтэй холбоотой жолооны механизм, тоормос зэрэг эд ангиудад доголдол үүссэн үед
- VSC, Active TRC эсвэл бусад аюулгүйн системүүд ажиллаж байгаа үед
- VSC, Active TRC эсвэл бусад аюулгүйн системүүд унтраастай үед

■ Тоормосны ажиллагааны дуу, тоормосны дөрөөний хариу үйлдэл өөрчлөгдөх

- Тоормос ажиллах үед тоормосны механизмаас дуу гарч, тоормосны дөрөөний хариу үйлдэл өөрчлөгдөж болох ба эдгээр нь доголдол биш болно.
- Систем ажиллах үед тоормосны дөрөө илүү хатуу мэдрэгдэх эсвэл доош гишгэгдэж болно. Аль ч нөхцөлд дөрөөг үргэлжлүүлэн гишгэх боломжтой. Шаардлагатай үед дөрөөг нэмж гишгэнэ.

PCS (Pre-Collision System)

PCS нь мэдрэгчээр урд автомашиныг (→X.243)

таньдаг. Мөргөлдөх эрсдэл өндөр гэж систем тооцоолсон үед жолоочид мөргөлтөөс зайлсхийх анхааруулга өгөх мөн тоормосны хүчийг нэмэгдүүлэх замаар мөргөлтөөс зайлсхийх боломжийг олгодог. Мөргөлдөх магадлал туйлын өндөр гэж тооцоолсон үед мөргөлтөөс зайлсхийх эсвэл мөргөлтийн хүчийг багасгах зорилгоор автоматаар тоормослоно.

PCS системийг идэвхжүүлэх, идэвхгүй болгох боломжтой ба анхааруулга өгөх мөчийг өөрчлөн тохируулах боломжтой. (→X.255)

Нийлүүлэгдсэн улс, бүс нутгаас хамаарч ашиглах боломжтой функц өөр өөр байна. Дэлгэрэнгүйг мэдрэх боломжтой объект ба функцийн жагсаалтаас харна уу.



АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь жолоочийн үүрэг болно. Замын хөдөлгөөнд ямагт анхааралтай оролцоно.

Ямар ч тохиолдолд тоормосны оронд PCS систем ашиглахыг хориглоно. Тохиолдол бүрд мөргөлтөөс сэргийлэх, мөргөлтийн нөлөө, гэмтлийг бууруулж чадахгүй. Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.

**АЮУЛТАЙ**

- Системийн үндсэн зориулалт нь мөргөлтөөс зайлсхийх, мөргөлтийн нөлөөг бууруулах байдаг. Нөгөөтээгүүр тухайн байдлаас хамаарч системийн ажиллагаа өөр өөр байж болно. Тохиолдол бүрд системийн ажиллагааны үр дүн нэг ижил биш байж болно.

Дараах нөхцөлийг анхааралтай уншина уу. Системд хэт найдалгүй ямагт анхааралтай жолоодно.

- Ашиглалтын аюулгүй байдал: →Х.236

■ **PCS системийг цуцлах нөхцөл**

- PCS системийг цуцлах шаардлагатай нөхцөл: →Х.236

Мэдрэх боломжтой объектууд

Тус систем дараах объектуудыг таних боломжтой (Тухайн функцээс хамаарч таних боломжтой объект өөр байж болно):

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объектууд	Ашиглах боломжтой функцүүд	Улс/бүс нутаг
1	• Автомашин • Дугуйтай хүн^{*1} • Явган зорчигч • Мотоцикл^{*1} • Хана	Мөргөлтийн өмнөх тоормосны анхааруулга болон дэмжлэг, мөргөлтийн өмнөх тоормос, ослын жолоодлогын туслах, уулзвар дахь мөргөлтөөс зайлсхийх дэмжлэг, бага хурдтай үед огцом хурд авалт хязгаарлах функц, амортизаторын удирдлагын функц ^{*2}	Украин, Казахстан, Беларусь, Молдав, Орос (Баруун), Азербайжан, Гүрж, Киргиз, Армен, Бруней

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объектууд	Ашиглах боломжтой функцүүд	Улс/бүс нутаг
2	- Автомашин - Дугуйтай хүн^{*1} - Явган зорчигч - Мотоцикл^{*1}	Мөргөлтийн өмнөх анхааруулга, мөргөлтийн өмнөх тоормосны дэмжлэг, мөргөлтийн өмнөх тоормос болон амортизаторын удирдлагын функц ^{*2}	Камбож, Филиппин, Вьетнам, Малайз, Монгол, Аргентин, Гватемал, Коста Рика, Панам, Перу, Боливи, Гондурас, Доминика
3	Автомашин	Мөргөлтийн өмнөх анхааруулга, мөргөлтийн өмнөх тоормосны дэмжлэг, мөргөлтийн өмнөх тоормос болон амортизаторын удирдлагын функц ^{*2}	—

^{*1}: Зөвхөн хүн унаж яваа үед мэдрэх боломжтой объект гэж мэдэрнэ.

^{*2}: Тоноглогдсон загварт


Хүснэгтэд тэмдэглэгдсэн улс болон бүс нутгийн мэдээлэл нь 2023 оны 12-р сарын байдлаарх болно. Нөгөөтээгүүр тухайн нийлүүлэгдсэн автомашинаас хамаарч улс, бүс нутгийн мэдээлэл өөр байж болно. Та өөрийн Lexus дилерээс дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

Системийн функц


■ Мөргөлтийн өмнөх анхааруулга

Урд талаараа мөргөлдөх магадлалтай гэж систем тооцсон үед анхааруулах дохио дуугаран мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарч жолоочид мөргөлтөөс сэргийлэх арга хэмжээ авахыг сануулна.

Тухайн мэдэрсэн объект нь автомашин байвал анхааруулгатай хамт илүү хүчтэй тоормос хийгдэнэ.



Хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн гэж систем тооцоолсон үед мэдээллийн дэлгэц дээр дараах тэмдэг болон анхааруулга гарна.



■ Мөргөлтийн өмнөх тоормосны дэмжлэг

Автомашин урд талаараа мөргөлдөх магадлал өндөр гэж систем тооцоолсон үедээ тоормосны дөрөөг гишгэсэн хүчнээс илүү хүчээр тоормослуулна.

■ Мөргөлтийн өмнөх тоормос

Мөргөлдөх магадлал туйлын өндөр гэж систем тооцоолсон үед мөргөлтөөс зайлсхийх эсвэл мөргөлтийн хүчийг багасгахаар автоматаар тоормос ажиллуулна.

■ Ослын жолоодлогын туслах


Дараах нөхцөлүүд бүрдсэн гэж систем тооцоолсон үед тус функц жолооны хүрдний ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. Дэмжлэгийн явцад мэдээллийн дэлгэц дээр дараах анхааруулга гарна.

- Мөргөлдөх магадлал өндөр
- Тус эгнээнд саадаас зайлсхийх маневр хийх зай байгаа
- Жолооч жолоо эргүүлж байгаа

Идэвхтэй жолооны механизмын функцтэй автомашин: Жолоочийн хийсэн зайлсхийх үйлдлээс үл хамааран мөргөлтөөс зайлсхийх, мөргөлтийн хүчийг бууруулах үүднээс тоормос болон жолооны

механизмыг удирдана.

Дэмжлэгийн явцад мөргөлтийн өмнөх анхааруулга ба мэдээлэл мэдээллийн дэлгэц дээр гарна.




■ Уулзвар дахь мөргөлтөөс зайлсхийх дэмжлэг (баруун/зүүн эргэлт)


Дараах нөхцөлүүдэд урд талаараа мөргөлдөх магадлал өндөр гэж систем тооцоолсон үед тус функц анхааруулга өгөх ба шаардлагатай үед мөргөлтийн өмнөх тоормос хийнэ.

Уулзвараас хамаарч функц зөв ажиллахгүй байж болно.

- Эсрэг чиглэлийн автомашины урдуур баруун/зүүн эргэх




- Эргэж буй чиглэлийн зам руу явган зорчигч, унадаг дугуй орохоор чиглэж буйг систем мэдэрсэн



■ Уулзвар дахь мөргөлтөөс зайлсхийх дэмжлэг (хөндлөн чиглэлийн автомашин)

Уулзвар зэрэг дээр урдаас ирж буй автомашин, мотоциклтой мөргөлдөх магадлал туйлын өндөр гэж систем тооцоолсон үед мөргөлтийн өмнөх анхааруулга өгөх ба мөргөлтийн өмнөх тоормос хийнэ.


Уулзвараас хамаарч функц зөв ажиллахгүй байж болно.



■ Бага хурдтай үед огцом хурд авалтыг хязгаарлах функц

Бага хурдаар яваа үедээ хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн ба систем мөргөлт үүсэх магадлалтай гэж тооцоолсон нөхцөлд хөдөлгүүрийн хүчийг эсвэл хурд авалтыг хязгаарлах үүднээс тоормос автоматаар зөөлөн баригдана. Ажиллагааны явцад дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр анхааруулах индикатор болон

мэдээлэл гарна.



■ Амортизаторын удирдлагын функц (тоноглогдсон загварт)

Систем урд талаараа мөргөлдөх эрсдэл өндөр гэж тооцоолсон үед AVS (→X.422) автомашины зөв байрлалыг хадгалах үүднээс амортизаторын ажиллах хүчийг удирдана.

⚠ АЮУЛТАЙ

■ Мөргөлтийн өмнөх тоормос

- Мөргөлтийн өмнөх тоормосны функц ажиллах үед тоормос их хүчээр ажиллана.
- Мөргөлтийн өмнөх тоормос нь автомашиныг зогссон хэвээр барих зориулалтгүй. Тус системийн ажиллагаагаар автомашин зогссон үед шаардлагатай тохиолдолд тоормос гишгэнэ.
- Жолоочийн зарим үйлдлээс хамаарч мөргөлтийн өмнөх тоормос идэвхжихгүй байж болно. Жолооч хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн эсвэл жолооны хурд эргүүлсэн үед систем жолоочийг мөргөлтөөс зайлсхийх арга хэмжээ авсан гэж тооцоолон улмаар мөргөлтийн өмнөх тоормосыг идэвхжүүлэхгүй байж болно.



АЮУЛТАЙ

- Мөргөлтийн өмнөх тоормосны ажиллагааны явцад жолооч хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн тохиолдолд систем жолоочийг мөргөлтөөс зайлсхийх арга хэмжээ авсан гэж тооцоолон мөргөлтийн өмнөх тоормосны ажиллагааг цуцална.

■ Бага хурдтай үед огцом хурд авалтыг хязгаарлах функц

Жолооны хурд эргүүлсэн нөхцөлд систем жолоочийг мөргөлтөөс зайлсхийх арга хэмжээ авсан гэж тооцоолж бага хурдтай үед огцом хурд авалтыг хязгаарлах функц ажиллахгүй байх эсвэл ажиллагаа цуцлагдаж болно.

■ Ослын жолоодлогын туслах

- Эгнээнээс гарахаас сэргийлсэн функцийн ажиллагаа дууссан гэж систем тооцоолсон үед тус функцийн ажиллагаа цуцлагдана.
- Дараах нөхцөлүүдэд жолооч үйлдэл хийж байна гэж систем тооцоолон ослын жолоодлогын туслах функц ажиллахгүй байх эсвэл ажиллагаа цуцлагдана.
- Хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн, жолоог огцом эргүүлсэн, тоормос гишгэсэн эсвэл эргэх дохионы хөшүүргийг түлхсэн. Энэ нөхцөлд систем жолоочийг мөргөлтөөс зайлсхийх арга хэмжээ авч байна гэж тооцоолж ослын жолоодлогын туслах функцийг цуцална
- Зарим нөхцөлд ослын жолоодлогын туслах функц ажиллах явцад хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн, жолоог огцом эргүүлсэн, тоормос гишгэсэн нөхцөлд систем жолоочийг мөргөлтөөс зайлсхийх арга хэмжээ авч байна гэж тооцоолж ажиллагааг цуцална

- Ослын жолоодлогын туслах функц ажиллах үед жолооны хурдийг хөдөлгөөнгүй барьсан эсвэл систем хурдийг ажиллуулж байгаагаас эсрэг зүгт хурдийг эргүүлсэн үед функц цуцлагдана

■ PCS системийн функц тус бүрийн ажиллах нөхцөл

PCS систем идэвхэжсэн бөгөөд урд талаараа объектод мөргөлдөх магадлал өндөр гэж систем тооцоолсон үед

Нөгөөтээгүүр функц дараах нөхцөлүүдэд ажиллахгүй байж болно:

- Аккумуляторын шонг салгаад буцааж залгасны дараа автомашин тодорхой хугацаанд асаагүй үед
- Арааны хөшүүрэг R байрлалд байгаа үед
- VSC OFF индикатор ассан үед (зөвхөн мөргөлтийн өмнөх анхааруулах функц ажиллана)

Ажиллагааны хурд болон функц тус бүрийн ажиллагааны цуцлагдах нөхцөлийг дараах жагсаалтаар харуулав.

● Мөргөлтийн өмнөх анхааруулга

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Автомашин объект хоорондын харьцангуй хурд
1/2	Урд талд явж буй эсвэл зогсож буй автомашин	5-180 км/ц (3-110 миль/ц)-н хооронд	5-180 км/ц (3-110 миль/ц)-н хооронд
3	Урд талд явж буй эсвэл зогсож буй автомашин	10-180 км/ц (7-110 миль/ц)-н хооронд	10-180 км/ц (7-110 миль/ц)-н хооронд
1	Урдаас ирж буй автомашин	30-180 км/ц (20-110 миль/ц)-н хооронд	80-220 км/ц (50-130 миль/ц)-н хооронд
1/2	Унадаг дугуй	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд
1/2	Явган зорчигч	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд
1	Урд талд явж буй эсвэл зогсож буй мотоцикл	5-180 км/ц (3-110 миль/ц)-н хооронд	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд
2	Урд талд явж буй эсвэл зогсож буй мотоцикл	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд
1	Урдаас ирж буй мотоцикл	30-180 км/ц (20-110 миль/ц)-н хооронд	30-180 км/ц (20-110 миль/ц)-н хооронд

Мөргөлтийн өмнөх анхааруулгын функц ажиллах үед жолооны хүрдийг хүчтэй эсвэл огцом эргүүлбэл функцийг ажиллагаа цуцлагдана.

- Мөргөлтийн өмнөх тоормосны дэмжлэг

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Автомашин объект хоорондын харьцангуй хурд
1/2/3	Урд талд явж буй эсвэл зогсож буй автомашин	30-180 км/ц (20-110 миль/ц)-н хооронд	10-180 км/ц (7-110 миль/ц)-н хооронд
1/2	Унадаг дугуй	30-80 км/ц (20-50 миль/ц)-н хооронд	30-80 км/ц (20-50 миль/ц)-н хооронд
1/2	Явган зорчигч	30-80 км/ц (20-50 миль/ц)-н хооронд	30-80 км/ц (20-50 миль/ц)-н хооронд
1	Урд талд явж буй эсвэл зогсож буй мотоцикл	30-180 км/ц (20-110 миль/ц)-н хооронд	10-80 км/ц (7-50 миль/ц)-н хооронд
2	Урд талд явж буй эсвэл зогсож буй мотоцикл	30-80 км/ц (20-50 миль/ц)-н хооронд	10-80 км/ц (7-50 миль/ц)-н хооронд

● Мөргөлтийн өмнөх тоормос

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Автомашин объект хоорондын харьцангуй хурд
1/2	Урд талд явж буй эсвэл зогсож буй автомашин	5-180 км/ц (3-110 миль/ц)-н хооронд	5-180 км/ц (3-110 миль/ц)-н хооронд
3	Урд талд явж буй эсвэл зогсож буй автомашин	10-180 км/ц (7-110 миль/ц)-н хооронд	10-180 км/ц (7-110 миль/ц)-н хооронд
1	Урдаас ирж буй автомашин	30-180 км/ц (20-110 миль/ц)-н хооронд	80-220 км/ц (50-130 миль/ц)-н хооронд
1/2	Унадаг дугуй	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд
1/2	Явган зорчигч	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд
1	Урд талд явж буй эсвэл зогсож буй мотоцикл	5-180 км/ц (3-110 миль/ц)-н хооронд	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд
2	Урд талд явж буй эсвэл зогсож буй мотоцикл	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд	5-80 км/ц (3-50 миль/ц)-н хооронд
1	Урдаас ирж буй мотоцикл	30-180 км/ц (20-110 миль/ц)-н хооронд	30-180 км/ц (20-110 миль/ц)-н хооронд

Мөргөлтийн өмнөх тоормосны функц ажиллах үед дараах аль нэг үйлдлийг

хийвэл функцийн ажиллагаа цуцлагдана.

- Хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн
- Жолооны хүрдийг хүчтэй эсвэл огцом эргүүлсэн
- Ослын жолоодлогын туслах

Эргэх дохионы гэрэл анивчиж байгаа үед ослын жолоодлогын туслах функц ажиллахгүй.

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Автомашин объект хоорондын харьцангуй хурд
1	Урд талд явж буй эсвэл зогсож буй автомашин, унадаг дугуй, явган зорчигч, мотоцикл	40-80 км/ц (25-50 миль/ц)-н хооронд	40-80 км/ц (25-50 миль/ц)-н хооронд
1	Урд талд явж буй эсвэл зогсож буй автомашин, Дугуйтай хүн, Явган зорчигч, Мотоцикл	Идэвхтэй жолоодлогын функц (тоноглогдсон загварт): * 80 км/ц (*50 миль/ц) хүртэл	Идэвхтэй жолоодлогын функц (тоноглогдсон загварт): * 80 км/ц (*50 миль/ц) хүртэл

*: Автомашины хамгийн бага хурд: Мөргөлтийн өмнөх тоормосны удирдлагаар мөргөлтөөс зайлсхийхэд хүндрэлтэй автомашины хурд

Ослын жолоодлогын туслах функц ажиллаж байгаа үед дараах аль нэг үйлдлийг хийвэл функцийн ажиллагаа цуцлагдана:

- Хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн
- Жолооны хүрдийг хүчтэй эсвэл огцом эргүүлсэн
- Тоормосны дөрөөг гишгэсэн
- Уулзвар дахь мөргөлтөөс зайлсхийх дэмжлэг (баруун/зүүн эргэлт)

Эргэх дохионы гэрэл асаагүй үед уулзвар дахь мөргөлтөөс зайлсхийх дэмжлэг (баруун/зүүн эргэлт) ажиллахгүй.

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Урдаас ирж буй автомашины хурд	Автомашин объект хоорондын харьцангуй хурд
1	Урдаас ирж буй автомашин	5-40 км/ц (3-25 миль/ц)-н хооронд	5-75 км/ц (3-45 миль/ц)-н хооронд	10-115 км/ц (7-70 миль/ц)-н хооронд
1	Явган зорчигч	5-30 км/ц (3-20 миль/ц)-н хооронд	—	5-40 км/ц (3-25 миль/ц)-н хооронд
1	Унадаг дугуй	5-30 км/ц (3-20 миль/ц)-н хооронд	—	5-50 км/ц (3-30 миль/ц)-н хооронд
1	Урдаас ирж буй мотоцикл	5-40 км/ц (3-25 миль/ц)-н хооронд	5-75 км/ц (3-45 миль/ц)-н хооронд	10-115 км/ц (7-70 миль/ц)-н хооронд

● Уулзвар дахь мөргөлтөөс зайлсхийх дэмжлэг (хөндлөн чиглэлийн автомашин)

► Урд хажуу радаргүй автомашин

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Урдаас ирж буй автомашины хурд	Автомашин объект хоорондын харьцангуй хурд
1	Автомашин, Мотоцикл (хажуу)	5-60 км/ц (3-38 миль/ц)-н хооронд	- Таны автомашины хурднаас бага 40 км/ц (25 миль/ц)-с бага	5-60 км/ц (3-38 миль/ц)-н хооронд

► Урд хажуу радартай автомашин

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Урдаас ирж буй автомашины хурд	Автомашин объект хоорондын харьцангуй хурд
1	Автомашин, Мотоцикл (хажуу)	5-60 км/ц (3-38 миль/ц)-н хооронд	50 км/ц (31 миль/ц)-с бага	5-60 км/ц (3-38 миль/ц)-н хооронд

PCS-н хувилбар 1: 40 км/ц (29 миль/ц)-с их хурдтай үед тус систем нөгөө автомашины хурд 40 км/ц (29 миль/ц) бага үед зөвхөн ажиллана.

PCS-н хувилбар 1: Тус систем хөндлөн чиглэлийн автомашины хурд таны автомашинтай адил эсвэл бага хурдтай үед зөвхөн ажиллана.

● Бага хурдтай үед огцом хурд авалт хязгаарлах функц

Эргэх дохионы гэрэл асаж байгаа үед функц ажиллахгүй.

PCS-н хувилбар	Мэдрэх боломжтой объект	Автомашины хурд	Автомашин объект хоорондын харьцангуй хурд
1	Урд талд явж буй эсвэл зогсож буй автомашин, явган зорчигч, унадаг дугуй, хана	0-15 км/ц (0-9 миль/ц)-н хооронд	0-15 км/ц (0-9 миль/ц)-н хооронд

PCS-н хувилбар 1: Бага хурдтай үед огцом хурд авалт хязгаарлах функц ажиллах үед дараах аль нэг үйлдэл хийгдсэн үед тус функцийг ажиллагаа цуцлагдана:

- Хаазны дөрөө сулласан
- Жолооны хүрдийг хүчтэй эсвэл огцом эргүүлсэн


■ Мэдрэх боломжтой объект

Систем нь хэмжээ, харагдах байдал, хөдөлгөөнөөр объектыг таньдаг.


Нөгөөтээгүүр орчны хүчтэй гэрэл, хөдөлгөөн, объектын байрлал, объектын өнцөг зэрэг хэвийн таних ажиллагааг алдагдуулах зүйлсээс хамаарч объектыг танихгүй байж болно.

Систем дараах хэлбэрүүдийг мэдрэх боломжтой объект гэж үзнэ.

- PCS-н хувилбар 1




- PCS-н хувилбар 2




■ Мөргөлт үүсэх магадлал байхгүй байсан ч систем ажиллаж болзошгүй нөхцөлүүд


- Дараах нөхцөлүүдэд систем мөргөлдөх магадлалтай гэж тооцоолон ажиллаж болзошгүй:
 - Мэдрэх боломжтой объект зэргийн хажуугаар гарах эсвэл зөрж өнгөрөх үед
 - Эгнээ байраа өөрчлөнгөө мэдрэх боломжтой объект зэргийг гүйцэж түрүүлэх үед
 - Мэдрэх боломжтой объектод огцом ойртох үед
 - Мэдрэх боломжтой объектод эсвэл замын хашлага, шон, мод, хана зэрэг замын хажууд байрлах бусад объект руу ойртох үед
 - Замын эргэлттэй хэсэг дээр мэдрэх боломжтой объект эсвэл бусад объект байгаа үед




- Урд талд таних боломжтой объекттой андуурагдах дүрс, хэлбэр байгаа үед
- Эгнээ сольж байгаа эсвэл баруун/зүүн эргэж буй объектыг гүйцэж түрүүлэх үед



- Баруун, зүүн эргэлт хийхээр зогсож буй мэдрэх боломжтой объектын хажуугаар өнгөрөх үед




- Мэдрэх боломжтой объект ойртож ирээд таны зорчиж буй эгнээнд орохын өмнө зогсолт хийсэн
- Аливаа объект (замын тэмдэг, зар сурталчилгааны самбар зэрэг)-н доогуур гарах үед




- Замын төлбөрийн цэг, авто зогсоолын болон бусад нээгдэж хаагддаг хаалтад ойртох үед
- PCS-н хувилбар 1: Баруун/зүүн эргэлт хийх үед тухайн зам дээр эсрэг чиглэлийн автомашин, явган зорчигч байгаа үед
- PCS-н хувилбар 1: Эсрэг чиглэлийн автомашин, явган зорчигч ойр байгаа үед баруун/зүүн эргэлт хийх үед
- PCS-н хувилбар 1: Эсрэг чиглэлийн автомашин, мотоцикл, явган зорчигч, унадаг дугуй тухайн эргэж буй зам руу оролгүй зогсож байгаа үед баруун/зүүн эргэлт хийх үед

- PCS-н хувилбар 1: Эсрэг чиглэлийн автомашин баруун/зүүн эргэлт хийж байгаа үед баруун/зүүн эргэлт хийх үед



- PCS-н хувилбар 1: Эсрэг чиглэлээс ирж буй автомашины чиглэлд жолооны хүрдийг эргүүлэх үед
- PCS-н хувилбар 1: Замын дээгүүр эсвэл доогуур объект хөдөлж байгаа үед




■ Систем хэвийн ажиллахгүй байх магадлалтай нөхцөлүүд


- Дараах нөхцөлүүдэд урд мэдрэгч объектыг танихгүй байх улмаар систем хэвийн ажиллахгүй байх магадлалтай:
- Объект таны автомашин руу ойртон ирж байгаа үед
- Таны автомашин эсвэл объект савлаж байгаа үед
- Мэдрэх боломжтой объект огцом маневр (огцом эргэх, хурд нэмэх, хасах зэрэг) хийсэн үед
- Мэдрэх боломжтой объект руу огцом ойртсон үед
- Мэдрэх боломжтой объект хана, хашаа, замын хашлага, траншейны таг, автомашин, зам дээрх төмөр лист зэргийн ойр орчимд байгаа үед
- Мэдрэх боломжтой объект аливаа байгууламжийн доор байгаа үед
- Том ачаа тээш, цүнх, шүхэр, замын хашлага зэрэгт мэдрэх боломжтой

объект нь хэсэгчлэн халхлагдсан үед

- Таних боломжтой олон объект нэг дор байгаа үед
- Мэдрэх боломжтой объект дээр нар эсвэл хүчтэй гэрэл тусч байгаа үед
- Мэдрэх боломжтой объект цагаан өнгөтэй, хүчтэй гэрэлтэй үед
- Мэдрэх боломжтой объект орчны өнгөтэй адил өнгөтэй үед
- Мэдрэх боломжтой объект огцом урдуур орох, огцом ойртох үед
- Ойртож буй автомашин ташуу өнцгөөс ойртож буй үед
- Урд талд хүүхдийн, том овортой ачаа ачсан, 2-с олон хүнтэй, онцгой хэлбэртэй унадаг дугуй (хүүхдийн суудалтай, tandem унадаг дугуй зэрэг.) байгаа үед
- Явган зорчигч, унадаг дугуйтай хүний өндөр 1 м (3.2 фут)-с бага эсвэл 2 м (6.5 фут)-с өндөр үед
- Явган зорчигч, унадаг дугуйтай хүн том овортой хувцас (борооны цув, урт банзал зэрэг), өмссөн ба энэ нь харагдах байдлыг бүдгэрүүлж байгаа үед
- Явган зорчигч урагш тонгойсон эсвэл явган сууж байгаа, дугуйтай хүн урагш тонгойсон үед
- Явган зорчигч, дугуйтай хүн хурдтай хөдөлж байгаа
- Явган зорчигч хүүхдийн тэрэг, тэргэнцэр, унадаг дугуй бусад тээврийн хэрэгсэл түрж байгаа үед
- Үүр, үдшийн бүрэнхий, шөнө, туннел дотор зэрэг бүдэг гэрэлтэй орчинд мэдрэх боломжтой объектын өнгө орчны ойролцоо үед
- Хөдөлгүүр асаасны дараа тодорхой хугацаанд автомашиныг жолоодоогүй, хөдөлгөөгүй үед
- Зүүн/баруун эргэлт хийснээс хэдхэн секундйн дараа зүүн/баруун эргэлт дахин хийх үед
- Замын эргэлттэй хэсгээр явснаас хэдхэн секундйн дараа дахин замын эргэлттэй хэсгээр явах үед
- PCS-н хувилбар 1: Баруун/зүүн эргэлт хийж буй эсрэг чиглэлийн автомашинаас 1-с олон эгнээний зайтай эгнээгээр явж байгаа үед
- PCS-н хувилбар 1: Баруун/зүүн эргэлт хийх үед эсрэг чиглэлийн автомашин зайтай байгаа үед



- PCS-н хувилбар 1: Явган зорчигч автомашины хойд эсвэл хажуу талаас ойртох үед баруун/зүүн эргэлт хийх



- Уулзвар дээр ойртож буй автомашин нь том ачааны машин, чиргүүл чирсэн машин зэргээр урт тээврийн хэрэгсэл байгаа үед
- PCS-н хувилбар 1: Дээрхээс гадна дараах зарим нөхцөлд ослын жолоодлогын туслах ажиллахгүй байж болно.
- Мэдрэх боломжтой объект хэр ойр үед
- Автомашиныг чиглүүлэх боломжтой хангалттай аюулгүй зай эсвэл саадгүй зай байхгүй үед
- Урдаас автомашин ирж байгаа үед
- PCS-н хувилбар 1: Дээр дурдсанаас гадна зарим нөхцөлүүдэд систем ханыг объект гэж мэдрэхгүй байх улмаар бага хурдад огцом хурд авалтыг хязгаарлах функц ажиллахгүй байж болно:
- Шилэн хаалга, төмөр тор зэргээр хана нэвт харагддаг үед
- Хана налуу эсвэл намхан байх үед
- Хана нарийн үед
- Бутлаг ургамал зэрэг ургамлаар хийгдсэн хана
- Зам хана дээр ойж байгаа
- Ташуу өнцгөөр хана руу ойртох үед

Мөргөлтийн өмнөх системийн тохиргоо өөрчлөх

- Өөрчлөх боломжтой тохиргоогоор мөргөлтийн өмнөх системийг идэвхжүүлэх/цуцлах боломжтой. (→X.593)

Асаах товчийг ON горимд шилжүүлэх бүрд систем идэвхэжнэ.

- Системийн ажиллагааг цуцалсан үед PCS анхааруулах гэрэл асаж мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.
- Мөргөлтийн өмнөх системийн тохиргоог өөрчлөх боломжтой тохиргоогоор өөрчлөх боломжтой. (→X.593)
- Идэвхтэй жолооны механизмын функцгүй автомашин: Мөргөлтийн өмнөх анхааруулга өгөх хугацааг өөрчилсөн үед ослын үеийн жолооны механизмын дэмжлэг ажиллах хугацаа мөн өөрчлөгдөнө. “Later”-г сонгосон үед ослын үеийн жолооны механизм ихэнх тохиолдолд ажиллахгүй.
- Идэвхтэй жолооны механизмын функцтэй автомашин: Мөргөлтийн өмнөх анхааруулга өгөх хугацааг өөрчилсөн үед ослын үеийн жолооны механизмын дэмжлэг (идэвхтэй жолооны механизм хамаарахгүй) ажиллах хугацаа мөн өөрчлөгдөнө. “Later”-г сонгосон үед ослын үеийн жолооны механизм (идэвхтэй

жолооны механизм
хамаарахгүй) ихэнх
тохиолдолд ажиллахгүй.

- Динамик радарын хурд баригч ажиллах үед мөргөлтийн өмнөх анхааруулгын ажиллах хугацаа нь хэрэглэгчийн хийсэн тохиргооноос үл хамааран “Earlier” горимоор ажиллана.

LTA (Lane Tracing Assist) систем

LTA функц

- Эгнээ байр тусгаарлах тод зурвастай зам дээр динамик радарын хурд баригч ашиглан зорчих үед урд камер болон радарын мэдрэгчээр урд талын замын эгнээ болон ойр орчмын автомашиныг мэдрэх ба автомашиныг тухайн эгнээнд барих үүднээс жолооны хүрдийг ажиллуулдаг.


Тус функцийг зөвхөн хурдны зам, шулуун зам дээр ашиглана.

Динамик радарын хурд баригч ажиллаагүй үед тус функц ажиллахгүй.

Замын түгжрэл зэргээр эгнээ тусгаарлах зурвас сайн харагдахгүй, огт харагдахгүй үед урд талын болон ойр орчмын автомашины явж буй чиглэл дээр үндэслэн тус функцийн дэмжлэг ажиллана.


Жолооны хүрдийг тодорхой хугацаанд эргүүлээгүй эсвэл чанга бариагүй үед функц жолоочид анхааруулга өгөх ба функцийн ажиллагаа цуцлагдана.

Жолооны хүрдийг чанга барих үед функц дахин ажиллаж эхэлнэ.



- Функц ажиллаж байгаа ба автомашин эгнээнээс гарах магадлалтай үед функц дэлгэц дээр мэдээлэл гарган дуут дохио өгч жолоочид анхааруулна.

Дохио дуугарах үед автомашины ойр орчмыг шалгах ба автомашиныг эгнээний голд буцаах байдлаар жолооны хүрдийг эргүүлнэ.



АЮУЛТАЙ

■ LTA систем ашиглахын өмнө

- LTA системд хэт найдаж болохгүй. LTA систем нь автомашиныг автоматаар жолооддог эсвэл урд талын замын нөхцөл байдалд хандуулах анхаарлыг бууруулах боломж бүрдүүлдэг систем биш юм. Хүрээлэн байгаа орчны байдалд анхаарал хандуулах мөн замын чиглэл, байдалд тохируулан жолооны хүрдтэй харьцах замаар жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг цаг ямагт бүрэн хангах үүрэгтэй. Мөн урт хугацаанд жолоо барин ядарсан үедээ хангалттай амралт авна.
- Буруу жолоодлого хийх, анхаарал болгоомж алдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.
- LTA систем ашиглаагүй үед LTA товчоор системийг унтраана.

■ Функцийн ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед энэ функц ажиллана:

- LTA систем замын эгнээ, урд талын болон ойр орчимд явж байгаа автомашины явж буй эгнээг таньсан
- Динамик радарын хурд баригч ажиллаж байгаа
- Эгнээний өргөн 3-с 4 м (10-с 13 фут) орчим байгаа
- Эргэх дохионы хөшүүргийг түлхээгүй
- Автомашин огцом эргэлттэй замаар яваагүй
- Автомашины хурдыг тодорхой хэмжээнээс давуулан нэмээгүй, хасаагүй
- Жолооны хүрдийг их хүчээр эргүүлээгүй
- Жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга (→X.258) ажиллаагүй байгаа
- Автомашин эгнээний голоор явж байгаа

■ Функц түр цуцлагдах

- Функцийн ажиллагааны нөхцөл хангагдаагүй үед функц түр хугацаанд цуцлагдаж болно. Ажиллагааны нөхцөл дахин бүрдсэн үед функцийн ажиллагаа автоматаар идэвхэжнэ. (→X.257)
- Функц ажиллах явцад ажиллагааны нөхцөл алдагдвал функцийн ажиллагаа түр цуцлагдсаныг илтгэж дохио дуугарна.
- Функцийн жолооны хүрдний дэмжлэгийн ажиллагаа жолоочийн жолооны хүрд эргүүлэх үед зогсоно.


■ LTA ажиллах үеийн эгнээнээс гарах гэж буйг анхааруулах функцийн ажиллагаа

- LDA функцийн анхааруулга өгөх хэлбэрийг жолооны хүрдний чичиргээ болгон өөрчилсөн эсэхээс үл хамааран LTA функц ажиллах явцад автомашин эгнээнээс хазайх үед дохио дуугарч жолоочид анхааруулга өгнө.
- Эгнээ солиход шаардагдах хэмжээ-

ний хүчээр жолооны хүрд эргүүлсэн үед систем автомашиныг эгнээнээс хазайгаагүй гэж тооцоолох ба анхааруулга ажиллахгүй.

■ Жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга

- Систем жолоочийг жолооны хүрднээс бариагүй гэж тооцоолсон үед жолооны хүрднээс барихыг анхааруулсан анхааруулга болон зурагт үзүүлсэн тэмдэг мэдээллийн дэлгэц дээр гарна. Систем жолоочийг жолооны хүрднээс барьсныг таньсан үед анхааруулга унтарна. Тус системийг ашиглах үед анхааруулга гарсан эсэхээс үл хамааран жолооны хүрднээс гараа салгаж болохгүй.



- Тодорхой хугацаанд жолооны хүрдийг ажиллуулаагүй үед анхааруулга үргэлжлэн гарах ба тус функцийг ажиллагаа түр хугацаанд цуцлагдана. Анхааруулга нь жолооч жолооны хүрдийг бага хэмжээгээр үргэлжлүүлэн ажиллуулах үед мөн гарч болно.

■ Жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга хэвийн ажиллахгүй нөхцөлүүд

- Автомашин, замын гадаргуугийн байдал, жолооны хүрдтэй хэрхэн харьцаж байгаа зэргээс хамаарч тус функц ажиллахгүй байж болно.
- LCA системтэй автомашин: Дараах нөхцөлүүдэд систем жолооч жолооны хүрднээс бариагүйг таних боломжгүй байж болно.
 - Жолооны хүрдэд бүрээс хийсэн
 - Жолооч бээлий өмссөн
 - Жолооны хүрдэд гадны биет наалдсан
 - Жолооч жолооны хүрдний модон


оруулга, арьсан бүрээсний залгаас болон мэдрэгчгүй бусад хэсгээс барьсан

- LCA системтэй автомашин: Дараах нөхцөлүүдэд жолооч жолооны хүрднээс бариагүй байсан ч жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга ажиллахгүй байж болох ба LTA функц хэвийн ажиллахгүй:
 - Жолооны хүрдэнд гараас өөр зүйл хүрсэн байгаа
 - Жолооны хүрдийг гарын шуу эсвэл урт зүйлээр дарсан

Функцийг идэвхжүүлэх, цуцлах

LTA товч дарах бүрд тус функцийг ажиллагаа ON/OFF тохиргоонд солигдоно.

LTA функц ON үед LTA индикатор асна.




АЮУЛТАЙ

■ Функци хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд функц хэвийн ажиллахгүй байж болох бөгөөд автомашин эгнээнээсээ гарч болно. Тус функцэд хэт найдалгүйгээр ойр орчмынхоо аюулгүй байдалд цаг ямагт анхаарал хандуулан жолооны хүрдээр эгнээ, чиглэлээ засаж жолоодно.

! АЮУЛТАЙ

- Урд талын эсвэл ойр орчмын автомашин эгнээгээ сольсон. (Урд талын эсвэл ойр орчмын автомашиныг дагаж таны автомашин эгнээгээ сольж болно)



- Урд талын эсвэл ойр орчмын автомашин зам хэрэн явж байгаа үед. (Таны автомашин мөн зам хэрэх улмаар эгнээнээс гарч болно)
- Урд талын эсвэл ойр орчмын автомашин эгнээнээс гарсан. (Урд талын эсвэл ойр орчмын автомашиныг дагаж таны автомашин эгнээнээс гарч болно)
- Урд талын эсвэл ойр орчмын автомашин зүүн/баруун зурваст хэт ойр явж байгаа үед. (Урд талын эсвэл ойр орчмын автомашиныг дагаж таны автомашин эгнээнээс гарч болно)
- Ойр орчимд хөдөлж буй объект, эд зүйл байгаа үед. (Автомашин болон тухайн объект, эд зүйлийн харьцангуй байрлалаас хамаарч таны автомашин замаас хазайж болно)
- Автомашин хөндлөн салхи, зэрэгцээ эгнээний автомашинаас үүссэн салхинд цохигдсон.
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд: →Х.240
- Эгнээ тусгаарлах зурвас танигдахгүй байж болох нөхцөлүүд: →Р.244
- Системийг цуцлах шаардлагатай нөхцөлүүд: →Х.236

Жолооны хүрдний дэмжлэгийн ажиллагааны дэлгэц

LTA системийн ажиллагааг харуулна.

Индикатор	Эгнээний дэлгэц	Жолооны хүрдний тэмдэг	Нөхцөл байдал
 Цагаан	 Саарал/ Цагаан	 Саарал	LTA функц хүлээлгийн горимд байгаа
 Ногоон	 Ногоон	 Ногоон	LTA функц ажиллаж байгаа
 Шаргал Анивчих	 Шаргал Анивчих	 Ногоон	Эгнээний дэлгэц анивчиж буй тал руу автомашин эгнээнээсээ гарч байгаа

LCA (Lane Change Assist) систем*

* Тоноглогдсон загварт


Үндсэн функц

Тус функц нь LTA системтэй уялдаатай ажилладаг ба жолооны хурд ажиллуулан эгнээ солиход дэмжлэг үзүүлдэг.

Тус функцийг зөвхөн шулуун зам, хурдны зам дээр ашиглана.

Жолооч жолооны хурд эргүүлэх үед системийн ажиллагаа түр зогсоно.

Эгнээ солиход туслах систем нь уулзвар дээр эгнээ солиход дэмжлэг үзүүлдэггүй.



⚠ АЮУЛТАЙ

■ LCA систем ашиглахын өмнө

● LCA системд хэт найдаж болохгүй.

LCA систем нь автомашины автоматаар жолооддог эсвэл урд талын замын нөхцөл байдалд хандуулах анхаарлыг бууруулах боломж бүрдүүлдэг систем биш юм. Хүрээлэн байгаа орчны байдалд анхаарал хандуулах мөн замын чиглэл, байдалд тохируулан жолооны хурдтай харьцах замаар жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг цаг ямагт бүрэн хангах үүрэгтэй.

Шилжиж болохгүй эгнээ (эсрэг урсгал, замын хөвөө зэрэг) рүү LCA систем ашиглан орж болохгүй.

● Буруу жолоодлого хийх, анхаарал болгоомж алдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ Функцийн ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед энэ функц ажиллана:

- LTA систем ажиллаж байгаа
- Өөрчлөх боломжтой тохиргоогоор эгнээ солиход туслах функцийг идэвхжүүлсэн
- Автомашины хурд 80-140 км/ц (50-85 миль/ц) хооронд байгаа
- Систем тухайн замыг шулуун зам, хурдны зам гэж таньсан
- Систем шилжин орох гэж буй эгнээ нь тасархай зураастай гэж таньсан
- Эргэх дохионы хөшүүргийг түлхсэн талд автомашин байхгүй гэж систем таньсан
- Навигацийн системийн газрын зургийн мэдээлэл зөв
- Жолооны хурдийг их хүчээр эргүүлээгүй
- Жолооны хурднээс гар салгасныг анхааруулах анхааруулга (→X.258) ажиллаагүй
- Хөдөлгүүр асааснаас хойш

автомашины ар талд 1-с их явж буй автомашин байгааг систем таньсан

■ Функция түр цуцлагдах


Дараах нөхцөлүүдэд ажиллаж буй LCA-н ажиллагаа цуцлагдаж жолоочид анхааруулах мэдээлэл болон дохио өгнө:

- Ажиллагааны нөхцөл (→Х.257) алдагдсан
- Систем эгнээ тусгаарлах шугам таних боломжгүй байгаа
- Эргэх дохионы хөшүүргийг хагас түлхсэн (→Х.262)
- Эргэх дохионы хөшүүргийг солих гэж буй эгнээний эсрэг чиглэлд түлхсэн
- Жолооч жолооны хүрд эргүүлсэн, тоормос, хааз гишгэсэн
- Жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга (→Х.262) ажилласан

Эргэх дохионы хөшүүргийг түлхсэн талаар бусад автомашин хурдтай ойртож буйг систем мэдэрсэн нөхцөлд анхааруулга гарч дохио дуугаран жолоочид анхааруулна. Энэ үед ойртож буй автомашинаас зайлсхийх үүднээс жолооны хүрд бага зэрэг эргэж болно.

■ Жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга

Систем жолоочийг жолооны хүрднээс бариагүй гэж тооцоолсон үед жолооны хүрднээс барихыг анхааруулсан анхааруулга болон зурагт үзүүлсэн тэмдэг мэдээллийн дэлгэц дээр гарна. Систем жолоочийг жолооны хүрднээс барьсныг таньсан үед анхааруулга унтарна. Тус системийг ашиглах үед анхааруулга гарсан эсэхээс үл хамааран жолооны хүрднээс гараа салгаж болохгүй.




■ Жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга хэвийн ажиллахгүй нөхцөлүүд

- Автомашин, замын гадаргуугийн байдал, жолооны хүрдтэй хэрхэн харьцаж байгаа зэргээс хамаарч тус функция ажиллахгүй байж болно.
- Дараах нөхцөлүүдэд систем жолооч жолооны хүрднээс бариагүйг таних боломжгүй байж болно.
 - Жолооны хүрдэд бүрээс хийсэн
 - Жолооч бээлий өмссөн
 - Жолооны хүрдэд гадны биет наалдсан
 - Жолооч жолооны хүрдний модон оруулга, арьсан бүрээсний залгаас болон мэдрэгчгүй бусад хэсгээс барьсан
- Дараах нөхцөлүүдэд жолооч жолооны хүрднээс бариагүй байсан ч жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга ажиллахгүй байж болох ба LCA функция хэвийн ажиллахгүй:
 - Жолооны хүрдэнд гараас өөр зүйл хүрсэн байгаа
 - Жолооны хүрдийг гарын шуу эсвэл урт зүйлээр дарсан

LCA системийг ажиллуулах

Эргэх дохионы хөшүүргийг бүрэн түлхсэн үед эгнээ солих дэлгэц гарч систем ажиллаж эхэлнэ.

LCA систем ашиглалгүйгээр эргэх дохионы хөшүүргийг бүрэн түлхэн эгнээ солих үед өөрчлөх боломжтой тохиргоогоор LCA системийг унтраана.



1 Бүрэн түлхэх (1): LCA ажиллана

2 Хагас түлхэх (2): LCA ажиллахгүй

⚠ АЮУЛТАЙ

■ **LCA системийг ашиглаж болохгүй нөхцөлүүд**

- Нэг эгнээтэй замаар явах үед
- Солих гэж буй эгнээ талд тасархай зураас байхгүй үед

Функцийг идэвхжүүлэх, цуцлах

Өөрчлөх боломжтой тохиргоогоор идэвхжүүлэх, цуцлах боломжтой. (→Х.593)

Дэлгэц ба системийн ажиллагаа

LCA системийн ажиллагааг харуулна.

LCA дэлгэц	Жолооны хүрдний тэмдэг	Нөхцөл
 Саарал сум, ногоон шугам	 Ногоон	LCA функц хүлээлгийн горимд байгаа
 Цэнхэр сум, цагаан шугам		LCA функц ажиллаж байгаа
	 Саарал	LCA ажиллах явцад автомашин ойртон ирсэн
Хоосон	 Саарал	LCA ажиллах явцад тусгаарлах шугам танигдаагүй

LDA (Lane Departure Alert) систем

Үндсэн функц

LDA систем нь автомашин тухайн явж буй эгнээ, чиглэлээс* гарч болзошгүйг жолоочид анхааруулах ба жолооны хүрдийг ажиллуулах замаар эгнээ, чиглэлээ* хадгалах боломжийг бүрдүүлдэг.

Урд камер ашиглан замын эгнээ, чиглэлээ* танина.

*: Өвс, шороо, эргэлт зэрэг замын хажуу тал болон засмал замын зааг хэсэг

■ Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах функц


Систем автомашиныг тухайн зорчиж буй эгнээ эсвэл чиглэлээс* гарах магадлалтай гэж тооцоолсон үед мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гаргах ба анхааруулах дохио дуугаргах эсвэл жолооны хүрд чичрэх байдлаар жолоочид мэдэгдэнэ.

Анхааруулах дохио дуугарсан үед орчны байдлыг нягтлаад жолооны хүрдийг болгоомжтой эргүүлэн автомашиныг эгнээнд нь буцаана.

Автомашин хажуу эгнээний автомашинтай мөргөлдөх магадлал өндөр байна гэж систем тооцоолсон үед эргэх дохионы хөшүүрэг түлхсэн байсан ч эгнээнээс гарах гэж буйг анхааруулах анхааруулга ажиллана.

*: Өвс, шороо, эргэлт зэрэг замын хажуу тал болон засмал замын

зааг хэсэг




■ Эгнээнээс гарахаас сэргийлэх функц

Систем автомашиныг тухайн зорчиж буй эгнээ эсвэл чиглэлээс* гарч байна гэж тооцоолсон үед эгнээ, чиглэлээс* гарахаас сэргийлж жолооны хүрдний дэмжлэг үзүүлнэ.

Систем жолоочийг тодорхой хугацаанд жолооны хүрд эргүүлээгүй, чанга бариагүй гэж тооцоолсон үед жолооны хүрднээс барих анхааруулга гарч дохио дуугарч жолоочид анхааруулна.


Автомашин хажуу эгнээний автомашинтай мөргөлдөх магадлал өндөр байна гэж систем тооцоолсон үед эргэх дохионы хөшүүрэг түлхсэн байсан ч эгнээнээс гарахаас сэргийлэх функц ажиллана.

*: Өвс, шороо, эргэлт зэрэг замын хажуу тал болон засмал замын зааг хэсэг



■ Амралт санал болгох функц

Автомашин савласан, зам хэрсэн үед анхааруулга гарч дохио дуугаран жолоочид амрахыг сануулна.



⚠ АЮУЛТАЙ

■ LDA систем ашиглахын өмнө

● LDA системд хэт найдаж болохгүй. LDA систем нь автомашины автоматаар жолооддог эсвэл аюулгүй жолоодлогод шаардагдах анхаарлыг бууруулах боломж бүрдүүлдэг систем биш юм. Хүрээлэн байгаа орчны байдалд анхаарал хандуулах мөн замын чиглэл, байдалд тохируулан жолооны хүрдтэй харьцах замаар жолооч хөдөлгөөний аюулгүй байдлыг цаг ямагт бүрэн хангах үүрэгтэй. Мөн урт хугацаанд жолоо барин ядарсан үедээ хангалттай амралт авна.

● Буруу жолоодлого хийх, анхаарал болгоомжоо алдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ Функц тус бүрийн ажиллах нөхцөлүүд

● Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах/гарахаас сэргийлэх функц

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед энэ функц ажиллана:

- Автомашины хурд 50км/ц (30 миль/ц)-с дээш

Эгнээний ойр орчимд бусад автомашин, мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч мэдрэгдсэн үед 40 км/ц (25 миль/ц)-с дээш хурдтай үед функц ажиллаж болно.

- Систем эгнээ байр, чиглэлийг таньж байгаа (Систем зөвхөн нэг талыг таньж байгаа үед зөвхөн тухайн талын систем ажиллана.)
- Зорчих хэсгийн эгнээний өргөн 3 м (9.8 фут)-с дээш
- Эргэх дохионы хөшүүрэг ажиллуулаагүй

(Эргэх дохионы хөшүүргийг ажиллуулсан талын эгнээнд өөр автомашин байгаагаас бусад үед)

- Автомашин огцом эргэлтэй замаар

- яваагүй үед
- Автомашины хурд тодорхой хэмжээнээс ихээр нэмэгдээгүй мөн хасагдаагүй
- Жолооны хүрдийг эгнээ солиход хангалттай хэмжээний хүчээр эргүүлээгүй
- VSC эсвэл TRC систем ажиллаагүй
- *: Өвс, шороо, эргэлт зэрэг замын хажуу тал болон засмал замын зааг хэсэг

■ Функци түр цуцлагдах

Функцийн ажиллагааны нөхцөл хангагдаагүй үед функц түр хугацаанд цуцлагдаж болно. Ажиллагааны нөхцөл дахин бүрдсэн үед функцийн ажиллагаа автоматаар идэвхэжнэ. (→Х.265)


■ Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах/ гарахаас сэргийлэх функцийн ажиллах нөхцөл

- Автомашины хурд, эгнээнээс гарч байгаа өнцөг, замын нөхцөл зэргээс хамаарч ажиллагаа жолоочид мэдэгдэхгүй байх эсвэл функц огт ажиллахгүй байж болно.
- Өөрчлөх боломжтой тохиргоогоор анхааруулгын төрлийг чичиргээ болгон тохируулсан ч тухайн байдлаас хамаарч дохио дуугарч болно.
- Эгнээ байр, чиглэл* сайн харагдахгүй эсвэл шулуун биш үед эгнээнээс гарах гэж буйг анхааруулах, гарахаас сэргийлэх функц ажиллахгүй байж болно.
- Явган зорчигч, зогсож буй автомашиныг тойрох зорилгоор жолоо эргүүлсэн гэж систем тооцоолсон үед эгнээнээс гарах гэж буйг анхааруулах, гарахаас сэргийлэх функц ажиллахгүй байж болно.
- Хажуу эгнээний автомашинтай мөргөлдөх эрсдэл байгаа үед систем аюулыг мэдрэхгүй байж болно.
- Жолооч жолооны хүрд эргүүлэх үед функцийн жолооны механизмын удирдлага дарагдана.

*: Өвс, шороо, эргэлт зэрэг замын хажуу тал болон засмал замын зааг хэсэг

■ Жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга

Дараах нөхцөлд жолоочид жолооны хүрд эргүүлэхийг анхааруулсан анхааруулга болон дараах зурагт үзүүлсэн тэмдэг гарна. Тус системийг ашиглах үед анхааруулга гарсан эсэхээс үл хамааран жолооны хүрднээс гараа салгаж болохгүй.



- Жолооч жолооны хүрднээс чанга бариагүй эсвэл эгнээнээс гарахаас сэргийлэх функц идэвхжиж тус функцийн жолооны хүрдний дэмжлэг ажиллах үед жолооны хүрдийг эргүүлээгүй гэж систем тооцсон үед

Жолооны хүрдний дэмжлэгийн ажиллах давтамж нэмэгдэхийн хэрээр анхааруулах дохионы дуугарах хугацаа уртасна. Жолооны хүрд эргүүлсэн гэж систем тооцсон үед ч дохио тодорхой хугацаанд дуугарна.

■ Амралт санал болгох функц

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед энэ функц ажиллана:

- Автомашины хурд 65 км/ц (40 миль/ц)-с дээш^{*1}
 - Автомашины хурд 50 км/ц (32 миль/ц)-с дээш^{*2}
 - Эгнээний өргөн 3 м (9.8 фут)-с их
- Автомашин болон замын байдлаас хамаарч амралт санал болгох функц ажиллахгүй байж болно.



Хянах самбарын удирдлагын  товч дарж анхааруулгыг унтраана.*1

Амралт санал болгох функцийн тус анхааруулга  товч дарах хүртэл дэлгэц дээр үргэлжлэн гарна.*1

*1: Украин, Беларусь, Молдав, Азербайжан, Армен, Гүрж, Казахстан, Киргиз, Орос, Латин Америкийн орнууд, Карибын тэнгисийн орнууд

*2: Украин, Беларусь, Молдав, Азербайжан, Армен, Гүрж, Казахстан, Киргиз, Орос, Латин Америкийн орнууд, Карибын тэнгисийн орнуудаас бусад

LDA тохиргоо өөрчлөх

- Өөрчлөх боломжтой тохиргоогоор LDA системийг идэвхжүүлэх, цуцлах

боломжтой. (→X.593)

- Өөрчлөх боломжтой тохиргоогоор LDA системийн тохиргоог өөрчлөх боломжтой. (→X.593)

АЮУЛТАЙ

■ Систем хэвийн ажиллахгүй байх магадлалтай нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд функц хэвийн ажиллахгүй байж болох бөгөөд автомашин эгнээнээсээ гарч болно. Функцэд хэт найдалгүй ойр орчмынхоо аюулгүй байдалд цаг ямагт анхаарал хандуулан жолооны хүрдээр эгнээ, чиглэлээ засаж жолоодно.

- Замын хашлага, хаалт зэрэг засмал зам болон зүлэг, шороо бусад объект хоорондын зааг сайн харагдахгүй эсвэл шулуун үед
- Автомашин хөндлөн салхи, ойр орчим дахь бусад автомашины салхинд цохигдсон үед
- Эгнээг таних боломжгүй нөхцөлүүд: →P.244
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцөлүүд: →X.240
- Системийн зарим болон бүх функц ажиллахгүй нөхцөлүүд: →X.242
- Системийг цуцлах шаардлагатай нөхцөлүүд: →X.236

Дэлгэц болон системийн ажиллагаа

Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах, гарахаас сэргийлэх функцийн ажиллагааны байдлыг дараах байдлаар харуулав.

Индикатор	Эгнээний дэлгэц	Жолооны хурдний тэмдэг	Нөхцөл байдал
 Шаргал Асах	Асаагүй	Асаагүй	Систем цуцлагдсан
Асаагүй	 Саарал	Асаагүй	Эгнээ тусгаарлах зурвас системд танигдахгүй байгаа
Асаагүй	 Цагаан	Асаагүй	Эгнээ тусгаарлах зурвас системд танигдсан
 Шаргал Асах	 Шаргал Асах	Асаагүй	Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах функц эгнээний дэлгэц анивчиж байгаа талд ажиллаж байгаа
 Ногоон	 Ногоон	 Ногоон	Эгнээнээс гарахаас сэргийлэх функц эгнээний дэлгэц асаж байгаа талд ажиллаж байгаа
 Шаргал Асах	 Шаргал Асах	 Ногоон	Эгнээнээс гарах гэж буйг анхааруулах/ гарахаас сэргийлэх функц эгнээний дэлгэц анивчиж байгаа талд ажиллаж байгаа

PDA (Proactive driving assist) жолоодлогод туслах систем*

* : Тоноглогдсон загварт

Мэдрэх боломжтой объект (→X.270) мэдрэгдсэн үед PDA жолоодлогод туслах систем нь тоормос болон жолооны хүрд ажиллуулж автомашиныг объектод хэт ойртохоос сэргийлэхэд тусална.



АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

Аюулгүй жолоодлого хийх нь жолоочийн үүрэг хариуцлага юм.

- PDA систем нь энгийн тоормос, жолооны хүрдний ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдрэгдсэн объектод хэт ойртохоос сэргийлэхэд туслах зориулалттай систем болно. Нөгөөтээгүүр системийн үзүүлэх дэмжлэг хязгаартай.

Жолооч шаардлагатай үед тоормосолж жолооны хүрдээ эргүүлнэ. Дараах зүйлсийг сайтар уншина. PDA системд хэт найдалгүйгээр цаг ямагт анхаарал болгоомжтой жолоодно. (→X.271)

- PDA нь аюулгүй жолоодлогод шаардагдах анхаарлыг бууруулах боломж олгодог систем биш болно. Систем зөв ажилласан ч орчны нөхцөл байдлыг жолооч болон систем өөрөөр таньж болно. Жолооч анхаарал болгоомжтой байж эрсдэлийг үнэлэн аюулгүй жолоодох шаардлагатай. Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- PDA нь анхаарал болгоомжгүй жолоодлого хийх, үзэгдэх орчин муутай үед автомат жолоодлого хийх систем биш юм. Жолооч нь орчны нөхцөлд байдалд анхаарлаа хандуулж аюулгүй жолоодлого хийх үүрэгтэй.

■ PDA системийг унтраах үед

- Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцөлүүд: →X.240
- Системийг цуцлах шаардлагатай нөхцөлүүд: →X.236

Систем ажиллах нөхцөл ба мэдрэх боломжтой объект

Жолоодлогын нөхцөлд нийцүүлэн PDA системийн мэдрэх боломжтой объект дараах байдлаар өөрчлөгдөнө.

Функц	Нөхцөл байдал	Ажиллагаа	Мэдрэх боломжтой объект
Саадыг урьдчилан таамаглах дэмжлэг	Мэдрэх боломжтой объект зам хөндлөн гарч байгаагаар мэдрэгдсэн	Мөргөлдөх эрсдэлийг бууруулж тоормосны зарим ажиллагааны дэмжлэг үзүүлнэ.	• Явган зорчигч • Унадаг дугуй
	Мэдрэх боломжтой объект замын хажуу талд мэдрэгдсэн	Объектод хэт ойртохоос сэргийлэхэд туслах үүднээс орчны нөхцөлд нийцүүлэн зарим тоормос, жолооны хүрдний ажиллагааны дэмжлэг үзүүлнэ.	• Явган зорчигч • Унадаг дугуй • Зогсоолд зогссон автомашин
		Жолооны хүрдний дэмжлэг нь автомашин тухайн эгнээнээс гарахааргүй хэмжээнд хийгдэнэ.	
Хурд хасах үеийн дэмжлэг	Урд автомашин байгаа эсвэл хажуу талын автомашин урдуур орж ирсэн гэж мэдрэгдсэн	Автомашин хоорондын зай хэт ойртохоос сэргийлж автомашин хурдаа зөөлөн хасна.	• Урд талын автомашин • Мотоцикл
	Автомашин урд талд эргэлт мэдрэгдсэн	Эргэлт рүү ороход автомашины хурд хэт өндөр гэж тооцсон үед автомашин хурдаа зөөлөн хасна.	Байхгүй
Жолооны хүрдний дэмжлэг (тус функцтэй автомашин)	Эгнээ, тусгаарлах зурвас мэдрэгдсэн	Систем жолоочийн үйлдлийг таамаглан жолооны хүрдний ажиллагааг дэмжинэ.	Байхгүй

■ Систем ажиллах автомашины хурд

- Мэдрэх боломжтой объект зам хөндлөн гарах үеийн дэмжлэг
30 - 60 км/ц (20 - 35 миль/ц) орчим
- Мэдрэх боломжтой объект замын хажуу талд байгаа үеийн дэмжлэг
30 - 60 км/ц (20 - 35 миль/ц) орчим
- Урд талд автомашин байгаа үеийн хурд хасах дэмжлэг

20 км/ц (15 миль/ц) ба түүнээс их

- Эргэлт дээр хурд хасах дэмжлэг

20 км/ц (15 миль/ц) ба түүнээс их

- Эгнээн доторх жолооны хүрдний дэмжлэг

10 - 140 км/ц (5 - 80 миль/ц) орчим

■ Системийн ажиллагаа цуцлагдах нөхцөл

- Дараах нөхцөлүүдэд системийн ажиллагаа цуцлагдана:
 - Динамик радарын хурд баригч

- эсвэл хурд баригч ажиллаж байгаа
- PCS унтарсан
- Системийн зарим болон бүх функц ажиллахгүй нөхцөлүүд: →X.242
- Арааны P, R эсвэл N байрлал сонгогдсон үед
- Дараах нөхцөлүүдэд тоормосны ажиллагааны дэмжлэг цуцлагдана:
 - Хурд 15 км/ц (9 миль/ц)-с бага
 - Автомашин тодорхой хурдад хүрсэн ба орчны нөхцөлд үндэслэн систем үйлдэл хийсэн үед
- Дараах нөхцөлүүдэд системийн ажиллагаа цуцлагдаж болно:
 - Тоормосны удирдлага эсвэл жолоодлогод туслах системийн хүч хязгаарлах удирдлага ажиллах үед (Жишээ: PCS, хөдөлгөөн эхлэх удирдлага)
 - Мэдрэгдсэн объект автомашинаас холдсон гэж систем тооцсон үед
 - Эгнээ тусгаарлах шугам танигдахаа больсон үед
 - Тоормосны дөрөө гишгэсэн
 - Хаазны дөрөө гишгэсэн
 - Тодорхой хүчнээс давуулан жолооны хүрдийг эргүүлсэн
 - Эргэх дохионы хөшүүргийг баруун/зүүн эргүүлсэн



АЮУЛТАЙ

■ Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд

- Замын эгнээ байр танигдахгүй байх нөхцөлүүд: →P.244
- Мэдрэгдсэн объект таны автомашин явж буй зам руу орохын өмнө зогссон үед
- Замын хашлага, хашаа зэргийн цаана буй мэдрэх боломжтой объектын хажуугаар хэт ойр өнгөрөх үед
- Мэдрэх боломжтой объектыг гүйцэж түрүүлэнгээ эгнээ солих үед

- Эгнээгээ сольж буй эсвэл баруун, зүүн эргэж байгаа мэдрэх боломжтой объектын хажуугаар өнгөрөх үед
- Ойр орчимд бусад объект (замын хашлага, цахилгааны шон, мод, хана, хашаа, шон, замын конус, шуудангийн хайрцаг зэрэг) байгаа
- Мэдрэх боломжтой объект гэж буруу танигдаж болох зураг, дүрс автомашины урд талд байгаа
- Замын дээр нам байрлах зүйлийн доогуур гарах (нам таазтай хонгил, замын тэмдэг, зарлалын самбар зэрэг)
- Цас мөстэй, эвдрэлтэй замаар явах
- Мэдрэх боломжтой объект таны автомашин руу ойртох үед
- Таны автомашин эсвэл мэдрэх боломжтой объект зам хэрэн явж байгаа
- Мэдрэх боломжтой объектын хөдөлгөөн өөрчлөгдсөн (чиглэл өөрчлөгдөх, огцом хурд нэмэх, хасах зэрэг)
- Мэдрэх боломжтой объектод огцом ойртох үед
- Урд талын автомашин, мотоцикл нь чанх урд талд байхгүй үед
- Мэдрэх боломжтой объектын дээд талд байгууламж байгаа үед
- Мэдрэх боломжтой объект хэсэгчлэн өөр эд зүйлийн (том ачаа тээш, шүхэр, замын хашлага зэрэг) ард халхлагдсан үед
- Мэдрэх боломжтой хэд хэдэн объект давхцаж байгаа үед
- Нарны туяа бусад автомашины их гэрэл зэрэг хүчтэй гэрэл мэдрэх боломжтой объектоос ойх үед
- Мэдрэх боломжтой объект цагаан өнгөтэй бөгөөд хэт тод харагдаж байгаа үед



АЮУЛТАЙ

- Мэдрэх боломжтой объектын өнгө, гэрлийн хэмжээ нь түүнийг ойр орчимд нь уусгаж байгаа үед
- Мэдрэх боломжтой объект таны автомашины урдуур огцом орох, хажуу талаас ойртох үед
- Таны автомашинаас 90 хэм эсвэл тодорхой өнцөгт байгаа, таны автомашин руу харсан автомашин руу ойртох үед
- Зогсоолд байрлуулсан автомашин таны автомашинаас 90 хэм эсвэл тодорхой өнцөгт байгаа
- Урд талд хүүхдийн, том овортой ачаа ачсан, 2-с олон хүнтэй, онцгой хэлбэртэй унадаг дугуй (хүүхдийн суудалтай, тандем унадаг дугуй зэрэг) байгаа үед
- Явган зорчигч, унадаг дугуйтай хүний өндөр 1 м (3.2 фут)-с бага эсвэл 2 м (6.5 фут)-с өндөр үед
- Явган зорчигч, унадаг дугуйтай хүн том овортой хувцас (борооны цув, урт банзал зэрэг), өмссөн ба энэ нь харагдах байдлыг бүдгэрүүлж байгаа үед
- Явган зорчигч урагш тонгойсон эсвэл явган сууж байгаа, дугуйтай хүн урагш тонгойсон үед
- Явган зорчигч, дугуйтай хүн хурдтай хөдөлж байгаа
- Явган зорчигч хүүхдийн тэрэг, тэргэнцэр, унадаг дугуй бусад тээврийн хэрэгсэл түрж байгаа үед

- Үүр, үдшийн бүрэнхий, шөнө, туннел дотор зэрэг бүдэг гэрэлтэй орчинд таних боломжтой объектын өнгө орчны ойролцоо үед
- Эгнээ 4 м (13.1 фут)-с өргөн үед
- Эгнээний өргөн 2.5 м (8.2 фут)-с бага үед
- Хөдөлгүүр асаасны дараа тодорхой хугацаанд автомашиныг жолоодоогүй, хөдөлгөөгүй үед
- Зүүн/баруун эргэлт хийснээс хэдхэн секундийн дараа зүүн/баруун эргэлт дахин хийх үед
- Эгнээ солих эсвэл эгнээ сольсноос хэдхэн секундийн дараа эгнээ солих үед
- Замын эргэлттэй хэсгээр явснаас хэдхэн секундийн дараа дахин замын эргэлттэй хэсгээр явах үед

PDA системийн тохиргоо өөрчлөх

- PDA системийн тохиргоог өөрчлөх боломжтой тохиргоогоор идэвхжүүлэх/цуцлах боломжтой. (→X.594)
- PDA системийн дараах тохиргоог өөрчлөх боломжтой тохиргоогоор өөрчлөх боломжтой. (→X.594)

Системийн ажиллагааны дэлгэц

Тухайн байдлаас хамаарч дараах индикатор, тэмдэг дэлгэц дээр

гарна.


Дэлгэцийг жолоодлогын аюулгүй байдлыг дэмжих функцийг мэдээллийн дэлгэцэд шилжүүлээгүй үед зарим тэмдэг гарахгүй.

Тэмдэг	Утга
	- Цагаан: Мэдрэх боломжтой объектыг монитор хийх - Ногоон: Мэдрэх боломжтой объект замын хөндлөн гарч байгаа эсвэл мэдрэх боломжтой объект замын хажуу талд байгаа үеийн дэмжлэг ажиллаж байгаа
	Явган зорчигч зам хөндлөн гарч байгаа эсвэл замын хажууд байгаа гэж танигдсан ба тоормос, жолооны хүрдний дэмжлэг ажиллаж байгаа
 	Автомашин замын хажууд байгаа гэж танигдсан ба тоормос, жолооны хүрдний дэмжлэг ажиллаж байгаа
	- Замын хажуу талд байгаа мэдрэх боломжтой объектод хэт ойртохоос сэргийлж жолооны хүрдний ажиллагааны дэмжлэг ажилласан - Жолооны хүрдний дэмжлэгтэй автомашин: Жолооны хүрдний дэмжлэг ажиллах үед
	Урд талд автомашин байгаа үеийн хурд хасах дэмжлэг ажилласан
	Тохиромжтой автомашин хоорондын зайг хадгалах анхааруулга
	Эргэлтийн үеийн хурд хасах дэмжлэг ажилласан

■ Жолооны хүрднээс гар салгасныг анхааруулах анхааруулга

Дараах нөхцөлүүдэд систем жолоочийг жолооны хүрднээс бариагүй гэж тооцоолон жолооны хүрднээс барихыг анхааруулсан анхааруулга болон зурагт үзүүлсэн

тэмдэг мэдээллийн дэлгэц дээр гарна. Систем жолоочийг жолооны хүрднээс барьсныг таньсан үед анхааруулга унтарна. Тус системийг ашиглах үед анхааруулга гарсан эсэхээс үл хамааран жолооны хүрднээс гараа салгаж болохгүй.



- Мэдрэх боломжтой объект замын хөндлөн гарч байгаа эсвэл мэдрэх боломжтой объект замын хажуу талд байгаа үеийн дэмжлэг ажилласан ба систем жолоочийг жолооны хүрднээс бариагүй гэж тооцсон үед.

Тодорхой хугацаанд жолооны хүрдийг ажиллуулаагүй үед анхааруулга үргэлжлэн гарна. Тус анхааруулга жолооч жолооны хүрдийг бага хэмжээгээр үргэлжлүүлэн ажиллуулах үед мөн гарч болно.

- **Урд талд автомашин байгаа үеийн хурд хасах дэмжлэгийн ажиллагаа дууссан үед өгөх анхааруулга**

Урд талд автомашин байгаа үеийн хурд хасах дэмжлэгийн ажиллагаа дууссан ч жолооч тоормос, хаазны дөрөө гишгээгүй ба урд талын автомашинд дахин ойртох үед дэлгэц анивчин дохио дуугарч жолоочид хурд хасах анхааруулга өгнө. Жолооч тоормос, хааз гишгэсэн гэж систем тооцоолсон үед анхааруулга цуцлагдана.



FCTA (Front Cross Traffic Alert) функц*

*: Тоноглогдсон загварт

Бага хурдаар уулзвар луу ойртох үед автомашины урдуур баруун эсвэл зүүнээс ойртож буй автомашиныг мэдрэн жолоочид анхааруулна.

FCTA системийн удирдлага

- Уулзварт ойртох үед автомашины урдуур баруун эсвэл зүүн талаас автомашин ойртох үед дэлгэц дээр мэдээлэл гарна.
- HUD дэлгэц



- Урд зүүн эсвэл баруун талаас автомашин ойртож байгаа ба таны автомашиныг уулзварт орох гэж байна гэж систем тооцоолсон үед дохио дуугарч дэлгэц дээр мэдээлэл гаран тоормос гишгэхийг сануулна.
- Мэдээллийн дэлгэц



АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

Аюулгүй жолоодлого нь жолоочийн үүрэг хариуцлага юм. Ойр орчмын байдлыг нягтлан жолоодлогын аюулгүй байдлыг хангана. FCTA систем нь урд баруун, зүүн талаас автомашин ойртож буйг мэдээлдэг туслах систем юм.

Системийн ажиллагаанд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай. Анхааруулгын дэлгэцийн заалт нь бодит замын хөдөлгөөний нөхцөлөөс өөр байж болно. Анхааруулгын дэлгэц нь тодорхой хугацааны унтрах ч энэ нь таны автомашины ойр орчимд бусад автомашин, явган зорчигч байхгүй болсныг бүрэн илэрхийлэхгүй.

■ FCTA системийн ажиллах нөхцөл


Тус систем дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Арааны Р эсвэл R-с бусад байрлал сонгогдсон
- Автомашины хурд 15 км/ц (10 миль/ц)-с бага
- Автомашины урдуур баруун эсвэл зүүн талаас 10 - 60 км/ц (7 - 37 миль/ц) хурдтай автомашин ойртож байгаа
- Автомашины чанх урд талд өөр автомашин байхгүй байгаа
- Хаазны дөрөөг хүчтэй гишгээгүй
- Тоормосны дөрөөг хүчтэй гишгээгүй үед

■ Автомашин ойртож ирээгүй ч систем ажиллаж болзошгүй нөхцөлүүд

Доор дурдсан зэрэг зарим нөхцөлүүдэд автомашин ойртож ирээгүй байсан ч систем ажиллаж болно:

- Замын хашлага, замын тэмдэг, шон, замын гэрэлтүүлэг, мод, өндөр өвс, хана зэрэг замын хажууд байрлах объект руу ойртох үед
- Зогсоолд байрлуулсан автомашин зэрэг замын хажууд байгаа объектын хажуугаар өнгөрөх үед
- Зайтай байгаа баруун, зүүн урдаас ойртож буй бусад автомашин, явган зорчигч байгаа үед
- Зорчиж буй эгнээний хажууд байрлах авто зогсоол зэргийн дотор бусад автомашин, явган зорчигч явж байгаа үед
- Явган хүний замаар явган зорчигч, унадаг дугуйтай хүн ойртож байгаа үед
- Автомашин, явган зорчигч таны автомашинаас холдон явж байгаа үед
- Ойртож буй автомашин хурдаа хасаж байгаа, зогссон үед
- Ойртож буй автомашин таны урд талд баруун/зүүн эргэлт хийсэн үед
- Явган зорчигч таны автомашин руу ойртож байгаа үед
- Урдаас ирж буй автомашин баруун/зүүн эргэлт хийсэн үед
- Баруун, зүүн урд талаас бусад автомашин ойртохоос өмнө таны автомашин уулзварт нэвтэрсэн үед
- Гэрлэн дохио дээр зогссон үед баруун, зүүн урд талаас автомашин ойртсон үед
- Ойртож буй автомашины урдуур баруун, зүүн эргэлт хийсэн үед




- Урдаас ирж буй автомашин ойртож ирээд хажуугаар зөрж өнгөрсөн үед
- Өөр автомашин хажуугаар гүйцэж түрүүлэх үед
- Өөр автомашин, явган зорчигчтой зэрэгцэн явах үед
- Өөр автомашин, явган зорчигч автомашины хажуу тал руу ойртох үед

■ Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд бусад автомашин урд хажуугийн радарын мэдрэгчид мэдрэгдэхгүй байх улмаар систем хэвийн ажиллахгүй байж болно:

- Ойртож буй автомашин огцом хөдөлсөн (огцом эргэсэн, хурд нэмсэн, хассан зэрэг)



- Баруун, зүүн урд талаас автомашин ташуу өнцгөөр ойртон ирсэн үед
- Баруун, зүүн урд талаас ойртож буй автомашин зайтай үед
- Таны болон ойртож буй автомашин хооронд эд зүйл байгаа үед
- Хоорондоо бага зайтайгаар хэд хэдэн автомашин зэрэг ойртох үед
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцөлүүд: →Х.240
- Системийн зарим болон бүх функц ажиллахгүй нөхцөлүүд: →Х.242

FCTA тохиргоо өөрчлөх

- Өөрчлөх боломжтой тохиргоогоор FCTA-г идэвхжүүлэх, цуцлах боломжтой. (→Х.593)
- Өөрчлөх боломжтой тохиргоогоор FCTA-н дараах тохиргоог өөрчлөх боломжтой. (→Х.593)

RSA (Road Sign Assist) систем*

*: Тоноглогдсон загварт

► Европоос бусад

RSA систем нь урд камераар тодорхой төрлийн замын тэмдгүүдийг таньж дэлгэц болон дуут дохиогоор жолоочид анхааруулга өгдөг.

► Европ

RSA систем нь урд камер таньсан замын тэмдэг, навигацийн системийн замын тэмдгийг дэлгэц болон дуут дохиогоор жолоочид анхааруулга өгдөг.

Серверт холбогдсон навигацийн системтэй (навигацийн систем суурилагдсан): Хурдны дээд хязгаарын мэдээллийг зөв гаргах үүднээс газрын зургийг* тогтмол шинэчлэх шаардлагатай.

*: Шинэчлэлийн тухай дэлгэрэнгүйг “Мультимедиа гарын авлага”.



АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

Европоос бусад:

- Аюулгүй жолоодлого нь жолоочийн үүрэг хариуцлага юм. Ойр орчмын байдлыг сайтар нягтлан жолоодлогын аюулгүй байдлыг хангана.

Европ:

- RSA дэлгэц, анхааруулах дохио, хурдны дээд хязгаарын мэдээллийг систем өгч байгаа эсэхээс үл хамааран замын хөдөлгөөний дүрмийг баримтлан аюулгүй жолоодлого хийх нь жолоочийн үүрэг юм. Тиймээс системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй. Ойр орчмын байдлыг сайтар нягтлан жолоодлогын аюулгүй байдлыг хангана.

- RSA системд хэт найдаж болохгүй. RSA нь замын тэмдгийн мэдээллийг жолоочид өгөх туслах систем боловч жолооч тэмдгийг өөрөө харах үйлдлийг орлохгүй. Аюулгүй жолоодох нь жолоочийн хариуцлага болно. Ойр орчмын байдлыг нягтлан жолоодлогын аюулгүй байдлыг хангана.

■ RSA ашиглаж болохгүй нөхцөлүүд

Системийг цуцлах шаардлагатай нөхцөлүүд: →Х.236

■ Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд

Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцөлүүд: →Х.240

Дэлгэцийн функц

► Европоос бусад

- Урд камер тэмдэг мэдрэх үед тэмдэг дэлгэц дээр гарна.

► Европ

- Урд камер тэмдэг мэдрэх эсвэл навигацийн системд замын тэмдгийн мэдээлэл байгаа үед тэмдэг дэлгэц дээр гарна.
- Нэгэн зэрэг хэд хэдэн тэмдэг гарч болно.

Автомашинь техник үзүүлэлтээс хамаарч дэлгэцээр гаргах

боломжтой тэмдгийн дээд тоо хязгаартай байж болно.

■ Тэмдгийн дэлгэцийн ажиллах нөхцөл

Дараах нөхцөлүүд бүрдсэн үед тэмдэг дэлгэц дээр гарна:

- Систем тэмдэг таньсан

Дараах нөхцөлүүдэд дэлгэцээр гарч байгаа тэмдэг унтарна:

- Тодорхой зайнд шинэ тэмдэг танигдаагүй
- Баруун, зүүн эргэсэн зэргээр тухайн явж буй зам солигдсон гэж систем тооцсон үед

■ Дэлгэцийн функц хэвийн ажиллахгүй байх нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд RSA систем хэвийн ажиллахгүй ба замын тэмдэг танихгүй байх эсвэл буруу тэмдэг дэлгэцээр гаргаж болно. Нөгөөтээгүүр энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.

- Замын тэмдэг бохирдсон, бүдэг, хазайсан, нугарсан
- Электрон замын тэмдгийн өнгөний ялгарал муу
- Замын тэмдэг бүхэлдээ, хэсэгчлэн мод, шон зэргээр халхлагдсан
- Урд камерт замын тэмдэг богино хугацаанд харагдсан
- Жолоодлогын байдлыг (эргэсэн, эгнээ сольсон зэрэг) систем буруу таньсан
- Уулзвараар нэвтэрсэн даруйд байрлах, эгнээ нийлэхээс өмнө наана байгаа тэмдэг
- Урд талын автомашины хойд талд наалт наасан
- Систем таних боломжтой тэмдэгтэй төстэй тэмдэг таних боломжтой тэмдэг гэж танигдсан
- Урд замын хурдны дээд хязгаарын тэмдэг нь урд камерын илрүүлэх хязгаарт байгаа үед
- Тойрог замаар явах үед
- Ачааны машин зэрэгт зориулсан тэмдэг танигдсан

Европ:

- Замын хөдөлгөөний эсрэг урсгалтай улс орноор явж байгаа үед

- Навигацийн системийн газрын зургийн мэдээлэл хуучирсан
- Навигацийн систем ашиглах боломжгүй байгаа.

Энэ нөхцөлд мэдээллийн дэлгэц болон наavigацийн системийн дэлгэц дээр хурдны дээд хязгаарын тэмдгийн заалт өөр байж болно.

Мэдэгдлийн функц

Дараах нөхцөлүүдэд RSA систем анхааруулга гаргаж жолоочид мэдэгдэл өгнө.

- Дэлгэцээр гарч буй хурдны дээд хязгаарын тэмдгээс автомашины хурд давсан үед тэмдэг тодоор гарч дохио дуугарна.

Европ:

Автозамын өөр цагийн бүсэд нэвтэрсэн үед хурдны дээд хязгаар болон бусад тэмдэг илүү тодоор гарах ба дохио дуугаран* жолоочид анхааруулга өгнө.*

*: Эдгээр функц нь тухайн зорчиж буй улсаас хамаарч өөр байна.

- RSA систем орох хориотой тэмдэг таньсан, наavigацийн систем дээр тус тэмдэгтэй бүсэд нэвтэрснийг мэдэрсэн үед мэдээллийн дэлгэц дээр тус тэмдэг гарах ба дохио дуугарч жолоочид анхааруулга өгнө. (Навигацийн системтэй автомашин)

■ Мэдэгдлийн функцийн ажиллах нөхцөл

● Хэт хурдны мэдэгдлийн функц
Тус функц дараах нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Систем хурдны дээд хязгаарын тэмдэг таньсан.
- Орох хориотой тэмдэг анхааруулах функц (Европ)

Тус функц дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Систем 1-с их орох хориотой тэмдгийг таньсан
- Автомашин орох хориотой тэмдгийн хажуугаар нэвтэрсэн
- Навигацийн системд орох хориотой тэмдгийн мэдээлэл байгаа

Систем дэмждэг замын тэмдгийн төрлүүд

- Дараах төрлийн замын тэмдгийг дэлгэцээр гаргах боломжтой.

Нөгөөтээгүүр стандарт бус, саяхан шинээр гарсан замын тэмдгийг гаргах боломжгүй.

► Европоос бусад



Хурдны дээд хязгаар

► Европ

- Хурдны дээд хязгаар тэмдэг*



Хурдны хязгаар/Хурдны дээд хязгаар эхлэх



Хурдны хязгаар/Хурдны дээд хязгаар дуусах

*: Хурдны дээд хязгаарыг тэмдэг

танигдаагүй эсвэл мэдээлэл байхгүй үед тэмдэг гарна.

- Хурдны дээд хязгаартай холбоотой мэдээлэл*^{1, 2}



Шулуун замын эхлэл



Шулуун замын төгсгөл



Хурдны зам



Хурдны замын гарц



Суурин газрын эхлэл



Суурин газрын төгсгөл



Хороолол



Хорооллын төгсгөл

*¹: Замын тэмдэг танигдсан боловч наavigацийн систем дээр хурдны дээд хязгаарын мэдээлэл байхгүй үед гарна.

*²: Замын тэмдэг танигдаагүй эсвэл наavigацийн систем дээр хурдны дээд хязгаарын мэдээлэл байхгүй үед тэмдэг гарна.

- Гүйцэж түрүүлэхийг хориглох тэмдэг



Гүйцэж түрүүлэхийг хориглох тэмдгийн эхлэх



Гүйцэж түрүүлэхийг хориглох тэмдгийн төгсгөл

- Бусад замын тэмдэг



Орох хориотой



Бүх хязгаарлалтын бүсийн төгсгөл



Зогс



Анхааруулах тэмдэг

- Замын нэмэлт тэмдэгтэй хурдны хязгаар^{*1}



Мөстэй



Замын нэмэлт тэмдэг^{*2}



Гарц баруун талд



Гарц зүүн талд



Цагийн хязгаарлалттай

^{*1}: Хурдны дээд хязгаарын тэмдэгтэй хамт гарна

^{*2}: Контент танигдаагүй.

- Автомашины техник

үзүүлэлтээс хамаарч замын тэмдэг давхардаж гарч болно.



Замын тэмдэг давхардах жишээ

RSA тохиргоо өөрчлөх

- RSA системийн дараах тохиргоог өөрчлөх боломжтой тохиргоогоор өөрчлөх боломжтой. (→X.595)

Динамик радарын хурд барих систем

Динамик радарын хурд баригч нь урд талд автомашин байгааг мэдрэн автомашин хоорондын зайг тогтоож, тохиромжит хоорондын зайг барих зорилгоор ажилладаг. Автомашин хоорондын зайг хүссэнээрээ тохируулах боломжтой.

Динамик радарын хурд баригчийг зөвхөн хурдны болон шулуун зам дээр ашиглана.



АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

● Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь жолоочийн үүрэг болно. Системд хэт найдалгүй ойр орчны нөхцөл байдалд анхаарал хандуулан аюулгүй жолоодно.

● Динамик радарын хурд баригч нь автомашины жолоодлогыг дэмжих замаар жолоочид ирэх ачааллыг бууруулахад туслах систем юм. Нөгөөтээгүүр системийн үзүүлэх дэмжлэг хязгаартай.

Дараах нөхцөлүүдийг сайтар уншина. Системд хэт найдалгүй цаг ямагт анхааралтай жолоодно.

Систем хэвийн ажиллахгүй нөхцөлүүд: →Х.287

● Хурдны хязгаар, замын ачаалал, зам болон цаг агаарын байдал зэрэгт нийцүүлэн тохирох хурдыг сонгоно. Жолооч тохируулсан хурдыг нягтлах үүрэгтэй.

● Системийн хэвийн ажиллагааны үед ч урд талын автомашины хөдөлгөөнийг жолооч болон систем өөр өөрөөр хүлээн авч болох тул жолооч анхаарал болгоомжтой байх, боломжит аюулыг таних мөн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Системд хэт найдах, хөдөлгөөний аюулгүй байдлыг систем хангана гэж бодох нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ Жолоодлогод туслах системийн анхааруулга

Системийн үзүүлэх дэмжлэг хязгаартай тул дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүрэх аюултай.

● Жолоочид харагдах байдалд үзүүлэх дэмжлэгийн дэлгэрэнгүй

Динамик радарын хурд баригч нь өөрийн болон өмнө яваа тээврийн хэрэгсэл хоорондын зайг тодорхойлоход зөвхөн туслах зориулалттай систем юм. Систем нь замын хөдөлгөөнд анхаарал болгоомжгүй оролцох боломжийг бүрдүүлэх механизм биш бөгөөд мөн үзэгдэх орчин муу нөхцөлд жолоодлогод дэмжлэг үзүүлэх систем биш юм.

Жолооч нь зогсож байсан үедээ ч автомашины ойр орчимд анхааралтай байна.

● Жолоочийн дүгнэлт гаргахад үзүүлэх дэмжлэгийн дэлгэрэнгүй

Динамик радарын хурд баригч нь урд талын автомашин хоорондын зайг тохируулсан зайнд байгаа эсэхийг тогтоодог ба бусад дүгнэлтийг гаргах боломжгүй. Тиймээс жолооч цаг ямагт өндөр сонор сэрэмжтэй байж, тухайн нөхцөлд болзошгүй аюул байгаа эсэхийг тогтоох нь туйлын чухал.

● Жолоочийн үйлдэлд үзүүлэх дэмжлэгийн дэлгэрэнгүй

**АЮУЛТАЙ**


Динамик радарын хурд баригч системд урд талын автомашинтай мөргөлдөхөөс сэргийлэх, зайлсхийх функц байдаггүй. Тиймээс аливаа болзошгүй аюул эрсдэл үүссэн нөхцөлд хөдөлгөөнд оролцож буй бүх талуудын аюулгүй байдлыг хангах үүднээс жолооч нэн даруй зохих арга хэмжээ авах шаардлагатай.

■ Динамик радарын хурд баригч ашиглаж болохгүй нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд динамик радарын хурд баригч ашиглаж болохгүй. Эсрэг тохиолдолд автомашины хурдны удирдлага алдагдах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- Явган зорчигч, унадаг дугуйтай хүн зорчиж буй замаар явах үед
- Хурдны зам, шулуун зам руу орох хэсэг, гарц орчмоор явах үед
- Ойртолтыг анхааруулах дохио олон удаа дуугарч байгаа үед
- Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцөлүүд: →Х.240
- Эгнээ байр системд мэдрэгдэхгүй байх нөхцөлүүд: →Р.244

Үндсэн функц

**A** Тогтмол хурдаар хөдөлгөөнд оролцох:

Урд талд автомашин байхгүй үед

Жолоочийн тохируулсан тогтмол хурдаар автомашин явна.

Уруу замаар уруудах үед тохируулсан хурднаас автомашины хурд давсан нөхцөлд дэлгэц анивчиж дохио дуугарна.

B Хөдөлгөөний хурд хасах, урд талын автомашиныг дагах:

Тохируулсан хурднаас урд талын автомашин бага хурдтай үед

Урд талд автомашин байгааг таньсан үед систем автоматаар автомашины хурдыг бууруулна. Хурд их хэмжээгээр бууруулах шаардлагатай үед систем тоормос ажиллуулна (тоормосны гэрэл мөн асна). Жолоочийн тохируулсан хоорондын зайг барихын тулд систем урд талын автомашины хурдны өөрчлөлтийг дагана. Урд талын автомашинд ойртохоос сэргийлэх зорилгоор систем хөдөлгөөний хурд хангалттай бууруулж чадаагүй үед ойртолтыг анхааруулах дохио дуугаргаж анхааруулна.

C Хурд нэмэх:

Тохируулснаас бага хурдтай автомашин урд талд байхгүй үед


Тохируулсан хурд хүртэл систем аажмаар хурд нэмнэ. Үүний дараа систем тогтмол хурдаар хөдөлгөөн үргэлжлүүлнэ.

D Хөдөлгөөн эхлэх:

Урд талын автомашин зогсох үед таны автомашин мөн зогсоно (системийн удирдлага автомашиныг зогсооно). Урд автомашин хөдөлгөөн эхлэх үед “RES” товч дарх асвэл хаазны дөрөө гишгэхэд (хөдөлгөөн эхлэх үйлдэл) үед урд автомашиныг дахин дагаж эхэлнэ. Хөдөлгөөн эхлэх үйлдэл хийгээгүй үед систем автомашиныг зогсоосон хэвээр байна.

Системийн эд ангиуд

■ Хянах самбарын дэлгэц




A Мэдээллийн дэлгэц

B Тохируулсан хурд

C Индикатор

■ Товч



A Жолоодлогод туслах горим сонгох товч

B Жолоодлогод туслах товч

C “+” товч/“RES” товч

D “-” товч

E Цуцлах товч


F Автомашин хоорондын зайн товч

Динамик радарын хурд баригч ашиглах

■ Хурд тохируулах

1 Жолоодлогод туслах горим сонгох товч дарж динамик радарын хурд баригч сонгоно.

Динамик радарын хурд баригчийн индикатор асна.




2 Хаазны дөрөөгөөр автомашины шаардлагатай хурд (30км/ц [20 миль/ц]-с дээш) хүртэл хурдаа нэмэх буюу хасах ба жолоодлогод туслах товч дарж хурд тохируулна.

Мэдээллийн дэлгэц дээр тохируулсан хурд гарна.

Товч суллах үеийн автомашины хур-


даар тохируулсан хурд сонгогдоно.



■ Тохируулсан хурдыг өөрчлөх

- Товчоор хурд тохируулах

Шинээр тохируулах хурд гарах хүртэл “+” эсвэл “-” товч дарна.



- 1 Хурд нэмэх
- 2 Хурд хасах

Тохиргоо (бага): Товчийг дарна.

Тохиргоо (их): Товчийг удаан дарж тохиргоо хийх ба тохируулах хурдад хүрэх үед суллана.

Тохируулсан хурд дараах байдлаар өөрчлөгдөнө:

Тохиргоо (бага): Товч дарах бүрд 1км/ц (0.6 миль/ц) эсвэл 1 миль/ц (1.6км/ц)-р өөрчлөгдөнө.

Тохиргоо (их): Товч дарах хугацаанд хурдны тохиргоо 5км/ц (3.1 миль/ц) эсвэл 5 миль/ц (8км/ц) шатлалтайгаар нэмэгдэх буюу буурна.

Өөрчлөх боломжтой тохиргоогоор тохируулсан хурдны өөрчлөгдөх шатлалыг солих боломжтой.

- Хаазны дөрөөгөөр тохируулсан хурдыг нэмэгдүүлэх


- 1 Шинээр тохируулах хурдад хүрэх хүртэл хааз гишгэнэ.
- 2 “+” товч дарна.

■ Хурд баригчийг цуцлах/дахин сэргээх

- 1 Цуцлах товч эсвэл жолоодлогч туслах товч дарж цуцална.

Тоормос гишгэхэд хурд баригч мөн цуцлагдана.

(Системийн удирдлагаар автомашин зогссон үед тоормос гишгэх нь удирдлагыг цуцлахгүй.)




- 2 “RES” товч дарж сэргээнэ.

■ Автомашин хоорондын зайг өөрчлөх

Товчийг дарах үед автомашин хоорондын зай дараах байдлаар өөрчлөгдөнө:

Урд талд автомашин мэдрэгдэх үед холбогдох **A** тэмдэг дэлгэцээр гарна.



► Украин, Молдаваас бусад

№	Автомашин хоорондын зай	Ойролцоо зай (Автомашинны хурд: 100 км/ц [60 миль/ц])
1	Хэт хол	70 м (230 фут) орчим
2	Хол	60 м (200 фут) орчим
3	Дунд	45 м (145 фут) орчим
4	Богино	30 м (100 фут) орчим

► Украин, Молдав

№	Автомашин хоорондын зай	Ойролцоо зай (Автомашинны хурд: 100 км/ц [60 миль/ц])
1	Хэт хол	60 м (200 фут) орчим
2	Хол	45 м (145 фут) орчим
3	Дунд	30 м (100 фут) орчим
4	Богино	25 м (85 фут) орчим

Автомашин хоорондын бодит зай нь автомашинны хурднаас хамаарч өөр өөр байна. Мөн автомашин

системийн удирдлагаар зогссон үед тохиргооноос үл хамааран урд автомашинаас тодорхой зайд зогсоно.

■ Ажиллах нөхцөл

- Арааны хөшүүрэг D-д байгаа.
- Автомашинны хурд 30км/ц (20 миль/ц)-с их үед хүссэн хурдаа тохируулах боломжтой.
- Автомашинны хурд 30км/ц [20 миль/ц]-с бага үед хурд тохируулсан нөхцөлд 30км/ц [20 миль/ц] хурдаар тохируулагдана
- Систем ажиллах хурдны дээд хязгаараас өндөр хурдтай үедээ хурд тохируулсан үед хурд системийн дээд хурдаар тохируулагдана

■ Хурдны тохиргоо хийсний дараа хурд нэмэх

Хэвийн жолоодлогын адилаар хаазны дөрөө ашиглан хурд нэмэх боломжтой. Хурд нэмсний дараа тохируулсан хурданд автоматаар буцна. Нөгөөтээгүүр автомашин хоорондын зай барих горимд урд талын дагаж буй автомашин хоорондын зай барихын тулд автомашинны хурд тохируулсан хурднаас буурч болно.

■ Автомашин дагах горимоор явах үед автомашин системийн удирдлагаар зогссон нөхцөлд

- Урд талын автомашин зогсож байх үед “RES” товч дарах ба товч дарснаас 3 секундний дотор урд талын автомашин хөдөлж эхэлсэн үед автомашин дагах горим сэргэнэ.
- Таны автомашин зогссоноос 3 секундний дотор урд талын автомашин хөдөлж эхэлсэн үед автомашин дагах горим сэргэнэ.

■ Автомашин хоорондын зай барих горим автоматаар цуцлагдах

Дараах нөхцөлүүдэд автомашин хоорондын зай барих горим автоматаар түр салгагдана:

- Тоормосны удирдлага эсвэл жолоодлогот туслах системийн хүчний удирдлага ажиллаж байгаа

(Жишээ: PCS систем, хөдөлгөөн эхлэх удирдлага)

- Зогсоолын тоормос ажиллуулсан үед
- Жолоодлогын үед жолооч аюулгүйн бүсээ тайлсан
- PCS системийн цуцалсан
- Огцом налуу зам дээр автомашин системийн удирдлагаар зогссон
- Автомашин системийн удирдлагаар зогссон үед дараах нөхцөл үүссэн:
 - Жолоочийн суудлын бүс тайлагдсан
 - Жолоочийн хаалга нээгдсэн
 - Автомашин зогсоноос хойш 3 минутын хугацаа өнгөрсөн

Зогсоолын тоормос автоматаар идэвхжиж болно.

- Системийн зарим болон бүх функц ажиллахгүй нөхцөлүүд: →Х.242

■ Динамик радарын хурд баригчийн анхааруулах мэдээлэл ба дохио

Ашиглалтын аюулгүй байдал: →Х.236

■ Мэдрэгч зөв таньж чадахгүй байж болох урд талын автомашин

Дараах нөхцөлүүдэд тухайн нөхцөлөөс хамаарч систем хангалттай хурд хасалт хийж чадахгүй эсвэл хурд авалт хийх шаардлагатай үед тоормос болон хаазны дөрөө ашиглана.

Эдгээр төрлийн тээврийн хэрэгслийг мэдрэгч зөв таньж чадахгүй байж болох тул ойртолтын анхааруулга (→Х.287) ажиллахгүй байж болно.

- Таны урдуур автомашин огцом орсон эсвэл тухайн явж буй эгнээнээс өөр автомашин хэт өндөр, хэт нам хурдаар
- Эгнээ солих үед
- Урд талын автомашин хэт бага хурдаар явж байгаа үед
- Тухайн явж буй эгнээнд өөр автомашин зогссон
- Тухайн явж буй эгнээгээр мотоцикл явж байгаа

■ Систем зөв ажиллахгүй байж болох нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд шаардлагатай нөхцөлд тоормосны дөрөө (тухайн нөхцөлөөс хамаарч шаардлагатай үед хааз) гишгэнэ.

Мэдрэгч автомашиныг зөв таньж чадахгүй байж болох тул систем зөв ажиллахгүй байж болно.

- Урд талын автомашин огцом тоормосолсон
- Замын түгжрэл дунд зэргээр бага хурдаар эгнээ солих үед

Ойртолтын анхааруулга

Урдуур автомашин огцом орж ирэх зэргээр автомашин урд талын автомашинд хэт ойртсон ба систем автоматаар хангалттай хурд бууруулах боломжгүй үед дэлгэц анивчих, анхааруулах дохио дуугарч жолоочид анхааруулга өгнө. Тоормос гишгэн автомашин хоорондын тохиромжтой зайг барина.

■ Анхааруулга өгөхгүй байх нөхцөлүүд

Автомашин хоорондын зай ойр үед ч дараах нөхцөлд систем анхааруулга өгөхгүй байж болно.

- Урд талын автомашины хурд таны автомашины хурдтай адил эсвэл илүү үед
- Урд талын автомашины хурд хэт бага үед
- Системийн хурдны тохиргоо хийгдсэн даруйд
- Хаазны дөрөө гишгэж байгаа

Замын эргэлт дээр хурд хасах функц

Эргэлт мэдрэгдсэн үед автомашины хурд хасагдаж

эхэлнэ. Эргэлт дуусах үед автомашины хурд хасалт дуусна.

Тухайн байдлаас хамаарч автомашины хурд тохируулсан хурдад буцна.

Урдуур автомашин огцом орж ирсэн эргээр автомашин хоорондын зайн удирдлага ажиллах шаардлагатай үед замын эргэлт дээр хурд хасах функц цуцлагдана.



■ Замын эргэлт дээр хурд хасах функц ажиллахгүй байж болох нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд тус функц зөв ажиллахгүй байж болно:

- Автомашин алсуур эргэлттэй замаар явж байгаа
- Хаазны дөрөө гишгэсэн
- Автомашин хэт богино эргэлтээр явсан

Эгнээ солихоос сэргийлэх функц (Украин, Молдав)

Гүйцэж түрүүлэх эгнээгээр хурд багатай автомашин явж байгаа үед эгнээ солихоос сэргийлэх функц ажиллана.

Гүйцэж түрүүлэх эгнээнд олон автомашин байгаа эсвэл хурд багатай автомашин явж байгаа үед DCM-гүй автомашинд тус

функц ажиллахгүй.

Эгнээ солих дэмжлэг

80 км/ц (50 миль/ц)-с дээш хурдтай үедээ гүйцэж түрүүлэх эгнээнд шилжих үйлдэл хийх үед эргэх дохионы хөшүүрэг түлхэн эгнээ солиход систем гүйцэж түрүүлэх үйлдэлд дэмжлэг үзүүлж хурд огцом нэмнэ.

► Украин, Молдаваас бусад

Гүйцэж түрүүлэх эгнээ гэдгийг систем автомашины жолооны хурдний байрлалаас (жолооны хурдний байрлал баруун эсвэл зүүн талд) хамаарч танина. Автомашиныг тухайн зориулан үйлдвэрлэснээс эсрэг чиглэлийн хөдөлгөөнтэй улсад ашиглаж байгаа үед гүйцэж түрүүлэх эгнээний эсрэг чиглэл рүү эргэх дохионы хөшүүргийг шилжүүлэх үед автомашин хурдаа нэмж болно (жишээлбэл баруун талын эгнээгээр гүйцэж түрүүлдэг улс оронд зориулагдсан автомашиныг эсрэг хөдөлгөөнтэй улсад ашиглах үед эргэх дохионы хөшүүргийг баруун тийш шилжүүлэхэд хурд нэмэгдэнэ).

► Украин, Молдав

DCM-тэй автомашин: Гүйцэж түрүүлэх эгнээ гэдгийг систем байршлын мэдээлэл болон ойр орчмын автомашины хөдөлгөөнөөс танина. Байршлын мэдээлэл байхгүй эсвэл ойр орчимд цөөн автомашин байгаа үед эгнээ солиход туслах функц, эгнээ солихоос сэргийлэх функц ажиллахгүй байж болно.

DCM-гүй автомашин: Гүйцэж түрүүлэх эгнээ гэдгийг систем автомашины жолооны хурдний


байрлалаас (жолооны хурдний байрлал баруун эсвэл зүүн талд) хамаарч танина. Хэрэв автомашины тухайн зориулан үйлдвэрлэснээс эсрэг чиглэлийн хөдөлгөөнтэй улсад ашиглаж байгаа үед гүйцэж түрүүлэх эгнээний эсрэг чиглэл рүү эргэх дохионы хөшүүргийг шилжүүлэх үед автомашин хурдаа нэмж болно (жишээлбэл баруун талын эгнээгээр гүйцэж түрүүлдэг улс оронд зориулагдсан автомашиныг эсрэг хөдөлгөөнтэй улсад ашиглах үед эргэх дохионы хөшүүргийг баруун тийш шилжүүлэхэд хурд нэмэгдэнэ).

80 км/ц (50 миль/ц)-с дээш хурдтай үедээ таны автомашинаас бага хурдтай автомашин явж буй гүйцэж түрүүлэх эгнээнд шилжих үйлдэл хийх үед эргэх дохионы хөшүүргийг түлхэн эгнээ солиход систем эгнээ солиход дэмжлэг үзүүлж хурдыг аажмаар бууруулна.

RSA замын тэмдэг таних функцтэй динамик радарын хурд баригч (тоноглогдсон автомашинд)


RSA функц асаалттай ба динамик радарын хурд баригч ажиллах явцад хурдны дээд хязгаарын замын тэмдэг танигдсан нөхцөлд тухайн хурд дээш/доош сумтай хамт гарна. “+” болон “-” товчийг удаан дарж тохируулсан хурдыг тухайн танигдсан хурдаар тохируулах боломжтой.

■ Танигдсан хурднаас тохируулсан хурд бага үед



“+” товчийг удаан дарна.

■ Танигдсан хурднаас тохируулсан хурд хурд их үед



“-” товчийг удаан дарна.

■ RSA замын тэмдэг таних функцтэй динамик радарын хурд баригч зөв ажиллахгүй байх нөхцөл

RSA функц хэвийн ажиллахгүй, замын тэмдэг зөв танихгүй нөхцөлүүдэд (→Х.263) RSA замын тэмдэг таних функцтэй динамик радарын хурд баригч нь хэвийн ажиллахгүй тул тус функцийг ашиглах үед хурдны дээд хязгаарын бодит заалтыг нягтална.

Дараах нөхцөлүүдэд “+” болон “-” товч дарж тохируулсан хурдыг танигдсан хурдад тохируулах боломжгүй байж болно:

- Хурдны дээд хязгаарын мэдээлэл байхгүй үед
- Танигдсан болон тохируулсан хурд

адил үед

- Танигдсан хурд нь динамик радарын хурд баригчийн ажиллах хурдны доод хязгаарт хүрээгүй, дээд хязгаараас давсан үед



Динамик радарын хурд баригчийн тохиргоо өөрчлөх

Өөрчлөх боломжтой тохиргоогоор динамик радарын хурд баригчийн тохиргоог өөрчлөх боломжтой. (→Х.594)

Дэлгэц ба системийн ажиллагааны статус

Динамик радарын хурд баригчийн ажиллагааны байдлыг харуулав.

Индикатор	Мэдээллийн дэлгэц		Нөхцөл
 Цагаан		Автомашин хоорондын зайн тохиргоо: Саарал	Динамик радарын хурд баригч унтраастай байгаа
 Ногоон		Автомашин хоорондын зайн тохиргоо: Цэнхэр Тохируулсан хурд: Ногоон	Тогтмол хурдаар явах
 Ногоон		Автомашин хоорондын зайн тохиргоо: Цэнхэр Тохируулсан хурд: Ногоон Урд автомашин: Цагаан	Урд талын автомашиныг дагах

Индикатор	Мэдээллийн дэлгэц		Нөхцөл
 Ногоон		Автомашин хоорондын зайн тохиргоо: Шаргалаар анивчих Тохируулсан хурд: Ногоон Урд автомашин: Шаргалаар анивчих	Ойртолтын анхааруулга
 Ногоон		Автомашин хоорондын зайн тохиргоо: Саарал Тохируулсан хурд: Цагаан Урд автомашин: Саарал	Хаазны дөрөөгөөр хурд нэмж байгаа
 Ногоон		Тохируулсан хурд: Урвуу дэлгэцэд ногоон	Тохируулсан хурднаас давсан
 Ногоон		Автомашин хоорондын зайн тохиргоо: Саарал Тохируулсан хурд: Цагаан Урд автомашин: Саарал	Системийн ажиллагаагаар автомашин зогссон

Хурд баригч

Хааз гишгэлгүйгээр автомашины тохируулсан хурдаар жолоодох боломжтой.

Хурд баригчийг хурдны зам буюу шулуун зам дээр ашиглана.



АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь жолоочийн үүрэг болно. Системд хэт найдаж болохгүй. Жолооч нь ойр орчимд анхаарал хандуулан аюулгүй жолоодох үүрэгтэй.
- Хурдны хязгаар, замын ачаалал, зам болон цаг агаарын нөхцөл байдал зэрэгт нийцүүлэн тохирох хурд сонгоно. Жолооч тохируулсан хурдыг нягтлах үүрэгтэй.

■ Хурд баригч ашиглаж болохгүй нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд хурд баригчийг ашиглаж болохгүй. Эсрэг тохиолдолд автомашины хурдны удирдлага алдагдах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүрэх аюултай.


- Огцом эргэлттэй зам дээр
- Салхитай зам дээр
- Бороо, цас, мөс зэргээр хучигдсан хальтиргаатай зам дээр
- Огцом уруу замаар уруудах, огцом өгсүүр уруу солигддог замаар явах үед

Уруу замаар явах үед автомашины хурд тохируулсан хурднаас давж болзошгүй.

- Системийг цуцлах шаардлагатай нөхцөлүүд: →Х.236


Системийн эд ангиуд

■ Хянах самбар



- A** Тохируулсан хурд
- B** Хурд баригчийн индикатор

■ Товч




- A** Жолоодлогод туслах горим сонгох товч
- B** Жолоодлогод туслах товч
- C** “+” товч / “RES” товч
- D** “-” товч
- E** Цуцлах товч

Хурд баригч ашиглах

■ Хурд тохируулах


- 1 Жолоодлогод туслах горим сонгох товчийг дарж хурд баригч сонгоно.

Хурд баригчийн индикатор асна.



- 2 Хаазны дөрөө ашиглан хүссэн хурд хүртэл хурдаа нэмж (30 км/ц [20 миль/ц]-с дээш) жолоодлогод туслах товчийг даран хурд баригчийн хурдыг тохируулна.


Товч суллах үеийн автомашины хурдаар хурд баригчийн хурд тохируулагдана.



■ Тохируулсан хурдыг өөрчлөх

- Товч ашиглан хурд өөрчлөх

Шинээр тохируулах хурд дэлгэцээр гарах хүртэл “+” эсвэл “-” товч дарна.



- 1 Хурд нэмэх

- 2 Хурд хасах

Тохируулсан хурд дараах байдлаар нэмэгдэх буюу буурна:

Тохиргоо (бага): Товч дарах бүрд 1км/ц (0.6 миль/ц) эсвэл 1 миль/ц (1.6км/ц)-р өөрчлөгдөнө.

Тохиргоо (их): Товчийг дараад суллах хүртэл тохируулсан хурд нэмэгдэх буюу хасагдана.

- Хаазны дөрөөгөөр тохируулсан хурд нэмэх


- 1 Хааз дөрөө гишгэн шинээр тохируулах хурдад хүртлээ хурд нэмнэ.

- 2 “+” товч дарна.

■ Хурд баригч цуцлах/сэргээх

- 1 Цуцлах товч эсвэл жолоодлогод туслах товч дарж цуцална.

Тоормос гишгэх үед хурд баригч мөн цуцлагдана.



2 “RES” товч дарж хурд баригчийн сэргээнэ.

■ Хурд баригчийн ажиллагаа автоматаар цуцлагдах


Дараах нөхцөлүүдэд хурд баригчийн ажиллагаа автоматаар цуцлагдана.

- Тохируулсан хурднаас бодит хурд 16км/ц (10 миль/ц) ба түүнээс доош буух үед

- Автомашины бодит хурд 30км/ц (20 миль/ц)-с бага болох үед
- Тоормосны удирдлага, жолоодлогод туслах системийн хүч хязгаарлах удирдлага ажиллах үед (Жишээ: PCS, хөдөлгөөн эхлэх удирдлага)
- Зогсоолын тоормос ажиллаж байгаа
- Жолооч аюулгүйн бүсээ тайлсан
- Системийн зарим болон бүх функц ажиллахгүй нөхцөлүүд: →X.242

Дэлгэц ба системийн ажиллагааны статус

Хурд баригчийн ажиллагааны статусыг харуулна.

Индикатор	Мэдээллийн дэлгэц		Нөхцөл
 Цагаан		Хоосон	Хурд баригч унтраастай байгаа
 Ногоон		Тохируулсан хурд: Ногоон	Тогтмол хурдаар явах
 Ногоон		Тохируулсан хурд: Урвуу дэлгэцэд ногоон	Тохируулсан хурднаас хурд давсан

EDSS (онцгой нөхцөлд автомашиныг зогсоох)^{*} систем

*: Тоноглогдсон загварт

EDSS буюу онцгой нөхцөлд автомашиныг зогсоох систем нь бие огцом муудах зэргээр жолооч автомашинаа үргэлжлүүлэн жолоодох боломжгүй болсон үед явж байгаа эгнээ дотроо автоматаар хурдыг бууруулан зогсоох функц юм.

LTA системийн ажиллагааны явцад жолооны хүрдээс барихгүй байх зэргээр жолоодлого хийхгүй үед жолооч хариу үйлдэл үзүүлэхгүй байна гэж тооцон ослоос сэргийлэх, ослын хохирлыг бууруулах үүднээс систем хурд хасаж автомашиныг зогсооно.



АЮУЛТАЙ

■ Ашиглалтын аюулгүй байдал

- Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь жолоочийн үүрэг болно. Замын хөдөлгөөнд ямагт орчин тойрондоо анхаарал хандуулж оролцоно. EDSS систем нь бие огцом муудсан зэргээр жолооч жолоодлогоо үргэлжлүүлэхэд хүндрэлтэй үед автомашиныг зогсоох зориулалттай. Тус систем нь нойрмог, эрүүл мэндийн шалтгаантай үед жолоодлогод туслах эсвэл анхаарал болгоомжгүйгээр замын хөдөлгөөнд оролцоход туслах зориулалтгүй болно.

- Тус систем бие огцом муудсан зэргээр жолооч жолоодлогоо үргэлжлүүлэхэд хүндрэлтэй үед ослоос сэргийлэх, ослын хохирлыг бууруулах үүднээс эгнээ дотроо хурдаа хасан зогсоох зориулалттай боловч олон нөхцөлөөс хамаарч ажиллагаа нь мөн өөрчлөгдөж болно. Тиймээс тохиолдол бүрд системийн ажиллагааны үр дүн нэгэн ижил түвшинд хүрэхгүй байж болно. Мөн ажиллагааны нөхцөл бүрдээгүй үед систем ажиллахгүй.

- Систем ажилласан үед жолооч жолоодлогоо үргэлжлүүлэх боломжтой болсон тохиолдолд жолооч жолоодлогоо даруй гартаа авах ба шаардлагатай үед замаас гарч зогсоод ослын дохиогоо асаан бусад жолоочид анхааруулга өгнө.

- Систем ажилласан үед хамт яваа зорчигч замаас гарч аюулгүй газарт автомашиныг зогсоох зэргээр аюулаас сэргийлэх зохих арга хэмжээг авна.

- Тус систем нь жолоочийн биеийн байдлыг жолооч жолооны хүрдтэй харьцаж байгаагаар дүгнэдэг тул жолооч тодорхой хугацаанд харьцаагүй тохиолдолд ажиллаж болно. Жолооч жолооны хүрдийг биеэрээ дарсан үед тус систем жолооч хариу үйлдэл үзүүлэхгүй байгааг таних боломжгүй тул ажиллахгүй.

Ерөнхий мэдээлэл

Тус систем 4 үе шаттайгаар ажилладаг. “Анхааруулга 1” ба “Анхааруулга 2” шатанд систем автомашины хурдыг удирдангаа анхааруулга өгч жолооч хариу

үйлдэл өгөх эсэхийг шалгадаг. Жолооч хариу үйлдэл өгөхгүй үед систем “Хурд хасаад зогсолт хийх” болон “Хөдөлгөөнгүй зогсоох” үе шатаар хурд хасаж зогсооно. Үүний дараа “Хөдөлгөөнгүй зогсоох” горимоор үргэлжлүүлэн зогсоодог.

■ Ажиллах нөхцөл

Систем дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- LTA систем ажиллаж байгаа
- Автомашины хурд 50 км/ц (30 миль/ц)-с их

■ Ажиллагаа цуцлагдах нөхцөл

Дараах нөхцөлүүдэд системийн ажиллагаа цуцлагдана:

- LTA-н ажиллагаа цуцлагдсан (LTA товч дарах зэргээр)
- Динамик радарын хурд баригчийн ажиллагааг цуцалсан
- Жолооч жолоодлого хийсэн (жолооны хүрдээс барьсан, тоормос, хаазны дөрөө гишгэсэн, зогсоолын тоормос, ослын дохионы гэрлийн товчийг дарсан, эргэх дохионы хөшүүргийг түлхсэн)
- Хурд хасаад зогсолт хийх үе шатанд жолоодлогод туслах товч дарсан
- Асаах товчийг ON-с Off горимд шилжүүлсэн
- Системийн зарим болон бүх функц ажиллахгүй нөхцөлүүд: →X.242

■ LTA системийн ажиллагаа цуцлагдах

EDSS системийн ажиллагааг цуцлах үед LTA системийн ажиллагаа мөн цуцлагдаж болно.

бариагүй байгааг анхааруулах анхааруулга ажилласан ч жолооч хариу үйлдэл хийгээгүй тохиолдолд дохио дуугаран анхааруулга өгч систем жолоочийн хариу үйлдлийг шалгана. Тодорхой хугацааны дотор жолооны хүрд эргүүлэх зэргээр хариу үйлдэл байхгүй үед систем “Анхааруулга 2” үе шат руу шилжинэ.

Зааварчилгаа

“Анхааруулга 2” үе шатанд шилжсэн үед дохио ойр давтамжтайгаар дуугаран дэлгэц дээр анхааруулга гарах ба автомашины хурд хасагдаж эхэлнэ. Тодорхой хугацааны дотор жолооны хүрд эргүүлэх зэрэг үйлдэл хийгээгүй тохиолдолд систем жолоочийг хариу үйлдэл үзүүлэхгүй байна гэж тооцоолон “Хурд хасаад зогсолт хийх” үе шат руу шилжинэ.

Жолооч хариу үйлдэл үзүүлэх хүртэл аудио системийн дуу түр хаагдана.

Автомашин хурд хасах үед замын нөхцөл зэргээс хамаарч тоормосны гэрэл асаж болно.

Автомашин тодорхой хэмжээнд хурд хассаны дараа ослын дохионы гэрэл асна.

Анхааруулга 1

Жолооч жолооны хүрдээс

Хурд хасаад зогсолт хийх

Систем жолоочийг хариу үйлдэл

үзүүлэхгүй байна гэж тооцоолсон нөхцөлд дохио үргэлжлэн дуугаран дэлгэц дээр анхааруулга гарах ба автомашины хурд аажмаар буурж зогсоно. Хурд буурах үед ослын дохионы гэрэл асаж бусад жолоочид анхааруулга өгнө.

Хөдөлгөөнгүй зогсоох

Автомашин бүрэн зогссоны дараа зогсоолын тоормос автоматаар залгагдана. “Хөдөлгөөнгүй зогсоох” үе шатанд шилжсэний дараа дохио үргэлжлэн дуугаран ослын дохионы гэрэл асаж бусад жолоочид онцгой байдал үүссэнийг анхааруулах ба хаалганы түгжээ тайлагдана.

■ Системийн ажиллагаа цуцлагдсаны дараа хийх боломжгүй үйлдлүүд

“Хурд хасаад зогсолт хийх” үе шатанд шилжсэний дараа EDSS системийн ажиллагааг цуцалсан ч хөдөлгүүрийг унтраагаад асаах хүртэл дараах функцийг ашиглах боломжгүй:

- LTA
- LCA (тоноглогдсон загварт)

Хурд хязгаарлагч*

*: Тоноглогдсон загварт

Хурд хязгаарлагч товчоор хурдны дээд хязгаарыг тохируулах боломжтой. Хурд хязгаарлагч нь тохируулсан хурднаас хэтрэхээс сэргийлдэг.


⚠ АЮУЛТАЙ

■ **Хурд хязгаарлагч ашиглаж болохгүй нөхцөлүүд**

- Мэдрэгч хэвийн ажиллахгүй нөхцөлүүд: →X.240
- Системийг цуцлах шаардлагатай нөхцөлүүд: →P.244

Системийн эд ангиуд


■ Хянах самбар



A Тохируулсан хурд

B Хурд хязгаарлагчийн индикатор

■ Товч




- A** Жолоодлогот туслах горим сонгох товч
- B** Жолоодлогот туслах товч
- C** “+” товч / “RES” товч
- D** “-” товч
- E** Цуцлах товч

Хурд хязгаарлагч ашиглах

■ Дээд хурд тохируулах

- 1 Жолоодлогот туслах горим сонгох товч даран хурд хязгаарлагчийг сонгоно.

Хурд хязгаарлагчийн индикатор цагаан өнгөөр асна.



- 2 Тохируулах хурдад хүрэх хүртэл хурд нэмэх буюу хасаад жолоодлогот туслах


товчийг дарж дээд хурдыг тохируулна.

Хурд хязгаарлагчийн индикатор цагаанаас ногоон өнгөтэй болно.

Мэдээллийн дэлгэц дээр тохируулсан хурд ногоон өнгөөр гарна.

Автомашины бодит хурд 30 км/ц (20 миль/ц)-с бага үед хурд тохируулсан тохиолдолд 30 км/ц (20 миль/ц) хурдаар дээд хурд тохируулагдана.

Системийн ажиллагааг цуцлах үед цуцлах товч эсвэл жолоодлогот туслах товчийг дарна.




R арааны байрлалд систем ажиллахгүй.

Жолоодлогот туслах товчийг олон дарсан үед систем ажиллахгүй.

■ Тохируулсан хурдыг өөрчлөх

“+” эсвэл “-” товчийг даран шинээр тохируулах хурдыг сонгоно.



- 1 Хурд нэмэх
- 2 Хурд хасах

Тохиргоо (бага): Товчийг дарна.

Тохиргоо (их): Товчийг удаан дарж тохиргоо хийх ба тохируулах хурдад хүрэх үед суллана.

Хурдны тохиргоо дараах байдлаар өөрчлөгдөнө:


Тохиргоо (бага): Товч дарах бүрд 1км/ц (0.6 миль/ц) эсвэл 1 миль/ц (1.6км/ц)-р өөрчлөгдөнө.

Тохиргоо (их): Товч дарах хугацаанд хурдны тохиргоо 5км/ц (3.1 миль/ц) эсвэл 5 миль/ц (8км/ц) шатлалтайгаар нэмэгдэх буюу буурна.

Өөрчлөх боломжтой тохиргоогоор товч дарах бүрд хурд өөрчлөгдөх хэмжээг тохируулах боломжтой.

■ Ажиллагааг цуцлах/сэргээх

- 1 Цуцлах товч эсвэл жолоодлоготод туслах товч дарж цуцална.



- 2 “RES” товч ажиллагааг сэргээнэ.

Ажиллагааг цуцалсан үед хурд хязгаарлагчийн индикатор цагаан болно.

■ Тохируулсан хурднаас давах

Тохируулсан хурднаас давсан дараах нөхцөлүүдэд дэлгэц дээр тохируулсан хурд анивчина:

- Хаазны дөрөө гишгэж хурд нэмсэн
- Уруу замаар явж байгаа

■ Хурд хязгаарлагчийн ажиллагаа автоматаар цуцлагдах

- Системийн зарим болон бүх функц ажиллахгүй нөхцөлүүд: →X.242


■ Тоормослох үеийн тоормосны дуу, тоормосны дөрөөний мэдрэмж өөрчлөгдөх

→X.242

Замын тэмдэг таних RSA функцтэй хурд хязгаарлагч


RSA функц болон хурд хязгаарлагч идэвхтэй нөхцөлд хурдны дээд хязгаарын тэмдэг танигдвал тус тэмдгийн заалт дээш/доош сумтайгаар дэлгэц дээр гарна.“+” эсвэл “-” товчийг даран тохируулсан хурдыг тэмдгийн хурдаар тохируулах боломжтой.

■ Танигдсан хурднаас тохируулсан хурд бага үед



“+” товчийг удаан дарна

■ Танигдсан хурднаас тохируулсан хурд их үед



“-” товчийг удаан дарна

■ Замын тэмдэг таних RSA функцтэй хурд хязгаарлагч хэвийн ажиллахгүй нөхцөлүүд

RSA функц хэвийн ажиллахгүй байх эсвэл замын тэмдгийг зөв танихгүй үед замын тэмдэг таних RSA функцтэй хурд хязгаарлагч хэвийн ажиллахгүй (→X.278). Тус функцийг ашиглах үед хурдны дээд хязгаарын бодит заалтыг нягтална.

Дараах нөхцөлүүдэд “+” болон “-” товч дарж тохируулсан хурдыг танигдсан хурдад тохируулах боломжгүй байж болно:

- Танигдсан болон тохируулсан хурд адил үед
- Танигдсан хурд нь хурд хязгаарлагчийн тохируулсан хурдад хүрээгүй

BSM (Blind Spot Monitor) систем*


BSM нь арын гуперын баруун, зүүн дотор талд байрлах хойд хажуугийн радарын мэдрэгч ашиглан эгнээ солих үед жолоочид туслах систем юм.

! АЮУЛТАЙ

■ BSM функц ашиглалттай холбоотой анхааруулга

- Жолооч аюулгүй жолоодлогыг бүрэн хангах үүрэгтэй. Замын хөдөлгөөнд цаг ямагт аюулгүй оролцож ойр орчимдоо анхаарал хандуулна.
- BSM нь жолоочид харагдахгүй хэсгээр автомашин зорчиж буйг анхааруулах нэмэлт функц юм. BSM системд хэт найдах, даатгахыг хориглоно. Эгнээ байраа өөрчлөх нь аюулгүй эсэхийг систем тооцоолох боломжгүй тул системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай. Тухайн нөхцөлөөс хамаарч систем зөв ажиллахгүй байж болно. Тиймээс жолооч өөрийн нүдээр замын аюулгүй байдлыг шалгах шаардлагатай.

Системийн эд ангиуд



А Голын дэлгэц

BSM функцийг асаах буюу унтраана.

В Хажуугийн толины индикатор

BSM функц нь хажуу эгнээгээр хажуугийн толинд үл харагдах өнцөгт зорчиж буй автомашиныг эсвэл автомашин огцом ойртож ирэх үед тухайн талын хажуугийн толины индикатор (→X.90) асдаг. Тухайн тал руу эргэх дохионы хөшүүргийг түлхэх үед хажуугийн толины индикатор анивчиж дохио дуугарна.

С Жолоодлогод туслах мэдээллийн индикатор

BSM функцийг унтраах үед асна. Энэ үед мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл асна.

■ Хажуугийн толины индикаторын харагдах байдал

Хүчтэй нарны гэрэлд индикатор гэрэл сайн харагдахгүй байж болно.

■ Дуут дохио дуугарах байдал

Хөгжмийн дуу чанга зэргээр дуу чимээтэй үед дуут дохио муу сонсогдож болно.


■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим функцийг өөрчлөх боломжтой. (→X.583)

**АЮУЛТАЙ****■ Системийн хэвийн ажиллагааг хангах**

Автомашины арын гуперны баруун ба зүүн дотор талд тус бүр нэг BSM мэдрэгч суурилагдсан байдаг. BSM системийн хэвийн ажиллагааг хангахын тулд дараах анхааруулгыг мөрдөнө.

- Мэдрэгч болон гуперны тухайн хэсгийг цаг ямагт цэвэр байлгана. Мэдрэгч болон гуперны тухайн хэсэг бохирдсон эсвэл цас мөс наалдсан байвал BSM системийн ажиллагаа алдагдах ба анхааруулга дэлгэц дээр гарна. Энэ үед бохирдол, цас мөсийг нь цэвэрлэж BSM функцийн ажиллах нөхцөлийг (→X.303) бүрдүүлэн 10 минут орчим жолоодно. Анхааруулга унтрахгүй байвал та өөрийн Lexus дилер дээр оношилгоо хийлгэнэ үү.



- Мэдрэгч болон гуперны тухайн хэсэгт нэмэлт тоноглол, хуулга, наалт (тунгалаг наалт хамаарна), хөнгөн цагаан тууз зэргийг наахыг хориглоно.
- Мэдрэгч болон гуперны тухайн хэсгийг будаж болохгүй.
- Мэдрэгч болон арын гуперны тухайн хэсгийг хүчтэй цохилтоос хамгаална. Мэдрэгчийн байрлал бага зэрэг хөдөлсөн үед ч системийн хэвийн ажиллагаа алдагдах ба автомашиныг мэдрэхгүй байж болно. Дараах нөхцөлд Lexus дилертээ хандаж оношлуулна уу.
- Мэдрэгч, түүний ойр орчим хүчтэй цохилтод өртсөн
- Мэдрэгчийн ойр орчим зурагдсан, хонхойсон эсвэл зарим хэсэг нь салж унасан
- Мэдрэгчийг задлахыг хориглоно.

! АЮУЛТАЙ

- Мэдрэгч болон гуперны тухайн хэсгийг өөрчилж болохгүй.
- Мэдрэгч эсвэл арын гуперыг салгах, угсрах, солих шаардлагатай үед Lexus дилертээ хандана уу.
- Арын гуперны будаг ба өнгө мэдрэгчийн ажиллагаанд нөлөөлөх магадлалтай. Арын гуперыг зөв засаагүй тохиолдолд анхааруулга гарч BSM ажиллахгүй байж болно. Аливаа будаг хийлгэх шаардлагатай үед та Lexus дилертээ хандана уу.

BSM системийг унтраах, асаах

Өөрчлөх боломжтой тохиргоогоор BSM системийг идэвхжүүлэх, цуцлах боломжтой. (→X.583)


BSM системийг унтраасан үед жолоодлогот туслах мэдээллийн индикатор (→X.90) асна. Энэ үед мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

Асаах товчийг ON горимд шилжүүлэх бүрд BSM систем автоматаар асна.

BSM системийн ажиллагаа

■ BSM системийн таних боломжтой объект


BSM функц нь хажуу эгнээгээр хажуугийн толинд үл харагдах өнцөгт зорчиж буй автомашиныг радарын мэдрэгч ашиглан мэдрэх ба хажуугийн толины индикатораар дамжуулан жолоочид мэдээлэл өгдөг.



- A** Хажуугийн толинд харагдахгүй хэсгээр (толинд үл харагдах хэсэг) явж байгаа автомашин
- B** Хажуугийн толинд харагдахгүй хэсгээр (толинд үл харагдах хэсэг) огцом ойртон ирж автомашин

■ Жолоодлогын үед мэдрэх хүрээ

Автомашины таних боломжтой хүрээг дараах байдлаар харуулав.



Функцийн мэдрэх хүрээ:

A Автомашины 2 талын 0.5 м (1.6 фут)-с 3.5м (11.5 фут) хүртэлх зай*¹

B Арын гупернээс 1 м (3.3 фут) орчим урагш*²

C Арын гупернээс 3 м (9.8 фут) орчим хойш

D Арын гупернээс хойш 3 м (9.8 фут)-с 70 м (230 фут)*³

*¹: Автомашины хажуу талаас 0.5 м (1.6 фут) хүртэлх зайг систем мэдрэхгүй.

*²: Автомашин бусад автомашинд гүйцэгдэх үед арын гупернээс урагш 3 м (9.8 фут) зайг мэдэрнэ.

*³: Таны автомашин болон системийн мэдэрсэн автомашины хурдны зөрүү их байх тусам илүү хол байгаа автомашиныг систем таних ба хажуугийн индикатор асах буюу анивчина.

■ BSM системтэй холбоотой функц

LDA систем нь хажуу эгнээгээр зорчиж буй мэдрэгдсэн автомашины мэдээллийг ашигладаг. Функцийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл болон ажиллах нөхцөлийг Х.264-с харна уу.

■ BSM функц ажиллах нөхцөл

BSM функц нь дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Асаах товч ON горимд байгаа.
- BSM функц асаалттай.
- Арааны хөшүүрэг R-с бусад араанд байгаа үед.
- Автомашины хурд 10км/ц (7 миль/ц)-с их.

■ Дараах нөхцөлд BSM функц автомашиныг мэдэрнэ

BSM функц дараах нөхцөлд мэдрэх хүрээнд байгаа автомашиныг мэдэрнэ:

- Хажуу эгнээний автомашин гүйцэж түрүүлэх үед
- Хажуу эгнээний автомашиныг бага хурдаар гүйцэж түрүүлэх үед
- Бусад тээврийн хэрэгсэл эгнээгээ солингоо системийн мэдрэх хүрээнд орж ирсэн үед

■ BSM функц автомашин танихгүй байх нөхцөлүүд

BSM функц нь дараах төрлийн тээврийн хэрэгсэл, объектыг мэдрэх боломжгүй:

- Бага оврын мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч зэрэг
- Эсрэг чиглэлийн автомашин
- Замын хашлага, хана, тэмдэг,

зогсож буй автомашин мөн бусад ижил төрлийн хөдөлгөөнгүй эд зүйл

- Нэг эгнээгээр зорчиж буй хойд талын автомашин
 - 2 эгнээний цаана зорчиж буй автомашин
 - Өндөр хурдаар таны гүйцэж түрүүлсэн бусад автомашин
- * : Тухайн нөхцөлөөс хамаарч автомашин, объектыг мэдрэх тохиолдол байдаг.

■ Дохио дуугарахгүй нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд эргэх дохионы хөшүүрэг түлхсэн ч индикатор анивчих бөгөөд дохио дуугарахгүй.

- Эргэх дохионы хөшүүргийг түлхэх үед мэдрэх хүрээнд бусад автомашин орж ирсэн
 - Хажуу эгнээний автомашиныг өндөр хурдаар гүйцэж түрүүлэх үед
- * : Тухайн нөхцөлөөс хамаарч дохио дуугарч болно.

■ Систем хэвийн ажиллахгүй байх нөхцөлүүд

- BSM функц дараах нөхцөлд хэвийн ажиллахгүй байж болно:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчимд шавар, цас, мөс, наалт наасан, тогтсон үед
 - Аадар бороо, цас, манан зэрэг цаг агаарын нөхцөл байдлаас тогтоол ус үүссэн замаар явах үед
 - Хоорондоо ойр зайтай хэд хэдэн автомашин ойртох үед
 - Таны автомашинаас хойд талын автомашин хүртэлх зай ойр үед
 - Таны автомашин болон функцийн мэдрэх хүрээнд орж ирсэн автомашин хоорондын хурдны зөрүү хэт их үед
 - Таны автомашин болон бусад автомашин хоорондын харьцангуй хурд өөрчлөгдөж байгаа үед
 - Функцийн мэдрэх хүрээнд орж

- ирсэн автомашин таны автомашинтай адил хурдтай үед
- Хөдөлгөөн эхлэх үед мэдрэх хэсэгт зогссон хэвээр байгаа автомашин
- Өгсүүр болон уруу олон давтамжтай үргэлжилсэн замаар явах
- Огцом эргэлт ихтэй эсвэл замын гадаргуу нь тэгш бус замаар явах үед
- Замын эгнээ өргөн үед эсвэл эгнээний нэг тал руу хэт шахаж явах зэргээр хажуу эгнээгээр зорчиж буй автомашин хүртэлх зай хол үед
- Автомашины хойд талд унадаг дугуйн суурь бусад нэмэлт тоноглол суурилуулсан үед
- Функцийн мэдрэх хүрээнд орж ирсэн автомашин болон таны автомашины өндөр хэт зөрүүтэй үед
- BSM функц асаасан даруйд
- Автомашин чирэх үед
- Дараах нөхцөлүүдэд BSM функц автомашин, объектыг буруу таних магадлал нэмэгдэнэ:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Функцийн мэдрэх хүрээнд орж ирсэн замын хаалт, хана зэрэг хүртэлх зай ойр үед
 - Өгсүүр болон уруу олон давтамжтай үргэлжилсэн замаар явах үед
 - Замын эгнээ нарийн үед эсвэл эгнээний нэг тал руу шахаж явах зэргээр функцийн таних хүрээнд хажуу эгнээнээс өөр эгнээгээр зорчиж буй автомашин орж ирэх үед
 - Огцом эргэлт ихтэй эсвэл замын гадаргуу тэгш бус замаар явах үед
 - Дугуй шарваж байгаа, хий эргэж байгаа үед
 - Таны автомашинаас хойд талын автомашин хүртэлх зай ойр үед
 - Автомашины хойд талд унадаг дугуйн суурь бусад нэмэлт тоноглол суурилуулсан үед
 - Автомашин чирэх үед

Араас автомашин ойртож буйг анхааруулах функц*

* Тоноглогдсон загварт

Араас автомашин ойртож буйг анхааруулах функц нь арын гуперын дотор талд байрлах радарын мэдрэгч ашигладаг. Тус систем араас автомашин ойртож буйг анхааруулах замаар жолоочид зайлсхийх арга хэмжээ авахыг сануулж жолоодлогод тусалдаг.

АЮУЛТАЙ

■ Системийн ашиглалттай холбоотой анхааруулга

Жолооч аюулгүй жолоодлогыг бүрэн хангах үүрэгтэй. Замын хөдөлгөөнд цаг ямагт аюулгүй оролцож ойр орчимдоо анхаарал хандуулна.

Араас автомашин ойртож буйг анхааруулах функц нь ар талд автомашин буйг анхааруулах нэмэлт функц юм.


Тухайн нөхцөлөөс хамаарч систем зөв ажиллахгүй байж болно. Тиймээс жолооч өөрийн нүдээр замын аюулгүй байдлыг шалгах шаардлагатай.

Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ Системийн хэвийн ажиллагааг хангах

→Х.301

Системийн эд ангиуд



A Мэдээллийн дэлгэц/HUD дэлгэц

Ар талын автомашины хөдөлгөөнд таны автомашин саад учруулж магадгүй нөхцөлд анхааруулга болон дохиогоор мэдээлэл өгнө.

B Голын дэлгэц

Араас автомашин ойртож буйг анхааруулах функцийг асааж унтраана.

Араас автомашин ойртож буйг анхааруулах функцийг асааж унтраах

Өөрчлөх боломжтой тохиргоогоор араас автомашин ойртож буйг анхааруулах функцийг асааж унтраах боломжтой. (→Х.583)

■ Дуут дохио дуугарах байдал


Хөгжмийн дуу чанга зэргээр дуу чимээтэй үед дуут дохио муу сонсогдож болно.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим функцийг өөрчлөх боломжтой. (→Х.583)

Араас автомашин ойртож буйг анхааруулах функц

Хойд хажуугийн радарын мэдрэгч ар талаас автомашин ойртож буйг мэдэрсэн нөхцөлд араас автомашин ойртож буйг анхааруулах функц нь мэдээллийн дэлгэц эсвэл HUD дэлгэц дээр мэдээлэл гарган дохио өгч жолоочид анхааруулга өгдөг.



■ Араас автомашин ойртож буйг анхааруулах функц ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Асаах товч ON горимд байгаа.
- BSM функц асаалттай.
- Арааны хөшүүрэг R-с бусад араанд байгаа үед.
- Автомашины хурд 100км/ц (63

миль/ц)-с их.

- Эргэх дохионы хөшүүргийг түлхээгүй
- Тоормос гишгээгүй
- Тус систем ажилласнаас хойш 5-с дээш минут өнгөрсөн

■ Дараах нөхцөлд араас автомашин ойртож буйг анхааруулах функц автомашины мэдрэнэ

Араас автомашин ойртож буйг анхааруулах функц нь мэдрэх хүрээнд байгаа тухайн эгнээгээр явж буй ар талын автомашиныг мэдрэнэ

■ Араас автомашин ойртож буйг анхааруулах функц автомашин танихгүй байх нөхцөлүүд

Араас автомашин ойртож буйг анхааруулах функц нь дараах төрлийн тээврийн хэрэгсэл, объектыг мэдрэх боломжгүй:

- Бага оврын мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч зэрэг*
- Замын хашлага, хана, тэмдэг, зогсож буй автомашин мөн бусад ижил төрлийн хөдөлгөөнгүй эд зүйл*
- Эсрэг чиглэлийн автомашин
- Хажуу эгнээний автомашин*

*: Тухайн нөхцөлөөс хамаарч автомашин, объектыг мэдрэх тохиолдол байдаг.

■ Араас автомашин ойртож буйг анхааруулах функц хэвийн ажиллахгүй байх нөхцөлүүд

- Дараах нөхцөлүүдэд систем ар талын автомашиныг мэдрэхгүй байж болно:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчимд шавар, цас, мөс, наалт наасан, тогтсон үед
 - Аадар бороо, цас, манан зэрэг цаг

- агаарын нөхцөл байдлаас тогтоол ус үүссэн замаар явах үед
- Өгсүүр болон уруу олон давтамжтай үргэлжилсэн замаар явах
- Автомашин чирэх үед
- Арын автомашин чанх араас ойртож ирээгүй үед
- Арын автомашин ташуу өнцгөөс ойртож ирсэн
- Ар талд гэнэт орж ирсэн автомашин
- Бусад автомашины ар талд огцом орсон
- Ар талд олон автомашин байгаа
- Ар талын автомашины ойр орчимд хашлага, хана бусад хөдөлгөөнгүй эд зүйл байгаа
- Холдон явсан автомашин дахин ойртож ирсэн
- Ар талын автомашин холдож байгаа
- Ар талын автомашин гүйцэж түрүүлсэн
- Өгсүүр болон уруу олон давтамжтай үргэлжилсэн замаар явах
- Арын автомашин хэт өндөр, нам
- Дараах нөхцөлүүдэд ар талд автомашин байхгүй байсан ч байгаа гэж буруу таних магадлал нэмэгдэнэ:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Автомашин чирэх үед
 - Таны автомашины ойр орчимд олон автомашин байгаа
 - Баруун/зүүн эргэлт хийх үед ар талаар автомашин явж өнгөрөх
 - Ар талын автомашин гүйцэж түрүүлэхээсээ өмнө ойртож ирсэн
 - Замын эгнээ нарийн үед эсвэл эгнээний нэг тал руу шахаж явах зэргээр функцийн таних хүрээнд хажуу эгнээнээс өөр эгнээгээр зорчиж буй автомашин орж ирэх үед
 - Ар талд олон автомашин байгаа
- Аливаа объект (замын тэмдэг, зар сурталчилгааны самбар зэрэг)-н доогуур гарах үед
- Ар талын автомашины ойр орчимд хашлага, хана бусад хөдөлгөөнгүй эд зүйл байгаа
- Эргэлттэй зам дээр хажуу талын автомашин ар талд байрлах үед
- Бусад автомашины ар талд огцом орсон

Автомат арын ослын дохионы гэрэл*

*: Тоноглогдсон загварт

Автомат арын ослын дохионы гэрэл арын гуперын дотор талд байрлах радарын мэдрэгч ашигладаг. Систем ар талаараа мөргөлтөд өртөх магадлал өндөр гэж тооцсон үед ослын дохионы гэрлийг асаан арын жолоочид анхааруулга өгдөг.



АЮУЛТАЙ

■ Систем ашиглалттай холбоотой анхааруулга

Жолооч аюулгүй жолоодлогыг бүрэн хангах үүрэгтэй. Замын хөдөлгөөнд цаг ямагт аюулгүй оролцож ойр орчимдоо анхаарал хандуулна. Систем ар талаараа мөргөлтөд өртөх магадлал өндөр гэж тооцсон үед ослын дохионы гэрлийг асаан арын жолоочид анхааруулга өгөх нэмэлт функц юм.

Тухайн нөхцөлөөс хамаарч систем зөв ажиллахгүй байж болно. Тиймээс жолооч өөрийн нүдээр замын аюулгүй байдлыг шалгах шаардлагатай.

Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.


■ Системийн хэвийн ажиллагааг хангах

→X.301

Автомат арын ослын дохионы гэрлийн ажиллагаа

Хойд хажуугийн радарын мэдрэгч

тухайн эгнээгээр араас ойртож буй автомашиныг мэдэрдэг. Систем ар талаараа мөргөлтөд өртөх магадлал өндөр гэж тооцсон үед ослын дохионы гэрлийг асаан арын жолоочид анхааруулга өгдөг. Мөн мэдээллийн дэлгэц эсвэл HUD дэлгэц дээр мэдээлэл гарган дохио өгч жолоочид анхааруулга өгдөг.



■ Автомат арын ослын дохионы гэрэл ажиллах нөхцөл

Дараах нөхцөлүүд бүрдсэн үед автомат арын ослын дохионы гэрэл ажиллана:

- Асаах товч ON горимд байгаа.
- Арааны хөшүүрэг R-с бусад араанд байгаа үед.
- Эргэх дохионы хөшүүргийг түлхээгүй
- Таны болон арын автомашин хоорондын харьцангуй хурд 30-100 км/ц (19-62 миль/ц) хооронд байгаа
- Таны автомашины хурд 10 км/ц (7

миль/ц)-с бага ба тоормос гишгэсэн

■ Дараах нөхцөлд автомат арын ослын дохионы гэрлийн автомашин мэдрэх нөхцөл

Мэдрэх хүрээнд тухайн эгнээгээр явж буй ар талаас мөргөх магадлал өндөртэй автомашиныг автомат арын ослын дохионы гэрэл мэдрэнэ.

■ Автомат арын ослын дохионы гэрэл автомашин танихгүй байх нөхцөлүүд

Автомат арын ослын дохионы гэрэл дараах төрлийн тээврийн хэрэгсэл, объектыг мэдрэх боломжгүй:

- Бага оврын мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч зэрэг
- Замын хашлага, хана, тэмдэг, зогсож буй автомашин мөн бусад ижил төрлийн хөдөлгөөнгүй эд зүйл
- Эсрэг чиглэлийн автомашин
- Хажуу эгнээний автомашин*

* Тухайн нөхцөлөөс хамаарч автомашин, объектыг мэдрэх тохиолдол байдаг.

■ Систем хэвийн ажиллахгүй байх нөхцөлүүд

- Дараах нөхцөлүүдэд систем ар талын автомашиныг мэдрэхгүй байж болно:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчимд шавар, цас, мөс, наалт наасан, тогтсон үед
 - Аадар бороо, цас, манан зэрэг цаг агаарын нөхцөл байдлаас тогтоол ус үүссэн замаар явах үед
 - Өгсүүр болон уруу олон давтамжтай үргэлжилсэн замаар явах
 - Автомашин чирэх үед
 - Арын автомашин чанх араас ойртож ирээгүй үед
 - Арын автомашин ташуу өнцгөөс ойртож ирсэн
 - Ар талд гэнэт орж ирсэн автомашин
 - Бусад автомашины ар талд огцом орсон
 - Ар талд олон автомашин байгаа
 - Ар талын автомашины ойр орчимд

хашлага, хана бусад хөдөлгөөнгүй эд зүйл байгаа

- Холдон явсан автомашин дахин ойртож ирсэн
- Ар талын автомашин холдож байгаа
- Ар талын автомашин гүйцэж түрүүлсэн
- Өгсүүр болон уруу олон давтамжтай үргэлжилсэн замаар явах
- Арын автомашин хэт өндөр, нам
- Дараах нөхцөлүүдэд мөргөлтөд өртөх магадлал байхгүй байсан ч систем ажиллах магадлал нэмэгдэнэ:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Автомашин чирэх үед
 - Таны автомашины ойр орчимд олон автомашин байгаа
 - Баруун/зүүн эргэлт хийх үед ар талаар автомашин явж өнгөрөх
 - Ар талын автомашин гүйцэж түрүүлэхээсээ өмнө ойртож ирсэн
 - Замын эгнээ нарийн үед эсвэл эгнээний нэг тал руу шахаж явах зэргээр функцийн таних хүрээнд хажуу эгнээнээс өөр эгнээгээр зорчиж буй автомашин орж ирэх үед
 - Ар талд олон автомашин байгаа
 - Аливаа объект (замын тэмдэг, зар сурталчилгааны самбар зэрэг)-н доогуур гарах үед
 - Ар талын автомашины ойр орчимд хашлага, хана бусад хөдөлгөөнгүй эд зүйл байгаа

Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт)*

* Тоноглогдсон загварт

Тус систем арын гуперын дотор талд байрлах радарын мэдрэгч ашигладаг. Зогсож байгаа автомашин ар талаараа мөргөлтөд өртөх магадлал өндөр гэж тооцсон үед мөргөлтийн нөлөөгөөр автомашин хөдлөн өөр зүйл мөргөх хоёр дахь мөргөлтийн хохирлыг бууруулах үүднээс систем автоматаар тоормосны системийг удирддаг.



АЮУЛТАЙ

■ Системийн ашиглалттай холбоотой анхааруулга


Жолооч аюулгүй жолоодлогыг бүрэн хангах үүрэгтэй. Замын хөдөлгөөнд цаг ямагт аюулгүй оролцож ойр орчимдоо анхаарал хандуулна. Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт) нь зогсож байгаа автомашин ар талаараа мөргөлтөд өртөх магадлал өндөр гэж тооцсон үед мөргөлтийн нөлөөгөөр үүсэх хоёр дахь мөргөлтийн хохирлыг бууруулах нэмэлт функц юм. Тухайн нөхцөлөөс хамаарч систем зөв ажиллахгүй байж болно. Тиймээс жолооч өөрийн нүдээр замын аюулгүй байдлыг шалгах шаардлагатай. Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ Системийн хэвийн ажиллагааг хангах

→Х.301

Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт)-н ажиллагаа

Тус систем арын гуперын дотор талд байрлах радарын мэдрэгч ашиглан зогсож буй үед ар талаас мөргөх магадлал өндөртэй автомашиныг мэдэрдэг. Зогсож байгаа автомашин ар талаараа мөргөлтөд өртөх магадлал өндөр гэж тооцсон үед мөргөлтийн нөлөөгөөр автомашин хөдлөн өөр зүйл мөргөх хоёр дахь мөргөлтийн хохирлыг бууруулах үүднээс систем автоматаар тоормосны гэрэл болон системийг удирддаг.



■ Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт) ажиллах нөхцөл

Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт) дараах нөхцөлд ажиллана:

- Асаах товч ON горимд байгаа.
- Арааны хөшүүрэг R-с бусад араанд байгаа үед
- Эргэх дохионы хөшүүргийг түлхээгүй
- Систем ажилласнаас хойш 7 минут өнгөрсөн
- Таны болон ар талын автомашин хоорондын харьцангуй хурд 30-100 км/ц (19-62 миль/ц) хооронд байгаа
- Таны автомашины хурд 0 км/ц (0 миль/ц)

*: N араатай үед тоормос гишгээгүй, зогсоолын тоормос, тоормос баригч ажиллаагүй байгаа

■ Дараах нөхцөлд хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт) автомашиныг мэдэрнэ

Мэдрэх хүрээнд тухайн эгнээгээр явж буй ар талаас мөргөх магадлал өндөртэй автомашиныг хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт) мэдэрнэ.

■ Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт) автомашин танихгүй байх нөхцөлүүд

Хоёр дахь мөргөлтийн тоормос (зогсож буй үеийн арын мөргөлт) дараах автомашин, объект мэдрэхгүй:

- Бага оврын мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч зэрэг
- Замын хашлага, хана, тэмдэг, зогсож буй автомашин мөн бусад ижил төрлийн хөдөлгөөнгүй эд зүйл
- Эсрэг чиглэлийн автомашин
- Хажуу эгнээний автомашин*

*: Тухайн нөхцөлөөс хамаарч автомашин, объектыг мэдрэх тохиолдол байдаг.

■ Систем хэвийн ажиллахгүй байх нөхцөлүүд

- Дараах нөхцөлүүдэд систем ар талын автомашиныг мэдрэхгүй байж болно:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчимд шавар, цас, мөс, наалт наасан, тогтсон үед
 - Аадар бороо, цас, манан зэрэг цаг агаарын нөхцөл байдлаас тогтоол ус үүссэн замаар явах үед
 - Өгсүүр болон уруу олон давтамжтай үргэлжилсэн замаар явах
 - Автомашин чирэх үед
 - Зогссон даруй араас ойртон ирсэн автомашин
 - Арын автомашин чанх араас ойртож ирээгүй үед
 - Арын автомашин ташуу өнцгөөс ойртож ирсэн
 - Ар талд гэнэт орж ирсэн автомашин
 - Бусад автомашины ар талд огцом орсон
 - Ар талд олон автомашин байгаа
 - Ар талын автомашины ойр орчимд хашлага, хана бусад хөдөлгөөнгүй эд зүйл байгаа
 - Ар талын автомашин гүйцэж түрүүлсэн
 - Өгсүүр болон уруу олон давтамжтай үргэлжилсэн замаар явах
 - Арын автомашин хэт өндөр, нам
 - ар талд олон автомашин байгаа
 - Автомашины хойд талд нэмэлт тоноглол (унадаг дугуйн суурь зэрэг) суурилуулсан
- Дараах нөхцөлүүдэд мөргөлтөд өртөх магадлал байхгүй байсан ч систем ажиллах магадлал нэмэгдэнэ:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Автомашин чирэх үед
 - Таны автомашины ойр орчимд олон автомашин байгаа
 - Баруун/зүүн эргэлт хийхээр зогсох үед ар талаар автомашин явж өнгөрөх
 - Ар талын автомашин гүйцэж түрүүлэхээсээ өмнө ойртож ирсэн

- Ойр орчимд олон автомашин байгаа
- Ар талд олон автомашин байгаа
- Ар талын автомашины ойр орчимд хашлага, хана бусад хөдөлгөөнгүй эд зүйл байгаа
- Замын хажууд зогсох үед ар талаас автомашин ойртон гүйцэж түрүүлэх
- Зогссон эсвэл хөдөлгөөн эхэлсэн даруйд ар талаас автомашин ойртон ирэх
- Хальтиргаатай зам дээр тоормослон дугуй түгжигдэх үед ар талаас автомашин ойртон ирэх
- Автомат авто угаалга дээр угаалгах үед

Аюулгүй буухад туслах систем

Аюулгүй буухад туслах систем (хаалга нээх удирдлагатай) нь арын гиперны дотор талд байрлах хойд хажуугийн радарын мэдрэгч ашиглан жолооч, зорчигчид буухаар нээсэн хаалгыг ойртож буй автомашин, унадаг дугуй мөргөх эрсдэл байгаа эсэхийг мэдэхэд туслах мөн мөргөлтийн эрсдэлийг бууруулах үүднээс хаалга нээх ажиллагааг цуцладаг.


АЮУЛТАЙ

■ Системийн ашиглалттай холбоотой анхааруулга

- Жолооч аюулгүй жолоодлогыг бүрэн хангах үүрэгтэй. Замын хөдөлгөөнд цаг ямагт аюулгүй оролцож ойр орчимдоо анхаарал хандуулна.
- Тус систем нь автомашин зогссон үед бусад автомашин, унадаг дугуй ойртож буй эсэхийг жолооч, зорчигчдод мэдээлдэг туслах систем болно. Систем дангаараа аюулгүй байдлыг бүрэн дүгнэх боломжгүй ба системийн ажиллагаанд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэн.

Тодорхой нөхцөлүүдэд систем бүх хүчин чадлаараа ажиллах боломжгүй байж болно. Тиймээс жолооч, зорчигчид аюулгүй байдлыг өөрийн нүдээр шууд харах мөн толь ашиглах шаардлагатай.

Системийн эд ангиуд



A Голын дэлгэц

Аюулгүй буухад туслах системийг асааж унтраана.

B Хажуугийн толины индикатор

Хаалга нээх үед хаалгатай (тээшний хаалганаас бусад) мөргөлдөж болзошгүй автомашин, унадаг дугуй мэдрэгдсэн үед тухайн мэдэрсэн талын хажуугийн толины индикатор (→X.90) асна.

C Мэдээллийн дэлгэц

Мөргөлт үүсэх эрсдэлтэй үед хаалга нээвэл мэдээллийн дэлгэц дээр хаалганы тэмдэг гарна. Хажуугийн толины индикатор ассан үед хаалга нээвэл дохио дуугарч анхааруулга өгнө.

D Жолоодлогод туслах мэдээллийн индикатор

Аюулгүй буухад туслах системийг унтраах үед асна. Энэ үед мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

E Спикер

Хажуугийн толины индикатор анивчих үед дуут зааварчилгаа өгч жолоочид систем ажилласныг мэдэгдэнэ. Дуут зааварчилгаа дууссаны дараа хаалга бүрэн хаах

хүртэл систем дахин мэдэгдэл өгөхгүй.

■ Хажуугийн толины индикаторын харагдах байдал

Нарны хүчтэй гэрэлд хажуугийн толины индикатор сайн харагдахгүй байж болно.

■ Анхааруулах дуут дохио

Хөгжмийн дуу чанга зэргээр дуу чимээтэй үед дуут дохио муу сонсогдож болно.

■ Дуут зааварчилгаа

Дараах нөхцөлүүдэд дуут зааварчилгаа гарахгүй:

- Жолооч, зорчигчид автомашинд байхгүй гэж тооцсон үед*
- Хаалга нээж автомашинд сууснаас хөдөлгүүр асаах хүртэл
- Хөдөлгүүр унтрааснаас хойш 3-с дээш минут өнгөрсөн
- Голын дэлгэцийн хэлийг дуут зааварчилгаа дэмждэггүй хэлээр тохируулсан
- Бүх хаалга гадна талаас түгжигдсэн
- Хөдөлгүүр унтрааснаас хойш хаалга 1 минутаас удаан хугацаанд нээлттэй байсан
- Голын дэлгэцийн өөрчлөх боломжтой тохиргоогоор ACC горимыг (→X.583) идэвхжүүлсэн ба хөдөлгүүр унтраасан
- Голын дэлгэцэн дээрх зогсоолд байрлуулахад туслах системийн дууны түвшнийг унтраасан

*: Систем хаалга нээх хаах үйлдлээр хөдөлгөөн эхлэхийн өмнө суудал бүр дээр зорчигч суусан, хөдөлгөөн дууссаны дараа зорчигч буусан гэж тооцоолдог.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим функцийг өөрчлөх боломжтой. (→X.583)



АЮУЛТАЙ

■ Системийн хэвийн ажиллагааг хангах

→X.301

өөрчлөх боломжтой тохиргоогоор асааж унтраана. (→X.583)

Системийг унтраасан үед жолоодлогод туслах мэдээллийн индикатор асаж мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

Асаах товчийг ON-д шилжүүлэх бүрд аюулгүй буухад туслах систем асна.


Аюулгүй буухад туслах системийг асаах, унтраах

Аюулгүй буухад туслах системийг

Аюулгүй буухад туслах системийн ажиллагаа

■ Аюулгүй буухад туслах системийн мэдрэх боломжтой объект


Аюулгүй буухад туслах систем ар талд байгаа дараах автомашин, унадаг дугуйг хойд хажуугийн радарын мэдрэгчээр мэдрэн жолооч, зорчигчдод хажуугийн толины индикатор, дуут дохио, мэдээллийн дэлгэцийн болон дуут зааварчилгаагаар дамжуулан мэдэгддэг.



A Нээх үед хаалгатай (тээшний хаалганаас бусад) эсвэл зорчигчтой мөргөлдөх магадлал өндөртэй автомашин, унадаг дугуй

■ Аюулгүй буухад туслах системийн мэдрэх хүрээ

Мэдрэх хүрээг дараах зургаар харуулав.



A Урд хаалганы хойд хэсгээс арагш 45 м (145 фут) зай*

*: Ойртож буй автомашин, унадаг дугуйн хурд өндөр байх тусам хажуугийн толины индикаторын асах, анивчих хугацаа эрт байна.

■ Аюулгүй буухад туслах системийн ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед аюулгүй буухад туслах систем ажиллана:

- Асаах товч ON горимд байгаа ба хөдөлгүүрийг унтрааснаас хойш эсвэл хаалга нээж жолооч, зорчигч сууснаас 3 хүртэлх минут өнгөрсөн (хаалга нээгээд хаасан үед ажиллах хугацаа уртсаж болно).
- Аюулгүй буухад туслах систем асаалттай
- Автомашин зогссон
- Арааны R-с бусад байрлалд байгаа

■ Аюулгүй буухад туслах системийн автомашин мэдрэх нөхцөл

Аюулгүй буухад туслах систем мэдрэх хүрээнд автомашин байгааг дараах үед мэдэрнэ:

- Автомашин зогссон ба хаалга нээх (тээшний хаалганаас бусад) хэсэг дэх мэдрэх хүрээнд хажуу эгнээгээр автомашин, унадаг дугуй явж байгаа

■ Систем автомашин мэдрэхгүй нөхцөлүүд

- Аюулгүй буухад туслах систем дараах объект, автомашин, унадаг дугуйг мэдрэхгүй:
 - Удаан хурдаар ойртож буй автомашин, унадаг дугуй
 - Хаалга нээх (тээшний хаалганаас бусад) үед хаалгатай мөргөлдөх магадлал багатай гэж тооцоолсон автомашин, унадаг дугуй
 - Чанх ардаас ойртож буй автомашин, унадаг дугуй
 - Урдаас ойртож буй автомашин, унадаг дугуй
 - Замын хашлага, хана, замын тэмдэг, зогссон автомашин бусад хөдөлгөөнгүй объект
 - Явган зорчигч, амьтан зэрэг*

*: Тухайн нөхцөлөөс хамаарч

автомашин, объектыг мэдрэх тохиолдол байдаг.

- Аюулгүй буухад туслах систем нь дараах нөхцөлүүдэд ажиллахгүй:
 - Хөдөлгүүр унтрааснаас хойш 3-с дээш минут өнгөрсөн (хаалга нээгээд хаасан үед ажиллах хугацаа уртсаж болно)
 - Таны автомашин бүрэн зогсоогүй

■ Систем зөв ажиллахгүй байж болох нөхцөлүүд

- Аюулгүй буухад туслах систем дараах нөхцөлүүдэд автомашиныг зөв мэдрэхгүй байж болно:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчимд шавар, цас, мөс, наалт наасан, тогтсон үед
 - Аадар бороо, цас, манан зэрэг цаг агаарын нөхцөл байдлаас тогтоол ус үүссэн замаар явах үед
 - Зогсоолд байрлуулсан автомашины араас ойртож буй автомашин эсвэл унадаг дугуй
 - Огцом эгнээгээ өөрчлөн араас ойртож буй автомашин, унадаг дугуй
 - Хөдөлгөөнөө эхэлж буй автомашин, унадаг дугуй
 - Тээшний хаалга нээлттэй үед
 - Автомашины хойд талд унадаг дугуйн суурь бусад нэмэлт тоноглол суурилуулсан үед
 - Ар талд хүн, замын хаалт, хана, самбар, зогсож буй автомашин бусад төстэй хөдөлгөөнгүй объект байгаа үед
 - Автомашин хазгайдуу зогссон үед
 - Ойртож буй автомашин, унадаг дугуйтай ойр бусад автомашин явж байгаа үед
 - Хана, самбар, эдгээртэй төстэй хөдөлгөөнгүй объектыг даган автомашин, унадаг дугуй ойртон ирсэн үед
 - Автомашин, унадаг дугуй өндөр хурдаар ойртон ирж байгаа үед
 - Автомашин чирч байгаа үед


- Огцом налуу зам дээр зогссон үед
- Эргэлттэй замын төгсгөл эсвэл дунд хэсэгт автомашин зогссон үед
- Дараах нөхцөлүүдэд аюулгүй буухад туслах систем автомашин, объектыг буруу таних магадлал нэмэгдэнэ:
 - Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөнөөс шалтгаалж мэдрэгчийн байрлал алдагдсан үед
 - Автомашин, унадаг дугуй автомашины ар талаас ташуу өнцгөөр ойртох үед
 - Автомашин хэзгйдүү зогссон үед
 - Зогсоолд байрлуулсан автомашины араас тодорхой өнцгөөр ойртож буй автомашин, унадаг дугуй
 - Ар талд хүн, замын хаалт, хана, самбар, зогсож буй автомашин бусад төстэй хөдөлгөөнгүй объект байгаа үед
 - Ойртож буй автомашин, унадаг дугуй огцом чиглэлээ өөрчилсөн үед
 - Хана, самбар, эдгээртэй төстэй хөдөлгөөнгүй объектыг даган автомашин, унадаг дугуй ойртон ирсэн үед
 - Тээшний хаалга нээлттэй үед
 - Автомашины хойд талд унадаг дугуйн суурь бусад нэмэлт тоноглол суурилуулсан үед
 - Автомашин, унадаг дугуй өндөр хурдаар ойртон ирж байгаа үед
 - Автомашин чирч байгаа үед
 - Огцом налуу зам дээр зогссон үед
 - Эргэлттэй замын төгсгөл эсвэл дунд хэсэгт автомашин зогссон үед
 - Хажуу эгнээнд зогсож буй автомашины араас бусад автомашин, унадаг дугуй ойртон ирж буй үед

Lexus parking assist-мэдрэгч

Lexus parking assist-мэдрэгч нь автомашин болон хана зэрэг объект хоорондын ойролцоо зайг хэт авианы мэдрэгчээр мэдрэн зайг жолоочид голын дэлгэц дээр харуулан дохиогоор мэдэгддэг.

Системийн эд ангиуд

■ Мэдрэгчийн төрөл



- A** Урд булангийн мэдрэгч
- B** Урд голын мэдрэгч
- C** Хойд булангийн мэдрэгч
- D** Хойд голын мэдрэгч


■ Дэлгэц

Мэдрэгч хана зэрэг аливаа саад байгааг мэдэрч голын дэлгэцийн заалтаар жолоочид саадын байрлал болон саад хүртэлх зайг мэдээлнэ.

Голын дэлгэц эсвэл арын камергүй автомашин: Хөдөлгөөнгүй объект мэдэрсэн үед Lexus parking assist-

мэдрэгчийн индикатор асна.
(→X.90)

► Голын дэлгэц



A Урд булангийн мэдрэгч мэдрэх

B Урд голын мэдрэгч мэдрэх

C Хойд булангийн мэдрэгч
мэдрэх

D Хойд голын мэдрэгч мэдрэх

Lexus parking assist- мэдрэгчийг асааж унтраах

Lexus parking assist-мэдрэгчийг өөрчлөх боломжтой тохиргоогоор асаах/унтраах боломжтой.
(→X.583)

Lexus parking assist-мэдрэгчийг унтраасан үед мэдээллийн дэлгэц дээр “Lexus parking assist-sensor OFF” индикатор (→X.90) асна.

Системийг OFF горимд унтраасан үед өөрчлөх боломжтой тохиргоогоор (→X.583) дахин ON горимд асаах хүртэл Lexus parking assist-мэдрэгч асахгүй.
(Тус аргаар унтраасан үед асаах

товчийг унтраагаад ON горимд асаасан ч мэдрэгч асахгүй.)

Мультимедиа дэлгэц эсвэл арын камергүй автомашин: Нөгөөтээгүүр араар R байрлалд шилжүүлэх үед систем автоматаар асааж Lexus parking assist-sensor OFF индикатор унтарна.

Арааны R байрлалд Lexus parking assist-мэдрэгчийг асаах болон унтраах боломжгүй.

Энэ үед Lexus parking assist-мэдрэгчийн тохиргоо өөрчлөгдөхгүй.



АЮУЛТАЙ

■ Системийн ашиглалттай холбоотой анхааруулга

Системийн мэдрэх түвшин болон хариу үйлдлийн гүйцэтгэл хязгаартай тул системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй. Жолооч нь орчны аюулгүй байдлыг нягтлан аюулгүй жолоодлого хийх үүрэгтэй.

■ Системийн хэвийн ажиллагааг хангах

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд системийн хэвийн ажиллагаа алдагдаж улмаар осолд хүрэх аюултай. Эдгээр анхааруулгыг мөрдөх боломжгүй нөхцөлд системийг унтраана.

● Мэдрэгчийг гэмтлээс хамгаалах ба цаг ямагт цэвэр байлгана.

● Наалт эсвэл дугаар нь гэрэлтдэг улсын дугаар (ялангуяа өдрийн гэрэл ашигласан) зэрэг электрон хэрэгсэл, манангийн гэрэл, гуперны төмөр хамгаалалт, утасгүй антен зэргийг мэдрэгчийн ойр орчимд суурилуулж болохгүй.

● Мэдрэгч болон ойр орчмыг хүчтэй цохилтоос хамгаална. Мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтод өртсөн бол Lexus дилерт хандаж оношлуулна уу. Мэдрэгч, урд болон арын гупер салгах/угсрах эсвэл солих үед Lexus дилерт хандана уу.

● Мэдрэгчийг өөрчлөх, задлах, будахыг хориглоно.



АЮУЛТАЙ

● Улсын дугаарын таг ашиглахгүй.

● Дугуйны хийг зөв хийлнэ.

● Зөвхөн оригинал явах эд ангийн сэлбэг ашиглана.

■ Автомашин угаах үед

● Өндөр даралтын автомашин угаагчаар угаах үедээ мэдрэгчийг гэмтээх аюултай тул мэдрэгч рүү шууд шүршиж болохгүй.

● Халуун уураар угаах нь мэдрэгчийг гэмтээх тул хэт ойртуулж болохгүй.

■ Системийн ажиллах нөхцөл

- Асаах товч ON горимд байгаа.
- Lexus parking assist-мэдрэгчийн функц идэвхжүүлсэн.
- Автомашины хурд 10км/ц (6 миль/ц)-с бага.
- Арааны хөшүүрэг P-с бусад араанд байгаа.
- Мультимедиа дэлгэц эсвэл арын камергүй автомашин: Арааг R байрлалд шилжүүлэх үед систем автоматаар асаж Lexus parking assist-sensor OFF индикатор

унтарна.

Энэ үед Lexus parking assist-мэдрэгчийн тохиргоо өөрчлөгдөхгүй.

■ Системийн мэдрэгчийн мэдээлэл

- Мэдрэгчийн таних хүрээ нь зөвхөн автомашины урд болон хойд гуперын ойр орчмоор хязгаарлагдана.
 - Объектын хэлбэр болон бусад хүчин зүйлээс хамаарч таних зай ойр байх эсвэл объектыг танихгүй байж болно.
 - Мэдрэгчид хөдөлгөөнгүй объект хэт ойр байгаа үед таних боломжгүй.
 - Объектыг таних болон дэлгэцээр анхааруулга өгөх (анхааруулах дуут дохио) хооронд богино хугацааны хоцрогдол үүсэж болно. Хурд бага үед ч анхааруулга гарч дохио дуугарах хүртэл объект мэдрэгчийн мэдрэх зайнд ойртсон байж болно.
 - Аудио системийн дуу эсвэл агааржуулалтын системийн ажиллах дуунаас хамаарч анхааруулах дуут дохио сайн сонсогдохгүй байж болно.
 - Бусад системийн дуут дохионоос шалтгаалж системийн дуут дохио сонсогдохгүй байж болно.
 - Систем доголдсон үед анхааруулах дохио дуугарч болно.
- ### ■ Систем зөв танихгүй байж болох объектууд


Автомашины болон орчны тодорхой нэг нөхцөлүүд нь мэдрэгчийг саадыг зөв мэдрэхэд нөлөөлөх магадлалтай. Дараах объектуудыг анхаарна уу:

- Төмөр утас, хашаа, олс зэрэг
 - Хөвөн, цас болон бусад дууны долгионыг шингээдэг материал
 - Хурц өнцөгтэй объект
 - Намхан объект
 - Өндөр бөгөөд объектын дээд хэсэг нь таны автомашин руу илүү гарсан саад
- Өмсөж буй хувцасны төрлөөс хамаарч хүн мэдрэхгүй байж болно.

■ Систем хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд

Автомашины болон орчны зарим нэг нөхцөлүүд нь мэдрэгч саадыг зөв мэдрэхэд нөлөөлөх магадлалтай. Зарим бодит жишээг доор дурдав.

- Мэдрэгч бохирдсон эсвэл цас мөс тогтсон (Мэдрэгчийг цэвэрлэх үед ажиллагаа сэргэнэ.)
- Мэдрэгч хөлдсөн (Мэдрэгчийн ойр орчмыг гэсгээх шаардлагатай) Цаг агаарын хэт хүйтэн нөхцөлд мэдрэгч хөлдсөн үед дэлгэц хэвийн бус ажиллах эсвэл хана зэрэг объектыг мэдрэхгүй байж болно
- Мэдрэгчийн ойр орчим хэт халуун, хэт хүйтэн байгаа үед



- Хэт энхэл донхолтой, налуу эсвэл хайрга, өвстэй зам дээр
- Автомашины ойр орчимд дуут дохио, мотоциклийн хөдөлгүүр, том оврын автомашины хийн тоормос болон бусад хэт авиа ялгаруулдаг дуу чимээ ихтэй үед
- Мэдрэгч рүү аливаа эд юмс цацагдсан эсвэл аадар бороо орж байгаа үед
- Объект мэдрэгчид хэт ойр байгаа үед
- Явган зорчигч хэт авиаг ойлгодоггүй материалтай хувцас (жишээлбэл, урт юбка зэрэг) өмссөн үед
- Объект газартай тэгш биш эсвэл автомашины чиглэлээс хөндлөн байрлалд биш, тэгш бус гадаргуутай эсвэл мэдрэх хүрээнд дэрвэж байгаа үед
- Хүчтэй салхитай үед
- Манан, цас, шороон шуурга зэрэг


цаг агаар муу үед

- Мэдэрсэн объект болон автомашины хооронд систем мэдрэх боломжгүй объект байгаа үед
- Автомашин, мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч урдуур огцом орсон эсвэл хажуугаар хурдтай өнгөрсөн үед
- Мөргөлт эсвэл бусад цохилтоос шалтгаалан мэдрэгчийн чиглэл алдагдсан үед
- Чирэх дэгээ, гиперны хамгаалалт (нэмэлт хүрээ зэрэг), унадаг дугуйн суурь, цас түрэх хусуур зэрэг мэдрэгчийг халхалж болзошгүй саад автомашинд суурилуулсан үед
- Ачсан ачаа тээшнээс хамаарч урд тал өргөгдсөн эсвэл доош дарагдсан
- Автомашин осолд орсон, системд доголдол үүссэн зэргээр автомашиныг хэвийн жолоодох боломжгүй үед
- Дугуйн гинж, жижиг нөөц дугуй эсвэл ослын дугуй засах нөхөөс ашигласан үед
- Автомашин чирч байгаа үед

■ Мөргөлт үүсэх магадлал байхгүй байсан ч систем ажиллаж болзошгүй нөхцөлүүд


Дараах нөхцөлүүдэд мөргөлт үүсэх магадлал байхгүй байсан ч систем ажиллаж болзошгүй.

- Нарийн замаар явах үед



- Самбар, туг, модны мөчир, замын хаалт (төмөр замын гарам, төлбөртэй зам, авто зогсоолын хаалт) зэрэгт ойртох үед


- Замын гадаргуу дээр энхэл донхол, нүх байгаа үед
- Борооны ус зайлуулах төмөр таг (торон) зэрэг зам дээрх металл гадаргуу дээр явах үед
- Огцом өгсүүр, уруу замаар явах үед
- Зам дээр буусан үер зэрэг их хэмжээний ус мэдрэгчийг цохисон үед
- Мэдрэгч мөс, цас, шороо тоос зэрэг тогтож бохирдсон үед. (мэдрэгчийг арчиж цэвэрлэх үед системийн хэвийн ажиллагаа сэргэнэ)
- Хүчтэй бороо, ус мэдрэгч руу цацагдаж байгаа үед
- Манан, цас, элсэн шуурга зэрэг цаг агаарын тааламжгүй нөхцөлд жолоодох үед
- Хүчтэй салхитай үед



- Автомашины дуут дохио, автомашин мэдрэгч, мотоциклын хөдөлгүүр, том оврын автомашины хийн тоормос бусад автомашины сонар мэдрэгч эсвэл автомашины ойр орчимд хэт авианы долгион үүсгэгч төхөөрөмж байгаа үед
- Ачсан ачаа тээшнээс хамаарч урд тал өргөгдсөн эсвэл доош дарагдсан
- Чиргүүл чирэх үед
- Мөргөлт болон бусад цохилтын нөлөөллөөс мэдрэгчийн чиглэл өөрчлөгдсөн
- Өндөр эсвэл мурийсан замын хашлаганд ойртсон
- Олон давхар авто зогсоол, баригдаж буй барилга доторх багануудад (Н хэлбэртэй төмөр

багана зэрэг) ойртох үед


- Осолд орсон эсвэл систем доголдсон зэрэг шалтгаанаар автомашиныг хэвийн жолоодох боломжгүй үед
- Хэт энхэл донхолтой, налуу эсвэл өвстэй замаар явах үед



- Дугуйн гинж, жижиг нөөц дугуй эсвэл ослын дугуй засах нөхөөс ашигласан үед
- Автомашин чирэх үед

Системийн мэдрэх хүрээ

■ Мэдрэгчийн мэдрэх хүрээ



A 100 см (3.3 фут) орчим

B 150 см (4.9 фут) орчим

C 60 см (2.0 фут) орчим

Тус зурагт мэдрэгчийн мэдрэх боломжтой хүрээг харуулав.

Автомашинд хэт ойр байгаа объектыг мэдрэгч мэдрэх боломжгүйг анхаарна уу.

Мэдрэх хүрээ нь объект зэргийн хэлбэрээс хамаарч өөрчлөгдөж болно.

■ Зай болон дуут дохио

Саад хүртэлх ойролцоо зай	Дуут дохио
Урд мэдрэгч: 100-с 60 см (3.3-с 2.0 фут)* Арын мэдрэгч: 150-с 60 см (4.9-с 2.0 фут)*	Удаан
60-с 45 см (2.0-с 1.5 фут)*	Дунд зэрэг
45-с 30 см (1.5-с 1.0 фут)*	Хурдан
30 см (1.0 фут) хүртэл	Үргэлжлэн дуугарах

* : Автоматаар анхааруулах дуут дохиог унтраах функц идэвхэжсэн. (→X.321)

Lexus parking assist-мэдрэгчийн дуут дохио

Мэдрэгч ажиллах үед анхааруулах дуут дохио дуугарна.

- Объектод 30 см (1.0 фут) хүртэлх зайд ойртох үед анхааруулах дуут дохио үргэлжлэн дуугарна.
- 2-с дээш мэдрэгч хөдөлгөөнгүй объектыг зэрэг мэдэрсэн үед илүү ойр байгаа мэдрэгчийн дуут дохио дуугарна.
- Дуут дохио дуугарах үед автомашин болон хөдөлгөөнгүй объект хоорондын зай улам ойртоогүй нөхцөлд дуут дохионы дуу автоматаар хаагдана. (дуут дохионы дууг автоматаар хаах функц)

■ Дуут дохионы дууны хэмжээг тохируулах

Lexus parking assist-мэдрэгч, RCTA, болон RCD функцийн дууг өөрчлөх боломжтой тохиргоогоор зэрэг хаах боломжтой. (→X.583)

■ Дуут дохионы дууг хаах

Объект мэдрэгдэх үед голын дэлгэц дээр дуут дохионы дууг хаах товч гарч ирнэ. Товч дарж дууг хаана.

Товч дарах үед Lexus parking assist-мэдрэгч, RCTA, болон RCD функцийн дуу зэрэг хаагдана.

- Дууг хаах тохиргоо дараах нөхцөлд автоматаар цуцлагдана:
 - Арааны хөшүүрэг сэлгэсэн
 - Автомашины хурд тодорхой хурднаас давсан
 - Мэдрэгчид доголдол үүссэн эсвэл системийн ажиллагаа түр цуцлагдсан
 - Ажиллаж буй функцийг гар аргаар цуцалсан
 - Асаах товчийг унтраасан

RCTA функц

RCTA функц функц нь хойд гуперт суурилсан BSM хойд хажуугийн радарын мэдрэгчийг ашигладаг. Тус функц нь ухрах үед харагдах байдал муутай хэсгийг жолооч шалгахад туслах зориулалттай.



АЮУЛТАЙ

■ Системийн ашиглалттай холбоотой анхааруулга

Жолооч нь жолоодлогын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Ойр орчмоо анхааран цаг ямагт аюулгүй жолоодно.

RCTA функц нь автомашины баруун, зүүн хойноос автомашин ойртож буйг жолоочид анхааруулах туслах функц юм.


Тодорхой нөхцөлд RCTA зөв ажиллахгүй байж болох тул шаардлагатай үед жолооч өөрийн нүдээр аюулгүй байдлыг шалгана.

Тус функцэд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.

■ Системийн хэвийн ажиллагааг хангах

→X.301

Системийн эд ангиуд



A Голын дэлгэц

RCTA функцийг голын дэлгэц дээр асааж унтраана.

Баруун, зүүн хойд талаас автомашин ойртож буй нь мэдрэгдсэн үед голын дэлгэц дээр тухайн талын RCTA тэмдэг (→X.323) гарна. Тус зурагт * 2 талаас автомашин ойртож буй жишээг харуулав.

*: Автомашины зэрэглэл болон тоноглолоос хамаарч бодит дэлгэц тус зургаас өөр байж болно.

B Хажуугийн толины индикатор

Баруун, зүүн хойд талаас автомашин ойртож буй нь мэдрэгдэх үед хоёр хажуугийн толины индикатор (→X.90) анивчиж дохио дуугарна.

C Жолоодлогод туслах

мэдээллийн индикатор

RCTA функцийг унтраасан үед асна. Энэ үед мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл асна.

RCTA функцийг асаах, унтраах

RCTA функцийг өөрчлөх боломжтой тохиргоогоор асаах, унтраах боломжтой. (→X.583)

RCTA функцийг унтраасан үед жолоодлогод туслах мэдээллийн индикатор (→X.90) асна. Энэ үед мэдээллийн дэлгэц дээр функц унтарсныг илтгэх мэдээлэл асна. Асаах товчийг ON горимд шилжүүлэх бүрд RCTA функц асна.

■ Хажуугийн толины индикаторын харагдах байдал

Хүчтэй нарны гэрэлд индикатор гэрэл сайн харагдахгүй байж болно.

■ RCTA дуут дохионы дуугарах байдал


Хөгжмийн дуу чанга зэргээр дуу чимээтэй үед RCTA дуут дохио муу сонсогдож болно.

Хойд хажуугийн радарын мэдрэгч
→X.301

RCTA функц

■ RCTA функцийн ажиллагаа

Тус функц нь автомашины баруун болон зүүн хойд талаас ойртож буй автомашиныг радарын мэдрэгч ашиглан мэдрэх ба хажуугийн толины индикатор болон анхааруулах дохио дуугаргаж жолоочид автомашин ойртож буйг анхааруулна.





A Ойртож буй автомашин

B Функцийн мэдрэх хүрээ

■ RCTA дэлгэц


Систем автомашины баруун болон зүүн хойд талаас ойртож буй автомашиныг мэдрэсэн үед дараах тэмдэг мультимедиа дэлгэц дээр гарна.

● Зурагт 2 талаас автомашин ойртох үеийн жишээ харуулав.



■ Функцийн мэдрэх хүрээ

Ойртож буй автомашиныг мэдрэх хүрээг дараах зурагт үзүүлэв.



Жолоочид хариу үйлдэл хийх хангалттай хугацаа өгөх үүднээс автомашин хурдтай ойртож байгаа үед илүү холоос анхааруулга өгөх боломжтой.

Жишээ:

Ойртож буй автомашины хурд	A Анхааруулга өгөх зай
56 км/ц (34 миль/ц) (хурдан)	30м (98 фут.)
8 км/ц (5 миль/ц) (удаан)	4м (13 фут.)

■ RCTA функцийн ажиллах нөхцөл

RCTA функц дараах нөхцөлүүд бүрдсэн үед ажиллана:

- Асаах товч ON горимд байгаа.
- RCTA функц асаалттай.
- Арааны хөшүүрэг R байрлалд.
- Автомашины хурд 15 км/ц (9 миль/ц).
- Ойртож буй автомашины хурд ойролцоогоор 8 км/ц (5 миль/ц)-56 км/ц (34 миль/ц)-ын хооронд байх.

■ Анхааруулах дохионы дуу

RCTA, Lexus parking assist-мэдрэгч, болон RCD (тоноглогдсон загварт) зэрэг функцийн дууны хэмжээг тохируулах боломжтой.

(→X.583)

■ Дуут дохионы дуу хаах

Объект мэдрэгдэх үед мэдээллийн дэлгэц болон мультимедиа дэлгэц дээр дуут дохионы дууг хаах товч

гарч ирнэ. Дохионы дууг **OK** эсвэл **OK** товч дарж **OK** дарна. Lexus parking assist-мэдрэгч, RCTA болон RCD (тоноглогдсон загварт) функцийн дуут дохионы дуу мөн хаагдана.


Дараах нөхцөлд дуу хаах тохиргоо автоматаар цуцлагдана:

- Арааны хөшүүргийг сэлгэсэн.
- Автомашины хурд тодорхой хурднаас давсан.
- Мэдрэгчид доголдол үүссэн эсвэл системийн ажиллагаа түр цуцлагдсан.
- Ажиллаж буй функцийг гар аргаар цуцалсан.
- Хөдөлгүүрийн асаах товчийг унтраасан.

■ Дараах нөхцөлд RCTA функц ойртож буй автомашиныг мэдрэхгүй

RCTA функц нь дараах төрлийн тээврийн хэрэгсэл, объектыг мэдрэх боломжгүй:

- Чанх ардаас ойртон ирж буй автомашин
- Хажуу талд зогсож буй автомашин ухрах үед
- Саад байгаагаас шалтгаалж мэдрэгч мэдрэх боломжгүй автомашин




- Замын хашлага, хана, тэмдэг, зогсож буй автомашин болон бусад ижил төрлийн хөдөлгөөнгүй эд зүйл
- Бага оврын мотоцикл, унадаг дугуй, явган зорчигч г.м.
- Цааш явж буй автомашин
- Хажуу талын зогсоолыг талбайгаас ойртож буй автомашин
- Мэдрэгч болон ойртож буй автомашины зай хэт ойр

* : Тухайн нөхцөлөөс хамаарч автомашин, объектыг мэдрэхгүй тохиолдол байдаг.


■ RCTA функц хэвийн ажиллахгүй байх магадлалтай нөхцөлүүд

Эдгээр нөхцөлүүдэд RCTA функц автомашиныг танихгүй, систем хэвийн ажиллахгүй байх магадлалтай:


- Мэдрэгч, мэдрэгчийн ойр орчим хүчтэй цохилтонд өртсөнөөс мэдрэгчийн байрлал алдагдсан үед
- Арын гуперны мэдрэгч байрлах хэсэгт шавар, цас мөс тогтсон, наалт наасан үед
- Аадар бороо, цас, манан зэрэг цаг агаарын муу нөхцөлөөс норсон замаар явах үед
- Хоорондоо ойр зайтай хэд хэдэн автомашин ойртох үед
- Автомашин өндөр хурдаар ойртох үед
- Чирэх дэгээ, гуперны хамгаалалт (нэмэлт хүрээ зэрэг), унадаг дугуйн суурь, цас түрэх отвал зэрэг мэдрэгчийг халхалж болзошгүй саад автомашинд суурилуулсан үед
- Налуугийн хэмжээ огцом өөрчлөгдөх зам дээр ухрах үед




- Зогсоолын талбайгаас бага өнцгөөр ухарч гарах үед



- RCTA функц асаасан даруйд
- RCTA функц асаалттайгаар хөдөлгүүр асаасан даруйд
- Саадаас хамаарч мэдрэгч автомашиныг мэдрэх боломжгүй үед
- Чиргүүл чирэх үед
- Таны автомашин болон мэдрэх бүсэд орж ирсэн автомашин хоорондын өндрийн зөрүү их үед
- Мэдрэгчийн ойр орчим хэт халуун эсвэл хэт хүйтэн үед
- Явах эд ангийг өөрчилсөн, тохирохгүй хэмжээтэй дугуйтай үед
- Ачсан ачаанаас хамаарч автомашины урд тал өргөгдсөн, доош дарагдсан үед
- Ухрангаа эргэх үед




- Мэдрэх хэсэгт өөр автомашин эргэлт хийж байгаа үед




■ Мөргөлт үүсэх магадлал байхгүй байсан ч систем ажиллаж болзошгүй нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд RCTA функц автомашин, объектыг буруу таних магадлал нэмэгдэнэ:


- Авто замтай залгаа зогсоолын хажуугийн авто замаар автомашин явах үед




- Электрон долгионыг автомашины хойд тал руу буцаан ойлгож болзошгүй замын хашлага, хана, замын тэмдэг эсвэл зогсож буй автомашин зэрэг металл хийцтэй эд зүйлс хүртэлх зай ойр үед



- Чирэх дэгээ, гуперны хамгаалалт (нэмэлт хүрээ зэрэг), унадаг дугуйн суурь, цас түрэх отвал зэрэг мэдрэгчийг халхалж болзошгүй саад автомашинд суурилуулсан үед
- Таны автомашины хажуугаар өөр автомашин явж өнгөрөх үед



- Системийн мэдрэсэн автомашин эргэлт хийнгээ ойртож байгаа үед



- Сэнс, барилгын эйр кондишн зэрэг эргэлддэг объект ойр орчимд байгаа үед
- Усалгааны ус шүршигч зэргээс арын гупер лүү ус шүршигдсэн, цацагдсан үед
- Хөдөлгөөнтэй объект (туг, автомашины утаа, борооны том дусал, цас, замын гадаргуу дээрх борооны ус зэрэг.)
- Замын хашлага, хана зэрэг системийн мэдрэх хүрээнд орж ирсэн объект хүртэлх зай хэт ойр үед
- Борооны ус зайлуулах системийн төмөр тор, таг
- Мэдрэгчийн ойр орчим хэт халуун, хэт хүйтэн үед
- Явах эд ангийг өөрчилсөн, тохирохгүй хэмжээтэй дугуйтай үед
- Ачсан ачаанаас хамаарч автомашины урд тал өргөгдсөн, доош дарагдсан үед
- Автомашин чирч байгаа үед

RCD арын камераар мэдрэх функц арын камераар мэдрэгч функц*

*: Тоноглогдсон загварт

Автомашин ухрах үед автомашины ар талын мэдрэх хүрээнд явган зорчигч байгааг RCD функц мэдрэн ажиллана. Зорчигч мэдрэгдсэн үед анхааруулах дуут дохио дуугарч мультимедиа дэлгэц дээр зорчигч байгааг жолоочид анхааруулж тэмдэг гарна.



АЮУЛТАЙ

■ Системийн ашиглалттай холбоотой анхааруулга

Тус системийн явган зорчигч мэдрэх, хариу үйлдэл үзүүлэх чадвар хязгаартай.

Жолооч системд хэт найдалгүй ойр орчны аюулгүй байдлыг нягтлан цаг ямагт аюулгүй жолоодлого хийх үүрэгтэй.

■ Системийн хэвийн ажиллагааг хангах

Осолд хүргэх аюултай тул дараах зүйлсийг сайтар анхаарна.

- Камерыг гэмтээлгүй байнга цэвэрлэнэ.
- Камерын ойролцоо электрон төхөөрөмж (гэрэлтдэг дугаарын суурь, манангийн гэрэл зэрэг) суурилуулж болохгүй.
- Камерын ойр орчмыг хүчтэй цохилтоос хамгаална. Камерын ойр орчим хүчтэй цохилтонд өртсөн тохиолдолд Lexus дилер дээр оношлуулна уу.

- Камерыг задлах, өөрчлөх, будахыг хориглоно.
- Камерт наалт, нэмэлт чимэглэл наахыг хориглоно.
- Арын гуперт оригинал бус хамгаалалтын хэрэгсэл (гуперны хүрээ зэрэг) суурилуулж болохгүй.
- Дугуйны хээг зөв тохируулна.
- Арын хаалга бүрэн хаагдсан эсэхийг нягтална.


■ RCD функц унтрах

Дээрх нөхцөлүүдийг мөрдөөгүй тохиолдолд тус функц унтарч болно. RCD функц хэвийн ажиллахгүй байх нь осолд хүргэх аюултай тул сайтар анхааран мөрдөнө.


- Дээрх нөхцөлүүдийг мөрдөөгүй.
- Lexus-н оригинал бус явах эд анги угсарч ашигласан.

Системийн бүтэц

Арын камерын байрлал



RCD дэлгэц



A Явган зорчигч мэдрэх тэмдэг
Явган зорчигч мэдрэгдэх үед дэлгэц дээр гарна.

RCD функцийг идэвхжүүлэх, цуцлах


RCD функцийг идэвхжүүлэх буюу цуцлан тохируулах боломжтой.

RCD функцийг цуцлах үед жолоочид туслах мэдээллийн индикатор ($\rightarrow X.90$) асаж мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

Асаах товч унтраагаад асаах бүрд RCD функц автоматаар идэвхэжнэ.

Явган зорчигч мэдрэгдсэн үед

Системийн мэдрэх хүрээнд явган зорчигч байгааг мөн явган зорчигч ойртон ирж буйг функц мэдэрсэн үед дуут дохио дараах байдлаар ажиллаж дэлгэц дээр мэдээлэл гарна:



A Явган зорчигч **A**-д байгаа үед
Дуут дохио: Үргэлжлэн дуугарна
Явган зорчигчийн тэмдэг: Анивчиж асна

B Явган зорчигч **B**-д байгаа үед
Дуут дохио (Автомашин зогсож байгаа үед): 3 удаа дуугарна
Дуут дохио (Автомашин ухрах үед явган зорчигч ойртож ирсэн): Үргэлжлэн дуугарна
Явган зорчигчийн тэмдэг: 3 анивчаад үргэлжлэн асна.

C Автомашин явган зорчигчтой **C** бүсэд мөргөлдөх магадлалтай гэж систем тооцсон үед
Дуут дохио: Үргэлжлэн дуугарна
Явган зорчигчийн тэмдэг: Анивчиж асна.

■ RCD функц ажиллах нөхцөл

● Асаах товч ON горимд байгаа.

- RCD функц асаалттай.
- Араа R байрлалд байгаа.

■ Дуут дохионы дууны хэмжээг тохируулах

Өөрчлөх боломжтой тохиргоогоор Lexus parking assist мэдрэгч, RCTA болон RCD-н дуут дохиог өөрчлөх боломжтой. (→X.583)

■ Дуут дохионы дууны хэмжээ тохируулах

Мэдээллийн дэлгэцээр дуут дохионы дууны хэмжээг тохируулж болно.

Товч дээр дарахад Lexus parking assist мэдрэгч, RCTA болон RCD-н дуут дохиог зэрэг хаагдана.

Дууг хаах тохиргоо дараах нөхцөлд автоматаар цуцлагдана:

- Арааны хөшүүргийг сэлгэсэн.
- Автомашины хурд тодорхой хурднаас давсан.
- Мэдрэгчид доголдол үүссэн эсвэл системийн ажиллагаа түр цуцлагдсан.
- Ажиллаж буй функцийг гар аргаар цуцалсан.
- Хөдөлгүүрийн асаах товчийг унтраасан.

■ Системийн хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд

- Тус функц дараах зарим явган зорчигчийг таних боломжгүй байх улмаар систем хэвийн ажиллахгүй байж болно:
 - Урагш тонгойсон, явган суусан хүн
 - Хэвтэж буй хүн
 - Гүйж буй хүн
 - Мэдрэх хүрээнд огцом орж ирсэн хүн
 - Унадаг дугуй, скэйтборд бусад хөнгөн зорчих хэрэгсэл унасан хүн
 - Борооны цув, урт юбка зэрэг явган зорчигчийн харагдах байдлыг сарниулах том хувцастай хүн
 - Борооны цув, урт юбка зэрэг явган зорчигчийн харагдах байдлыг сарниулах том хувцастай хүн
 - Түрдэг тэрэг, шүхэр зэрэгт биеийн зарим хэсэг халхлагдсан хүн
 - Шөнийн цагаар зэрэг харанхуйд сайн харагдахгүй байгаа хүн

- Дараах нөхцөлүүдэд функц зарим явган зорчигчийг таних боломжгүй байх улмаар систем хэвийн ажиллахгүй байж болно:

- Цаг агаар муу (бороо, цас, манан зэрэг) үед ухрах үед
- Арын камер бохирдсон (шороо, цас, мөс зэрэг наалдсан) эсвэл линз зурагдсан үед
- Нар, автомашины их гэрэл зэрэг хүчтэй гэрэл арын камер луу шууд тусч байгаа үед
- Гарааш, газар доорх авто зогсоолын хаалганы ойр орчимд зэргээр орчны гэрлийн хэмжээ өөрчлөгддөг газар ухрах үед
- Үүр, үдшийн бүрий, газар доорх авто зогсоол зэрэг бүрэнхий орчинд ухрах үед
- Камерын байрлал болон чиглэл алдагдсан үед
- Чирэх дэгээ угсарсан үед
- Камерын линз дээр усны дусал урсаж байгаа үед
- Автомашины өндөр огцом өөрчлөгдсөн үед (хамар өргөгдөх, буух зэрэг)
- Дугуйн гинж эсвэл жижиг нөөц дугуй, онцгой үед дугуй нөхөх нөхөөс ашигласан үед
- Явах эд ангийг өөрчилсөн, үйлдвэрлэгчийн зааснаас өөр хэмжээтэй дугуй ашигласан үед
- Камерын ойр орчимд нэмэлт электрон тоноглол (улсын дугаарын гэрэл, манангийн гэрэл зэрэг) угсарсан
- Арын гуперт гуперны нэмэлт хүрээ, хормой зэргийг угсарсан үед
- Чиргүүл чирч байгаа үед

■ Систем санамсаргүй ажиллаж болзошгүй нөхцөлүүд

- Мэдрэх хүрээнд явган зорчигч байхгүй байсан ч дараах объект мэдрэх хүрээнд орсон үед тус функц ажиллаж болно.
 - Шон, замын конусан тэмдэг, хашаа эсвэл зогсож буй автомашин зэрэг гурван хэмжээт зүйл
 - Автомашин мотоцикл зэрэг хөдөлж буй объект
 - Ухрах үед туг дэрвэх, тогтоол ус цацагдах (эсвэл утаа, уур, бороо, цас зэрэг агаарт буй зүйл) зэргээр аливаа эд зүйл автомашинд ойртох

- Чулуун зам, хайрган хучилттай зам, трамвайн рельс, зам засвар, цагаан шугам, зам гарч явган зорчигч эсвэл зам дээр унасан навч
- Борооны ус зайлуулах сувгийн төмөр торон таг
- Тогтоол ус, зам дээр тогтсон усанд ойсон объект
- Зам дээр туссан сүүдэр
- Дараах нөхцөлүүдэд явган зорчигч мэдрэх хүрээнд байхгүй байсан ч функц ажиллаж болзошгүй:
 - Замын хажуу эсвэл зам дээр товгор хэсэг рүү чиглэн ухарсан
 - Өгсүүр, уруу зам руу чиглэн ухарсан
 - Ачсан ачаанаас хамаарч автомашины хойд тал өргөгдсөн, дарагдсан
 - Арын гуперт нэмэлт хүрээ зэрэг гуперын хамгаалалт суурилуулсан
 - Мөргөлт болон бусад хүчин зүйлээс хамаарч арын камерыг авсан эсвэл нэмж суурилуулсан
 - Автомашины ар талд чирэх дэгээ угсарсан
 - Арын камерын линз дээр усны дусал урссан
 - Арын камер бохирдсон (шороо, цас, мөс зэрэг наалдсан)
 - Бусад автомашины ослын дохионы гэрэл зэрэг анивчин гэрэл мэдрэх хүрээнд байгаа
 - Дугуйн гинж эсвэл жижиг нөөц дугуй, онцгой үед дугуй нөхөх нөхөөс ашигласан
 - Чиргүүл чирч байгаа үед
- RCD функцийн анхааруулгыг сонсох, мэдэхэд хүндрэлтэй байх нөхцөлүүд
- Аудио системийн дууны хэмжээ өндөр, агааржуулагчийн систем ажиллаж байгаа зэргээс шалтгаалж функцийн анхааруулах дуут дохио муу сонсогдож болно.
- Бүхээгийн хэм хэт нам, хэт өндөр үед голын дэлгэц хэвийн ажиллахгүй байж болно.

PKSB (Зогсоолд байрлуулахад туслах тоормос) систем**

* : Тоноглогдсон загварт

PKSB систем буюу зогсоолд байрлуулахад туслах тоормосны систем зогсоолд байрлуулах зэргээр бага хурдаар явах, ухрах үед ажилладаг дараах функцүүдээс бүрдэнэ. Мэдрэгдсэн объект болон явган зорчигчтой мөргөлдөх эрсдэлтэй гэж систем тооцоолсон үед анхааруулга ажиллана. Мэдрэгдсэн объект, явган зорчигчтой мөргөлдөх эрсдэл өндөр гэж тооцоолсон үед мөргөлтөөс сэргийлэх, мөргөлтийн хүчийг бууруулах үүднээс систем автоматаар тоормос ажиллуулна.

PKSB систем

Тус систем дараах объектыг мэдрэх боломжтой объект гэж мэдэрдэг. (Мэдрэх боломжтой объект нь функцээс хамаарч өөр байна.)

- PKSB тоормос (урд, хойд талын хөдөлгөөнгүй объект):→X.334
- PKSB тоормос (ар талын явж буй автомашин) (тоноглогдсон загварт):→X.337
- PKSB тоормос (ар талын явган

зорчигч) (тоноглогдсон
загварт):→Х.338

АЮУЛТАЙ

Системийн ашиглалттай холбоотой анхааруулга

Осолд хүргэх аюултай тул системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй.

Замын хөдөлгөөнд оролцохдоо ямагт орчин тойрондоо анхаарал хандуулж оролцоно.

Автомашин, зам, цаг агаарын нөхцөл зэргээс хамаарч систем ажиллахгүй байж болно.

Мэдрэгч болон радарын мэдрэх боломж хязгаартай. Замын хөдөлгөөнд оролцохдоо ямагт орчин тойрондоо анхаарал хандуулна.

● Жолооч хөдөлгөөний аюулгүй байдал, аюулгүй жолоодлогыг бүрэн хангах үүрэгтэй. Замын хөдөлгөөнд оролцохдоо ямагт орчин тойрондоо анхаарал хандуулж оролцоно. PKSB систем нь мөргөлтийн хүчийг бууруулахад зориулагдсан систем ба нөгөөтээгүүр зарим нөхцөлд ажиллахгүй байж болно.

● PKSB нь автомашиныг зогсооход зориулагдсан систем биш болно. Систем автомашиныг зогсоосон ч системийн тоормосны удирдлага 2 секундйн дараа цуцлагдах тул тоормосны дөрөө гишгэж бүрэн зогсооно.

● Системийн ажиллагааг хана зэрэг объект руу санаатайгаар жолоодож шалгах нь туйлын аюултай. Ийм үйлдэл огт хийж болохгүй.

■ Зогсоолд байрлуулахад туслах тоормос салгах нөхцөлүүд

Мөргөлт үүсэх аюул байхгүй хэдий ч дараах нөхцөлд систем ажиллаж болзошгүй тул салгана.

● Автомашиныг динамометрийн төхөөрөмж, дамарт хэмжилтийн төхөөрөмж ашиглан оношлох үед

● Автомашиныг усан онгоц, ачааны машин бусад тээврийн хэрэгсэл дээр ачин тээвэрлэх үед

● Амортизатор, явах эд ангийг өөрчилсөн, тохирохгүй хэмжээтэй дугуй суурилуулсан үед

● Ачсан ачаанаас үүдэн автомашины урд тал өргөгдсөн эсвэл доош дарагдсан үед

● Чирэх дэгээ, гуперны хамгаалалт (нэмэлт хүрээ зэрэг), унадаг дугуйн суурь, цас түрэх хусуур зэрэг мэдрэгчийг халхалж болзошгүй зүйл суурилуулсан үед

● Автомат авто угаалга ашиглах үед

● Автомашин осолд орсон, систем доголдсон зэрэг хэвийн жолоодлого хийх боломжгүй үед

● Автомашиныг автоспорт, бартаат замын жолоодлогод ашиглах үед

● Дугуйны хий зөв хийлэгдээгүй үед

● Дугуй хэт элэгдсэн үед

● Дугуйн гинж, жижиг нөөц дугуй, онцгой нөхцөлд хэрэглэх дугуйн нөхөөс ашиглаж байгаа үед

● Чиргүүл чирч байгаа үед

■ Явах эд ангийн анхааруулга

Автомашины явах эд ангийг өөрчилж болохгүй. Автомашины өндөр, хазайлт өөрчлөгдсөн үед мэдрэгч мэдрэх боломжтой объектыг зөв танихгүй байх улмаар осолд хүргэх аюултай.


Зогсоолд байрлуулахад туслах тоормос идэвх-жүүлэх, салгах

PKSB товч даран идэвхжүүлэх, цуцлах боломжтой.

PKSB-г цуцалсан үед жолоодлогод туслах мэдээллийн инди-

катор (→X.90) асаж мэдээллийн дэлгэц дээр мэдээлэл гарна.

OFF-д (цуцлах) шилжүүлсэн үед хөдөлгүүр унтраагаад асаасан ч буцаж идэвхжихгүй (Хөдөлгүүр асаах товчны ажиллагаагаар функц дахин идэвхжихгүй).



■ Дөрвөн дугуй хөтлөх системийн товч L4-д байгаа үед

Зогсоолд байрлуулахад туслах функц автоматаар цуцлагдана.

Хөдөлгүүрийн хүч хязгаарлах болон тоормосны удирдлагын дэлгэц ба дуут дохио

Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага эсвэл тоормосны удирдлага ажиллах үед дуут дохио дуугарч мэдээллийн дэлгэц, HUD дэлгэц (тоноглогдсон загварт) болон мультимедиа дэлгэц дээр анхааруулга гарна.

Тухайн байдлаас хамаарч хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага нь хаазны ажиллагааг эсвэл хүчийг тохируулан ажиллана.

- Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлагын ажиллагаа (хааз

хязгаарлах)

Тодорхой хэмжээнээс давсан хаазны ажиллагааг систем хязгаарлана.

Мультимедиа дэлгэц: Анхааруулга гарахгүй

Мэдээллийн дэлгэц: “Object Detected Acceleration Reduced” анхааруулга гарах

Жолоодлогод туслах мэдээллийн индикатор: Асаагүй

Дуут дохио: Дуугарахгүй

- Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлагын ажиллагаа (боломжит хэмжээнд хөдөлгүүрийн хүчийг хязгаарлах)

Систем хэвийн үеэс илүү хүчтэй тоормос шаардлагатай гэж тооцоолсон.

Голын дэлгэц (Панорамик дэлгэц, Multi-terrain монитортой загвар): “BRAKE!”

Мэдээллийн дэлгэц: “BRAKE!”

Жолоодлогод туслах мэдээллийн индикатор: Асаагүй

Дуут дохио: Богино дуут дохио

- Тоормосны ажиллагаа

Ослын тоормос хийх шаардлагатай гэж систем тооцоолсон.

Голын дэлгэц (Панорамик дэлгэц, Multi-terrain монитортой загвар): “BRAKE!”

Мэдээллийн дэлгэц: “BRAKE!”

Жолоодлогод туслах мэдээллийн индикатор: Асаагүй

Дуут дохио: Богино дуут дохио

- Системийн ажиллагаагаар автомашин зогссон

Тоормосны удирдлагаар автомашин зогссон.

Голын дэлгэц (Панорамик дэлгэц,

Multi-terrain монитортой загвар):
“Switch to Brake”

Мэдээллийн дэлгэц: “Accelerator Pedal is Pressed Press Brake Pedal”
(Хаазны дөрөө гишгээгүй үед “Press Brake Pedal” анхааруулга гарна.)

Жолоодлогод туслах мэдээллийн индикатор: Асах


Дуут дохио: Үргэлжлэн дуугарах

Системийн ерөнхий мэдээлэл

Зогсоолд байрлуулахад туслах тоормос нь автомашиныг аливаа объекттой мөргөлдөх эрсдэлтэй гэж тооцоолсон үедээ автомашины хурд нэмэгдэхээс сэргийлж хөдөлгүүрийн хүчийг хязгаарладаг. (Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага: Зураг 2.)

Мөн хаазны дөрөө гишгэсэн хэвээр үед ч автомашины хурдыг бууруулах үүднээс тоормос барилтыг ажиллуулна. (Тоормосны удирдлага: Зураг 3.)


- Зураг 1: PKSB систем ажиллаагүй үед



- A** Хөдөлгүүрийн хүч
- B** Тоормослох хүч

- C** Хугацаа


- Зураг 2: Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллах үед



- A** Хөдөлгүүрийн хүч
- B** Тоормослох хүч
- C** Хугацаа

- D** Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж эхэлнэ (Систем объекттой мөргөлдөх эрсдэл өндөр гэж тооцоолсон үед)

- Зураг 3: Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага болон тоормосны удирдлага ажиллах үед



- A** Хөдөлгүүрийн хүч
- B** Тоормослох хүч
- C** Хугацаа

D Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж эхэлнэ (Систем объектод мөргөлдөх эрсдэл өндөр гэж тооцсон үед)

E Тоормосны удирдлага ажиллаж эхэлнэ (Систем объектод мөргөлдөх эрсдэл туйлын өндөр гэж тооцоолсон үед)

■ Зогсоолд байрлуулахад туслах тоормос ажилласан үед

Зогсоолд байрлуулахад туслах тоормосны ажиллагаагаар автомашин зогссон үед зогсоолд байрлуулахад туслах тоормос салгагдах ба PKSB OFF индикатор асна. Хэрэв зогсоолд байрлуулахад туслах тоормос шаардлагагүй нөхцөлд ажилласан үед ажиллагааг тоормосны дөрөө гишгэх эсвэл автоматаар цуцлагдах 2 секундйн хугацаанд хүлээх үед ажиллагаа цуцлагдана. Системийн ажиллагаа цуцлагдсаны дараа хаазны дөрөө гишгэн хэвийн жолоодох боломжтой.

■ Зогсоолд байрлуулахад туслах тоормос дахин идэвхжүүлэх

PKSB (Зогсоолд байрлуулахад туслах тоормос) системийн ажиллагаагаар цуцлагдсан системийг буюу системийг дахин сэргээхдээ хөдөлгүүр асаах товчийг унтраагаад дахин асаана.

Мөн дараах аль нэг нөхцөл бүрдсэн үед систем автоматаар идэвхжиж PKSB индикатор унтарна: (→X.90):

- Арааны P байрлал сонгогдсон
- Объект автомашины явах чиглэлээс гарсан
- Автомашины чиглэл өөрчлөгдсөн

■ Дуут дохио

Lexus parking assist мэдрэгч идэвхтэй эсэхээс үл хамааран (→X.317) PKSB системийг идэвхжүүлсэн нөхцөлд (→X.331) тоормосны удирдлага болон хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажилласан тохиолдолд дохио дуугарч объект хүртэлх ойролцоо зайг анхааруулна.

PKSB тоормос (урд, хойд талын хөдөлгөөнгүй объект)*


*: Тоноглогдсон загварт

Автомашины явж буй чиглэлд хана зэрэг хөдөлгөөнгүй объект байгааг мэдэрсэн ба хаазны дөрөөний буруу ажиллагаанаас автомашин урагш огцом ухасхийх, арааны байрлал буруу сонгосноос эсрэг чиглэлд хөдлөх мөн зогсож байгаа болон бага хурдаар явах үедээ тухайн объектод мөргөлдөх эрсдэлтэй гэж систем тооцоолсон мөргөлтийн хүчийг бууруулах, үүсэх хор хохирлын хэмжээг багасгах зорилгоор систем ажилладаг.


Функцийн ажиллагааны жишээ (урд, хойд талын хөдөлгөөнгүй объект)

Тус функц автомашины явж буй чиглэлд дараах объект байгааг мэдэрсэн нөхцөлүүдэд ажиллана.


- Бага хурдаар явж байгаа ба тоормосны дөрөө гишгээгүй эсвэл оройтож гишгэсэн үед



- Хаазны дөрөөг огцом хүчтэй гишгэсэн үед



- Буруу араа сонгосноос шалтгаалж автомашин урагш хөдлөх үед



Мэдрэгчийн төрөл

→X.316

! АЮУЛТАЙ

- Системийн хэвийн ажиллагааг хангах

→X.317

- Төмөр замын гармаар гарах зэрэг шаардлагагүй үед PKSB функц ажилласан нөхцөлд

→X.334

- Автомашин угаах үеийн анхааруулга

→X.318

- Зогсоолд байрлуулахад туслах тоормосны функц (Урд болон хойд талын хөдөлгөөнгүй объект) ажиллах нөхцөл

Тус функц нь жолоодлогод туслах мэдээллийн индикатор асаагүй (→X.89, 90) ба дараах бүх нөхцөл бүрдсэн үед ажиллана:

- Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага
- Зогсоолд байрлуулахад туслах

тоормос идэвхэжсэн байгаа.

- Автомашины хурд 15км/ц (9 миль/ц)-с бага
- Автомашины явж буй чиглэлд 2-с 4 м (6-с 13 фут) зайд хөдөлгөөнгүй объект байгаа
- Мөргөлтөөс зайлсхийх үүднээс зогсоолд байрлуулахад туслах тоормосны систем энгийн үеэс илүү хүчтэй тоормос шаардлагатай гэж тооцоолсон үед
- Тоормосны удирдлага
- Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага ажиллаж байгаа үед
- Мөргөлтөөс зайлсхийх үүднээс зогсоолд байрлуулахад туслах тоормосны систем огцом тоормос шаардлагатай гэж тооцоолсон үед

■ **Дараах нөхцөлд PKSB функц (Урд болон хойд талын хөдөлгөөнгүй объект)-н ажиллагаа зогсоно**

Дараах аль нэг нөхцөлд функцийн ажиллагаа зогсоно:

- Хөдөлгүүрийн хүч хязгаарлах удирдлага
- Зогсоолд байрлуулахад туслах тоормос салгагдсан үед
- Хэвийн тоормосны ажиллагаагаар мөргөлтөөс сэргийлэх боломжтой болсон гэж систем тооцоолсон үед.
- Хөдөлгөөнгүй объект 2-с 4 м (6-с 13 фут) хол байгаа эсвэл автомашины явж буй чиглэлд байхгүй үед
- Тоормосны удирдлага
- Зогсоолд байрлуулахад туслах тоормос салгагдсан үед
- Автомашин тоормосны удирдлагаар зогссоноос хойш 2 секунд өнгөрсөн
- Автомашин тоормосны удирдлагаар зогссоны дараа тоормосны дөрөө гишгэсэн
- Хөдөлгөөнгүй объект 2-с 4 м (6-с 13 фут) хол байгаа эсвэл автомашины явж буй чиглэлд байхгүй үед

■ **PKSB функц (Урд болон хойд талын хөдөлгөөнгүй объект)-н мэдрэх хүрээ**

PKSB функц (Урд болон хойд талын хөдөлгөөнгүй объект)-н мэдрэх хүрээ нь Lexus parking assist-мэдрэгчийн мэдрэх хүрээнээс өөр байдаг.

J Lexus parking assist-мэдрэгч/RCTA функц/RCD арын камераар мэдрэх функц*¹-н дууг хаах товч

Lexus parking assist-мэдрэгч, RCTA функц) болон RCD арын камераар мэдрэх функцийг дууг хаана.

K Арын камер угаах товч*¹

Богино дарах:

Арын камер угаагч тодорхой хугацаанд ажиллана.


Удаан дарах:

Арын камер угаах товч дарах хугацаанд арын камер угаагч ажиллана.

*¹: Тоноглогдсон загварт

*²: Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

► Арын өргөн болон панорамик харагдац

**A** Камерын бохирдол мэдрэх тэмдэг*¹

Камер дээр бохирдол мэдрэгдсэн үед тус тэмдэг дэлгэц дээр гарна.

B Lexus parking assist-мэдрэгч

Мэдрэгч асаалттай үед саад мэдрэгдсэн нөхцөлд индикатор асаж дохио дуугарна.

C Дэлгэцийн горим солих товч

Товч дарах бүрд дэлгэцийн горим солигдоно.

D Чиглүүлэх шугам солих товч

Чиглүүлэх шугам солих товч дарах бүрд горим солигдоно. (→X.380)

[E] RCTA функц)/RCD арын камераар мэдрэх функц^{*1}

Дараах нөхцөлд индикатор дэлгэц дээр гарна.

- Арын камераар мэдрэх функц ар талд явган зорчигч мэдэрсэн үед
- Камер ар талд явган зорчигч мэдэрсэн үед

[F] Өөрчлөх тохиргооны товч

Автоматаар эргэлтийн үеийн харагдац гаргах, автомашины өнгө солих, Lexus parking assist-мэдрэгчийн таних хүрээг өөрчлөх зэрэг тохиргоог хийх боломжтой. (→X.388)

[G] RCD арын камераар мэдрэх функц^{*1}

Арын камер автомашины ар талд явган зорчигч мэдэрсэн нөхцөлд дэлгэц дээр индикатор гарна.

[H] PKSB (Зогсоолд байрлуулахад туслах тоормос)^{*1}

Мөргөлдөж болзошгүй саад мэдрэгдэх үед дэлгэц дээр мэдээлэл гарна.

[I] Дуу хоолойн команд таних тэмдэг^{*2}

Дуу хоолойн удирдлагын систем ажиллах үед тус тэмдэг гарна.

[J] Lexus parking assist-мэдрэгч/RCTA функц)/RCD арын камераар мэдрэх функц^{*1}-н дууг хаах товч

Lexus parking assist-мэдрэгч, RCTA функц) болон RCD арын камераар мэдрэх функцийг дууг хаана.

[K] Арын камер угаах товч^{*1}

Богино дарах:

Арын камер угаагч тодорхой хугацаанд ажиллана.

Удаан дарах:

Арын камер угаах товч дарах хугацаанд арын камер угаагч ажиллана.

^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Тус функцийг зарим улс, бүс нутагт ашиглах боломжгүй.

■ Арын болон панорамик харагдац/Арын өргөн болон панорамик харагдац

- “R” араатай үед камерын товч дарж панорамик болон урд талын өргөн харагдац руу шилжүүлэх боломжтой.
- Lexus parking assist-мэдрэгч (→X.316) болон камерын дүрс дээрх саадын байрлал давхцахгүй байж болно.

⚠ АЮУЛТАЙ

■ Чиглүүлэх шугам

- Дугуйн байрлал болон автомашины байрлал заах шугамын зааж буй байрлал нь зорчигчдын тоо, тээш, замын хэвгий, замын гадаргуу, орчны гэрлийн хэмжээ, үйлдвэрлэгчийн зааснаас бусад дугуй, явах эд анги угсарсан зэргээс хамаарч бодит байрлалаас өөр байж болно. Жолоодлогын үед цаг ямагт орчны аюулгүй байдлыг нягтална.

⚠ АЮУЛТАЙ

■ Lexus parking assist-мэдрэгч, RCTA функц болон RCD арын камераар мэдрэх функцийн дэлгэц


Lexus parking assist-мэдрэгч, RCTA функц болон RCD арын камераар мэдрэх функцийн дэлгэц нь камерын дүрсэн дээр гардаг тул орчны гэрэл, өнгөнөөс хамаарч харахад хүндрэлтэй байж болно.

Чиглүүлэх шугамын горим солих

Чиглүүлэх шугам солих товч дарах бүрд горим дараах байдлаар солигдоно:

► Эргэх чиглэл заах шугам

Жолооны хүрдийг эргүүлэх үед тухайн эргэх чиглэлийг заах шугамыг харуулна.



A Урд зайн чиглүүлэх шугам

Автомашины урд талын 1 м (3 ft.) (цэнхэр) зайг заана.

B Хажуугийн эргэх чиглэл заах шугам

Жолооны хүрдийг эргүүлэх үед тухайн маршрутыг (шар) тооцон харуулна.

C Ухрах чиглэл заах шугам

Жолооны хүрдийг эргүүлэх үед тухайн маршрутыг (шар) тооцон харуулна.

D Арын зайн чиглүүлэх шугам

Автомашины ар талын зайг заана.

- Чиглүүлэх шугам нь эргэх чиглэл заах шугамын хөдөлгөөнийг дагана.
- Автомашины арын гупернээс 0.5 м (1.5 фут) (улаан) болон 1 м (3 фут) (шар) зайг заана.

[E] Арын зайн чиглүүлэх шугам

Автомашины арын гупернээс 0.5 м (1.5 фут) (цэнхэр) зайг заана.

[F] Автомашины өргөнийг заах шугам

Энэ шугам нь автомашиныг шулуун ухраах үеийн замыг заана.

- Тус шугам нь автомашины бодит өргөнөөс илүү өргөн байна.
- Жолооны хүрд шулуун үед чиглүүлэх шугам болон эргэх чиглэл заах шугам давхцаж харагдана.


[G] Автомашины төвийг заах шугам

Энэ шугам нь автомашины төвийг тооцоолон харуулна.

► Зогсоолд байрлуулахад туслах чиглүүлэх шугам

Эргүүлсэн жолооны хүрдийг буцаах цэгийг (Зогсоолд байрлуулахад туслах шугам) дэлгэцээр харуулна.

Тус горимыг эргэх чиглэл заах шугамын туслалцаагүйгээр зогсоолд байрлуулах ур чадвартай жолооч ашиглахад тохиромжтой.



[A] Урд зайн чиглүүлэх шугам

Автомашины урд талын 1 м (3 ft.) (цэнхэр) зайг заана.

[B] Арын зайн чиглүүлэх шугам

Автомашины ар талын зайг заана.

- Автомашины арын гупернээс 0.5 м (1.5 фут) (улаан) зайг заана.

[C] Автомашины төвийг заах шугам

Энэ шугам нь автомашины төвийг тооцоолон харуулна.

[D] Автомашины өргөнийг заах шугам

Энэ шугам нь автомашиныг шулуун ухраах үеийн замыг заана.

- Тус шугам нь автомашины бодит өргөнөөс илүү өргөн байна.

[E] Зогсоолд байрлуулахад туслах чиглүүлэх шугам


Автомашины хойд талын эргэлт хийх боломжит бага замыг заана.

- Зогсоолд байрлуулах үед мэдээллийн журмаар ашиглана.

► Зай заах шугам

Зөвхөн зай заах шугам дэлгэцээр гарна.

Тус горимыг чиглүүлэх шугамын туслалцаагүйгээр зогсоолд байрлуулах үр чадвартай жолооч ашиглахад тохиромжтой.



A Урд зайн чиглүүлэх шугам

Автомашины урд талын 1 м (3 ft.) (цэнхэр) зайг заана.

B Арын зайн чиглүүлэх шугам


Автомашины ар талын зайг заана.

- Автомашины арын гүпернээс 0.5 м (1.5 фут) (улаан) зайг заана.

► Автомашины төвийг заах шугам

Жолооны хүрд эргүүлэх үед тухайн эргэх чиг заах болон автомашины төвийг заах шугамыг харуулна.

Арын гүпер төв хэсгээр шон, замын тэмдэг рүү ойртох үед тус горимыг ашиглана.



A Урд зайн чиглүүлэх шугам

Автомашины урд талын 1 м (3 ft.) (цэнхэр) зайг заана.

B Хажуугийн эргэх чиглэл заах шугам

Жолооны хүрдийг эргүүлэх үед тухайн маршрутыг (шар) тооцон

харуулна.

С Арын зайн чиглүүлэх шугам

Автомашины ар талын зайг заана.

- Чиглүүлэх шугам нь эргэх чиглэл заах шугамын хөдөлгөөнийг дагана.
- Автомашины арын гупернээс 0.5 м (1.5 фут) (улаан) болон 1 м (3 фут) (шар) зайг заана.

D Ухрах чиглэл заах шугам

Жолооны хүрдийг эргүүлэх үед тухайн маршрутыг (шар) тооцон харуулна.

E Автомашины төвийг заах шугам

Жолооны хүрдний эргэлтээс хамаарсан автомашины төвийг заах шугам (ногоон)-г тооцоолон харуулна.

■ Чиглүүлэх шугамын дэлгэцийн горим

Арын тээшний хаалга хаагдаагүй үед чиглүүлэх шугам гарахгүй. Хэрэв тээшний хаалга хаасан ч чиглүүлэх шугам гарахгүй байвал та өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа оношлуулна уу.



АЮУЛТАЙ


■ Чиглүүлэх шугамын дэлгэцийн горим

Автомашины арын өргөнийг заах шугам нь автомашины бодит өргөнөөс өргөн байдаг. Ухрах үйлдэл хийх үед ойр орчмын аюулгүй байдлаа ямагт нягтална.

**Эргэх чиглэл заах шугам
ашиглан зогсоолд
байрлуулах**

- 1 Арааг “R”-д шилжүүлнэ.
- 2 Эргэх чиглэл заах шугам зогсоолын талбайд орох

байдлаар жолооны хүрдийг эргүүлж зөөлөн ухарна.




A Зогсоолын талбай

B Эргэх чиглэл заах шугам

- 3** Автомашины хойд тал зогсоолын талбайд орох үед зогсоолын тусгаарлах хоёр талын шугам дотор автомашины өргөнийг заах

шугам орох байдлаар жолооны хүрдийг эргүүлнэ.




A Автомашины өргөнийг заах шугам

- 4** Зогсоолын талбайн шугам болон автомашины өргөнийг заах шугам зэрэгцэх үед жолооны хүрдийг буцааж тэгшлээд автомашиныг зогсоолын талбайд бүрэн ортол зөөлөн ухарна.
- 5** Автомашиныг зохих байрлалд байрлуулаад үйлдлээ дуусгана.

Зогсоолд байрлуулахад туслах шугам ашиглан зогсоолд байрлуулах

- 1 Арааг "R"-д шилжүүлнэ.
- 2 Зогсоолд байрлуулахад туслах шугам зогсоолын тусгаарлах

шугамын үзүүртэй давхцах хүртэл зөөлөн ухарна.



A Зогсоолд байрлуулахад туслах чиглүүлэх шугам

B Зогсоолын тусгаарлах шугам

3 Жолооны хүрдийг зүүн тийш тултал эргүүлээд зөөлөн ухарна.

4 Зогсоолын талбайн шугамтай автомашин зэрэгцээ болох үед жолооны хүрдийг буцааж тэгшлээд автомашиныг зогсоолын талбайд бүрэн ортол зөөлөн ухарна.


5 Автомашиныг зохих байрлалд байрлуулаад үйлдлээ дуусгана.

Хажуугийн толь эвхээтэй үед дэлгэцийн харагдах байдал

Хажуугийн толь эвхэгдсэн үед ч дэлгэц нь автомашины ойр орчмын дүрсийг харуулж зай талбай багатай орчин, авто зогсоолд аюулгүй байдлыг нягтлахад тусалдаг.

Дэлгэц

► Хажуугийн болон урд өргөн харагдац




A Хажуу талыг харуулах

B Lexus parking assist-мэдрэгч

Мэдрэгч асаалттай үед саад мэдрэгдсэн нөхцөлд индикатор асаж дохио дуугарна.

C Урд талыг өргөнөөр харуулах


► Хажуу болон ар тал

**A** Хажуу талыг харуулах**B** Lexus parking assist-мэдрэгч

Мэдрэгч асаалттай үед саад мэдрэгдсэн нөхцөлд индикатор асаж дохио дуугарна.

C Ар талыг харуулах

► Ар талыг өргөнөөр харуулах, хажуу талыг харуулах

**A** Хажуу талыг харуулах**B** Lexus parking assist-мэдрэгч

Мэдрэгч асаалттай үед саад мэдрэгдсэн нөхцөлд индикатор асаж дохио дуугарна.

C Ар талыг өргөнөөр харуулах

■ Lexus parking assist-мэдрэгчийн дэлгэц


Lexus parking assist-мэдрэгч (→Х.316) болон камерын дүрс дээрх саадын байрлал давхцахгүй байж болно.

Томруулж харуулах функц

Дэлгэцээр гарч буй объект жижиг бөгөөд сайн харагдахгүй үед дүрсийг томруулж харах боломжтой.

Панорамик дэлгэц дээр томруулах гэж буй цэг дээр дарна.

Дэлгэц



- Сонгосон хэсэг томорч харагдана.
- Автомашины урд болон хойд талын дүрсийг томруулж харах боломжтой.
- Томруулж харуулах функцийг цуцлах үед дэлгэц дээр дахин дарна.

■ Дэлгэцийг томруулах


- Дэлгэцийг томруулж харуулах функц дараах бүх нөхцөл бүрдсэн үед идэвхэжнэ:
 - Автомашины хурд 12км/ц (7 миль/ц)-с бага
 - Lexus parking assist-мэдрэгч (→Х.316) асаалттай байгаа
- Дараах нөхцөлүүдэд дэлгэцийг томруулж харуулах функц автоматаар цуцлагдана:
 - Автомашины хурд 12км/ц (7 миль/ц)-с өндөр
 - Lexus parking assist-мэдрэгч цуцлагдсан
- Дэлгэцийг томруулан харуулах үед чиглүүлэх шугам дэлгэцээр гарахгүй.

Автомашины доод талыг харуулах дэлгэц

Дугуйн байрлал, автомашины доод талын байдлыг мэдэхэд туслах үүднээс автомашины одоогийн байрлалаас өмнө нь камераар авсан дүрсийг нэгтгэн харуулдаг. Дүрсийг панорамик, хажуугийн оврын эсвэл

эргэлтийн үеийн харагдцуудаар харуулах боломжтой.

Дэлгэц



A Дугуйны мөр

Жолооны хүрдний ажиллагаатай холбоотой байдлаар дугуйны байрлалын чиглүүлэх шугам харуулна.

B Чиглүүлэх шугам

Автомашины гадна талыг харуулна.

■ Автомашины доод талыг харуулах дэлгэц

- Өөрчлөх боломжтой тохиргооны дэлгэц ассан ба автомашин урагш эсвэл арагш явах үед тус дэлгэц гарна.
- Дэлгэц дараах нөхцөлүүдэд гарахгүй:
 - Хурд 20 км/ц (12 миль/ц)-с их
 - Автомашин зогссоноос хойш тодорхой хугацаа өнгөрсөн
 - Автомашин ассанаас хойш тодорхой зайнд яваагүй
 - Хажуугийн толь эвхэгдсэн
 - ABS ажиллаж байгаа
 - Систем зөв ажиллахгүй байгаа
- Дараах нөхцөлүүдэд систем хэвийн ажиллахгүй:
 - Цастай зам дээр
 - эрэл тусч сүүдэр үүссэн
 - Камерын линз бохирдсон эсвэл гадны биет тогтсон
 - Ус (гол, тэнгис зэрэг)
 - Нэмэлт тоноглол угсрагдсан
 - Камерын урд талд саад байгаа
 - Дугуй сольсон
 - Тээшний хаалга онгойсон ба камерын тусгал буруу
 - Зам хальтиргаатай эсвэл дугуй хий эргэж байгаа
 - Автомашин налуу зам дээр байгаа
- Өмнө авсан дүрс тул дараах нөхцөлд бодит байдлаас өөр байж болно:
 - Зураг авсны дараа саад гарч ирсэн, хөдөлсөн
 - Зураг авсны дараа цас, элс тогтсон
 - Дэлгэцээр гарах хэсэгт шавар, тогтоол ус байгаа
 - Автомашин хий эргэсэн

- Автомашины доод талыг харуулах дэлгэц дараах нөхцөлд хэсэгчлэн эсвэл бүтнээр хар өнгөтэй болно:
- Дүрс аваагүй үед автомашин хөдөлсөн
- Жолооны хүрдийг тодорхой өнцгөөс илүү эргүүлсэн
- Автомашин зогсоод тодорхой хугацаа өнгөрсөн



АЮУЛТАЙ


■ Автомашины доод талыг харуулах дэлгэц

- Зорчигчдын тоо, ачсан ачаа, замын хэвгий, замын гадаргуугийн байдал, орчны гэрлийн хэмжээ, нэмэлт тоноглол, дугуй солих болон бусад шалтгаанаас хамаарч дугуй болон автомашины чиглүүлэх шугам бодит байрлалаас өөр байж болно. Жолоодлогын үед цаг ямагт орчны аюулгүй байдлыг нягтална.
- Дэлгэцийн дүрс нь өмнө бичигдсэн дүрс юм Хэрэв саад болон бусад зүйлс дүрс авснаас хойш хөдөлсөн нөхцөлд дэлгэцийн дүрс болон бодит байдал таарахгүй байж болно.

Multi-terrain мониторын тохиргоог өөрчлөх

Multi-terrain монитортой холбоотой эргэлтийн үеийн автомат дэлгэц болон автомашины өнгийг солих боломжтой.

- 1  товчийг дарна.



- 2 Тохиргоогоо сонгоно.

- Эргэлтийн үеийн харагдац

Эргэлтийн үеийн дэлгэцийг автоматаар харуулна.

- Автомашины доод талыг харуулах дэлгэц

Автомашины доод талыг харуулах

дэлгэцийн тохиргоог идэвхжүүлэх буюу цуцална. Тохиргоог идэвхжүүлсэн үед автомашины доод тал, урд дугуйн байрлал зэргийг мэдэхэд туслах үүднээс автомашин урагш эсвэл арагш хөдлөх үед эсрэг талын камераар өмнө нь авсан дүрсийг харуулна. Дүрсийг панорамик, хажуугийн оврын эсвэл эргэлтийн үеийн дэлгэцийн харагдцаар харуулна.

- Lexus Park Assist 3D дэлгэц

Lexus parking assist-мэдрэгчийн 3D дэлгэцийг нуух, гаргах тохиргоо хийнэ.

- LEXUS зогсоолд байрлуулахад туслах функцийг зай

Lexus parking assist-мэдрэгчийн саад мэдэрч ажиллах зайг тохируулна.

- Автомашины өнгө

Дэлгэцээр харуулах автомашины өнгийг солино.

■ Дэлгэцийн тохиргоо цуцлагдах

Аюулгүйн үүднээс автомашин хөдөлж байгаа үед дэлгэцийн тохиргоо хийх

боломжгүй.

Multi-terrain монитор ашиглах үед

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд санамсаргүй осолд хүргэх аюултай. Мөн жолоодлогын үед автомашины эргэн тойрон болон хойд талын аюулгүй байдлыг шууд нягтална.



АЮУЛТАЙ

Multi-terrain монитормыг ашиглаж болохгүй нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд Multi-terrain монитор ашиглаж болохгүй. Систем хэвийн ажиллахгүй байх, улмаар осолд хүргэх аюултай.

- Мөстсөн, цастай бусад хальтиргаатай зам дээр
- Дугуйн гинж эсвэл нөөц дугуй ашиглах үед
- Урд ба хойд хаалга, тээшний хаалга дутуу хаагдсан үед
- Дов толгод зэрэг тэгш бус замаар явах үед
- Үйлдвэрлэгчийн зааснаас өөр хэмжээтэй дугуй ашигласан үед
- Тулгуур эд ангид өөрчлөлт хийсэн үед
- Камерт харагдах хэсэгт оригинал бус нэмэлт тоноглол суурилуулсан үед

Чиглүүлэх шугам

Дугуйн байрлал болон автомашины байрлал заах шугамын зааж буй байрлал нь зорчигчдын тоо, тээш, замын хэвгий, замын гадаргуу, орчны гэрлийн хэмжээ зэргээс хамаарч бодит байрлалаас өөр байж болно. Жолоодлогын үед цаг ямагт орчны аюулгүй байдлыг нягтална.



АНХААР


Панорамик харагдах байдал

- Автомашины доод талыг харуулах харагдац, явж буй үеийн дэлгэц, панорамик дэлгэц хажуугийн оврын, эргэлтийн үеийн харагдац нь автомашины урд, хойд, баруун болон зүүн камерын авсан дүрсийг систем нэг дүрс болгон харуулдаг. Системийн харуулах хүрээ мөн хүчин чадал хязгаартай тул ашиглахаас өмнө системийн онцлогтой танилцана.
- Автомашины доод талыг харуулах харагдац, явж буй үеийн дэлгэц, панорамик дэлгэц хажуугийн оврын, эргэлтийн үеийн харагдац горимд автомашины 4 өнцгийн дүрс бүдэг харагдах, бүрсийж болно. Энэ хэсэг нь камернуудын авсан дүрсүүдийг нийлүүлэх зааг бөгөөд ингэж дүрс бүдэг харагдах нь системийн хэвийн ажиллагаа алдагдсаныг илэрхийлэхгүй.
- Камер бүрийн орчны гэрлийн түвшнээс хамаарч автомашины доод талыг харуулах харагдац, явж буй үеийн дэлгэц, панорамик дэлгэц хажуугийн оврын, эргэлтийн үеийн харагдац дээр тод, бүдэг цэгүүд гарч болно.
- Автомашины доод талыг харуулах харагдац, явж буй үеийн дэлгэц, панорамик дэлгэц хажуугийн оврын, эргэлтийн үеийн харагдац нь камер тус бүрийн байрлалаас дээш мөн зураг авах хязгаараас гаднах объектыг харуулах боломжгүй.
- Автомашины зарим хэсэг камерт харагддаггүй ба эдгээр нь дэлгэц дээр харагдахгүй.

- Урд талын өргөн дэлгэц эсвэл хойд талыг харуулах дэлгэцийн горимд харагдаж буй 3 хэмжээст объект нь автомашины доод талыг харуулах харагдац, явж буй үеийн дэлгэц, панорамик дэлгэц хажуугийн оврын, эргэлтийн үеийн харагдац дээр харагдахгүй байж болно.
- Явган зорчигч болон бусад 3 хэмжээст саад нь панорамик дэлгэцээр өөр харагдаж болно. (Үүнээс гадна объект дэлгэц дээр нааш унаж байгаа харагдах, ойртох, холдох, харагдах, харагдахгүй байх мөн тухайн зүйл хүртэлх бодит зай өөр байх зэрэг олон төрлийн зөрүүнүүд үүсэж болно.)
- Камер суурилагдсан урд талын аль нэг хаалга эсвэл тээшний хаалга нээлттэй үед панорамик дэлгэцийн зөв дүрслэл алдагдаж болно.
- Автомашины доод талыг харуулах харагдац, явж буй үеийн дэлгэц, панорамик дэлгэц хажуугийн оврын, эргэлтийн үеийн харагдац дээр гарч буй автомашины дүрс нь компьютерын боловсруулан гаргасан дүрс бөгөөд өнгө, хэлбэр, хэмжээ зэрэг нь бодит байдлаас өөр байж болно. Тиймээс ойр орчимд буй 3 хэмжээст объект нь автомашинд тулсан харагдах мөн эдгээр 3 хэмжээст объект хүртэлх бодит зай дэлгэц дээр гарч буй зайнаас өөр байж болно.

Дэлгэцийн харуулах хүрээ


Автомашины эргэн тойронд дэлгэцээр харуулах боломжгүй сохор цэгүүд байдаг. Дэлгэц дээр аливаа саад харагдахгүй байгаа ч мөргөлдөж болзошгүй бодит саад зам дээр байж болно. Ойр орчны аюулгүй байдлыг шууд нягтална уу.



A Дэлгэцээр харуулах хэсэг

B Дэлгэцээр харагдахгүй объект

Сүүдэртэй хэсэгт байгаа объект дэлгэц дээр харагдахгүй.



A Дэлгэцээр харуулах хэсэг

B Тухайн объектын дэлгэцээр харагдахгүй хэсэг


Тухайн объектын тодорхой өндрөөс дээш байрлах хэсэг дэлгэцээр харагдахгүй.

■ Дэлгэц дээр дүрс гарах хэсэг


- Автомашины тэмдгийн эргэн тойронд байгаа хараар тэмдэглэгдсэн хэсгүүд дэлгэц дээр харагдахгүй. Шууд харж нягтална.

- Систем нь 4 камерын дүрсийг тэгш замын гадаргуу дээр байгаа гэж тооцоолон нэгтгэдэг тул панорамик дэлгэц/хөдлөх үеийн дэлгэц/нэвт харагдах дэлгэц/хажуугийн оврын дэлгэц/эргэлтийн үеийн дэлгэц дараах байдлаар гарч болно.

- Объект бодит харагдах байдлаасаа нарийн, том, богино харагдаж болно
- Объект замаас өндөрт байрлаж байгаа үед бодит зайнаас хол харагдах эсвэл огт харагдахгүй байж болно
- Өндөр объект нь дүрс гарахгүй хэсгээс нааш гарах байдлаар харагдаж болно
- Камер тус бүрийн гэрлийн тод байдлын ялгаа дэлгэц дээр ялгарч харагдаж болно.
- Зорчигчдын тоо, ачаа тээшний хэмжээ, шатахууны хэмжээ зэргээс хамаарч автомашины их биеийн хазайлт, автомашины өндөр өөрчлөгдсөнөөс шалтгаалж дүрсний байрлал өөрчлөгдөж болно.
- Урд хаалга, тээшний хаалга бүрэн хаагдаагүй үед дүрс болон чиглүүлэх шугам гарахгүй.
- Панорамик дэлгэц/хөдлөх үеийн дэлгэц/ нэвт харагдах дэлгэц/ хажуугийн оврын дэлгэц/эргэлтийн үеийн дэлгэцийн дүрсний байрлал, дэлгэцээр харагдаж буй замын гадаргуу бодит байрлалаас өөр байж болно.
- Улсын дугаарын гэрэлтэй хүрээний гэрэл дэлгэц дээр гарч болно.
- Зурагт -р тэмдэглэгдсэн хэсгийн дүрсийг нийлүүлэн дэлгэцээр харуулдаг тул зарим хэсэг муу харагдаж болно.



■ Урд талын өргөн дэлгэц



A Дэлгэцээр харуулах хэсэг


B Харагдахгүй объект

Гуперын булантай ойр хэсгүүд дэлгэцээр гарахгүй.

■ Дэлгэцийн харуулах хүрээ

- Камерын тусгалын хүрээ хязгаарлагдмал байдаг. Гуперны 2 зах мөн гупер доор байгаа объект дэлгэц дээр харагдахгүй.
- Дэлгэцийн дүрсний алслалт нь бодит байдлаас өөр байж болно.
- Камерт тусгай линз ашиглагддаг. Дэлгэцээр зааж буй зай болон бодит зай хоорондоо зөрүүтэй байж болно.

- Хажуу тал, хойд талын харагдац (толь эвхээтэй үед)




- A** Дэлгэцээр харуулах хэсэг

■ Дэлгэцийн харуулах хүрээ

- Автомашин болон замын гадаргуугийн нөхцөлөөс хамаарч дэлгэцээр харуулах хүрээ өөр байж болно.
- Камерын тусгалын хүрээ хязгаарлагдмал байдаг. Зорчигч талын гуперны булан эсвэл гупер доор байгаа объект дэлгэц дээр харагдахгүй.
- Дэлгэцийн дүрсний алслалт нь бодит байдлаас өөр байж болно.
- Камерт тусгай линз ашиглагддаг. Дэлгэцээр зааж буй зай болон бодит зай хоорондоо зөрүүтэй байж болно.

- Ар талын дэлгэц




- A** Дэлгэцээр харуулах хэсэг

- B** Харагдахгүй объект

Гуперын булантай ойр хэсгүүд дэлгэцээр гарахгүй.

► Ар талын өргөн дэлгэц



A Дэлгэцээр харуулах хэсэг

B Харагдахгүй объект

Гуперын булантай ойр хэсгүүд дэлгэцээр гарахгүй.


■ Дэлгэцийн харуулах хүрээ

- Автомашин болон замын гадаргуугийн нөхцөлөөс хамаарч дэлгэцээр харуулах хүрээ өөр байж болно.
- Камерын тусгалын хүрээ хязгаарлагдмал байдаг. Гуперын булан эсвэл гупер доор байгаа объект дэлгэц дээр харагдахгүй.
- Дэлгэцийн дүрсний алслалт нь бодит байдлаас өөр байж болно.
- Камерт тусгай линз ашиглагддаг. Дэлгэцээр зааж буй зай болон бодит зай хоорондоо зөрүүтэй байж болно.
- Арын камераас өндөрт байрлах объект дэлгэцээр гарахгүй.
- Улсын дугаарын гэрэлтэй хүрээний гэрэл дэлгэц дээр гарч болно.


■ Камерын байрлал

Multi-terrain мониторын камерын байрлалыг дараах зурагт харуулав.


■ Урд камер



■ Хажуугийн камер



■ Хойд камер



■ Камер цэвэрлэх

Бохирдол, гадны биет (усны дусал, мөс, шавар г.м.) камерт

тогтсон үед камер цэвэр дүрс дамжуулах чадваргүй болно. Энэ үед камерыг их хэмжээний усаар угааж линзийг нойтон зөөлөн даавуугаар арчина.

Хойд камер: Камерын линз дээрх бохирдлыг камер угаагч ашиглан цэвэрлэх боломжтой. (тоноглогдсон загварт) (→Х.232)



АНХААР

■ Камер ашиглах

- Multi-terrain монитор дараах нөхцөлүүдэд хэвийн ажиллахгүй байж болно.
- Автомашины урд тал, хойд тал мөн хажуугийн толь мөргөлтөнд өртсөн үед камерын байрлал, өнцөг өөрчлөгдсөн байх магадлалтай.
- Камер нь усны хамгаалалттай тул салгах, задлах, өөрчлөхийг хориглоно. Камерын хэвийн ажиллагааг алдагдуулна.
- Камерын линзийг цэвэрлэх үед их хэмжээний усаар угаах ба зөөлөн нойтон даавуугаар арчина. Линзийг хүчтэй зүлгэсэн тохиолдолд хортон суулгах аюултай ба линз цэвэр дүрс дамжуулах чадваргүй болно.
- Органик уусгагч, автомашины өнгөлгөөний вакс, шил толь цэвэрлэгч, шилний өнгөлгөөг камерт хийх, хүргэхийг хориглоно. Хэрэв санамсаргүй эдгээрийг камерт хүргэсэн тохиолдолд нэн даруй арчиж цэвэрлэнэ.
- Хүйтэн үед халуун ус цацагдсан зэргээр температур огцом өөрчлөгдсөн тохиолдолд систем хэвийн ажиллахгүй байж болно.

- Автомашин угаах үед камер болон камерын ойр орчим руу ус хүчтэй шүрших, цацаж болохгүй. Камерын эвдрэлд хүргэнэ.

- Камерыг эвдрэлд хүргэх тул хүчтэй цохилтоос хамгаална. Камер хүчтэй цохилтод өртсөн бол та өөрийн Lexus дилерт хандаж нэн даруй оношлуулна.

Хойд камерыг шил арчигчийн шингэнээр угаах

Шил арчигчийн шингэнээр хойд камерыг угаах боломжтой.

- Камер цэвэрлэх үед шил арчигчийн шингэнээс шалтгаалж дүрс сайн харагдахгүй байж болно. Ухрах үйлдэл хийхийн өмнө орчны аюулгүй байдлыг шууд болон толинд харж нягтална.
- Цэвэрлэсний дараа камерын линз дээр шил арчигчийн шингэн үлдсэн тохиолдолд шөнийн цагаар хойд талын автомашины их гэрлийн тусгалын өндөр, хазайлтаас хамаарч дүрс муу харагдаж болно.
- Цэвэрлэх үед зарим бохирдол бүрэн цэвэрлэгдэхгүй байж болно. Энэ нөхцөлд камерын линзийг их хэмжээний усаар угаах ба зөөлөн нойтон даавуугаар арчина.
- Шил арчигчийн шингэн линзний гадаргуу руу цацагдаг. Мөс, цас зэрэг камерын ойр орчимд тогтсон зүйлийг цэвэрлэж чадахгүй байж болно.




АНХААР

- Шил арчигчийн шингэний нөөцийн саванд шингэн байгаа ч цацагдахгүй үед угаагчийн хошуу бөглөрөөгүй эсэхийг шалгана.
- Шил арчигчийн шингэний нөөцийн сав насос хэт халах аюултай тул камер угаагчийг удаан ажиллуулж болохгүй.
- Угаагчийн хошуу бөглөрсөн үед Та өөрийн Lexus дилерт хандана уу. Зүү болон бусад зүйлээр сэтгэж болохгүй. Хошуу гэмтэх аюултай.
- Зарим гадны биет камер угаагчаар бүрэн цэвэрлэгддэггүй. Энэ нөхцөлд камерын линзийг их хэмжээний усаар угаагаад нойтон зөөлөн даавуугаар арчина. Хортон сууж дүрс цэвэр гарахгүй болох тул хатуу зүйлээр үрж болохгүй.
- Шил арчигчийн шингэн арын камерын гадаргуу руу цацагддаг. Камерын ойр орчмын цас, мөс бусад бохирдол бүрэн цэвэрлэгдэхгүй байж болно.
- Шил арчигчийн шингэн хөлдөхөөс сэргийлж гадна агаарын хэмд тохирсон шингэн ашиглана.
- Өндөр даралтын автомашин угаагчаар угаах үед хошуу гэмтээх аюултай тул шууд шүршиж болохгүй. Өндөр даралттай ус хошууг гэмтээх, хошуу дотор орон хөлдөж хошууг гэмтээх аюултай. Энэ нөхцөлд хошуу хэвийн ажиллахгүй.
- Хүйтэн үед халуун ус цацах зэргээр хошууг температурын огцом өөрчлөлтөд оруулж болохгүй.

- Камер угаагчийг тогтмол ашигладаг нөхцөлд шил арчигчийн шингэнийг ойр ойрхон солих шаардлагатай. Камер угаагч нь шил арчигчийн шингэн ашигладаг.
- Хошууны тусгал алдагдах тул хошууг хүчтэй цохилтоос хамгаална.
- Хүчтэй чичиргээтэй зам дээр хошуунаас шил арчигчийн шингэн дусаж дүрс сайн харагдахгүй байж болно.
- Дэлгэц болон системийн төрлөөс хамаарч камер угаагчийн байрлал өөр байж болно.
- Шил арчигчийн товчийг дарах хугацаанд камер угаагч ажиллана.
- Камер угаагчийг идэвхжүүлэх үед арын шил угаагчийг мөн асаана.
- Камер цэвэрлэх үед шил арчигчийн шингэнээс шалтгаалж дүрс сайн харагдахгүй байж болно. Энэ нөхцөлд ойр орчмоо шууд харж нягтална.
- Камер угаагч ашигласны дараа линз дээр шингэн үлдсэн нөхцөлд шөнийн цагаар арын автомашины их гэрлийн өндөр, тусгалаас хамаарч дүрс сайн харагдахгүй байж болно.

Зогсоолд байрлуулахад туслах гэрэл

Multi-terrain мониторын зогсоолд байрлуулахад туслах гэрэл нь дараах байрлалд байдаг.



АНХААР

- Зогсоолд байрлуулахад туслах гэрэл
- Multi-terrain мониторын хэвийн ажиллагаа алдагдах тул дараах анхааруулгыг мөрдөнө:
 - Гэрэл дээр хэт хүчээр дарах, цохихоос сэргийлнэ. Гэрлийн байрлал, өнцөг өөрчлөгдсөн байх магадлалтай
 - Усны хамгаалалттай хийгдсэн тул салгах, задлах, өөрчлөхийг хориглоно. Гэрлийн хэвийн ажиллагааг алдагдуулна
 - Гэрлийг цэвэрлэх үед их хэмжээний усаар угаах ба зөөлөн нойтон даавуугаар арчина
 - Органик уусгагч, автомашины өнгөлгөөний вакс, шил толь цэвэрлэгч, шилний өнгөлгөө хийх, гэрэлд хүргэхийг хориглоно. Хэрэв санамсаргүй хүргэсэн тохиолдолд нэн даруй арчиж цэвэрлэнэ
 - Хүйтэн үед халуун ус цацагдсан зэргээр температур огцом өөрчлөгдсөн тохиолдолд систем хэвийн ажиллахгүй байж болно
 - Автомашин угаах үед гэрэл болон гэрлийн ойр орчим руу ус хүчтэй шүршиж цацаж болохгүй. Камерын эвдрэлд хүргэнэ


● Гэрэл гэмтэх тул хүчтэй цохилтоос хамгаална. Гэрэл хүчтэй цохилтонд өртсөн бол та өөрийн Lexus дилерт хандаж нэн даруй шалгуулна уу.

Дэлгэц дэх дүрс болон бодит замын байдлын зөрүү

Multi-terrain монитор болон зай заах шугам нь тэгш гадаргуутай зам дээрх зайг заадаг. Дараах тохиолдлуудад дэлгэцийн заалт болон бодит зай хооронд зөрүү үүсэж болно.


Автомашины ар тал огцом өгсүүр замтай үед

Бодит зайтай харьцуулахад зай заах шугам илүү ойр байна. Үүнээс шалтгаалан аливаа объект бодит зайнаасаа илүү хол харагдана. Мөн үүнтэй адил шалтгааны улмаас чиглүүлэх шугам болон автомашины бодит чиглэл, зайны хооронд зөрүү үүснэ.




Автомашины ар тал огцом уруу замтай үед

Бодит зайтай харьцуулахад зай заах шугам илүү хол байна. Үүнээс шалтгаалан аливаа объект бодит зайнаасаа илүү ойр харагдана. Мөн үүнтэй адил шалтгааны улмаас чиглүүлэх шугам болон автомашины бодит чиглэл, зайны хооронд зөрүү үүснэ.



Автомашины аль нэг тал хазайсан үед


Зорчигчдын тоо, ачааны хуваарилалт зэргээс хамаарч автомашин аль нэг тал руугаа хазайсан үед зай заах шугам болон автомашины бодит чиглэл, зайны хооронд зөрүү үүснэ.



A Үүссэн зөрүү

Автомашины төвийг заах шугам

Чиглүүлэх шугам нь арын гуперны ойролцоо агаарт харагдаж байгаа тул чиглүүлэх шугам төвөөс хазайсан байдалтай харагдаж болно.



3 хэмжээст объектын дүрс болон бодит байдлын зөрүү

Чиглүүлэх шугам объектыг тэгш гадаргуу дээр байгаа гэж тооцоолон харуулдаг тул 3 хэмжээс объектын бодит байрлалыг тогтоох боломжгүй байдаг. Нааш түрэн гарсан хэсэг бүхий 3 хэмжээст объектод (ачааны машины тэвш зэрэг) ойртох үед дараах анхааруулгыг мөрдөнө.




АЮУЛТАЙ

■ Lexus parking assist-мэдрэгчийн автоматаар гарч ирдэг дэлгэц

Lexus parking assist-мэдрэгчийн индикатор улаан өнгөөр асах эсвэл дуут дохио үргэлжлэн дуугарч байгаа үед автомашины ойр орчмыг даруй шалгах ба санамсаргүй осол үүсгэх аюултай тул аюулгүй байдлыг шалгалгүйгээр үргэлжлүүлэн жолоодож болохгүй.


Панорамик дэлгэц (томруулж харуулах дэлгэц мөн хамаарна)

Тус зураг дээр автомашин болон бусад объект, автомашин хооронд зай байгаа бөгөөд мөргөлдөх эрсдэлгүй харагдаж байна. Бодит байдал дээр бусад объект таны автомашины явах зам дээр байх, улмаар мөргөлдөх эрсдэл үүссэн байж болно. Автомашины ойр орчмын аюулгүй байдлыг шууд харж нягтална.




Эргэх чиглэл заах шугам

- Бусад автомашины гүпер дэлгэц дээр эргэх чиглэл заах шугамын гадна талд буюу мөргөлдөх аюул эрсдэл харагдахгүй байсан ч бодит байдал дээр саад таны автомашины явах зам дээр байх, улмаар мөргөлдөх эрсдэл үүссэн байж болно. Ойр орчмын аюулгүй байдлыг шууд харж нягтална.




A Эргэх чиглэл заах шугам

- Өндөр байрлалд байгаа 3 хэмжээс объект (нааш илүү гарсан хэсэгтэй хана, ачааны машины тэвш г.м.) нь дэлгэц дээр харагдахгүй байж болно. Автомашины ойр орчмын аюулгүй байдлыг шууд харж нягтална.



A Хананы нааш илүү гарсан хэсэг


- Дэлгэцээр харахад ачааны машины тэвш эргэх чиглэл заах шугамын гадна талд байх ба мөргөлдөх аюул эрсдэл харагдахгүй байсан ч бодит байдал дээр ачааны машины тэвшний хэсэг автомашины явах зам дээр байх, улмаар мөргөлдөх эрсдэл үүссэн байж болно. Автомашины ойр орчмын аюулгүй байдлыг шууд харж нягтална.



A Эргэх чиглэл заах шугам


Зай заах шугам

Автомашины ойр орчим болон ар талыг шууд харж шалгана. Дэлгэц дээр ачааны машин **B** -р байрлалд харагдана. Гэвч бодит байдал дээр хэрэв та **A** хүртэл ухрах үед та ачааны машиныг мөргөнө. Дэлгэц дээр **A** хамгийн ойр, **B** болон **C** нь хамгийн хол харагдаж байна. Гэвч бодит байдал дээр **A** ба **C** хүртэлх зай адил ба **B** нь **A** ба **C** -с хол зайд байна. Автомашины ойр орчмын аюулгүй байдлыг шууд харж нягтална. **D** хүртэлх зай ойролцоогоор 1 м (3 ft.).




Ташуу багана

Панорамик дэлгэц сонгогдсон үед ташуу багана нь эгц босоо бөгөөд зайтай харагдах боловч бодит байдал дээр баганын дээд тал наашаа ташуу байрласан ба автомашин баганыг мөргөх магадлалтай. Автомашины хойд талын аюулгүй байдлыг нүдээр харж нягтална уу.



Томруулж харуулах функц

Энгийн панорамик харагдцаас ялгаатай нь панорамик дэлгэцийн томруулж харуулах функц нь дэлгэц дэх автомашины тэмдгийг дарж томруулж харуулна. Тиймээс зам, хана дээрх цагаан шугам нь гулзайсан байдлаар харагдаж болно.



Автомашины доод талын харагдац

Зорчигчдын тоо, ачаа тээшний жин, замын хэвгий, замын гадаргуугийн нөхцөл байдал, орчны гэрлийн хэмжээ зэргээс хамаарч дэлгэцээр харуулж буй дугуйн байрлал болон автомашины байрлал заах шугам нь бодит байдлаас өөр байж болно. Автомашины ойр орчмын аюулгүй байдлыг цаг ямагт

нягталж жолоодно.

■ Автомашины доод талыг харуулах дэлгэц ашиглах

- Дэлгэцээр харуулж буй дүрс нь автомашины одоогийн байрлалаас хойноос авсан дүрс юм. Тиймээс дэлгэцийн дүрс нь дараах нөхцөлүүдэд бодит байдлаас өөр байж болно.
 - Объект хөдөлсөн, дүрс авсны дараа орж ирсэн зүйл
 - Элс, цас зэргийн сул эд зүйл нурсан, хөдөлсөн үед
 - Саад хөдөлсөн үед
 - Системийн харуулах хүрээ буюу камерын зураг авах хүрээнд тогтоол ус, шалбааг зэрэг байгаа үед
 - Автомашин шарваж байгаа
- Дараах нөхцөлүүдэд дэлгэцээр харуулж буй дугуйн байрлал болон автомашины байрлал заах шугам бодит байдлаас өөр байж болно.
 - Дугуй сольсон
 - Нэмэлт төхөөрөмж, тоноглол суурилуулсан үед

⚠ АЮУЛТАЙ

■ Чиглүүлэх шугам

Дэлгэцийн энэ горимын чиглүүлэх шугамыг өмнө нь авсан дүрснээс систем боловсруулан гаргадаг тул бодит шугамын заалт бодит байдлаас өөр байж болно. Автомашины ойр орчмын аюулгүй байдлыг цаг ямагт нягтлангаа жолоодно.

Таны зайлшгүй мэдэх шаардлагатай зүйлс

■ Автомашинд асуудал гарсан гэж үзвэл

Дараах шинж тэмдгүүд илэрсэн үед тухайн шалтгааны дагуу арга хэмжээ авч дахин шалгана.

Тохирох арга хэмжээ авсан ч засагдахгүй байвал та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

Шинж тэмдэг	Шалтгаан	Авах арга хэмжээ
Дүрс муу харагдах	• Харанхуйд байгаа • Линзний ойр орчим хэт хүйтэн, хэт халуун • Гадаа хэт хүйтэн • Камер дээр усны дусал тогтсон • Бороо эсвэл хур тунадастай • Гадны биет (шавар г.м.) камерт наалдсан • Нарны гэрэл, машины их гэрэл камер дээр шууд туссан • Автомашин өдрийн гэрэл, натрийн гэрэл, мөнгөн усны уурын гэрэл доор байгаа үед	Автомашины ойр орчмыг шууд харангаа ухарна. (Харагдах байдал сайжирсны дараа дэлгэцийг дахин ашиглана.) Multi-terrain монитор системийн дүрсний чанарыг дэлгэцийн тохиргоотой адил аргаар хийнэ. Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.
Дүрс бүрсийх	Бохирдол, гадны биет (усны дусал, мөс, шавар г.м.) камерт тогтсон	Камерыг их хэмжээний усаар угаасны дараа линзийг зөөлөн нойтон даавуугаар арчина. Арын камер: Камер угаагч ашиглан линзийг цэвэрлэнэ. (→X.232)
Камерын чиглэл алдагдах	Камер, түүний ойр орчим хүчтэй цохилтонд өртсөн	Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу
Чиглүүлэх шугамын тохиргоо алдагдах	Камерын байрлалын тохиргоо алдагдсан	Lexus дилер дээрээ оношлуулна уу.
	• Автомашин хазайсан (хүнд ачаа ачсан, дугуй хагарснаас хийн даралт буурсан зэрэг) • Автомашин налуу газар байгаа.	Автомашины ойр орчмыг шууд харангаа ухарна.
Жолооны хүрд шулуун үед эргэх чиглэл заах шугам хөдлөх	Жолооны хүрдний мэдрэгч буруу сигнал өгч байгаа	Та өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа оношлуулна уу.
Чиглүүлэх шугам гарахгүй байх	Тээшний хаалга нээлттэй	Тээшний хаалгыг хаана. Шийдвэрлэгдэхгүй бол та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

Шинж тэмдэг	Шалтгаан	Авах арга хэмжээ
Панорамик дэлгэц томорч харагдахгүй байх Нэвт харагдах дэлгэц/Хөдлөх үеийн дэлгэц/хажуугийн оврын дэлгэц/Эргэлтийн үеийн дэлгэц гарахгүй үед	Lexus parking assist-мэдрэгч доголдсон эсвэл бохирдсон	Доголдол үүссэн үед Lexus parking assist-мэдрэгчийн зааврын дагуу тохиргоог хийнэ. (→X.316)
Шил арчигчийн шингэн цацагдахгүй байх	Шингэн дууссан	Шингэн нэмнэ.
	Хошуу бөглөрсөн	Lexus дилер дээрээ оношлуулна уу.
	Шил арчигчийн шингэн хөлдсөн	Гадна агаарын хэмд тохирох шингэн ашиглана.
	Тээшний хаалга нээлттэй	Тээшний хаалга хаана.
	Удаан хугацаанд ажиллуулаагүйгээс шингэн дамжуулах хоолой хатсан.	Арын камер угаагчийн товчийг хэд хэдэн удаа ажиллуулна.
Арын камерын дүрс бүдэг	Гадны биет (усны дусал, шавар, цас, мөс хайлуулах бодис зэрэг) камер дээр тогтсон.	Камерыг их хэмжээний усаар угаагаад зөөлөн нойтон даавуугаар арчина.
	Гадны биет (цас, мөс шавар зэрэг) камерын ойр орчимд тогтсон.	Гадны биетийг цэвэрлэнэ.
Камер угаагчийн товч ажиллахгүй байх	Панорамик дэлгэцэд доголдол үүссэн.	Lexus дилер дээрээ оношлуулна уу.

Бүтээгдэхүүний лиценз

About Free / Open-Source Software Information

This product includes the free / open-source software.


You can obtain the licensing information of the free / open-source software from the following URL.

<https://www.denso.com/global/en/opensource/svss/toyota/>

Жолоодлогын горим сонгох товч

Жолоодлогын нөхцөлд
тохируулан жолоодлогын
горим сонгох боломжтой.

Системийн эд ангиуд




- A** MODE SELECT товч
- B** DRIVE MODE товч
- C** Мэдээллийн дэлгэц (→X.98)

Жолоодлогын горим сонгох


- 1 DRIVE MODE товч дарна.

Товч дээрх **A** индикатор асна.



- 2 MODE SELECT товчийг баруун болон зүүн эргүүлж мэдээллийн дэлгэц дээр горим сонгоно.

► AVSS системгүй загвар



- Хэвийн горим

Шатахууны бага зарцуулалт, дуу чимээ бага, динамик гүйцэтгэлийг тэнцвэртэйгээр бүрдүүлэх горим. Хотын жолоодлогод тохиромжтой.

- 3 Эко жолоодлогын горим


Хөдөлгүүрийн хаазыг удирдах, агааржуулалтын системийн ажиллагааг удирдах (халуун/хүйтэн) замаар шатахуун зарцуулалтыг сайжруулах, байгаль орчинд ээлтэй байдлаар

хөдөлгөөн эхлэхэд жолоочид тусална. Горим идэвхжих үед эко горимын индикатор асна.

- **SPORT горим**

Хурдны хайрцаг, хөдөлгүүр, жолооны механизмыг цогцоор нь удирдах замаар хурдтай, хүчтэй хурд авалтыг бий болгодог. Уулын замаар явах зэргээр нарийн жолоодлого шаардлагатай үед тохиромжтой. SPORT горимын индикатор асна.

- ▶ **AVSS системтэй загвар**



- **Хэвийн горим**

Шатахуун бага зарцуулалт, дуу чимээ бага, динамик гүйцэтгэлийг тэнцвэртэйгээр бүрдүүлэх горим. Хотын жолоодлогод тохиромжтой.

- **Комфорт горим**

Автомашины амортизаторын системийг удирдах замаар илүү тав тухтай зорчих боломж бүрдүүлнэ. Хотын нөхцөлд тохиромжтой. Комфорт горимын индикатор асна.

- **Эко жолоодлогын горим**

Хөдөлгүүрийн хаазыг удирдах, агааржуулалтын системийн ажиллагааг удирдах (халуун/хүйтэн) замаар

шатахуун зарцуулалтыг сайжруулах, байгаль орчинд ээлтэй байдлаар хөдөлгөөн эхлэхэд жолоочид тусална. Горим идэвхжих үед эко горимын индикатор асна.

- **SPORT S горим**

Хурдны хайрцаг удирдах замаар хурд авалтыг нэмэгдүүлнэ нь хүчтэй Хурд авалт шаардлагатай үед тус горим тохиромжтой. "SPORT S" индикатор асна.

- **SPORT S+ горим**

Хурдны хайрцаг, хөдөлгүүр, амортизаторын ажиллагаа, жолооны механизмыг цогцоор нь удирдах замаар автомашины жолоодлого болон тогтвортой байдлыг бүрдүүлж спорт жолоодлого хийхэд тохиромжтой болгодог. Горим идэвхжих үед SPORT S+ горимын индикатор асна.

- **Custom горим**

Явах эд анги, кузов, агааржуулалтын системийн функцийг ажиллагааг таны хүссэн тохиргоонд тохируулна. Тус горимыг зөвхөн голын дэлгэцийн жолоодлогын горим тохируулах дэлгэцээр идэвхжүүлнэ. (→X.583) CUSTOM горимын индикатор асна.

■ Жолоодлогын горим сонгох товч ажиллах нөхцөл

Дөрвөн дугуй хөтлөх системийн товч H4 байрлалд байгаа.

■ Эко жолоодлогын горим дахь агааржуулалтын системийн ажиллагаа

Эко жолоодлогын горим нь шатахуун зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор агааржуулалтын системийн сэнсний хурд мөн халуун хүйтнээр үлээх хэмжээг хязгаарладаг. Агааржуулалтын системийн ажиллагааг нэмэх үед дараах үйлдлийг хийнэ:

- Эко агааржуулалтын системийн горимыг унтраах(→X.438)
- Сэнсний хурд нэмэх (→X.437)
- Эко жолоодлогын горим унтраах (→X.407)

■ Жолоодлогын горим автоматаар цуцлагдах

Дараах нөхцөлд жолоодлогын горим цуцлагдаж хэвийн горимд шилжинэ:

- Sport, SPORT S, SPORT S+ горим эсвэл custom горим сонгогдсон үед
- Хөдөлгүүр асаах товчийг унтраагаад дахин асаасан
- Дөрвөн дугуй хөтлөх системийн товч L4 байрлалд байгаа
- Multi-terrain Select ассан (тоноглогдсон загварт)
- “REMOLQUE” горим (тоноглогдсон загварт) ассан
- Эко жолоодлогын горим эсвэл комфорт горим сонгогдсон үед
- Дөрвөн дугуй хөтлөх системийн товч L4 байрлалд байгаа
- Multi-terrain Select ассан (тоноглогдсон загварт)
- “REMOLQUE” горим (тоноглогдсон загварт) ассан

■ Өөрчлөх боломжтой тохиргоо (AVSS системтэй загварт)


Зарим тохиргоог өөрчлөх боломжтой.

(Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)

Дөрвөн дугуй хөтлөх систем

Дөрвөн дугуй хөтлөх системийн болон төвийн дифференциал цоожлогчийн товч ашиглан дараах горимуудыг сонгоно.

Системийн товч



A H4 (өндөр хурдны байрлал)

Бүх төрлийн зам дээр хэвийн жолоодлого хийх үед ашиглана.

B L4 (нам хурдны байрлал)

Огцом өгсүүр, уруу, бартаат, элс, шавартай замаар зүтгүүлэх зэрэг автомашины зүтгэх хүчийг дээд зэргээр шаардсан үед ашиглана.

Нам хурдны индикатор асна.

H4 ба L4 хооронд солих

■ H4-с L4 лүү шилжүүлэх

1 Автомашиныг зогсооно.

- 2 Арааг N байрлалд шилжүүлнэ.
- 3 Системийн товч дараад цагийн зүүний эсрэг эргүүлнэ.

Индикатор асах хүртэл хүлээнэ.

■ L4-с H4 лүү шилжүүлэх

- 1 Автомашиныг зогсооно.
- 2 Арааг N байрлалд шилжүүлнэ.
- 3 Системийн товч дараад цагийн зүүний дагуу эргүүлнэ.

Индикатор унтрах хүртэл хүлээнэ.


Төвийн дифференциал цоожлогчийн товч

Автомашин суусан, хальтиргаа их, бартаат зам дээр төвийн дифференциалыг цоожилно.

Төвийн дифференциал цоожлогчийн индикатор асна.

Төвийн дифференциалыг салгах үед товчийг дахин дарна.

Автомашин тухайн суусан газраас гарсан эсвэл хальтиргаагүй, тэгш зам дээр гарсны дараа төвийн дифференциалыг салгана.



■ Дөрвөн дугуй хөтлөх системийн товчны ажиллах нөхцөл

- Асаах товч ON горимд байгаа.
- Арааны хөшүүрэг N байрлалд.
- Автомашин бүрэн зогссон.

■ Дөрвөн дугуй хөтлөх системийн нам хурдны индикатор

“H4” болон “L4” байрлалын хооронд шилжүүлэх үед индикатор анивчина.

■ Хальтиргаатай зам дээр

- Бартаа ихтэй зам дээр дөрвөн дугуй хөтлөх системийн товчийг L4 байрлалд шилжүүлээд арааны хөшүүргийг M горимын 2-р араанд шилжүүлсэн үед дөрвөн дугуйн хүчийг удирдах замаар жолоочид туслах Active TRC систем тоормосны ажиллагааг хамгийн үр дүнтэй байдлаар удирдана.
- Автомашин суусан эсвэл огцом уруу замаар уруудах зэргээр автомашины хүчин чадал, зүтгэх хүчийг дээд зэргээр шаардсан нөхцөлд арааны хөшүүргийг M горимын 1-р араанд шилжүүлнэ.

■ Төвийн дифференциал цоожлогчийн индикатор

Төвийн дифференциалыг цоожлох, салгах үед индикатор анивчина.

■ Төвийн дифференциал цоожлогчийн товчны ажиллах нөхцөл

- Асаах товч ON горимд байгаа.
- Автомашины хурд 100 км/ц (62 миль/ц)-с бага үед.

■ Төвийн дифференциал залгах, салгах

- Дөрвөн дугуй хөтлөх системийн товч L4 байрлалд төвийн дифференциал цоожлогч залгагдсан үед VSC автоматаар салгагдана. (Төвийн дифференциалын индикатор болон VSC OFF индикатор асна.)
- Дифференциал цоожлогч гүйцэд

залгадаагүй үед төвийн дифференциалын индикатор анивчина. Төвийн дифференциалыг салгасан ч индикатор унтрахгүй үед хурд нэмж хасангаа шулуун явах эсвэл ухрах үйлдэл хийнэ.

- Хурд баригч асаалттай үед төвийн дифференциал цоожлогч 5 секундйн дотор залгагдах эсвэл салгагдахгүй үед хурд баригчийг унтраана.

■ 4 дугуй хөтлөх системийн нам хурдны индикатор эсвэл төвийн дифференциалын индикатор анивчих

- Дөрвөн дугуй хөтлөх системийн товч ашиглах үед дөрвөн дугуй хөтлөх системийн нам хурдны индикатор үргэлжлэн анивчвал автомашиныг бүрэн зогсоон арааны хөшүүргийг N араанд шилжүүлээд товчийг дахин дарна.
- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний температур хэт нам үед автомат хурдны хайрцгийн шингэний хэм хүйтэн байгаагаас шалтгаалан дөрвөн дугуй хөтлөх системийг “H4” болон “L4” хооронд шилжүүлэх боломжгүй байж болно. Энэ нөхцөлд мэдээллийн дэлгэцийн зааварчилгааг дагах ба хөдөлгүүр халсны дараа үйлдлийг давтана.

Дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч 4 дугуй хөтлөх системийн нам хурдны индикатор эсвэл төвийн дифференциалын индикатор үргэлжлэн анивчиж байвал хөдөлгүүр, тоормосны систем, дөрвөн дугуй хөтлөх системд доголдол үүссэн байх магадлалтай. Энэ нөхцөлд H4 ба L4 хооронд шилжүүлэх боломжгүй ба төвийн дифференциал цоожлогч ажиллахгүй байж болно. Lexus дилерт нэн даруй хандаж оношлуулна уу.



АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үед

Автомашины дугуй барьцалдах чадвараа алдсан үед дөрвөн дугуй хөтлөх системийн товчтой ямар ч нөхцөлд харьцахыг хатуу хориглоно. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

■ Автомашиныг зогсоолд байрлуулах, удаан зогсолт хийх үед

Дөрвөн дугуй хөтлөх системийн нам хурдны индикатор унтрах эсвэл асахаас өмнө арааны хөшүүргийг хөдөлгөсөн үед хөтлөх систем дутуу залгагдах аюултай. Энэ тохиолдолд автомашины хурдны хайрцгаас урд ба хойд хөтлөгч гол салгагдах ба хурдны хайрцгийн арааны байрлалаас үл хамааран автомашин өнхөрнө. (Энэ үед индикатор анивчих ба анхааруулах дохио дуугарна.)

Араа “P” байрлалд байсан ч автомашин чөлөөтэй өнхрөх аюултай. Таныг болон бусдыг гэмтээх аюултай тул хөтлөх системийг гүйцэд залгахад анхаарна.



АНХААР

■ Төвийн дифференциалын гэмтлээс сэргийлэх

- Хуурай, хатуу зам дээр хэвийн жолоодлого хийх үед төвийн дифференциалыг салгана.
- Автомашин суусан газар эсвэл хальтиргаатай, энхэл донхолтой замаас гарсны дараа төвийн дифференциалыг салгана.
- Автомашин эргэлт хийх мөн автомашины дугуй газраас хөндий хий эргэж байгаа үед төвийн дифференциал цоожлогчийн товчийг дарж болохгүй.

Арын дифференциал цоожлогч*


*: Тоноглогдсон загварт

Арын дифференциал цоожлогчийг автомашин зөвхөн суусан эсвэл хальтиргаатай, энхэл донхолтой зам дээр дугуй хий эргэх үед ашиглана. Аль нэг дугуй хий эргэх үед систем нь үр дүнтэй.

Арын дифференциал цоожлогчийн товч

Товч дээр дарж системийг асааж унтраана.

Энэ үед дифференциал түгжих/салгах дэлгэцийн дифференциал цоожлогчийн индикатор анивचना. Үйлдэл дуусах хүртэл хүлээнэ. Арын дифференциал цоожлогч залгадаг үед индикатор үргэлжлэн асна. Салгах үед товч дээр дахин дарна.



■ Ашиглах үеийн зөвлөмж

Эхлээд дөрвөн дугуй хөтлөх системийг “L4”-д шилжүүлэн төвийн дифференциал залгаад урагш хөдлөх боломжтой эсэхийг шалгана. Тус аргаар автомашин хөдлөхгүй үед арын дифференциал цоожлогчийг мөн залгана.

- Дифференциалыг цоожлохын өмнө бүх дугуй хөдөлгөөнгүй болсон эсэхийг нягтална.
- Автомашин суусан газраас гарсан даруйд дифференциал цоожлогчийг салгана.

■ Арын дифференциал цоожлогч салгасны дараа

Арын дифференциал цоожлогчийн салгасан ч индикатор анивчсан хэвээр байвал автомашиныг хөдөлгөөнгөө жолооны хүрдийг 2 тийш бага зэрэг эргүүлнэ.

■ Автоматаар салгах функц

Дараах аль нэг нөхцөлд дифференциал цоожлогч салгагдана:

- Асаах товчийг унтраах.
- Дөрвөн дугуй хөтлөх системийг “H4”-д шилжүүлэх.
- Төвийн дифференциал салгах.

■ Арын дифференциал цоожлогч салгасны дараа

Индикатор унтарсан эсэхийг нягтална.

■ Дифференциал түгжих/ салгах дэлгэцийн арын дифференциал цоожлогчийн индикатор

- Арын дифференциал залгах, салгах үед тус индикатор анивचना.
- Арын дифференциал цоожлогчийн товчийг ажиллуулсан ч индикатор анивчсан хэвээр байвал орчны аюулгүйн байдлыг нягтлаад автомашиныг хөдөлгөөнгөө жолооны хүрдийг 2 тийш бага зэрэг эргүүлнэ.

Дээрх үйлдлийг хийсэн ч индикатор анивчсан хэвээр байвал нэн даруй Lexus дилер дээрээ оношуулна уу. Дөрвөн дугуй хөтлөх системд доголдол үүссэн байж болзошгүй.

■ Арын дифференциал түгжих

Арын дифференциал түгжигдсэн үед дараах системүүд ажиллахгүй.

- ABS
- Тоормосонд туслах систем
- VSC
- Уруу замд туслах удирдлагын систем
- Active TRC



АЮУЛТАЙ

■ Дифференциал цоожлогч ашиглах үед

Дараах анхааруулгыг дагаж мөрдөнө. Эсрэг тохиолдолд осолд хүргэх аюултай.

- Дээр зааснаас өөр нөхцөлд урд дифференциал цоожлогч ашиглаж болохгүй.
- Дугуйн эргэлт бүрэн зогсоогүй үед урд дифференциал цоожлогчийг залгаж болохгүй.
- Дифференциал цоожлогдсон үед 8 км/ц (5 миль/ц)-с дээш хурдтай явж болохгүй.
- Хойд дифференциал цоожлогч салгагдсаны дараа даруй товчийг унтраах ба залгасан байрлалд автомашины үргэлжлүүлэн жолоодож болохгүй.

Crawl Control*

*: Тоноглогдсон загварт

Хааз болон тоормос ашиглалгүйгээр тогтмол бага хурдаар хэт бартаатай замаар явах боломж бүрдүүлсэн систем юм. Зүтгэх хүчний алдагдал болон хальтиргаатай зам дээрх хальтиргааг боломжит бага хэмжээнд бууруулж автомашины тэнцвэр алдахаас сэргийлдэг.



АЮУЛТАЙ

■ Crawl Control ашиглах үед


Crawl Control функцэд хэт найдаж болохгүй. Функц нь автомашины хүчин чадлын хязгаарыг нэмэгдүүлдэггүй. Замын нөхцөл байдлыг цаг ямагт нягтлан аюулгүй жолоодлого хийнэ.

■ Системийн хэвийн ажиллагаанд нөлөөлөх нөхцөлүүд

Дараах замын нөхцөлд систем тогтмол хурд барих боломжгүй ба улмаар осолд хүргэх аюултай:

- Хэт уруу, өгсүүр зам
- Хэт тэгш бус гадаргуутай зам
- Цастай, хальтиргаатай зам

Системийн эд ангиуд




- A** Хянах самбар (→X.88)
- B** Голын дэлгэц (→X.105)
- C** MODE SELECT товч
- D** DAC/CRAWL товч


Crawl Control асаах

1 DAC/CRAWL товч дарна.

A индикатор болон хянах самбар дахь Crawl Control индикатор асаж шарвалтын индикатор анивчина.




2 MODE SELECT товчийг баруун зүүн эргүүлж хянах самбар дээр горим сонгоно.



Сонгох боломжтой горим

Замын нөхцөл байдалд нийцүүлэн дараах 5 горимоос сонгох боломжтой.



1 Lo

Хадархаг зам эсвэл уруу зам дээр тохиромжтой.

2 Lo-Mid

Хадархаг зам, уруу зам эсвэл овгор товгортой өгсүүр зам дээр тохиромжтой.

3 Mid

Овгор товгортой өгсүүр зам дээр

тохиромжтой.

4 Mid-Hi

Цас, шавар, хайрга чулуутай, элс, шороо, овгор товгор (өгсүүр) өвстэй зам дээр тохиромжтой.

5 Hi

Цас, шавар, хайрга чулуутай, элс, шороо, овгор товгор (өгсүүр) өвстэй зам дээр тохиромжтой.

Crawl Control унтраах

- ▶ DAC/CRAWL товчны индикатор асаж байх үед

DAC/CRAWL товч дахин дарна.

- ▶ DAC/CRAWL товчны индикатор асаагүй үед

DAC/CRAWL товч дарж индикаторыг асаана. Индикатор ассан үед товчийг дахин дарна.

Crawl Control систем унтарсан үед Crawl Control индикатор, шарвалтын индикатор унтарч мэдээллийн дэлгэц дээр Crawl Control систем унтарсныг илтгэх мэдээлэл хэсэг хугацаанд гарна.

Жолоодлогын үед Crawl Control систем унтраах нөхцөлд анхаарал болгоомжтой жолоодно.

■ Crawl Control ажиллах нөхцөл

- Хөдөлгүүр асаалттай.
- Арааны хөшүүрэг Р эсвэл N-с өөр байрлалд.
- Дөрвөн дугуй хөтлөх системийн товч L4 байрлалд.
- Жолоочийн хаалга хаалттай.

■ Crawl Control автоматаар цуцлагдах

Дараах нөхцөлүүдэд анхааруулах дохио тасалдаж дуугарах ба Crawl Control автоматаар цуцлагдана. Энэ тохиолдолд Crawl Control индикатор анивчих ба дараа нь унтрах ба мэдээллийн дэлгэц дээр хэдэн секундйн турш Crawl Control унтарсан тухай мэдээлэл гарна.

- Арааны хөшүүрэг Р эсвэл N байрлалд шилжсэн.
- Дөрвөн дугуй хөтлөх системийн товч H4 байрлалд.
- Жолоочийн хаалга онгойх үед

■ Crawl Control функцийн ажиллагааны хязгаар

- Дараах нөхцөлд уруу замаар тогтмол хурдаар явах үед тоормос ашиглан хурд тохируулж болно. Гэвч өгсүүр замаар тогтмол хурдаар явах үед хөдөлгүүрийн хүчийг удирдах боломжгүй.
- Автомашины хурд 10км/ц (6 миль/ц)-с давах үед
- Дараах нөхцөлд хөдөлгүүр болон тоормосны хүчийг түр хугацаанд удирдах боломжгүй. Энэ үед Crawl Control индикатор анивчина.
- Арын дифференциал түгжигдсэн үед: Автомашины хурд 10 км/ц (6 миль/ц)-с давах үед
- Арын дифференциал залгагдаагүй үед: Автомашины хурд 25км/ц (15 миль/ц)-с давах үед

■ Crawl Control системийг удаан хугацаанд үргэлжлүүлэн ашигласан үед

- Crawl Control системийг удаан хугацаанд үргэлжлүүлэн ашигласан тохиолдолд анхааруулах дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр доголдлын анхааруулга гарах ба тоормосны системийн хэт халалтаас шалтгаалж Crawl Control индикатор унтарч систем түр хугацаанд идэвхгүй болно. Энэ үед автомашиныг даруй аюулгүй газар зогсоох ба анхааруулга унтрах

хүртэл тоормосны системийг хангалттай хөргөөнө. (Энэ үед автомашиныг хэвийн жолоодлогын горимоор жолоодох боломжтой.)

- Crawl Control системийг удаан хугацаанд үргэлжлүүлэн ашигласан тохиолдолд анхааруулах дохио дуугарч мэдээллийн дэлгэц дээр доголдлын анхааруулга гарах ба хурдны хайрцгийн хэт халалтаас шалтгаалж систем түр хугацаанд идэвхгүй болно. Дэлгэцийн анхааруулга унтрах хүртэл автомашиныг аюулгүй газарт зогсооно.

■ Crawl Control системээс шалтгаалсан дуу, чичиргээ

- Хөдөлгүүр асах эсвэл автомашин хөдөлж эхлэх үед хөдөлгүүрийн хэсгээс дуу гарч болно. Энэ дуу нь Crawl Control системд доголдол үүссэнийг илтгэхгүй.
- Crawl Control систем ажиллах үед дараах нөхцөл байдал үүсэж болно. Эдгээр нь Crawl Control системд доголдол үүссэнийг илтгэхгүй.
- Автомашины их бие, жолооны хүрднээс чичиргээ мэдрэгдэх
- Автомашин зогссоны дараа мотор ажиллах дуу сонсогдох

■ Системд доголдол үүссэн үед

Анхааруулах гэрэл, анхааруулах мэдээлэл асах буюу гарна. (→X.537, 541)

Multi-terrain Select*

*: Тоноглогдсон загварт

Multi-terrain Select нь бартаатай замын жолоодлогыг сайжруулах систем юм.

Тухайн замын нөхцөлд тохирох горимыг сонгоно. Тоормосны удирдлага, зүтгэх хүчний удирдлага, амортизаторын удирдлагыг тухайн сонгосон горимд нийцүүлэн удирдана.

AUTO горим сонгогдсон үед замын нөхцөлд нийцүүлэн тоормосны удирдлага, зүтгэх хүчний удирдлага, амортизаторын удирдлагыг автоматаар тохируулна.



АЮУЛТАЙ


■ Multi-terrain Select ашиглах үед

Амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй ослоос сэргийлэхийн тулд дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:


- Жолоодлогын өмнө тухайн сонгосон горимын индикатор асаж байгааг нягтална. Индикатор асаагүй үед систем ажиллахгүй.
- Хүснэгт дэх замын нөхцөлүүд (→X.417) нь зөвхөн жишээ болно. Замын энхэл донхол, хальтиргаа зэргээр тухайн сонгосон горим тохиромжгүй байж болох тул жолоодлогын өмнө замын нөхцөл байдлыг нягтална.
- Multi-terrain Select нь автомашины хүчин чадлын хязгаарыг нэмэгдүүлэхэд зориулагдсан систем биш юм. Замын нөхцөл байдлыг урьдчилан сайтар нягтлаж аюулгүй жолоодлого хийнэ.

**АНХААР****■ Ашиглалтын үеийн анхааруулга**

Multi-terrain Select нь бартаат замын жолоодлогод ашиглагдахад зориулагдсан систем бөгөөд бусад үед ашиглахыг хориглоно.

Системийн эд ангиуд**A** MTS товч**B** MODE SELECT товч**C** Мэдээллийн дэлгэц
Сонгосон горимыг харуулна.**Горим солих****1 MTS товч дарна.**


Товч дарах үед товчны **A** индикатор асна.



2 MODE SELECT товчийг
баруун зүүн эргүүлэн

мэдээллийн дэлгэц дээр жолоодлогын горим сонгоно.

Дөрвөн дугуй хөтлөх системийн товчны байрлалаас хамаарч дараах горимуудаас сонгох боломжтой.



► Дөрвөн дугуй хөтлөх системийн товч L4-д байгаа үед

Горим		Замын нөхцөл
	AUTO	Бүх замд тохиромжтой
	SAND	Элсэрхэг замд тохиромжтой
	MUD	Шавартай замд тохиромжтой
	ROCK	Хадархаг замд тохиромжтой

Тоормосны удирдлага идэвхэжсэн үед шарвалтын индикатор анивчина.

► Дөрвөн дугуй хөтлөх системийн товч H4-д байгаа үед

Горим		Замын нөхцөл
	AUTO	Бүх замд тохиромжтой
	DIRT	Шороон замд тохиромжтой

Горим		Замын нөхцөл
	SAND	Элсэрхэг замд тохиромжтой
	MUD	Шавартай замд тохиромжтой
	DEEP SNOW	Гүнзгий цастай замд тохиромжтой

Тоормосны удирдлага идэвхэжсэн үед шарвалтын индикатор анивчина. SAND, MUD эсвэл DEEP SNOW горим сонгогдсон үед VSC автоматаар цуцлагдана. (VSC OFF индикатор асна.)

■ Multi-terrain Select

Multi-terrain Select нь бартаат зам дээрх зүтгэх хүчний удирдлагыг хамгийн дээд байдлаар удирддаг. Үүнээс шалтгаалж шатахуун зарцуулалт энгийн горимтой харьцуулахад нэмэгддэг.

■ Системийн ажиллагаа автоматаар цуцлагдах

Дараах нөхцөлүүдэд Multi-terrain Select автоматаар цуцлагдана.

- 4 дугуй хөтлөх системийн товчны Н4 байрлалд DRIVE MODE товч дарсан.
- Асаах товчийг дарж унтраасан.

■ AUTO горим

Тухайн замын нөхцөлийг систем тооцоолон тоормосны удирдлага, зүтгэх хүчний удирдлага болон амортизаторын удирдлагыг идэвхжүүлдэг. Замын нөхцөлийг тооцоолох системийн чадвар хязгаартай тул энхэл донхол, хальтиргаатай зэрэг тухайн замын нөхцөлд системийн тус горим тохиромжгүй байж болно. Тус нөхцөлд жолоодлого эхлэхээс өмнө тухайн замын нөхцөлд тохирох жолоодлогын горим сонгоно.

■ Multi-terrain Select унтраах

Дараах үйлдлээр Multi-terrain Select унтраах боломжтой ба мэдээллийн дэлгэц дэх агуулга унтарна.

► MTS товчны индикатор ассан үед Систем ажиллах үед MTS товч дарна.

► MTS товчны индикатор асаагүй үед MTS товч дарж индикаторыг асаана.

Multi-terrain Select индикатор асаалттай үед MTS товч дахин дарна.

■ Автомашин суусан үед

Хүч дамжуулах анги болон дифференциалын тохиргоог өөрчилнө. Дараах функцийн ажиллагааны дэлгэрэнгүйг дараах хуудаснаас үзнэ үү.

● Дөрвөн дугуй хөтлөх систем (→X.409)

● Төвийн дифференциал цоожлогч (→X.410)

● Арын дифференциал цоожлогч* (→X.412)

*: Тоноглогдсон загварт

■ Multi-terrain Select систем ассан үеийн жолоодлого

Дараах нөхцөлүүд үүсэж болох ба эдгээр нь системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.

● Автомашины их бие, жолооны хүрднээс чичиргээ мэдрэгдэх.

● Хөдөлгүүрийн хэсгээс систем ажиллах дуу гарах.

■ Lexus дилер дээр оношилгоо хийлгэх нөхцөлүүд

Дараах нөхцөлүүдэд системд доголдол үүссэн байж болзошгүй. Даруй Lexus дилер дээр оношлуулна уу.

● Шарвалтын индикатор асаж байгаа.

● Multi-terrain Select сонгосон ч мэдээллийн дэлгэц дээр системийн аль ч горимын индикатор асахгүй байгаа.

Уруу замд туслах удирдлагын систем*

* Тоноглогдсон загварт

Уруу замд туслах удирдлагын систем нь уруу зам дээр хурд хэт нэмэгдэхээс сэргийлэхэд тусалдаг. Систем туслах хурдны хайрцгийн H4 горимд, хурд 30 км/ц (18 миль/ц)-с бага ба хааз, тоормос гишгээгүй үед ажиллана.

⚠ АЮУЛТАЙ

■ Уруу замд туслах удирдлагын систем ашиглах үед


Уруу замд туслах удирдлагын системд хэт найдаж болохгүй. Тус функц нь автомашины хүчин чадлыг нэмэгдүүлэх систем биш болно. Замын нөхцөлийг цаг ямагт нягтлан аюулгүй жолоодлого хийнэ.

Системийн ажиллагаа

DAC/CRAWL товч дарна.


Уруу замд туслах удирдлагын системийн индикатор асаж систем ажиллаж эхэлнэ.

Систем ажиллах явцад шарвалтын индикатор анивчиж тоормос/тоормосны туслах гэрэл асна. Ажиллагааны явцад дуу гарч болно. Энэ нь доголдлыг илэрхийлэхгүй.



Уруу замд туслах удирдлагын системийн хурд тохируулах

MODE SELECT товч эргүүлж хүссэн хурдаа тохируулна (4-с 30 км/ц (3-с 18 миль/ц)). Тохируулсан хурд мэдээллийн дэлгэц дээр гарна.



A Хурд нэмэх

B Хурд хасах

Системийг унтраах

► DAC/CRAWL товчны индикатор асаж байх үед

DAC/CRAWL товч дахин дарна.

► DAC/CRAWL товчны индикатор асаагүй үед

DAC/CRAWL товч дарж

индикаторыг асаана. Индикатор ассан үед DAC/CRAWL товч дахин дарна.

Индикатор анивчиж системийн ажиллагаа аажмаар зогсож эхлэх ба систем бүрэн унтарсан үед унтарна. Индикатор анивчих үед DAC/CRAWL товч дахин дарвал систем дахин асна.

■ Ажиллагааны үеийн зөвлөмж

Арааны хөшүүрэг P, N-с бусад байрлалд байгаа үед систем ажиллана.

■ Систем ажиллахгүй нөхцөл

- Туслах хурдны хайрцгийн L4 горим сонгогдсон.
- Арын дифференциал залгагдсан. (тоноглогдсон загварт)

■ Уруу замд туслах удирдлагын системийн индикатор анивчсан үед

- Дараах нөхцөлүүдэд индикатор анивчиж системийн ажиллагаа зогсоно:
 - Туслах хурдны хайрцгийн L4, H4 горим сонгогдсон
 - Арын дифференциал залгагдсан (тоноглогдсон загварт)
 - Арааны хөшүүрэг P-д байгаа
 - Автомашины хурд 30 км/ц (18 миль/ц)-с давсан
 - Тоормосны механизм халсан
- Дараах нөхцөлд индикатор анивчиж анхааруулга өгөх боловч систем үргэлжлүүлэн ажиллана:
 - Арааны хөшүүрэг N-д байгаа.

Системийн ажиллагаа аажмаар зогсож эхэлнэ. Систем ажиллах хугацаанд индикатор анивчих ба систем бүрэн унтарсан үед унтарна.

■ Системийг үргэлжлүүлэн удаан ашигласан үед

Системийг үргэлжлүүлэн удаан ашигласан үед тоормосны системд хэт халалт үүсэж болно. Хэт халалтаас сэргийлж дуут дохио дуугарах ба системийн ажиллагаа түр цуцлагдана.

Энэ нөхцөлд уруу замд туслах удирдлагын системийн индикатор анивчих ба мэдээллийн дэлгэц дээр “Traction Control Turned OFF” гарна.

“Traction Control Turned OFF” анхааруулга унтарч анивчиж байсан уруу замд туслах удирдлагын системийн индикатор үргэлжлэн асах хүртэл системийг ашиглахаас зайлсхийнэ. (Автомашиныг хэвийн жолоодлогоор үргэлжлүүлэн жолоодох боломжтой.)

■ Уруу замд туслах удирдлагын системийн дуу, чичиргээ

- Хөдөлгүүр асах эсвэл хөдөлгөөн эхэлсэн даруйд хөдөлгүүрийн хэсгээс дуу гарч болно. Энэ нь уруу замд туслах удирдлагын системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.
- Уруу замд туслах удирдлагын систем ажиллах үед дараах аль нэг нөхцөл үүсэж болно. Эдгээр нь доголдлыг илэрхийлэхгүй.
 - Автомашины их бие эсвэл жолооны хурднээс чичиргээ мэдрэгдэх
 - Автомашин зогсох үед моторын ажиллах дуу сонсогдох

■ Системийн доголдол

Дараах нөхцөлд өөрийн Lexus дилер дээр автомашинаа шалгуулна уу.

- Хөдөлгүүр асах товчийг ON горимд асаасан ч уруу замд туслах удирдлагын системийн индикатор асахгүй байх.
- “DAC/CRAWL” товч дарсан ч уруу замд туслах удирдлагын системийн индикатор асахгүй байх.
- Шарвалтын индикатор асах.



АЮУЛТАЙ

- Систем дараах замын гадаргуу дээр ажиллахгүй ба ашигласан нөхцөлд амь нас, эрүүл мэндэд ноцтой осолд хүргэх аюултай.
- Нойтон, шавартай зэрэг хальтиргаатай зам
- Мөстсөн зам
- Шороон зам

Жолоодлогод туслах системүүд

Хөдөлгөөний аюулгүй байдал, жолоодлогыг сайжруулах үүднээс мөн замын байдлаас хамаарч дараах системүүд автоматаар ажилладаг. Нөгөөтээгүүр эдгээр системүүд нь зөвхөн туслах үүрэгтэй тул жолоодлогын үед системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй.

Жолоодлогод туслах системүүдийн ойлголт

■ ABS (Anti-lock Brake System) үл түгжигдэх тоормос

Тоормос огцом гишгэсэн эсвэл хальтиргаатай зам дээр тоормослох үед дугуй түгжигдэхээс сэргийлж тусална.

MTS системтэй загвар: Multi-terrain Select систем ажиллахтай зэрэгцэн ABS ажиллана.

■ Тоормосонд туслах систем

Систем ослын зогсолт хийж байна гэж тооцоолсон үед тоормосны дөрөө гишгэх үед тоормосны хүчийг нэмэгдүүлнэ.

■ VSC систем (Vehicle Stability Control буюу автомашины тэнцвэрийн систем)

Шарвалт үүссэн эсвэл хальтиргаатай зам дээр эргэлт хийх үед автомашины тэнцвэр хадгалахад

тусална.

ABS, TRC, VSC ба EPS системүүдтэй хамтран цогцоор ажилладаг.

Хальтиргаатай зам дээр шарвалт үүсэх үед жолооны механизмын удирдлагаар тухайн чиглэлийн тэнцвэр хадгалахад тусална.

■ Чиргүүлийн савлагааг хянах систем (чирэх дэгээтэй автомашин)

Чиргүүл савлах үед дугуйнд тус бүр өөр хүчээр тоормос өгөх мөн хөдөлгүүрийн мушгих хүчийг удирдах замаар чиргүүлийн савлалтыг зогсооход тусална.

■ Active TRC (Traction Control) систем

Хальтиргаатай зам дээр хөдөлгөөн эхлэх, хурд авах үед хөтлөх дугуй хий эргэхээс сэргийлэх буюу автомашины зүтгэх хүчийг тогтмол барихад туслах систем.

■ Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага

Өгсүүр замд хөдөлгөөн эхлэх үед арагш өнхрөхөөс сэргийлэхэд туслах систем.

■ EPS цахилгаан жолооны хүчлүүр

Жолооны хүрд эргүүлэхэд шаардагдах хүчийг бууруулах үүднээс цахилгаан мотор ашигладаг.

■ E-KDSS систем (тоноглогдсон загварт)

Бартаат зам, эргэлттэй зам зэрэг зам болон жолоодлогын нөхцөлд

нийцүүлэн тэнцвэржүүлэгчийг удирдан жолоодлогын тав тух, тэнцвэрийг сайжруулдаг. Үүнээс гадна MTS системийн горим сонгогдсон үед тухайн жолоодлогын горимд тохирох байдлаар ажилладаг. (→Х.416) Дөрвөн дугуй хөтлөх системийн L4 горим сонгосон үед бартаат замын жолоодлогод нийцсэн байдлаар систем ажилладаг.

■ AVS (Adaptive Variable Suspension System) систем (тоноглогдсон загварт)

Замын байдал, жолоодлогоос хамаарч 4 дугуйн амортизаторын ажиллагааг тус бүр өөрөөр удирдаж жолоодлогын тав тух, тэнцвэр мөн автомашины байрлалыг хадгалахад тусалдаг.

Мөн сонгосон жолоодлогын горимд нийцүүлэн (→Х.407) амортизаторын ажиллагаа өөрчлөгдөх ба дөрвөн дугуй хөтлөх системийн товчийг L4 байрлалд шилжүүлсэн үеийн жолоодлогын тав тухыг хангана. (→Х.409)

■ Ослын тоормосны сигнал

Огцом тоормос хийсэн үед ослын дохионы гэрэл автоматаар анивчин асаж арын жолоочид анхааруулга өгнө.


■ Хоёр дахь мөргөлтийн тоормос

SRS аюулгүйн дэрний мэдрэгч мөргөлтийг мэдэрч систем ажиллах ба тоормос болон тоормосны гэрэл автомашины хурд бууруулах, хоёр дахь

мөргөлтөөс үүсэх нэмэлт хохирлыг бууруулах үүднээс автоматаар ажиллана.

■ Active TRC/VSC/Чиргүүлийн савлагааг хянах систем ажиллах үед (чирэх дэгээтэй автомашин)

TRC/VSC/Чиргүүлийн савлагааг хянах систем ажиллах үед шарвалтын индикатор анивчина.




■ Active TRC системийг салгах

Автомашин цас, шаварт суусан үед Active TRC систем дугуйнд дамжуулах хөдөлгүүрийн хүчийг бууруулах магадлалтай.

Автомашиныг чөлөөлөх үед  -г дарж салгаж автомашины зүтгэх хүчийг нэмэх шаардлагатай.

Active TRC системийг унтраах үед  товчийг хурдан дараад авна.



Мэдээллийн дэлгэц дээр "Traction Control Turned OFF" анхааруулга гарна.

Системийг асаах үед  товчийг дахин дарна.

■ Active TRC/VSC/Чиргүүлийн савлагааг хянах системийг (чирэх дэгээтэй автомашин) салгах

Active TRC/VSC/Чиргүүлийн савлагааг хянах системийг салгах үед

автомашин зогссон нөхцөлд  товчийг 3-с дээш секунд дарна.

VSC OFF индикатор асаж мэдээллийн дэлгэц дээр "Traction Control Turned OFF" анхааруулга гарна.*

Системийг асаах үед  товчийг дахин дарна.

*: PCS системтэй автомашинд PCS систем мөн салгагдана (зөвхөн мөргөлтийн өмнөх анхааруулга ажиллана). PCS анхааруулах гэрэл мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарна (→X.248)

■ товч дараагүй үед TRC систем салгагдсан тухай анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гарсан нөхцөлд

TRC систем түр салгагдсан үед анхааруулга гарна. Анхааруулга үргэлжлэн гарч байгаа үед Lexus дилертээ хандана уу.

■ Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын ажиллах нөхцөл

Дараах бүх нөхцөл бүрдсэн үед удирдлага ажиллана:

- Араа P эсвэл N (өгсүүр замд урагш/арагш хөдөлгөөн эхлэх үед)-с бусад арааны байрлалд байгаа үед.

- Автомашин зогссон.

- Хаазны дөрөө гишгээгүй байгаа.

- Зогсоолын тоормос залгагдаагүй.

- Асаах товч ON горимд байгаа.

■ Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын ажиллагаа автоматаар цуцлагдах

Дараах аль нэг нөхцөлд өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын ажиллагаа зогсоно:

- Арааны хөшүүргийг P эсвэл N-д шилжүүлсэн

- Хаазны дөрөө гишгэсэн

- Зогсоолын тоормос татагдсан

- Тоормосны дөрөө сулласнаас хойш 2 секундээс илүү хугацаа өнгөрөөгүй

- Хөдөлгүүр унтраастай

■ Цахилгаан жолооны хүчлүүрийн системийн ажиллагаа буурах

EPS системийн ажиллагаа жолооны хурдийг удаан хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулсан үед системийн халалтаас сэргийлж буурна. Энэ үед жолооны хурд хүнд мэдрэгдэх ба жолооны хурдийг идэвхтэй ашиглахаас татгалзах эсвэл аюулгүй газарт зогсоно. Системийн хэвийн ажиллагаа 10 минутын дараа сэргэнэ.

■ ABS, тоормосонд туслах систем, VSC, Чиргүүлийн савлагааг хянах систем, TRC болон өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын ажиллагаатай холбоотой дуу, чичиргээ

- Тоормосны дөрөө давтан гишгэсэн, хөдөлгүүр асаасан эсвэл хөдөлж эхэлсэн даруйд хөдөлгүүрийн хэсгээс дуу гарч болно. Эдгээр нь системүүдэд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.

- Дээрх системүүд ажиллах үед дараах байдал үүсэж болно. Эдгээр нь системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй.

- Автомашинны их бие болон жолооны хурднээс чичиргээ мэдрэгдэж болно
- Автомашин зогссоны дараа моторын дуу сонсогдож болно

- ABS идэвхэжсэний дараа тоормосны дөрөө чичирхийлж болно

- ABS идэвхэжсэний дараа тоормосны дөрөө доош бууж болно

■ TRC, Чиргүүлийн савлагаа хянах систем(чирэх дэгээтэй автомашин) ба VSC систем автоматаар идэвхжих

TRC, Чиргүүлийн савлагаа хянах систем ба VSC систем унтраасны дараа систем дараах нөхцөлд автоматаар идэвхэжнэ:

- Асаах товч унтраасан.

- Зөвхөн TRC систем унтраасан үед автомашины хурд нэмэгдэхэд TRC систем идэвхэжнэ. TRC болон VSC систем зэрэг унтраасан үед автомашины хурд

нэмэгдсэн ч систем идэвхжихгүй.

■ Ослын тоормосны сигналын ажиллах нөхцөл

Дараах нөхцөлүүдэд ослын тоормосны сигнал ажиллана:

- Ослын дохионы гэрэл унтарсан.
- Автомашины бодит хурд 55км/ц (35 миль/ц)-с дээш.
- Систем автомашины хурд хасалтын хэмжээнээс огцом тоормос хийж байгаа гэж тооцоолсон үед.

■ Ослын тоормосны сигнал автоматаар цуцлагдах нөхцөл

Дараах аль нэг нөхцөлд автоматаар цуцлагдана:

- Ослын дохионы гэрэл асаасан.
- Систем автомашины хурд хасалтыг огцом тоормос хийж байгаа биш тооцоолсон үед.

■ Хоёр дахь мөргөлтийн тоормос ажиллах нөхцөл

Автомашины хөдөлгөөний явцад мөргөлт үүссэнийг SRS аюулгүйн дэрний систем мэдрэх үед тус систем ажиллана. Нөгөөтээгүүр систем эд анги гэмтсэн үед ажиллахгүй.

■ Хоёр дахь мөргөлтийн тоормосны ажиллагаа автоматаар цуцлагдах

Дараах нөхцөлүүдэд системийн ажиллагаа автоматаар цуцлагдана.

- Хурд 0 км/ц (0 миль/ц) болсон.
- Систем ажиллах явцад тодорхой хэмжээний хугацаа өнгөрсөн.
- Хаазны дөрөөг хүчтэй гишгэсэн.



АЮУЛТАЙ

■ ABS үр дүнтэй ажиллахгүй нөхцөл

- Дугуйн барьцалдах чадвараас хэтэрсэн (цастай замд элэгдсэн дугуйтай зэрэг) үед.
- Нойтон, хальтиргаатай зам дээр өндөр хурдтай явах үед усан гулгаа үүссэн.

■ ABS ажиллах үеийн тоормосны зам энгийн үеэс уртсах

ABS нь тоормосны замыг богиносгоход зориулагдсан систем биш болно. Урд автомашинаас цаг ямагт ялангуяа дараах нөхцөлүүдэд аюулгүй зай барина:

- Шороон, хайрган эсвэл цасанд хучигдсан зам

- Дугуйн гинж ашиглаж байгаа үед

- Замын товгор хэсгээр явах үед

- Нүхтэй, тэгш бус замаар явах үед

■ TRC/VSC үр дүнтэй ажиллах боломжгүй нөхцөлүүд

Хальтиргаатай замаар явах үед TRC/VSC систем идэвхтэй үед ч автомашины жолоодлого, зүтгэх хүч хүрэхгүй байж болно.

Автомашин тэнцвэр болон хүч алдаж болзошгүй замын нөхцөлд автомашин жолоодож болохгүй.

■ Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага үр дүнтэй ажиллах боломжгүй нөхцөлүүд

- Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын ажиллагаанд хэт найдаж болохгүй. Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага хэт налуу зам, мөстсөн зам дээр үр дүнтэй ажиллахгүй байж болно.

- Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлага нь зогсоолын тоормос шиг автомашиныг удаан хугацаанд хөдөлгөөнгүй зогсоох систем биш болно. Осолд хүргэх тул налуу зам дээр автомашиныг зогсооход ашиглахыг хориглоно.

■ TRC/VSC/Чиргүүлийн савлагааг хянах систем идэвхэжсэн үед (чирэх дэгээтэй автомашин)

Шарвалтын индикатор анивчина. Хайнга жолоодлого нь осолд хүргэх аюултай тул цаг ямагт анхааралтай жолоодно. Индикатор анивчих үед илүү анхаарал хандуулна.

АЮУЛТАЙ

■ TRC/VSC/Чиргүүлийн савлагааг хянах систем унтарсан үед (чирэх дэгээтэй автомашин)

Тухайн замын нөхцөлд тохирох хурдаар анхаарал болгоомжтой жолоодно. Эдгээр нь автомашины тэнцвэр, жолоодлогыг сайжруулахад туслах систем тул зайлшгүй шаардлагатайгаас бусад үед унтрааж болохгүй.

Чиргүүлийн савлагааг хянах систем нь VSC системийн нэг бүрэлдэхүүн хэсэг ба VSC систем унтарсан үед ажиллахгүй эсвэл доголдоно.

■ Дугуй солих

Бүх дугуйны хэмжээ, үйлдвэрлэгч, хээ болон даац нь ижил байна. Мөн бүх дугуйны хийн даралтын хэмжээ тохиромжтой түвшинд байна. ABS, TRC, VSC болон чиргүүлийн савлагааг хянах системүүд нь автомашинд өөр өөр дугуй угсарсан үед зөв ажиллахгүй.

Дугуй болон обуд солих үед Lexus дилертээ хандаж дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

■ Дугуй, амортизаторын зөв ашиглалт

Асуудалтай дугуй, өөрчлөлт хийгдсэн амортизаторын системийн эд анги ашиглах нь жолоодлогод туслах системүүдийн ажиллагаанд нөлөөлөх улмаар эвдрэлд хүргэх аюултай.

■ Чиргүүлийн савлагаа хянах системийн анхааруулга (чирэх дэгээтэй автомашин)

Тус систем чиргүүлийн савлагаа үүссэн тохиолдол бүрд савлагааг бууруулах боломжгүй. Автомашин, чиргүүл, замын гадаргуу, жолоодлого хийж буй орчин зэрэг олон хүчин зүйлээс чиргүүлийн савлагааг хянах систем үр дүнтэй ажиллах боломжгүй байж болно. Чиргүүл хэрхэн зөв чирэх тухай мэдээллийг та чиргүүлийн ашиглалтын гарын авлагаас харна уу.

■ Чиргүүл савласан үед (чирэх дэгээтэй автомашин)

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

● Жолооны хурдийг шулуун чиглэлд хөдөлгөөнгүй чанга барина. Жолоог эргүүлж савлагааг зогсоох арга хэмжээ авч болохгүй.

● Чиргүүл савлаж эхлэвэл хурд хасах зорилгоор хаазны дөрөөг аажмаар суллана. Хурд нэмэхийг хориглоно. Тоормос гишгэхийг хориглоно.

Чиргүүл савласан үед жолооны хурд, тоормосыг зөвхөн шаардагдах хэмжээнд ашигласан тохиолдолд автомашин болон чиргүүлийн тэнцвэр даруй хэвийн болж эхэлнэ. (→X.197)

■ Хоёр дахь мөргөлтийн тоормос

Системийн ажиллагаанд хэт найдаж болохгүй. Систем хоёр дахь удаагийн мөргөлтөөс үүсэх хохирлыг бууруулах зориулалттай систем ба нөгөөтээгүүр янз бүрийн байдлаас хамаарч системийн ажиллагааны үр дүн өөр байж болно. Системд хэт найдах нь амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

АНХААР

■ E-KDSS системийн анхааруулга (тоноглогдсон загварт)

Дараах нөхцөлд системийн ажиллагаа доголдож бартаат зам дээрх жолоодлогын тав тух, туулах чадвар буурч болно. Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

● Замын эргэлттэй хэсгээр явах үед автомашины хазайлт хэвийн үеэс нэмэгдсэн мэдрэж төрөх.

**АНХААР**

- Налуу зам, энхэл донхолтой зам дээр автомашиныг удаан хугацаанд хазайлган орхисны дараа автомашиныг хөдөлгөх үед их бие буцаж тэгшрэхгүй байх (тэгш зам дээр гаргасан ч их бие хазайсан хэвээр байх).

Бартаат замын жолоодлого

Тус автомашин нь газраас тэнхлэг хүртэлх зай өндөртэй, дугуйн мөр богинотой буюу хүндийн төв нь өндөрт байрлах тул төрөл бүрийн бартаат зам дээр туулах чадвар сайтай ба автомашины utility vehicle төрөлд хамаарагддаг.

Off-road автомашины онцлог

- Автомашины загвар дизайн, онцлогоос хамаарч суудлын автомашинтай харьцуулахад хүндийн төв нь илүү өндөрт байрлах ба нөгөөтээгүүр энэ төрлийн автомашин унах, хөмрөх магадлал ихтэй байдаг. Бодит байдал дээр utility vehicles төрлийн автомашин нь бусад төрлийн автомашинтай харьцуулахад унасан, хөмөрсөн хувь хэмжээ илүү өндөр байдаг.
- Газраас тэнхлэг хүртэлх зай өндөр учир замын нөхцөл байдлыг илүү сайн харах, эрсдэлийг урьдчилж мэдэх боломжтойгоороо давуу талтай.
- Энэ төрлийн автомашин нь суудлын автомашин мөн бартаат замын зориулалттай спорт автомашинтай адил

хурдаар эргэлт хийхэд зориулагдаагүй болно. Тиймээс өндөр хурдтай огцом эргэлт хийх үед автомашин хөмрөх аюултай.

⚠ АЮУЛТАЙ

■ Off-road автомашины анхааруулга

Амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй ноцтой хохирол, автомашины эвдрэлийг боломжит бага хэмжээ хүртэл бууруулахын тулд дараах анхааруулгыг цаг ямагт дагаж мөрдөнө:

- Автомашин унасан, хөмөрсөн үед аюулгүйн бүс бүслээгүй хүний амь насанд эрсдэл учрах аюул бүсэлсэн хүнтэй харьцуулахад туйлын өндөр байдаг тул жолооч болон бүх зорчигч цаг ямагт аюулгүйн бүс зүүж ашиглана.
- Огцом эргэлт, огцом маневр хийхээс аль болох зайлсхийнэ. Автомашины жолоодлогыг буруу хийсэн тохиолдолд жолоодлогоо алдах эсвэл автомашин унах, хөмрөхөд хүрэх ба улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.
- Дээврийн ачаа дээр тээш ачих нь автомашины хүндийн төвийг илүү өндөр болгох тул өндөр хурд, огцом хөдөлгөөн эхлэх, огцом эргэлт хийх, огцом, тоормослох болон огцом маневр зэргээс зайлсхийнэ. Жолоодлогоо алдах эсвэл автомашин унах, хөмрөхөд хүргэх ба улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

- Хүчтэй хөндлөн салхитай үед цаг ямагт хурдаа хасна. Автомашины хэлбэр болон хүндийн төв өндөр байдгаас хамаарч хөндлөн салхинд суудлын автомашинаас илүү мэдрэмтгий байдаг ба хурд хасах нь автомашины удирдлагыг сайжруулна.
- Хэт налуу зам дээр хөндлөн явахыг хориглох ба эгц дээш эсвэл доош явах нь зүйтэй. Автомашин (мөн бусад ижил төстэй бартаат замын автомашин) урагш болон арагш талаасаа илүү хажуу тал руугаа хялбар унах магадлалтай байдаг.

Off-road буюу бартаат замын жолоодлого

Бартаат замаар явах үед жолоодлогоос авах таатай мэдрэмжийг бүрдүүлэх мөн автомашины хөдөлгөөний тасралтгүй байдлыг хангах үүднээс дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:

- Зөвхөн Off-road автомашин явах боломжтой газраар явна.
- Бусдын хувийн өмч, эзэмшлийг хүндэлнэ. Бусдын өмч, эзэмшил газар нэвтрэхийн өмнө тухайн хүний зөвшөөрөл авна.
- Автомашин нэвтрэхийг хориглосон газар луу нэвтрэхийг хориглоно. Хөдөлгөөн хориглосон хаалт, хаалга, замын тэмдгийн заалтыг баримтална.
- Хатуу гадаргуутай замаас гарч болохгүй. Зам норсон эсвэл ус тогтсон үед жолоодлогын арга техникээ өөрчлөх мөн замын

гадаргууг гэмтээхээс сэргийлж хөдөлгөөнөө зогсооно.

⚠ АЮУЛТАЙ

■ Off-road буюу бартаат замын жолоодлогын анхааруулга

Амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй ноцтой хохирол, автомашины гэмтлийг боломжит бага хэмжээнд бууруулах үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө:

- Бартаат зам дээр анхааралтай жолоодно. Аюултай газраар явахгүй байх зэргээр шаардлагагүй эрсдэлд орохоос зайлсхийнэ.
- Бартаат замын жолоодлогын үед жолооны хүрдний дотор талаас барихыг хориглоно. Замын энхэл донхолд дугуй цохигдох үед жолооны хүрд хүчтэй эргэж гар гэмтээх аюултай тул 2 гар, ялангуяа эрхий хуруугаа хүрдний гадна талд байрлуулна.
- Элс, шавар, ус болон цастай замаар явсны дараа тухай бүр тоормосны ажиллагааг шалгана.
- Өндөр өвс, шавар, чулуу, элстэй замаар явсан, гол туулсны дараа автомашины доод талд өвс, бут сөөг, цаас, даавуу, чулуу болон элс зэрэг наалдаагүй эсэхийг нягтлах ба эдгээр зүйлс наалдсан, тогтсон үед цэвэрлэнэ. Наалдсан хэвээр жолоодлого хийх нь эвдрэл гэмтэл үүсэх, гал түймэр гаргах аюултай.
- Бартаат зам, шороон зам дээр хэт өндөр хурд авах, харайлгах, огцом эргэлт хийх, аливаа зүйл мөргөх зэргээс зайлсхийнэ. Энэ нь жолоодлого алдах, автомашин унах, хөмрөхөд хүргэх, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай. Мөн амортизатор, араам, их биед өндөр үнийн дүн бүхий гэмтэл учруулах магадлалтай.

**АНХААР****■ Уснаас үүдэх гэмтлээс сэргийлэх**

Хөдөлгүүр болон бусад хэсгүүдэд ус гэмтэл учруулахаас сэргийлж зохих бүх арга хэмжээг авна.

● Хөдөлгүүрийн агаар сорох хоолойд нэвтэрсэн ус хөдөлгүүрт ноцтой гэмтэл учруулна.

● Автомат хурдны хайрцагт ус орсон тохиолдолд араа шилжилт муудах, хурдны хайрцагт чичиргээ үүсэж түгжигдэх болон бусад ноцтой гэмтэл учруулна.

● Ус нь дугуйн холхивчийг тосолгоогүй болгох, зэврэлт үүсгэх, эдэлгээг богиносгох аюултай ба мөн дифференциал, хурдны хайрцаг, туслах хурдны хайрцагт нэвтрэх магадлалтай ба хүч дамжуулах ангийн тосны чанарт сөргөөр нөлөөлнө.

■ Ус туулсны дараа

Жижиг гол гатлах зэргээр ус туулах үед эхлээд усны гүн болон голын ёроол хэр хатуу болохыг шалгана. Гүнзгий уснаас зайлсхийж бага хурдаар жолоодно.

■ Бартаат замаар явсны дараах үзлэг

● Тоормосны наклад, планзны завсар тогтсон элс, шавар нь тоормосны хүчийг бууруулах, механизмыг гэмтээх аюултай.

**АНХААР**

● Шороон зам, элс, шавар, ус зэрэг бартаат замаар явсан өдөр тутам засвар үйлчилгээний үзлэг хийх шаардлагатай. Хуваарьт засвар үйлчилгээний дэлгэрэнгүйг (→Х.485)-с харна уу.

Өвлийн жолоодлого

Автомашиныг өвлийн улиралд жолоодохын өмнө шаардлагатай бэлтгэл, үзлэгийг хийнэ. Цаг агаарын байдалд тохируулан жолоодлого хийнэ.

Өвлийн бэлтгэл

- Гадна агаарын хэмд тохирсон тос тосолгооны материал, шингэн ашиглана.
- Хөдөлгүүрийн тос
- Хөргөлтийн шингэн
- Шил арчигчийн шингэн
- Засвар үйлчилгээний ажилтнаар аккумулятораа шалгуулна.
- Өвлийн 4 дугуй ашиглах эсвэл урд дугуйнд гинж угсарч ашиглана*.

Бүх дугуй ижил хэмжээтэй, нэг үйлдвэрийн байх ба дугуйн гинж нь тухайн дугуйн хэмжээнд тохирсон байна.

*: 265/70R18, 265/50R22 дугуйнд гинж угсарч болохгүй.

**АЮУЛТАЙ****■ Өвлийн дугуй ашиглах**

Осол үүсэх эрсдэлийг бууруулах үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд автомашины жолоодлого алдагдах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

● Зөвхөн үйлдвэрлэгчийн заасан хэмжээтэй дугуй ашиглана.

**АЮУЛТАЙ**

- Дугуйн хийн даралтыг үйлдвэрлэгчийн заасан хэмжээнд тохируулна.
- Хурдны дээд хязгаар эсвэл тухайн ашиглаж буй өвлийн дугуйны хурдны хязгаарлалтаас хэтрүүлэхийг хориглоно.
- Бүх дугуйг өвлийн дугуйгаар солино.

■ Дугуйн гинж угсарсан автомашин жолоодох (265/55R20 дугуй)

Осол үүсэх эрсдэлийг бууруулах үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд автомашины аюулгүй жолоодлого алдагдах улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирна.

- 50 км/ц (30 миль/ц) хүртэлх хурдаар жолоодно. Замын хурдны дээд хязгаар тус хурднаас бага байвал тухайн хурдны дээд хязгаарыг баримтална.
- Энхэл донхолтой, нүхтэй замаар явахаас зайлсхийнэ.
- Огцом хурд нэмэх, жолоо эргүүлэх, хөдөлгүүрийн тоормос үүсгэх араа хүндрүүлэхээс зайлсхийнэ.
- Замын эргэлт дээр урьдчилж хурд хасаж тэнцвэрээ хадгална.
- LTA систем ашиглаж болохгүй.
- LDA систем ашиглаж болохгүй.

**АНХААР****■ Өвлийн дугуй засах, солих**

Өвлийн дугуй задлах, угсрах нь дугуйн хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөх тул Lexus дилер эсвэл бусад албан ёсны дугуй засварын төв дээр өвлийн дугуй засуулах буюу солиулна.

Автомашин жолоодохын өмнө

Жолоодлогын нөхцөлд тохируулан дараах үйлдлийг хийнэ:

- Хөлдсөн цонх, шил арчигчийг хүчээр нээж ажиллуулж болохгүй. Хөлдсөн хэсэгт халуун ус асгаж тогтсон мөсийг хайлуулах ба дахин хөлдөхөөс сэргийлж даруй арчина.
- Автомашины агааржуулалтын системийн сэнсний хэвийн ажиллагааг хангах үүднээс салхины шилний урд талын агаар сорох хоолойд тогтсон цасыг цэвэрлэнэ.
- Гадна гэрэл, дээвэр, араам, дугуй болон тоормосны механизм дээр цас тогтсон эсэхийг шалгаж цэвэрлэнэ.
- Гутлын уланд наалдсан шавар, цас зэргийг унагасны дараа автомашинд сууна.

Автомашин жолоодох үед

Автомашины хурдыг аажмаар нэмэх ба урд талын автомашинаас хангалттай

зайтайгаар мөн тухайн замын нөхцөлд тохирсон хурдаар жолоодно.

Зогсоолд байрлуулах үед

- Зогсоолын тоормосны автомат горимыг унтраана. Эсрэг тохиолдолд зогсоолын тоормос хөлдөж автоматаар салгагдахгүй байж болно.

Автомат горимыг унтраасан ч зогсоолын тоормос автоматаар ажиллаж болзошгүй тул дараах функцийг ашиглахаас зайлсхийнэ.

- Тоормос баригч систем
- Автомашиныг зогсоолд байрлуулна. Зогсоолын тоормос хөлдөх улмаар автомашиныг дахин асаах үед тоормос салахгүй байх аюултай тул зогсоолын тоормосыг татаж болохгүй. Автомашин өнхрөхөөс сэргийлж дугуйн ивүүр ашиглана. Дугуйн ивүүр ашиглаагүй тохиолдолд автомашин өнхөрч осол аваар үүсгэх аюултай.
- Зогсоолын тоормос автомат горимд байгаа үед арааг Р-д шилжүүлээд зогсоолын тоормосыг салгана. (→Х.208) Зогсоолын тоормос залгаатай үед автомашиныг унтраана.
- Тоормос залгалгүйгээр зогсоолд байрлуулсан үед арааны хөшүүрэг Р-с шилжин хөдлөхгүй эсэхийг нягтална.
- Өвөл гадаа хүйтэнд тоормосыг


залгасан хэвээр байрлуулах үед тоормос хөлдөж болзошгүй.

Дугуйн гинж сонгох

- 265/55R20 дугуйтай автомашин

Тохирсон хэмжээтэй цасны гинж сонгоно.

Дугуйн хэмжээнээс хамаарч гинж өөр өөр хэмжээтэй байдаг.



Хажуугийн гинж :

- A** 5мм (0.20 инч) диаметртэй
- B** 18мм (0.71инч) өргөнтэй
- C** 46мм (1.81инч) урттай

Хөндлөн гинж:

- D** 6.3мм (0.25 инч) диаметртэй
- E** 22.6мм (0.89 инч) өргөнтэй
- F** 38.1мм (1.50 инч) урттай

- 265/55R20 дугуйгүй автомашин

Гинж угсарч болохгүй.

Өвлийн дугуй ашиглана.

Дугуйн гинж ашиглалттай холбоотой дүрэм журам

Гинж ашиглалттай холбоотой дүрэм журам нь тухайн бүс нутгийн онцлог, замын нөхцөлөөс хамаарч өөр өөр байна. Гинж угсрахын өмнө бүс нутгийн дүрэм журмыг урьдчилж шалгана.

■ Дугуйн гинж угсрах (265/55R20 дугуйтай автомашин)

Дугуйн гинж угсрах, салгах үед дараах анхааруулгыг мөрдөнө:

- Дугуйн гинжийг аюулгүй газар угсрах буюу салгана.
- Дугуйн гинжийг зөвхөн хойд дугуйнд угсрах ба урд дугуйнд угсарч болохгүй.
- Гинжийг хойд дугуйнд аль болох чанга угсрах ба 0.5-1.0 км (1/4-1/2 миль) яваад дахин чангална.
- Дугуйн гинжний гарын авлагад заасны дагуу угсарна.



АНХААР

■ Дугуйн гинж угсрах (265/55R20 дугуйтай автомашин)

Дугуйн гинж угсарсан үед дугуйн хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийн хэвийн ажиллагаа алдагдаж болно.

- 5-1. Lexus агааржуулалтын
автомат горим
Lexus агааржуулалтын
автомат горим434
- 5-2. Агааржуулалтын систем ба
цан арилгагч
Урд автомат
агааржуулалтын систем
.....435
Арын автомат
агааржуулалтын систем
.....443
Жолооны хүрд
халаагч/суудал
халаагч/суудлын
агааржуулагч446
- 5-3. Салоны гэрэл ашиглах
Салоны гэрлийн жагсаалт
.....448
- 5-4. Хайрцаг тавиур зэргийг
ашиглах
Хайрцаг тавиурын жагсаалт
.....452
Тээшний хэсэг
.....456
- 5-5. Салоны бусад хэрэгсэл
ашиглах
Цайрдаг шилтэй панорамик
дээврийн нээлхий
.....459
Салоны бусад хэрэгслүүд461

Lexus агааржуулалтын автомат горим

Lexus агааржуулалтын автомат горим нь агааржуулалтын системийн хэмийн тохиргоо, гадна болон салоны агаарын хэмтэй уялдан автоматаар ажиллана. Тус функц систем тус бүрийг тохируулах шаардлагагүйгээр тав тухыг хангана.

Агааржуулалтын автомат горим асаах

Lexus агааржуулалтын автомат горим нь агааржуулалтын системийн “AUTO” горимтой хамт ажиллана.

- 1 Option дэлгэцийн товч сонгоно. (→X.435)
- 2 “Climate concierge” товчийг сонгоно.
- 3 “AUTO” товчийг асаана.

Автоматаар ажиллах функцүүд

- Автомат агааржуулалтын систем (→X.435, 443)

Жолооч, урд зорчигчийн суудал, арын суудал халаагчийн (тоноглогдсон загварт) температурын тохиргооны дагуу агааржуулалтын систем автоматаар ажиллана.

- Суудал халаагч (→X.446)

Жолооч, урд зорчигчийн суудлын

температурын тохиргооны дагуу суудал халаагч автоматаар ажиллана.

Суудал халаагч, суудлын агааржуулагчийн тохиргоо нь агааржуулалтын системийн тохиргоо, гадна агаарын хэм зэрэгт нийцүүлэн автоматаар сонгогдоно.

- Суудлын агааржуулагч (→X.447)

Жолооч, урд зорчигчийн суудлын температурын тохиргооны дагуу суудлын агааржуулагч автоматаар ажиллана.

Суудал халаагч, суудлын агааржуулагчийн тохиргоо нь агааржуулалтын системийн тохиргоо, гадна агаарын хэм зэрэгт нийцүүлэн автоматаар сонгогдоно.

- Жолооны хүрд халаагч* (→X.446)

Гадна агаарын хэм болон агааржуулалтын системийн температурын тохиргоонд нийцүүлэн жолооны хүрд халаагч автоматаар ажиллана.

* : Тоноглогдсон загварт

Зорчигч мэдрэх функц

- Урд зорчигчийн суудалд зорчигч мэдрэгдсэн үед суудал халаагч, суудлын агааржуулагч автоматаар ажиллана.
- Суудал халаагч, суудлын агааржуулагчийн товчийг AUTO горимд тохируулсан үед тус функц ажиллахгүй.

Арын суудал халаагчийн ажиллагаа (Арын суудал халаагчтай автомашин)


Арын суудал халаагч Lexus агааржуулалтын автомат горимоор удирдагдахгүй.

Урд автомат агааржуулалтын систем

“AUTO” товч асаасан үед температурын тохиргооноос хамаарч агааржуулагчийн байрлал, сэнсний хурд автоматаар тохируулагдана.

Баруун жолооны хүрдтэй автомашинд товчны байрлал болон хэлбэр өөр байна. Мөн системээс хамаарч дэлгэц болон товчны байрлал өөр байна.

Option дэлгэцийн товч



5

Салоны функц, тоноглолууд

A Зүүн талын температур удирдлагын товч

B Үлээх чиглэл тохируулах товч

C Option дэлгэцийн товч

D Товчлол дэлгэцийн товч

Олон төрлийн функцийн товчлол (shortcut) тэмдэг гаргана.

E Урд/хойд удирдлагын дэлгэцийн товч (тоноглогдсон загварт)

F “SYNC” товч

G Баруун талын температур удирдлагын товч

H “A/C” товч

I Гадна агаар/дотор агаарын горимд солих товч

J Сэнсний хурд тохируулах товч

K “OFF” товч

L “AUTO” товч

■ Температур тохируулах

Температур тохиргооны хүрдийг цагийн зүүний дагуу эргүүлж

температур нэмэх ба эсрэг эргүүлж хасна.

“SYNC” товчны индикатор

асаалттай үед урд зорчигчийн болон арын суудлын температурын тохиргоо жолоочийн суудлын тохиргоог дагана.

“SYNC” товчны индикатор асаагүй үед “SYNC” товч дарахад “SYNC” товчны индикатор асаж урд зорчигчийн болон арын суудлын температурын тохиргоо жолоочийн суудлын тохиргоотой ижил болно.

Урд зорчигчийн суудлын талын температурын тохиргооны товч дарсан үед “SYNC” товчны индикатор унтрах ба тус суудлын температурын тохиргоог тусад нь хийх боломжтой болно.

Арын суудлын температурын тохиргооны товч дарсан нөхцөлд “SYNC” товчны индикатор унтрах ба арын суудлын температурын тохиргоог тусад нь хийх боломжтой болно.

“A/C” индикатор асаагүй үед систем орчны хэмээр эсвэл халуун агаараар үлээнэ.

Урд зорчигчийн суудлын ба арын суудлын температурын тохиргооны товч дарсан үед жолооч, урд зорчигчийн суудал, арын суудлын температурын тохиргоог тус тусад нь хийнэ.

■ Сэнсний хурд тохируулах

Сэнсний хурд тохируулах товчны “+”-г дарах мөн сэнсний хурд тохируулах товчны тэмдгийг баруун тийш шилжүүлэн хурдыг нэмнэ. Сэнсний хурд тохируулах товчны “-”-г дарах мөн сэнсний хурд тохируулах товчны тэмдгийг зүүн тийш шилжүүлэн хурдыг хасна.

“OFF” товч дарж сэнсийг унтраана.

Сэнсний хурд тохируулах товчны “-”-г удаан дарах эсвэл сэнсний хурд тохируулах товчны тэмдгийг зүүн тийш шилжүүлэн удаан барьж сэнсийг унтраах боломжтой.

■ Агаар үлээх чиглэл солих

Үлээх чиглэл тохируулах товч сонгоно.

Товч дарах бүрд үлээх чиглэлийн горим дараах байдлаар өөрчлөгдөнө.

Тухайн сонгосон горимоос хамаарч үлээх агааржуулалтын хоолой, сэнсний хурд өөрчлөгдөнө.



: Агаарын урсгалыг цээж рүү чиглүүлнэ



: Агаарын урсгалыг цээж ба хөл рүү чиглүүлнэ



: Агаарын урсгалыг хөл рүү чиглүүлнэ



: Хөл рүү үлээх ба салхины шилний цан арилгагч

ажиллана.

■ Гадна агаар болон дотор агаарын горимд солих

Хонгил, хөдөлгөөний ачаалал ихтэй зам зэрэг дээр бүхээгт тоос орохоос сэргийлэх мөн гадна

агаарын хэм өндөр үед бүхээгийг хөргөх зорилгоор дотор агаарын горимд түр хугацаанд шилжүүлэх нь тохиромжтой.

Гадна агаар/дотор агаарын горимд солих товч сонгоно.

Товч дарах бүрд гадна агаар болон дотор агаарын горимд солигдоно. Дотор агаарын горим сонгогдсон үед индикатор асна.

Агааржуулалтын системийн хэмийн тохиргоо, бүхээгийн хэм гадна агаар (автомашин утаа) зэргээс хамаарч гадна болон дотор агаарын горим автоматаар солигдож болно.

■ Гадна агаарын хэм 24°C (75°F)-с өндөр ба агааржуулалтын систем асаалттай үед

- Агааржуулалтын системийн цахилгаан зарцуулалтыг багасгах үүднээс агааржуулалтын систем автоматаар дотор агаарын горимд шилжиж болно. Энэ нь шатахуун зарцуулалтыг мөн бууруулна.
- Асаах товчийг ON горимд шилжүүлэх үед дотор агаарын горим үндсэн горимоор сонгогдоно.
- Гадна агаар/дотор агаарын горим солих товч даран гадна агаарын горимд шилжүүлэх боломжтой.

■ Эко агааржуулалтын горим

Тус горимд агааржуулалтын систем нь сэнсний хурдыг бууруулан шатахуун зарцуулалтыг сайжруулдаг.

1 Option дэлгэцийн товч сонгоно. (→X.435)

2 “Eco Heat/Cool” товч сонгоно.

- Эко горимд агааржуулалтын систем шатахуун зарцуулалтыг бууруулах байдлаар ажилладаг.
- Хөдөлгүүрийн хурд болон компрессорын ажиллагааг удирдан хөргөх, халуунаар үлээх хэмжээг бууруулдаг
- Автомат горим сонгогдсон үед сэнсний хурд хязгаарлагддаг
- Жолоодлогын горимыг эко горимд

шилжүүлсэн үед эко агааржуулалтын горим автоматаар асна. Энэ үед “Eco Heat/Cool” товч сонгон эко агааржуулалтын горим унтраах боломжтой.

■ Бүхээгийг хурдан халаах (Max heat)

“MAX heat”-г асаасан үед бүхээгийг хурдан халаах үүднээс агааржуулалтын системийн тохиргоо шууд өөрчлөгдөнө.

1 Товчлол дэлгэцийн товч сонгоно. (→X.435)

2 “MAX heat” товч сонгоно.

- Жолоочийн суудлын агааржуулалтын системийн хэм “Hi” тохиргоонд шилжих ба “AUTO” товч асна.
- Жолоочийн суудал халаагч Hi тохиргоонд шилжинэ.
- Жолооны хурд халаагч Hi тохиргоонд шилжинэ.
- Дараах нөхцөлүүдэд урд зорчигчийн суудлын суудал халаагч/суудлын агааржуулагч “AUTO” горимд шилжинэ.
- “Climate concierge” асаалттай үед
- Урд зорчигчийн суудалд зорчигч суусан гэж систем тооцсон үед
- “SYNC” товчны индикатор ассан үед урд зорчигчийн болон арын суудлын температурын тохиргоо мөн “Hi” болно.

■ Бүхээгийг хурдан хөргөх (Max cool)

“MAX cool”-г асаасан үед бүхээгийг хурдан хөргөх үүднээс агааржуулалтын системийн тохиргоо шууд өөрчлөгдөнө.

1 Товчлол дэлгэцийн товч сонгоно. (→X.435)

2 “MAX cool” товч сонгоно.

- Жолоочийн суудлын агааржуулалтын системийн

хэм “Lo” тохиргоонд шилжих ба “AUTO” товч асна.

- Жолоочийн суудлын агааржуулагч Hi тохиргоонд шилжинэ. (Суудлын агааржуулагчтай)
- Дараах нөхцөлүүдэд жолооны хурд халаагч “AUTO” горимд шилжинэ (Жолооны хурд халаагчтай автомашин).
- “Climate concierge” асаалттай үед
- Дараах нөхцөлүүдэд урд зорчигчийн суудлын суудал халаагч/суудлын агааржуулагч “AUTO” горимд шилжинэ.
- “Climate concierge” асаалттай үед
- Урд зорчигчийн суудалд зорчигч суусан гэж систем тооцсон үед
- “SYNC” товчны индикатор ассан үед урд зорчигчийн болон арын суудлын температурын тохиргоо мөн “Lo” болно.

■ nanoe™ X систем*1, 2

(тоноглогдсон загварт)

Агааржуулалтын систем нь nanoe™ үүсгэгч технологитой. Тус систем нь жолоочийн суудлын цонхон талын агааржуулагчийн хоолойноос усан тоосонцроор бүрхэгдсэн үл ялиг хүчиллэг nanoe™ ялгаруулж бүхээгт цэвэр агаар оруулдаг*3.

- 1 Option дэлгэцийн товч сонгоно. (→X.435)
- 2 “nanoe™X” товч сонгоно.
- “nanoe™X”-г идэвхжүүлсэн үед

сэнс асаахад nanoe™ X систем асна.

- Дараах нөхцөлүүд бүрдсэн үед систем дээд хүчин чадлаар ажиллана.
- Цээж рүү, цээж ба хөл рүү үлээх чиглэл сонгогдсон.
- Жолоочийн талын цонхны агааржуулагчийн хоолой нээлттэй
- nanoe™ X ялгарч байгаа үед озоны хий бага хэмжээгээр ялгарч болох ба зарим үед сулхан үнэртэж болно. Энэ нь ойн агаарт агуулагдах хэмжээний буюу байгальд байх хэвийн хэмжээ бөгөөд хүний биед аливаа нөлөө үзүүлэхгүй.
- Систем ажиллах үед бага хэмжээний дуу гарч болно. Энэ доголдлыг илэрхийлэхгүй. Систем ажиллаж эхэлсэн даруйд сонсогдох хэмжээний дуу гарч болно. Энэ нь доголдол биш болно.

*1: nanoe™ ба nanoe™ тэмдэг нь Панасоник корпорацад бүртгэлтэй барааны тэмдэгт болно.

*2: nanoe™ X нь эрүүл мэндэд тустай гидроксил радикал агуулсан нано хэмжээтэй электростатик атомжуулсан усны тоосонцор юм.


*3: Температур, чийгшилтээс хамаарч сэнсний хурд, агаарын хэмжээ, nanoe™ X систем бүрэн хүчин чадлаар ажиллахгүй байж болно.

■ Салхины шилний цан арилгах

Цан арилгагчаар салхины шил, урд хажуу шилний цан арилгана.

Салхины шилний цан

арилгагчийн товч дарна.



Чийгшил бууруулах функц ажиллаж агаарын урсгал нэмэгдэнэ.

Дотор агаарын горим сонгогдсон үед гадна/дотор агаарын горимоор гадна агаарын горимд сонгоно. (автоматаар сонгогдож болно.)


Салхины шил, урд хажуу шилний цанг хурдан арилгах үед сэнсний хурд болон температурыг нэмнэ.

Өмнөх горимд буцах үед цан арилсны дараа салхины шилний цан арилгах товчийг дахин дарна.

■ Хойд цонх ба хажуу толины цан арилгах

Цан арилгагч ашиглан хойд цонхны цан арилгах, хажуу толинд тогтсон усны дусал, мөс зэргийг цэвэрлэх боломжтой.

Хойд цонх ба хажуу толины цан арилгагчийн товч дарна.



Хойд цонх ба хажуу толины цан арилгагч ажиллаж цан арилгана.

Цан арилгагч тодорхой хугацааны дараа автоматаар унтарна.

■ Салхины шилний мөс арилгагч (тоноглогдсон загварт)/ Салхины шилний цан арилгагч (тоноглогдсон загварт)

Салхины шилний мөс арилгагч ашиглан шил арчигч салхины шилтэй наалдан хөлдөхөөс сэргийлэх боломжтой.

► Салхины шилний мөс арилгагчтай загвар

1 Option дэлгэцийн товч сонгоно. (→X.435)

2 “Deicer” товч сонгоно.

Салхины шилний мөс арилгагч тодорхой хугацааны дараа автоматаар унтарна.

► Салхины шилний цан арилгагчтай автомашин

1 Option дэлгэцийн товч сонгоно. (→X.435)

2 “Deicer” товч сонгоно.

Салхины шилний цан арилгагч тодорхой хугацааны дараа автоматаар унтарна.

Гадна агаарын хэм 5°C (41°F)-с их үед салхины шилний цан арилгагч ажиллахгүй.

■ Тоостой замаар явах үед

Бүх цонхыг хаана. Цонх хаасны дараа бүхээгт орсон тоос үлдэх үед гадна агаарын горим сонгож сэнсний хурдыг унтраах горимоос бусад горимд тохируулна.

■ Гадна агаарын хэм хүйтэн үед

“A/C” товч дарсан ч чийгшил

бууруулах функц ажиллахгүй байж болно.

■ Агааржуулагч, эйр кондишны үнэр

● Цэвэр агаар оруулах үед гадна агаарын горимд шилжүүлнэ.

● Агааржуулагч ажиллах үед автомашины гадна болон дотор талаас олон төрлийн үнэр агааржуулагчийн системд орох, хуримтлагдаж болно. Үүнээс шалтгаалж агааржуулагчаас үнэр мэдрэгдэж болно.

● Үнэр үүсэхээс сэргийлж агааржуулалтын систем ажиллаж эхлэх үед хөл рүү үлээх горимоор ажиллах эсвэл агааржуулалтын систем автомат горимоор ажиллаж эхлэх үед хэсэг хугацаанд үлээхгүй байж болно.

● Автомашиныг зогсоолд байрлуулах үед агаарын солилцоог сайжруулах, автомашин асаах үед үнэр үүсэхээс сэргийлж гадна агаарын горимд шилжинэ.

■ “MAX heat”

● “MAX heat” товч ашиглан агааржуулалтын системийг унтраах боломжгүй.

● “MAX heat” товч дарсны дараа агааржуулалтын системийн температур тохируулах товчоор тохируулах боломжтой.

● “Climate concierge” асаалттай үед “AUTO” товч асаасан нөхцөлд температурын тохиргоонд нийцүүлэн урд суудлын суудал халаагч ба суудлын агааржуулагч болон жолооны хүрд халаагч автоматаар ажиллана.

● Функц тус бүрийг өөрийн хүссэнээр тохируулах боломжтой.

■ “MAX cool”

● “MAX cool” товч ашиглан агааржуулалтын системийг унтраах боломжгүй.

● “MAX cool” товч дарсны дараа агааржуулалтын системийн температур тохируулах товчоор тохируулах боломжтой.

● “Climate concierge” асаалттай үед “AUTO” товч асаасан нөхцөлд температурын тохиргоонд

нийцүүлэн урд суудлын суудал халаагч ба суудлын агааржуулагч болон жолооны хүрд халаагч автоматаар ажиллана.

● Функц тус бүрийг өөрийн хүссэнээр тохируулах боломжтой.

■ Цонх цантах

Бүхээгийн агаарын чийгшилт өндөр үед цонх амархан цантана. “A/C” товч дарахад агааржуулалтын хоолойноос үлээх агаарын чийгшил бууруулах ба салхины шилний цанг үр дүнтэй арилгана.

● “A/C” товч унтраасан тохиолдолд цонх илүү хурдан цантаж болно.

● Дотор агаарын горим сонгогдсон үед цонх цантаж болно.

■ Дуугаар удирдах систем ашиглах

Агааржуулалтын системийг дуугаар удирдах боломжтой. Дэлгэрэнгүйг “Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага”-с харна уу.

■ Хөргүүртэй хайрцаг асаалттай үед (тоноглогдсон загварт)

Агааржуулалтын системийг унтраах боломжгүй.

■ Салоны агаар шүүгч

→X.518

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Автомат горимтой (“AUTO” товч асаалттай үед) холбоотой функцүүдийг голын дэлгэцийн “Vehicle customise”-р өөрчлөх боломжтой. Хаягдал утааны мэдрэгчийн мэдрэх түвшнийг мөн өөрчлөх боломжтой. (→X.583)



АЮУЛТАЙ


■ nanoe™ X үүсгүүр (тоноглогдсон загварт)

Өндөр хүчдэлтэй эд ангитай тул үүсгэгчийг задалж засаж болохгүй. Засвар шаардлагатай үед Lexus дилерт хандана уу.

■ Салхины шилний цан арилгагч буруу ажиллахаас сэргийлэх

- Хэт чийгшилттэй газар агааржуулалтын системийн температурыг хүйтэн хэмд тохируулсан үедээ шил арчигчийн цан арилгагч ашиглаж болохгүй. Гадна болон дотор талын температурын зөрүүнээс салхины шилний гадна тал цантаж үзэгдэх орчныг хязгаарлана.

- Агааржуулалтын хоолойг халхлах эд зүйлсийг хянах самбар дээр тавьж болохгүй. Агаарын урсгал халхлагдаж цан арилгагчийн хэвийн ажиллагаа алдагдаж болно.



■ Хажуугийн толины цан арилгагч ажиллах үед

Хойд цонх ба хажуу толины цан арилгагч ажиллах үед толины гадаргуу хэт халж болох ба түлэх аюултай тул хүрч болохгүй.

■ Түлэгдэхээс сэргийлэх

- Салхины шилний мөс арилгагчтай загвар: Мөс арилгагч ажиллах үед салхины шилний доод тал, хажуу багана талын шилэнд хүрч болохгүй.
- Салхины шилний цан арилгагчтай загвар: Цан арилгагч ажиллах үед гадаргуу хэт халах тул салхины шилэнд (ялангуяа доод тал) хүрч болохгүй.



АНХААР

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед шаардлагагүй тохиолдолд агааржуулалтын системийг унтраана.

■ Агааржуулалтын системийн доголдлоос сэргийлэх

Үлээх хоолойнд эд зүйл унагаж болохгүй.

Доголдол үүсгэх аюултай.


■ nanoTM Х-н эвдрэлээс сэргийлэх (тоноглогдсон загварт)

Жолооч талын үлээх хоолой руу аливаа эд зүйл хийх, суурилуулах, шүршигч цацаж болохгүй. Ион үүсгэгчийн хэвийн ажиллагаа алдагдана.

Агааржуулалтын хоолойн байрлал ба ажиллагаа

■ Байрлал


Тухайн сонгосон горимоос хамаарч үлээх чиглэл, сэнсний хурд өөрчлөгдөнө.



←: Тоноглогдсон загварт


■ Агааржуулалтын хоолойн байрлал тохируулах, нээх ба хаах

► Урд хажуу




- 1 Агаарын урсгалыг баруун зүүн, дээш доош чиглүүлэх
- 2 Хүрдийг эргүүлж хоолойг нээж хаах

► Урд гол



- 1 Агаарын урсгалыг баруун зүүн, дээш доош чиглүүлэх
- 2 Хүрдийг эргүүлж хоолойг нээж хаах

► Хойд (тоноглогдсон загварт)



- 1 Агаарын урсгалыг баруун зүүн, дээш доош чиглүүлэх
- 2 Хүрдийг эргүүлж хоолойг нээж хаах


Арын автомат агааржуулалтын систем*

*: Тоноглогдсон загварт

Голын дэлгэц болон арын агааржуулалтын системийн удирдлагын самбарын урд/хойд удирдлагын дэлгэцийн товчоор арын агааржуулалтын системийг удирдах боломжтой.

“AUTO” товчийг асаасан үед температурын тохиргоонд нийцүүлэн үлээх горим сэнсний хурд автоматаар тохируулагдана.

Арын агааржуулалтын системийн удирдлага (голын дэлгэц)



Тус зурагт зүүн жолооны хүрдтэй автомашиныг харуулав. Баруун жолооны хүрдтэй загварт товчны байрлал, хэлбэр өөр байна.

- A** Температур тохируулах товч
- B** Үлээх чиглэл тохируулах товч
- C** Урд/хойд удирдлагын дэлгэцийн товч
- D** “REAR OFF” товч
- E** Сэнсний хурд тохируулах товч
- F** “REAR AUTO” товч

■ Температур тохируулах

Температур тохиргооны хүрдийг цагийн зүүний дагуу эргүүлж температур нэмэх ба эсрэг эргүүлж хасна.

■ Сэнсний хурд тохируулах

Сэнсний хурд тохируулах товчны “+”-г дарах мөн сэнсний хурд тохируулах товчны тэмдгийг баруун тийш шилжүүлэн хурдыг нэмнэ. Сэнсний хурд тохируулах

товчны “-”-г дарах мөн сэнсний хурд тохируулах товчны тэмдгийг зүүн тийш шилжүүлэн хурдыг хасна.

“REAR OFF” товч дарж сэнсийг унтраана.

Сэнсний хурд тохируулах товчны “-”-г удаан дарах эсвэл сэнсний хурд тохируулах товчны тэмдгийг зүүн тийш шилжүүлэн удаан барьж сэнсийг унтраах боломжтой.

■ Агаар үлээх чиглэл солих

Үлээх чиглэл тохируулах товч дарна.

Товч дарах бүрд үлээх чиглэлийн горим дараах байдлаар өөрчлөгдөнө.



: Агаарын урсгалыг цээж рүү чиглүүлнэ




: Агаарын урсгалыг цээж ба хөл рүү чиглүүлнэ



: Агаарын урсгалыг хөл рүү чиглүүлнэ

Арын агааржуулалтын системийн удирдлага (арын агааржуулалтын системийн удирдлагын самбар)



A Температур тохируулах товч

B Үлээх чиглэл тохируулах товч

C “AUTO” товч

D “OFF” товч

E Сэнсний хурд тохируулах товч

■ Температур тохируулах

Температур тохируулах товчны $\wedge$ -г дарж нэмэх ба $\vee$ -г дарж температур хасна.

■ Сэнсний хурд тохируулах

Сэнсний хурд тохируулах товчны $\rangle$ (нэмэх)-г дарж нэмэх ба $\langle$ (хасах)-г дарж температур хасна.

Сэнсний хурд дэлгэц дээр гарна. (7 түвшин)

“OFF” товч дарж сэнсийг унтраана.

■ Агаар үлээх чиглэл солих

Үлээх чиглэл тохируулах товч дарна.

Товч дарах бүрд үлээх чиглэлийн горим дараах байдлаар

өөрчлөгдөнө.



: Агаарын урсгалыг цээж

рүү чиглүүлнэ



: Агаарын урсгалыг цээж

ба хөл рүү чиглүүлнэ



: Агаарын урсгалыг хөл

рүү чиглүүлнэ

Арын суудлын температур тохируулах

Дараах байдлаар тохируулах боломжтой:

- “SYNC” товчны индикатор асаалттай үед: Жолоочийн суудлын температур тохируулна.


Арын суудлын температурын тохиргоо жолоочийн суудлын тохиргоог дагана.

- Голын дэлгэцээр (gear агааржуулалтын системийн удирдлагын дэлгэц) эсвэл арын агааржуулалтын системийн удирдлагын самбараар арын суудлын температур тохируулна.


Агааржуулалтын хоолойн байрлал ба ажиллагаа

■ Байрлал

Тухайн сонгосон горимоос хамаарч үлээх чиглэл, сэнсний хурд өөрчлөгдөнө.



■ Агааржуулалтын хоолойн байрлал тохируулах, нээх ба хаах



1 Агаарын урсгалыг баруун зүүн, дээш доош чиглүүлэх

2 Нээх буюу хаах

Товчийг арагш бүрэн шилжүүлж хаана.

Жолооны хүрд халаагч* / суудал халаагч/суудлын агааржуулагч

* Тоноглогдсон загварт

● Жолооны хүрд халаагч

Жолооны хүрдний хажуу талын барих хэсгийг халаана

● Суудал халаагч

Суух хэсгийг халаана

● Суудлын агааржуулагч

Суудал дотор байрлах сэнсээр сайн агаар сэлгэлтийг хадгална



АЮУЛТАЙ

■ Түлэгдэж гэмтэхээс сэргийлэх

Дараах хүмүүс халаагч асаалттай үед жолооны хүрдтэй харьцаж байхдаа эсвэл суудал дээр сууж байгаа тохиолдолд анхаарал болгоомжтой байна:

- Нялх, бага насны хүүхэд, настай хүн, өвчтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй
- Мэдрэмтгий арьстай хүн
- Ядарч сульдсан хүн
- Согтууруулах ундаа, нойр хүргэдэг эм (нойрны эм, ханиадны эм г.м.) хэрэглэсэн хүн



АНХААР

■ Суудал халаагч, агааржуулагчийг гэмтлээс сэргийлэх

Тэгш бус гадаргатай хүнд зүйл суудал дээр тавихгүй байх мөн хурц үзүүртэй зүйл (зүү, хадаас г.м.) суудалд хатгахыг хориглоно.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед энэ функцийг ашиглаж болохгүй.

Жолооны хүрд халаагч

Голын дэлгэц дээрээс -г сонгоно.

Ажиллах явцад индикатор (улаан) асна. Автомат ажиллагааны явцад "AUTO" индикатор асна.

Товч дарах бүрд ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдөнө.

AUTO → Hi (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

Ажиллах явцад индикатор (улаан) асна. Автомат ажиллагааны явцад "AUTO" индикатор асна.

■ Ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Жолооны хүрд халаагчийн тохиргоог өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)

Суудал халаагч

■ Урд суудал

Голын дэлгэц дээрээс  эсвэл -г дарна.

Ажиллах явцад индикатор (улаан) асна. Автомат ажиллагааны явцад "AUTO" индикатор асна.

Товч дарах бүрд ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдөнө.

AUTO → Hi (3 сегмент асах) → Mid (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

■ 2-р эгнээний захын суудал (тоноглогдсон загварт)


Товч дарж суудал халаагчийг асааж унтраана.

Ажиллах явцад **A** индикатор асна.


Товч дарах бүрд ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдөнө.

Hi (3 сегмент асах) → Mid (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

► Арын автомат агааржуулалтын системгүй загвар



► Арын автомат агааржуулалтын системтэй загвар



■ Ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Суудал халаагчийн тохиргоог өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)

▲ АЮУЛТАЙ

■ Хэт халах, түлэгдэж гэмтэхээс сэргийлэх

Суудал халаагчтай холбоотой дараах анхааруулгыг мөрдөнө:

● Суудал халаагч ашиглах үед суудлын зөөлөвч, бүтээлэг зэргийг суудал дээр тавьж болохгүй.

● Шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэж болохгүй.

Суудлын агааржуулагч

Голын дэлгэцээс  эсвэл -г сонгоно.

Ажиллах явцад (цэнхэр) индикатор асна. Автомат ажиллагааны явцад “AUTO” индикатор асна.

Товч дарах бүрд ажиллагаа дараах байдлаар өөрчлөгдөнө.

AUTO → Hi (3 сегмент асах) → Mid (2 сегмент асах) → Lo (1 сегмент асах) → Off

■ Ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Агааржуулалтын системтэй холбоотой удирдлагын горим


Суудлын агааржуулагч Hi горимд тохируулагдсан үед суудлын агааржуулагчийн сэнсний хурд агааржуулалтын системийн хурдны тохиргоогоор нэмэгдэж болно.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Суудлын агааржуулагчийн тохиргоог өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)

Салоны гэрлийн жагсаалт

Салоны гэрлийн байрлал



- A** Арын салоны гэрэл (→X.449)
- B** Хаалганы дотор хавтасны гэрэл^{*1}
- C** Хаалганы дотор бариулын гэрэл^{*1}
- D** Арын хувийн гэрэл (→X.450)
- E** Арааны хөшүүргийн гэрэл^{*2}
- F** Урд салоны гэрэл/Урд хувийн гэрэл (→X.449, 450)
- G** Урд самбарын гэрэл^{*1} (тоноглогдсон загварт)
- H** Хөлийн гэрэл^{*1}
- I** Босгоны гэрэл (тоноглогдсон загварт)
- J** Голын хайрцгийн дээд гэрэл^{*1}
- K** Хаалганы гэрэл
- L** Гадна талын хөлийн гэрэл
- M** Гишгүүрийн гэрэл

^{*1}: Зарим загварт салоны гэрлийн өнгийг өөрчлөх боломжтой. Дэлгэрэнгүйг "Мультимедиа гарын авлага"-с харна уу.

*2: Арааны хөшүүргийн гэрлийг арын гэрэлтэй зэрэг асааж унтраах боломжтой.

■ Entry системийн гэрэл

Асаах товчны горим, электрон түлхүүр байгаа эсэх, хаалга түгжигдсэн эсэх, хаалга хаалттай эсэх зэргээс хамаарч гэрэл автоматаар асаж унтарна. Мөн арааны ажиллагаатай уялдан гэрлийн хэмжээ автоматаар тохируулагдана.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Асаах товчийг OFF горимд шилжүүлсэн, салоны гэрлүүд асах горимд асаж байгаа үед гэрэл 20 орчим минутын дараа автоматаар унтарна.

■ Салоны гэрлүүд автоматаар асах нөхцөлүүд

Аль нэг SRS аюулгүйн дэр дэлгэгдсэн эсвэл ар талаасаа хүчтэй мөргөлтөд өртөх үед салоны гэрлүүд автоматаар асна.

Гэрлүүд автоматаар 20 орчим минутын дараа унтарна. Салоны гэрлүүдийг гар аргаар унтраах боломжтой. Гэхдээ нэмэлт мөргөлт үүсэхээс сэргийлж аюулгүй байдал хангагдах хүртэл гэрлүүдийг унтраахгүй байх нь зүйтэй. (Салоны гэрлүүд мөргөлтийн хүч болон нөхцөлөөс хамаарч автоматаар асахгүй байж болно).

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим тохиргоог (гэрэл унтраах хүртэлх хугацаа зэрэг) өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)



АНХААР

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед аккумуляторын цэнэг суухаас сэргийлж салоны гэрлийг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн асааж болохгүй.

Салоны гэрэл ашиглах


■ Урд салоны гэрэл асааж унтраах

Товчийг дарна.

Товч дарах бүрд гэрэл асаж унтарна.

Арын салоны гэрэл, арын хувийн гэрэл нь урд салоны гэрэлтэй зэрэг асаж унтарна.

Хаалганы байрлалд тохируулсан үед хаалга онгойход гэрэл асна.




■ Арын салоны гэрэл асааж унтраах

Товчийг дарна.

Товч дарах бүрд гэрэл асаж унтарна.

Урд салоны гэрэл асаж унтрах үед арын салоны гэрлийг зэрэг ажиллах байдлаар тохируулах боломжтой. Энэ тохиргоог хийсэн үед арын салоны гэрлийг товчоор нь унтраах боломжгүй.




■ Хаалганы байрлалд тохируулах

Хаалгатай холбоотой салоны гэрлийн товч дарна.

Хаалга нээгдэх/хаагдах үед гэрэл асна/унтарна.

Товчийг дарах бүрд хаалганы байрлалд тохируулах тохиргоо асаж унтарна.

Хаалганы байрлалд тохируулагдсан үед **A** индикатор асна.




Хувийн гэрэл ашиглах

■ Урд хувийн гэрлийг асааж унтраах

Гэрэл дээр дарна.

Дарах бүрд гэрэл асаж унтарна.




■ Арын хувийн гэрлийг асааж унтраах

Товч дээр дарна.

Товч дарах бүрд гэрэл асаж унтарна.

Урд салоны гэрэл асаж унтрах үед арын хувийн гэрлийг зэрэг ажиллах байдлаар тохируулах боломжтой. Энэ тохиргоог хийсэн үед арын хувийн гэрлийг товчоор нь унтраах боломжгүй.



■ Хувийн гэрэл хэвийн хариу үйлдэл үзүүлэхгүй үед


- Линз дээр ус, шороо зэрэг тогтсон
- Нойтон гараар ажиллуулсан
- Бээлий өмссөн зэрэг

**АНХААР****■ Хувийн гэрлийн линз салгах**

Гэрэл гэмтэх тул хувийн гэрлийн линзийг салгаж болохгүй. Линзийг салгах шаардлагатай үед Lexus дилертээ хандана уу.

Хайрцаг, тавиурын жагсаалт

Хайрцаг, тавиурын байрлал



- A** Тасалбар хадгалах гэр
- B** Урд хайрцаг (→X.453)
- C** Ундааны тавиур (→X.454)
- D** Хаалганы халаас
- E** Аяганы тавиур (→X.454)
- F** Нээлттэй тавиур (→X.455)
- G** Голын хайрцаг (тоноглогдсон загварт) (→X.453)



АЮУЛТАЙ


■ Хайрцагт үлдээж болохгүй зүйлс

Хайрцагт шил, асаагуур, шүршдэг лааз зэргийг үлдээвэл бүхээг хэт халах үед дараах байдал үүсэж болох тул үлдээж болохгүй:


- Хайрцаг дахь өөр эд зүйлтэй нийлсэн үед шил халах, хагарч болно.
- Асаагуур, шүршдэг лааз дэлбэрч болно. Асаагуур бусад зүйлтэй нийлсэн үед асах, хий ялгаруулах зэргээр галын аюул үүсгэнэ.

Урд хайрцаг

► Зүүн жолооны хүрдтэй



- 1 Нээх (товч дээр дарна)
 - 2 Механик түлхүүрээр түгжээ тайлах
 - 3 Механик түлхүүрээр түгжих
- Баруун жолооны хүрдтэй




- 1 Нээх (товч дээр дарна)
- 2 Механик түлхүүрээр түгжээ тайлах
- 3 Механик түлхүүрээр түгжих

■ Урд хайрцгийн гэрэл

Оврын гэрэл асах үед урд хайрцгийн гэрэл асна.

■ Тусгаарлагчийг салгах

Урд хайрцаг доторх тусгаарлагчийг дээш татан авах боломжтой.



! АЮУЛТАЙ


■ Жолоодлогын үед

Хөдөлгөөний үед урд хайрцгийг хаалттай байлгана. Огцом тоормос, эргэлтийн үед онгорхой хайрцагт эсвэл доторх эд зүйлд нь цохигдон осолд хүрэх аюултай.

Голын хайрцаг (тоноглогдсон загварт)

Автомашинд голын эсвэл хөргүүртэй хайрцаг суурилагдсан. Хөргүүртэй хайрцагтай бол дэлгэрэнгүйг Х.461-с харна уу.

Голын хайрцгийг баруун болон зүүн мөн хойд талаас нь онгойлгоно.





АЮУЛТАЙ

■ Жолоодлогын анхааруулга

үеийн


Голын хайрцгийг хаалттай байлгана.

Огцом тоормос, эргэлт эсвэл ослын үед бэртэл гэмтэл авах аюултай.

Аяганы тавиур


■ Урд суудал

Тагийг нээнэ.




■ 2-р эгнээний суудал

Гарын түшлэгийг доош буулгана.



■ Хойд хажуу тал



АЮУЛТАЙ

■ Ашиглаагүй үед (Урд суудал)

Аяганы тавиурыг хаалттай байлгана. Осол, огцом тоормослох үед бэртэл гэмтэлд хүргэх аюултай.

■ Аяганы тавиурт тавихад тохиромжгүй зүйлс


Аяганы тавиурт аяга, ундааны лаазнаас өөр зүйл тавьж болохгүй. Таг тагласан байсан ч аяганы тавиурт өөр зүйл тавьж болохгүй.

Осол үүссэн эсвэл огцом тоормос хийсэн үед бусад зүйлс аяганы тавиураас шидэгдэж гэмтэл учруулах аюултай. Боломжтой бол халуун ундааг таглах нь зүйтэй.


*: 2-р эгнээний аяганы тавиураас бусад

Ундааны тавиур

■ Урд хаалга



■ Арын хаалга



■ Ундааны тавиур

- Ундаа байрлуулах үед таглана.
- Лонхны хэмжээ, хэлбэрээс хамаарч ундааг байрлуулах боломжгүй байж болно.



АНХААР


■ Ундааны тавиурт байрлуулахад тохиромжгүй зүйлс

Ундааны савны тавиурт таглаагүй сав, лонх, дотроо шингэн зүйлтэй шилэн болон цаасан сав тавьж болохгүй. Доторх зүйлс нь асгарах, шил хагарах аюултай.

Нээлттэй тавиур


■ А төрөл (тоноглогдсон загварт)

Утасгүй цэнэглэгчтэй загвар:
→Х.466




■ В төрөл

Ашиглах үед урд аяганы тавиурын тагийг хаана.



■ С төрөл (тоноглогдсон загварт)



АЮУЛТАЙ

■ Нээлттэй тавиурт хадгалахад тохиромжгүй зүйлс

Тавиур дээр эд зүйл тавих үед дараах анхааруулгыг мөрдөнө. Огцом тоормос эсвэл ослын үед бусад зүйлс тавиураас шидэгдэх аюултай. Энэ тохиолдолд шидэгдсэн зүйлс дөрөөний ажиллагаанд саад учруулах эсвэл жолоочийн анхаарал сарниулах улмаар осолд хүргэх аюултай.

- Тавиур дээр хялбар хөдлөх, өнхрөх эд зүйл байрлуулж болохгүй.
- Тавиурын ирмэгээс давуулан эд зүйл давхарлаж тавьж болохгүй.
- Тавиурын дээш ил гарган эд зүйл тавьж болохгүй.


Тээшний хэсэг

Тээш бэхлэх дэгээ


Дэгээг ашиглах үед дээш өргөнө.

Тээш бэхлэх дэгээг ачаа тээшийг бэхлэх үед ашиглана.

- ▶ 3-р эгнээний суудалгүй загвар



- ▶ 3-р эгнээний суудалтай загвар



⚠ АЮУЛТАЙ


■ Дэгээ ашиглаагүй үед

Дэгээ ашиглаагүй үед бэртэл гэмтлээс сэргийлж дэгээг хураах байрлалд хураана.


Тээшний хэсгийн шал

- 1 Тээшний хэсгийн шалыг дээш өргөнө.

- ▶ 3-р эгнээний суудалгүй загвар



- ▶ 3-р эгнээний суудалтай загвар



⚠ АЮУЛТАЙ

■ Тээшний шалтай харьцах үед

Шалтай харьцах үед шалан дээр эд зүйл тавьж болохгүй. Гар хуруугаа хавчуулах бусад гэмтэл авах аюултай.

■ Шал эвхсэн, салгасан үед


Хөдөлгөөн эхлэхээс өмнө анхны байрлалд буцаана. Огцом тоормос, ослын үед жолооч, зорчигч шал болон шалны доод талд хадгалагдсан эд зүйлсэд цохигдох аюултай.

Шалны доод талын хөндий

Шалыг нээнэ. (→X.456)

Дараах зүйлсийг хадгалах боломжтой.

- 3-р эгнээний суудалгүй загвар




A Ослын гурвалжин*

B Багаж хэрэгслүүд

*: Ослын гурвалжин нь үндсэн тоноглолд хамаарахгүй.

- 3-р эгнээний суудалтай загвар



A Ослын гурвалжин*


*: Ослын гурвалжин нь үндсэн тоноглолд хамаарахгүй.

■ Ослын гурвалжин

Ослын гурвалжин тэмдгийн хэлбэр, хэмжээнээс хамаарч тус байрлалд хадгалах боломжгүй байж болно.

Туслах хайрцаг (тоноглогдсон загварт)


Тагийг авна.




Ачааны халхавч (тоноглогдсон загварт)

■ Ачааны халхавч угсрах

- 1 Халхавчийн 1 талыг эхлээд угсарна. Тухайн тал руу дарангаа халхавчийн нөгөө талыг угсарна.




- 2 Халхавчийг татаж гаргаад дэгээнд бэхэлнэ.




■ Ачааны халхавч салгах

- 1 Халхавчийн 2 үзүүрийг дэгээнээс салгаад хураана.



- 2 Халхавчийн 1 талыг дотогш дараад сууринаас салгана.

Халхавчийг салгасан нөхцөлд автомашинаас гаргана.



! АЮУЛТАЙ

■ Ачааны халхавч

- Ачааны халхавч дээр аливаа эд зүйл тавьж болохгүй. Огцом тоормос, эргэлтийн үед тэдгээр эд зүйл шидэгдэн жолооч, зорчигчийг цохих аюултай. Улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.
- Ачааны халхавч руу бага насны хүүхэд гаргах, авируулахыг хориглоно. Эсрэг тохиолдолд халхавчийг гэмтээх мөн хүүхдэд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах гэмтэл учруулах аюултай.


Цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхий*

* Тоноглогдсон загварт

Таазны товч ашиглан дээврийн электрон нарны хаалт нээх хаах, дээврийн нээлхийг тунгалаг болон цайралттай болгоно.

Дээврийн электрон нарны хаалт, цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхий ажиллуулах

■ Дээврийн электрон нарны хаалтыг нээж хаах



1 Нээх*

2 Хаах*

Дээврийн электрон нарны хаалт хаагдах үед дээврийн нээлхий автоматаар цайралттай болох ба индикатор унтарна.

* Дээврийн электрон нарны хаалтыг дутуу зогсоох үед товчны аль нэг талыг дарна.


■ Дээврийн нээлхийг тунгалаг, цайралттай болгох

Цайралттай болгох товч дарна.

Товч дарах бүрд дээврийн нээлхий тунгалаг болон цайралттай тохиргоонд шилжинэ.

Тунгалаг үед товчны **A** индикатор асна.

Дээврийн электрон нарны хаалт бүрэн хаалттай үед цайралттай болгох товч дарсан тохиолдолд дээврийн электрон нарны хаалт автоматаар нээгдээд дээврийн нээлхий тунгалаг болно.



■ Дээврийн электрон нарны хаалт, цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхийн ажиллах нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Дээврийн нээлхий тунгалаг үед

● Цаг агаарын зарим нөхцөлд мөн гадна болон дотор гэрлийн тусгалаас хамаарч дээврийн нээлхий дээр зурааснууд (хөндлөн хээтэй) гарч болно.

● Харж буй өнцгөөс хамаарч дээврийн нээлхий цайралттай харагдаж болно.

■ Дээврийн нээлхий хэт хүйтэнд хэмд

Дээврийн нээлхий тунгалаг болон цайралттай тохиргоонд шилжих хүртэл хугацаа шаардагдаж болно.

Тохиргоог өөрчлөхөөс өмнө бүхээгийг хангалттай халаана.

■ Асаах товчийг унтраах

Асаах товчийг OFF горимд унтраах үед дээврийн нээлхий автоматаар цайрна.

■ Цайралттай болгох товчны индикатор анивчиж байгаа үед

Цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхийд доголдол үүссэн байж болзошгүй. Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Дээврийн электрон нарны хаалтын ажиллагаа

Дээврийн электрон нарны хаалтын моторыг хэт халахаас сэргийлж богино хугацаанд олон удаа ашигласан нөхцөлд дээврийн электрон нарны хаалтын ажиллагаа цуцлагдаж болно. Энэ нөхцөлд дээврийн электрон нарны хаалтын товч дарахаас зайлсхийнэ.

Дээврийн электрон нарны хаалтын мотор хэвийн ажиллах хүртэл хүлээнэ.

■ Автомашин хүчтэй мөргөлтөд өртсөн үед

Дээврийн нээлхий цайрах бай буцаж тунгалаг болохгүй. Lexus дилер дээрээ оношлуулна уу.

■ Дээврийн электрон нарны хаалтын хавчихаас сэргийлэх функц

● Дээврийн электрон нарны хаалт хаагдах явцад хаалт болон хүрээний завсар эд зүйл хавчуулагдвал хаалтын ажиллагаа зогсох ба буцаж бага зэрэг нээгдэнэ.

● Хавчихаас сэргийлэх функц ажилласан нөхцөлд хаалт эсрэг чиглэлд нээгдэх үйлдэл бүрэн зогсох хүртэл “CLOSE” товчийг дарсан ч хаалт хаагдахгүй.

● Жолоодлогын үед хаалт аливаа зүйлд цохигдсон эсвэл жолоодлогын нөхцөлөөс хамаарч хаалт дээр доргилт ирсэн нөхцөлд дээврийн электрон нарны хаалт эсрэг чиглэлд нээгдэж болно.

■ Дээврийн электрон нарны хаалтын автоматаар нээгдэх, хаагдах функц ажиллахгүй үед

Дараах үйлдлээр анхны тохиргоонд буцаана.

1 Асаах товчийг ON горимд шилжүүлнэ.

2 “CLOSE” товчийг удаан дарна.

Хаалт бага зэрэг дутуу хаагдаад зогсоно. Үргэлжлээд бүрэн нээгдээд буцаж бүрэн хаагдана.

Үйлдэл дуусаагүй байхад товчийг сулласан нөхцөлд үйлдлийг дахин эхэлнэ.

Дээрх үйлдлийг хийсэн ч автоматаар нээгдэх, хаагдах функц хэвийн ажиллахгүй нөхцөлд Lexus дилер дээрээ оношлуулна уу.

■ Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим функцийг өөрчлөх боломжтой. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →X.583)



АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.


■ Цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхий

Өндөр хүчдэлтэй эд ангитай тул цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхийг задлах, салгахыг хориглоно. Цайрдаг шилтэй панорамик дээврийн нээлхийд засвар шаардлагатай нөхцөлд Lexus дилертээ хандана.

⚠ АЮУЛТАЙ

■ Дээврийн электрон нарны хаалтыг нээж хаах үед

- Дээврийн электрон нарны хаалт ажиллах явцад зорчигч гар хуруугаа хавчуулахаас сэргийлнэ.



- Дээврийн электрон нарны хаалтыг бага насны хүүхдээр нээлгэж хаалгаж болохгүй. Дээврийн электрон нарны хаалт хүний биеийг хавчиж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

■ Дээврийн электрон нарны хаалтын хавчихаас сэргийлэх функц

- Функцийг албаар идэвхжүүлэх үүднээс гар, биеэ санаатайгаар хавчуулж болохгүй.
- Дээврийн электрон нарны хаалт бүрэн хаагдахын дөнгөж өмнө аливаа зүйл хавчуулагдсан нөхцөлд тус функц ажиллахгүй байж болно. Мөн тус функц нь нарны хаалтын товч дарж байгаа үед ажилдаггүй. Гар хуруугаа хавчуулахаас сэргийлнэ.

■ Түлэгдэх, гэмтэхээс сэргийлэх


Дээврийн шилний доод тал болон электрон нарны хаалтын завсар хүрч болохгүй. Гараа хавчуулж гэмтэх аюултай. Мөн автомашиныг нарны шууд гэрэлд удаан орхисон үед дээврийн шилний доод тал халж түлэх аюултай.

Салоны бусад хэрэгслүүд

Хөргүүртэй хайрцаг (тоноглогдсон загварт)

Хөдөлгүүр асаалттай үед агааржуулалтын системээр хөргөгддөг хөргүүртэй хайрцаг ашиглах боломжтой.


- 1 Товч дарангаа тагийг өргөж нээнэ.



- 2 Хөргүүртэй хайрцаг асааж унтраана.

Хөргүүртэй хайрцаг ассан үед **A** индикатор асна.

Урд агааржуулагчийн систем унтраастай үед хөргүүртэй хайрцаг асаавал урд агааржуулагчийн систем автоматаар асна.



■ Урд агааржуулагчийн систем ашиглаагүй үед

Хөргүүртэй хайрцаг асах үед урд агааржуулагчийн систем автоматаар асна.

■ Хөргүүртэй хайрцаг ассан үед

- Урд агааржуулалтын системийг унтраах боломжгүй.
- Температурын тохиргоо хийх зорилгоор хөргүүртэй хайрцагийн ажиллагаа түр зогсож болно.

■ Гадна агаарын хэм 0°C (32°F)-с бага үед

Хөргүүртэй хайрцаг ажиллахгүй байж болно.

■ Хөргүүртэй хайрцагт хадгалахад тохиромжгүй зүйлс

- Таггүй савтай ус ундаа
- Хэврэг эд зүйлс, амархан мууддаг эсвэл хүчтэй үнэртэй зүйлс
- Хэрэглэгчийн гарын авлага, электрон төхөөрөмж, CD зэрэг.

■ Хөргүүртэй хайрцаг цэвэрлэх үед

Нойтон даавуугаар бохирдлыг арчиж цэвэрлэнэ. Ус шууд хүргэх нь хайрцагийн ажиллагааг доголдуулж болзошгүй.



АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үеийн анхааруулга

Хөдөлгөөний үед хөргүүртэй хайрцаг хаалттай байлгана.

Огцом тоормос, эргэлт эсвэл осол үүссэн тохиолдолд бэртэл гэмтэл авах аюултай.




АНХААР

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж хөдөлгүүр унтраастай үед шаардлагагүй тохиолдолд хөргүүртэй хайрцагийг унтраана.

Нарны хаалт




- 1 Нарны хаалтыг урд байрлуулах үед доош буулгана.
- 2 Нарны хаалтыг хажуу талд байрлуулах үед доош буулгаад дэгээнээс мултлах ба хажуу тийш эргүүлнэ.
- 3 Нарны хаалт уртасгагч (тоноглогдсон загварт) ашиглах үед хажуу тийш болгоод арагш гүйлгэнэ.

Нарны хаалтын толь

Тагийг хажуу тийш гүйлгэж нээнэ.

Таг нээгдэх үед гэрэл асна.



■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж гэрэл унтрах

Хөдөлгүүр унтраастай үед нарны хаалтын толины гэрэл 20 минутын дараа автоматаар унтарна.

**АНХААР**

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед нарны хаалтын толины гэрлийг шаардлагагүй үед унтраана.

Цахилгааны залгуур (12V)


Цахилгаан залгуурт 12 VDC/10 A (120 W чадалтай) хүртэл цахилгаан хэрэгсэл залгаж ашиглана.

Олон цахилгаан хэрэгсэл ашиглах үед бүх хэрэгслийн нийт чадал 120 W-с бага байна.

■ А төрөл


Тагийг нээнэ.

Хаах үед таган дээр дарна.



■ В төрөл

Тагийг нээнэ.



■ Цахилгааны залгуур ашиглах боломжтой нөхцөл

Асаах товч ACC, ON горимд байгаа.

■ Хөдөлгүүр унтраах үед

Зөөврийн зай хураагуур зэрэг цэнэглэх функцтэй электрон төхөөрөмжийг салгана. Холбоотой орхисон тохиолдолд асаах товч дарсан ч автомашин хэвийн унтрахгүй байж болно.

**АНХААР**

■ Цахилгааны залгуураашиглаагүй үед

Залгуурын гэмтлээс сэргийлж ашиглаагүй үе тагийг таглана.

Гадны биет, шингэн зүйл залгуурт орж богино холболт үүсгэх аюултай.


■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед шаардлагагүй нөхцөлд цахилгааны залгуурыг ашиглаж болохгүй.

Цахилгааны залгуур (Хувьсах гүйдлийн 120 эсвэл 220V) (тоноглогдсон загварт)

100W хүртэлх цахилгаан хэрэгсэл залгаж ашиглана.

Тагийг нээнэ.



■ Цахилгааны залгуур ашиглах боломжтой нөхцөл

Асаах товч ON горимд байгаа.

■ Цахилгааны залгуур

100W-с дээш чадалтай хувьсах гүйдлийн 120V эсвэл 220V-н хэрэгсэл ашиглаж болохгүй. Эсрэг тохиолдолд хамгаалалтын хэлхээ цахилгааныг тасална.

■ Хэвийн ажиллахгүй байж болох төхөөрөмжүүд (120 эсвэл 220V)

Дараах 120 эсвэл 220V-н хувьсах гүйдлийн цахилгаан хэрэгслүүд нь 100W-с бага чадалтай байсан ч хэвийн ажиллахгүй байх магадлалтай:

- Асах үедээ цахилгааны хэрэглээ өндөр цахилгаан хэрэгслүүд
- Өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгслүүд
- Цахилгааны тогтвортой эх үүсвэр шаарддаг цахилгаан хэрэгслүүд



АНХААР

■ Цахилгааны залгуур ашиглаагүй үед

Залгуурын гэмтлээс сэргийлж ашиглаагүй үе тагийг таглана.

Гадны биет, шингэн зүйл залгуурт орж богино холболт үүсгэх аюултай.


■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

Хөдөлгүүр унтраастай үед шаардлагагүй нөхцөлд цахилгааны залгуурыг ашиглаж болохгүй.

USB Type-C цэнэглэх порт

USB Type-C цэнэглэх порт нь 3A 5V цахилгаанаар электрон төхөөрөмжийг хангадаг. USB Type-C цэнэглэх порт нь зөвхөн цэнэглэх зориулалттай. Дата өгөгдөл дамжуулах бусад зорилгоор ашиглах боломжгүй. Төхөөрөмжөөс хамаарч зөв цэнэглэхгүй тул порт ашиглахаас өмнө тухайн төхөөрөмжийн гарын авлагатай танилцана уу.


■ А төрөл



■ В төрөл


- Арын автомат агааржуулалтын системгүй загвар

Тагийг нээнэ.




- Арын автомат агааржуулалтын системтэй загвар

Тагийг нээнэ.



- **С төрөл (тоноглогдсон загварт)**



- **USB Type-C цэнэглэх порт ашиглах боломжтой нөхцөл**

Асаах товч ACC, ON горимд байгаа.

- **USB Type-C цэнэглэх порт зөв ажиллахгүй байж болох нөхцөлүүд**

- 3А, 5V-с илүү цахилгааны хэрэглээтэй төхөөрөмж холбосон

- USB санах ой зэрэг компьютертой холбогдож ажиллах зориулалттай төхөөрөмж холбосон үед
- Холбосон төхөөрөмж унтраастай үед (төхөөрөмжөөс хамаарна)
- Автомашин наранд зогссон зэргээр бүхээгийн хэм хэт халуун үед

■ **Холбосон төхөөрөмжийн тухай**

Холбосон төхөөрөмжөөс хамаарч цэнэг шахалт тогтмол тасалдаж болно. Энэ нь доголдол биш болно.



АНХААР

■ **USB Type-C цэнэглэх портын гэмтлээс сэргийлэх**

- Портонд гадны биет хийж болохгүй.
- Ус бусад шингэн зүйл порт руу асгаж болохгүй.
- В төрөл: USB Type-C цэнэглэх порт ашиглаагүй үед тагийг таглана. Гадны биет эсвэл шингэн портод орж богино холболт үүсгэх аюултай.

- USB Type-C цэнэглэх портод хэт хүч, цохилт учруулахаас сэргийлнэ.

- USB Type-C цэнэглэх портыг задлах, өөрчлөхийг хориглоно.

■ **Холбосон төхөөрөмжийг гэмтлээс сэргийлэх**

- Төхөөрөмжийг автомашинд үлдээж болохгүй. Бүхээгийн хэм хэт халуун болох, улмаар төхөөрөмжийг гэмтээж болно.

- Холболт хийсэн үед төхөөрөмж эсвэл холбох кабелийг доош хүчтэй дарах, хэт хүч учруулж болохгүй.

■ **Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх**

Хөдөлгүүр унтраастай үед USB Type-C цэнэглэх порт удаан хугацаанд ашиглаж болохгүй.

Утасгүй цэнэглэгч (тоноглогдсон загварт)

Wireless Power Consortium-н Qi стандартад нийцсэн утасгүй цэнэглэх технологитой зөөврийн төхөөрөмж (ухаалаг утас, гар утасны зай г.м.)-г цэнэглэх хэсэгт байрлуулан цэнэглэх боломжтой.

Ашиглах боломжтой зөөврийн төхөөрөмжийн мэдээллийг Wireless Power Consortium-н цахим хуудаснаас харах боломжтой.

<https://www.wirelesspowerconsortium.com/>


Цэнэглэх тавиураас овор хэмжээний хувьд том төхөөрөмжийг энэ функцээр цэнэглэх боломжгүй. Мөн зөөврийн төхөөрөмжөөс хамаарч функц хэвийн ажиллахгүй байж болно. Цэнэглэх зөөврийн төхөөрөмжийн гарын авлагыг уншиж танилцана уу.

■ “Qi” лого

“Qi” лого нь Wireless Power Consortium-н бүртгэлтэй барааны тэмдэг юм.



■ Эд ангиудын нэршил



- A** Ажиллагааны индикатор
- B** Цэнэглэх хэсэг*
- C** Цэнэглэх тавиур
- D** 10 см (3.9 инч) орчим
- E** 2.5 см (1.0 инч) орчим

* Утасгүй цэнэглэгчийн цэнэглэх ороомог нь цэнэглэх хэсэг дотор зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх ороомог руу хөдөлнө. Зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх ороомог цэнэглэх хэсэг дотор байгаа үед цэнэглэх боломжтой. Цэнэглэх тавиурт 2-с олон зөөврийн төхөөрөмж байрлуулсан үед цэнэглэх ороомгууд нь зөв танигдахгүй байх улмаар цэнэглэгдэхгүй байж болно.

■ Утасгүй цэнэглэгч ашиглах


Зөөврийн төхөөрөмжийг цэнэглэх тавиур дээр тавина.

Зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх талыг доош харуулан цэнэглэх тавиурын гол хэсэгт зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх хэсгийг голлуулан тавина.

Цэнэглэх үед ажиллагааны индикатор (шаргал) асна.

Цэнэглэх үйлдэл хийгдэхгүй үед “Функц хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд” (→Х.471)-с авах арга хэмжээг харна уу.

Цэнэглэж дууссаны дараа ажиллагааны индикатор (ногоон) асна.



■ Дахин цэнэглэх функц

- Цэнэглэж дуусаад цэнэглэхгүй горимд хэсэг хугацаанд байсны дараа дахин цэнэглэж эхэлнэ.
- Зөөврийн төхөөрөмжийг цэнэглэх хэсгээс бага зэрэг хөдөлгөсөн үед цэнэглэх ороомог тавиураас хөндийрч

■ Ажиллагааны индикатор асах

Ажиллагааны индикатор		Нөхцөл
Цэнэглэх тавиурын индикатор	Голын дэлгэцийн индикатор	
Унтарсан	Дэлгэцээр гарахгүй	Мультимедиа систем эсвэл хайбрид систем унтраастай
Ногоон (асах)	Саарал	Хүлээлгийн горим (цэнэглэх боломжтой)*1
		Цэнэглэж дууссан*2
Шаргал (асах)	Цэнхэр	Цэнэглэж байгаа

*1: Хүлээлгийн горимд цэнэг шахахгүй. Тус горимд цэнэглэх тавиур дээр металл эд зүйл байрлуулсан ч халахгүй.

цэнэглэлт зогсоно. Нөгөөтээгүүр цэнэглэх тавиур дотор цэнэглэх ороомог байгаа үед ороомог өөрөө хөдлөн дахин цэнэглэж эхэлнэ. Зөөврийн төхөөрөмж цэнэглэх хэсгээс гарсан үед цэнэглэлт зогсоно. Зөөврийн төхөөрөмжийг цэнэглэх хэсгийн гол руу тавина.

■ Хурдан цэнэглэх функц

- Дараах зөөврийн төхөөрөмж нь хурдан цэнэглэх функц дэмждэг.
- WPC Ver1.3.2 дэмждэг ба хурдан цэнэглэх функцтэй зөөврийн төхөөрөмж
- 7.5 W-р цэнэглэх iOS-той iPhone гар утас (iPhone 8-с хойших загвар)
- Galaxy-н оригинал хурдан цэнэглэх стандартыг дэмждэг цэнэглэх төхөөрөмж
- Хурдан цэнэглэх функцийг дэмждэг зөөврийн төхөөрөмж холбосон үед тус функц идэвхэжнэ.

*2: Зөөврийн төхөөрөмжөөс хамаарч цэнэглэж дууссан ч индикатор шаргал өнгөөр асаж болно.

■ Утасгүй цэнэглэгч хэвийн ажиллахгүй үед

Утасгүй цэнэглэгч хэвийн ажиллахгүй үед дараах үйлдлийг хийнэ.

Ажиллагааны индикатор		Нөхцөл
Цэнэглэх тавиу-рын индикатор	Голын дэлгэцийн индикатор	
Шаргал (Нэг секунд тутам анивчих)	Саарал	Автомашинаас утасгүй цэнэглэгч рүү холбогдох холбоо амжилтгүй болсон үед → Хөдөлгүүр асаалттай үед унтраагаад асаана. Асаах товч ACC горимд байгаа үед хөдөлгүүр асаана. (→X.203)
Ногоон (Нэг секунд тутам анивчих)	Дэлгэцээр гарахгүй	Утасгүй цэнэглэгч ба мультимедиа системийн холбоо амжилтгүй болсон үед → Хөдөлгүүр асаалттай үед унтраагаад асаана. Асаах товч ACC горимд байгаа үед хөдөлгүүр асаана. (→X.203)
Ногоон (асах)	Цэнхэр	AM радио станц автоматаар сонгогдож байгаа (тоноглогдсон загварт) → Систем AM радиог автоматаар сонгох үйлдэл дуусах хүртэл хүлээнэ. Автоматаар сонгох үйлдэл дуусахгүй үед автоматаар сонгох сонголтыг хийнэ.
		Smart entry & start систем түлхүүр таних үйлдэл хийж байгаа → Түлхүүр таних үйлдэл дуусах хүртэл хүлээнэ.

Ажиллагааны индикатор		Нөхцөл
Цэнэглэх тавиу-рын индикатор	Голын дэлгэцийн индикатор	
Ногоон (асах)	Саарал	Гадны эд зүйл мэдрэгдсэн: Цэнэглэх хэсэгт гадны металл эд зүйл мэдрэгдсэн мөн цэнэглэх ороомгийн хэт халалтаас сэргийлэх функц ажилласан. → Цэнэглэх хэсгээс гадны эд зүйлийг салгана.
		Зөөврийн төхөөрөмж буруу байрласан: Зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх ороомог цэнэглэх хэсгээс гарсан, зөөврийн төхөөрөмжийн камер, хамгаалалтын гэр зузаан тул цэнэглэх ороомгийн хэт халахаас сэргийлэх функц ажилласан → Цэнэглэхээ зогсоож зөөврийн төхөөрөмжийг утасгүй цэнэглэгчээс авах ба 5 секундйн дараа утасгүй цэнэглэгч голлуулан тавина. Мөн зөөврийн төхөөрөмж хамгаалалтын гэртэй байвал салгана.
Ногоон (асах)	Саарал	Зөөврийн төхөөрөмжийн батарей хамгаалах функц: Бүрэн цэнэглэгдэхээс өмнө зөөврийн төхөөрөмжийн батарей хамгаалах функц ажилласан. → Төхөөрөмжийн тохиргоог шалгана.
		Электрон түлхүүр таних үйлдэл хийгдсээр байгаа: Өөрчлөх боломжтой тохиргоогоор мультимедиа функц ашиглах явцад электрон түлхүүр олон удаа мэдрэгдсэн боловч түлхүүр танигдаагүй. → Асаах товч ACC эсвэл ON горимд шилжүүлээд түлхүүрийг шалгана.
Шаргал (4 удаа анивчих)	Саарал	Утасгүй цэнэглэгчийн дотоод хэм зохих хэмжээнээс халснаас аюулгүйн систем ажиллаж цэнэглэгч унтарсан → Цэнэглэхээ зогсоож зөөврийн төхөөрөмжийг авна. Хангалттай хөрсний дараа дахин цэнэглэнэ.

■ Дараах нөхцөлд утасгүй цэнэглэгч ашиглах боломжтой

Асаах товч ACC, ON горимд байгаа.

■ Зөөврийн төхөөрөмж ашиглах

- Qi стандартад нийцсэн утасгүй цэнэглэх технологитой зөөврийн төхөөрөмжийг цэнэглэж болно. Нөгөөтээгүүр Qi стандартын хувилбар 1.0, 1.3.2-с хойших төхөөрөмжийг цэнэглэх боломжгүй байж болно.
- Утасгүй цэнэглэгч нь гар утас, ухаалаг утас зэрэг 5W хүртэлх бага чадалтай төхөөрөмжид зориулагдсан болно.
- Нөгөөтээгүүр дараах 5W-с илүү чадалтай зөөврийн төхөөрөмжийг цэнэглэх боломжтой.
- 7.5 W-р цэнэглэдэг iPhone-г 7.5 хүртэлх ваттаар цэнэглэх
- Galaxy цэнэглэх стандартын хурдан цэнэглэлт дэмждэг төхөөрөмж. Төхөөрөмж тус бүрийн цэнэглэх хүчин чадлыг шалгана уу
- WPC стандартын Ver1.3.2 хувилбарыг дэмждэг EPP гаралттай зөөврийн төхөөрөмжийг 15 хүртэлх ваттаар цэнэглэх

■ Smart entry & start систем ашиглах

Төхөөрөмж цэнэглэх явцад Smart entry & start систем электрон түлхүүр мэдэрвэл цэнэглэлт түр зогсож болно. Электрон түлхүүрийг таних үйлдэл дууссаны дараа цэнэглэлт автоматаар үргэлжилнэ.

■ Зөөврийн төхөөрөмжид хамгаалалтын гэр, чимэглэл хийсэн үед

Зөөврийн төхөөрөмжид Qi технологи дэмжихгүй хамгаалалтын гэр, чимэглэл хийсэн үед цэнэглэгч ашиглан цэнэглэж болохгүй. Хамгаалалтын гэр болон чимэглэлийн төрлөөс хамаарч цэнэглэгдэхгүй байж болно. Цэнэглэх хэсэг дээр зөөврийн төхөөрөмж тавьсан ч цэнэглэгдэхгүй үед гэр, чимэглэлийг салгаж авна.

■ Цэнэглэх үед AM радиотой холбоотой байдлаар ажиллах (тоноглогдсон загварт)

- Цэнэглэх үед сонсож буй AM радиод шуугиан үүсвэл шуугианыг бууруулах үүднээс цэнэглэх давтамж автоматаар солигддог.
- AM радио станцыг автоматаар хайх үед цэнэглэх давтамж радио станц гэж буруу танигдахаас сэргийлж цэнэглэлт түр зогсоно. Радио станцын хайлт дуусах үед цэнэглэлт автоматаар эхэлнэ.

■ Утасгүй цэнэглэгч ашиглах үед анхаарах зүйлс

- Автомашины бүхээг дотор электрон түлхүүр байхгүй үед цэнэглэхгүй. Хаалга нээгээд хаах үед цэнэглэх ажиллагаа түр цуцлагдаж болно.
- Цэнэглэх үед утасгүй цэнэглэгч болон зөөврийн төхөөрөмж халах ба энэ нь хэвийн зүйл болно. Цэнэглэх явцад зөөврийн төхөөрөмж халах үед төхөөрөмжийн хамгаалах функц идэвхжиж цэнэглэгдэхгүй болж болно. Энэ тохиолдолд төхөөрөмж хөрсний дараа дахин цэнэглэнэ.

Утасгүй цэнэглэгчийн хэмийг бууруулах үүднээс сэнс ажиллах ба энэ нь хэвийн үзэгдэл болно.

■ Ажиллагааны дуу

Утасгүй цэнэглэгчийн асаах товч асаалттай үед хөдөлгүүр асаах товчийг ACC эсвэл ON горимд шилжүүлэх эсвэл зөөврийн төхөөрөмж хайх үед утасгүй цэнэглэгч дуу гаргах ба энэ нь хэвийн зүйл болно.

■ Утасгүй цэнэглэгч цэвэрлэх

→X.480

■ Функц хэвийн ажиллахгүй байж болох нөхцөлүүд

Дараах нөхцөлд төхөөрөмжийг хэвийн цэнэглэхгүй байж болно.

- Зөөврийн төхөөрөмж дүүрэн цэнэгтэй
- Зөөврийн төхөөрөмжийг холбогч кабель ашиглан цэнэглэж байгаа
- Цэнэглэх хэсэг болон зөөврийн төхөөрөмжийн завсар гадны биет

байгаа

- Цэнэглэх үед зөөврийн төхөөрөмж халсан
- Утасгүй цэнэглэгчийн ойр орчмын хэм 35°C (95°F)-с даван халсан
- Зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх талыг дээш харуулж тавьсан
- Цэнэглэх хэсэгт эвхэгддэг зэрэг жижиг зөөврийн төхөөрөмжийг буруу байрлуулсан
- Зөөврийн төхөөрөмж цэнэглэх тавиураас том
- Телевизийн цамхаг, цахилгаан станц, ШТС, радио станц, том оврын дэлгэц, нисэх буудал болон бусад хүчтэй радио болон цахилгаан соронзон долгион цацдаг байгууламжийн ойр орчимд
- Бүхээгт электрон түлхүүр байхгүй
- Дараах аль нэг зүйл зөөврийн төхөөрөмж болон цэнэглэх хэсгийн завсар хавчуулагдсан, орсон үед
 - Зузаан гэр, савтай үед
 - Цэнэглэх талыг тэгш бус гадаргатай байлгах, гэрийг хазгай угсарсан, ташуу хэмтэй гэртэй
 - Зузаан нэмэлт чимэглэлтэй
 - Хуруундаа хийн төхөөрөмжийг барих цагариг, оосортой гэр
- Зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх талд камер зэрэг нааш илүү гарсан бүтэцтэйгээс цэнэглэх хэсэг хооронд зай үүсэж байгаа
- Зөөврийн төхөөрөмж дараах эд зүйлтэй хүрсэн, халхлагдсан үед:
 - Хөнгөн цагаан хуулгатай зэрэг металлтай карт
 - Хөнгөн цагаан хуулгатай тамхины хайрцаг
 - Металл түрийвч, цүнх зэрэг
 - Зоос
 - Металл материалаар хийгдсэн өөрөө халдаг гар дулаацуулагч
 - CD, DVD болон бусад медиа
 - Металл чимэглэл, тоноглол
 - Металл хамгаалалтын гэр зэрэг
 - Зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх талд соронзтой дэлгэгддэг хамгаалалтын гэр

- Ойр орчимд электрон долгион ашигладаг алсын удирдлага ашиглагдсан үед
- Цэнэглэх тавиурт 2-с их зөөврийн төхөөрөмж байрлуулсан үед
- Дотроо S-Pen (Galaxy Note цуврал зэрэг) балтай зөөврийн төхөөрөмжийг S-Pen балтай нь тавиур дээр тавьсан үед

Цэнэглэлт хэвийн бус хийгдэх бусад аливаа шалтгаанаар индикатор анивчиж байгаа үед утасгүй цэнэглэгч доголдсон байж болно. Та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

■ Ухаалаг утасны үйлдлийн систем шинэчлэгдсэн үед

Ухаалаг утасны үйлдлийн систем шинэ хувилбараар шинэчлэгдсэн үед утасны цэнэглэлтийн техник үзүүлэлт бага зэрэг өөрчлөгдсөн байж болно. Дэлгэрэнгүйг гар утас үйлдвэрлэгчийн цахим хуудаснаас нягтална уу.

■ Барааны тэмдэгтийн мэдээлэл

- iPhone нь АНУ болон бусад улсад бүртгэлтэй Apple Inc-н барааны тэмдэгт болно.
- Galaxy нь Samsung Electronics Co., Ltd-д бүртгэлтэй барааны тэмдэгт болно.



АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үед

Аюулгүйн шаардлагын үүднээс жолооч цэнэглэж буй зөөврийн төхөөрөмжийг удирдах, ажиллуулахыг хориглоно.

■ Хөдөлгөөний үед

Аюулгүйн шаардлагын үүднээс жолооч цэнэглэж буй зөөврийн төхөөрөмжийг удирдах, ажиллуулахыг хориглоно.

■ Электрон төхөөрөмжид учруулах долгионы нөлөөллийн тухай анхааруулга

Дотуур суулгасан дефибриллятор, кардиостимулятор /зохиомлоор зүрхний хэмнэл удирдагч/ мөн бусад эмчилгээний электрон төхөөрөмжтэй хүн өөрийн эмчид хандаж утасгүй цэнэглэгч ашиглалттай холбоотой зөвлөгөө авна.

■ Системд доголдол үүсэх, түлэгдэж гэмтэхээс сэргийлэх

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд утасгүй цэнэглэгчид гэмтэл учруулах, гал авалцах, хэт халснаас шалтгаалан түлэгдэх, тогонд цохиулах аюултай.

- Цэнэглэх хэсэг болон зөөврийн төхөөрөмжийн завсар аливаа металл эд зүйл хийж болохгүй
- Цэнэглэх хэсэгт хөнгөн цагаан наалт эсвэл бусад металл эд зүйл нааж болохгүй
- Зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх тавиуртай харьцах гадаргууд (эсвэл хамгаалалтын гэрт) хөнгөн цагаан наалт эсвэл металл эд зүйл нааж болохгүй
- Цэнэглэх тавиурыг жижиг эд зүйл тавих тавиур болгон ашиглахгүй.
- Хүчтэй цохилтоос сэргийлнэ.
- Задлах, салгах, өөрчлөлт хийж болохгүй
- Зориулалтын биш зөөврийн төхөөрөмж цэнэглэж болохгүй
- Соронзтой эд зүйлс ойртуулахгүй
- Цэнэглэх хэсэг бохирдсон үед цэнэглэж болохгүй
- Даавуу зэргээр бүтээхгүй.




АНХААР

■ Дата мэдээлэл гэмтээх, ажиллагаагүй болгохоос сэргийлэх

- Утасгүй цэнэглэгч ашиглах үед соронзон орны нөлөөгөөр дата устах тул кредит карт зэргийн соронзон карт эсвэл соронзон бичлэгтэй медиа төхөөрөмжийг цэнэглэгчид ойртуулж болохгүй. Мөн бугуйн цаг зэргийн нарийн хийцтэй механизм нь эвдэрч болох тул ойртуулж болохгүй.
 - Замын IC карт зэрэг зайнаас ажилладаг IC картыг цэнэглэх хэсэг болон зөөврийн төхөөрөмжийн цэнэглэх талын завсар хийж болохгүй. IC чип хэт халж зөөврийн төхөөрөмж эсвэл IC карт гэмтэнэ. Зөөврийн төхөөрөмжийг хамгаалалтын гэрээс гаргалгүй цэнэглэх, төхөөрөмжид IC карт тогтоосон үед цэнэглэхээс сэргийлнэ.
 - Зөөврийн төхөөрөмжийг бүхээгт үлдээж болохгүй. Нартай үед бүхээг хэт халж төхөөрөмжид гэмтэл учруулах магадлалтай.
 - Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх
- Хөдөлгүүр унтраастай үед утасгүй цэнэглэгч удаан ашиглаж болохгүй.

Гарын түшлэг

Ашиглах үед доош буулгана.




**АНХААР****■ Гарын түшлэгийг гэмтлээс сэргийлэх**

Хэт их даралт учруулж болохгүй.

Арын хаалганы нарны хаалт (тоноглогдсон загварт)

Арын хаалганы нарны хаалтыг татаж гаргаад дэгээнд бэхэлнэ.

Буцааж эвхэх үед дэгээнээс мултлаад зөөлөн хураана.

**АЮУЛТАЙ****■ Арын хаалганы нарны хаалт**

● Нарны хаалт ашиглах үед хуруугаа дэгээ болон ховилд хийж болохгүй. Хуруу хавчуулагдаж гэмтэх аюултай.

● Аль нэг дэгээ хийгдээгүй үед нарны хаалт ашиглаж болохгүй.

Нарны хаалт мултарч гэмтэл бэртэлд хүргэх аюултай.

**АНХААР****■ Арын хаалганы нарны хаалтын хэвийн ажиллагааг хангах**

Дараах анхааруулгыг мөрдөнө.

**АНХААР**

● Нарны хаалт нээх хаах үед саад болох аливаа зүйл байрлуулж болохгүй.

● Нарны хаалт дээр аливаа эд зүйл байрлуулж болохгүй.

● Дэгээнд тогтоосон нарны хаалтыг хэт хүчээр татаж болохгүй.

● Арын хаалга нээгдэж хаагдах явцад нарны хаалттай харьцаж болохгүй.

● Нарны хаалтыг ташуу байрлалд эвхэхгүй.

Ташуу хадгалсан үед нарны хаалт хэлбэр алдана.

■ Арын хаалганы нарны хаалтыг гэмтлээс хамгаалах

Нарны хаалтыг гэмтэхээс сэргийлж дараах анхааруулгыг мөрдөнө:

● Дэгээнд ээрнарны хаалтаас өөр зүйл өлгөж болохгүй.


Дэгээ гэмтэж болно.

● Нарны хаалт дэгээнд өлгөөтэй үед хаалтаас татаж болохгүй.

Хаалт гэмтэж болно.

Хувцасны дэгээ

Хувцасны дэгээ 2-р эгнээний суудлын туслах бариулд байрладаг.



! АЮУЛТАЙ


■ Хувцасны дэгээнд тогтооход тохиромжгүй эд зүйлс

Хувцасны өлгүүр бусад хатуу, хурц өнцөгтэй зүйл дэгээнд өлгөхийг хориглоно. SRS хөшигөн аюулгүйн дэр дэлгэгдэх үед эдгээр нь шидэгдэж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

Туслах бариул

(А төрөл) Суух үед биеийн тэнцвэрээ хадгалах зориулалтаар ашиглана.

(В төрөл) Бууж суух үед ашиглана.



A Туслах бариул (А төрөл)

B Туслах бариул (В төрөл)

! АЮУЛТАЙ

■ Туслах бариул (А төрөл)

Туслах бариулыг бууж суух, суудлаас босох үед ашиглаж болохгүй.

! АНХААР

■ Туслах бариулын эвдрэл гэмтлээс сэргийлэх

Эвдрэл гэмтлээс сэргийлж туслах бариулд хүнд зүйл өлгөх болон байрлуулж болохгүй.

Засвар үйлчилгээ ба арчилгаа

6

6-1. Засварүйлчилгээбаарчилгаа

Автомашины гадна талыг
цэвэрлэх, хамгаалах ...476

Автомашины дотор талыг
цэвэрлэх, хамгаалах ...479

6-2. Засвар үйлчилгээ

Засвар үйлчилгээнд
тавигдах шаардлага482

Хуваарьт засвар үйлчилгээ
.....484

6-3. Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээ

Өөрөө хийх засвар
үйлчилгээний анхааруулга
.....491

Капот493

Хөдөлгүүрийн хэсэг494

Дугуй.....504

Дугуйны хийн даралт513

Обуд514

Салоны агаар шүүгч.....516

Электрон түлхүүрийн зай
.....517

Гал хамгаалагч шалгах,
солих
.....520

Гэрлийн ламп.....522

Автомашины гадна талыг цэвэрлэх, хамгаалах

Автомашиныг хамгаалах, зөв нөхцөлд хадгалах үүднээс дараах арга хэмжээг авна:

Цэвэрлэх зааварчилгаа

- Дээрээс доош чиглэлд угаах ба их бие, шаврын хаалт, доод талыг их хэмжээний усаар угааж тоос шавраас нь салгана.
- Автомашины их биеийг зөөлөн пролон эсвэл илгэн алчуур зэрэг зөөлөн алчуураар арчина.
- Цэвэрлэхэд хүндрэлтэй толбо, бохирдлыг авто угаалгын саван ашиглан цэвэрлэх ба усаар сайтар арилгана.
- Үлдсэн усыг арчиж авна.
- Уснаас хамгаалах гадаргуу муудсан үед ваксдана.

Угааж цэвэрлэсэн гадаргуу дээр ус бөнгөнөж тогтохгүй байвал кузов хүйтэн үед автомашиныг ваксдана.

■ Өөрөө эдгэдэг гадаргуу

Автомашины гадаргуу нь автомашин угаалга зэргээс үүдсэн бага зэргийн сэвд тэсвэртэй өөрөө эдгэдэг гадаргуутай.

- Гадаргуу нь үйлдвэрээс нийлүүлэгдсэнээс хойш 5-8 жил болдог.
- Сэвийн гүн, гадна агаарын хэм зэргээс хамаарч эдгэх хугацаа янз бүр байна. Бүлээн усаар гадаргууг халаагаад байвал эдгэх хугацаа богиносно.

- Түлхүүр, зоос зэргээс үүссэн гүн сэв эдгэрэхгүй.
- Үрэгч материал агуулсан вакс ашиглаж болохгүй.

■ Автомат авто угаалгын газар

- Автомашиныг угаалгахын өмнө:
 - Толгийг эвхэж хураана
 - Тээшний автомат хаалгыг унтраана
- Урд талаас нь эхэлж угаана.

Хөдөлгөөн эхлэхийн өмнө хураасан толгийг дэлгэнэ.

- Автомат авто угаалгын сойз автомашины арьс, эд ангид (обуд г.м.) хортон суулгах, будагт гэмтэл учруулж болзошгүй.
- Арын спойлерыг зарим автомат угаалгын газарт угаах боломжгүй байдаг. Автомашинд гэмтэл учруулах эрсдэл нэмэгддэг.

■ Өндөр даралтын авто угаалга

- Ус бүхээгт орж болох тул авто угаалгын шүршигч хошууг цонх, хаалганд хэт ойртуулах, эдгээр хэсгүүд рүү удаан шүршихгүй.
- Явах эд ангийн (дифференциалын араа зэрэг) холхивч болон тосолгооны жийргэвч рүү өндөр даралтын хошууг хэт ойртуулж болохгүй.

Эд ангид ус нэвтэрсэн үед товуудыг угаах, улмаар эд ангийн тосолгоог алдагдуулна.

■ Обуд (матт будаггүй обудтай автомашин)

- Шавар, бохирдлыг саармаг цэвэрлэгээний бодисоор даруй цэвэрлэнэ
- Цэвэрлэгээний бодис ашигласны дараа нэн даруй угааж арилгана.
- Будгийг гэмтлээс хамгаалах үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө.
 - Хүчиллэг, шүлтлэг эсвэл үрэгч бодис ашиглаж болохгүй.
 - Хатуу сойз, зүлгүүр ашиглаж болохгүй.
 - Цаг агаар халуун үед эсвэл хол замд халсан зэрэг шалтгаанаар дугуй халсан үед цэвэрлэгээний бодис ашиглахыг хориглоно.

■ Хөнгөн цагаан обуд (матт будагтай обудтай автомашин)

Матт будагтай обуд нь энгийн хөнгөн цагаан обуднаас өөр аргаар цэвэрлэгээ хийхийг шаарддаг тул цэвэрлэгээ хийх үед дараах анхааруулгыг мөрдөнө. Дэлгэрэнгүйг та өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

- Шавар бохирдлыг усаар цэвэрлэнэ. Хэрэв обуд их бохирдсон үед саармаг цэвэрлэгээний бодисоор норгосон пролон, зөөлөн даавуу ашиглана.
- Цэвэрлэгээний бодис ашиглах үед усаар даруй угааж арилгана. Зөөлөн даавуугаар үлдэгдэл усыг арчина.
- Матт будгийг гэмтлээс хамгаалах үүднээс дараах анхааруулгыг мөрдөнө:
 - Хатуу сойз, хуурай даавуу ашиглаж үрж болохгүй
 - Аливаа обуд өнгөлөгч эсвэл үрэгч бодис ашиглаж болохгүй
 - Автомат автомашин угаалга ашиглах үед угаах төхөөрөмжийн обуд зүлгэх функцийг унтраана (тус функцтэй төхөөрөмжид)
 - Өндөр даралтын эсвэл уурын авто угаалга ашиглаж болохгүй
 - Цаг агаар халуун үед эсвэл хол замд халсан зэрэг шалтгаанаар дугуй халсан үед цэвэрлэгээний бодис ашиглахыг хориглоно

■ Тоормосны хавчигч аппаратын өнгөлгөө

- Цэвэрлэгээний бодис ашиглах үед саармаг бодис ашиглана. Өнгөлгөөг гэмтээх тул хатуу зүлгүүр, үрэгч бодис ашиглаж болохгүй.
- Хавчигч аппарат халуун үед цэвэрлэгч бодис ашиглаж болохгүй.
- Цэвэрлэгээний бодис ашигласан даруйд угааж цэвэрлэнэ.

■ Тоормосны наклад ба хавчигч аппарат

Тоормосны наклад болон диск нойтон байдалтай автомашиныг зогсоолд байрлуулсан үед зэв үүсэж наклад ба диск наалдаж болно. Автомашин угаасны дараа зогсоолд байрлуулахаас өмнө тодорхой зайнд жолоодож тоормос хэд хэдэн удаа ажиллуулна.

■ Гупер, хаалганы хажуу кант

Зүлгүүрээр зүлгэхийг хориглоно.

■ Завсар ховилууд

Бохирдол арилахгүй үед дараах байдлаар цэвэрлэнэ:

- 5% хувийн агууламжтай саармаг цэвэрлэгээний бодисыг зөөлөн даавуунд уусган цэвэрлэх ба усаар бодисыг угаана.
- Үлдсэн чийгийг хуурай, зөөлөн даавуугаар арчина.
- Тосорхог давхарга тогтсон үед спиртийн агууламжтай нойтон салфетка эсвэл ижил төрлийн бүтээгдэхүүн ашиглаж цэвэрлэнэ.

■ Smart entry & start системийн санамж

- Электрон түлхүүр таних хүрээнд байгаа ба хаалганы бариул норсон үед хаалга түгжигдэх болон тайлагдаж болно. Энэ тохиолдолд автомашин угаах үед дараах арга хэмжээ авна:
 - Электрон түлхүүрийг 2м (6 фут) зайд байрлуулах эсвэл автомашин угаалгын үед түлхүүрийг тусад нь байлгах зүйтэй. (Түлхүүр хулгайд алдахаас сэргийлнэ.)
 - Электрон түлхүүрийг зайны цэнэг хэмнэх горимд тохируулж smart entry & start системийг цуцална. (→X.144)
- Электрон түлхүүр автомашин дотор байгаа ба автомашин угаах явцад хаалганы бариул норсон үед мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах ба автомашины гадна талд дуут дохио дуугарна. Дохиог унтраах үед хаалга түгжинэ.



АЮУЛТАЙ

■ Автомашин угаах үед


Хөдөлгүүрийн хэсэгт ус хүргэж болохгүй. Электрон төхөөрөмж зэрэгт галын аюул үүсэх аюултай.

▲ АЮУЛТАЙ

■ Салхинышилугаажцэвэрлэхүед

Шил арчигчийн хөшүүргийг off болгоно.

Шил арчигчийг “AUTO” болгон тохируулсан үед дараах тохиолдлуудад шил арчигч гэнэт ажиллаж гараа хавчуулах мөн бусад ноцтой гэмтэл учруулах аюултайгаас гадна шил арчигч эвдэрч болзошгүй.



A Off

B AUTO

- Салхины шилний борооны мэдрэгч байрлах дээд талд гараар хүрсэн үед
- Бороо мэдрэгчийн ойролцоо нойтон алчуур зэрэг зүйл барьсан үед
- Салхины шил дээр аливаа эд зүйл унах, цохих үед
- Борооны мэдрэгчийн их биед гараар хүрэх эсвэл мэдрэгчийг аливаа эд зүйл цохих, мөргөх үед

■ Яндантай холбоотой анхааруулга

Хөдөлгүүрийн ажилласан хий нь янданг өндөр хэмд халаадаг.

Халуун янданд түлэх аюултай тул автомашин угаах үед яндан хангалттай хэмжээнд хөрөх хүртэл гүрч болохгүй.

■ BSM системтэй хойд гуперын анхааруулга (тоноглогдсон загварт)

Хойд гуперын дээд талын будаг ховхорсон, хортон суусан үед систем хэвийн ажиллахгүй байж болно. Энэ үед та өөрийн Lexus дилерт хандаж зөвлөгөө авна уу.

▲ АНХААР

■ Будаг муудах, их бие, эд ангиуд (хөнгөн цагаан хайлшин обуд зэрэг) зэврэхээс сэргийлэх

- Дараах тохиолдолд автомашиныг нэн даруй угаана:

- Далайн ойр орчмоор явсны дараа
- Давс цацсан замаар явсны дараа
- Будагт тортог, модны шүүс, давирхай зэрэг наалдсан үед
- Будган дээр хорхой шавьж наалдсан, шувуу, хорхой шавьжны баас унасан үед
- Уурхайн тоос, нунтаг төмөр, химийн бодис, хөө тортогтой болон тосорхог утааны бохирдолтой газраар явсны дараа
- Тоос, шавар ихээр наалдсан үед
- Бензин, бензол зэргийн шингэн бодис будган дээр асгарсан үед

- Хэрэв будаг зурагдсан, хортон суусан бол даруй засуулна.

- Дугуйн обудыг хадгалах үед обудны зэврэлтээс сэргийлж бүх шавар тоосыг цэвэрлэж чийгшилт багатай орчинд хадгална.

■ Гадна гэрэл цэвэрлэх

- Анхаарал болгоомжтой угаана. Угааж цэвэрлэх үедээ аливаа органик эд зүйлс, хатуу сойзоор зүлгэхийг хориглоно. Энэ нь гэрлийн гадаргууг гэмтээх аюултай.

- Гэрлийн гадаргууд вакс түрхэхийг хориглоно. Энэ нь гэрлийн линзийг гэмтээх аюултай.



АНХААР

■ **Автомат авто угаалга ашиглах үед**

Шил арчигчийг off унтраана. Хөшүүрэг “AUTO” байрлалд байгаа үед шил арчигч ажиллаж эвдрэх аюултай.

■ **Өндөр даралтын авто угаалгаар автомашин угаалгах үед**

● Өндөр даралттай ус камер (тоноглогдсон автомашинд) эсвэл камерын ойр орчмыг шүршихээс зайлсхийнэ. Өндөр даралттай уснаас ирэх цохилт, доргилтоос системийн хэвийн ажиллагаа алдагдах аюултай.

● Автомашины эмблемийн ард байрлах радар луу ус шууд шүршиж болохгүй. Төхөөрөмжийг гэмтээх аюултай.

● Даралтын хошууг жийрэг (резин, каучук материалаар хийгдсэн таг), холбох эд ангиуд болон дараах эд ангиудад ойртуулж болохгүй. Өндөр даралттай усны нөлөөгөөр эд ангиудад гэмтэл үүсэж болно.

- Хүч дамжуулах ангийн эд анги
- Жолооны механизмын эд анги
- Амортизатортай холбоотой эд анги
- Тоормосны эд анги

● Шүршигч хошууг автомашины их биеэс 30 см (11.9 инч)-с зайтай барина. Эсрэг тохиолдолд резин эд анги, гүпер гэмтэх, хэлбэр өөрчлөгдөх аюултай.

● Салхины шилний доод тал руу удаан шүршиж болохгүй. Агааржуулалтын системийн сорох хоолой салхины шилний доод талд байрлах ба системийн хэвийн ажиллагаа алдагдах аюултай.

● Өндөр даралтын автомашин угаагчаар автомашины доод талыг угааж болохгүй.

Автомашины дотор талыг цэвэрлэх, хамгаалах

Салоныг цэвэрлэх үед тухайн эд анги, материал бүрд тохирсон цэвэрлэгээ хийнэ.

Автомашины дотор талыг хамгаалах

- Тоос сорогчоор шороо тоосыг соруулна. Бүлээн усанд дүрж мушгисан алчуураар бохирдсон гадаргууг арчина.
- Алчуураар арчиж цэвэрлэх боломжгүй бохирдлыг саармаг цэвэрлэгээний бодисын 1 хувийн уусмал шингээсэн алчуураар арчина. Алчуураа сайтар мушгиж салонд үлдсэн цэвэрлэгээний бодис, усны үлдэгдлийг гүйцэд арчиж авна.

■ Хивс угаалгын шингэнээр хивсэнцэр цэвэрлэх

Хивс угаалгын хөөсөрдөг шингэн байдаг бөгөөд пролон, сойз ашиглан тойрог хэлбэрээр зүлгэж угаана. Хивсэнцэр цэвэрлэх үед ус ашиглахгүй бөгөөд хивсэнцрийг аль болох хуурай байлгаснаар илүү удаан ашиглах боломжтой.

■ Аюулгүйн бүс

Даавуу, пролон ашиглан зөөлөн савантай бүлээн усаар цэвэрлэнэ. Мөн аюулгүйн бүс хэт элэгдсэн, үрэгдэж сэтэрсэн зэргийг тогтмол шалгана.



АЮУЛТАЙ

■ Бүхээгт ус ашиглах

- Автомашины бүхээгт шингэн зүйл асгах, цацахыг хориглоно. Цахилгааны эд ангиудад доголдол үүсэх, гал түймэрт хүргэх аюултай.
- SRS аюулгүйн дэр, цахилгаан утас норгохгүй. (→Х.38) Цахилгааны доголдол үүсэж аюулгүйн дэр дэлгэгдэх, ажиллагаа алдагдаж эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулна.
- Утасгүй цэнэглэгчтэй автомашин: Утасгүй цэнэглэгчийг (→Х.466) норгож болохгүй. Цэнэглэгч халж галын аюул үүсгэх эсвэл тог цохиж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болно.

■ Салон цэвэрлэх (ялангуяа хянах самбар, урд тал)

Вакс, өнгөлгөөний бодис ашиглахгүй. Урд хэсгийг өнгөлснөөр салхины шилэнд ойж жолоочийн нүдийг гялбуулах улмаар эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.



АНХААР

■ Цэвэрлэгээний бодис

- Дараах нь өнгө алдагдуулах, будагт хортон суулгах, гэмтэл учруулах тул ашиглаж болохгүй:
 - Суудлаас бусад хэсэгт: Бензол болон бензин зэргийн органик нэгдэл, хүчиллэг, шүлтлэг уусмал, цайруулагч болон өнгө оруулагч
 - Жолооны хүрд: Шингэлэгч, спирттэй цэвэрлэгээний бодис зэрэг органик нэгдэл
- Өнгөлгөөний вакс, бодис ашиглахыг хориглоно. Хянах самбар, салоны бусад хэсгийн будагтай гадаргууг гэмтээх аюултай.

■ Арьсан гадаргууг хамгаалах

Арьс гэмтэх, муудахаас сэргийлж дараах анхааруулгыг мөрдөнө:

- Арьсан гадаргуугаас аливаа бохирдлыг даруй цэвэрлэнэ
- Нарны гэрэл шууд тусах газарт удаан хугацаанд зогсоож болохгүй. Ялангуяа зуны улиралд сүүдэр газар зогсооно.
- Бүхээг халах үед суудал дээр винил, хуванцар эсвэл вакс агуулсан эд зүйл орхивол арьсан гадаргууд наалдаж болох тул орхихгүй.

■ Шал усаар угаах

Автомашины шалыг усаар угаахыг хориглоно.

Шалны дээд болон доод талд байрлах аудио системийн электрон төхөөрөмж зэрэгт ус хүрсэн үед электрон системд гэмтэл үүсэх аюултай. Мөн ус автомашины их биед зэврэлт үүсгэж болзошгүй.

■ Салхины шилний дотор талыг цэвэрлэх үед

Линзэнд шил цэвэрлэгч хүргэж болохгүй. Мөн линзэнд гараар хүрэхийг хориглоно. (→Х.237)

■ Хойд цонхны шилний дотор талыг цэвэрлэх

- Хойд шилний цан арилгагчийн халаагч болон антен гэмтээх аюултай тул хойд цонхны шилийг шил цэвэрлэгч ашиглан цэвэрлэж болохгүй. Бүлээн усаар норгосон даавуугаар зөөлөн арчиж цэвэрлэнэ. Шилийг халаагч, антены дагуу арчиж цэвэрлэнэ.
- Халаагч, антеныг гэмтээх, зурахаас сэргийлнэ.

Никель, металл гадаргууг цэвэрлэх

- Бохирдлыг нойтон даавуу эсвэл нийлэг илгэн алчуураар

арчиж цэвэрлэнэ.

- Гадаргууг хуурай зөөлөн даавуугаар арчиж үлдэгдэл чийгийг авна.

■ Никель, металл гадаргууг цэвэрлэх

Никель, металл гадаргуу нь бодит металл ашигласан тул тогтмол цэвэрлэж байх шаардлагатай. Хэрэв бохирдсон гадаргууг удаан хугацаанд цэвэрлээгүй үед бүрэн цэвэрлэгдэхгүй болно.

Арьсан бүрээс, доторлогоог цэвэрлэх

- Тоос сорогч ашиглан тоос, бохирдлыг цэвэрлэнэ.
- Үлдсэн тоос шороог цэвэрлэгээний бодисын уусмал шингээсэн алчуураар арчиж авна.

Бөс даавуунд зориулагдсан саармаг цэвэрлэгээний бодисын 5 орчим хувийн уусмал ашиглана.

- Алчуураа сайтар мушгиж салонд үлдсэн цэвэрлэгээний бодис, усны үлдэгдлийг арчиж авна.
- Үлдсэн чийгийг хуурай, зөөлөн алчуураар арчиж авна. Арьсан гадаргууг нарны гэрлийн шууд тусгалгүй, агааржуулалттай газар хатаана.

■ Арьсан бүрээс, доторлогоог арчлах талаар

Автомашинны салоны чанарыг хэвээр хадгалахын тулд Lexus-н зүгээс салоныг жилд 2 ба түүнээс олон удаа

цэвэрлэхийг зөвлөж байна.

Нийлэг арьсан бүрээс, доторлогоог цэвэрлэх

- Тоос сорогч ашиглан тоос, бохирдлыг цэвэрлэнэ.
- Нийлэг арьстай хэсгийг саармаг цэвэрлэгээний бодисын 1 хувийн уусмал шингээсэн алчуураар арчина.
- Алчуураа сайтар мушгиж цэвэрлэгээний бодис, усны үлдэгдлийг гүйцэд арчиж авна.

Засвар үйлчилгээнд тавигдах шаардлага

Аюулгүй бөгөөд эдийн засагт хэмнэлттэй байдлаар автомашиныг ашиглахын тулд өдөр тутмын арчилгаа болон засвар үйлчилгээ зайлшгүй шаардлагатай. Lexus нь дараах засвар үйлчилгээ хийхийг зөвлөж байна:



АЮУЛТАЙ

■ Автомашины засвар үйлчилгээг зөв хийгээгүй үед

Автомашины засвар үйлчилгээг зөв хийгээгүй тохиолдолд автомашиныг эвдрэл гэмтэлд хүргэх мөн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

■ Аккумулятортай харьцах үеийн техникийн аюулгүй байдал

Аккумуляторын шон, зажим болон бусад эд ангиуд нь хүний тархи гэмтээдэг хар тугалга болон хар тугалганы орцтой эд ангиудаас бүрддэг. Тиймээс аккумулятортай харьцсаны дараа гараа сайтар угаана. (→X.499)

Хуваарьт засвар үйлчилгээ

- Хуваарьт засвар үйлчилгээ хуваарийн дагуу тогтсон давтамжтай хийж гүйцэтгэнэ.

Хуваарьт засвар үйлчилгээ хийх давтамжийг одометрийн гүйлт эсвэл хугацааны аль нэг нь засварын хуваарьт заасан хэмжээнд хүрэх үед хийж гүйцэтгэнэ.

Дараагийн засвар үйлчилгээг өмнөх засвартай адил гүйлт, хугацааны

давтамжаар хийж гүйцэтгэнэ.

- Засвар үйлчилгээг хаана хийлгэх вэ?

Автомашины засвар үйлчилгээ, үзлэг оношилгоо хийлгэх үед та тухайн орон нутаг дахь Lexus дилерт хандах нь зүйтэй.

Lexus-н засварчид нь тогтмол түгээгдэн ирдэг мэдээлэл авдаг, дилерийн сургалтын хөтөлбөрт хамрагдах зэргээр сүүлийн үеийн засвар үйлчилгээний мэдээлэл, өндөр мэдлэг бүхий мэргэжилтнүүд юм. Сурангаа засвар хийх биш Lexus дээр сурах зүйлээ сурч мэдсэний дараа таны автомашины засвар үйлчилгээг хийдэг тул тэдэнд даатгах нь зөв юм.

Таны Lexus дилер нь засвар үйлчилгээгээ хийж гүйцэтгэхийн Lexus-н тусгай засварын багаж, тоног төхөөрөмжид ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байдаг. Энэ нь ажлын үр дүнг сайжруулж зардлыг бууруулдаг.

Таны Lexus дилерийн засвар үйлчилгээний албаны мэргэжилтнүүд таны автомашинд хийгдэх бүх хуваарьт засвар үйлчилгээг найдвартай, бага зардлаар хийнэ.

Резин хоолой, шланг (хөргөлтийн болон халаалтын систем, тоормос болон шатахууны систем)-г мэргэжлийн үнэмлэх бүхий засварчид Lexus-н засварын хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Резин хоолой, шланг нь засвар хийх шаардлагатай чухал эд анги юм. Гэмтсэн, муудсан резин хоолойг даруй солиулна уу. Резин хоолой нь цаг хугацааны явцад мөн мушгигдах, үрэгдэх, хагарах зэргээр мууддаг

болохыг анхаарна уу.

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээ

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээ гэж юу вэ?

Олон засвар үйлчилгээг бага хэмжээний техникийн мэдлэг болон автомашины ерөнхий засварын багажтай үед та өөрөө хийх боломжтой байдаг.

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээг номын энэ хэсэгт ойлгомжтой тайлбарлаж байна.

Зарим засвар үйлчилгээ тусгай багаж болон мэргэжлийн мэдлэг шаарддаг тул мэргэжлийн засварчнаар хийлгэх нь зүйтэй. Та өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээг хийж сурсан, дадсан байсан ч засварын түүхийг хадгалж үлддэг Lexus дилерт хандаж автомашины засвар үйлчилгээг хийлгэхийг танд зөвлөж байна. Энэ засварын түүх нь үйлдвэрлэгчийн баталгаат хугацааны засвар үйлчилгээ хийлгэх үед танд тустай мэдээлэл юм.

■ Таны автомашинд засвар хийх шаардлагатай болоод байна уу?

Засвар үйлчилгээ хийх шаардлагатай болсныг илтгэх хөдөлгүүрийн хэвийн бус дуу бусад нүдэнд харагдах өөрчлөлтүүдийг анхаарч мэднэ. Зарим чухал шинж тэмдгүүд:

- Хөдөлгүүрийн галын тохиргоо алдагдах, цохио үүсэх
- Хөдөлгүүр хүчгүй болох
- Хөдөлгүүрийн хэвийн бус дуу чимээ
- Автомашин доор шингэн асгарсан байх (эйр кондишноос гоожиж байгаа тохиолдолд хэвийн)

● Яндангийн дуу өөрчлөгдөх (Энэ нь хортой нүүрсхүчлийн хий алдагдаж байгааг илэрхийлэх тохиолдолд байдаг. Цонхоо нээсэн байдалтай хөдөлгөөнөө үргэлжлүүлж яндангаа нэн даруй үзүүлэх шаардлагатай.)

● Дугуйны хий гарсан юм шиг харагдах, эргэлт хийх үед дугуй хэт их чохорч дуугарах, дугуй тэгш бус элэгдэх

● Тэгш зам дээр шулуун явах үед автомашин нэг тал руугаа даялах

● Амортизатор ажиллах үеийн хэвийн бус дуу

● Тоормосны хүч алдагдах, тоормос болон консны дөрөө зөөлөн болох, дөрөө шаланд тултал гишгэгдэх, тоормослох үед автомашин нэг тал руугаа чирэх

● Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэм хэт халах (→Х.93)

● Хөдөлгүүр байнга халах, хөдөлгүүрийн тосны даралт бага заах

Хэрэв таны автомашинд дээрх шинж тэмдгүүд илэрч байгаа тохиолдолд нэн даруй өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа үзүүлнэ үү. Таны автомашинд тохиргоо эсвэл засвар хийх шаардлагатай болсон байж болзошгүй.

Хуваарьт засвар үйлчилгээ

Хуваарьт засвар үйлчилгээг дараах байдлаар хийнэ:

Хуваарьт засвар үйлчилгээ хийх хэрэгцээ шаардлага

Автомашины засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. ("Засварын хуваарь"-г харна уу.)

Таны автомашины ашиглалтын нөхцөл дараах аль нэг эсвэл хэд хэдэн нөхцөлд хамаарах үед автомашины зарим нэг засвар үйлчилгээг илүү богино давтамжтай хийх шаардлагатай. (Засварын нэмэлт хуваарь"-г харна уу.)

A. Замын нөхцөл 1. Бартаатай, шавартай эсвэл хайлсан цастай зам. 2. Тоос шороотой зам (Зам хатуу хучлагагүй эсвэл хуурай үед шороо тоос их босдог). 3. Давс цацсан зам.	B. Жолоодлогын нөхцөл 1. Хүнд ачаатай (Жишээ нь: Чиргүүл, аяны чиргүүл чирэх (чирэх дэгээтэй), дээвэр дээрээ ачаа ачих г.м.). 2. Удаан нормалдах эсвэл цагдаа, такси, хүргэлтийн үйлчилгээний гэх мэт байнгын ажиллагаатай автомашин. 3. Өндөр хурдаар (автомашины дээд хурдны 80% ба түүнээс дээш хувьтай дүйцэх хурд) 2-с дээш цаг явах
---	---

Засварын хуваарь

Засварын агуулга:

C = Цэвэрлэх

I = Шалгах, засах, шаардлагатай үед солих

L = Тослох

R = Солих эсвэл тослох

T = Зохих хүчээр чангалах

ЗАСВАР ХИЙХ ДАВТАМЖ:		ОДОМЕТРИЙН ЗААЛТ								cap
(Одометрийн заалт эсвэл сарын аль нэг түрүүлж хүрсэн үед)	x1000 км	10	20	30	40	50	60	70	80	
	x1000 миль	6	12	18	24	30	36	42	48	
ХӨДӨЛГҮҮРИЙН ҮНДСЭН ЭД АНГИ										
1	Духны ремень		I		I		I		I	24
2	Хөдөлгүүрийн тос	Засвар үйлчилгээний сануулга гарч ирэх үед солино. <<Тэмдэглэл 1.>>								
3	Хөдөлгүүрийн тосны шүүр	Засвар үйлчилгээний сануулга гарч ирэх үед солино. <<Тэмдэглэл 1.>>								
4	Хүйтэн, халуунаар үлээх систем <<Тэмдэглэл 2.>>				I				I	24
5	Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэн (intercooler-н шингэн) <<Тэмдэглэл 3.>>				I				I	-
6	Яндангийн хоолой, бэхэлгээ		I		I		I		I	12
АСААХ СИСТЕМ										
7	Очлуур						R			-
8	Аккумулятор	I	I	I	I	I	I	I	I	12
ШАТАХУУН БОЛОН ХАЯГДАЛ УТААНЫ ХЯНАЛТЫН СИСТЕМ										
9	Бензин шүүр								R	96
10	Хавхалганы механизм <<Тэмдэглэл 4 ба 5.>>	10000 км тутамд инжектор цэвэрлэгчийг шатахууны саванд хийнэ.								-
11	Шатахуун цацах систем <<Тэмдэглэл 4 ба 6.>>	10000 км (6000 миль) тутамд инжектор цэвэрлэгчийг шатахууны саванд хийнэ.								-
12	Агаар шүүгч		I		R		I		R	I: 24 R: 48
13	Шатахууны савны таг, хоолой, холбоос, ууршилт хянах хавхлаг <<Тэмдэглэл 2.>>				I				I	24
14	Нүүрсэн шүүр				I				I	24
ЯВАХ ЭД АНГИ БОЛОН ИХ БИЕ										

ЗАСВАР ХИЙХ ДАВТАМЖ:		ОДОМЕТРИЙН ЗААЛТ								сар
(Одометрийн заалт эсвэл сарын аль нэг түрүүлж хүрсэн үед)	x1000 км	10	20	30	40	50	60	70	80	
	x1000 миль	6	12	18	24	30	36	42	48	
33	Гэрэл, дуут дохио, шил арчигч болон шингэн	I	I	I	I	I	I	I	I	6
34	Салоны агаар шүүгч		R		R		R		R	-

Тэмдэглэл:

1. Хөдөлгүүрийн тос болон тосны шүүрийг засварын сануулга гарахгүй байсан ч 12 сарын дараа эсвэл 10000 км (6000 миль)-т солих. Шороо тоостой орчин, замын нөхцөлд ашиглагддаг автомашины хувьд засварын сануулга 10000 км (6000 миль) хүрээгүй байхад гарч болно. Шороо тоостой орчинд ашиглагддаг автомашины хөдөлгүүрийн тос болон тосны шүүрийг 5000 км (3000 миль)/ 6 сар тутам засварын сануулга гарахаас өмнө солих.

5. Эхний удаа 80000 км (48000 миль)/ 48 сар, дараа нь 20000 км (12000 миль)/ 12 сар тутамд шалгах.

6. Эхний удаа 160000 км (100000 миль), дараа нь 80000 км (48000 миль) тутам солих.

4. Тоёотагийн оригинал эсвэл дүйцэх чанартай инжектор цэвэрлэгч,

5. Зөвхөн Филиппин, Малайз улс

6. Коста Рика, Гватемал, Гондурас, Панам, Боливи, Перу, Азербайжан, Армени, Киргиз, Бруней, Монгол

7. Зогсоолын тоормосны үзлэг шаардлагагүй

8. Вакум насосын ир болон ирний тагийг шинээр солих ба хуучин ир, ирний тагийг дахин ашиглаж болохгүй.

9. Ус туулсан, ус хүрсэн үед 24 цагийн дотор тосолно.

Засварын нэмэлт хуваарь

Ашиглалтын нөхцөлөөс хамаарч дараах засвар үйлчилгээг илүү богино хугацаанд хийх шаардлагатай (Дэлгэрэнгүйг “Засварын хуваарийн шаардлага”-с харна уу).

А-1: Бартаатай, шавартай, хайлмаг цастай зам	
Тоормосны наклад, диск шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Тоормосны трубка, шланг шалгах*	10000 км (6000 миль), 6 сар тутам

А-1: Бартаатай, шавартай, хайлмаг цастай зам	
Хөтлөх голын гармошка резин шалгах*	10000 км (6000 миль), 12 сар тутам
Хүч дамжуулах ангийн тос солих	40000 км (24000 миль)/ 48 сар тутам
Кардан гол тослох <<Тэмдэглэл 1.>>	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Кардан гол чангалах	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Кардан голын гармошка резин шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Жолооны хүрд, холбоос, аппарат шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Урд болон хойд амортизатор шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Араам, их биеийн боолт гайк чангалах <<Тэмдэглэл 2.>>	10000 км (6000 миль), 6 сар тутам

* : Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

А-2: Тоос шороо ихтэй зам (Хатуу хучилт багатай эсвэл тоос их босдог зам)	
Агаар шүүгч шалгах* эсвэл солих (тоноглогдсон загварт агаар сорох хоолой)	I: 10000 км (6000 миль)/ 12 сар тутам R: 40000 км (24000 миль)/ 48 сар тутам
Тоормосны наклад, диск шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Хүч дамжуулах ангийн тос	40000 км (24000 миль)/ 48 сар тутам
Кардан голын тосолгоо <<Тэмдэглэл 1.>>	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Кардан голын боолт чангалах	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Кардан голын гармошка резин шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Салоны агаар шүүгч солих	15000 км (9000 миль)

* : Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

А-3: Давс цацсан зам дээр ашиглах үед	
Кардан голын тосолгоо <<Тэмдэглэл 1.>>	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Кардан голын боолт чангалах	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Кардан голын гармошка резин шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам

* : Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

В-1: Хүнд ачаатай (Жишээ нь: Чиргүүл, аяны чиргүүл чирэх (чирэх дэгээтэй), дээвэр дээрээ ачаа ачих г.м.).	
Тоормосны наклад, диск шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Автомат хурдны хайрцгийн шингэн шалгах* эсвэл солих	I: 40000 км (24000 миль)/ 24 сар тутам R: 80000 км (48000 миль)/ 48 сар тутам
Хүч дамжуулах ангийн тос солих	40000 км (24000 миль)/ 48 сар тутам
Урд дифференциалын тос солих	20000 км (12000 миль)/ 24 сар тутам
Хойд дифференциалын тос солих	20000 км (12000 миль)/ 24 сар тутам
Кардан голын тосолгоо <<Тэмдэглэл 1.>>	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Кардан голын боолт чангалах	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Кардан голын гармошка резин шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Урд болон хойд амортизатор шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Явах эд анги болон их биеийн боолт чангалах <<Тэмдэглэл 2.>>	10000 км (6000 миль)/ 6 сар тутам

* : Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

В-2: Гадна агаарын хасах хэмд 8 км (5 миль) хүртэлх богино зайд тогтмол ашиглагддаг. (Хөдөлгүүр ажиллагааны хэвийн хэмд хүрэхгүй.)	
Тоормосны наклад, диск шалгах*	5000 км (3000 миль)/ 3 сар тутам
Автомат хурдны хайрцгийн шингэн шалгах* эсвэл солих	I: 40000 км (24000 миль)/ 24 сар тутам R: 80000 км (48000 миль)/ 48 сар тутам

* : Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

В-3: Өндөр хурдаар (автомашины дээд хурдны 80% ба түүнээс дээш хувьтай дүйцэх хурд) 2-с дээш цаг явах	
Автомат хурдны хайрцгийн шингэн шалгах* эсвэл солих	I: 40000 км (24000 миль)/ 24 сар тутам R: 80000 км (48000 миль)/ 48 сар тутам
Хүч дамжуулах ангийн тос солих	40000 км (24000 миль)/ 48 сар тутам
Урд дифференциалын тос солих	20000 км (12000 миль)/ 24 сар тутам
Хойд дифференциалын тос солих	20000 км (12000 миль)/ 24 сар тутам

* : Шаардлагатай тохиолдолд засварлах буюу солино.

Тэмдэглэл:

1. Ус туулсан, ус хүрсэн үед 24 цагийн дотор тосолно.

2. Суудлын бэхэлгээний боолт, явах эд ангийн бэхэлгээний боолт, нумын стремян боолтод хамаарна.

Өөрөө хийх боломжтой засвар үйлчилгээний анхааруулга

Та засвар үйлчилгээгээ бие даан хийх үед номын энэ хэсэгт заасан зааварчилгааны дарааллыг баримтална.

Засвар үйлчилгээ

Хийх зүйл	Сэлбэг, багаж зэрэг
Аккумулятор (→X.499)	- Халуун ус - Хүнсний сода - Товууд - Түлхүүр (зажимны боолтод ашиглах) - Нэрмэл ус
Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний түвшин/inter-cooler-н хөргөлтийн шингэний түвшин (→X.498)	- Зөвхөн “Toyota Super Long Life Coolant” эсвэл адил өндөр чанартай, этилен гликол суурьтай, силикат, амины хүчил, нитрит, борын хүчил агуулаагүй хосолмол органик хөргөлтийн шингэн ашиглана. “Toyota Super Long Life Coolant” нь 50% хөргөлтийн шингэн, 50% ионгүйжүүлсэн уснаас бүрддэг. - Юүлүүр (цэвэр)

Хийх зүйл	Сэлбэг, багаж зэрэг
Хөдөлгүүрийн тосны түвшин (→X.495)	“Toyota Genuine Motor Oil” эсвэл дүйцэх тос - Даавуун болон цаасан алчуур - Юүлүүр (зөвхөн хөдөлгүүр тосонд ашиглагдах)
Гал хамгаалагч (→X.520)	Хуучин гал хамгаалагчтай адил ампертай
Гэрлийн ламп (→X.522)	Хуучин ламптай адил дугаар, ваттай ламп
Радиатор, кондишны радиатор, intercooler (→X.499)	—
Дугуйны хийн даралт (→X.513)	- Дугуйн даралт хэмжигч манометр - Насос, компрессор
Шил арчигчийн шингэн (→X.502)	- Антифризийн (өвөл ашиглах үед) орцтой ус болон шил арчигчийн шингэн - Юүлүүр (зөвхөн ус, шил арчигчийн шингэнд ашиглагдах)



АЮУЛТАЙ

Автомашины хөдөлгүүрийн хэсэгт гэнэт ажиллаж эхэлдэг, халдаг мөн хүчдэл авч асдаг олон төрлийн механизм болон шингэнүүд байдаг. Амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй ноцтой хохирлоос сэргийлэхийн тулд дараах анхааруулгыг мөрдөнө.

■ Хөдөлгүүрийн хэсэгт засвар үйлчилгээ хийх үед

- Эргэж буй духны ремень, сэнсэнд гар, хувцас, түлхүүр багажаа ойртуулж болохгүй.



АЮУЛТАЙ

- Жолоодлогын дараа халуун байж болох тул хөдөлгүүр, радиатор, янданд хүрч болохгүй. Мөн бусад шингэнүүд халуун байж болно.
- Хөдөлгүүрийн хэсэгт цаас, даавуу зэргийн шатамхай материал орхиж болохгүй.
- Шатахуун болон аккумуляторын ойр орчимд тамхи татах, оч үсрүүлэх болон ил задгай гал гаргахыг хориглоно. Шатахуун болон аккумуляторын уур нь галын аюултай.
- Аккумулятортай харьцах үед туйлын анхаарал болгоомжтой байна. Аккумуляторт хортой, идэмхий хүхрийн хүчил агуулагддаг.
- Тоормосны шингэн нь таны гар, нүд мөн автомашины будагтай хэсгийг гэмтээх аюултай тул анхаарал болгоомжтой харьцана. Тоормосны шингэн таны гарт хүрсэн, нүдэнд орсон үед тухайн хэсгийг цэвэр усаар даруй угаана. Эвгүй мэдрэмж төрсөн үед даруй эмчид хандана уу.

■ Хөргөлтийн сэнс эсвэл радиаторын торны ойр орчимд ажиллах үед

Асаах түлхүүрийг унтраана. Асаах түлхүүр ON горимд байгаа ба хэрэв агааржуулалтын систем асаалттай эсвэл хөргөлтийн шингэний хэм өндөр үед сэнс автоматаар ажиллаж болно. (→Х.499)

■ Автомашины доор ажиллах эсвэл доор байх үед

Зөвхөн домкратаар тулсан үед автомашины доод талд орохыг хориглоно. Ямагт автомашин өргөх хөл эсвэл бусад хатуу тулаас ашиглана.

■ Аюулгүйн нүдний шил

Шингэн цацагдах, аливаа зүйл унах, үсрэх зэргээр нүдэнд орохоос сэргийлж аюулгүйн нүдний шил зүүнэ.



АНХААР

■ Агаар шүүгчийг салгаж авсан тохиолдолд

Агаар шүүгчгүй үед агаар дахь тоосноос шалтгаалж хөдөлгүүрийн хэт элэгдэл үүсэх магадлалтай.

■ Шингэний түвшин бага эсвэл их үед

Тоормосны наклад элэгдэх эсвэл нөөцийн савны түвшин их үед тоормосны шингэний түвшин бага зэрэг доошлох нь хэвийн үзэгдэл юм. Нөөцийн савны шингэн дундарч байнга дүүргэх шаардлагатай болох нь ноцтой эвдрэл гэмтэл үүссэнийг илэрхийлнэ.


Капот

Автомашины дотор талаас түгжээг тайлж капотыг сөхнө.


Капот нээх

- 1 Капот нээх хөшүүргийг татна.

Капот бага зэрэг нээгдэнэ.



- 2 Туслах хөшүүргийг дээш татаж капот нээнэ.



АЮУЛТАЙ


■ Хөдөлгөөн эхлэхийн өмнө

Капот гүйцэд хаагдаж түгжигдсэн эсэхийг шалгана.

Хэрэв капот бүрэн түгжигдээгүй тохиолдолд хөдөлгөөний үед капот онгойх улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осол гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хөдөлгүүрийн хэсэг

Эд ангиуд




- A** Гал хамгаалагчийн хайрцаг (→X.520)
- B** Аккумулятор (→X.499)
- C** Intercooler-н хөргөлтийн шингэний нөөцийн сав (→X.498)
- D** Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний нөөцийн сав (→X.498)
- E** Хөдөлгүүрийн тос нэмэх таг (→X.497)
- F** Радиаторын хөргөлтийн сэнс (→X.499)
- G** Хөдөлгүүрийн тосны шүүб (→X.495)
- H** Агаар шүүгч (→X.502)
- I** Шил арчигчийн шингэний сав (→X.502)
- J** Intercooler-н радиатор (→X.499)
- K** Хөдөлгүүрийн радиатор (→X.499)
- L** Хөргөлтийн цахилгаан сэнс (тоноглогдсон загварт)
- M** Кондишны радиатор (→X.499)


Хөдөлгүүрийн таг

■ Хөдөлгүүрийн тагийг нээлттэй байлгана.

- 1 Товчийг дарж түгжээг татаад тагийг дээш өргөнө.




- 2 Зурагт үзүүлсний дагуу тагийг хийнэ.



■ Хөдөлгүүрийн тагийг угсрах

Зурагт үзүүлсний дагуу тагийг хийнэ.



АНХААР

■ Таг буцааж угсарсны дараа


Таг анхны байрлалд зөв, хөдөлгөөнгүй угсрагдсан эсэхийг нягтална.

Хөдөлгүүрийн тос шалгах


Хөдөлгүүрийн ажлын температурт хөдөлгүүр унтраасны дараа шүүб ашиглан тосны түвшнийг шалгана.

- 1 Автомашиныг тэгш газарт байрлуулна. Хөдөлгүүр халаасны дараа унтраах ба тос бүрэн доош буух хүртэл 5 орчим минут хүлээнэ.

- 2 Шүүбний үзүүрт алчуур барингаа татаж гаргана.



- 3 Шүүбийг арчиж цэвэрлэнэ.
4 Шүүбийг гүйцэд буцааж хийнэ.
5 Шүүбний үзүүрт алчуур барингаа татан гаргаж тосны түвшнийг шалгана.



A Бага

Автомашин болон хөдөлгүүрийн төрлөөс хамаарч шүүбний хэлбэр өөр байдаг.

- 6 Шүүбийг арчаад буцааж хийнэ.



АНХААР

■ Хөдөлгүүрийн ноцтой гэмтлээс сэргийлэх

Тосны түвшнийг байнга шалгана.

■ Хөдөлгүүрийн тосны хэрэглээ

Автомашины ашиглалтын үед

тодорхой хэмжээний хөдөлгүүрийн тос хэрэглэгддэг. Дараах нөхцөлүүдэд хөдөлгүүрийн тосны хэрэглээ нэмэгддэг тул илүү богино хугацаанд тос нэмэх шаардлагатай.

- Шинэ автомашин эсвэл хөдөлгүүр шинээр сольж тавьсан зэргээр автомашины хөдөлгүүр шинэ үед
- Чанар муутай тос эсвэл тухайн нөхцөлд үл тохирох зууралданги чанартай тос ашигласан үед
- Өндөр хурдтай эсвэл ачаа ихтэй, чиргүүл чирсэн эсвэл хурд тогтмол нэмж хасдаг нөхцөлд автомашин ашиглагдаж байгаа үед
- Автомашиныг удаан хугацаанд нормал хаазтай орхидог эсвэл байнга замын түгжрэлтэй замаар явдаг үед

■ Хөдөлгүүрийн тосны түвшин нэмэгдэх

Хөдөлгүүр ажлын хэмд халахгүй байдлаар богино зайд тогтмол ашиглагдсан нөхцөлд хөдөлгүүр дотор хөлрөлт үүсэх эсвэл дутуу шатсан түлш тостой холилдсоноор тосны түвшин нэмэгдэж болно. Нөгөөтээгүүр энэ нь доголдлыг илэрхийлэхгүй. Дараах нөхцөлд хөдөлгүүр халахгүй.

- Богино зайд явах
- Бага хурдаар явах
- Гадна агаарын хэм хүйтэн

Хөдөлгүүрийн тос шалгах үед хөдөлгүүр халсан эсэхийг шалгана. Тосны түвшин шүүбний дээд хэмжээнээс давсан үед та өөрийн Lexus дилерт хандана уу

Хөдөлгүүрийн тос нэмэх

■ Тосны маркийг шалгах ба шаардлагатай зүйлс бэлдэнэ

Тосны маркийг шалгаж мэдэх ба тос нэмэхийн өмнө дараах зүйлсийг бэлдэнэ үү.

- Хөдөлгүүрийн тос сонгох

→Х.576

- Тосны хэмжээ (бага болон дүүрэн тэмдгийн хооронд)


1.5 л (1.6 qt., 1.3 Imp. qt.)

- Бэлдэх зүйлс

Цэвэр юүлүүр


■ Хөдөлгүүрийн тос нэмэх

Хөдөлгүүрийн тосны түвшин шүүбний бага түвшний ойролцоо эсвэл түүнээс бага байгаа үед хөдөлгүүрийн тостой адил маркийн тос нэмж хийнэ.



- 1 Тагийг цагийн зүүний эсрэг эргүүлж авна.
- 2 Шүүбийг шалгангаа тос бага багаар нэмнэ.

Тосны түвшнийг шүүбний дүүрэн тэмдгээс давуулж болохгүй ба бага болон дүүрэн тэмдгийн хооронд нэмнэ.



А Бага

В Дүүрэн

Хөдөлгүүрийн төрлөөс хамаарч шүүбний хэлбэр өөр байж болно.

- 3 Тагийг цагийн зүүний дагуу эргүүлж таглана.

■ Тос сольсны дараа

Хөдөлгүүрийн тосны засвар үйлчилгээний мэдээллийг дараах дарааллаар тэглэнэ:

- 1 Голын дэлгэцээс -г дарна.
- 2 “Vehicle customise”-г дарна.
- 3 “Utility”-г дарна.
- 4 “Oil maintenance”-г дарна.
- 5 “Reset”-г дарна.

Үйлдэл дууссаны дараа үйлдэл дууссаныг илтгэх мэдээлэл гарна.

! АЮУЛТАЙ

■ Хөдөлгүүрийн хуучин тос

- Арьсны гэмтэлд хүргэх аюултай тул хуучин тостой удаан хугацаанд эсвэл тогтмол харьцахаас зайлсхийнэ. Бие, арьсанд наалдсан хөдөлгүүрийн тосыг саван, усаар сайтар угааж арилгана.
- Хуучин хөдөлгүүрийн тос, тосны шүүрийг зөвхөн зориулалтын газар, зохих журмын дагуу хаяна. Ахуйн хэрэглээний хогтой хамт хаях, бохир усны шугамд хийх, газарт асгахыг хатуу хориглоно. Хог хаягдлын дахин ашиглалт, устгалтай холбоотой мэдээллийг та өөрийн Lexus дилер эсвэл засварын төвүүдээс тодруулна уу.
- Хуучин тосыг бага насны хүүхдийн гар хүрэхгүй газар тавина.

**АНХААР****■ Хөдөлгүүрийн тос солих үед**

- Автомашины эд анги дээр тос асгахаас зайлсхийнэ.

**АНХААР**

- Хөдөлгүүр гэмтэх магадлалтай тул шаардлагатай хэмжээнээс илүү тос хийхийг хориглоно.

- Тос нэмэх тухай бүрд тосны шүүбийг шалгана.


- Хөдөлгүүрийн тос нэмэх таг гүйцэд таглагдсаныг нягтална.

■ Тос сольсны дараа

Хөдөлгүүрийн тосны засвар үйлчилгээний мэдээллийг тэглэх шаардлагатай Тэглээгүй нөхцөлд дараагийн удаагийн тос солих сануулга зөв гарахгүй байж болно.

Хөргөлтийн шингэн шалгах**■ Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний нөөцийн сав**

Хөргөлтийн шингэний түвшин нь хөдөлгүүр хүйтэн үед шингэний нөөцийн савны “F” болон “L” шугамын хооронд байна.



A Нөөцийн савны таг


B “F” шугам

C “L” шугам

Шингэний түвшин “L” шугамаас буурсан үед “F” шугам хүртэл нэмнэ. (→X.566)

■ Intercooler-н хөргөлтийн шингэний нөөцийн сав

Хөргөлтийн шингэний түвшин нь хөдөлгүүр хүйтэн үед шингэний нөөцийн савны “F” болон “L” шугамын хооронд байна.



A Нөөцийн савны таг

B “F” шугам

C “L” шугам

Шингэний түвшин “L” шугамаас буурсан үед “F” шугам хүртэл нэмнэ. (→X.566)

■ Хөргөлтийн шингэн сонгох

Зөвхөн “Toyota Super Long Life Coolant” эсвэл адил өндөр чанартай, этилен гликол суурьтай, силикат, амин хүчил, нитрит, борын хүчил агуулаагүй хосолмол органик хөргөлтийн шингэн ашиглана.

“Toyota Super Long Life Coolant” нь 50% хөргөлтийн шингэн болон 50% ионгүйжүүлсэн уснаас бүрддэг. (Ажиллах хэм: -35°C [-31°F] хүртэл)

Дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилерт хандаж авна уу.

■ Хөргөлтийн шингэний түвшин богино хугацаанд дундрах үед

Хөдөлгүүрийн радиатор, хоолой, хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний нөөцийн савны таг, радиаторын таг, Intercooler-н радиатор, Intercooler-н хөргөлтийн шингэний нөөцийн савны таг, дренаж, усны насосыг шалгана.

Хэрэв та шингэн алдагдаж байгаа газрыг биечлэн тодорхойлох боломжгүй үед өөрийн Lexus дилерт хандаж шингэний алдагдлыг тодорхойлуулах шаардлагатай.



АЮУЛТАЙ

■ Хөдөлгүүр халуун үед

Радиаторын таг, хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний нөөцийн савны таг эсвэл Intercooler-н хөргөлтийн шингэний нөөцийн савны тагийг нээж болохгүй. Хөргөлтийн системд даралт үүссэн байж болох ба энэ үед тагийг авахад хэт халуун хөргөлтийн шингэн цацагдаж түлэгдэл үүсгэх аюултай.



АНХААР

■ Хөргөлтийн шингэн нэмэх үед

Хөргөлтийн шингэн нь цэвэр ус эсвэл найруулаагүй цэвэр антифриз байж болохгүй. Ус болон антифризийн зөв хувь хэмжээгээр найруулсан шингэн нь зэврэлтээс хамгаалахын зэрэгцээ зөв тосолгоог үзүүлэх, хөдөлгүүр хөргөх үйлчилгээтэй байна. Антифриз, хөргөлтийн шингэний үйлдвэрлэгчийн шошго, мэдээллийг уншина уу.

■ Шингэн асгасан үед

Будаг болон эд ангид учруулах гэмтлээс сэргийлж усаар угаана.

Радиатор, кондишны болон Intercooler-н радиатор шалгах

Хөдөлгүүрийн радиатор, кондишны радиатор ба Intercooler-н радиатор шалгаж аливаа гадны биетээс цэвэрлэнэ. Эдгээрийн аль нэг нь хэт бохирдсон эсвэл тухайн эд ангийг биечлэн шалгах боломжгүй үед та өөрийн Lexus дилерт хандаж шалгуулна уу.



АЮУЛТАЙ

■ Хөдөлгүүр халуун үед

Хөдөлгүүрийн радиатор, кондишны радиатор эсвэл Intercooler-н радиатор халуун ба, хүрсэн тохиолдолд түлэгдэх зэрэг ноцтой гэмтэл учрах тул хүрч болохгүй.

Аккумулятор шалгах

Дараах байдлаар шалгана.

■ Анхааруулах тэмдэг

Аккумуляторын тэмдгийн утга:

	Тамхи татах, ил гал, оч гаргахыг хориглоно.
	Нүдээ хамгаалах шаардлагатай.
	Бага насны хүүхдийг ойртуулахыг хориглоно
	Аккумуляторын хүчил

	Ашиглалтын гарын авлага
	Тэсрэх аюултай хий


■ Хөдөлгүүрийн таг салгах

→Х.495

■ Аккумуляторын гадна тал

Шон зэврээгүй, холболт сулраагүй, зажимд цууралт, сулралт үүсээгүй зэргийг нягтална.


► А төрөл



A Шон

B Аккумуляторын бэхэлгээ

► В төрөл




A Шон

B Аккумуляторын бэхэлгээ

■ Аккумуляторын шингэн

Шингэн дээд доод хэмжээний хооронд байгаа эсэхийг нягтална.




A Дээд хэмжээ

B Доод хэмжээ

Шингэний түвшин доод буурсан байвал нэрмэл ус нэмнэ.

■ Аккумулятор шалгах

Индикаторын өнгөөр аккумуляторыг шалгана.



A Улаан болон тунгалаг: Солих шаардлагатай. Lexus дилер дээр оношлуулна уу.

B Тунгалаг ба улаан: Цэнэглэх шаардлагатай. Lexus дилер дээр оношлуулна уу.


C Цэнхэр ба улаан: Сайн

■ Нэрмэл ус нэмэх

1 Агааржуулалтын тагийг авна.

2 Нэрмэл ус нэмнэ.

Аккумуляторын шингэний дээд хэмжээний зураас харагдахгүй үед аккумуляторын торыг нүдээр шууд харж шингэний түвшнийг шалгана.



A Бага

B Хэвийн

3 Агааржуулалтын тагийг буцааж сайтар таглана.

■ Хөдөлгүүрийн тагийг угсарна

→X.495

■ Цэнэглэхийн өмнө

Аккумулятор цэнэглэгдэх үед шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай устөрөгч ялгардаг. Дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:

- Аккумуляторыг автомашинаас салгалгүй цэнэглэх үед газардуулгын утсыг салгана.
- Аккумулятор цэнэглэгчийн утсыг аккумулятортай холбох, салгах үед цэнэглэгчийг унтраах товчоор унтраасан байна.

■ Цэнэглэж дууссан/аккумулятор холбосны дараа

- Аккумуляторыг буцааж холбосны дараа smart entry & start системээр хаалганы түгжээ заримдаа тайлагддаггүй. Энэ тохиолдолд түлхүүрийн алсын удирдлагын функц эсвэл механик түлхүүр

ашиглан хаалгыг түгжиж тайлна.

- Асаах товчны ACC горимд хөдөлгүүр асаана. Асаах товч дарах үед товчны унтрах горимд шилжиж хөдөлгүүр асахгүй байж болно. Энэ тохиолдолд товчийг дахин дарж хөдөлгүүр асаана.

- Хөдөлгүүр асаах товчны горим нь автомашины компьютерт тэмдэглэгддэг. Аккумулятор буцаан холбох үед асаах түлхүүрийн горим аккумулятор салгахын өмнөх горимд шилждэг. Тиймээс хөдөлгүүр заавал унтраана. Аккумуляторын цэнэг суух үед ямар горимд байсан нь тодорхойгүй нөхцөлд анхааралтай холбоно.

Дээрх аргуудаар хөдөлгүүр асаах оролдлого хэд хэдэн удаа хийсэн ч хөдөлгүүр асахгүй байгаа тохиолдолд та өөрийн Lexus дилерт хандана уу.

⚠ АЮУЛТАЙ

■ Аккумуляторт агуулагддаг бодисууд

Аккумуляторт хортой, идэмхий хүүхрийн хүчил агуулагддаг ба шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай устөрөгч мөн ялгардаг. Амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй ноцтой хохирлоос сэргийлж эдгээрийг мөрдөнө:

- Багаж түлхүүрээр аккумуляторын шонд хүрч оч гаргаж болохгүй.
- Аккумуляторын хажууд тамхи татах, ил гал гаргахыг хориглоно
- Нүд, арьс болон хувцсанд хүргэхээс зайлсхийнэ.
- Электролитээр амьсгалах, уухыг хатуу хориглоно.
- Хамгаалалтын нүдний шил зүүнэ.
- Хүүхэд ойртуулж болохгүй.

■ Цэнэглэхэд аюулгүй газар

Аккумуляторыг ил задгай газар цэнэглэнэ. Гарааш, битүү өрөө зэргийн агааржуулалт муутай газар цэнэглэхийг хориглоно.

■ Электролиттэй холбоотой арга хэмжээ

- Электролит нүдэнд орсон үед цэвэр усаар нүдээ 15-с дээш минут угаах ба эмнэлгийн тусламж авна. Хамгийн ойрын эмнэлэг хүрэх замдаа даавуу, пролон норгож тавина.
- Электролит арьсанд хүрсэн үед хүрсэн хэсгийг сайтар угаана. Танд өвдөлт, арьс түлэгдсэн мэдрэмж төрсөн үед даруй эмнэлгийн тусламж авна.
- Электролит хувцсанд хүрвэл хувцсыг нэвчиж таны арьсанд хүрэх аюултай. Даруй хувцсаа тайлах ба шаардлагатай үед дээр дурдсан арга хэмжээг авна.



АЮУЛТАЙ

- Электролитийг санамсаргүй уусан үед их хэмжээний ус эсвэл сүү ууна. Эмнэлгийн яаралтай тусламж даруй авна.



АНХААР

■ Аккумулятор цэнэглэх үед

Хөдөлгүүр асаалттай үед аккумулятор цэнэглэж огт болохгүй. Мөн бусад электрон төхөөрөмжийг унтраах шаардлагатай.


■ Нэрмэл ус нэмэх үед

Хэт их нэмэхийг хориглоно. Аккумулятор цэнэглэх үед асгарсан ус эзвэрлэлт үүсгэх магадлалтай.

Шил арчигчийн шингэн

Шил арчигчийн шингэн цацагдахгүй эсвэл мэдээллийн

дэлгэц дээр “Windshield Washer Fluid Low” асаж байгаа үед шил арчигчийн шингэн дууссан байж болно. Шил арчигч шингэн нэмнэ.



АЮУЛТАЙ

■ Шил арчигчийн шингэн нэмэх

Хөдөлгүүр зэрэг дээр асгарсан тохиолдолд гал авалцах аюултай тул хөдөлгүүр асаалттай үед шингэн нэмж болохгүй.



АНХААР

■ Шил арчигчийн шингэнээс өөр шингэн ашиглахыг хориглоно

Шил арчигчийн шингэний оронд хөдөлгүүрийн антифриз, савантай ус ашиглахыг хориглоно. Энэ нь автомашины будаг хагарч гэмтэх мөн насос эвдэрч шил арчигчийн шингэн цацагдахгүй болгоход хүргэж болно.


■ Шил арчигчийн шингэнийг шингэлэх

Шаардлагатай тохиолдолд усаар шингэлнэ. Шил арчигчийн шингэний лонхон дээрх царцах температурын жагсаалтыг нягтална уу.

Агаар шүүгч шалгах


Дараах дарааллаар шалгана:

- 1 Агаар шүүгчийн гэрийн ойр орчим дахь тоос шороог даралттай хийгээр цэвэрлэнэ.
- 2 Хумсыг тайлна.




- 3 Тагийг дээш өргөөд агаар шүүгчийг салгаж авна.

Гадна талыг шалгах ба хэт бохирдсон тохиолдолд солино. Шүүр дээр тоос тогтсон үед даралттай хийгээр үлээлгэж цэвэрлэнэ.



- 4 Шалгаж дууссаны дараа шүүр зөв угсрагдсан байгааг нягтална. Хавчаарыг хийж

агаар шүүгчийн гэрийн дээд талыг тагийг таглана.



⚠ АЮУЛТАЙ

■ Тоос сорохоос сэргийлэх

Агаар шүүгчийг даралттай хийгээр цэвэрлэх үед тоос амьсгалахаас сэргийлж амны хаалт зүүнэ.

⚠ АНХААР

■ Хөдөлгүүрийн эвдрэл гэмтлээс сэргийлэх


- Хөдөлгүүрийн хэт элэгдэл үүсгэх тул агаар шүүгчийг авсан хэвээр жолоодож болохгүй.
- Тоос шороотой байж болох тул шүүрийг цохих, унагаахас сэргийлнэ.

Дугуй

Дугуйг засвар үйлчилгээний төлөвлөгөө болон хээний элэгдэлд тохируулан солих эсвэл байрлалыг нь өөрчилнө.

Дугуй шалгах

Хээний элэгдлийн индикаторыг шалгана. Мөн нэг талын хээ нь хэт элэгдэх зэргээр тэгш бус элэгдсэн эсэхийг шалгана. Байрлал өөрчлөөгүй үед нөөц дугуйны байдал, хийг шалгана.



A Шинэ хээ

B Элэгдсэн хээ

C Хээний элэгдлийн индикатор

Индикаторын байрлалыг дугуйны бөөрөн дээр "TWI" эсвэл "△"

тэмдгээр заасан байдаг. Дугуйны хээ элэгдэж индикатор гарч ирсэн үед дугуйг солино.

■ Дугуй солих шаардлагатай үе

Дараах нөхцөлд дугуйг солино:

- Элэгдлийн индикатор гарч ирсэн.
- Утас гарах хэмжээнд дугуй зүсэгдсэн, язарсан, цуурсан, дотоод гэмтлийг илэрхийлэх булцуу үүссэн зэргээр дугуй гэмтсэн үед
- Хагархайн хэмжээ, байрлал мөн бусад гэмтлийн улмаас дугуйн хий тогтмол суларч байгаа эсвэл зөв засах боломжгүй үед.

Шаардлагатай тохиолдолд та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ Дугуйн ашиглалтын хугацаа

Үйлдвэрлэснээс хойш 6-с дээш жил болсон дугуйг бага ашигласан, огт ашиглаагүй эсвэл ил гэмтэлгүй байсан ч мэргэжлийн засварчнаар шалгуулна.

■ Өвлийн дугуйны хээ 4 мм (0.16 инч)-с багассан үед

Өвлийн дугуйны барьцалдах чадвар үгүй болно.

⚠ АЮУЛТАЙ

■ Дугуй шалгах, солих үед

Ослоос сэргийлэхийн тулд дараах анхааруулгыг дагаж мөрдөнө.

Эсрэг тохиолдолд явах эд ангид гэмтэл учруулах мөн автомашины жолоодлогыг аюултай болгох, улмаар амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

- Өөр үйлдвэрлэгч, загвар, хээтэй дугуйнуудыг ашиглаж болохгүй. Мөн хээний элэгдлийн хэмжээ нь хэт өөр дугуй хольж угсрахгүй.
- Үйлдвэрлэгчийн зааснаас өөр хэмжээтэй дугуй ашиглахгүй.
- Өөр бүтэц, хийцтэй (radial, bias-belted, bias-ply) дугуй ашиглахгүй.

- Зуны, бүх улирлын, өвлийн дугуй хольж ашиглахгүй.
- Өөр автомашинд ашиглагдаж байсан дугуй ашиглахгүй. Өмнөх ашиглалтын байдал нь тодорхойгүй дугуй ашиглахгүй.



АНХААР

■ Бартаатай замаар явах үед


Сул хөрстэй болон донсолгоотой замаар өндөр анхаарал болгоомжтой жолоодно. Замын эдгээр нөхцөл дугуйны хийн даралт суларч донсолгоо шингээх чадвар нь буурдаг. Үүнээс гадна бартаа, донсолгоотой замаар явах нь дугуй, обуд болон автомашины их биеийг гэмтээх аюултай.

■ Дугуйны хийн даралт тухай бүрд сулраад байгаа үед

Дугуй, обуд гэмтсэн байж болох тул үргэлжлүүлэн жолоодож болохгүй.

Дугуйны байрлал солих

Дараах дарааллаар өөрчилнө.



Дугуйны жигд элэгдэл, эдэлгээг уртасгахын тулд 5000 км (3000 миль) тутамд дугуйн байрлал өөрчлөхийг Lexus зөвлөж байна.

Байрлал өөрчлөөд системийн тохиргоог дахин тохируулна.

■ Дугуйн байрлал солих үед


Асаах товчийг OFF горимд унтраана. Асаах товчны ON горимд дугуйн байрлалын мэдээлэл шинэчлэгдэхгүй.

Санамсаргүй ON горимд дугуйн байрлал сольсон үед асаах товч OFF унтраагаад ON горимд асаах эсвэл дугуйн даралтыг нягтлаад системийн тохиргоог дахин тохируулна.


Дугуйн даралт анхааруулах систем

Анхааруулах хавхлаг болон дамжуулагч ашиглан ноцтой нөхцөл байдал үүсэхээс өмнө дугуйн даралт буурсныг мэдэрдэг дугуйн даралт анхааруулах систем таны автомашинд суурилагдсан болно. Систем дараах 2 анхааруулгатай. (→X.538)

► Мэдээллийн дэлгэц



► Голын дэлгэц



● Дэлгэц дээр “Adjust Pressure” гарах (Хэвийн анхааруулга)

Хий сулрах, агаарын хэм буурах зэрэг энгийн шалтгаанаар даралт багасах үед дугуйн даралт анхааруулах гэрэл асаж дохио дуугарна.

● Дэлгэц дээр “Immediately Check tyre when Safe” гарах (Онцгой үеийн анхааруулга)

Дугуй хагарах зэрэг шалтгаанаар даралт багасах үед дугуйн даралт анхааруулах гэрэл асаж дохио дуугарна. Нөгөөтээгүүр хийн даралт огцом буурах (дугуй задрах зэрэг) үед анхааруулга гарахгүй.

● Дугуйн хийн даралт тогтоосон хэмжээнээс буурах үед голын дэлгэц дээр анхааруулга гарна. (→Х.109)

■ Дугуйн даралт тогтмол шалгах

Дугуйн даралт анхааруулах систем нь дугуйн даралтыг тогтмол шалгах үүргийг гүйцэтгэдэггүй. Та автомашины өдөр тутмын үзлэг, шалгалтын хүрээнд дугуйн даралтыг тогтмол шалгах шаардлагатай.

■ Дугуйны хийн даралт

● Асаах товчийг ON горимд дарснаас хойш тодорхой минутын дотор даралт дэлгэцээр гарахгүй байх эсвэл хийн даралт тохируулснаас хойш тохируулсан даралтын хэмжээ өөрчлөгдөхгүй байж болно.

● Дугуйн даралт нь температур өөрчлөгдөх үед өөрчлөгдөнө. Мөн дэлгэцийн заалт дугуйн хийн даралт хэмжигчээр хэмжсэн хэмжээнээс өөр байж болно.

■ Дугуйн даралт анхааруулах системийн хэвийн ажиллагаа алдагдах нөхцөлүүд

● Дараах тохиолдлуудад системийн

- хэвийн ажиллагаа алдагдаж болно.
- Lexus-н оригинал обуд ашиглаагүй үед
- OE (Original Equipment) биш дугуй сольж тавьсан үед
- Хэмжээ нь тохирохгүй дугуй сольж тавьсан үед
- Дугуйн гинж г.м. зүйлс дугуйнд угсарсан үед
- Нэмэлт тулгууртай ослын гүйлттэй дугуй угсарсан үед
- Радио долгионд нөлөөлдөг цонхны хуулга наасан үед
- Автомашин, ялангуяа автомашины дугуй болон шаврын хаалтын ойр орчимд их хэмжээний цас, мөс тогтсон үед
- Дугуйн даралт тохирох хэмжээнээс хэт өндөр үед
- Дугуйн хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчгүй дугуй ашиглаж байгаа үед
- Дугуйн даралт анхааруулах компьютерт дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийн ID код бүртгэгдээгүй үед
- Дараах нөхцөлүүд системийн ажиллагаанд нөлөөлөх магадлалтай.
- Телевизийн цамхаг, цахилгаан станц, ШТС, радио станц, том оврын дэлгэц, нисэх буудал болон бусад хүчтэй радио долгион, соронзон орон үүсгэдэг газрын ойр орчимд
- Зөөврийн радио, гар утас, утасгүй суурин холбооны утас болон бусад утасгүй харилцаа холбооны төхөөрөмж биедээ авч явах үед
- Радио долгионы нөхцөл байдлаас хамаарч дугуйны байрлалын мэдээлэл дэлгэцээр зөв гарахгүй үед жолоодлого болон радио долгионы нөхцөл өөрчлөгдөх үед дэлгэц дээр засагдаж болно.
- Автомашиныг зогсоолд байрлуулсан үед анхааруулга асах эсвэл унтрах хугацаа уртсаж болно.
- Дугуй задарсан зэргээр дугуйн даралт огцом унасан үед анхааруулах функц ажиллахгүй байх тохиолдол гардаг.

Дугуйн хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч угсрах

Дугуй, обуд солих үед дугуйн хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч мөн угсарна.

Шинэ хавхлаг болон дамжуулагч суурилуулсан үед шинэ ID кодыг системд бүртгүүлж системийн тохиргоог дахин тохируулна. (→X.510)

■ Дугуй, обуд солих үед

▶ Латин Америкаас бусад улс

ID код бүртгүүлээгүй үед дугуйн даралт анхааруулах системийн хэвийн ажиллагаа алдагдана. Автомашиныг 10 орчим минут жолоодох үед системийн доголдлыг илэрхийлж дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчсаны дараа үргэлжлэн асна.

▶ Латин Америкийн улсууд

ID код бүртгүүлээгүй үед дугуйн даралт анхааруулах системийн хэвийн ажиллагаа алдагдана. Автомашиныг 20 орчим минут жолоодох үед системийн доголдлыг илэрхийлж дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчсаны дараа үргэлжлэн асна.



АНХААР

■ Дугуй, обуд, дугуйны даралт анхааруулах хавхлаг, дамжуулагч, дугуйны хошууны таг засах, солих

● Дугуй, обуд мөн дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч салгах, буцааж угсрах үед буруу ажиллагааны улмаас дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийг гэмтээх эрсдэлтэй тул та өөрийн Lexus дилерт хандана уу.



АНХААР

- Дугуйны хошуунд таг заавал хийнэ. Хошуунд таг хийгээгүй үед ус дугуйны даралт анхааруулах хавхлагд орж гэмтээх аюултай.
- Дугуйны хошуунд таг хийх үед гацдаг тул тохирохгүй таг хийж болохгүй.

Дугуй тус бүрийн байрлалыг бүртгэх

■ Дугуй тус бүрийн байрлал бүртгэх шаардлагатай нөхцөлүүд

Дугуйн байрлал сольсны дараа дугуй тус бүрийн байрлал бүртгэх шаардлагатай.

Дугуйн байрлал бүртгэх үйлдлийг ганцаараа хийх боломжтой. Баруун, зүүн тийш эргэнгээ тодорхой зайд урагш явна. Мөн жолоодлогын нөхцөлөөс хамаарч бүртгэл удаа дараа хийгдэж болно.

■ Дугуй тус бүрийн байрлал бүртгэх

1 Автомашин аюулгүй газар зогсоогоод хөдөлгүүрийг унтраан 15-с дээш минут хүлээнэ.

2 Хөдөлгүүр асаана.

Автомашин явж байх үед дугуйн байрлал бүртгэх боломжгүй.

3 Голын дэлгэцээс -г сонгоно.

4 “Vehicle customise”-г сонгоно.

5 “Tyre pressure”-г сонгоно.

6 “Tyre rotation”-г сонгоно.

7 “Continue”-г сонгоно.

Мэдээллийн дэлгэц дээр дугуйн байрлал бүртгэх үйлдэл хийгдэж байгааг илэрхийлэх мэдээлэл гарна. Дугуй тус бүрийн хийн даралт дээр “--” тэмдэг гарах ба бүртгэл эхэлнэ.

8 Шулуун чиглэлд (тогтмол баруун зүүн эргэнгээ) 10-с 30 минутын хугацаанд 40 км/ц (25 миль/ц) ба түүнээс дээш хурдаар жолоодно.

Бүртгэл дууссан үед дугуйн даралт анхааруулах гэрэл унтрах ба мэдээллийн дэлгэц дээр дугуй тус бүрийн даралтын мэдээлэл гарна.

40 км/ц (25 миль/ц)-с дээш хурдтай явах боломжгүй байсан ч удаан хугацаанд жолоодон дугуйн байрлалыг бүртгэх боломжтой. Нөгөөтээгүүр 1 цагаас удаан явсан ч бүртгэл дуусахгүй үед автомашиныг аюулгүй газар асаах товчны ON горимд 15-с дээш минут зогсоогоод дахин жолоодно.

■ Дугуйн байрлал бүртгэх үед

- Хэвийн нөхцөлд бүртгэл бүрэн дуусахад ойролцоогоор 30 минут шаардагдана.
- 40 км/ц (25 миль/ц)-с дээш хурдтай явах үед дугуйн байрлал бүртгэх боломжтой.

■ Дугуйн байрлал бүртгэх үйлдэл

- Дугуйн байрлал бүртгэх явцад асаах товчийг унтраасан нөхцөлд асаах товчийг дараагийн удаа ON горимд шилжүүлэхэд бүртгэх үйлдэл автоматаар дахин сэргэх тул үйлдлийг эхлэх шаардлагагүй.
- Дугуй тус бүрийн байрлалыг таньж байгаа ба хийн даралтын хэмжээ дэлгэц дээр гараагүй үед хийн даралт унасан нөхцөлд хийн даралт анхааруулах гэрэл асна.

■ Дугуйн байрлал бүртгэгдэхгүй үед хялбар

- Дараах нөхцөлүүдэд дугуйн байрлал бүртгэхэд хугацаа шаардагдах эсвэл бүртгэх боломжгүй байж болно.
 - 40 км/ц (25 миль/ц)-с дээш хурдаар яваагүй
 - Хатуу хучилтгүй замаар явсан
- 1 цагаас удаан явсан ч бүртгэл дуусахгүй байвал автомашиныг аюулгүй газар 15-с дээш минут зогсоогоод дахин жолоодно.
- Дугуйн байрлал бүртгэх явцад автомашин ухарвал тухайн цэг хүртэлх цуглуулсан мэдээлэл устана. Үйлдлийг дахин эхэлнэ.

Дугуйн даралт тохируулах

■ Дугуйн даралт тохируулах үед

Дараах нөхцөлүүдэд дугуйн даралт анхааруулах системийн тохиргоо хийх шаардлагатай.

- Ачсан ачаа тээш зэргээс шалтгаалж тохиромжтой дугуйн даралтын хэмжээ өөрчлөгдсөн үед.
- Дугуйн хэмжээ өөрчлөгдсөн зэргээр дугуйн даралтын хэмжээ өөрчлөгдсөн үед.

Дугуйн хийн даралтыг зохих хэмжээнд тохируулаад голын дэлгэцийн дугуйн даралтын тохиргоог сонгон дугуйн даралтыг тохируулна. (→X.509)

Өөр хэмжээтэй дугуй угсарсан зэргээр дугуйны хийн даралт систем тохируулсан хэмжээнээс өөрчлөгдөх үед системд шинэ

даралтын хэмжээг бүртгүүлэх шаардлагатай. Дугуйн даралт бүртгэхийн өмнө дугуй тус бүрийн хийн даралтыг зохих хэмжээнд тохируулна. Шинээр бүртгэгдсэн даралтын хэмжээнд үндэслэн дугуйн даралт анхааруулах систем ажилладаг. (→Х.509)

■ Дугуйны хийн даралт тохируулах

1 Хөдөлгүүрийг асаана.

Автомашин явж байх үед дугуйн хийн даралт тохируулах боломжгүй.

2 Голын дэлгэцээс -г сонгоно.

3 “Vehicle customise”-г сонгоно.


4 “Tyre pressure”-г сонгоно.

5 “Set indicated air pressure”-г сонгоод тохируулах урд ба хойд дугуйн даралт сонгоно.

6 “OK”-г дарна.

Дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа удаан анивчина.

Дугуйн даралт тохируулж дууссаны дараа мэдээллийн дэлгэц дээр үйлдэл дууссаныг илтгэх мэдээлэл гарна.



■ Одоогийн дугуйн хийн даралт ашиглан тохируулах

1 Дугуй тус бүрийн даралтыг зохих хэмжээнд тохируулна.

Дугуй хүйтэн үед даралтыг тохируулна.

2 Хөдөлгүүр асаана.

Автомашин явж байх үед дугуйн хийн даралт тохируулах боломжгүй.

3 Голын дэлгэцээс -г сонгоно.

4 “Vehicle customise”-г сонгоно.


5 “Tyre pressure”-г сонгоно.

6 “Set current air pressure”-г сонгоно.

7 “Continue”-г сонгоно.

Дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа удаан анивчиж мэдээллийн дэлгэц дээр дугуйн даралт анхааруулах системийн тохиргоо хийгдэж буйг илэрхийлэх мэдээлэл гарна.

Дугуйн даралт тохируулж дууссаны дараа мэдээллийн дэлгэц дээр үйлдэл дууссаныг илтгэх мэдээлэл гарна.



■ Дугуйн даралт анхааруулах системийн анхааруулга өгөх чадвар (Одоогийн дугуйн хийн даралт ашиглан тохируулах)

● Одоогийн дугуйн хийн даралт ашиглан дугуйн хийн даралт тохируулах үед тухайн тохиргоо хийгдсэн үеийн байдлаас хамаарч анхааруулга өгөх хугацаа өөр байдаг. Тиймээс хийн даралт бага зэрэг буурах болон ихсэх үед анхааруулга өгч болно.

● Дугуй тус бүрийн хийн даралтын зохих хэмжээнд тохируулсны дараа системийн хийн даралтыг

тохируулна. Мөн үйлдлийг дугуй хүйтэн үед хийх шаардлагатай.

■ **Дугуйн даралт анхааруулах системийн анхааруулга өгөх чадвар (Одоогийн дугуйн хийн даралт ашиглан тохируулах)**

● Дугуйн байрлал бүртгэх явцад асаах товчийг унтраасан нөхцөлд асаах товчийг дараагийн удаа ON горимд шилжүүлэхэд бүртгэх үйлдэл автоматаар дахин сэргэх тул үйлдлийг дахин эхлүүлэх шаардлагагүй.

● Системийн тохиргоог хийх шаардлагагүй үед санамсаргүйгээр тохиргоог эхлүүлсэн үед дугуйг хүйтэн үед дугуйн хийн даралтыг тохируулсны дараа системийн тохиргоог дахиж хийнэ.

■ **Дугуйн даралт тохируулах үйлдэл хүндрэлтэй үед**

● Дугуйн даралт тохируулах үйлдэл хэвийн нөхцөлд 3 минут орчим хугацаанд дуусдаг.

● Дугуйн даралт тохируулах үйлдэл эхлэх үед анхааруулах гэрэл 3 удаа анивчихгүй байвал үйлдэл эхлээгүй байж болно. Үйлдлийг дахин эхэлнэ.

● Дээрх үйлдлийг хийсэн ч дугуйн даралт зөв тохируулах боломжгүй үед Lexus дилертээ хандана уу.



АЮУЛТАЙ

■ **Одоогийн дугуйн хийн даралт ашиглан тохируулах үед**

Дугуйн даралт тохируулах үйлдэл эхлэхээс өмнө дугуй тус бүрийн хийн даралтыг зохих түвшинд тохируулна. Эсрэг тохиолдолд дугуйн хийний даралт бага байсан ч анхааруулах гэрэл асахгүй байх мөн хийний даралт хэвийн үед ч анхааруулах гэрэл асах магадлалтай.

ID код бүртгэх

■ **ID код бүртгэх шаардлагатай нөхцөл**

Дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч нь дахин давтагдахгүй ID кодтой байдаг. Автомашинд шинэ дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч ашиглах үед компьютерт ID код бүртгэх шаардлагатай.

■ **ID код бүртгэх**

ID код бүртгэхийн өмнө автомашины ойр орчимд дугуйн даралт анхааруулах хавхалгатай өөр дугуй байхгүй байгаа эсэхийг нягтална.

1 Автомашиныг аюулгүй газарт байрлуулаад 15-с дээш минут унтраана.

2 Хөдөлгүүрийг асаана.

Автомашин явж байх үед ID код бүртгэх боломжгүй.

3 Голын дэлгэцээс -г сонгоно.

4 “Vehicle customise”-г сонгоно.


5 “Tyre pressure”-г сонгоно.

6 Дэлгэц дээр тухайн сонгох гэж буй дугуйн иж бүрдэл (“Set 1” эсвэл “Set 2”) гарч байгаа эсэхийг нягтална.

Дэлгэц дээр гарч буй дугуйн иж бүрдэл дээр ID код бүртгэгдэнэ. Бүртгэх гэж буй дугуйн иж бүрдлийг солих үед дэлгэц дээр гарах дугуйн иж бүрдлээс сонгоод бүртгэнэ.

Тухайн дугуйны иж бүрдэлд ID код өмнө нь бүртгэгдсэн үед дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа

удаан анивчаад мэдээллийн дэлгэц дээр код солигдож байгааг илэрхийлэх мэдээлэл гарна.




7 “New tyre registration”-г сонгоно.

8 “Continue”-г сонгоно.

Дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа удаан анивчих ба мэдээллийн дэлгэц дээр ID код бүртгэх үйлдэл хийгдэж буйг илэрхийлэх мэдээлэл гарна. Дугуйн иж бүрдэл сонгох үйлдэл цуцлагдаж бүртгэл эхэлнэ.

Бүртгэл хийгдэх явцад дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчаад үргэлжлэн асах ба мэдээллийн дэлгэцийн дугуй тус бүрийн даралтын заалт “---” тэмдэг болж гарна.



9 Шулуун чиглэлд (тогтмол баруун зүүн эргэнгээ) 10-30 минутын хугацаанд 40 км/ц (25 миль/ц) ба түүнээс дээш хурдаар жолоодно.

Бүртгэл дууссан үед дугуйн даралт анхааруулах гэрэл унтрах ба мэдээллийн дэлгэц дээр дугуй тус бүрийн даралтын мэдээлэл гарна.

40 км/ц (25 миль/ц)-с дээш хурдтай явах боломжгүй үед бүртгэл дуусахад хугацаа шаардагдаж болно. 1 цагаас илүү хугацаанд явсан ч бүртгэл дуусахгүй үед үйлдлийг дахин эхнээс нь хийнэ.

10 Тухайн угсарсан дугуйн иж бүрдлийн хийн даралт өмнөх иж бүрдлээс өөр үед дугуйн даралт анхааруулах системд хийн даралтын тохиргоо хийх шаардлагатай. (→X.508)

Дугуйн иж бүрдлийн хийн даралт өмнөх иж бүрдэлтэй ижил үед даралтын тохиргоо хийх шаардлагагүй.

■ ID код бүртгэх үед

- Дугуйн байрлал бүртгэх үйлдэл хэвийн үед 30 орчим минутын дотор дуусдаг.
- 40км/ц (25 миль/ц)-с дээш хурдтай явж ID код бүртгэх боломжтой.
- ID кодыг та өөрөө бүртгэх боломжтой ба нөгөөтээгүүр жолоодлогын нөхцөлөөс хамаарч бүртгэл удаан хийгдэж болно.
- Өмнө нь ID код бүртгэсэн дугуйн иж бүрдэл ашиглах үед дугуйн иж бүрдэл хооронд тохиргоог илүү хурдан солих боломжтой. (→X.512)

■ ID кодын бүртгэл хийхэд хүндрэлтэй байгаа үед

- Дараах нөхцөлүүдэд ID код бүртгэл хийхэд хэвийн үеэс удаан хугацаа шаардах эсвэл хийх боломжгүй болж болно.
- Автомашиныг 40км/ц (25 миль/ц)-с бага хурдаар жолоодсон
- Хатуу хүчилтгүй замаар явсан
- Автомашиныг өөр автомашины ойролцоо явуулснаас тухайн автомашины дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчаас шалтгаалж систем дугуйн даралт анхааруулах хавхлаг болон

дамжуулагчийг танихгүй байгаа

- Дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч суурилуулсан дугуй автомашин дотор эсвэл ойр орчимд байгаа
- Бүртгэх явцад автомашин ухарсан нөхцөлд тухайн цэг хүртэлх цуглуулсан мэдээлэл устана. Үйлдлийг дахин эхэлнэ.
- Бүртгэх үйлдэл 1 цагаас илүү хугацаанд дуусахгүй үед ID код бүртгэх үйлдлийг дахин хийнэ.
- ID код бүртгэх үйлдэл эхлүүлэх үед анхааруулах гэрэл 3 удаа анивчаагүй үед бүртгэх үйлдэл эхлээгүй байж болно.
- Дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч ID код бүртгэгдэхгүй үед Lexus дилертээ хандана уу.

ID код бүртгэлийг цуцлах

ID код бүртгэх үйлдэл эхлүүлсний дараа цуцлах үед голын дэлгэцээс “New tire registration”-г дахин сонгоно.

ID код бүртгэх үйлдэл цуцлагдсан үед дугуйн даралт анхааруулах гэрэл унтарна.

Дугуйн даралт анхааруулах гэрэл унтрахгүй үед ID код цуцлах үйлдэл зөв хийгдээгүй байж болно. Цуцлах үед голын дэлгэцээс “New tire registration”-г дахин сонгоно.

Дугуйн иж бүрдэл сонгох

Таны автомашины дугуйн хийн даралт анхааруулах систем нь 2 өөр иж бүрдэл (өвлийн болон зуны зэргээр) дугуйн ID код бүртгэх боломжтой. Энэ нь

өвлийн дугуй зэрэг 2 дахь иж бүрдэл дугуй бүртгэх боломж олгодог.

- Тус функц нь зөвхөн 2 дахь дугуйн иж бүрдлийг бүртгүүлсэн үед ажиллана. 2 дахь дугуйн иж бүрдэл бүртгүүлээгүй үед дэлгэц дээр “Set 2 (Unregistered)” гарах ба иж бүрдлийн сонголт идэвхжихгүй.

ID кодыг бие даан бүртгэх боломжтой (→X.510)

- Зөвхөн иж бүрдэл хооронд солих боломжтой ба иж бүрдлүүдийн дугуйг хольсон үед функц ажиллахгүй.

- ID код бүртгэх явцад дугуйн иж бүрдэл хооронд солих боломжгүй. Дугуйн иж бүрдэл солихын өмнө бүртгэлийг цуцална.

- Тухайн ашиглах дугуйн иж бүрдлийг автомашинд угсарна.

- 1 Тухайн ашиглах дугуйн иж бүрдлийг автомашинд угсарна.

- 2 Голын дэлгэцээс -г сонгоно.

- 3 “Vehicle customise”-г сонгоно.

- 4 “Tyre pressure”-г сонгоно.

- 5 Дугуйн иж бүрдэл сонгох тохиргооны дэлгэцээс тухайн тохиргоо хийх иж бүрдлийг (“Set 1” эсвэл “Set 2”) сонгоно.

- 6 Бүртгэл хийх гэж буй дугуйг сонгоод “OK” дарна.

Дугуйн даралт анхааруулах гэрэл 3 удаа удаан анивчиж мэдээллийн


дэлгэц дээр өөрчлөлт хийгдэж буйг илэрхийлэх мэдээлэл гарах ба дугуйн иж бүрдэл солих өөрчлөлт хийгдэж эхэлнэ.

Дугуйн иж бүрдэл солих үйлдэл эхлэх ба дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчаад үргэлжлэн асна. Мөн өөрчлөлт хийгдэх явцад мэдээллийн дэлгэцийн дугуй тус бүрийн хийн даралтын заалт “---” болно.

2 орчим минутын хугацаанд дугуйн иж бүрдэл солих үйлдэл дуусах ба дугуйн даралт анхааруулах гэрэл унтарч мэдээллийн дэлгэц дээр үйлдэл дууссаныг илтгэх мэдээлэл гарна.

4 орчим минутын дараа солих үйлдэл дуусахгүй үед дэлгэц дээр дугуйн иж бүрдэл солих үйлдэл бүрэн хийгдээгүйг илтгэх мэдээлэл гарна.

Аль дугуйн иж бүрдэл угсрагдсан байгааг нягтлаад үйлдлийг дахин эхэлнэ.



7 Тухайн угсарсан дугуйн иж бүрдлийн хийн даралт өмнөх иж бүрдлээс өөр байвал дугуйн даралт анхааруулах системийн хийн даралтын тохиргоо хийх шаардлагатай. (→Х.508)

Дугуйн иж бүрдлийн хийн даралт өмнөх иж бүрдэлтэй ижил үед даралтын тохиргоо хийх шаардлагагүй.

8 Дугуй тус бүрийн байрлалыг бүртгэнэ. (→Х.507)

Дугуйны хийн даралт

Дугуйны хийн даралтыг тохирох хэмжээнд барих шаардлагатай. Дугуйны хийн даралтыг сардаа багадаа 1 удаа шалгана. Lexus-н зүгээс 2 долоо хоногт 1 удаа шалгаж байхыг зөвлөж байна.

■ Дугуйны хийн даралт тохироогүй дугуй ашигласан үед

Хийн даралт тохироогүй дугуй ашигласнаар дараах зүйлс үүснэ:

- Шатахуун зарцуулалт муудах
- Жолоодлого болон жолоодлогын тав тух буурах
- Элэгдлээс шалтгаалж дугуйны ашиглалтын хугацаа богиносох
- Аюулгүй байдал буурах
- Явах эд анги гэмтэх

Дугуйны хий гарч байнга хийлдэг болсон тохиолдолд Lexus дилертээ хандана уу.

■ Дугуйны хийн даралт шалгах арга

Дугуйны хийн даралт шалгах үед дараах зүйлсийг баримтална:

- Зөвхөн дугуй хүйтэн үед шалгана. Автомашин 3-с дээш цаг зогссон эсвэл 1.5 км эсвэл 1 миль ба түүнээс хол замд яваагүй үед дугуйн хийн даралт шалгаснаар та зөв хэмжилт хийх боломжтой.
- Дугуйны хийн даралт шалгах үед зөвхөн манометр хэрэглэнэ. Дугуйны хийн даралтыг гадна харагдах байдлаар нь дүгнэх нь хүндрэлтэй.
- Автомашин явах үед дугуй халах ба дугуйны хийн даралт нэмэгдэх нь хэвийн зүйл болно. Тиймээс автомашин явсны дараа дугуйн

даралтыг бууруулж болохгүй.

- Автомашины тэнцвэрийг хадгалах байдлаар зорчигчид болон тээшийг суулгах буюу байрлуулна.



АЮУЛТАЙ

■ Дугуйны барьцалдах чадварыг хадгалахад хийн даралтыг зөв тааруулах нь туйлын чухал

Дугуйн даралтыг зөв тааруулна.

Дугуйны хийн даралтыг зөв тааруулаагүй үед амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй дараах байдал үүсэх аюултай:

- Дугуй хэт элэгдэх
- Тэгш бус элэгдэх
- Жолоодлого муудах
- Дугуй хэт халснаас шалтгаалж дугуй зад үсрэх
- Дугуй обудны завсраар хий алдагдах
- Обуд хэлбэрээ алдах, дугуй гэмтэх
- Хөдөлгөөний үед зам дээр (зам дээрх саад, замын огцом өнцөгтэй булан, 2 замыг холбох тэлэлтийн заадал г.м.) дугуй гэмтэх өндөр эрсдэл үүсэх



АНХААР

■ Дугуйны даралтыг шалгах, тааруулах үед

Дугуйны хошууны тагийг буцааж заавал таглана.

Тагийг буцааж таглаагүй тохиолдолд шороо тоос, чийг хавхлагд орж дугуйны хий алдагдахад хүргэж болзошгүй ба улмаар хийн даралтыг бууруулна.

Обуд

Обуд хэлбэрээ алдсан, цуурсан эсвэл их хэмжээгээр зэвэрсэн үед шинээр солих шаардлагатай. Эсрэг тохиолдолд обуднаас дугуй салах эсвэл жолоодлого алдах аюултай.

Обуд сонгох

Обуд солих үед хуучин обудтай даац, диаметр, өргөн болон обудыг автомашинд угсрах үед дугуй наана болон цаана суух хэмжээ* зэрэг нь ижил обудаар солино.

Шинэ обуд Lexus дилер дээр байгаа болно.

*: Нийтлэг нэршил нь "offset".

Дараах обуд ашиглахыг Lexus дэмждэггүй:

- Өөр хэмжээ болон хэлбэртэй обуднууд ашиглах
- Хуучин обуд
- Хэлбэр алдсан обудыг засаж ашиглах

■ Обуд солих үед

Таны Lexus автомашины обуданд дугуйн даралт багасах үед урьдчилан анхааруулга өгөх зориулалттай дугуйны хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч суурилагдсан байдаг. Тиймээс обуд солих үед дугуйны хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагчийг суурилуулах шаардлагатай. (→X.507)

**АЮУЛТАЙ****■ Обуд солих үед**

- Жолоодлого алдагдахад хүрч болзошгүй тул энэхүү гарын авлага дээр зөвлөснөөс өөр хэмжээтэй обуд ашиглахыг хориглоно.
- Олгой хаймаргүй дугуйнд зориулагдсан обуднаас хий алдагдаж байгаа үед олгой хаймар ашиглахыг хатуу хориглоно. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осол аваарт хүргэх аюултай.

Гэмтэлтэй обуд ашиглахыг хориглоно.

Хагарсан, хэлбэр алдсан обуд ашиглахыг хориглоно.

Эсрэг тохиолдолд хөдөлгөөний үед обуднаас хий алдагдаж осол аваарт хүргэх аюултай.

**АНХААР****■ Дугуйн хийн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч солих**

- Дугуй засах, солих нь дугуйн даралт анхааруулах хавхлаг, дамжуулагчийн ажиллагаанд нөлөөлж болзошгүй тул дугуйтай холбоотой засвар үйлчилгээг та өөрийн Lexus дилер эсвэл бусад мэргэжлийн газраар хийлгэнэ үү. Мөн дугуйн даралт анхааруулах хавхлаг, дамжуулагчийг та Lexus дилерээсээ худалдан авна уу.
- Зөвхөн Lexus-н оригинал обуд ашиглана. Оригинал биш обуд ашиглах үед хавхлаг болон дамжуулагч хэвийн ажиллахгүй байж болно.

Хөнгөн цагаан хайлшин обудны анхааруулга


- Зөвхөн Lexus-н дугуйн гайк болон дугуйн гайкны түлхүүрийг ашиглана.
- Дугуйны байрлал сольсон, дугуй зассан буюу сольсны дараа дугуйн гайк сулраагүй эсэхийг 1600 км (1000 миль) дээр шалгана.
- Дугуйн гинж ашиглах үедээ хөнгөн цагаан хайлшин обудаа гэмтээхээс сэргийлнэ.
- Зөвхөн Lexus-н оригинал эсвэл адил чанартай обуд тэнцвэржүүлэгч жин ашиглах ба тэнцвэржилт тохируулахад хуванцар, резин алх ашиглана.

Салоны агаар шүүгч


Агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах үүднээс салоны агаар шүүгчийг тогтмол солино.

Салгаж авах дараалал


- 1 Асаах товч дарж унтраана.
- 2 Урд хайрцаг нээж тусгаарлах тавиурыг авна. (→X.453)
- 3 Хавтанг салгана.



- 4 Шүүрийн таг (A) -н түгжээг тайлаад (B) хумснаас шүүрийн тагийг салгаж авна.




- 5 Агаар шүүгчийн хайрцгийг салгана.



- 6 Хайрцгаас салоны шүүр гаргаж шинээр солино.

Шүүгч дээрх “↑ UP” тэмдгийг дээш харуулна.



■ Шалгах давтамж

Засвар үйлчилгээний хуваарийн дагуу шалгана. Тоос шороотой эсвэл хөдөлгөөний ачаалал ихтэй зам дээр шүүлтүүрийг илүү богино давтамжтай шалгана. (→X.484)

■ Үлээх агаарын хэмжээ огцом буурсан үед

Агаар шүүгч бөглөрсөн байж болно. Агаар шүүгчийг шалгаад шаардлагатай бол солино.


**АНХААР**

■ **Агааржуулалтын систем ашиглах үед**

Шүүлтүүр суурилуулсан байгааг нягтална. Шүүлтүүргүйгээр ашиглах нь агааржуулалтын системд гэмтэл учруулна.

■ **Шүүлтүүрийн тагийг гэмтлээс сэргийлэх**

Сумны чиглэлийн дагуу хөдөлгөж таг салгах үед хумсанд хэт даралт учруулахаас сэргийлнэ. Хайрцгийн хумс гэмтэх аюултай.

**Электрон түлхүүрийн зай**

Цэнэг суусан үед зайг шинээр солино. Дараах үйлдлийг зөв хийгээгүй нөхцөлд түлхүүр гэмтэх тул түлхүүрийн зайг Lexus дилер дээрээ солиулах нь зүйтэй.

■ **Цэнэг дууссан үед**

Дараах шинж тэмдэг илэрч болно:

- Smart entry & start систем болон түлхүүрийн алсын удирдлага хэвийн ажиллахгүй.
- Системийн мэдрэх хүрээ багасна.

■ **Түлхүүр картын зай солих үед (тоноглогдсон загварт)**

Түлхүүр картын зай зөвхөн Lexus дилер дээр байдаг. Та өөрийн Lexus дилер дээрээ зайг солиулж болно.

Бэлдэх зүйлс

Дараах зүйлсийг бэлдэнэ:

- Хасах толгойтой халив
- Хасах толгойтой жижиг халив
- Литийн зай: CR2032 эсвэл CR2450

■ **Литийн зай CR2032 эсвэл CR2450 ашиглах**


- Түлхүүрийг зайг та өөрийн Lexus дилер, цахилгаан барааны болон зургийн аппаратын дэлгүүрээс худалдан авах боломжтой.
- Үйлдвэрлэгчийн ашиглахыг зөвлөж буй эсвэл түүнтэй ижил болон дүйцэх төрлийн зай ашиглана.
- Хуучин зайг тухайн улс орны хуульд

заасны дагуу хаяж устгана.

Зай солих


▶ А төрөл

- 1 Механик түлхүүрийг сугалж авна.




- 2 Тагийг тайлж авна.

Түлхүүрт гэмтэл учруулахаас сэргийлж гэмтэл халивын үзүүрийг даавуугаар жийрэглэнэ.




- 3 Хуучин зайг салгаж авна.

Шинэ зайны “+” талыг дээш харуулан хийнэ.



▶ В төрөл


- 1 Механик түлхүүрийг сугалж авна.



- 2 Тагийг тайлж авна.




- 3 Зайны тагийг авна.



- 4 Хуучин зайг салгаж авна.

Шинэ зайны “+” талыг дээш

харуулан хийнэ.



⚠ АЮУЛТАЙ

■ Зайтай холбоотой анхааруулга

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

- Зайг залгивч болохгүй. Химийн түлэгдэлд хүргэнэ.
- Электрон түлхүүрт товчин эсвэл зоосон зай ашиглагддаг. Зайг залгивал 2 цагийн дотор химийн түлэгдэл үүсгэх ба амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.
- Шинэ ба хуучин зайг хүүхдийн гар хүрэхгүй газар байлгана.
- Таг бүрэн хаагдахгүй үед түлхүүрийг ашиглаж болохгүй бөгөөд хүүхдийн гар хүрэхгүй газар байлгаж Lexus дилерт хандана.
- Санамсаргүйгээр зай залгисан, биеийн аль нэг хэсэгтээ оруулсан үед нэн даруй эмнэлгийн яаралтай тусламж авна уу.
- **Зай дэлбэрэх, шатамхай шингэн эсвэл хий гарахаас сэргийлэх**
- Зөвхөн хуучин зайтай адил төрлийн зай ашиглана. Буруу төрлийн зай ашиглавал зай дэлбэрэх аюултай.
- Өндөрлөг газар зэрэг хэт бага даралттай газар эсвэл хэт өндөр хэмтэй газар зайг байлгаж болохгүй.

- Зайг түлэх, эвдлэх, хуваах, зүсэхийг хориглоно.

⚠ АНХААР

■ Зай солих үед

Тохирох хэмжээтэй хасах халив ашиглана. Хэт хүчтэй дарах нь зай хэлбэрээ алдах, гэмтэхэд хүргэнэ.

■ Түлхүүрийн зай сольсны дараа

Ослоос сэргийлж дараах анхааруулгыг дагаж мөрдөнө:

- Зөвхөн гар хуурай үед солино. Чийг нь зайнд зэврэлт үүсгэх аюултай.
- Түлхүүр доторх бусад хэсгүүдэд хүрэх, хөдөлгөхийг хориглоно.
- Зайны терминалуудыг далийлгах, хэлбэрийг нь өөрчлөхийг хориглоно.

Гал хамгаалагч

Аль нэг төхөөрөмж ажиллахгүй байвал гал хамгаалагч шатсан байж болно. Гал хамгаалагчийг зайлшгүй шалгаж солино.


Шалгах, солих

- 1 Асаах товчийг дарж унтраана.
- 2 Хөдөлгүүрийн таг авна. (→X.495)
- 3 Гал хамгаалагчийн хайрцгийн тагийг нээнэ.

► Хөдөлгүүрийн хэсэг


А төрөл:

Хумсан дээр дарж тагийг авна.




В төрөл:

Хумсан дээр дарж тагийг авна.




► Удирдлагын самбар (зүүн жолооны хүрдтэй)

A тагийг аваад **B** хөлийн гэрлийн (тоноглогдсон загварт) холбоосыг салгана.




Тагийг салгаж авна.



► Удирдлагын самбар (баруун жолооны хүрдтэй)


Тагийг салгаж авна.



4 Гал хамгаалагчийг тусгай багажаар салгана.

Зөвхөн зарим төрлийн гал хамгаалагчийг багажаар авах

боломжтой.




5 Гал хамгаалагч шатсан эсэхийг шалгана.

A, B төрлийн гал хамгаалагч: Зохих ампертай шинэ гал хамгаалагчаар шатсан гал хамгаалагчийг солино. Амперын мэдээллийг гал хамгаалагчийн тагнаас харж болно.

C, D төрлийн гал хамгаалагч: Lexus дилертээ хандана уу.


► A төрөл



A Шатаагүй гал хамгаалагч

B Шатсан гал хамгаалагч


► B төрөл



A Шатаагүй гал хамгаалагч

B Шатсан гал хамгаалагч


► C төрөл



A Шатаагүй гал хамгаалагч

B Шатсан гал хамгаалагч

► D төрөл



A Шатаагүй гал хамгаалагч

B Шатсан гал хамгаалагч

■ Гал хамгаалагч сольсны дараа

- Тагийг буцааж гүйцэд угсарна.
- Гал хамгаалагч сольсон ч гэрэл асахгүй байвал гэрлийн лампыг солих шаардлагатай. (→X.522)
- Гал хамгаалагч дахин шатсан нөхцөлд та автомашинаа Lexus дилерт хандаж оношлуулна уу.

■ Хэлхээнд хэт ачаалал үүссэн үед

Гал хамгаалагч нь хэлхээний утсыг хамгаалж шатдаг.

■ Гэрлийн ламп солих үед

Lexus нь тус автомашинд зориулагдсан Lexus-н оригинал бүтээгдэхүүн ашиглахыг зөвлөж байна. Тодорхой төрлийн лампууд нь хэлхээний хэт ачааллаас сэргийлэхэд зориулагдсан байдаг тул оригинал биш эсвэл тус автомашинд зориулагдаагүй ламп ашиглах боломжгүй байж болно.



АЮУЛТАЙ

■ Системийн эвдрэл, автомашины гал түймрээс сэргийлэх

Автомашинд гэмтэл үүсэх мөн гал гарах, гэмтэлд хүрэх аюултай тул дараах анхааруулгыг мөрдөнө.

- Зааснаас өндөр ампертай гал хамгаалагч эсвэл гал хамгаалагчийн оронд өөр зүйл хийж ашиглахыг хатуу хориглоно.
- Зөвхөн Lexus-н оригинал эсвэл дүйцэх чанартайг ашиглана. Түр зуурын засвар байсан ч цахилгааны утас ашиглахгүй.
- Гал хамгаалагч болон хайрцгийг өөрчлөхийг хориглоно.



АНХААР

■ Гал хамгаалагч солихын өмнө

Lexus дилертээ нэн даруй хандаж цахилгааны хэт ачааллын шалтгааныг тодруулж засуулна.

Гэрлийн ламп

Дараах гэрлүүд шатсан нөхцөлд Lexus дилер дээрээ солиулна уу.

■ LED гэрлүүд

Автомашины гэрлүүд нь олон тооны LED гэрлээс бүрддэг. Аль нэг LED гэрэл шатсан тохиолдолд Lexus дилертээ хандаж шинээр солиулна уу.

■ Линз дотор хөлрөлт үүссэн үед

Линз дотор богино хугацаанд хөлрөлт үүсэх нь хэвийн үзэгдэл юм. Дараах нөхцөлд Lexus дилертээ хандаж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу:

- Линз дотор талд усны том дуслууд үүссэн үед
- Гэрэл дотор ус хуралдсан үед

- 7-1. Чухал мэдээлэл
 Ослын дохионы гэрэл ...524
 Онцгой нөхцөл байдалд
 автомашин зогсоох
 шаардлагатай үед524
 Түвшин нэмэгдэж буй усанд
 автомашин суусан үед 525
- 7-2. Онцгой нөхцөлд авах арга
 хэмжээ
 Чирүүлэх, ачиж тээвэрлэх
 үед527
 Автомашинд асуудал
 гарсан гэж үзвэл
530
 Бензин насос таслах
 систем531
 Анхааруулах гэрэл ассан,
 анхааруулах дохио
 дуугарсан үед532
 Дэлгэц дээр анхааруулга
 гарсан үед541
 Дугуй хагарсан үед548
 Хөдөлгүүр асахгүй үед..557
 Түлхүүрээ гээсэн үед559
 Электрон түлхүүр хэвийн
 ажиллахгүй үед.....559
 Аккумуляторын цэнэг суусан
 үед561
 Хөдөлгүүр халсан үед...566
 Автомашин суусан үед..568

Ослын дохионы гэрэл


Эвдрэл гэмтлийн улмаас зам дээр зогсох үед бусад жолоочид анхааруулах үүднээс ослын дохионы гэрэл ашиглана.

Ашиглах зааварчилгаа

Товчийг дарна.

Эргэх дохионы бүх гэрэл анивчих горимоор асна.

Ослын дохионы гэрлийг унтраахдаа товчийг дахин дарна.



■ Ослын дохионы гэрэл

- Хөдөлгүүр унтраастай үед ослын дохионы гэрлийг удаан асаавал аккумуляторын цэнэг сууна.
- Аль нэг SRS аюулгүйн дэр дэлгэгдсэн эсвэл хойд талаас хүчтэй мөргөлт ирсэн үед ослын дохионы гэрэл автоматаар асна. Ослын дохионы гэрэл 20 минут асаад автоматаар унтарна. Товчлуур дээр 2 удаа дарж ослын дохионы гэрлийг гар аргаар унтраах боломжтой (Мөргөлтийн хүч, нөхцөлөөс хамаарч ослын дохионы гэрэл автоматаар асахгүй байж болно).


Онцгой шаардлагатай үед автомашиныг зогсоох

Автомашиныг хэвийн байдлаар зогсоох боломжгүй зэрэг зөвхөн онцгой, аваарын нөхцөл үүссэн үед дараах дарааллаар зогсооно:

Автомашин зогсоох

- 1 Тоормосны дөрөөг 2 хөлөөрөө чанга үргэлжлүүлэн гишгэнэ.
- Автомашиныг зогсооход шаардагдах тоормосны үйлчилгээ буурах тул тоормосны дөрөөг олон дахин гишгэж болохгүй.
- 2 Арааг N байрлалд шилжүүлнэ.
 - Араа N байрлалд шилжсэн үед
- 3 Хурд буурсны дараа замын хажуу талд аюулгүй газарт зогсоно.
- 4 Хөдөлгүүрийг унтраана.
 - Арааг N байрлалд шилжүүлж болохгүй үед
- 3 Автомашины хурдыг боломжит хэмжээнд хамгийн ихээр бууруулахын тулд тоормосны дөрөөг 2 хөлөөрөө үргэлжлүүлэн гишгэнэ.
- 4 Асаах товчийг 2 ба түүнээс дээш секунд үргэлжлүүлэн дарах эсвэл 3 ба түүнээс олон удаа богино хугацаанд

товчийг дарж хөдөлгүүрийг унтраана.



5 Замын хажуу талд аюулгүй газарт зогсооно.

■ Онцгой нөхцөл байдалд автомашин зогсоосон үед

Аккумуляторын цэнэг зарцуулалтыг бууруулах үүднээс агааржуулалтын систем зэрэг функцүүдийн ажиллагаа хязгаарлагдана.



АЮУЛТАЙ

■ Хөдөлгөөний үед хөдөлгүүр унтраах шаардлагатай тохиолдолд

Хөдөлгүүр унтраасан ч жолооны хүчлүүр эсвэл тоормосны удирдлага ажиллагаагүй болохгүй. Нөгөөтээгүүр аккумуляторын үлдэгдэл цэнэгийн хэмжээ эсвэл ашиглалтын нөхцөл байдлаас шалтгаалж эдгээр системийн хүчлүүрийн ажиллагаа жолоодлого хийх эсвэл зогсооход хүндрэлтэй болж болно. Хөдөлгүүр унтраахаас өмнө хангалттай хэмжээнд хурд хасна.

Түвшин нэмэгдэж буй усанд автомашин суусан үед

Тус автомашин нь гүнзгий устай, үерлэсэн замаар явахад зориулагдаагүй болно. Түвшин нэмэгдэж байгаа эсвэл үерлэсэн замаар явж болохгүй. Автомашин усанд живэх, урсаж эхлэх үед автомашинд үлдэх нь аюултай тул усанд автсан, живсэн үед сандралгүй тайван байж, дараах арга хэмжээг авна.

- Хаалга онгойлгох боломжтой байвал хаалгыг онгойлгож автомашинаас гарна.
- Хаалга онгойхгүй үед цонх нээх товчоор цонхийг нээж автомашинаас гарах боломжийг нягтална.
- Цонх нээх боломжтой үед цонхоор гарна.
- Түвшин нэмэгдэж буй уснаас шалтгаалж хаалга болон цонх нээгдэхгүй үед сандралгүй тайван байж автомашины гадна болон дотор талын усны даралт ижил болох хүртэл бүхээгийн усны түвшин нэмэгдэхийг хүлээгээд дараа нь хаалгыг нээж гарна. Автомашины гадна талын усны түвшин хаалганы дундаас дээш байгаа үед усны

даралтаас шалтгаалж хаалгыг дотор талаас онгойлгох боломжгүй.

■ Усны түвшин шал давсан үед

Усны түвшин шал давсан үед тодорхой хугацааны дараа электрон төхөөрөмжүүд гэмтэж автомат цонх ажиллагаагүй болох ба хөдөлгүүр унтарч автомашиныг хөдөлгөх боломжгүй болно.

■ Аваарын алх ашиглах^{*1}


Тус автомашины салхины болон цонхны шилэнд давхар хальсаар бүрсэн шил^{*2} ашиглагддаг. Давхар хальсаар бүрсэн шилийг аваарын алхаар^{*1} хагалах боломжгүй.

^{*1}: Аваарын алхны тухай дэлгэрэнгүй мэдээллийг та өөрийн Lexus дилер эсвэл авто тоноглолын дэлгүүрээс авна уу.

^{*2}: тоноглогдсон загварт

■ Давхар хальсаар бүрсэн шил таних арга

Давхар хальсаар бүрсэн шилийг хажуу талаас нь харвал давхарласан 2 шилнээс бүрдэж харагдана.



A Давхар хальсаар бүрсэн шил

B Хатаасан шил



АЮУЛТАЙ

■ Жолоодлогын үеийн анхааруулга

Усны түвшин нэмэгдэж байгаа эсвэл үерлэсэн замаар явж болохгүй. Автомашин эвдэрч явахгүй болох мөн үерт автах, урссанаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах аюулд хүрнэ.

Чирүүлэх, тээвэрлэх үед

Чирүүлэх шаардлагатай үед өөрийн Lexus дилер эсвэл мэргэжлийн байгууллагад хандан дугуй өргөгчтэй чирэгчээр чирүүлэх эсвэл тэвштэй бүтэн ачигч машинаар ачиж тээвэрлүүлнэ.

Чирэх үед аюулгүйн гинж ашиглах ба орон нутгийн хууль дүрмийг мөрдөнө.


Чирүүлэхийн өмнө дилерт хандах нөхцөл

Дараах нь хурдны хайрцагт гэмтэл үүссэнийг илтгэнэ. Чирүүлэхийн өмнө Lexus дилер, мэргэжлийн байгууллагад хандана.

- Хөдөлгүүр асаалттай ч автомашин хөдлөхгүй үед
- Автомашинаас хэвийн бус дуу гарч байгаа үед


Дугуй өргөгчтэй чирэгч машинаар чирэх

- Урдаас чирэх



Хойд дугуйнд чирэх дугуйг хийнэ.

- Ардаас чирэх



Урд дугуйнд чирэх дугуйг хийнэ.


⚠ АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

■ Чирүүлэх үед

Автомашин тээвэрлэх үед бүх 4 дугуйг газраас хөндий тээвэрлэнэ. Дугуй газартай харьцсан байдалтай чирэх үед явах эд анги болон түүнтэй холбоотой бусад эд ангиуд гэмтэх, автомашин ачааны машинаас даялж шидэгдэх аюултай.





АНХААР


■ **Дугуй өргөгчтэй чирэгч машинаар чирэх үед автомашиныг гэмтлээс хамгаалах**

● Жолооны хурд түгжигч функцтэй загвар: Хөдөлгүүр асаах товч унтраастай үед автомашины хойд талаас чирэхийг хориглоно. Жолооны хурд түгжих механизмд урд дугуйг шулуун барих техникийн хүчин чадал байхгүй.

● Автомашин өргөх үед өргөсөн талын эсрэг талд газар хүртэл хангалттай зай үлдээнэ. Эсрэг тохиолдолд чирэх үед газарт шүргэж автомашин гэмтэнэ.


■ **Крантай машинаар чирэх**

Автомашины их биед гэмтэл учруулахаас сэргийлж крантай машинаар чирэхийг хориглоно.




Тэвштэй бүтэн ачигч машинаар ачиж тээвэрлэх

Тэвштэй бүтэн ачигч машинаар тээвэрлэх үед зурагт цэгүүдийг ашиглан тэвштэй бэхэлнэ.



Бэхэлгээнд олс, гинж ашиглах үед хараар тодруулсан хэсгийн өнцөг 45° байх ёстойг анхаарна.



Дээрх аргаар автомашиныг бэхлэх боломжгүй үед дугуйгаар бэхлэх олс ашиглана.



АНХААР

■ **Тэвштэй бүтэн ачигч машинаар тээвэрлэх үед**

Автомашинд гэмтэл учруулах тул бэхэлгээг хэт чангалж болохгүй.

Ослын үед чирэх


Чирэгч автомашин олдохгүй үед зайлшгүй шаардлагатай үед чирэх дэгээнд олс, гинж холбон богино зайнд чирүүлэх боломжтой. Чирэх үйлдлийг зөвхөн хатуу гадаргуутай зам дээр 30км/ц (18 миль/ц) хүртэлх хурдаар богино зайнд хийж болно.

Чирүүлэх үед жолооч жолооны хурд, тоормостой харьцах бөгөөд автомашины дугуй, явах эд анги, тэнхлэг, жолооны механизм болон тоормосны ажиллагаа хэвийн байх шаардлагатай.

Ослын үед чирэх дараалал

- 1 Чирэх дэгээнд олс, гинжийг сайтар бэхэлнэ.

Автомашины их биед гэмтэл учруулахгүй байхад анхаарна.



- 2 Жолооч чирүүлэх автомашины жолооны ард суугаад хөдөлгүүр асаана.

Хөдөлгүүр асахгүй үед асаах товчийг ON болгоно.

- 3 Дөрвөн дугуй хөтлөх системийн товчийг “Н4”-д шилжүүлнэ. (төвийн дифференциалыг* салгана.

*: Тоноглогдсон загварт

- 4 Арааг N байрлалд шилжүүлж зогсоолын тоормос салгана.

Автомат горимыг унтраана.
(→X.214)

Арааны хөшүүрэг шилжихгүй үед:
→X.209

■ Чирэх үед

Хөдөлгүүр асахгүй үед жолооны хүрд, тоормосны аппаратур ажиллахгүй тул жолооны хүрд, тоормос хүнд болно.

! АЮУЛТАЙ

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

■ Чирэх үед

● Олс, гинж ашиглан чирэх үед чирэх дэгээ, олс, гинжинд хэт ачаалал өгөх огцом хөдөлгөөн зэргээс зайлсхийнэ. Чирэх дэгээ, уян холбоос гэмтэж шидэгдсэн хэлтэрхий ойр орчимд байгаа хүнийг ноцтой гэмтээж болзошгүй.

● Жолооны хүрд түгжигчтэй загвар: Асаах товчийг Off горимд буцааж болохгүй. Жолооны хүрд түгжигдэж жолоодлого хийх боломжгүй болох аюултай.

! АНХААР

■ Зайлшгүй тохиолдолд чирэх үед автомашиныг гэмтлээс хамгаалах

Олс, гинжийг автомашины явах эд ангиас уяхгүй.

Автомашинд асуудал гарсан гэж үзвэл

Таны автомашинд дараах аль нэг шинж тэмдэг илрэх нь тохиргоо, засвар үйлчилгээ хийх шаардлагатай байгааг илэрхийлнэ. Lexus ди-лертээ нэн даруй хандана уу.

Ил харагдах шинж тэмдэг

- Автомашины доороос шингэн дусах.
(Эйр кондишн ажилласны дараа ус дусах нь хэвийн болно.)
- Дугуй тэгш бус элэгдэх, хагарсан мэт харагдах.
- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний температур хэвийн үеэс өндөр заах.
- Хөдөлгүүрийн тосны даралт хэвийн хэмжээнээс тогтмол бага заах.
- Вольтметр хэвийн хэмжээнээс тогтмол өндөр эсвэл бага заах.

Сонсогдох шинж тэмдэг

- Яндангийн дуу өөрчлөгдөх
- Эргэлт дээр дугуй хэт чахарч дуугарах
- Явах эд ангиас хэвийн бус дуу гарах
- Хөдөлгүүрт цохио үүсэх бусад дуу чимээ гарах

Ажиллагаатай холбоотой шинж тэмдэг

- Хөдөлгүүр доголдох, хүч алдах, бөглөрөх
- Хүч илт муудах
- Тоормослох үед автомашин нэг тал руугаа зуурах
- Тэгш зам дээр автомашин нэг тийш хазайх
- Тоормосны ажиллагаа алдагдах, дөрөө зөөлөн болох, шаланд тулах

Бензин насос таслах систем

Хөдөлгүүр хүч алдаж унтрах, мөргөлтийн үед аюулгүйн дэр дэлгэгдэх үед шатахуун алдагдах эрсдэлийг хамгийн бага хэмжээнд бууруулах үүднээс бензин насос таслах систем тасалдаг.

Хөдөлгүүр асаах

Систем ажилласны дараа хөдөлгүүр асаах үед дараах үйлдлийг хийнэ.

- 1 Асаах товчийг ACC эсвэл OFF горимд шилжүүлнэ.
- 2 Хөдөлгүүр асаана.



АНХААР

■ Хөдөлгүүр асаахын өмнө

Автомашины доод талын замын гадаргууг шалгана.

Хэрэв зам дээр шатахуун асгарсан байвал шатахууны системд гэмтэл үүссэн ба солих шаардлагатай. Энэ тохиолдолд хөдөлгүүр асааж болохгүй.

Анхааруулах гэрэл ассан, дохио дуугарсан үед

Анхааруулах гэрэл ассан, анивчсан үед дараах үйлдлийг яарч сандралгүй хийнэ. Анхааруулах гэрэл ассан эсвэл анивчсаны дараа буцаж унтрах нь системд доголдол үүссэнийг илэрхийлэхгүй. Нөгөөтээгүүр энэ тохиолдол олон давтагдах үед та өөрийн Lexus дилерт хандаж оношлуулна уу.

Анхааруулах гэрэл, дохионы авах арга хэмжээ

■ Тоормосны системийн анхааруулах гэрэл (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Улаан)	Дараах утгыг илэрхийлнэ: ● Тоормосны шингэний хэмжээ бага ● Тоормосны системд доголдол үүссэн → Автомашиньг аюулгүй газарт даруй зогсоогоод өөрийн Lexus дилерт хандана уу. Үргэлжлүүлэн жолоодох нь аюултай.

■ Тоормосны системийн анхааруулах гэрэл (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Шар)	Дараах аль нэг доголдол үүссэнийг илэрхийлнэ: ● Зогсоолын тоормосны систем ● Цахилгаан удирдлагатай тоормосны систем → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Аккумулятор цэнэглэх системийн анхааруулах гэрэл* (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Цэнэглэх системд доголдол үүссэнийг заана → Аюулгүй газарт даруй зогсон Lexus дилертээ хандана уу.

* : Тус гэрэл мэдээллийн дэлгэц дээр гарна.

■ Хөдөлгүүрийн тосны даралт багассаныг анхааруулах гэрэл* (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Хөдөлгүүрийн тосны даралт бага байгааг анхааруулна. → Аюулгүй газарт даруй зогсон Lexus дилертээ хандана уу.

* : Тус гэрэл мэдээллийн дэлгэц дээр гарна.

■ Хөргөлтийн шингэний хэм анхааруулах гэрэл* (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Хөдөлгүүр хэт халсныг илэрхийлнэ → Автомашиныг аюулгүй газарт даруй зогсооно. Авах арга хэмжээ (→Х.566)

* : Тус гэрэл мэдээллийн дэлгэц дээр гарна.

■ Доголдол анхааруулах гэрэл

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Дараах аль нэг доголдол үүссэнийг илэрхийлнэ: ● Хөдөлгүүрийн электрон удирдлагын систем ● Хөдөлгүүрийн электрон хаазны удирдлагын систем ● Электрон хурдны хайрцгийн удирдлагын систем ● DPF систем (тоноглогдсон загварт) → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ SRS анхааруулах гэрэл

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Дараах аль нэг доголдол үүссэнийг илэрхийлнэ: ● SRS аюулгүйн дэрний систем ● Аюулгүйн бүс буцаан чангалагч систем → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ ABS анхааруулах гэрэл

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Дараах аль нэг доголдол үүссэнийг илэрхийлнэ: ● ABS тоормос ● Тоормосонд туслах систем → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Жолооны хүчлүүрийн анхааруулах гэрэл (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Улаан)  (Шар)	EPS электрон жолооны хүчлүүрийн системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ PCS анхааруулах гэрэл (анхааруулах дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	PCS (Мөргөлтийн өмнөх аюулгүйн систем)-н доголдлыг илэрхийлнэ. → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана. VSC (автомашины тэнцвэрийн систем), PCS системийг идэвхгүй болгосон үед PCS анхааруулах гэрэл асна.

■ LTA индикатор (анхааруулах дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Шар)	LTA системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана.

■ LDA индикатор (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Шар)	LDA системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана.

■ PDA индикатор (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Шар) (тоноглогдсон загварт)	PDA системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана.

■ Хурд баригчийн индикатор (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Шар)	Хурд баригч системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана.

■ Динамик радарын хурд баригчийн индикатор (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Шар)	Динамик радарын хурд барих системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана.

■ Хурд хязгаарлагчийн индикатор (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Шар)	Хурд хязгаарлагч системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана.

■ Жолоодлогод туслах мэдээллийн индикатор

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Дараах аль нэг системд доголдол үүссэн байж болзошгүйг илтгэнэ. ● PCS систем ● LDA систем → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана. Дараах системд доголдол үүссэн эсвэл ажиллагаа цуцлагдсаныг илтгэнэ. ● PKSB тоормос (тоноглогдсон загварт) ● BSM систем (тоноглогдсон загварт) ● RCTA систем (тоноглогдсон загварт) ● Аюулгүй буухад туслах систем → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана.

■ Lexus parking assist-мэдрэгчийн OFF индикатор (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Lexus parking assist-мэдрэгч функцэд доголдол үүссэнийг илтгэнэ. → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу. Мэдрэгч бохирдсон эсвэл мөс тогтсон зэргээр систем түр цуцлагдсаныг илтгэнэ. → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана. (→X.541)

■ Дөрөөний буруу ажиллагааг анхааруулах гэрэл* (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Анхааруулах дохио дуугарсан үед: ● Brake Override системд доголдол үүссэн ● Хөдөлгөөн эхлэх удирдлагад доголдол үүссэн ● Хөдөлгөөн эхлэх удирдлага ажиллаж байгаа → Мэдээллийн дэлгэц дээрх зааварчилгааг дагана. Анхааруулах дохио дуугарахгүй үед: Brake Override систем ажиллаж байгаа. → Хаазны дөрөөг суллаж тоормос гишгэнэ.

* : Тус гэрэл мэдээллийн дэлгэц дээр гарна.

■ Шарвалтын индикатор

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Дараах аль нэг доголдол үүссэнийг илэрхийлнэ: ● VSC систем ● Чиргүүлийн савлагааг хянах систем ● Active TRC систем ● Өгсүүр замд хөдөлгөөн эхлэхэд туслах удирдлагын систем ● Уруу замд туслах удирдлагын систем ● Multi-terrain Select (тоноглогдсон загварт) ● Crawl Control (тоноглогдсон загварт) → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ 4 дугуй хөтлөх системийн нам хурдны индикатор

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Анивчих)	Гэрэл хурдан анивчих нь 4 дугуй хөтлөх системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Төвийн дифференциал цоожлогчийн индикатор

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Анивчих)	Гэрэл хурдан анивчих нь төвийн дифференциал цоожлогчийн системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Арын дифференциал цоожлогчийн индикатор

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Анивчих) (тоноглогдсон загварт)	Арын дифференциал цоожлогчийн системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Зогсоолын тоормосны индикатор

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Анивчих)	Зогсоолын тоормос бүрэн залгагдаагүй эсвэл салгагдаагүйг илтгэнэ. → Зогсоолын тоормосны товч дахин ажиллуулна. Зогсоолын тоормос салгагдаагүй үед гэрэл асна. Зогсоолын тоормос салгасны дараа гэрэл унтрах нь систем хэвийн ажиллаж байгааг илтгэнэ.

■ Тоормос баригчийн ажиллагааны индикатор (дохио)

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
 (Анивчих)	Тоормос баригчийн системд доголдол үүссэнийг илтгэнэ. → Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Шатахуун багассаныг анхааруулах гэрэл

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Шатахууны үлдэгдэл хэмжээ 12.0 л (3.2 gal., 2.6 Imp.gal.)-с багассан → Шатахуун цэнэглэнэ.

■ Дугуйн даралт анхааруулах гэрэл

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Гэрэл асах: ● Хэвийн шалтгаанаар дугуйн даралт буурсан → Дугуй хангалттай хөрсний дараа дугуй тус бүрийн даралтыг тохируулна. ● Дугуй хагарсан → Автомашин даруй аюулгүй газар зогсоож шаардлагатай арга хэмжээг авна. Гэрэл 1 минут анивчсаны дараа асах (дохио дуугарахгүй): Дугуйн даралт анхааруулах систем доголдсон → Та өөрийн Lexus дилер дээр системийг шалгуулна уу.

■ Жолооч, урд зорчигчийн аюулгүйн бүсний гэрэл (дохио)*

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Жолооч/урд зорчигчид аюулгүйн бүс сануулах → Аюулгүйн бүс зүүнэ. Урд зорчигчийн суудалд зорчигч суусан нөхцөлд анхааруулах гэрэл (дохио)-г унтраах үед зорчигч аюулгүйн бүс зүүнэ.

*: Жолооч болон урд зорчигчийн аюулгүйн бүсний анхааруулах дохио: Жолооч болон урд зорчигчийн аюулгүйн бүсний анхааруулах дохио нь жолооч болон урд зорчигч аюулгүйн бүс бүслээгүйг анхааруулна. Бүс бүслээгүй үед автомашины хурд тодорхой хурдад хүрсний дараа тодорхой хугацаанд тасалдаж дуугарна.

■ Арын зорчигчийн аюулгүйн бүсний гэрэл (дохио)*

Анхааруулах гэрэл	Дэлгэрэнгүй/Авах арга хэмжээ
	Арын зорчигчид аюулгүйн бүс бүслэхийг сануулна → Аюулгүйн бүс зүүнэ.

*: Арын зорчигчийн аюулгүйн бүсний анхааруулах дохио: Арын зорчигчийн аюулгүйн бүсний анхааруулах дохио нь арын зорчигч аюулгүйн бүс бүслээгүйг анхааруулна. Бүс бүслээгүй эсвэл бүс бүслээд буцаагаад тайлсан үед автомашины хурд тодорхой хурдад хүрсний дараа тодорхой хугацаанд тасалдаж дуугарна.

■ Анхааруулах дохио

Дуу чимээтэй эсвэл аудио хөгжмийн дуунаас шалтгаалж зарим үед дохио сонсогдохгүй байж болно.

■ Урд зорчигч мэдрэх мэдрэгч, зорчигчийн аюулгүйн бүсний анхааруулах гэрэл, дохио

- Урд зорчигчийн суудал дээр эд зүйл тавьсан үед суудлын мэдрэгч ажиллаж урд суудалд зорчигч суугаагүй үед ч анхааруулах гэрэл анивчиж дохио дуугарч болно.
- Суудал дээр зөөлөвч тавьсан үед мэдрэгч зорчигч суусныг мэдрэхгүй байх улмаар анхааруулах гэрэл ажиллахгүй байж болно.

■ Жолоодлогын үед доголдол анхааруулах гэрэл ассан үед

Зарим загварт шатахуун бүрэн дууссан үед доголдол анхааруулах индикатор асна. Даруй шатахуун цэнэглэх ба доголдол анхааруулах гэрэл хэсэг явалтын дараа унтарна. Гэрэл унтрахгүй байгаа тохиолдолд та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ Цахилгаан жолооны хүчлүүрийн анхааруулах гэрэл (дохио)

Аккумуляторын цэнэг хангалтгүй болох эсвэл хүчдэл түр хугацаанд унах үед цахилгаан жолооны хүчлүүрийн анхааруулах гэрэл асаж дохио дуугарч болно.

■ Дугуйн даралт анхааруулах гэрэл асах үед

Дугуй хагараагүй эсэхийг шалгана.

Дугуй хагарсан үед: →Х.548

Дугуй хагараагүй үед:

Хөдөлгүүрийг унтраагаад ОН горимд асаана. Дугуйн даралт анхааруулах гэрэл асах эсвэл анивчиж байгаа эсэхийг нягтална.

► Дугуйн даралт анхааруулах гэрэл 1 минут анивчаад асаж байгаа үед

Дугуйн даралт анхааруулах системд доголдол үүссэн байж болзошгүй. Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

► Дугуйн даралт анхааруулах гэрэл ассан үед

Дугуй хангалттай хөрсний дараа дугуй бүрийн даралтыг шалгаж тохирох хэмжээнд тохируулна.

Тодорхой хэдэн минут өнгөрсөн ч анхааруулах гэрэл унтрахгүй үед дугуй тус бүрийн хийн даралтыг шалгаад системийн тохиргоог дахиж хийнэ. (→Х.508)

Дугуйн даралтын тохиргоог системд зөв хийсэн ч хэдэн минутын дараа анхааруулах гэрэл унтрахгүй үед та Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Байгаль цаг агаарын шалтгаанаар дугуйн даралт анхааруулах гэрэл асах

Температурын өөрчлөлт зэргээс шалтгаалан дугуйн хий өөрөө гарах зэргээс шалтгаалж дугуйн хийн даралт анхааруулах гэрэл асаж болно. Энэ тохиолдолд дугуйн хийн даралтыг тохируулсны дараа гэрэл унтарна (тодорхой хэдэн минутын дараа).

■ Нөөц дугуй ашиглах үед

Нөөц дугуйнд мөн дугуйн даралт анхааруулах хавхлаг болон дамжуулагч суурилагдсан байдаг. Нөөц дугуйны хийн даралт бага үед дугуйн даралт анхааруулах гэрэл асна. Дугуйны хий гарсан үед нөөц дугуй сольж ашигласан ч дугуйн даралт анхааруулах гэрэл унтрахгүй.

Засаж хийн даралтыг зөв тохируулсан дугуйгаар нөөц дугуйг буцааж солино. Дугуйн даралт анхааруулах гэрэл

хэдэн минутын дараа унтарна.

■ Дугуйн даралт анхааруулах системийн хэвийн ажиллагаа алдагдах нөхцөлүүд

→Х.505

▲ АЮУЛТАЙ

■ Мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах үед анхааруулах гэрэл ассан, анхааруулах дохио дуугарсан үед

Мэдээллийн дэлгэцийн зааврыг шалгаж баримтална.

Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

■ Жолооны хүчлүүрийн анхааруулах гэрэл ассан үед

Шар гэрэл ассан үед жолооны хүчлүүрийн дэмжлэг хязгаарлагдана. Улаан гэрэл ассан үед жолооны хүчлүүрийн дэмжлэг байхгүй болох тул хүрд хэт хатуу болно. Жолооны үед хэвийн үеэс хүнд болсон үед чанга барьж илүү хүчээр эргүүлнэ.

■ Дугуйн даралт анхааруулах гэрэл ассан үед

Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдолд автомашины удирдлага алдах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

● Автомашиныг нэн даруй аюулгүй газарт зогсооно. Дугуйн хийн даралтыг даруй тохируулна.

● Дугуйн хийн даралт тохируулсны дараа анхааруулах гэрэл дахин асвал дугуй хагарсан байх магадлалтай тул дугуйгаа шалгана. Дугуй хагарсан тохиолдолд нөөц дугуйгаар солих ба хагарсан дугуйгаа ойр байрлах Lexus дилерт хандаж засуулна.

● Огцом тоормос болон маневр хийхээс зайлсхийнэ. Автомашины дугуй муудсан үед автомашины жолоодлого, тоормосны удирдлага алдагдах аюултай.

■ Дугуй задрах, хий огцом алдагдах үед

Дугуйн даралт анхааруулах систем тэр даруйд мэдрэхгүй байж болно.




АНХААР

■ Дугуйн даралт анхааруулах системийн хэвийн ажиллагааг хангах

Дугуйн даралт анхааруулах системийн хэвийн ажиллагаа алдагдаж болзошгүй тул өөр үйлдвэрлэгч, өөр техник үзүүлэлттэй дугуйг хольж ашиглахыг хориглоно.

Дэлгэц дээр анхааруулга гарсан үед

Системд үүссэн доголдол, буруу ажиллагаа мөн шаардагдаж буй засвар үйлчилгээний анхааруулга зэрэг мэдээллийн дэлгэц дээр гардаг. Анхааруулга гарвал тухайн анхааруулгын дагуу зохих арга хэмжээг авна.



Мэдээллийн дэлгэцийн зааварчилгааг мөрдөнө. Зохих үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч анхааруулга дахин гарвал Lexus дилертээ хандана уу.

Анхааруулах мэдээлэл болон анхааруулга

Анхааруулгын агуулгаас хамаарч анхааруулах гэрэл болон дохио дараах байдлаар ажиллана. Хэрэв анхааруулга дилер дээр автомашин оношлуулах шаардлагатайг анхааруулж байгаа тохиолдолд Lexus дилер дээр даруй оношилгоо хийлгэнэ.

Анхааруулах гэрэл	Анхааруулах дохио *	Анхааруулга
—	Дуугарах	• Жолоодлоготой холбоотой системд доголдол үүссэн, арга хэмжээ аваагүй тохиолдолд аюултай нөхцөл бүрдэх зэрэг онцгой нөхцөл байдал үүссэнийг заана • Автомашинд гэмтэл учруулах эсвэл аюултай байдалд хүргэх нөхцөлийг заана.
Асах эсвэл анивчих	Дуугарах	Мэдээллийн дэлгэц дээр зааж буй системд доголдол үүссэн байж болзошгүй зэрэг онцгой нөхцөл байдал үүссэнийг заана
—	Дуугарахгүй	• Электрон төхөөрөмжийн доголдол, байдал, засвар хийх шаардлага зэрэг нөхцөл байдлыг заана • Буруу үйлдэл хийсэн эсвэл үйлдлийг зөв хийх арга зэргийг заана

*: Мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарах үед анхааруулах дохио дуугарна.

■ Анхааруулах мэдээлэл

Дараах анхааруулах мэдээлэл нь ашиглалтын нөхцөл болон автомашины техник үзүүлэлтээс хамаарч өөр байж болно.

■ Анхааруулах дохио

Дуу чимээ ихтэй эсвэл аудио хөгжмийн дуунаас шалтгаалж зарим тохиолдолд дохио сонсогдохгүй байж болно.

■ Lexus дилер дээр очих шаардлагатайг анхааруулсан анхааруулга гарсан үед

Систем эсвэл мэдээллийн дэлгэц дээр гарч буй хэсэгт доголдол үүссэн байж болно. Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ Системийн ажиллагааны тухай анхааруулга гарсан үед

- Хааз эсвэл тоормосны дөрөөний ажиллагааны тухай анхааруулга гарсан үед
- PCS мөргөлтийн өмнөх тоормос, динамик радарын хурд барих

систем зэрэг жолоодлогод туслах системүүд ажиллах үед тоормосны дөрөөний ажиллагааны тухай анхааруулга гарч болно. Анхааруулга гарсан үед автомашины хурдыг хасах эсвэл мэдээллийн дэлгэцийн анхааруулгын зааварчилгааг мөрдөнө.

- Brake Override систем ажиллах үед анхааруулга гарна. (→X.190)
- Хөдөлгөөн эхлэх удирдлага, PKSB (→X.194, 330) системүүд ажиллах үед анхааруулга гарна. Мэдээллийн дэлгэцийн зааварчилгааг мөрдөнө.

- Асаах товчны ажиллагаатай холбоотой анхааруулга гарсан үед

Хөдөлгүүр асаах үед асаах товчийг буруу дарсан эсвэл асаах товчийг буруу ажиллуулсан үед асаах товчны ажиллагаатай холбоотой зааварчилгаа гарна. Мэдээллийн дэлгэцийн зааварчилгааг баримтлан асаах товчийг дахин ажиллуулна.

- Арааны хөшүүргийн ажиллагаатай холбоотой анхааруулга гарсан үед
- Арааны хөшүүргийн буруу ажиллагаа

мөн автомашин санамсаргүй хөдлөхөөс сэргийлэх үүднээс мэдээллийн дэлгэц дээр арааны хөшүүргийг шилжүүлэхийг анхааруулсан анхааруулга гарч болно. Энэ тохиолдолд мэдээллийн дэлгэцийн зааварчилгааг баримтлан арааны хөшүүргийг шилжүүлнэ.

- Мэдээллийн дэлгэц дээр эд анги нээлттэй/хаалттай байгаа тухай эсвэл шаардлагатай зүйлсийг нэмэх тухайн анхааруулга, зураг гарсан үед

Мэдээллийн дэлгэц, анхааруулах гэрлийн зааж буй тухайн эд ангийг шалгаад нээлттэй хаалга хаах, шаардлагатай зүйлсийг нэмэх зэрэг зохих арга хэмжээг авна.

■ **Хэрэглэгчийн гарын авлага унших шаардлагатайг анхааруулсан анхааруулга гарсан үед**

- “Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэн Temp High” анхааруулга мэдээллийн дэлгэц дээр гарсан үед тухайн зааварчилгааг дагана. (→X.566)
- Дараах анхааруулга гарсан үед доголдол үүссэн байж болзошгүй. Аюулгүй газарт даруй зогсон Lexus дилертээ хандана уу.
- “Transmission Oil Temp High Stop in a Safe Place and See Owner’s Manual”
- “Smart Entry & Start System malfunction”
- Дараах анхааруулга гарсан үед доголдол үүссэн байж болзошгүй. Аюулгүй газарт даруй зогсон Lexus дилертээ хандана уу. Жолоодлогоо үргэлжлүүлэх нь аюултай.
- “Oil Pressure Low”
- “Braking Power Low”

■ **“Engine Stopped Steering Power Low” анхааруулга гарсан үед**

Жолоодлогын үед хөдөлгүүр унтрахад гарна.

Жолооны хүрд хэвийн үеэс хүнд болсон нөхцөлд жолооны хүрдээс сайтар барин илүү хүчээр эргүүлнэ.

- **“Shift into P before exiting vehicle” анхааруулга гарсан үед**

Автомашин хөдөлгүүр асаалттай ба арааны хөшүүрэг Р-с өөр байрлалд жолоочийн хаалга онгойх үед анхааруулга гарна.

Арааны хөшүүргийг Р-д шилжүүлнэ.

- **“Auto Power OFF to Conserve Battery” анхааруулга гарсан үед**

Автомат унтраах функц систем унтраасан үед анхааруулга гарна.

Дараагийн удаа автомашин асаах үедээ 5 орчим минут хөдөлгүүрийн эргэлтийн бага зэрэг өндөр барьж аккумулятор цэнэглэнэ.

- **“Engine Oil Level Low Add or Replace” анхааруулга гарсан үед**

Хөдөлгүүрийн тосны хэмжээ бага байгааг заана. Тосны түвшин шалгаж шаардлагатай бол нэмнэ. (→X.496) Налуу газар дээр энэ анхааруулга гарч болно. Тэгш газарт автомашин байрлуулж анхааруулга унтрахыг нягтална.

- **“Oil Maintenance Required Soon” анхааруулга гарсан үед**

Хөдөлгүүрийн тос солих хуваарь болж байгааг илтгэнэ.

Хөдөлгүүрийн тосыг шалгах ба шаардлагатай үед солино. Тос сольсны дараа анхааруулгыг тэглэнэ. (→X.497)

- **“Oil Maintenance Required” анхааруулга гарсан үед**

Хөдөлгүүрийн тос солих шаардлагатайг илтгэнэ.

Өөрийн Lexus дилер дээр хөдөлгүүр тос, тосны шүүр шалгуулж солиулна. Тос сольсны дараа анхааруулгыг тэглэнэ (→X.497)

■ Мэдээллийн дэлгэц дээр “Parking Assist Unavailable Sensor Blocked” анхааруулга гарсан үед

Мэдрэгч дээр усны дусал, мөс, цас, шороо тоос зэрэг тогтсон байж болно. Бохирдлыг цэвэрлэхэд системийн хэвийн ажиллагаа сэргэнэ.

Мэдрэгч бохирдсон үед дэлгэц дээр бохирдсон мэдрэгчийг харуулна.

Мөн нам хэмд мэдрэгч дээр мөс тогтсоноос дэлгэц дээр анхааруулга гарч, мэдрэгч объектыг танихгүй байж болно. Мөс хайлах үед системийн хэвийн ажиллагаа сэргэнэ. Мэдрэгч бохирдоогүй үед анхааруулга гарвал системд доголдол үүссэн байж болно. Lexus дилертээ хандаж оношилгоо хийлгэнэ үү.

■ “Parking Assist Unavailable Low Visibility See Owner’s Manual” анхааруулга гарсан үед

Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ.

-  RCD систем (тоноглогдсон загварт)
-  PKSB тоормос (тоноглогдсон загварт)

Арын камерын бохирдлыг цэвэрлэнэ.

■ “System Malfunction Visit Your Dealer” анхааруулга гарсан үед

Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ.

- PCS систем
- LDA систем
- LTA систем
-  LCA систем (тоноглогдсон загварт)
- AHS холын гэрэл (тоноглогдсон загварт)
- AHB холын гэрэл
- Динамик радарын хурд барих систем

-  RSA систем (тоноглогдсон загварт)
- PDA систем (тоноглогдсон загварт)
-  BSM систем
-  RCTA функц
-  Аюулгүй буухад туслах систем
- Lexus parking assist-мэдрэгч
-  PKSB тоормос (тоноглогдсон загварт)
-  RCD систем (тоноглогдсон загварт)

Lexus дилер дээрээ даруй оношлуулна уу.

■ “System Stopped See Owner’s Manual” анхааруулга гарсан үед

Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ.

- PCS систем
- LDA систем
- LTA систем
-  LCA систем (тоноглогдсон загварт)
- AHS холын гэрэл (тоноглогдсон загварт)
- AHB холын гэрэл
- Динамик радарын хурд барих систем
-  RSA систем (тоноглогдсон загварт)
- PDA систем (тоноглогдсон загварт)
-  BSM систем
-  RCTA функц
-  Аюулгүй буухад туслах систем
- Lexus parking assist-мэдрэгч
-  PKSB тоормос (тоноглогдсон загварт)

-  RCD систем (тоноглогдсон загварт)

Дараах арга хэмжээг авна.

- Аккумуляторын хүчдэл шалгах
- Lexus Safety System + системийн мэдрэгчид гадны биет тогтсон эсэхийг шалгаад цэвэрлэнэ (→X.237)
- RCD системтэй загвар: Тээшний хаалга нээлттэй эсэхийг шалгана.

Мэдрэгчийн хэвийн ажиллагаа алдагдсан байж болно. (→X.304, 315, 319, 325, 329)

- BSM, RCTA, аюулгүй буухад туслах систем ашигладаг арын гуперны мэдрэгчид гадны биет тогтсон эсэхийг шалгаад цэвэрлэнэ. (→X.301)
- Lexus parking assist-мэдрэгч, PKSB (тоноглогдсон загварт) эсвэл RCD (тоноглогдсон загварт) системийн мэдрэгчид гадны биет тогтсон эсэхийг шалгаад цэвэрлэнэ. (→X.316)
- Асуудал шийдвэрлэгдэж мэдрэгч хэвийн ажиллаж эхэлсэн нөхцөлд анхааруулга өөрөө унтарна.

■ **“System Stopped Front Camera Low Visibility See Owner’s Manual” анхааруулга гарсан үед**

Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ.

- PCS систем
- LDA систем
- LTA систем
-  LCA систем (тоноглогдсон загварт)
- AHS холын гэрэл (тоноглогдсон загварт)
- AHB холын гэрэл
- Динамик радарын хурд барих систем
-  RSA систем (тоноглогдсон загварт)

загварт)

- PDA систем (тоноглогдсон загварт)

Дараах арга хэмжээг авна.

- Шил арчигчаар салхины шилэнд тогтсон бохирдол, гадны биетийг цэвэрлэнэ.
- Агааржуулалтын системээр салхины шилний цан арилгана.
- Капотыг хаах ба урд камерын урд талыг халхлах аливаа наалт, хуулга зэргийг авна.

■ **“System Stopped Front Camera Out of Temperature Range Wait until Normal Temperature” анхааруулга гарсан үед**

Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ.

- PCS систем
 - LDA систем
 - LTA систем
 -  LCA систем (тоноглогдсон загварт)
 - AHS холын гэрэл (тоноглогдсон загварт)
 - AHB холын гэрэл
 - Динамик радарын хурд барих систем
 -  RSA систем (тоноглогдсон загварт)
 - PDA систем (тоноглогдсон загварт)
- Дараах арга хэмжээг авна.
- Наранд зогссон зэргээр урд камер халсан үед агааржуулалтын систем ашиглан камер орчмын хэмийг буулгана.
 - Автомашиныг зогсоолд байрлуулан нарны хаалт ашигласан үед хаалтын төрлөөс хамаарч нарны гэрэл хаалтаас ойн камерын ойр орчмыг хэт халааж болзошгүй.
 - Хэт хүйтэн цаг агаартай газар зогсоолд байрлуулсан зэргээр урд камер хөрсөн үед агааржуулалтын

системийг ашиглана.

■ **“System Stopped Front Radar Sensor Blocked Clean Radar Sensor” анхааруулга гарсан үед**

Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ.

- PCS систем
- LDA систем
- LTA систем
-  LCA систем (тоноглогдсон загварт)
- AHS холын гэрэл (тоноглогдсон загварт)
- AHB холын гэрэл
- Динамик радарын хурд барих систем
- PDA систем (тоноглогдсон загварт)

Дараах арга хэмжээг авна.

- Радарын мэдрэгч, радарын мэдрэгчийн таган дээр гадны биет тогтоогүй эсэхийг шалгаад шаардлагатай үед цэвэрлэнэ. (→X.245)
- Цөл, тал хээр, хотын зах зэрэг ойр орчимд автомашин, барилга байгууламж цөөтэй задгай замаар явах үед тус анхааруулга гарч болно. Автомашин болон барилга байгууламжтай газраар явах үед тус анхааруулга унтарна.

■ **“System Stopped Front Radar Sensor Out of Temperature Range Wait until Normal Temperature” анхааруулга гарсан үед**

Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ.

- PCS систем
- LDA систем
- LTA систем
-  LCA систем (тоноглогдсон загварт)

● AHS холын гэрэл (тоноглогдсон загварт)

● AHB холын гэрэл

● Динамик радарын хурд барих систем

● PDA систем (тоноглогдсон загварт)

Радарын мэдрэгчийн температур ажиллах боломжтой хэмжээнээс давсан. Температур хэвийн хэмжээнд хүрэх хүртэл хүлээнэ.

■ **“System Stopped Front Radar In Self Calibration See Owner’s Manual” анхааруулга гарсан үед**

Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ.

- PCS систем
- LDA систем
- LTA систем

●  LCA систем (тоноглогдсон загварт)

● AHS холын гэрэл (тоноглогдсон загварт)

● AHB холын гэрэл

● Динамик радарын хурд барих систем

● PDA систем (тоноглогдсон загварт)

Дараах арга хэмжээг авна.

- Радарын мэдрэгч, радарын мэдрэгчийн таган дээр гадны биет тогтоогүй эсэхийг шалгаад шаардлагатай үед цэвэрлэнэ. (→X.245)
- Радарын мэдрэгчийн тусгал алдагдсан байж болох ба энэ нөхцөлд жолоодлогын явцад тусгал автоматаар засагдана. Үргэлжлүүлэн жолоодно.

■ **“Unavailable Activation Condition not Satisfied See Owner’s Manual” анхааруулга гарсан үед**

Ажиллагааны нөхцөл бүрдээгүй тул  LCA функцийг ашиглах боломжгүй.

Ажиллагааны нөхцөлийг бүрдүүлээд эргэх дохионы хөшүүргийг дахин түлхэнэ.

■ **“Cruise Control Unavailable See Owner’s Manual” анхааруулга гарсан үед**

Дараах аль нэг систем цуцлагдсаныг илтгэнэ.

● Динамик радарын хурд барих систем

● Хурд баригч

Жолоодлогод туслах товчийг олон дахин дарсан үед анхааруулга гарна.

Жолоодлогод туслах товчийг хурдан, чанга дарна.

■ **Дараах анхааруулга гарсан үед зохих арга хэмжээ авч анхааруулга унтарсныг нягтална.**

• “CRAWL Unavailable See Owner’s Manual” (→X.415)

■ **“Speed Limit Exceeded” анхааруулга гарсан үед (зарим загварт)**

Автомашины хурд 120 км/ц (75 миль/ц)-с давсныг анхааруулна. Анхааруулах дохио 6 секунд дуугарах эсвэл хурд 120 км/ц (75 миль/ц)-с буух үед зогсоно. Автомашины хурдыг бууруулна.



АЮУЛТАЙ

■ **Мэдээллийн дэлгэц дээр анхааруулга гарсан, анхааруулах гэрэл ассан, анхааруулах дохио дуугарсан үед**

Мэдээллийн дэлгэц дээр гарсан анхааруулгыг шалгаж мөрдөнө. Эсрэг тохиолдолд амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.



АНХААР

■ **Хөдөлгүүрийн тосны түвшин анхааруулах анхааруулга гарсан үед**

Хөдөлгүүрийн тос бага үед үргэлжлүүлэн жолоодох нь хөдөлгүүрийн гэмтэлд хүргэнэ.

■ **“Water accumulation in fuel filter See owner’s manual” гарсан үед**

Дэлгэц дээр анхааруулга гарсан үед үргэлжлүүлэн жолоодож болохгүй. Хуримтлагдсан тунадас инжекторын насос гэмтээх аюултай.

Дугуй хагарсан үед

Автомашинд нөөц дугуй суурилагдсан байдаг ба хагарсан дугуйн оронд сольж тавих боломжтой. Дугуйны талаар дэлгэрэнгүйг: →Х.503

АЮУЛТАЙ

Дугуй хагарсан үед

Хагарсан дугуйтай үргэлжлүүлэн жолоодож болохгүй.


Богино зайнд автомашины дугуй, обуд засварлах боломжгүй хэмжээнд гэмтэх аюултай ба энэ нь осолд хүргэж болно.

Автомашин домкратаар өргөхийн өмнө


- Хатуу, тэгш гадаргуутай аюулгүй газарт зогсооно.
- Зогсоолын тоормос татна.
- Арааны хөшүүргийг Р-д шилжүүлнэ.
- Гадны биет нэвтэрснийг таних мэдрэгч, хазайлтын мэдрэгчийг унтраана. (→Х.83)
- Хөдөлгүүрийг унтраана.
- Ослын дохионы гэрэл асаана. (→Х.524)

Нөөц дугуй, домкрат болон багажийн байрлал

- 5 суудалтай загвар




- A** Домкрат
 - B** Багажийн хайрцаг
 - C** Нөөц дугуй
- 7 суудалтай загвар



- A** Домкрат
- B** Багажийн хайрцаг
- C** Нөөц дугуй

Багаж



- A** Домкратын иш
- B** Домкратын нэмэлт иш
- C** Халив
- D** Дугуйн дорцов

⚠ АЮУЛТАЙ

■ Дугуйн домкрат ашиглах

Дараах анхааруулгыг мөрдөнө.


Домкрат буруу ашигласнаар автомашин домкратаас унах зэргээр амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэнэ.

- Домкратыг зөвхөн дугуй солих, дугуйн гинж угсрах, салгах зорилгоор ашиглана.
- Дугуй солих үед зөвхөн автомашинд дагалдаж ирсэн домкрат ашиглана. Домкратыг өөр автомашинд ашиглах мөн өөр автомашины домкратыг ашиглаж болохгүй.

- Домкратаар өргөх цэг дээр домкрат хөдөлгөөнгүй байрлуулна.

⚠ АЮУЛТАЙ

- Домкратаар өргөсөн үед биеийн аль нэг хэсгээ автомашин доогуур оруулахыг хориглоно.
- Домкратаар өргөсөн үед хөдөлгүүр асаах, жолоодож болохгүй.
- Автомашин дотор хүн байгаа үед домкратаар өргөхийг хориглоно.
- Автомашин өргөх үед домкратын дээр болон доор аливаа зүйл хийхийг хориглоно.
- Дугуй солиход шаардлагатай хэмжээнээс өндөр өргөхгүй.
- Шар анхааруулах **A** зурааснаас өндөр өргөхгүй.



- Автомашинны доор орох шаардлагатай үед зөөврийн хөлтэй тулгуураар тулна.


Гэмтэж болох тул автомашин буулгах үед бусад хүн ажиллаж эсвэл ойр орчимд байхгүй байгааг нягтална.

■ Домкратын бариул ашиглах үед


Нэмэх халиваар домкратын ишний бүх боолтыг сайтар чангалж нэмэлт иш сугарахаас сэргийлнэ.

Домкрат гаргах


1 Тагийг авна.



2 Резин уяаг тайлна.



3 Домкрат гаргана.



1 Суллах


2 Чангалах

Домкрат ашиглаж дууссаны дараа гаргасны эсрэг дарааллаар буцааж хийнэ. Мөн домкратыг резин уяагаар сайтар бэхэлнэ.


Багажийн хайрцаг гаргах

1 Шалны хавтанг өргөнө.

► 5 суудалтай загвар




► 7 суудалтай загвар




2 Багажийн хайрцаг гаргана.

► 5 суудалтай загвар




3 Домкратын ишийг дугуй буулгах боолтод хийнэ.

► 7 суудалтай загвар


**Нөөц дугуй гаргах**


1 Домкратын иш угсрах

Домкратын нэмэлт иш болон дугуйн дорцовыг багажийн уутнаас гаргаад дараах дарааллаар угсарна.



2 Тагийг салгана.






1 Доош буулгах


2 Дээш өргөх

Хойд гупер хамгаалах үүднээс домкратын иш доор даавуу хийнэ.


4 Нөөц дугуйг газарт бүрэн буулгана.



5 Нөөц дугуйг татаж гаргаад бэхэлгээний дэгээг мултална.




6 Нөөц дугуйны обудны таг салгаж авна.




Хагарсан дугуй солих

1 Дугуйнд ивүүр хийнэ.




Хагарсан дугуй	Дугуйн ивүүрийн байрлал
Зүүн урд	Баруун хойд дугуйны ард ивүүр хийнэ
Баруун урд	Зүүн хойд дугуйны ард ивүүр хийнэ
Зүүн хойд	Баруун урд дугуйны урд ивүүр хийнэ
Баруун хойд	Зүүн урд дугуйны урд ивүүр хийнэ

- 2 Колпакийг зурагт үзүүлсний дагуу дорцовын үзүүрээр хөшиж авна.




- 3 Дорцовоор дугуйн боолтыг бага зэрэг суллана (нэг эргэлт орчим).




- 4 Домкратын ишинд дугуйн дорцов хийнэ.

Домкратын ишийг дараах дарааллаар угсарна.




- 5 Домкратаар өргөх цэгүүдийг дараах зурагт харуулав


- Урд



- Хойд




- 6 Дугуйг газраас бага зэрэг хөндийрөх хэмжээнд өргөнө.



- 7 Дугуйн бүх боолтыг тайлж дугуйг салгана.

Дугуйг газарт тавих үед обудны нүүр

гэмтэхээс сэргийлж дээш харуулна.



АЮУЛТАЙ

■ Хагарсан дугуй солих

- Явж байсан автомашины обудны диск, тоормосны ойр орчимд автомашин зогссон даруйд хүрч болохгүй.

Явж байсан автомашины обудны диск, тоормосны ойр орчим хэт халсан байдаг. Дугуй солих зэргээр автомашины эдгээр хэсгүүдэд гар, хөл, биеийн бусад хэсгээр хүрсэн тохиолдолд түлэгдэх аюултай.

- Дараах анхааруулгыг мөрдөнө. Эсрэг тохиолдол ноцтой бэртэлд хүргэх аюултай:

- Автомашин доороос гаргахаас өмнө нөөц дугуйг газарт бүрэн буулгана.

- Колпакийг гараар тайлж болохгүй. Бэртэл гэмтлээс сэргийлж колпактай ажиллах үед анхаарал болгоомжтой харьцана.

- Дараах анхааруулгыг мөрдөөгүй тохиолдолд дугуйн боолт суларч дугуй салах, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

- Дугуй сольсны дараа даруй Ньютон-метрийн дорцовоор дараах хүчээр чангална.

Чангалах хүч: 131 N•m (13.4 kgf•m, 97 ft•lbf)

- Дугуй угсрах үед зөвхөн тухайн обуданд зориулагдсан боолт ашиглана.

- Боолт, гайкны эрэг, обудны боолтын нүхэнд цууралт үүссэн, хэлбэрээ алдсан үед та өөрийн Lexus дилерт хандаж автомашинаа шалгуулна уу.


- Хөдөлгөөний үед шидэгдэх аюултай тул хэт гэмтсэн колпак ашиглаж болохгүй.

- Нөөц дугуй солих үед тээшний автомат хаалганы ажиллагааг цуцална. (→X.138) Дугуй солих үед тээшний автомат хаалганы товч санамсаргүй дарагдаж гар хуруугаа хавчуулах зэргээр гэмтэх аюултай.

Нөөц дугуй угсрах

- 1 Обудтай харьцах хэсгийн гадны биет, бохирдлыг арчиж цэвэрлэнэ.


Обудны завсар гадны биет орсон тохиолдолд боолт автомашины хөдөлгөөний үед суларч дугуй салах аюултай.




- 2 Нөөц дугуйг угсарч боолтыг гараар ижил хүчээр чангална.

Боолтын шайб **A** -г обудны боолтын нүхтэй **B** зөөлөн нийлэх хүртэл

эргүүлнэ.




3 Автомашиныг буулгана.



4 Зурагт үзүүлсэн дарааллаар боолтыг 2-3 удаа эргүүлж сайтар чангална.


Чангалах хүч:
131 N•m (13.4 kgf•m, 97 ft•lbf)



5 Колпак буцааж суурилуулна.


Хагарсан дугуйны обудны тагийг дотор талаас нь түлхэж салгаад

буцааж угсарна.



Хагарсан дугуй, домкрат, бүх багажийг хураах


- 1 Хагарсан дугуйг хошууг нь дээш харуулна
- 2 Нөөц дугуйны обудны таг хийнэ.



- 3 Бэхэлгээний дэгээ **A**-г угсарна. Домкратын ишийг цагийн зүүний дагуу эргүүлж гинжийг татна.

Обудны голд бэхэлгээний дэгээ

голлосон эсэхийг нягтална.



4 Дугуйг дээш өргөнө.


Хойд гуперыг хамгаалах үүднээс домкратын иш доор даавуу хийнэ.

Дугуйг өргөх үед мөргөлт, огцом тоормосны үед урагш шидэгдэхээс сэргийлж дугуй аливаа эд ангийг хавчилгүйгээр эгц дээш өргөгдөж байгааг нягтална


Дугуйг хагас өргөөд гинж дугуйн нүхэнд зөв байрласан эсэхийг нягтална.

Чангалах хүч:

47 N•m (4.8 kgf•m, 34.7 ft•lbf)



5 Чангалсны дараа дугуйны бэхэлгээ сулраагүйг нягтална:



1 Нааш цааш татах


2 Эргүүлж үзэх

Ойр орчмын эд ангитай дугуй давхцаагүйг нүдээр нягтална.

Дугуй сул эсвэл буруу бэхлэгдсэн үед 4 ба 5-р үйлдлийг давтана.

6 Дугуйг буулгасан, хөдөлгөсөн бүрд 5-р үйлдлийг давтана.

7 Тагийг зурагт үзүүлсний дагуу хийнэ.



8 Багаж болон домкратыг хөдөлгөөнгүй бэхэлнэ.

■ Дугуй сольсны дараа

Дугуйн даралт анхааруулах системийн тохиргоог дахин тохируулна. (→X.508)

⚠ АЮУЛТАЙ

■ Хагарсан дугуй суурилуулах үед

Нөөц дугуйн сууринд дугуй буцаан суурилуулах үйлдлийг зөв хийгээгүй нөхцөлд нөөц дугуйн суурь гэмтэх, дугуй унаж улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.

■ Домкрат, багаж ашигласны дараа

Хөдөлгөөн эхлэхийн өмнө бүх багаж хэрэгсэл, домкрат тус бүрийн байрлалдаа хөдөлгөөнгүй бэхлэгдсэн эсэхийг шалгаж огцом тоормос, ослын үед бэртэл гэмтэл учруулах аюул эрсдэлийг бууруулна.



АНХААР

■ Хагарсан дугуй суурилуулах үед

Автомашини доод тал болон дугуйн завсар аливаа зүйл хавчуулагдаагүйг нягтална.



АНХААР

■ Дугуй солих үед

Обуд, дугуй эсвэл дугуйн даралт анхааруулах хавхлаг, дамжуулагч салгах, угсрах үед буруу үйлдлээс шалтгаалж хавхлаг, дамжуулагч гэмтэх аюултай тул та өөрийн Lexus дилерт хандана уу.

■ Дугуйн даралт анхааруулах хавхлаг, дамжуулагчийг гэмтлээс сэргийлэх

Дугуйг шингэн нөхөөсөөр нөхсөн үед хавхлаг болон дамжуулагч хэвийн ажиллахгүй байж болно. Нэн даруй өөрийн Lexus дилер эсвэл бусад албан ёсны төвд хандана уу. Дугуй солих үед хавхлаг, дамжуулагчийг мөн солино. (→X.506)

Хөдөлгүүр асахгүй үед

Зөв дарааллаар (→X.203) асаах оролдлого хийсэн ч хөдөлгүүр асахгүй үед дараах зүйлсийг шалгана:

Стартер мотор хэвийн эргэж байгаа ч хөдөлгүүр асахгүй үед

Дараах аль нэг нөхцөл байдлаас шалтгаалсан байж болно:

- Шатахууны саванд хангалттай шатахуун байхгүй. Шатахуун цэнэглэнэ.
- Хөдөлгүүр баяжсан. Зөв дарааллын дагуу асаах оролдлого дахин хийнэ. (→X.203)
- Хөдөлгүүрийн иммобилайзер системд доголдол үүссэн. (→X.79)

Стартер мотор удаан эргэх, салоны болон их гэрэл бүдэг асах, дуут дохио дуугарахгүй байх, сул дуугарах

Дараах аль нэг нөхцөл байдлаас шалтгаалсан байж болно:

- Аккумуляторын цэнэг суусан. (→X.561)
- Аккумуляторын шонгийн холболт суларсан, зэвэрсэн.

Стартер мотор эргэхгүй байх

Дараах аль нэг нөхцөл байдлаас шалтгаалсан байж болно:

Электрон түлхүүрийн зайны цэнэг суух, гал хамгаалагч шатсан зэрэг цахилгааны гэмтлээс шалтгаалж хөдөлгүүр асаах системд доголдол үүссэн байж болно. Нөгөөтээгүүр онцгой нөхцөлд хөдөлгүүр асаах аргаар асааж болно (→X.558)

Стартер мотор эргэхгүй, салоны болон их гэрэл асахгүй, дуут дохио дуугарахгүй байх

Дараах аль нэг нөхцөл байдлаас шалтгаалсан байж болно:

- Аккумуляторын цэнэг суусан. (→X.561)
- Аккумуляторын аль нэг эсвэл 2 шон зэрэг салсан.
- Жолооны хүрд түгжих системд доголдол үүссэн. (тоноглогдсон загварт).

Гэмтэл засагдахгүй, засах арга тодорхойгүй үед Lexus дилертээ хандана уу.

Онцгой нөхцөлд хөдөлгүүр асаах

Хөдөлгүүр асахгүй ба асаах товч хэвийн ажиллаж байгаа үед дараах аргаар хөдөлгүүр асааж

болно:

- 1 Зогсоолын тоормосны товчийг татаад зогсоолын тоормос идэвхэжсэн эсэхийг нягтална. (→X.213)

Зогсоолын тоормосны индикатор асна.

- 2 Арааг Р-д шилжүүлнэ.
- 3 Асаах товчийг ACC^{*1}, 2-д шилжүүлнэ.
- 4 Тоормосны дөрөө гишгэнгээ асаах товчийг 15-с дээш секунд удаан дарна.

Дээрх аргаар хөдөлгүүр ассан ч системд доголдол үүссэн байж болзошгүй тул Lexus дилертээ хандаж автомашинаа оношлуулна уу.

^{*1}: ACC горимыг өөрчлөх боломжтой тохиргоогоор идэвхжүүлэх, цуцлах боломжтой.

^{*2}: ACC горимыг цуцалсан үед асаах товчийг ON болгоод OFF-д буцаах ба 5 секундийн дотор X.560-д заасан аргаар хөдөлгүүр асаана.

Түлхүүрээ гэсэн үед

Lexus дилер дээр бусад түлхүүр эсвэл түлхүүрийн пайзны дээр тэмдэглэгдсэн дугаараар шинэ оригинал түлхүүр дахин хийлгэх боломжтой. Түлхүүрийн пайзыг автомашинд хадгалахгүй ба түрийвч зэрэг аюулгүй газар хадгална.



АНХААР

■ Электрон түлхүүр гээгдсэн үед

Алга болсон электрон түлхүүр олдоогүй нөхцөлд автомашин хулгайд өртөх эрсдэл нэмэгдэнэ. Энэ тохиолдолд үлдсэн бүх электрон түлхүүр болон түлхүүр картын (тоноглогдсон загварт) хамт нэн даруй өөрийн Lexus дилерт хандана уу.

Электрон түлхүүр хэвийн ажиллахгүй үед

Электрон түлхүүр болон автомашин хоорондын долгионд саад үүссэн (→Х.144) эсвэл электрон түлхүүрийн зайны цэнэг суусан үед Smart entry & start систем болон түлхүүрийн алсын удирдлагын функц ажиллахгүй. Энэ үед дараах дарааллаар хаалга онгойлгож автомашиныг асаах боломжтой.

■ Электрон түлхүүр хэвийн ажиллахгүй үед

- Smart entry & start систем тохиргоо өөрчлөх тохиргоогоор салгагдсан эсэхийг шалгана. Салгагдсан үед функцийг идэвхжүүлнэ. (Өөрчлөх боломжтой тохиргоо: →Х.586)
- Түлхүүр зайны цэнэг хадгалах горимд тохируулагдсан эсэхийг шалгаж функцийг цуцална. (→Х.144)
- Электрон түлхүүр түр хугацаанд ажиллахгүй байж болно. (→Х.144)



АНХААР


■ Smart entry & start системд доголдол эсвэл түлхүүртэй холбоотой асуудал үүссэн үед

Электрон түлхүүр, түлхүүр картын хамтаар автомашинаа өөрийн Lexus дилер дээр оношлуулна уу.

Хаалга түгжих, тайлах


Механик түлхүүр ашиглан (→Х.117) дараах үйлдлийг

хийнэ.



- 1 Бүх хаалга түгжих
- 2 Бүх хаалга тайлах

■ Түлхүүртэй холбогдсон функц



- 1 Цонх, дээврийн нээлхий ^{*1} хаана (эргүүлээд барина) ^{*2}
- 2 Цонх, дээврийн нээлхий ^{*1} нээнэ (эргүүлээд барина) ^{*2}

^{*1}: Тоноглогдсон загварт

^{*2}: Тус тохиргоог Lexus дилер дээр хийнэ.

⚠ АЮУЛТАЙ

■ **Механик түлхүүр ашиглан цонх, дээврийн нээлхий (тоноглогдсон загварт) ажиллуулах үед**


Автомат цонх, дээврийн нээлхий ажиллуулахын өмнө зорчигч хавчуулагдах аюул байхгүйг нягтална. Мөн бага насны хүүхдээр механик түлхүүр ашиглуулахыг хориглоно. Автомат цонх, дээврийн нээлхийнд бага насны хүүхэд болон зорчигчид хавчуулагдах аюултай.

Хөдөлгүүр асаах

- 1 Араа Р байрлалд байгааг шалгаад тоормосны дөрөөг гишгэнэ.
- 2 Электрон түлхүүр, түлхүүр картын (тоноглогдсон загварт) Lexus эмблемтэй талыг асаах товчинд хүргэнэ.

Электрон түлхүүр танигдах үед анхааруулах дохио дуугарах ба асаах товч ON горимд шилжинэ.

Хэрэглэгчийн хүсэлтээр хийх тохиргоогоор Smart entry & start систем салгагдсан үед асаах товч ACC горимд шилжинэ.



- 3 Тоормосны дөрөөг сайтар гишгэх ба мэдээллийн дэлгэц

дээр  гарч байгаа эсэхийг нягтална.

- 4 Асаах товчийг богино, чанга дарна.

Дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч хөдөлгүүр асахгүй үед Lexus дилертээ хандана уу.

■ Хөдөлгүүр унтраах

Хэвийн ашиглалтын үед хөдөлгүүр унтраахтай адилаар арааны хөшүүргийг Р байрлалд буцааж асаах товчийг дарна.

■ Түлхүүрийн зай солих

Дээрх арга нь түр зуурын арга тул электрон түлхүүрийн зайны цэнэг суусан үед шинээр солих нь зүйтэй. (→Х.517)

■ Дохиоллын систем

Механик түлхүүрээр автомашин түгжих үед дохиоллын систем идэвхжихгүй.

Дохиоллын систем идэвхтэй үед механик түлхүүрээр хаалга тайлсан тохиолдол дохиоллын систем ажиллаж болно. (→Х.81)

■ Асаах товчны горим солих

Дээр дурдсан 3-р шат дээр тоормосны дөрөөг суллаад асаах товч дарна. Хөдөлгүүр асахгүй ба товч дарах бүрд асаах товчны горим солигдоно. (→Х.205)

Аккумуляторын цэнэг суусан үед

Автомашины аккумуляторын цэнэг суусан үед дараах аргаах хөдөлгүүрийг асааж болно.


Мөн та өөрийн Lexus дилер бусад мэргэжлийн засварын төвд хандах боломжтой.

Хөдөлгүүрийг асаах

Хэрэв танд холбогч кабель байгаа ба 12 в аккумулятортай холбож асаах өөр автомашин байгаа үед дараах дарааллаар холбож асаах боломжтой.


- 1 Электрон түлхүүр биедээ авч яваа эсэхээ нягтална.

Холбогч кабель холбох үед байдлаас хамаарч дохиолол ажиллах, хаалга түгжигдэх магадлалтай. (→Х.83)




- 2 Капот нээгээд (→Х.493) хөдөлгүүрийн тагийг авна. (→Х.495)

- 3 Аккумуляторын нэмэх (+) шонгийн тагийг авна.



- 4 Хөдөлгүүрийн тагийг авна.


Тагны ирмэгээс татаж хумснуудыг мултлаад нааш татаж тагийг сугална.



- 5 Холбогчийн нэмэх утасны хавчаарыг өөрийн автомашины [A] -д холбох ба холбогчийн нэмэх утасны нөгөө үзүүрийг холбох автомашины [B] -д холбоно. Дараа нь холбогчийн хасах утасны хавчаарыг холбох автомашины [C] -д холбоод хасах утасны нөгөө үзүүрийг [D] -д холбоно.


Хангалттай урттай холбогч кабель ашиглана.

- Зүүн жолооны хүрдтэй



- [A] Аккумуляторын нэмэх (+) шон (таны автомашин)
 [B] Аккумуляторын нэмэх (+) шон (холбох автомашин)
 [C] Аккумуляторын хасах (-) шон (холбох автомашин)
 [D] Зурагт үзүүлсэн металл эд анги

► Баруун жолооны хүрдтэй



A Аккумуляторын нэмэх (+) шон (таны автомашин)

B Аккумуляторын нэмэх (+) шон (холбох автомашин)

C Аккумуляторын хасах (-) шон (холбох автомашин)

D Зурагт үзүүлсэн металл эд анги

6 Холбох автомашины хөдөлгүүрийг асаах ба хөдөлгүүрийн эргэлтийг бага зэрэг нэмж аккумуляторыг 5 минут орчим цэнэглэнэ.

7 Жолооны хүрд түгжих функцтэй загвар: Асаах товчны Off горимд аль нэг хаалгыг нээгээд хаана.

8 Холбох автомашины хөдөлгүүрийн эргэлтийг өндөр хэвээр барингаа өөрийн автомашины асаах товчийг ON горимд шилжүүлнэ.

9 Хөдөлгүүр ассаны дараа холбогч кабелийг холбох үеийн эсрэг дарааллаар салгана.

Хөдөлгүүрийн тагийг салгах үеийн урвуу дарааллаар угсарна. Бэхэлгээг шалгана.

Хөдөлгүүр ассаны дараа даруй өөрийн Lexus дилер дээр оношилгоо хийлгэнэ үү.

■ Аккумуляторын цэнэг суусан үед автомашин асаах

Автомашиныг түлхэж эсвэл чирч асаах боломжгүй.

■ Аккумуляторын цэнэг суухаас сэргийлэх

- Хөдөлгүүр унтраастай үед их гэрэл болон аудио системийг унтраана.
- Замын түгжрэл зэргээр хөдөлгүүр удаан хугацаанд бага хурдаар ажиллах үед шаардлагагүй электрон төхөөрөмжүүдийг унтраана.

■ Аккумулятор салгасан, цэнэг суусан үед

- Аккумуляторыг салгах үед ECU-д хадгалагдсан мэдээллүүд арилна. Аккумулятор салгахын өмнө Lexus дилертээ хандана уу.
- Зарим системийн тохиргоог анхны тохиргоонд тохируулна. (→X.602)

■ Аккумуляторын шон салгах үед

Аккумуляторын шонг салгах үед ECU-д хадгалагдсан мэдээллүүд арилна. Аккумуляторын шонг салгахын өмнө Lexus дилертээ хандана уу.

■ Аккумулятор цэнэглэх

Аккумуляторт хуримтлагдсан цахилгаан цэнэг нь автомашин ашиглагдаагүй үед ч хэвийн цэнэг алдалт болон зарим электрон төхөөрөмжийн онцлогоос хамаарч бага багаар алдагдаж байдаг. Автомашиныг удаан хугацаанд ашиглаагүй үед аккумуляторын цэнэг сууж хөдөлгүүр асах боломжгүй болдог (Хөдөлгөөний үед аккумулятор цэнэглэгддэг).

■ Аккумулятор цэнэглэх, солих үед

● Аккумуляторын цэнэг суусан үед зарим нөхцөлд Smart entry & start системээр хаалганы түгжээ тайлах боломжгүй болдог. Түлхүүрийн алсын удирдлага, механик түлхүүр ашиглан хаалга түгжиж тайлна.

● Аккумуляторыг дахин цэнэглэсний дараа эхний оролдлогоор хөдөлгүүр асахгүй байж болох ба 2 дахь оролдлогоор хэвийн асна. Энэ нь доголдол биш болно.

● Асаах товчны горим автомашины компьютерт хадгалагддаг. Аккумулятор холбох үед асаах товч аккумулятор цэнэг алдах үеийн горимд буцдаг. Аккумулятор салгахаас өмнө асаах товчийг унтраана.

Аккумуляторын цэнэг суухаас өмнөх асаах товч ямар горимд байсан нь тодорхойгүй үед аккумуляторыг дахин холбохдоо болгоомжтой холбоно.

■ Аккумулятор шинээр солих

● Европын Холбооны стандартад нийцсэн аккумулятор ашиглана.

Өмнөхтэй адил овор хэмжээтэй (LN4), (80Ah) ба түүнээс илүү хүчин чадалтай дүйцэх 20HR буюу 20 ба түүнээс цагийн багтаамжтай мөн (689A)-с дээш хүчин чадалтай дүйцэх үзүүлэлттэй (ССА) аккумулятор ашиглана.

- Овор хэмжээ өөр үед аккумулятор бүрэн бэхлэгдэхгүй байж болно.
- Тохирохгүй аккумулятор ашиглагд-

сан нөхцөлд аккумуляторын ажиллагаа муудах улмаар хөдөлгүүр асахгүй нөхцөлд хүргэнэ.

- 20 цагийн багтаамж бага нөхцөлд богино хугацаанд ашиглаагүй үед ч аккумуляторын цэнэг суух улмаар хөдөлгүүр асахгүй байж болно.

- Дэлгэрэнгүйг та өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

⚠ АЮУЛТАЙ

■ Аккумуляторын шон салгах үед

Хасах (-) шонг эхлээд салгана. Нэмэх (+) шон салгах үед (+) терминал ойр орчмын металл гадаргууд хүрсэн үед тогонд цохиулах, оч үсрэх улмаар галын аюул үүсгэж амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

■ Аккумулятор шатах, дэлбэрэхээс зайлсхийх

Аккумулятораас гарч байж болзошгүй шатамхай хийнд санамсар болгоомжгүй гал авалцахаас сэргийлж дараах анхааруулгыг мөрдөнө:

● Холбогч кабелийг зөв холбосон эсэх мөн кабель тухайн шонгоос өөр эд ангитай нийлээгүй эсэхийг нягтална.

● Холбогч кабелийн “+” утасны нөгөө үзүүрийг автомашины аливаа эд анги, будаггүй гадаргууд хүрэхээс сэргийлнэ.

● Холбогч кабелийг “+” болон “-” шонтой хооронд нь холбохыг хориглоно.

● Аккумуляторын ойр орчимд ил гал, чүдэнз, тамхины асаагуур, тамхи татахыг хориглоно.

**АЮУЛТАЙ****■ Аккумуляторын анхааруулга**

Аккумулятор нь хорттой, идэмхий хүчиллэг электролит болон хар тугалганы орц, агууламжтай эд ангиудаас бүрддэг. Аккумулятортай харьцах үед дараах анхааруулгыг мөрдөнө:

- Аккумулятортай харьцах үед цаг ямагт хамгаалалтын шил зүүж хэрэглэх ба арьс, хувцас болон автомашины их биед аккумуляторын шингэн (хүчил) хүргэхгүй.
- Аккумулятор дээрээс тонгойж харахыг хориглоно.
- Хэрэв аккумуляторын шингэн нүд, арьсанд хүрсэн үед даруй усаар угаах ба эмнэлгийн тусламж даруй авна. Эмнэлгийн тусламж авах хүртэл нойтон пролон, даавуу тухайн хэсэг дээр тавина.
- Аккумуляторын бэхэлгээ, шон бусад эд ангиудтай харьцсаны дараа гараа заавал угаана.
- Аккумуляторт бага насны хүүхэд ойртуулахыг хориглоно.

■ Аккумулятор солих үед

- Агааржуулалтын таг болон индикатор нь бэхэлгээнд ойр үед аккумуляторын шингэн (хүхрийн хүчил) асгарч болзошгүй.
- Аккумулятор солих тухай мэдээллийг өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

■ Аккумулятор салгах үед

Их бие талын хасах (-) шонг салгаж болохгүй. Салгасан хасах (-) утас нэмэх (+) шонд хүрч богино холболт үүсгэх улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулна.

**АНХААР****■ Холбогч кабельтай харьцах үед**

Холбогч кабель холбох, салгах үед хөргөлтийн сэнс болон ременьтэй орооцолдохоос сэргийлнэ.

■ Холбогч кабель холбох үед

Холбогч кабелийг зөвхөн заасан шон, цэгүүдэд холбоно. Эсрэг тохиолдолд цахилгаан төхөөрөмжид сөрөг нөлөө үзүүлэх, гэмтээх аюултай.

Хөдөлгүүр халсан үед


Хөдөлгүүр халсныг дараах зүйлс илэрхийлнэ.

- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэний хэмийн заалт (→Х.93) улаан бүсэд орох эсвэл хөдөлгүүрийн хүч алдагдах. (Автомашины хурд нэмэгдэхгүй зэргээр.)
- Мэдээллийн дэлгэц дээр “Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэн Temp High Stop in a Safe Place See Owner’s Manual” анхааруулга гарах
- Капотноос уур гарах.

Авах арга хэмжээ

- 1 Автомашиныг аюулгүй газарт зогсоох ба агааржуулагчийн системийг унтраасны дараа хөдөлгүүрийг унтраана.
- 2 Уур гарч байгаа үед: Уур зогссоны дараа капотыг зөөлөн сөхнө. Уур гарахгүй үед: Капотыг зөөлөн сөхнө.
- 3 Хөдөлгүүр хангалттай хөрсний дараа хоолой, радиатораас

шингэн алдагдаагүй эсэхийг нягтална.




- A** Радиатор
- B** Хөргөлтийн сэнс
- C** Intercooler-н радиатор

Их хэмжээний хөргөлтийн шингэн алдагдсан байвал даруй өөрийн Lexus дилерт хандана уу.

- 4 Хөргөлтийн шингэний түвшин нь шингэний нөөцийн савны “F” болон “L” шугам хооронд байна.


- Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэн



- A** Нөөцийн сав
- B** “F” шугам
- C** “L” шугам

► Intercooler-н шингэн

хөргөлтийн



A Нөөцийн сав


B “F” шугам

C “L” шугам

5 Шаардлагатай тохиолдолд хөргөлтийн шингэн нэмнэ.


Зайлшгүй шаардлагатай үед ус ашиглаж болно.

► Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэн



► Intercooler-н шингэн

хөргөлтийн



6 Хөдөлгүүрийг асааж хөргөлтийн сэнс ажиллаж байгаа, радиатор, хоолойноос шингэн алдагдаж байгаа эсэхийг нягтална.

7 Сэнс ажиллахгүй үед: Хөдөлгүүр даруй унтрааж өөрийн Lexus дилерт хандана. Сэнс ажиллаж байгаа үед: Автомашиныг ойрын Lexus дилер дээр оношлуулна уу.

8 Мэдээллийн дэлгэц дээр “Engine Coolant Temp High Stop in a Safe Place See Owner’s Manual” анхааруулга гарсан эсэхийг шалгана.

Анхааруулга унтрахгүй үед: Хөдөлгүүрийг унтрааж өөрийн Lexus дилерт хандана уу.

Анхааруулга гараагүй үед: Ойр байрлах Lexus дилерт хандаж оношлуулна уу.



АЮУЛТАЙ

■ Автомашины капотны доод талыг шалгах үед

Дараах анхааруулгыг мөрдөнө.

Эсрэг тохиолдолд түлэгдэх зэргээр бэртэх аюултай.

● Капотноос уур гарч байгаа үед уур зогсох хүртэл капотыг онгойлгож болохгүй. Хөдөлгүүрийн хэсэг хэт халсан байх магадлалтай.

● Сэнс болон дамжуулгын ременьд гар, хувцас (ялангуяа зангиа, ороолт) зэргээ ойртуулахыг хориглоно. Эсрэг тохиолдолд гар, хувцас орооцолдох улмаар ноцтой гэмтэлд хүргэх аюултай.

● Хөдөлгүүр, радиатор халуун үед хөргөлтийн шингэний нөөцийн савны таг суллахыг хориглоно. Өндөр хэмтэй уур, хөргөлтийн шингэн цацагдана.



АНХААР

■ Хөргөлтийн шингэн нэмэх үед

Хөдөлгүүр хангалттай хөрсний дараа хөргөлтийн шингэн бага багаар нэмнэ. Халуун хөдөлгүүрт хүйтэн хөргөлтийн шингэн хийх нь хөдөлгүүр гэмтээнэ.

■ Хөргөлтийн системийн гэмтлээс сэргийлэх

Дараах анхааруулгыг мөрдөнө:

● Хөргөлтийн шингэнийг гадны биетээр (элс, шороо, тоос г.м.) бохирдуулахаас зайлсхийнэ.

● Хөргөлтийн шингэний нэмэлт бодис ашиглаж болохгүй.

Автомашин суусан үед

Автомашин шавар, цасанд сууж дугуй хий эргэх үед дараах үйлдлийг хийж гүйцэтгэнэ:

Гаргах дараалал

1 Хөдөлгүүр унтрааж зогсоолын тоормос татаад арааг Р байрлалд буцаана.

Арааг Р-д шилжүүлсний дараа араа суллах товч дарж болохгүй.

2 Хойд дугуйны ойр орчимд байгаа шавар, цасыг авна.

3 Барьцалдах чадварыг сайжруулах үүднээс хойд дугуйнд чулуу, мод болон бусад эд зүйл хийнэ.

4 Хөдөлгүүр асаана.

5 Арааг D эсвэл R байрлалд шилжүүлээд зогсоолын тоормос суллах ба хаазны дөрөөг анхаарал болгоомжтой гишгэнэ.

■ Суусан автомашиныг гаргах хүндрэлтэй үед

Дараах үйлдлийг хийнэ.

● Active TRC систем унтраана (→X.422)

● Дөрвөн дугуй хөтлөх системийн товчны горим солино (→X.409)

● Төвийн дифференциал цоожлогч ашиглана (→X.409)

● Арын дифференциал цоожлогч ашиглана* (→X.412)

● Crawl Control* ашиглана (→X.413)

● Multi-terrain Select* ашиглана (→X.416)

* : Тоноглогдсон загварт



АЮУЛТАЙ

■ Суусан автомашин гаргах оролдлого хийх үед

Суусан автомашин гаргахаар урагш болон арагш зүтгүүлэх үед бусад автомашин, объект, хүн мөргөхөөс сэргийлж автомашины ойр орчим чөлөөтэй эсэхийг нягтална. Автомашин чөлөөтэй болох үед урагш эсвэл арагш огцом ухасхийх аюултай тул өндөр анхаарал болгоомжтой байна.

■ Арааны хөшүүрэг шилжүүлэх үед

Араа шилжүүлэх үед хаазны дөрөө гишгэж болохгүй.

Энэ нь автомашин огцом ухасхийн хөдлөхөд хүргэх, улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах осолд хүргэх аюултай.



АНХААР

■ Хурдны хайрцаг болон бусад эд ангиудын гэмтлээс зайлсхийх

- Дугуйг хэт хий эргүүлэх, хаазны дөрөөг шаардлагатай хэмжээнээс хэтрүүлэн гишгэхээс зайлсхийнэ.
- Дээрх үйлдлийг хийж гүйцэтгэсэн ч автомашиныг гаргах боломжгүй үед өөр тээврийн хэрэгслээр чирүүлэх шаардлагатай.
- Суусан автомашиныг гаргахаар зүтгэх үед автомат хурдны хайрцгийн шингэний хэмийн анхааруулга дэлгэц дээр гарсан үед даруй хаазны дөрөөнөөс хөлөө салгах ба анхааруулга унтрах хүртэл хүлээнэ. Эсрэг тохиолдолд хурдны хайрцаг халж гэмтэх аюултай. (→Х.541)

8-1. Техник үзүүлэлт

Засвар үйлчилгээний
мэдээлэл (шатахуун, тос
г.м.)572

Шатахууны мэдээлэл582

8-2. Өөрчлөх боломжтой
тохиргоо

Өөрчлөх боломжтой
тохиргоо583

8-3. Дахин тохируулах тохиргоо

Дахин тохируулах зүйлс600

Засвар үйлчилгээний мэдээлэл (шатахуун, тос г.м.)

Овор хэмжээ

Нийт урт		4970 мм (195.7 in.) ^{*2} 4960 мм (195.3 in.) ^{*3, 4}
Нийт өргөн		1990 мм (78.3 in.) ^{*3, 4} 2000 мм (78.7 in.) ^{*2}
Нийт өндөр ^{*1}		1925 мм (75.8 in.) ^{*3} 1935 мм (76.2 in.) ^{*2, 4}
Тэнхлэг хоорондын зай		2850 мм (112.2 in.)
Дугуйн мөрний зай	Урд	1667 мм (65.6 in.) ^{*3, 4} 1687 мм (66.4 in.) ^{*2}
	Хойд	1668 мм (65.7 in.) ^{*3, 4} 1688 мм (66.5 in.) ^{*2}

^{*1}: Автомашин хоосон үед

^{*2}: 18 инчийн дугуйтай загвар

^{*3}: 20 инчийн дугуйтай загвар

^{*4}: 22 инчийн дугуйтай загвар

Жин (чирэх дэгээтэй)

► VJA252L-GNUZZX загвар^{*1}

Автомашинны бүх жин	22 инчийн дугуйтай загвар	3170 кг (6989 lb.)
	20 инчийн дугуйтай загвар ^{*2}	3120 кг (6878 lb.)
	20 ^{*3} ба 18 инчийн дугуйтай загвар	3125 кг (6889 lb.)
Нэг тэнхлэг дээрх хамгийн их ачаалал	Урд	1530 кг (2976 lb.) ^{*4} 1605 кг (3538 lb.) ^{*5} 1570 кг (3858 lb.) ^{*6}
	Хойд	1775 кг (3913 lb.) ^{*4} 1860 кг (4101 lb.) ^{*5, 6}

Чиргүүлийн холбоосны жин		130 кг (287 lb.)* ⁴ 140 кг (309 lb.)* ^{5, 6}
Чирэх хүчин чадал	Тоормостой	3220 кг (7099 lb.)* ^{4, 7} 3210 кг (7077 lb.)* ^{4, 8} 3500 кг (7716 lb.)* ^{5, 6}
	Тоормосгүй	750 кг (1653 lb.)

*1: Загварын код нь үйлдвэрлэгчийн пайз дээр байдаг. (→X.574)

*2: Урд манангийн гэрэлгүй загвар

*3: Урд манангийн гэрэлтэй загвар

*4: 22 инчийн дугуйтай загвар

*5: 20 инчийн дугуйтай загвар

*6: 18 инчийн дугуйтай загвар

*7: AVSS системгүй загвар

*8: AVSS системтэй загвар

► VJA252R-GNUZZQ загвар*¹

Автомашины бүх жин	22 ба 20 инчийн дугуйтай загвар* ²	3175 кг (7000 lb.)
	20 инчийн дугуйтай загвар* ³	3150 кг (6945 lb.)
	18 инчийн дугуйтай загвар	3110 кг (6856 lb.)
Нэг тэнхлэг дээрх хамгийн их ачаалал	Урд	1570 кг (3858 lb.)* ⁴ 1605 кг (3538 lb.)* ⁵ 1530 кг (2976 lb.)* ⁶
	Хойд	1860 кг (4101 lb.)* ^{4, 5} 1775 кг (3913 lb.)* ⁶
Чиргүүлийн холбоосны жин		350 кг (772 lb.)* ^{4, 5} 310 кг (683 lb.)* ⁶
Чирэх хүчин чадал	Тоормостой	3500 кг (7716 lb.)* ^{4, 5} 3130 кг (6900 lb.)* ⁶
	Тоормосгүй	750 кг (1653 lb.)

*1: Загварын код нь үйлдвэрлэгчийн пайз дээр байдаг. (→X.574)

*2: AVSS системтэй загвар

*3: AVSS системгүй загвар

*4: 18 инчийн дугуйтай загвар

*5: 20 инчийн дугуйтай загвар

*6: 22 инчийн дугуйтай загвар

► VJA252L-GNUZZ загвар^{*1}

Автомашины бүх жин		3175 кг (7000 lb.) ^{*2} 3145 кг (6934 lb.) ^{*3, 4} 3150 кг (6945 lb.) ^{*3, 5} 3105 кг (6845 lb.) ^{*6}
Нэг тэнхлэг дээрх хамгийн их ачаалал	Урд	1530 кг (3373 lb.) ^{*2} 1605 кг (3538 lb.) ^{*3} 1570 кг (3461 lb.) ^{*6}
	Хойд	1775 кг (3913 lb.) ^{*2} 1860 кг (4101 lb.) ^{*3, 6}
Чиргүүлийн холбоосны жин		60 кг (132 lb.)
Чирэх хүчин чадал	Тоормостой	1500 кг (3307 lb.)
	Тоормосгүй	750 кг (1653 lb.)

*1: Загварын код нь үйлдвэрлэгчийн пайз дээр байдаг. (→X.574)

*2: 22 инчийн дугуйтай загвар

*3: 20 инчийн дугуйтай загвар

*4: Гарын оролцоогүй тээшний автомат хаалгагүй загвар

*5: Гарын оролцоогүй тээшний автомат хаалгатай загвар

*6: 18 инчийн дугуйтай загвар


Автомашины дугаар

■ Автомашины арлын дугаар


Vehicle identification number (VIN) буюу автомашины арлын дугаар нь таны Lexus автомашинд олгогдсон, үл давтагдах бүртгэлийн дугаар ба эзэмшигчийн бүртгэл хийхэд

ашиглагддаг.

Энэ дугаарыг баруун урд араамд тэмдэглэсэн байдаг.




Зарим загвар дээр энэ дугаарыг хянах самбарын зүүн дээд буланд тэмдэглэсэн байдаг.




Энэ дугаар үйлдвэрлэгчийн шошго дээр тэмдэглэгдсэн

байдаг.



■ Хөдөлгүүрийн дугаар

Хөдөлгүүрийн блокт зурагт үзүүлсний дагуу хөдөлгүүрийн дугаар тэмдэглэгдсэн байдаг.



Хөдөлгүүр

Загварын нэр	V35A-FTS
Төрөл	V6 цилиндртэй, 4 тактын бензин (турботой)
Поршенгийн явалт, цилиндрийн диаметр	85.5 × 100.0 мм (3.37 × 3.94 in.)
Хөдөлгүүрийн эзлэхүүн	3445 см ³ (210.2 cu.in.)
Клапангийн зай	Автомат тохируулгатай
Ремень чангалагч	Автомат тохируулгатай

Шатахуун

Шатахууны төрөл	Зөвхөн хар тугалгагүй бензин
Шинжилгээний октаны тоо	95 (октаны тоо 91) буюу түүнээс дээш
Шатахууны савны багтаамж (стандарт)	80 л (21.1 gal., 17.6 Imp.gal.)

Тосолгооны систем

■ Тосны багтаамж (Тосыг бүрэн асгаад дахин дүүргэх [жишээ *])

Шүүртэй	7.3 л (7.7 qt., 6.4 Imp. qt.)
Шүүргүй	7.0 л (7.4 qt., 6.2 Imp. qt.)

*: Хөдөлгүүрийн тосны багтаамжийн мэдээлэл нь тос солих үед ашиглагдах жишээ юм. Тос нэмэх үед шүүбний доод ба дээд түвшний хооронд тохируулан тос нэмнэ. (→X.496) Хөдөлгүүрийг халаасны дараа унтраах ба 5-с дээш минутын дараа тосны түвшнийг шүүб татаж шалгана.

■ Хөдөлгүүрийн тос сонгох

Lexus автомашинд “Toyota Genuine Motor Oil” ашиглагддаг. Тос солих үед Lexus-с зөвшөөрөгдсөн “Toyota Genuine Motor Oil” эсвэл дараах тосны зэрэг, зууралдангитай тос ашиглана.

Тосны зэрэг:


0W-20, 5W-20, 5W-30 ба 10W-30:

API ангиллын SL “Energy-Conserving”, SM “Energy-Conserving”, SN “Resource-Conserving”, SN

PLUS “Resource-Conserving” эсвэл SP “Resource-Conserving”; эсвэл ILSAC GF-6A бүх улирлын тос

Тохиромжтой зууралданги (SAE): Үйлдвэрээс хийгдэн ирдэг SAE 0W-20 нь шатахуун хэмнэлт, хүйтэн агаартай үеийн хөдөлгүүр асалтад хамгийн тохиромжтой.

Хүйтний улиралд SAE 10W-30 ба түүнээс дээш зууралдангитай хөдөлгүүрийн тос ашигласан тохиолдолд хөдөлгүүрийн асалт муудах тул SAE 0W-20, 5W-20 эсвэл 5W-30 хөдөлгүүрийн тос ашиглана.



A Хөдөлгүүрийн тосны ашиглах боломжтой температур


B Тохиромжтой температур

Тосны зууралданги (0W-20 тосыг жишээ болгон тайлбарлав):

- Тосны 0W-20 зууралдангийн үзүүлэлт дээрх 0W нь тухайн тосны хүйтэнд асаах чадварыг илэрхийлнэ. W тэмдэгтийн өмнөх тоо бага байх тусам автомашины хөдөлгүүр хүйтэн нөхцөлд илүү сайн асна.
- 0W-20 дээрх 20 нь тосны хэм хэт өндөр үеийн зууралданги чанарыг илэрхийлнэ. Зууралданги чанар өндөртэй тос.

Тосны шошго дахь мэдээлэл:

Тосны саван дээр дараах API-н тэмдэгтийн аль нэг эсвэл зэрэг тэмдэглэгдсэн байдаг.



A API Сервисийн тэмдэгт

Дээд тал: “API SERVICE SN” тэмдэглэгээ нь Америкийн Нефть Судлалын Хүрээлэн (API)-н боловсруулан гаргасан тосны чанарыг хангасан утгыг илэрхийлнэ.

Төв хэсэг: “SAE 0W-20” тэмдэглэгээ нь зууралдангийн SAE ангилалд хамаарах утгыг илэрхийлнэ.

Доод тал: “Resource-Conserving” тэмдэглэгээ нь тухайн тос шатахуун зарцуулалт болон байгаль орчинд ээлтэй утгыг илэрхийлнэ.

B ILSAC Сертификатын тэмдэгт

Олон Улсын Тосны Стандартчилал Баталгаажуулалтын Холбоо (ILSAC)-ны Сертификатын тэмдэгт савны урд талд тэмдэглэгдсэн байдаг.

Хөргөлтийн систем

Багтаамж ^{*1}	Intercooler-н хөргөлтийн шингэн	3.7 л (3.9 qt., 3.3 Imp. qt.)
	Хөдөлгүүрийн хөргөлтийн шингэн	13.2 л (14.0 qt., 11.6 Imp. qt.) ^{*2} 15.3 л (16.2 qt., 13.5 Imp. qt.) ^{*3}
Хөргөлтийн шингэний төрөл		Ашиглах боломжтой шингэний төрлүүд: • “Toyota Super Long Life Coolant” • Дээрхтэй адил өндөр чанарын, этилен гликол суурьтай, силикатгүй, амингүй, нитритгүй, борын хүчлийн давсгүй, удаан эдэлгээтэй холимог органик хүчлийн технологитой шингэн. Усыг дангаар нь хэрэглэхийг хориглоно.

*1: Багтаамжийн хэмжээг зөвхөн мэдээллийн журмаар ашиглана уу. Шингэн солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.

*2: Арын агааржуулалтын системгүй загвар

*3: Арын агааржуулалтын системтэй загвар

Асаах систем

■ Очлуур (свеча)

Үйлдвэрлэгч	DENSO EC22HPR-D7
Очлуурын электродын зай	0.7 мм (0.028 in.)



АНХААР

■ Иридийн очлуур

Зөвхөн иридийн очлуур хэрэглэнэ. Очлуурын электродын зайнд өөрчлөлт хийхийг хориглоно.

Цахилгааны систем

20°C (68°F) хэм дэх нягтрал:	1.250 ба түүнээс дээш Нягтрал заасан хэмжээнээс бага үед аккумуляторыг цэнэглэнэ.
Цэнэглэх хурд:	5 A max.

Дифференциал

Тосны багтаамж	Урд	1.16 л (1.23 qt., 1.02 Imp. qt.)
	Хойд	Арын LSD дифференциалгүй: 6.83 л (7.22 qt, 6.01 Imp.qt.) Арын LSD дифференциалтай: 6.50 л (6.87 qt, 5.72 Imp.qt.)
Тосны төрөл, зууралданги чанар		Toyota Genuine Differential Gear Oil LT 75W-85 GL-5 эсвэл дүйцэх чанарын тос

Автомашин үйлдвэрээс “Toyota Genuine Differential Gear Oil” тостой нийлүүлэгддэг.

“Toyota Genuine Differential Gear Oil” эсвэл түүнтэй дүйцэх, дээр дурдсан техникийн шаардлага хангах тос ашиглана. Дэлгэрэнгүйг Lexus дилерээс авна уу.

Автомат хурдны хайрцаг

Шингэний багтаамж (стандарт)	11.1 л (11.73 qt, 9.77 Imp.qt)
Шингэний төрөл	Toyota Genuine ATF WS

Багтаамжийн хэмжээг зөвхөн мэдээллийн журмаар ашиглана уу. Шингэн солих шаардлагатай үед та өөрийн Lexus дилерт хандана уу.



АНХААР

■ Автомат хурдны хайрцгийн шингэний төрөл

Дээр зааснаас өөр төрлийн шингэн ашиглах нь хэвийн бус дуу чимээ, чичиргээ үүсгэх эсвэл хурдны хайрцагт ноцтой гэмтэлд хүргэж болно.

Туслах хурдны хайрцаг

Тосны багтаамж	1.78 л (1.88 qt., 1.57 Imp. qt.)
Тосны төрөл*	Toyota Genuine Transfer Gear oil LF эсвэл дүйцэх чанарын тос
Тохиромжтой зууралданги чанар	SAE 75W

*: Автомашин үйлдвэрээс “Toyota Genuine Transfer Gear oil LF” тостой нийлүүлэгддэг. Үйлдвэрлэгчийн баталсан “Toyota Genuine Transfer Gear oil LF” эсвэл түүнтэй дүйцэх, дээр дурдсан техникийн шаардлага хангах тос ашиглана. Дэлгэрэнгүйг Lexus дилерээс авна уу.

Тоормос

Дөрөөний зай*	Зүүн жолооны хүрдтэй: Хамгийн багадаа 95 мм (3.74 in.) Баруун жолооны хүрдтэй: Хамгийн багадаа 110 мм (4.33 in.)
Дөрөөний сул явалт	1 — 6 мм (0.04 — 0.24 in.)
Шингэний төрөл	SAE J1703 эсвэл FMVSS No. 116 DOT 3 SAE J1704 эсвэл FMVSS No. 116 DOT 4

*: Хөдөлгүүр ажиллаж байх үед 300 N (31kgf, 67 lbf) хүчээр зогсоох үеийн хамгийн бага дөрөөний зай.

Хүч дамжуулах ангийн тосолгоо (кардан гол)

► Урд

Чагтан гол	Литий суурьтай хүч дамжуулах ангийн тос, NLGI No.2
Карданы шлиц	Молибден дисульфид литий суурьтай явах эд ангийн тос, NLGI No.2 эсвэл литий суурьтай явах эд ангийн тос, NLGI No.2

► Хойд

Чагтан гол	Литий суурьтай хүч дамжуулах ангийн тос, NLGI No.2
------------	--

Жолооны хүрд

Сул явалт	30 мм (1.18 инч)-с бага
-----------	-------------------------

Дугуй болон обуд

► 22 инчийн дугуйтай загвар

Дугуйн хэмжээ	265/50R22 112V	
Дугуйны хийн даралт (Хүйтэн үед)	Урд дугуй kPa (kgf/cm ² эсвэл bar, psi)	Хойд дугуй kPa (kgf/cm ² эсвэл bar, psi)
	230 (2.3, 33)	230 (2.3, 33)
Обудны хэмжээ	22 × 7 1/2J	
Дугуйн гайк чангалах хүч	131 N•m (13.4 kgf•m, 97 ft•lbf)	

► 20 инчийн дугуйтай загвар

Дугуйн хэмжээ	265/55R20 113V	
Дугуйны хийн даралт (Хүйтэн үед)	Урд дугуй kPa (kgf/cm ² эсвэл bar, psi)	Хойд дугуй kPa (kgf/cm ² эсвэл bar, psi)
	230 (2.3, 33)	230 (2.3, 33)
Обудны хэмжээ	20 × 7 1/2J	
Дугуйн гайк чангалах хүч	131 N•m (13.4 kgf•m, 97 ft•lbf)	

► 18 инчийн дугуйтай загвар

Дугуйн хэмжээ	265/70R18 116H	
Дугуйны хийн даралт (Хүйтэн үед)	Урд дугуй kPa (kgf/cm ² эсвэл bar, psi)	Хойд дугуй kPa (kgf/cm ² эсвэл bar, psi)
	230 (2.3, 33)	230 (2.3, 33)
Обудны хэмжээ	18 × 7 1/2J	
Дугуйн гайк чангалах хүч	131 N•m (13.4 kgf•m, 97 ft•lbf)	

■ Тохирлын гэрчилгээ

Тус автомашины суурилагдсан дугуй нь Энэтхэг улсын IS 15633 стандартад нийцсэн бөгөөд тус улсын 1989 оны Моторжсон Тээврийн Хэрэгслийн Үндсэн Дүрмийн 95-р заалтын шаардлагыг хангасан болно.

Шатахууны мэдээлэл

Зөвхөн хар тугалгагүй бензин ашиглана.

Хөдөлгүүрийн хүчин чадлыг дээд хэмжээнд хүргэх үүднээс хар тугалгагүй, шинжилгээний октаны тоо 95 (октаны тоо 91)-с дээш бензин ашиглана.

Дээрх өндөр чанарын бензин байхгүй нөхцөлд шинжилгээний октаны тоо 91 (октаны тоо 87)-тэй бензин түр ашиглаж болно.

■ Бензин хөдөлгүүрт этанолын хольцтой бензин ашиглах

10 хүртэлх хувийн этанолийн хольцтой бензин ашиглахыг Lexus зөвшөөрдөг. Этаноллын хольцтой бензин ашиглах үедээ тухайн бензиний шинжилгээний октаны тоо нь дээрх шаардлагад нийцсэн эсэхийг нягтлах шаардлагатай.

■ Таны хөдөлгүүрт детонац буюу цохилт үүссэн үед

- Өөрийн Lexus дилерт хандана уу.
- Мөн хурд авах, өгсүүр замаар явах үед үе үе богино хугацааны бага хэмжээний цохилт хөдөлгүүрт үүсэх тохиолдол байдаг ба энэ нь хэвийн зүйл бөгөөд анхаарал шаардлагагүй юм.



АНХААР

■ Бензиний чанартай холбоотой анхааруулга

- Чанарын шаардлага хангаагүй шатахуун ашиглахыг хориглоно. Эсрэг тохиолдолд хөдөлгүүрт гэмтэл учруулах аюултай.

- Манган, төмөр, хар тугалга зэрэг металл агуулсан бензин нь хөдөлгүүр, хаягдал утааны хяналтын систем гэмтээх тул ашиглаж болохгүй.

- Металлын орцтой шатахууны нэмэлт бодис ашиглаж болохгүй.

- M15, M85, M100 зэрэг метанолийн хольцтой бензин ашиглаж болохгүй. Хөдөлгүүрт гэмтэл, доголдол учруулж болзошгүй.

- “E50” эсвэл “E85” нэрээр борлуулдаг биоэтанол шатахуун мөн 10-с дээш хувийн этанолийн өндөр агууламжтай шатахуун ашиглаж болохгүй. 10-с дээш хувийн этанолийн өндөр агууламжтай шатахуун (E10) шатахуун ашиглах нь шатахууны систем гэмтээх аюултай. Танд эргэлзээ төрсөн нөхцөлд өөрийн Lexus дилерээс тодруулна уу.

Өөрчлөх боломжтой тохиргоо

Таны автомашинд өөрийн хэрэглээнд нийцүүлэн тохируулах олон төрлийн электрон төхөөрөмж, функцүүд байдаг. Тохиргоог голын дэлгэц ашиглан мөн Lexus дилер дээр хийлгэж болно.

Зарим өөрчлөх боломжтой тохиргоо Миний тохиргоо функцтэй уялдан өөрчлөгддөг. (→X.185)

Автомашины тохиргоог өөрчлөх

■ -р тохиргоо хийх

- 1 Дэлгэцээс -г сонгоно.
- 2 “Vehicle customise” эсвэл “Driving assist”-г сонгоно.
- 3 Өөрчлөх тохиргоог сонгоно.

Асааж унтраах боломжтой функц дээр  (ON) /  (OFF)-г сонгоно.

Дууны түвшин, мэдрэгчийн мэдрэх түвшин зэрэг түвшин тохируулах боломжтой функц дээр тохиргооны тэмдгийг хөдөлгөн тохируулна.

■ -р тохиргоо хийх

- 1 Дэлгэцээс -г сонгоно.

Өөрчлөх боломжтой тохиргоо

Зарим функцийн тохиргоо нь бусад функцийн тохиргоог өөрчлөх үед давхар өөрчлөгддөг. Дэлгэрэнгүйг та өөрийн Lexus дилерээс авна уу.

- 2 “Driving assist”-г сонгоно.

- 3 Жагсаалтаас өөрчлөх тохиргоог сонгоно.

Товч дарах бүрд тохиргоо идэвхжиж унтарна.

Идэвхжүүлсэн үед дэлгэц дээр томоор гарна.

■ Өөрчлөх боломжтой тохиргоог хийх үед

Автомашиныг аюулгүй газар зогсоон зогсоолын тоормос татаад арааны хөшүүргийг Р-д шилжүүлнэ. Мөн аккумуляторын цэнэг суухаас сэргийлж хөдөлгүүрийг асаалттай байлгана.

■  тэмдгийг ашиглах

Автомашины зарим тохиргоог  тэмдгээр өөрчлөх боломжтой.

АЮУЛТАЙ

■ Тохиргоо хийх үед

Тохиргоо хийх үед хөдөлгүүр асаалттай байх шаардлагатай тул автомашиныг агааржуулалт сайтай газар зогсооно. Битүү орчинд нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) зэрэг хорт хий агуулагддаг утаа хуримтлагдаж автомашины дотор орох улмаар амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учрах аюултай.

АНХААР

■ Тохиргоо хийх үед

Аккумуляторын цэнэг суухаас сэргийлж хөдөлгүүрийг асаалттай үед тохиргоо хийнэ.

A Голын дэлгэц ашиглан өөрчлөх боломжтой тохиргоо

B Lexus дилер дээр өөрчлөх боломжтой тохиргоо

Тэмдгийн утга: О = Болно, – =Болохгүй

■ Дохиоллын систем (→Х.81)

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Механик түлхүүрээр түгжээ тайлах үед цуцлах тохиргоо*	Off	On	—	О

*: Зарим загваруудад

■ Хэмжих хэрэгслүүд болон мэдээллийн дэлгэц (→Х.88, 93)

Мэдээллийн дэлгэц, хянах самбар дээр гарах хэл, хэмжих хэрэгслийн нэгжийн тохиргоо голын дэлгэцийн тохиргоог дагаж өөрчлөгдөнө. Дэлгэрэнгүйг "Мультимедиа хэрэглэгчийн гарын авлага"-с харна уу.

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
Хянах самбарын төрөл*	Төрөл 1	Төрөл 2	О	—
		Төрөл 3		
Эко жолоодлогын индикатор*	On	Off	О	—
Зөвлөмж функц*	On	On (зогссон үед)	О	О
		Off		
Тоормосны гэрлийн индикатор	On	Off	О	—

*: Тус тохиргоо нь Миний тохиргооны дагуу өөрчлөгдөнө

■ HUD дэлгэц*¹ (→Х.99)

Функц	Үндсэн тохиргоо	Өөрчилсөн тохиргоо	A	B
HUD дэлгэц* ²	On	Off	О	—
HUD дэлгэцийн төрөл* ²	Стандарт	Бүтэн	О	—
		Бага		
HUD дэлгэцийн гэрлийн түвшин* ²	Стандарт	Off	О	—

